


Номлогчийн Үйлчлэлд Зориулсан Удирдамж

“Миний Сайн Мэдээг Номло”

(С ба Г 50:14)



“Ариун Сүнсний хүлээн авалтаар та нар ариусгагдаж болохын тулд, эцсийн өдөр та нар миний өмнө толбогүйгээр зогсож болохын тул наманчлагтун, мөн надад ирэгтүн мөн миний нэрээр баптисм хүртэгтүн, ертөнцийн хязгаарууд та нар бүгд” (3 Нифай 27:20)

Нэр:

Номлол болон Үйлчлэлийн Огноо:

Бүс Нутгуудийн Жагсаалт:

Хамтрагч нар:

Баптисм Хүртэж, Гишүүнээр Батлуулсан Хүмүүсийн Нэрс болон Хаягууд:

“Миний Сайн Мэдээг Номло”

(С ба Г 50:14)

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хэвлэв.
Солт Лэйк Хот, Юта Муж

Хавтасны зургийг: Greg K. Olsen © 1988 он
Иохан Баптист Есүс Христэд баптисм хүртээж байгаа нь
Dr. Gerry Hooper болон Mill Pond Press хэвлэлийн газарт талархал илэрхийлье.
Хуулбарлахыг хориглоно.

© 2005 by Intellectual Reserve, Inc
Бүх эрх хамгаалагдсан

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.
Англи хэлний зөвшөөрөл: 11/04
Орчуулгын зөвшөөрөл: 11/04
Preach My Gospel-ийн орчуулга
Mongolia
36617 363

“Миний Сайн Мэдээг Номло”

(C a Г 50:14)

Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичиг	v
Танилцуулга: “Миний Сайн Мэдээг Номло”-ыг Би Хэрхэн Хамгийн Сайнаар Ашиглаж Чадах Вэ?	vii
1 Номлогчийн Хувьд Миний Зорилго Юу Вэ?	1
2 Би Хэрхэн Үр Ашигтайгаар Суралцаж, Заахад Бэлтгэх Вэ?	19
3 Би Юу Судалж, Юу Заах Вэ?	31
• Хичээл 1: Есүс Христийн Сайн Мэдээний Сэргээлтийн Захиас	33
• Хичээл 2: Авралын Төлөвлөгөө	51
• Хичээл 3: Есүс Христийн Сайн Мэдээ	66
• Хичээл 4: Зарлигууд	79
• Хичээл 5: Хуулиуд ба Ёслолууд	91
4 Би Хэрхэн Сүнсийг Танин Мэдэж, Ойлгох Вэ?	99
5 Мормоны Номны Үүрэг Юу Вэ?	117
6 Христийнхтэй Адил Зан Чанаруудыг Би Хэрхэн Хөгжүүлэх Вэ?	131
7 Би Номлолынхоо Хэлийг Хэрхэн Илүү Сайн Сурах Вэ?	145
8 Би Цагийг Хэрхэн Ухаалгаар Ашиглах Вэ?	155
9 Заах Хүмүүсийг Би Хэрхэн Олох Вэ?	177
10 Заах Арга Барилаа Би Хэрхэн Сайжруулах Вэ?	199
11 Амлалтуудыг Хийж, Биелүүлэхэд нь Би Хүмүүст Хэрхэн Туслах Вэ?	221
12 Баптисм болон Гишүүнээр Батлагдахад нь Хүмүүсийг Би Хэрхэн Бэлтгэх Вэ?	231
13 Би Гадас болон Хэсгийн Удирдагчидтай Хэрхэн Ажиллах Вэ?	243
Индекс	255



Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичиг

Эрхэм Номлогч оо:

Бид таны номлогч байгаа энэ агуу боломжид тань баяр хүргэж байна. Номлолын ажлаас илүү хүчирхэг эсвэл агуу их баяр баяслыг авчирдаг ажил гэж байхгүй.

Таныг илүү бэлтгэгдсэн, илүү сүнслэгээр боловсорсон ба илүү итгэлтэй багш байхад туслахын тулд “Миний Сайн Мэдээг Номло” нь төлөвлөгдсөн юм. Би танаас үүнийг өдөр болгон өөрийн хувийн болон хамтрагчийн бэлтгэлдээ, мөн өөрийн дүүргийн хурал болон бүсийн чуулгандаа ашиглахыг хүсч байна. Судрын ишлэлүүдээс суралцаж, мөн сургаал ба зарчмуудыг судал.

Бид таныг өөрсдийн Тэнгэр дэх Эцэгийн гайхамшигт ажилд нь Түүнд туслан амлалтуудаа өсгөхийг шаардаж байна. Номлогч бүр “үхэшгүй байдал хийгээд, мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрахад” (Мосе 1:39) туслах чухал үүрэгтэй.

Таныг залбиралтайгаар мөн даруухнаар Түүнд үйлчлэхэд Их Эзэн таныг элбэгээр адислах бөгөөд шагнах болно. Түүний хүүхдүүдийн дунд ажиллах үед чинь өмнө нь тохиолдож байсан туршилагаас тань илүү их баяр баясгалан таныг хүлээж байна.

Тэргүүн Зөвлөл



Танилцуулга: “Миний Сайн Мэдээг Номло”-ыг Би Хэрхэн Хамгийн Сайнаар Ашиглаж Чадах Вэ?

Тэмдэглэл

“Миний Сайн Мэдээг Номло”


Номлогчийн хэрэгцээндээ “Миний Сайн Мэдээг Номло”-ыг ашигла. Та бүх суралцах цагаа цөөн догол мөрүүд, эсвэл бүхэл бүтэн бүлгийг судлахад зарцуулж болно. Та бүлгүүдийг дарааллаар нь юмуу, эсвэл өөрийнхөө хэрэгцээнд илүү тохирох өөр дэс дарааллыг төлөвлөн тогтоож суралцаарай. Энэ уян хатан байдал нь танд юу хэрэгтэй байгаа, та үүнийг хэзээ хэрэглэх хийгээд номлолын ерөнхийлөгчийнхөө удирдамж болгосноор суралцах боломжийг олгоно.

“Миний Сайн Мэдээг Номло” дахь бүх бүлгүүд нь таныг номлогчийн зорилгуудаа биелүүлэхэд өөрийгөө бэлтгэхэд туслах болно. Хэдий тийм ч та бүлэг 3-ыг судалж эхэлснээр зорилтдоо хүрэх арга замын ялгааг мэдэрнэ. Ихэнх бүлгүүд зөвхөн танд хандсан байгаа. Бүлэг 3 илүү ерөнхий сонсогчдод хандсан байдаг. Та өөрийн сайн мэдээний мэдлэг хийгээд гэрчлэлийг бэхжүүлэх, мөн бусдад зааж, тэднийг амлалтууд болон гэрээнүүдийг хийж, үүнийгээ сахихад бэлтгэх заах зүйлүүдийг бүлэг 3-аас суралцах болно.

Бусад бүлгүүдийн заримд байгаа сургаалууд ч бас танд сонирхогчид болон шинэ гишүүддээ заахад тань тусална. Жишээлбэл; бүлэг 4, “Би Хэрхэн Сүнснийг Танин Мэдэж, Ойлгох Вэ?” нь танд зарим сонирхогчдодоо Ариун Сүнсний хүчээр хэрхэн гэрчлэл олж авах тухай заахад тусалж болно. Бүлэг 5, “Мормоны Номны Үүрэг Юу вэ?” нь Мормоны Номыг унших талаар сонирхогчийн тань эргэлзээг тайлахад тусална. Бүлэг 2, “Би Хэрхэн Үр Ашигтайгаар Суралцаж, Заахад Бэлтгэх Вэ?”-гээс гарах санаанууд нь Мормоны Номыг суралцсанаар илүү ихийг олж авахад нь шинэ хөрвөгчдөд тусалж болно.

“Миний Сайн Мэдээг Номло” нь номлогчийн ажлын гол зарчмууд дээр төвлөрдөг. Энэ нь танд тулгарах бүх асуудал буюу нөхцөл байдлуудад хариулдаггүй. Та Сүнснийг дагаж, судраас судалж, зарлигуудыг сахиж, юу сурснаа ашигласнаар хамгийн их үр дүнтэй байх болно.

Номлолынхоо турш эдгээр бүлгүүдийг суралц. Юу сурснаа амьдралд хэрэгжүүл. Ажлаа үнэлж дүгнэ. Өөрийгөө өдөр бүр бэлтгэхийг хичээж, тогтмол өсөн сайжрахыг эрэлхийлдэг номлогч нар Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авч, амьдралдаа адислалуудыг харах болно.



Номлогчийн Хичээлүүд

Та хүмүүсийг баптисм болон гишүүний баталгаанд бүрэн дүүрэн бэлтгэхэд нь туслах хамгийн сайн арга юу байна түүгээр хичээлүүдээ уян хатан байдлаар зааж болно. Таны зорилго нь зөвхөн энэ бүгдийг заагаад зогсохгүй бусад Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчсэнээр Христэд ирэхэд нь туслах явдал юм. Хичээлүүд нь 45 минутаас дээш явагдах тохиолдол цөөхөн гарна. Танд богино хичээл заах боломж олгох тийм цаг олдож ч болох юм. Ийм тохиолдолд танд бүхэл хичээлийнхээ жижиг хэсгүүдийг заах тогтмол хийгээд богино уулзалтууд хэрэгтэй болох болно.

Та хичээлүүдийг маш олон арга замуудаар зааж болно. Аль хичээлийг нь заах, үүнийгээ хэзээ заах, үүндээ хэр их хугацаа зарцуулах гэж байгаа тань сонирхогчийн хэрэгцээ болон Сүнсний удирдамжаар тодорхойлогдвол илүү сайн. Хичээлийг тэр чигээр нь бүү цээжил.

Хувиараа Суралцах, Хамтрагчтайгаа Суралцах нь, Дүүргийн Хурал болон Бүсийн Чуулган

Номлолынхоо турш үр ашигтай судлах нь танд номлогчийн хувьд зорилгоо биелүүлэх хийгээд Есүс Христийн сайн мэдээний талаарх гэрчлэлээ батжуулахад туслах болно. Судлах хамгийн чухал дөрвөн боломж нь хувиараа суралцах, хамтрагчтайгаа суралцах, дүүргийн хурал болон бүсийн чуулган юм. Таны өдрийн хуваарьт өдөр бүр хувиараа болон хамтрагчтайгаа суралцах цаг багтсан байх ёстой.

Номлогчийн Өдрийн Хуваарь*

6:30	Босох, залбирах, дасгал хийх (30 минут) болон өдөртөө бэлдэх.
7:30	Өглөөний унд.
8:00	Хувиараа суралцах: Мормоны Ном, бусад судрууд, номлогчийн хичээлүүдийн сургаалууд, “Миний Сайн Мэдээг Номло” дээрх бусад бүлгүүд.
9:00	Хамтрагчтайгаа суралцах: хувиараа суралцаж байхдаа сурсан зүйлээсээ хуваалцах, заахад бэлтгэх, заах дадлага хийх, “Миний Сайн Мэдээг Номло” дээрх бүлгүүдээс судлах, өдрийнхөө төлөвлөгөөг баталгаажуулах.
10:00	Номлолоо эхлэх. Хэл сурч байгаа номлогч нарын хувьд хэл сурах 30-60 минут үлдэх бөгөөд үүндээ мөн өдрийн турш ашиглах хэл сурах үйл ажиллагаануудыг төлөвлөх. Номлогч нар номлолд нь хамгийн сайн тохирох өдрийн аль нэг цагуудыг өдрийн хоол, нэмж сурах цаг болон оройн хоолонд зориулан авч болно. Оройн хоол нь ерөнхийдөө 18:00 цагаас оройтолгүй дуусч байх ёстой.
21:00	Амьдарч байгаа байрандаа эргэн ирээд (хичээл зааж байгаа бол 21:30 ирж болно) дараагийнхаа өдрийн үйл ажиллагааг төлөвлөх (30 минут). Тэмдэглэлээ бичих, ор дэрээ засах, залбирах.
22:30	Орондоо орох.

*Далын Ерөнхийлөгчийн Зөвлөл, эсвэл Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр танай номлолын ерөнхийлөгч орон нутгийн нөхцөл байдалдаа тохируулан энэ хуваарийг өөрчилж болно.

Хувиараа суралцах цаг дээр сурсан зүйл тань ‘хаант улсын сургаалыг та нар бие биендээ зааж’ болох хамтрагчтайгаа суралцах цаг, дүүргийн хурал, бүсийн чуулгануудад тань туслах болно (С ба Г 88:77–г үз). Суралцах хэсэг болон дүүргийн хурлаас олж авсан мэдлэг тань таныг сүнслэг хүчээр заахад тусална.



Хувиараа Суралцах

Хувиараа суралцахын зорилго нь сэргээгдсэн сайн мэдээний талаарх таны мэдлэг, гэрчлэлийг бэхжүүлэх хийгээд зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээг хангахад танд туслах явдал мөн. Та хувиараа суралцахдаа жишиг бүтээлүүд хийгээд зөвшөөрөгдсөн номлогчийн номын санд анхаарлаа төвлөрүүл.

- *Jesus the Christ*
- *Our Heritage*
- *Our Search for Happiness*
- *True to the Faith*

Та дараах тохиолдолд хувийн судалгаагаа үр ашигтай болгож чадна:

- Мормоны Ном болон бусад судруудаас унш.
- Номлогчийн хичээлүүд дэх сургаалуудыг судал.
- “*Миний Сайн Мэдээг Номло*” гарын авлагын бусад бүлгүүдийг судал.

Хамтрагчтайгаа Суралцах

Хамтрагчтайгаа суралцахын зорилго нь (1) Сүнсээр заахын тулд хамтрагчтайгаа эв нэгдлийг төлөвшүүлэх түүнчлэн (2) өөрийн тань заадаг хүмүүсийн өсөлт хөгжилтэд анхаарал төвлөрүүлэх явдал мөн. Дараах тохиолдолд та хамтрагчтайгаа суралцахыг үр дүнтэй болгож чадна:

- Хувиараа суралцахаас олж авсан ойлголтуудаасаа бие биетэйгээ хуваалц.
- Заах тусгай үүрэгт ажил, гишүүдийн гэрээр очиж уулзах, заах хүмүүс олох боломжууд хийгээд бусад үйл ажиллагаануудад бэлтгэ. Заах, олох болон илүү үр ашигтайгаар ажиллахад тань танд туслах материалыг судал. Өөрийнхөө хамт ажилладаг хүмүүстэй ярилц. Сурсан зүйлээ хэрэглэх төлөвлөгөө зохио.
- Зарчмууд, зорилгууд, ур чадвар хийгээд хамтрагчтайгаа суралцах төлөвлөгөөнүүдийг ярилцахаа үргэлжлүүл.

Дүүргийн хурлууд

Дүүргийн хурлын зорилго бол ‘хаант улсын сургаалыг та нар бие биендээ заах’ явдал мөн (С ба Г 88:77–г үз).

- Дүүргийн хурлууд долоо хоног бүр 60–90 минут явагддаг.
- Дүүргийн удирдагч дүүргийн хурлыг төлөвлөж, хөтлөн явуулах бөгөөд заахад туслуулахаар бусад номлогч нарыг урьж болно.

- Дүүргийн хурлууд:
 - Хувиараа болон хамтрагчтайгаа суралцсанаас олсон ойлголтуудыг хуваалцах
 - Янз бүрийн боломжит нөхцөлүүдээр хичээлүүдийг заан турших
 - “Миний Сайн Мэдээг Номло”-д дурдагдсан зарчмууд болон чадваруудыг тайлбарлах, харуулах болон дадлага хийх
 - Сонирхогчдынхоо өсөлт болон хэрэгцээг ярилцах
 - Дүүрэг дэх бэрхшээлүүдийг тодорхойлж ярилцах
 - Номлолын ажлын туршлага болон гэрчлэлүүдийг хуваалцахыг багтаадаг.
- Дүүргийн удирдагчид дүүрэг дэх номлогч нарын хүч чармайлтуудын талаарх илтгэлийг хүлээж авахын тулд дүүргийн хурлыг ашиглаж болно. Тэд зорилго дэвшүүлэх буюу бусад номлогч нарын ажлын хувь хэмжээг заах, эсвэл тэдний зорилгын талаар тайлагнахыг хүсэх ёсгүй.

Бүсийн Чуулганууд

Бүсийн чуулганыг номлолын ерөнхийлөгчийн удирдлага дор явуулдаг.

“Миний Сайн Мэдээг Номло”-ын Онцлогууд

“Миний Сайн Мэдээг Номло” дахь бүлэг бүр нь хэд хэдэн онцлогтой. Эдгээр онцлогууд нь таныг тодорхой арга замаар сурахад албадах биш—харин судалсан зүйлээсээ илүү ихийг мэдэж авахад танд туслах учиртай. Өөрийнхөө хэрэгцээнд тулгуурласан уян хатан арга хэлбэрээр эдгээр онцлогуудыг ашигла.

Судлах Тэмдэглэл

“Миний Сайн Мэдээг Номло” нь таныг сурсан зүйлээ ойлгож, тодруулж, мөн санаж байхад тань туслахын тулд судлах тэмдэглэлийг хэрэглэхийг ямагт асуудаг. Ахлагч Ричард Ж.Скотт заахдаа, “Нягт нямбай хөтөлсөн мэдлэг нь хэрэгтэй цагт бэлэн байдаг мэдлэг юм. Сүнслэг байдлын хувьд эмзэг мэдээллүүд нь таны хэр их нандигнахаас хамаарч Их Эзэнд мэдээлэх нандин газар хадгалагдах ёстой. Ингэж бичиж үлдэх нь таны гэрэл хүлээн авах цаашдын боломжийг нэмэгдүүлдэг.” (“Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, Nov. 1993, 86). Судлах тэмдэглэлээ байнга үзсэнээр сүнслэг тохиолдлуудаа эргэн санаж, шинэ ойлголтуудыг харж, мөн өөрийнхөө өсөлтийг мэдрэх болно.

Судлах тэмдэглэл тань үддэг тэмдэглэлийн дэвтэр, дэвтэр буюу үдэгчтэй хавтас байж болно. Хэрхэн сурсанд тань тохирох арга замаар өөрсдийн бодол болон сэтгэгдлээ бичиж, зохион байгуул. Хожим нь нэвтэрч ороход хялбар байх тийм түлхүүр мэдээллүүдээр өөрийн системийг баяжуул. Юу сурснаа дахин хянаж мөн хэрэглэхийн тулд үүнийгээ байн байн ашигла. Судлах тэмдэглэлээ хувиараа болон хамтрагчтайгаа суралцах, дүүргийн хурал, бүсийн чуулган мөн номлолын ерөнхийлөгчтэй хийдэг ярилцлагын турш төрсөн сэтгэгдлээ бичиж авч, тэмдэглэхэд ашигла.

Мэдээллийн Хайрцаг

“Миний Сайн Мэдээг Номло” дээрх хайрцгууд нь таныг сурахад туслах болно. Зарим хайрцгууд урьдчилан үнэлэх буюу гол санаануудыг нь дүгнэдэг. Бусад нь таны сурлага, судраас суралцах, сурснаа амьдралд хэрэгжүүлэх, чадвараа өсгөх, зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээнд тохируулахдаа анхаарахад тусалдаг. Ихэнх тохиолдолд, эдгээр хайрцгууд нь эхлэх цэг болж өгдөг. Суралцах шинэ үйл

ажиллагаануудыг хөгжүүлж, нэмэлт судруудыг эрж хайснаар хайрцаг дахь үйл ажиллагаануудыг залбиралтайгаар нэмж бий болго.

Үүнийг Анхаар

- “Таныг хүлээн авах”
- Заах хүмүүсийг ол
- Олох хүчин чармаг
- Хэвпэл мэлээпэл

“Үүнийг Анхаар.” Ихэнх бүлгүүд “Үүнийг Анхаар” хайрцаг дахь асуултуудаар эхэлдэг. Эдгээр асуултууд нь тухайн бүлгийн гол санаанд анхаарал хандуулж, суралцахад тань санал болгосон санаануудаар хангах болно. Юу сурснаа зохион байгуулж, ойлгож, тунгаан бодож, мөн амьдралд хэрэгжүүлэхдээ эдгээр асуултуудыг ашигла.

Үүнийг Сана

- “Таныг хүлээн авах”
- Олохдоо Сүнснийг
- Таны бүс дэх хүмүү
- Сүмийн илэвхтэй

“Үүнийг Сана.” Ихэнх бүлгүүд нь тухайн бүлгийн ихэнх чухал санаануудыг нэгтгэн дүгнэсэн “Үүнийг Сана” хайрцагаар төгсдөг. Та бүлгийг судалж дуусаад тэдгээр үндсэн зарчмуудыг ойлгосон эсэхээ батлахаар эдгээр мэдээллүүдийг нягтлан үз. Эдгээр зарчмуудыг амьдралд хэрхэн сайн хэрэгжүүлж байгаагаа үнэлж дүгнээд, юу сурснаа хэрэгжүүлэх төлөвлөгөөг хий.

Судар Судлах

Есүс Христийн жишэ

3 Нифай 12:48
3 Нифай 27:21, 27

Сайн мэлээний анх

“Судар Судлах.” Эдгээр хайрцагууд нь таны ойлголт болон гэрчлэлийг өсгөх ишлэлүүдийг танд өгдөг. Нэмэлт судруудыг эрэлхийлснээр эдгээр ишлэлүүдийг баяжуул. Таныг ойлголт хуримтлуулж, юу сурснаа хэрэгжүүлэхэд туслах үүнтэй холбоотой нэмэлт асуултуудыг өөрсдөөсөө асуу.

Үйл Ажиллагаа: Хув

Та 1 Нифай 8, 11-т га амьдралын модны зу бэлэгддэг (1 Нифай 1

- Жимсийг идсэний

“Үйл Ажиллагаа.” Ихэнх бүлгүүд таны хувиараа болон хамтрагчтайгаа суралцахад зориулсан сурах, ашиглахыг нэмэгдүүлэх үйл ажиллагаануудтай. Эдгээр үйл ажиллагаануудыг номлолынхоо турш давтан хий. Таны болон таны зааж байгаа тэдгээр хүмүүсийн хэрэгцээ өөрчлөгдөж байдаг учраас та ингэх болгондоо шинэ ойлголтуудыг олж авч байх болно.

Сүнсийг Дага

“Сүнс нь энэ ажил да чанаржуулснаар ном Таны авьяас болон ур (Ezra Taft Benson, sei

Улаан Хайрцагууд. Эдгээр хайрцагууд нь заах болон сургаалыг номлох олон нөхцөл байдлуудад зориулсан чухал мэдээлэл болон зөвлөмжүүдийг агуулсан байдаг.

Түүхүүд

“Миний Сайн Мэдээг Номло” дээрх бүх түүхүүд нь үнэн хэдий ч ихэнх хүмүүсийнх нь нэрийг өөрчлөн бичсэн байгаа. Түүх бүр номлогчийн ажилтай холбоотой хэд хэдэн зарчмуудыг үзүүлсэн байдаг. Эдгээр түүхүүдийг уншиж байхдаа эдгээрт үзүүлж байгаа зарчмуудыг нь анзаар.

Тэмдэглэл

Заах болон Хэрэглэхэд Зориулсан Санаанууд

Бүлэг бүр хувиараа суралцах, хамтрагчтайгаа суралцах, дүүргийн хурал болон бүсийн чуулганд зориулсан нэмэлт санаануудыг багтаасан байгаа. Сурах үйл ажиллагааны баялаг нөөц нь энэ материалыг судлах үр дүнтэй арга замуудын жишээгээр хангадаг. Эдгээр хэсгүүдийн нэгийг сурах юмуу зааж байх болгондоо бүтээлчээр сэтгэж, нэмэлт үйл ажиллагаануудыг бий болгох сүнслэг урмыг эрэлхийл. Номлолынхоо турш эдгээр үйл ажиллагаануудыг хэд хэдэн удаа хийж гүйцэтгэ.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх

Хувиараа Суралцах

- Номлогчийн эцэг эхдээ бичсэн доорх захидлыг унш: "Би нэг гайхалтай эмэгтэйд автобусан дотор заасан юм. Бид дүүргийн хурлаас буцаж яв бөгөөд ганцхан сул байсан суудал дээр би суугаад захиануудаа үзэж юм. Мэдээж, хамгийн түрүүнд унших захидал бол нялх Иваны зурагта нарын захидал байсан юм. Миний хажууд нэг нүд зураг уруу харж бай анзаарав мөн би дээш харахад настай эмэгтэйн нүдтэй тулгарав. Тэр руу харж инээмсэглэсэнээ цонх руу харав. Тэгээд тэрээр яг унтах гэж мэт нүдээ анив. 'Тэнгэрлэг Эцэг минь, би энэ эмэгтэйтэй ярихыг хүсч Надад туслаач' хэмээн би залбирав. Минутын дараа тэрээр нүдээ нэс цэх суув, энэ үед би хурдхан шиг 'тэр хоорхон байна уу?' хэмээн хэлс түүнд нялх Иваны зургийг үзүүлээд, гэр бүлийнхээ тухай ярьж эхлэв. Ү түүнээс хүүхдүүдийнх нь тухай асуухад түүний нүдэнд нулимс хурж, ох түүнийг ямар их үзэн яддаг хийгээд өөртэй нь юу ч хийхийг хүсдэггүй надад ярив. Тэрээр уйлж мөн би ч түүнтэй хамт уйлсан юм. Би түүнд төлөвлөгөөний талаар мөн Тэнгэрлэг Эцэг түүнийг мэддэг бөгөөд түү

Салбарууд болон Дүүргүүдэд Үйлчилж Байгаа Номлогч Нар

Олон номлогч нар салбар болон дүүрэгт үйлчилдэг. Хэдийгээр энэ гарын авлага нь хэсэг болон гадсуудад хамааралтайгаар бичсэн ч зарчмууд нь салбар болон дүүргүүдэд адил юм. Салбар болон дүүргийн удирдагч нартай ажиллаж байхад тань номлолын ерөнхийлөгч таныг аливаа тохируулга, зохицуулалт хийхэд танд зааварчлах болно.

Хэсгийн Номлогч Нар болон Удирдагчдаар Ашиглуул

"Миний Сайн Мэдээг Номло" нь Сүмийн бүрэн цагийн номлогч нарт зориулагдсан. Хэдий тийм ч үүн дотор заагддаг зарчим, сургаалууд нь Их Эзэний хаант улсыг байгуулахыг эрэлхийлж байгаа тэдгээр хэсгийн номлогч нар болон удирдагчдад бас тохиромжтой юм. Энэ гарын авлагаас тогтмол суралцах нь тэдэнд гишүүн номлогчийн үүрэг хариуцлагуудаа биелүүлэх боломжийг олгож, бүрэн цагийн номлогч нартай нэгдэн ажиллахад тусална.



Дан Жөүнс, энэ эрин үеийн хамгийн агуу номлогч нарын нэг, Уэлст сайн мэдээг номлодог.

Номлогчийн Хувьд Миний Зорилго Юу Вэ?

Таны Зорилго

Есүс Христэд итгэх итгэл, Түүний Цагаатгал, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах ба эцсээ хүртэл тэвчихээр дамжуулан сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь туслах байдлаар бусдыг Христэд ирэхэд нь урих.

Үүнийг Анхаар

- Номлогчийн хувьд миний зорилго юу вэ?
- Сайн мэдээ гэж юу вэ?
- Яагаад бид сайн мэдээг номлодог вэ?
- Бид яагаад хүч болон эрх мэдэлтэйгээр заах ёстой вэ?
- Сэргээлтийн захиас юу вэ? Яагаад энэ нь тийм чухал вэ?
- Бусдыг хөрвүүлэгдэхэд нь туслахад миний хүлээх үүрэг юу вэ?
- Өөрийгөө амжилттай номлогч мөн эсэхийг би яаж мэдэх вэ?

Есүс Христийн Сэргээгдсэн Сайн Мэдээг Заах Таны Үүрэг

Та хүмүүсээр хүрээлэгдсэн байдаг. Та гудамжинд тэдний хажуугаар гарч, тэдэнтэй гэрт нь очиж уулзан, тэдний дунд явдаг. Тэд бүгдээрээ Бурханы хүүхдүүд, таны ах, эгч дүүс юм. Бурхан таныг хайрладгийн нэгэн адил Тэр бас тэднийг хайрладаг. Эдгээр хүмүүсийн олон нь амьдралын зорилгыг эрж хайж байдаг. Тэд гэр бүлийнхээ төлөө санаа тавьдаг. Тэд бол Бурханы хүүхдүүд, Түүний мөнхийн гэр бүлийн гишүүд гэсэн мэдлэгээс ирэх хамаарлын мэдрэмж тэдэнд хэрэгтэй. Үнэт зүйлс хувирч, өөрчлөгдөж байдаг дэлхийд тэд аюулгүй байхыг

Тэмдэглэл

Тэмдэглэл

хүсдэг. Тэд “энэ дэлхийд амар амгаланг, ирэх дэлхийд мөнх амьдралыг” (С ба Г 59:23) хүсдэг хэдий ч, тэд “үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас үнэнээс хол байдаг” (С ба Г 123:12).

Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Есүс Христийн сайн мэдээ нь тэдний гэр бүлүүдийг адисалж, тэдний сүнслэг хэрэгцээнүүдийг ханган, мөн тэдний хамгийн их хүсч байгаа хүслүүдийг гүйцэлдүүлэхэд туслах болно. Хэдийгээр тэд яагаад гэдгийг мэдэхгүй байж болох ч гэсэн тэд алдаа, нүглүүдээс ирдэг гэм буруугийн мэдрэмжүүдээс хөнгөвчлөгдөх хэрэгтэй. Тэд нүглүүдийнхээ өршөөлийг хүлээн авах болон Ариун Сүнсний бэлгийг хүртсэнээр гэтэлгэлийн баяр хөөрийг амсах хэрэгтэй.

Есүс Христийн эрх мэдэлтэй төлөөлөгчийн хувьд та “гэтэлгэл Ариун Мессаяд мөн түүгээр дамжин ирдэг” бөгөөд хэн ч “Ариун Мессаягийн сайн үйл, нигүүлсэл, мөн ач ивээлээр биш л бол Бурханы дэргэд оршиж чадахгүй” (2 Нифай 2:6, 8) гэдгийг хүмүүст хүч болон эрх мэдлээр зааж чадна. Хүмүүс Есүс Христийн сайн мэдээг хүлээн зөвшөөрч, баптисмын ёслолууд болон гишүүний баталгааг санваарын эрх мэдлээр хүлээн авсан үедээ “үүрд зайлуулагдахгүй” (Мормоны ном, Эхний хуудас) гэдэгтэй итгэлтэй байж болно.



Есүс Христийн Цагаатгалын тухай таны ойлголт өсөхийн хэрээр сайн мэдээг хуваалцах хүсэл тань өсөн нэмэгдэх болно. Лихайн нэгэн адил та “эдгээр зүйлүүдийг газар дэлхийн оршин суугчдад мэдүүлэх нь агуу их . . . чухлыг” (2 Нифай 2:8) мэдрэх болно.

“Энэ сайн мэдээг бүх дэлхийд хүргэхийг Бурхан бидэнд зарлигласан юм. Энэ бол өнөөдөр биднийг нэгтгэх учиртай тэрхүү зорилго мөн. Дэлхийг өөрийг нь устгалд хүргэх гай гамшгаас зөвхөн сайн мэдээ л аврах болно. Зөвхөн сайн мэдээ л бүх арьстан, үндэстнүүдийг амар амгаланд нэгтгэх болно. Зөвхөн сайн мэдээ л хүмүүний гэр бүлд баяр хөөр, аз жаргал, авралыг авчрах болно” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон заажээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 167).

Та хүмүүст нүглүүдээсээ цэвэршихэд нь туслахад Есүс Христийг төлөөлөхөөр дуудагдсан билээ. Та тэднийг Есүс Христэд ирж, Түүний сэргээгдсэн сайн мэдээнд хөрвүүлэгдэхэд тэднийг урих аргаар үүнийг хийдэг. Тэд Аврагчид ирэхийн тулд наманчлалд хөтлөх Түүнд итгэх итгэлтэй байж—Түүний заадаг зүйлүүдэд нийцүүлэн, шаардлагатай өөрчлөлтүүдийг амьдралдаа гаргах ёстой. Та хүмүүст сэргээгдсэн сайн мэдээг тэдэнд Сүнсээр зааснаар мөн тэдний заадаг зүйлүүдийн дагуу амьдрах амлалтад тэднийг урих аргаар ийм итгэлийг хөгжүүлэхэд нь тусалж чадна. Энэ амлалтыг биелүүлэх нь тэднийг баптисмын гэрээ, гишүүний баталгаа болон Ариун Сүнсний үнэт бэлэг авахад бэлтгэдэг. Тэд “эгэл хүнээ” хойш тавьж, “Их Эзэн Христийн цагаатгалаар дамжин” (Мозая 3:19) Гэгээнтэн болдог.

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Та 1 Нифай 8, 11-т гардаг амьдралын модны үзэгдлийн тухай судлахдаа энэ хуудсан дээрх амьдралын модны зургийг сайн ажигла. Энэ үзэгдэлд амьдралын мод нь Бурханы хайрыг бэлэгддэг (1 Нифай 11:21–22-ыг үз).

- Жимсийг идсэний дараа Лихай юу хүссэн бэ? (1 Нифай 8:10–18-ыг үз.)
- Үзэгдэлд, уг жимснээс хүртэх боломжтой байхын тулд хүмүүс юу хийх хэрэгтэй байсан бэ? Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ? Амлалтууд болон гэрээнүүд нь биднийг эдгээр адислалуудыг хүртэхэд ямар арга замуудаар тусалдаг вэ?
- Бусдад сайн мэдээний үр жимсүүдийг олж, хүртэхэд нь туслахад номлогчийн хувьд таны үүрэг юу вэ?

Сайн Мэдээ Гэр Бүлүүдийг Адисалдаг

Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн захиас гэр бүлүүдийг адисалдаг. Сэргээлтийн улмаас бид гэр бүлүүдэд зориулсан Бурханы зорилгуудыг ойлгодог: “Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь гэр бүлийн холбоог нас барсны дараа мөнхжих боломжтой болгодог. Ариун сүмүүдэд гүйцэтгэдэг ариун нандин ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүмүүсийг Бурханы дэргэд эргэж очих, мөн гэр бүлүүдийг мөнхөд нэгдэх боломжтой болгодог” (Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг, Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил, товхимол х.1).

Дэлхий дээр гэр бүлийн холбоо нь бидний агуу баяр хөөрийн зарим нэгэн эх сурвалж байж чадна. Сатан гэр бүлийг олон талаас нь довтолж байна, үүний улмаас маш олон гэр бүл түүний хүч чармайлтаар устгагдаж байна. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний захиас нь эдүгээ болон үүрд мөнхөд нэгдэх боломжийг гэр бүлүүдэд олгодог. Гэр бүлүүд сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар амар амгалан, баяр хөөр болон энэ амьдралд хамаарал, холбоотойн мэдрэмжийг мэдэрч чадна. Гэр бүлүүд сайн мэдээний гэрлээр дамжуулан, үл ойлголцох байдал, зөрчил, сөргөлдөөн болон бэрхшээлүүдийг шийдвэрлэж чадна. Санал зөрөлдөөний улмаас хагаралд хүрсэн гэр бүлүүд наманчлал, уучлал, Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэлээр дамжин илааршиж чадна. “Их Эзэн Есүс Христийн сургаалуудад үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэр бүлүүд болон гэрлэлтүүд нь итгэл, залбирал, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр, амралт чөлөөт цагаа эрүүл саруул, идэвхтэй өнгөрүүлэх үйл ажиллагаан дээр үндэслэгдэж, оршин тогтнодог” (Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг, Залуу Эмэгтэйчүүдийн Хувийн Хөгжил Дэвшил, товхимол х.1).

Эцэг, эх, хүүхдүүд нь сайн мэдээгээр амьдрахад бие биенээ дэмжиж, улмаар санваарын сэргээгдсэн эрх мэдлээр гэр бүлийн нэгж болж, лацдан холбуулж чадах гэр бүлүүдийг олж, заахад хүч чармайлтаа дайчил.

*“Таны хийх Их Эзэний
ажлаас хамгийн чухал нь
өөрийн тань гэр орны дөрвөн
хананы дотор байх болно.”*

—ЕРӨНХИЙЛӨГЧ ХАРОЛД Б.ЛИ
THE TEACHINGS OF HAROLD B. LEE, SEL. CLYDE J.
WILLIAMS (1996), 280

Сүнсээр Заах нь

Есүс Христийн сайн мэдээ бол “итгэгч хүн бүрийг авралд хүргэх Бурханы хүч” (Ром 1:16) учраас сайн мэдээний Сэргээлтийн захиас нь Бурхан Тэргүүтний гурав дахь гишүүн Ариун Сүнсний хүч—тэнгэрлэг хүчээр заагддаг байх ёстой. Тэр нь Сүнс гэж нэрлэгдэх нь олонтаа бөгөөд Түүний үүргүүдийн нэг нь үнэнийг заах, мөн гэрчлэх явдал мөн. Та энэ хүчээр заасан үед Ариун Сүнс:

- Танд шинэ үнэнүүдийг зааж, судалсан сургаалуудыг тань танд сануулах болно (Иохан 14:26-г үз).
- Яг хэрэгтэй үед хэлэх үгсийг тань танд өгөх болно (С ба Г 84:85-ыг үз).
- Таны захиасыг заадаг хүмүүсийн тань зүрх сэтгэлд хүргэх болно (2 Нифай 33:1-ийг үз).
- Таны захиасын үнэнийг гэрчилж, таны үгсийг батлах болно (С ба Г 100:5–8-ыг үз).
- Өөрийн тань зааж байгаа хүмүүсийн хэрэгцээнүүдийг ялган танихад танд туслах болно (Алма 12:7-г үз).

Бусдад итгэлийг бий болгон төлөвшүүлэх тийм аргаар сайн мэдээний үнэнүүдийг заахад Сүнс амин чухал юм. Та Сүнсэнд итгэж найдах итгэлийг хөгжүүлэхийг хичээхдээ дараах зүйлүүдийг хийх хэрэгтэй:

- Сүнсний төлөө залбирах (С ба Г 42:14-ийг үз).
- Зүрх сэтгэлээ цэвэршүүлэх (С ба Г 112:28-ыг үз).
- Зарлигуудыг сахих (С ба Г 20:77, 79-ийг үз).
- Бурханы үгийг хичээнгүйлэн нөөцлөх (С ба Г 11:21; 84:85-ыг үз).
- Бусад хүмүүсийг таны захиасыг ойлгож, гэгээрсэн байхаар заах (С ба Г 50:13–22-ыг үз).
- Итгэлээ хөгжүүлэх (Моронай 10:7-г үз).

Таныг Их Эзэний тогтоосон шаардлагуудыг хангасан үед Сүнс танд өгөгдөх болно гэсэн амлалттайгаар таныг ариун дуудлагад тань онцгойлон адисалсан билээ. Сүнсний бэлгүүдийг таашаах нь таны хамгийн эрхэм чухал хүслүүдийн нэг мөн.

Таны Дуудлагын Хүч ба Эрх Мэдэл

Номлогч нар “[өөрсдийн] томилогдсон томилолтын тэрхүү хүчний дагуу баяр баясгалангийн баярт мэдээг, бүр үүрдийн сайн мэдээг тунхаглан” явах ёстой (С ба Г 79:1). Сайн мэдээг номлох эрх мэдэл танд бий. Хэрэв та санваар атгадаг бол үүний ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэл танд байдаг. Таныг энэхүү эрх мэдлийг залбиралтайгаар бас зохистойгоор ашиглахад та дуудлагынхаа бодит нотолгоо болсон Сүнсний хүчийг хүлээн авах болно. Энэхүү үүргээ биелүүлэхээс айх буюу ичиж зовох хэрэггүй. Та яг Мозаягийн хөвгүүд шиг Бурханы хүч болон эрх мэдлээр заах ёстой (Алма 17:2–3-ыг үз).

Та санваарын эрх мэдлээр онцгойлон адислагдахдаа Их Эзэнийг төлөөлөх эрх болон онцгой боломжийг хүлээн авсан байдаг. Энэхүү эрх мэдлийг дэлхийд нотолдог тохинууллын гэрчилгээг та хүлээн авсан билээ. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ: “Онцгойлон адислах нь шууд утга учраараа хийгдэж болно, энэ бол нүглээс, шунаг хүслээс, бүдүүлэг, дорд, хэрцгий, үнэ цэнэгүй буюу

бүдүүн хадуун бохир заваан бүхнээс онцгойлон адислах, бодол санаа болон үйл ажиллагааны илүү өндөр түвшин рүү дэлхийгээс онцгойлон адислах явдал мөн. Адислал нь итгэлтэйгээр гүйцэтгэх дээр үндэслэгдсэн нөхцөл юм” гэжээ (*The Teachings of Spencer W. Kimball*, ed. Edward L. Kimball [1982], 478).

Таны дуудлагатай хамт дуудлагынхаа дагуу зохистой амьдрах үүрэг хариуцлага ирдэг. Та Их Эзэний төлөөлөгчийн хувьд “итгэгч хүмүүст үлгэр дуурайл” (1 Тимот 4:12) байх ёстой. Бурханы зарлигуудын дагуу амьдрахыг хичээж, ариун сүмд өөрийн хийсэн гэрээнүүдийг сахь; судруудыг мэд; эелдэг боловсон, цаг баримталдаг, мөн найдвартай бай; биеэ авч явах, хувцаслалт, үс засалтын талаарх номлогчийн жишгүүдийг баримтал; өөртэйгөө хамт үйлчилдэг болон хамт ажилладаг хүмүүсийг хайрла. Үйлдэл бүртгээ Христийн нэрийг эрхэмлэж яв.

Эрх мэдлээс гадна та бас хүчийг ажилдаа ашигладаг. Таны хүлээж авсан эрх мэдэл хүч рүү хөтөлж болно. Чухамдаа, сүнсний хүч бол таны эрх мэдэл бодитойн нэг нотолгоо юм. Сүнсний хүч бол ажлаа илүү үр ашигтай хийх боломжийг танд олгож байгаа бэлэг юм.

Таныг ажиллаж, зааж байхад таны хүч, таны эрх мэдэл мэдэгдэхүйц байх ёстой. Таны хийдэг олон зүйлд хүч үзүүлэгдэж болно, тухайлбал:

- Яг тухайн үед Их Эзэн танд юу гэж хэлэх байсныг хэлэхийн тулд Сүнсээр удирдагддаг байх (С ба Г 84:85-ыг үз).
- Хаашаа явах, юу хийх талаараа удирдамж хүлээн авдаг байх (С ба Г 28:15; 31:11; 75:26–27-г үз).
- Сүнсний гэрчлэлээр батлагдсан өөрийн гэрчлэлтэй байх (2 Нифай 33:1; С ба Г 100:5–8-ыг үз).
- Авралын ёслолуудад оролцох (С ба Г 84:19–20-ийг үз).
- Хэрэв та ахлагч бол санваарын адислалууд өгөх (Иаков 5:14–15-ыг үз).
- Өөрийн хамт ажилладаг хүмүүстэй хамт мөн тэдний төлөө залбирдаг байх (Алма 6:6; 8:18–22; 10:7–11; 31:26–35; С ба Г 75:19-ийг үз).
- Их Эзэнийг, өөрийн гэр бүлийг, номлогч нөхдөө, түүнчлэн өөрийн үйлчилдэг хүмүүсийг хайрлах хайраа илэрхийлэх.

Судар Судлах

Та хүчийг хэрхэн хүлээн авдаг вэ?

Алма 17:2–3

С ба Г 53:3

1 Коринт 2:4

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Төлөөлөгчдийг томилж байгаа Христийн уран зургийг харж, дараа нь Иохан 15:1–16-г унш. Ямар арга замаар Христ жимсний мод байдаг вэ? Та хэрхэн тэр модны мөчир байдаг вэ? Таныг онцгойлон адисалсан нь энэ харилцаанд хэрхэн холбогдох вэ?

Тохинууллын гэрчилгээгээ дахин унш. Юу уншсан тухай мэдрэмжүүд болон бодол санаануудаа тэмдэглэ. Та нар энэ бүлгийг судлах бүртээ энэ үйл явцыг давт. Цаг хугацаа өнгөрөх тутам таны мэдрэмжүүд хэрхэн өөрчлөгдсөнийг ажигла.

Көртландын Ариун Сүмийг онцгойлон адислах залбирал болж, Бошиглогч Иосеф Смитэд бурханлиг нөлөөллөөр өгөгдсөн хэсгүүд болох Сургаал ба Гэрээний 109:13–15, 21–30, 38–39, 55–57-г судал. Иосеф Смит итгэлтэй хүмүүст ямар адислалууд хүссэн бэ?



Есүс Христийн Сайн Мэдээ

Есүс Христийн сайн мэдээ таны захиас, таны зорилго аль алиныг нь тодорхойлдог; чухамдаа энэ нь, номлогчийн ажил гэж юу вэ, мөн яагаад номлогчийн ажлыг хийдэг вэ гэдгийг хоёуланг нь тайлбарладаг. Аврагч Өөрийн сайн мэдээнд зарим нэг чухал үндсэн гол сургаалуудыг хамруулан тодорхойлжээ. Тэрээр Эцэгийнхээ хүслийг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн бөгөөд түүний Эцэг Түүнийг загалмай дээр өргөгдөхийн тулд дэлхий рүү илгээсэн юм. Түүний Цагаатгал болон Амилуулалтаар, бүх хүмүүс сайн буюу муу байсан өөрсдийн ажлаар шүүгдэхийн тулд Христийн өмнө зогсохоор дээш аваачигдах болно. Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, нүглүүдээ наманчлан, Христийн нэрээр баптисм хүртдэг хүмүүс Ариун Сүнсээр цэвэршиж чадна. Хэрэв тэд эцсээ хүртэл тэвчих юм бол эцсийн өдөр тэд Христийн өмнө толбогүй зогсож, Их Эзэний амралтад орох болно. Эцэгийн өмнө Христ тэднийг гэм буруугүйгээр байлгах болно. Тэрээр тэдний Зууч бөгөөд Өмгөөлөгч байх болно. Итгэлтэй байдалд эцсээ хүртэл тэвчээгүй хүмүүс “Эцэгийн шударга шүүхийн өмнө . . . улмаас галд хаягдах” болно (3 Нифай 27:13–22-ыг үз; 2 Нифай 31:10–21; 3 Нифай 11: 31–41; С ба Г 76:40–42, 50–53-тай харьцуул.)

Сайн мэдээний зорилго бол шүүлтийн өдөр хүмүүс Аврагчийн нигүүлслийг хүлээн авч болохын тулд тэднийг нүглүүдээс нь цэвэршүүлэх явдал мөн. Гиймээс, энэ номны гол буюу илүү чухал зүйл нь Есүс Христ болон Түүний Цагаатгалд итгэх итгэл, наманчлал баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах болон эцсээ хүртэл тэвчихээр дамжуулан сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь тэдэнд туслах замаар Христэд ирэхэд нь бусдыг урих явдал мөн.

Хувь хүмүүс болон гэр бүлүүд Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, нүглүүдээ наманчлахад тэд түүнийг дагаж эхэлдэг. Тэд баптис-

“Сайн мэдээний анхны зарчмуудыг номло—тэдэнд дахин дахин номло: тэдгээрийн талаарх шинэ үзэл санаанууд болон нэмэлт ойлголт та нарт илчлэгдэх болно. Та нар тэдгээрийн тухай ойлголтоо нэмэгдүүлж, тэдгээр нь та нарт илүү тодорхой болно. Тэгвэл та нар [өөрсдийнхөө] зааж байгаа хүмүүст тэдгээрийг илүү тодорхой ойлгуулах боломжтой болно.”

—ХАЙРУМ СМИТ
HISTORY OF THE CHURCH, 6:323

маар дамжуулан, мөн эдгээр ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдлийг Бурханаас хүлээн авсан хэн нэгнээс Ариун Сүнсний бэлэг хүлээн авснаар нүглүүдийнхээ ангижралыг хүлээж авдаг. Тэгээд тэд эцсээ хүртэл тэвчих буюу өөрөөр хэлбэл, тэд бүх амьдралынхаа туршид Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэн, наманчилж, мөн өөрсдийн хийсэн гэрээнүүдээ үргэлж шинэчилнэ гэсэн үг юм. Эдгээр нь зүгээр л амьдралдаа нэг удаа хийх алхмууд биш; харин эдгээр алхмуудыг бүх амьдралынхаа туршид давтахад улам илүү ихээр шагнаан урамшуулагч амьдралын загвар болдог. Чухамдаа энэ бол, ухамсрын амар амгаланг авчрах, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг Түүний дэргэд амьдрахаар эргэж очих боломжийг хангах, амьдралын тэрхүү цорын ганц арга зам мөн.

Есүс Христэд дуулгавартай байх нь насан туршийн амлалт юм. Итгэл, наманчлалыг хөгжүүлж, баптисм хүртэн, Христэд үйлчлэх шийдвэр төгс байдлаар, түүнчлэн Ариун Сүнсний бэлэг хүлээж авахаар дамжуулан, бид эдгэрэл, нүглүүдийн өршөөлийг, түүнчлэн Аврагч болон Түүний сайн мэдээн дэх бүрэн хөрвөлтийг хүлээн авч чадна.

Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал болон санваарын эрх мэдэл сэргээгдсэнийг заах замаар, Түүний заадаг зүйлүүдээр амьдрахад тэднийг урих замаар, түүнчлэн наманчлалаар дамжуулан Есүс Христэд итгэх итгэлтэй болоход нь хүмүүст тусал.

Судар Судлах

Сайн мэдээ буюу Христийн сургаал гэж юу вэ?

2 Нифай 31:10–21

3 Нифай 11:31–41

3 Нифай 27:13–22

Сэргээлтийн Захиас: Итгэлийн Суурь

Та хаана үйлчилж байгаа, эсвэл хэнд зааж байгаа нь хамаагүй, өөрийн заалтыг Есүс Христийн сайн мэдээний Сэргээлт дээр төвлөрүүл. “Есүс Христийн сайн мэдээ тун хэрэгтэй байгаа дэлхийд Сэргээлтийн захиасыг заасны тань төлөө Их Эзэн таныг адислах болно” (“Номлогчийн Ажлын Талаар Хэлэх Үг, Тэргүүн Зөвлөлийн Захидал,” 2002 оны 12-р сарын 11). Та номлогчийн хичээлүүд дэх сургаалуудыг судлахдаа, бидэнд нэг л захиас байдгийг: Бурхан орчин үеийн бошиглогчоор дамжуулан Христийн Цагаатгал дээр төвлөрдөг сайн мэдээний анхны зарчмууд болон ёслолуудаар амьдарснаар гүйцэлддэг авралын төлөвлөгөөний тухай мэдлэгийг сэргээснийг харах болно.

Өөрийн тань заадаг хүн бүр дараах зүйлийг ойлгосон байхад анхаар:

- Бурхан бол Тэнгэр дэх бидний Эцэг гарцаагүй мөн. Тэр бидэнд хайртай. Дэлхий дээрх хүн бүр Бурханы хүүхэд, Бурханы гэр бүлийн гишүүн юм. Бурханы Хүү Есүс Христ бол бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч.
- Тэнгэр дэх бидний хайрт Эцэг библийн түүхийн туршид Өөрийн сайн мэдээг бошиглогчдод илчлэх замаар Өөрийн хүүхдүүдтэй харилцаж ирсэн билээ. Харамсалтай нь, олон хүмүүс энэхүү сайн мэдээг эсэргүүцэж байлаа; тэр ч байтугай үүнийг хүлээн авсан хүмүүсийн зарим нь сайн мэдээний сургаалууд болон ёслолуудыг өөрчилж, итгэлгүй байдал хийгээд урвалтад автжээ.
- Тэнгэр дэх бидний Эцэг Өөрийн Хайрт Хүү Есүс Христийг дэлхий рүү илгээсэн юм. Тэрээр гайхамшгуудыг үйлдэж, Өөрийн сайн мэдээг зааж байлаа. Тэр Цагаатгалыг гүйцэлдүүлээд дараа нь амилсан билээ.

Тэмдэглэл

- Бурхан Анхны Үзэгдлээс эхлэн, Өөрийн хүүхдүүдэд хайранд хүрч эхэлсэн юм. Тэрээр Есүс Христийн сайн мэдээ болон Өөрийн санваарын эрх мэдлийг сэргээж, Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Өөрийн Сүмийг дэлхий дээр зохион байгуулсан билээ. Мормоны Ном бол энэхүү Сэргээлтийн итгэл үнэмшилтэй нотолгоо мөн.



Урвалт болон сэргээлтийн загварыг харахад нь та сонирхогчдод тусалж чадвал, хожмын үеийн Сэргээлт туйлын чухал байсныг ойлгоход тэд бэлтгэгдэх болно. Сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авах, сэргээгдсэн санваарын эрх мэдлээр авралын ёслолуудыг хүлээн авах, түүнчлэн мөнх амьдралд хүрэх замыг дагах хэрэгцээг тэд харах болно. Сүм бол ердөө л нэг өөр шашин биш, энэ бол ганцхан Америкийн сүм ч биш гэдгийг хүлээн зөвшөөрөхөд нь хүмүүст тусал. Харин энэ бол эхлэлээс илчлэгдэн, заагдаж байсан тэрхүү “сайн мэдээний бүрэн байдлын” (С ба Г 1:23) сэргээлт юм.

Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ бол Иосеф Смит бошиглогч байсны, мөн Есүс Христийн сайн мэдээ

сэргээгдсэний итгэл үнэмшилтэй нотолгоо мөн. Энэ бол манай шашны шаантаг чулуу, энэхүү захиасыг заах хамгийн хүчирхэг эх сурвалж мөн. Зарим чухал үнэнүүд, түүний дотор Бурхан бол бидний Эцэг, бид Түүний хүүхдүүд, бид төрөхөөсөө өмнө Түүнтэй хамт амьдарч байсан бөгөөд Христийн Цагаатгалаар дамжин, сайн мэдээний хуулиуд болон ёслолуудыг дуулгавартай дагаснаар Бурханы дэргэд үүрд мөнх хамт амьдарч чадах тухай мэдлэг Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн юм.

Мормоны Ном бол Өөрийн хүүхдүүдийг хайрлах Бурханы хайрын нотолгоо мөн. Бурхан Өөрийн хүүхдүүдэд хандан ярьдгийг энэ ном харуулдаг. Та зааж, гэрчлэхдээ Мормоны номыг уншиж, үүний захиасын талаар залбирахад хүмүүсийг урь. Таны заадаг хүн бүр Мормоны Номыг Бурханы илчлэлт хэмээн хүлээж авахаа шийдэх ёстой.

Моронай 10:3–5 дахь гайхамшигт амлалтад итгэ. Энэ номыг уншиж, үүнийг ойлгох, энэ нь үнэн болохыг Бурханаас чин сэтгэлээсээ асуухыг ойлгон сэнхрүүлэхэд чадах бүхнээ хий. Ариун Сүнсний гэрчлэл нь Христ Өөрийн Сүмийг сэргээсэн гэдэгт итгэх тэдний итгэлийн суурийн чулуу болдог. Сүнсний баталгааг хүлээн авахад нь заадаг хүмүүстээ тусал.

Судар Судлах

Та номлогчийнхоо ажилд Мормоны Номыг хэрхэн ашиглах ёстой вэ?

1 Нифай 13:39

Моронай 10:3–5

С баГ 42:12–14

2 Нифай 29:8–10

С ба Г 20:5–16

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Та орон нутгийн сонинд зориулж Сэргээлтийн захиасын тухай өгүүлэл бичих боллоо гэж бод. Гол захиасыг дүрсэлсэн гарчиг-нэрийг судлах тэмдэглэлдээ бич. Тэгээд энэ захиасын тухай, түүний дотор ойлголт тань таны амьдралын замыг хэрхэн өөрчилсөн хийгээд өөрийнхөө эргэн тойрон дахь дэлхийг үзэх үзлийн тухай өөрийн бодол санаанууд болон мэдрэмжүүдийг тэмдэглэ.

Амлалтуудаа Биелүүлэхэд нь Бусдад Туслах нь: Итгэл болон Наманчлалд Хүрэх Зам

Үнэн сургаалыг тэдэнд зааж, наманчлалд тэднийг урих замаар Есүс Христэд итгэх тэдний итгэлийг төлөвшүүлдэг амлалтуудыг хийж, сахихаар дамжуулан амьдралаа өөрчилснөөр баптисм болон гишүүний баталгаанд тэнцэхэд нь хүмүүст тусал. Эдгээр амлалтууд нь хүмүүсийг нандин гэрээнүүдийг хийж, сахихад бэлтгэдэг.

Ахлагч Жеффри Холланд заахдаа: “Сонирхогч Мормоны Номыг уншаагүй, эсвэл үүний тухай залбираагүйгээ танд хэлэх үед таны байдал нэн гунигтай байх болно! . . . Ихэнх тохиолдолд, энэ бүхний тухайд бид ч бас туйлын гунигтай байдаг. Энэ бол мөнх амьдрал юм. Энэ бол Бурханы хүүхдүүдийн аврал юм. Сонирхогчийн мөнхийн ирээдүй түүний юу хийхээр сонгосноос хамаардаг. . . . Энэ бол энэ сонирхогчийн нэгэн цагт алхах хамгийн чухал зам мөн. Хэдийгээр тэр үүнийг мэдэхгүй байж болох ч гэсэн, та үүнийг мэдэж байгаа шүү дээ! . . . Тийм болохоор энэ нөхцөлд хяналт тавь. Хүч болон эрх мэдэлтэйгээр зааж, тэгээд хэрэв амлалт авч түүнийгээ биелүүлж байх талаар амжилттай биш болж эхэлбэл, гунигла” гэжээ (“Making and Keeping Covenants,” missionary satellite broadcast, 1997оны 4-р сар).

Сайн мэдээний бүрэн байдлын Сэргээлтийг ойлгуулахаар хүмүүст заахдаа та “наманчлалыг тунхагладаг” (С ба Г 15:6). Наманчлал нь зүрх сэтгэлээ өөрчлөх, нүглээ орхих, Бурханд үйлчлэх хүслийг өөртөө багтаадаг. Энэ нь Сүнсэнд өөрийгөө даруухнаар тавин өгч, Бурханы хүсэлд захирагдахыг өөртөө багтаадаг. Энэ нь Бурханы хүсэлд нийцүүлэн амьдрах өөрийн шийдвэр төгс байдлыг дээшлүүлэхийг хүмүүсээс шаарддаг. Наманчлал нь бодол санаа, хүсэл эрмэлзэл, дадал зуршил болон үйлдлийн чин сэтгэлийн хийгээд өнө удаан өөрчлөлтийг шаарддаг. Наманчлахын тулд тэд юу хийх ёстойгоо ойлгоход нь хүмүүст туслахдаа зоригтой, хайраар дүүрэн бай. Амлалтуудаа хийхэд нь хүмүүсийг урьснаар, сэрэмжлүүлгийн болон найдварын дуу хоолой аль алиныг нь та үр ашигтайгаар өргөж чадна.

Судар Судлах**Наманчлалыг тунхаглах талаар эдгээр судрууд юу заадаг вэ?**

Алма 29:1–4

Алма 62:45

С ба Г 15:6; 16:6

Алма 42:31

С ба Г 14:8

Баптисм ба Гишүүний Баталгаа

Өөрийн заадаг хүмүүст баптисм хүртээж, гишүүнээр батлуулах нь таны зорилгын гол зүйл мөн. Баптисм нүглүүдийн ангижралын төлөө байдаг бөгөөд Ариун Сүнсний бэлэг нь үүний хувьд зохистойгоор амьдардаг хүмүүст үй олон адислал авчирдаг. Эдгээр ёслолуудаар дамжин хүмүүс мөнх амьдралд хүрэх хаалга уруу орж, тэгээд энэ зам дээр цааш үргэлжлүүлдэг. “Бид хүмүүсийг Сүмд

Тэмдэглэл

авчрахын төлөө юм уу, эсвэл Сүмийн гишүүнчлэлийг нэмэгдүүлэхийн тулд номлодог буюу заадаггүй. Зөвхөн илүү сайн амьдралаар амьдрахад нь хүмүүст ойлгуулан сэнхрүүлэх гэж бид номлодог буюу заадаггүй. . . . Сэлэстиэл хаант улсын хаалгуудыг Бурханы хөвгүүд болон охидод нээхийн тулд наманчлал, баптисм, гишүүний баталгаагаар Христэд ирэхэд бид бүхнийг урьдаг. Өөр хэн ч үүнийг хийж чадахгүй” гэж Ахлагч Даллин Х.Өүкс хэлжээ (“The Purpose of Missionary Work,” missionary satellite broadcast, 1995 оны 4-р сар).

Та сэргээгдсэн сайн мэдээг заахдаа, баптисм болон гишүүний баталгааны ариун мөн чанарыг ойлгоход нь хүмүүст тусал. Ариун Сүнсний бэлэг хүлээж авах нь энэ амьдралд агуу адислал, түүнчлэн тэдний авралын түлхүүр байдгийг мэдэхэд нь тэдэнд тусал. Ариун Сүнс [тэдэнд] “бүх зүйлийг заах” болно (Иохан 14:26). “Та сонирхогчдод зааж, тэднийг усаар хийх баптисмд бэлтгэхдээ, бас Ариун Сүнсний бэлэг—галын баптисмын тухай бодох ёстой. Үүнийг нэг л өгүүлбэр гэж бод. Эхлээд усны баптисм ирж, дараа нь галын баптисм ирдэг” гэж Ерөнхийлөгч Бойд К.Пакер сургажээ (“The Gift of the Holy Ghost: What Every Missionary Should Know—and Every Member As Well,” seminar for new mission presidents, 2003 оны 6-р сар). “Усны баптисм бол хагас баптисм юм, Ариун Сүнсний баптисм болох нөгөө хагасгүйгээр энэ нь хэрэггүй юм” гэж Бошиглогч Иосеф Смит сургасан байдаг (*History of the Church*, 5:499).

Баптисм болон гишүүний баталгаанд тэнцэхийн тулд тэд Сургаал ба Гэрээ 20:37-д өгөгдсөн нөхцөлүүдийг хангах ёстойг ойлгоход нь заадаг хүмүүстээ тусал.

С ба Г 20:7: Баптисмд Тэнцэх нь

- Бурханы өмнө өөрсдийгөө даруусгах.
- Баптисм хүртэх хүсэлтэй байх.
- Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр ирэх.
- Бүх нүглүүдээ наманчлах.
- Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авах хүсэлтэй байх.
- Эцсээ хүртэл Бурханд үйлчлэх шийдвэр төгс байх.
- Нүглүүдийнхээ ангижралын төлөө тэд Христийн Сүнсийг хүлээн авснаа ажил үйлсээрээ харуулах.

Зохистой хөрвөгчид баптисм хүртсэнийхээ дараа тэд Сүмийн гишүүнээр батлагдаж, ариун Сүнсний бэлэг тэдэнд өгөгддөг. Гишүүний энэ баталгаа баптисмын дараа удалгүй ариун ёслолын цуглаан дээр бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн чиглүүлэл дор болдог. Энэ хоёр ёслол богинохон хугацаагаар тусгаарлагддаг бөгөөд гишүүний баталгаа нь баптисм дээр нэмэгдэж, үүнийг дуусгавар болгодог.

Судар Судлах

Ариун сүнсний бэлэг ямар байдлаараа бидний хүлээн авч чадах хамгийн агуу бэлгүүдийн нэг болдог вэ?

3 Нифай 19:1–13

Иохан 3:5

Галат 5:22–25

С ба Г 45:56–57

Иохан 14:26

Guide to the Scriptures, “Holy Ghost”

Хөрвөгчид яагаад Ариун Сүнсний бэлэг авахыг хүсдэг вэ?

2 Нифай 31:12–17

Үйлс 8:14–17

Үйлс 19:1–6

2 Нифай 32:1–5

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Дараах судруудыг судалж, тэнцэх зүйлүүдийн болон баптисмын гэрээнүүдийн жагсаалт гарга. Бусдад тавих эдгээр шаардлагуудыг хэрхэн заах талаар хамтрагчтайгаа ярилц.

2 Нифай 31:13
Мозая 18:8–10

Алма 7: 14–16
3 Нифай 11:21–41

Моронай 6:1–4
С ба Г 20:37

Сүмийг Төлөвшүүлэх нь

Хүмүүс баптисм хүртэж, Сүмийн гишүүнээр батлуулсан үед, эдгээр шинэ хөрвөгчид шинэ амьдралдаа зохицож, сүнслэг байдлынхаа өсөлтийг үргэлжлүүлэхэд нь туслахын тулд хэсгийн удирдагчид болон гишүүдтэй хамтран ажиллахаа үргэлжлүүл. Гэрчлэлтэй хүмүүс баптисм хүртэж, гишүүнээр батлуулан, гэрээнүүдээ сахиж, ариун сүмд явахаар идэвхтэй бэлтгэн, хэсэг буюу салбарыг бэхжүүлэхэд туслахын хэрээр Сүм төлөвшдөг.

Үүрэгт ажил өгсөн, гишүүн найз нартай хөрвөгчид, түүнчлэн Бурханы үгээр тэжээгдэж байгаа хүмүүс гэрчлэл болон итгэлдээ өсөх болно. Номлогч нар, хэсгийн удирдагчид, түүнчлэн Сүмийн гишүүд шинэ гишүүдийг цэнэглэн, хүчирхэгжүүлэх ажлаас зайлсхийх ёсгүй.

Амжилттай Номлогч

Номлогчийн хувьд таны амжилт нь хүмүүсийг олж, заан, баптисм хүртээж, гишүүнээр батлуулах, түүнчлэн Ариун Сүнсний оршихуйг эдэлдэг Сүмийн итгэлтэй гишүүд болоход нь туслахад гаргасан таны хүч чармайлтаар үндсэндээ хэмжигддэг.

Өөрийгөө бусад номлогч нартай харьцуулахаас, түүнчлэн өөрийнхөө хүч чармайлтын харагдахуйц үр дүнг тэднийхтэй жишиж хэмжихээс зайлсхий. Өөрийн тань захиасыг хүлээн авах уу, үгүй юү гэдэг тухайд хүмүүс сонголттойг санагтун. Таны үүрэг бол, тэд зөв сонголт хийж чадахуйцаар тодорхой, хүч нөлөөтэйгөөр заах явдал мөн. Зарим хүмүүс бүр энэ нь үнэн гэсэн сүнсний гэрчлэл хүлээн авсан үедээ ч, таны захиасыг хүлээн авахгүй байж болно. Та тэднийг хайрладаг мөн тэдний авралыг хүсдэг учраас та гунигтай байх болно. Гэвч та санаагаар унах ёсгүй. Санаагаар унах нь итгэлийг тань сулруулах болно. Хэрэв та хүсэн хүлээсэн зүйлээ доошлуулах юм бол, таны үр ашиг буурах болно, улмаар Сүнсийг дагахад бүр хэцүү болно.

Дараах тохиолдолд та амжилттай номлогч байна гэдгээ мэдэж болно:

- Танаар дамжуулан Сүнс хүмүүст гэрчилдгийг мэд.
- Хүмүүст хайртай бай, тэдний авралыг хүс.
- Номлогчийн дүрмүүдийг ширхэгчлэн дуулгавартай дага.
- Хаашаа явах, юу хийх, юу хэлэхийг өөрт тань үзүүлэх Ариун Сүнсийг хүлээн авч түүнийг хэрхэн дагахыг мэдэж чадахуйцаар амьдар.
- Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүл.
- Өдөр бүр үр ашигтай ажилла, бодгалиудыг Христэд авчрахын төлөө чадах бүхнээ хий, суралцаж, сайжрахыг чин сэтгэлээсээ эрэлхийл.
- Та хаана ч ажиллахаар томилогдлоо гэсэн Сүмийг (хэсгийг) төлөвшүүлэхэд тусал.

Тэмдэглэл

Тэмдэглэл

- Нүглийн үр дагавруудаас хүмүүсийг сэрэмжлүүл. Амлалт авч, биелүүлэхэд тэднийг урь.
- Бусад номлогч нарт зааж, үйлчил.
- Тэд захиасыг тань хүлээн авсан, аваагүй хамаагүй, боломж олдох бүрт сайныг үйлдэж, хүмүүст үйлчилж яв.

Та чадах бүхнээ хийсэн ч, та мөн л сэтгэл дундуур байж болно, гэвч та өөртөө сэтгэл дундуур байхгүй байх болно. Өөрөөр тань дамжуулан Сүнс ажиллаж байгааг мэдэрсэн цагт Их Эзэн баярладгийг та тодорхой мэдэрч чадна.

Судар Судлах

Их Эзэний үйлчлэгчид ажлынхаа талаар ямар бодолтой байдаг вэ? Өөрсдийнхөө үйлчилдэг хүмүүст Их Эзэний үйлчлэгчид хэрхэн нөлөөлдөг вэ?

Мозая 28:3

Нифай 28:4–10

С ба Г 68:2–6

Алма 8:14–15

Ифэр 12:13–15

Хиламан 10:3–5

С ба Г 15:4–6; 16:4–6

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

- Хиламан 10:1–5, 3 Нифай 7:17–18-ыг унш. Эдгээр номлогч нар, тэдний үйлчлэлийн талаар Их Эзэн ямар бодолтой байсан бэ?
- Абинадай, Аммон нарын номлогчийн хүч чармайлтуудын талаар бод (Мозая 11–18; Алма 17–20, 23–24-ийг үз). Тэдний хүч чармайлтын тэр даруйд гарсан үр дүн өөр өөр байсан хэдий ч, яагаад тэр хоёр номлогч хоёул амжилттай байсан бэ?
- Юу сурснаа судлах тэмдэглэлдээ тэмдэглэ.

Үүнийг Сана

- Таны зорилго бол Есүс Христэд итгэх итгэл, Түүний Цагаатгал, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах хийгээд эцсээ хүртэл тэвчихээр дамжин сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь тэдэнд туслах замаар Христэд ирэхэд нь бусдыг урих явдал мөн.
- Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ бол бид мөнхийн аз жаргалыг үүгээр олж болох цорын ганц арга зам мөн.
- Дуудлага тань танд эрх мэдэл өгдөг, гэрээнүүдээ сахих нь танд хүчийг өгдөг.
- Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн билээ. Мормоны ном бол Иосеф Смит бошиглогч байсны нотолгоо мөн.
- Тэднийг амлалт авч, биелүүлэхэд урьснаар сайн мэдээгээр амьдрахад нь та хүмүүст тусалдаг.
- Хүмүүсийг түүнд авчирснаар та Их Эзэнийг хайрлах хайраа, Түүний Цагаатгалын төлөөх талархлаа харуулдаг.
- Та дуулгавартай байж, зөв шударгаар амьдран, сайн мэдээгээр амьдрахад нь бусдад туслахын тулд чадах бүхнээ хийж байгаа үед та амжилт гаргадаг.

Номлогчийн Ажил

Дараах нотолгоонуудыг энэ эрин үед Сүмийн Ерөнхийлөгчид хийжээ.

Ерөнхийлөгч Иосеф Смит (1830–1844)

“Эцсийн эцэст, хамгийн агуу, хамгийн ач холбогдолтой үүрэг бол Сайн Мэдээг номлох явдал мөн” (*Teachings of the Prophet Joseph Smith*, sel. Joseph Fielding Smith [1976], 113).

“Агуу зүйлүүд тэдний хүч чармайлтаас хамаардгийг Гэгээнтнүүд санаг, мөн эцсийн өдрүүдийн агуу ажлыг гүйцэлдүүлэхэд тэд бидэнтэй болон Ариун Сүнстэй хамтран ажиллагсад байхаар дуудагдсан юм” (*Teachings of the Prophet Joseph Smith*, 178–79).

Ерөнхийлөгч Бригам Янг (1847–1877)

“Номлолд байдаггүй эрэгтэй ч, эмэгтэй ч энэ Сүмд үгүй. Энэхүү номлол тэдний насан турш үргэлжилдэг, мөн энэ нь сайныг үйлдэх, зөв шударга ёсыг хөхүүлэн дэмжих, үнэний зарчмуудыг заах, түүнчлэн тэд мөнх амьдралыг олж авч болох зарчмуудаар амьдрах амьдралыг өөрсөддөө болон эргэн тойрныхоо бүх хүмүүст олж авах явдал мөн” (*Discourses of Brigham Young*, sel. John A. Widtsoe [1954], 322).

Ерөнхийлөгч Жон Тейлор (1880–1887)

“Бидний үүрэг бол сайн мэдээг бүх хүмүүст заах явдал мөн. . . . Энэ бол Бурхан биднээс хүсэн хүлээдэг тэр зүйл юм” (*The Gospel Kingdom*, sel. G. Homer Durham [1943], 234–35).

Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф (1889–1898)

“Бид энэ дэлхийд номлохоор ирсэн юм; . . . ингэснээр урагш одож, дэлхийн үндэстнүүдэд сэрэмжлүүлэх хүч бидэнд бий. . . . Израилын ахлагчдын хувьд бидний цөөн хэдхэн нь бидний албан тушаал, бидний дуудлага, Бурхантай харилцах бидний харилцаа, бидний үүрэг хариуцлага, эсвэл бидний гараас Их Эзэн шаарддаг тэрхүү ажлыг бүрэн дүүрэн ухамсарлан ойлгодог” (*The Discourses of Wilford Woodruff*, sel. G. Homer Durham [1946], 124).

Ерөнхийлөгч Лорензо Снөү (1898–1901)

“Их Эзэний хүүхдүүд болох хүмүүст номлохоор түүнийг Их Эзэн илгээхэд уг ахлагч сайн мэдээг номлоход олсон амжилтыг нь өдий их сонирхдог мөнх бус хүн гэж үгүй” (*The Teachings of Lorenzo Snow*, comp. Clyde J. Williams [1984], 70).

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1901–1918)

“Дэлхийд бидэнд нэг үүрэг зорилго бий: эрэгтэй хүн бүр, эмэгтэй хүн бүр, ойлголтод хүрч өссөн буюу хариуцлагын насанд хүрсэн хүүхэд бүр . . . үнэний тухай гэрчлэлээ хэлэх, үнэнийг номлоход мэргэшсэн байх ёстой” (*Gospel Doctrine*, 13 дахь хэвлэл. [1968], 251–52).

Ерөнхийлөгч Хибер Ж.Грант (1918–1945)

“Хүмүүсийн хувьд бидэнд хийх нэг онцгой эрхэм зүйл бий, энэ бол нүглээ наманчилж, Бурханд ирэхэд дэлхийг уриалан дуудах явдал мөн. Урагш одож, Их Эзэн Есүс Христийн сайн мэдээг, амьдралын болон авралын төлөвлөгөө дэлхий дахинд сэргээгдсэнийг тунхаглах нь бидний бүхнээс илүү эрхэм үүрэг мөн. . . . Агуу үнэт сувд үнэхээр бидэнд бий. Дэлхийн эзэмшдэг бүх баялаг хийгээд шинжлэх ухааны мэдээллээс илүү үнэ цэнэтэй зүйл бидэнд бий. Амьдралын болон авралын төлөвлөгөө бидэнд бий. . . . Хөршийгөө хайрлах өөрсдийн хайрыг дэлхийд харуулах

хамгийн сайн арга бол урагш одож, үүний бурханлиг чанарын тухай туйлын мэдлэгийг тэрээр бидэнд өгсөн Их Эзэн Есүс Христийн сайн мэдээг тунхаглах явдал мөн” (Conference Report, 1927 оны 4-р сар, 175–76).

Ерөнхийлөгч Жорж Алберт Смит (1945–1951)

“Энэ бол та нарын үүрэг зорилго, Сүмийн ах, эгч нар минь, энэ бол та нарын үүрэг хариуцлага. Та нар үнэгүйгээр хүлээж авсан, мөн эдгээр алдар суут үнэнүүдийг Түүний бусад хөвгүүд, охидтой үнэгүйгээр хуваалцахыг Тэнгэрлэг Эцэг маань та нараас хүсэн хүлээх болно” (*Sharing the Gospel with Others*, түүвэрлэсэн, Preston Nibley [1948], 213).

“Бид Есүс Христийн Сайн Мэдээний адислалуудыг Эцэгийнхээ бусад хүүхдүүдтэй хуваалцаж, эндэх болон үүний дараах бидний амьдралыг баялаг болгох зарлигуудыг сахисан нөхцөлд л зөвхөн Сэлэстиэл Хаант улс дахь өөрсдийн өргөмжлөлийг хүртэх болно” (*Sharing the Gospel with Others*, 190).

Ерөнхийлөгч Давид О.МакКей (1951–1970)

“Гишүүн бүр . . . номлогч!” (Conference Report, 1959 оны 4-р сар, 122).

“Христийн үнэн шашин бол үйлдэл дэх хайр юм. Өөрсдийн нөхдийг хайрлах амь биеэ үл бодох хайрыг харуулахаас илүүгээр Бурханыг хайрлах хайраа харуулах илүү сайн арга зам гэж үгүй. Энэ бол номлогчийн ажлын сүнс юм” (*Gospel Ideals* [1954], 129).

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1970–1972)

“Бид бүгдээрээ номлогч нар гэдгийг бид сонссон. Гишүүн бүр . . . номлогч байх ёстой, . . . Сүмийн гишүүдийн хувьд бид Есүс Христийн сайн мэдээний амжилт өөд өөрсдийгөө дайчилснаар номлогч нар болдог. Энэ бол Сүмийн гишүүн бүрийн үүрэг хариуцлагын хэсэг мөн” (*Take Heed to Yourselves* [1971], 27–28).

Ерөнхийлөгч Харолд Б.Ли (1972–1973)

“Номлогчийн ажил бол эдүгээ Сүмийн гишүүдэд заах гэрийн багшийн ажил бөгөөд гэрийн багшлалт бол Сүмийн гишүүдэд хандсан номлогчийн ажлаас илүү ч биш, дутуу ч биш зүйл юм” (*Improvement Era*, 1964 оны 12-р сар, 1078).

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1973–1985)

“Өнөө үе бол сайн мэдээг өмнө нь хэзээ ч хүргэж байгаагүй тийм алс холд хүргэх Их Эзэний цаг үе юм. . . . Энэ дэлхийд хүмүүний олон нь учрыг мэдээд, бас учрыг мэдэлгүйгээр, ‘Ирээч . . . бидэнд туслаач’ хэмээн гуйж байна. Тэр бол танай хөрш байж болно. Тэр бол найз тань байж болно. Тэр бол садан хамаатан тань байж болно. Тэр бол ердөө өчигдөрхөн таны танилцсан хүн байж болно. Гэтэл тэдэнд хэрэгтэй зүйл бидэнд байдаг. Петрийн нэгэн адил, ‘Одоо, Эзээн, . . . таны үгийг ярих зориг зүрхийг Өөрийнхөө үйлчлэгчид соёрхооч’ (Үйлс 4:29) хэмээн өөрсдийн сурснаас шинэ зориг авч, залбирцгаая” (*Teachings of Spencer W. Kimball* [1982], 546).

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1985–1994)

“Бид сайн мэдээг бусадтай хуваалцах ёстой. Гишүүн бүр номлогч байх нь бидний үүрэг хариуцлага. Энэ бол Бурханы бошиглогчдоос бидэнд өгдөг дуудлага. . .

Гишүүн-номлогчийн ажил бол манай гишүүдийн хувьд хүний өсөлтийн агуу түлхүүрүүдийн нэг мөн. Гишүүн-номлогчийн ажил үүнийг хэрэглэдэг аль ч хэсэгт сүнслэг байдлыг өргөнө гэдэг нь миний итгэл үнэмшил юм” (*Teachings of Ezra Taft Benson*, 208–9).

Ерөнхийлөгч Ховард В.Хантер (1994–1995)

“Сайн мэдээг бүх үндэстэн, хэлтэн, хүмүүст баттай хүргэх нь мөнх бус байдал дахь бидний цорын ганц хамгийн агуу үүрэг хариуцлага мөн. . . . Өмнөх зарим эрин үеүдэд байснаас эсрэгээр, сайн мэдээг бүх дэлхийд хүргэхэд туслах онцгой боломжтойгоор бид энэхүү эцсийн өдрүүдэд төрсөн билээ” (“Walls of the Mind,” *Ensign*, 1990 оны 9-р сар, 10).

“Цагаатгал номлогчийн ажилтай юугаараа холбогддог вэ? Ямар ч цаг үед бид Цагаатгалын адислалуудыг өөрсөд дээрээ амсдаг, тусалж чадахгүй байлаа гэхэд бид бусдыг халамжлах талаар санаа тавьдаг. . . . Хувь хүний хөрвүүлгийн нэг чухал үзүүлэлт бол сайн мэдээг бусадтай хуваалцах хүсэл юм” (“The Atonement and Missionary Work,” номлолын шинэ ерөнхийлөгчдөд зориулсан семинар, 1994 оны 6-р сар).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1995—)

“Бид Түүний ажил болон Түүний алдар сууд Эцэгтээ туслахын тулд ‘хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрахад’ (Моисе 1:39) туслахын тулд энд байгаа билээ. Та нарын үүрэг хариуцлагын хүрээн дэх өөрсдийн тань үүрэг миний үүрэг хариуцлагын хүрээн дэх миний үүргийн нэгэн адил чухал юм” (Conference Report, 1995 оны 4-р сар, 94; *Ensign*, 1995 оны 5-р сар, 71)

“Бусдыг үнэний мэдлэгт авчрахын төлөө гишүүн бүрийн зүрх сэтгэлийн чадавхид ухамсрын сонирхол суулгагдах болтугай. Тэрээр үүн дээр ажиллаг. Тэрээр энэ тухай нэгэн үзүүрт агуу сэтгэлээр залбираг” (“Find the Lambs, Feed the Sheep,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 106).

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- Энэ бүлгийн эхэн дэх хэсгээр нэгээс хоёр минутын яриа бэлтгэ. Яриаг хамтрагчтайгаа буюу дүүргийн хурал дээр бусад номлогч нартай хуваалцахаар бэлтгэ.
- Өөрсдийнхөө хөрвүүлгийн түүхийг ярихыг саяхны хөрвөгчдөөс хүс. “Наманчлалд хүргэх итгэлийг” (Алма 34:17) олж авахад тэдэнд юу тусалсан бэ? Та яагаад баптисм хүртэж, гишүүнээр батлуулахаар шийдсэн бэ? Сүмийн шинэ гишүүд болсон нь тэдэнд ямар санагдсан бэ? Номлогч нар тэдэнд хэрхэн илүү сайн үйлчилж болох байсан бэ?
- Сэрэмжлүүлгийн дуу хоолойг өргөх гэсэн нь ямар утгатайг авч үз (Иаков 3:12; С ба Г 1:4; 38:41; 63:57–58; 88:81; 112:5; Езекиел 3:17–21; 33:1–12-ыг үз). Энэ нь таны хувьд юу гэсэн үг болох хийгээд үүнийг хийхийн тулд хэрхэн ажиллахаа өөрийн үгсээр бич.
- Мормон 8, Моронай 1 болон 10-ыг унш. Унших үедээ “Манай үеийн тухай Моронайн найдвар ямар байсан бол? Мормоны Номыг яахыг тэр биднээс хүссэн бэ? Хэрэв түүнтэй ярилцах боломж надад олдсон бол би Моронайд юу хэлэх байсан бэ? гэж өөрөөсөө асуу. Өөрийн санаа бодлуудыг судлах тэмдэглэлдээ бич.
- Иосеф Смит болон Сэргээлтийн тухай гэрчлэлийг тань бэхжүүлсэн, өөрийнхөө амьдралын үйл явдлуудыг авч үз. Тэгээд: Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф Смит дээр хүрч ирснийг мэдэхэд юу танд тусалсан бэ гэсэн асуултанд хариу бич.

Хамтрагчтайгаа Суралцах

- Бүлгийн эхэн дэх “Үүнийг Анхаар” хэсгийн асуултуудад өгсөн өөрийн хариултуудыг бие биентэйгээ хуваалц
- Номлолын дуудлага хүлээн авахад өөрийн тань найдвар, хүслүүд юу байсныг бие биентэйгээ хуваалц. Таны туршлага өөрийн тань хүсэн хүлээж байсан зүйлүүдээс хэр зэрэг зөрөөтэй байна вэ? Та эдгээр хүсэн хүлээж байсан зүйлүүдээ хэр зэрэг бүрэн дүүрэн хангаж чадах вэ?
- Guide to the Scriptures дахь “Ministry” гэдэг үгийг уншиж, ярилц.
- Дараах агуу номлогч нараас нэгийг нь сонгож, жагсаасан ишлэлүүдийг унш. Унших үедээ, энэ номлогч (1) дуудлагаа хэрхэн ойлгож, өөрийгөө үнд хэрхэн зориулсныг, (2) уг ажилд хандах хандлага, хүслээ хэрхэн харуулсныг, түүнчлэн (3) сайн мэдээг хүлээн авахад нь бусдад хэрхэн тусалсныг ярилц.
Алма (Мозая 18) Нифай, Лихай нар (Хиламан 5) Паул (Үйлс16)
Аарон (Алма 22; 23:1–6) Петр (Үйлс 2)
- “Сайн Мэдээний Сэргээлт” сэдвээр Дууллын номноос хоёр дуу сонгож ав (хуудас 424-ийг үз). Дууллуудыг унших буюу дуул. Үгсийн утгыг ярилц.
- Guide to the Scpirtures дахь “Faith,” “Repentance,” “Baptism,” “Holy Ghost”-ыг ийг хамтдаа унш. Сэдэв тус бүр дэх судрын бүх ишлэлийг уншиж, ярилц.
- Guide to the Scriptures дахь “Dispensations”-ыг хамтдаа унш. Сургаал ба Гэрээ 136:37-г бас хамт уншиж, ярилц.

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Хөрвүүлгийнхээ туршлагаас хуваалцахыг саяхны хоёр буюу гарван хөрвөгчөөс хүс. Номлогч нарын талаар, тэдний заасан зүйлийн талаар, амлалтуудаа биелүүлэх талаар тэд ямар бодолтой байсан бэ? Тэдний хөрвүүлэгт юу хамгийн хүчтэй нөлөөлсөн бэ?
- Танай бүсэд Сүмийг төлөвшүүлэх боломжууд хийгээд бэрхшээлүүдийн талаар номлогч нарт ярихыг санваартны нэг удирдагчаас хүс.
- Алма 18-ыг уншиж, дараах асуултуудыг ярилц: Уг түүхийн эхэнд Лэмонайн бодол санаа ямар байсан бэ? Тэд хэрхэн өөрчлөгдсөн бэ? Сайн мэдээний адислалуудыг хүлээн авахын тулд хүн ямар бодол санаатай байх ёстой вэ? Алма 34:15–16-г уншиж, үүнийг Лэмонайн түүхтэй харьцуул. Нигүүлслийг олж авах боломжийг Христийн Цагаатгал бидэнд хэрхэн олгосон бэ?
- Амжилттай номлогч байх нь юу гэсэн үг болохыг ярилц. Амжилтын тодорхой жишээнүүд гаргахад номлогч нарыг урь.
- Номлогч нарыг гурван бүлэгт хуваа. Нэг бүлэгт Үйлс 2:36–38-ыг (Петр) уншихаар, нөгөө бүлэгт Үйлс 16:25–33-ыг (Паул) уншихаар, сүүлчийн бүлэгт Мозая 18:8–11-ийг (Алма) уншихаар даалга. “Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэн, наманчилж, мөн баптисм болон гишүүний баталгааг хүлээн авахад нь бусдад туслахын тулд энэ номлогч юу хийсэн бэ?” гэсэн асуултад хариулахыг бүлэг бүрээс хүс. Наманчлах, баптисм хүртэх болон Ариун Сүнсийн бэлэг хүлээн авахад хүмүүсийг урих үед итгэлээ хөгжүүлэхэд нь тэдэнд тусалж чадсан эдгээр түүхүүдээс номлогч нар юу мэдэж авсныг ярилц.
- Хурлаас хэд хоногийн өмнө, бүлгийн эхэн дэх “Үүнийг Анхаар” хэсгээс сонгож авсан асуултуудыг тунгаан бодохыг хэдэн номлогч нарт даалга. Өөрт нь даалгасан асуултаар хоёроос гурван минутын яриа бэлтгэхийг номлогч бүрээс хүс. Дүүргийн хурал буюу бүсийн чуулганы үеэр бэлтгэсэн үгнүүдээ хэлэх боломжийг номлогч нарт олго. Үг хэлсний дараа тэд юу мэдэж авсан болон номлогчийн ажилд тэд үүнийг хэрхэн ашиглах тухай ярилц.
- Номлогч нарыг дөрвөн бүлэгт хуваа. Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн болон илчлэгдсэн үнэнүүд, гэрээнүүд хийгээд ёслолуудаас тэд хичнээнийг нэрлэж чадсанаараа жагсаалт хийхийг бүлэг бүрээс хүс. Жагсаалтыг нь бүлэг бүрээр хуваалцуул. Сэргээлтээр дамжуулан илчилсэн аль нэг үнэн амьдралд хэрхэн нөлөөлсөн тухай хуваалцахад номлогч нарыг урь.

Номлолын Ерөнхийлөгч

- Ярилцлагуудын үеэр дараах зүйлүүдийг өөртэйгөө хуваалцахыг номлогч нараас үе үе хүс.
 - Есүс Христийн тухай тэдний гэрчлэл
 - Сэргээгдсэн сайн мэдээний тухай болон Иосеф Смитийн үүрэг зорилгын тухай тэдний гэрчлэл
 - Мормоны Номны тухай тэдний гэрчлэл
 - Номлогчийн хувьд тэдний зорилгын талаарх тэдний санаа бодлууд
- Өөрсдийнх нь номлолын зорилго юу болох талаар тэд ямар бодол санаатай байдгийг судлах тэмдэглэлдээ тэмдэглэхэд номлогч нарыг урь. Ярилцлагын үед бичсэн зүйлээ хуваалцахыг тэднээс хүс.
- Шинэ гишүүдэд баяр хүргэсэн захидал илгээ.

Тэмдэглэл

Lined writing area for notes.



Би Хэрхэн Үр Ашигтайгаар Суралцаж, Заахад Бэлтгэх Вэ?

Тэмдэглэл

Үүнийг Анхаар

- Сайн мэдээг судлах нь яагаад чухал вэ?
- Заадаг хүмүүст маань миний судалгаа хэрхэн нөлөөлөх вэ?
- Яагаад би Есүс Христийн сайн мэдээний сургаалуудыг оюундаа байнга нөөцлөх хэрэгтэй вэ?
- Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний сургаалуудыг би хэрхэн үр ашигтайгаар суралцаж, бусдад заахад хэрхэн бэлтгэж чадах вэ?
- Хувиараа болон хамтрагчтайгаа суралцахыг би хэрхэн сайжруулж чадах вэ?

“**М**иний үгийг тунхаглахыг бүү эрэлхийл, харин эхлээд миний үгийг олж авахыг эрэлхийл, тэгвэл хэл тань чөлөөтэй болох болно; тэгээд хэрэв та хүсэх аваас, миний Сүнс мөн миний үг, тийм ээ, хүмүүнийг итгүүлэх Бурханы хүч чамд байх болно” (С ба Г 11:21) гэж Их Эзэн хэлжээ. Үр ашигтайгаар заахын тулд та сүнсний хүчийг олж авах хэрэгтэй. Таны хувьд сайн мэдээнд өсч хөгжин, мөнх амьдрал уруу хөтөлдөг зам дээр үлдэхийн тулд сайн мэдээг судалдаг дадал зуршлыг та хөгжүүлэх хэрэгтэй (С ба Г 131:6-г үз). Номлогчийн хувьд таны хөгжүүлэх суралцах дадал зуршил нь таныг хувь хүний хувьд адисалж, Аврагчид итгэх итгэлдээ өсөхөд нь заадаг хүмүүст тань туслах болно.

Өдөр бүр үр ашигтайгаар суралцах нь үргэлж залбирлаар эхлэх ёстой. Суралцах нь хувь хүний сонголтыг ашиглахыг шаарддаг итгэлийн үйлдэл юм. Хэрхэн үр ашигтайгаар суралцахыг мэдэхийн төлөө олон номлогч мэрийн чармайдаг. Зарим хүмүүс юуг, хэрхэн суралцахыг өөрсдөд нь хэлж өгөх бусад

хүмүүс буюу бүтцийг нь тодорхойлсон хөтөлбөрүүдэд ихэд найдлага тавьдаг. Сайн багшаас сурах нь их чухал ч гэсэн, утга учир бүхий өөрийн гэсэн суралцах туршлагатай байх нь илүү чухал юм. Судалгаанаасаа сайн үр дүнд хүрэх нь сурах хүчтэй хүсэлтэй байж, “үнэн хүсэлтэйгээр” (Моронай 10:4) сурахаас, “зөв шударга ёсны төлөө өлсөж, цангахаас,” (Матай 5:6) түүнчлэн сонирхогчдынхоо асуултууд, санаа зоволтуудын хариуг эрж хайхаас хамаарна.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Өмнөх хуудсан дээрх Иосеф Смитийн зургийг хар. Иосеф Смит—Түүх 1:11–13-ыг унш. Өөрийн судлах тэмдэглэл дэх дараах асуултуудад хариул.

- Иаков 1:5-ыг Иосеф Смит уншиж, тунгаан бодсон нь түүнийг илчлэлт хүлээн авахад хэрхэн хөтөлсөн бэ?
- Түүний судалгаа дараах үеийнхэнд нь хэрхэн нөлөөлсөн бэ?
- Судалж, эрж хайх түүний шийдвэр амьдралд тань ямар нөлөө үзүүлсэн бэ?
- Сайн мэдээг судалсан тань таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

Судар Судлах

Сайн мэдээг суралцахад ямар арга барилаар хандахыг Их Эзэн биднээс хүсдэг вэ?

2 Нифай 4:15–16

С ба Г 58:26–28

С ба Г 88:118

2 Нифай 32:3

Ариун Сүнсээр Сурах нь

Та Ариун Сүнсээр заалгуулж байхад сайн мэдээг судлах таны судалгаа хамгийн үр ашигтай байдаг. Ариун Сүнсээр өөртөө туслуулахын тулд сайн мэдээг судлахдаа үргэлж залбирлаар эхэлж бай. Тэрээр таны амьдралыг адислах мэдлэг болон итгэл үнэмшлийг авчирч, бусдын амьдралыг адислах боломжийг танд олгох болно. Есүс Христэд итгэх таны итгэл өсөн нэмэгдэх болно. Наманчлах, сайжрах таны хүсэл өсөн нэмэгдэх болно.

Ийм маягийн судалгаа таныг үйлчлэлд бэлтгэж, ая тухыг өгөн, асуудлуудыг шийдвэрлэж, эцсээ хүртэл тэвчих хүч чадлыг танд өгдөг. Сайн мэдээг амжилттай судлах нь хүсэл, үйлдлийг шаарддаг. “Учир нь хичээнгүйлэн хайгч тэр олох болно; мөн Бурханы нууцууд тэдэнд энэ цагт ч, хуучин цагийн адил, бас ирэх цагийн адилаар, бас ирэх цагт ч, Ариун Сүнсний хүчээр задлагдах болно” (1 Нифай 10:19). Иносын нэгэн адил та мөнх амьдралыг мэдэхийн төлөө өлссөн үед, мөн эдгээр үгсийг “зүрх сэтгэлдээ гүнзгий [шингэх] болгосон үед” (Инос 1:3), Ариун Сүнс таны оюун ухаан хийгээд илүү агуу гэрэл болоод ойлголтод нээх болно.

Сайн мэдээг судлах нь бас илчлэлт хүлээн авах үйл явц юм (Иаков 4:8-ыг үз). “Болгоогтун, чи ойлгосонгүй; чи надаас асуухаас өөрөөр санаа тавиагүй байхад



чинь, би үүнийг чамд өгөх юм шигээр чи бодсон байна. Гэвч, болгоогтун, би чамд хэлнэ, чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой, мөн энэ нь зөв аваас, цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно” (С ба Г 9:7–8) хэмээн Их Эзэн Оливер Каудерид хэлсэн байдаг. Суралцах үедээ оюун ухаанд тань ирэх санаанууд, зүрх сэтгэлд тань ирэх мэдрэмжүүдийг, ялангуяа заадаг хүмүүсийнхээ талаар нягт няхуур анхаарч бай.

Судар Судлах

Сайн мэдээг суралцахад бидэнд туслах Ариун Сүнсний үүрэг юу вэ?

2 Нифай 32:5

С ба Г 11:12–14

Иохан 16:13

Алма 5:45–46

С ба Г 39:5–6

1 Коринт 2:9–14

Моронай 10:5

Иохан 14:26

Сурсан Зүйлээрээ Амьдар

Сайн мэдээг ойлгохоос ирдэг баяр хөөрийг мэдрснээрээ та сурсан зүйлээ хэрэглэхийг хүсэх болно. Ойлголттойгоо нийцэн амьдрахыг хичээ. Ингэх нь таны итгэл, мэдлэг, гэрчлэлийг бэхжүүлэх болно. Сурсан зүйл дээрээ үйл ажиллагаа явуулах нь нэмэлт, туршигдсан ойлголтыг авчрах болно (Иохан 7:17-г үз).

Та суралцах болон итгэлээр судруудын болон хожмын үеийн бошиглогчдын үгсийг нөөцөлсөн үед сайн мэдээг хуваалцах хүсэл тань нэмэгдэх болно. Таныг заах үед юу хэлэхийг тань мэдэхэд Сүнс танд туслах болно хэмээн танд амласан байдаг. “Мөн та нар юу хэлэхээ урьдаас бүү бод; харин амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл, мөн хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсэг нь яг тэр цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 84:85).

*“Зөв сургаал ойлгогдож,
хандлага, зан төлвийг
өөрчилдөг, Сайн
мэдээний сургаалуудыг
судлах нь зан төлвийг
судлахаас илүү хурднаар
зан төлвийг сайжруулах
болно.”*

—ЕРӨНХИЙЛӨГЧ БОИД К.ПАКЕР
“LITTLE CHILDREN,” ENSIGN, 1986 ОНЫ 11-Р САР, 17

Судар Судлах

Сайн мэдээг судлах талаар судрууд юу заадаг вэ?

1 Нифай 10:17–19

С ба Г 50:19–22

С ба Г 88:118

С ба Г 11:21–22

Хичээлүүдийг Судалж, Заахад Бэлтгэх нь

Хичээлүүд (бүлэг 3 дахь) нь баптисмын ярилцлагын асуултууд, даалгаврууд болон таны заах ёстой сургаалуудыг агуулдаг. Та бас хичээлүүдээс заах ашигтай санаануудыг олох болно. Гэсэн хэдий ч, таны хэлэх болгоныг, эсвэл үүнийг хэрхэн хэлэхийг хичээлүүд хэлж өгөхгүй. Үүний оронд, та хичээлүүдийг бүх талаас нь ойлгож, Сүнсээр, өөрийн үгээр заах үүрэгтэй. Бусад хүмүүс Есүс Христэд итгэх итгэлдээ хүчирхэг болж, наманчлахыг хүсэн, Бурхантай гэрээнүүдэд орохоор заа.

Үр бүтээлтэй багш нар мэдлэг, чадвараа дээшлүүлэхийн тулд байнга ажилладаг. Та сургаалын тухай мэддэг бүхнээ заахгүй ч гэсэн, таны өсөн нэмэгдсэн мэдлэг таны гэрчлэлийг хийгээд сүнсний хүчээр заах чадварыг тань төлөвшүүлэх болно. Та хичээлүүдийг төлөвлөгдсөнөөр нь ашиглаж байгаагаараа дараах тохиолдлуудад мэдэх болно:

- Та хичээлүүдэд бэлтгэж, заахдаа Сүнсийг эрэлхийлж, дагах.
- Сургаалуудыг тогтвортой судалж, өндрөөр үнэлэн, амьдралдаа хэрэглэхийг чармайх.
- Зааж байгаа хүн бүрт зориулан тусгай төлөвлөгөө хийхийн тулд хамтрагчтайгаа хамтран ажиллах.
- Заахдаа гол захиасууд болон сургаалуудад анхаарал төвлөрүүл.
- Заадаг хүмүүсийнхээ хэрэгцээг хангахын тулд хичээлийн дараалал, үргэлжлэх хугацаа, байранд зохицуулалт хийх.
- Судруудаас тодорхой байдлаар, итгэл үнэмшилтэйгээр олонтаа заадаг байх.
- Гэрчлэлээ олон удаа хэлэх.
- Баптисм болон гишүүний баталгаа уруу хөтөлдөг даалгаврууд авч, биелүүлэхэд нь бусдад туслах.

Эдгээр зүйлүүдийг хийх нь Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлтэй болоход нь бусдад туслах боломжийг танд олгох болно.

Та номлолоо эхлэх үед захиасыг зохион байгуулж сурах, шаардлагатай заах ур чадваруудыг олж авах нь танд хэрэгтэй байх болно. Туршлага хуримтлуулсан үедээ та мэдлэгээ гүнзгийрүүлж, заах чадвараа өргөжүүлэн тэлэхийг хүсэх болно. Заах үүрэгтээ бэлтгэхдээ, Сүнсээр заах боломжийг өөрт тань олгодог мөн даалгаврууд авч биелүүлэхэд бусдад тусалдаг хичээлийн төлөвлөгөөтэй байхыг та хүсэх болно. Доорх удирдамжууд нь номлолынхоо туршид таны хэрэглэж болох зөвлөмжүүд юм. Гэсэн хэдий ч, та удирдамж бүрийг бүх нөхцөлд ашиглах ёстой гэж бодох хэрэггүй. Үүний оронд, та Сүнсээр удирдагдсанаараа, өөрийн хэрэгцээг хангахын тулд эдгээр удирдамжуудыг хэрэглэ. Хэрэв та шинэ хэл сурч байгаа бол, эхлээд эдгээр удирдамжуудыг төрөлх хэл дээрээ дараа нь номлолын хэл дээрээ хэрэглэ.

- **Амлалтууд болон баптисмын ярилцлагын асуултуудад анхаарал төвлөрүүл.** Хүмүүс амлалт авч баптисм, гишүүний баталгаанд бэлтгэхээр заа. Хичээл бүрийн баптисмын ярилцлагын асуултууд болон даалгавруудыг ойлго. Таны заалтаас хүн сурах, мэдрэх, тэгээд хийх зүйлүүдийг мэд. Эдгээр зарчмуудыг өөрийн үгээр, тодорхой байдлаар бас хүчтэйгээр тайлбарлахын тулд хамтрагчтайгаа хамтран ажилла.
- **Сургаалыг судалж, хэрэглэ.** Сургаал бол хичээлийн суурь нь юм. Сургаалын тухай баттай ойлголт олж авахын тулд судрууд, хичээлүүд, товхимлууд, “Заах Санаанууд” болон номлогчийн номын санг залбиралтайгаар судал. Тухайн хичээл дэх сургаалыг дэмжих материалыг эрж хай. Сургаалын зарчмуудын дэс дарааллыг цээжээр тогтоо. Сурсан зүйлээ хэрэглэ. Сурсан зүйлээ судлах тэмдэглэлдээ тэмдэглэ. Сурсан зүйлээ бусад номлогч нартай хуваалц.

- **Заах зүйлээ зохион байгуулж, нэгтгэн дүгнэ.** Сургаалыг тодорхой, хүчтэйгээр заахаар бэлтгэхийн тулд, хичээлийн төлөвлөгөөгөөр заах зүйлээ зохион байгуулж нэгтгэн дүгнэ. Тухайн хичээлийн сургаал, баптисмын ярилцлагын асуултууд болон даалгаврууд дээр анхаарал төвлөрүүл. Хичээлийн төлөвлөгөөгөө судрууд, асуултууд болон жишээнүүдээр баяжуул. Эдгээр нь таны заах үүргийн үргэлжлэх хугацааны дагуу өөрчлөгдөх учиртай. Та сонирхогч бүрт зориулж хичээлийн бүрэн шинэ төлөвлөгөө хийх ёсгүй, гэвч та хичээлийн төлөвлөгөөгөө байнга шинэчлэн сайжруулж, заадаг хүмүүсийнхээ хэрэгцээг хангахын тулд өөрчилж байх ёстой. Хичээлийн төлөвлөгөөг анх хийхдээ та үүнийг энгийн, товч тодорхой байлгахыг хичээ. Туршлагатай болохын хэрээр хичээлийнхээ төлөвлөгөөг баяжуул.



- **Хэрэгцээн дээр анхаарал төвлөрүүл.** Сайн мэдээний сургаалуудыг хүн бүрт хэрэглэхдээ, заадаг хүмүүсийнхээ хэрэгцээг хангахын тулд та заах арга барилдаа зохицуулалт хийдэг байх ёстой. Сургаал судалж, хичээлийн төлөвлөгөө хийхдээ эдгээр зохицуулалтуудыг эргэн харж, сайжруул. Өгөх урилгуудаа тогтоо. Баптисм болон гишүүний баталгаагаар дамжуулан Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хүлээж авахад нь заадаг хүмүүстээ туслах туйлын зорилгод анхаарал төвлөрүүл.
- **Асуултуудад хариулахад бэлтгэ.** Номлогчийн хувьд та олон асуулт сонсох болно. Судлах тэмдэглэлдээ эдгээр асуултуудыг тэмдэглэ. Хариултад зориулж, судрууд болон бусад материалуудыг судал. Ойлгохын төлөө залбир. Хариултуудыг судлах тэмдэглэлдээ тэмдэглэ. Бусад номлогч нараас олж мэдсэн зүйлээ нэгтгэн дүгнэ. Олонтаа гардаг асуултууд болон тэдгээрийн хариултуудыг иш татахын тулд судлах тэмдэглэлдээ нэм.
- **Хичээлийг заа.** Заах нь өөрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүчирхэг боломж юм. Та сургаалыг судалж, хичээлийн төлөвлөгөө зохион байгуулахдаа, өөрийн хамтрагч болон бусад номлогч нарт заа. Шинэ тайлбар, арга барил, туршлага, асуултууд болон амлалт өгөхөд нь бусдыг урих арга замуудыг туршин хэрэглэ. Санаа, зөвлөмжүүд хүс.
- **Заалтандаа үнэлгээ өг.** Заалтын нөхцөл бүрийн дараа, хэр зэрэг сайн заасандаа үнэлгээ өгч бай. Та сургаал дээр анхаарал төвлөрүүлсэн үү? Наманчилж, даалгавар авч, биелүүлэхэд та сонирхогчдыг урьсан уу? Баптисм болон гишүүний баталгаанд тэднийг бэлтгэхээр та ажилласан уу? Та үр дүнтэй асуултуудыг хэрэглэсэн үү? Та гэрчлэлээ хуваалцсан уу? Та зааж өгөх хүн асуусан уу? Хичээлийн төлөвлөгөөндөө сайжруулах зохицуулалт хий.

Тэмдэглэл

Та хичээлүүдийг суралцахдаа сургаалын тухай гүнзгий мэдлэг эрж хайхаа үргэлжлүүл. Илүү агуу хүчтэйгээр заахын тулд идэвхтэй ажилла. Та залбирал, итгэлд суралцах юм бол, таны мэдлэг, гэрчлэл өсөх болно. Гэвч, мэддэг бүхнээ заах гэж бүү оролд. Захиасыг тодорхой, энгийнээр, түүнчлэн хувь хүмүүсийн хэрэгцээн дээр тулгуурлан, “хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсгийг” (С ба Г 84:85) заахын тулд Сүнснийг дагаж заа.

Тодорхойлогч Үгс

Хосгүй өвөрмөц үгсийн сантай хүчирхэг захиас бидэнд байдаг. Хүлээлгийн өрөөнд байгаа гэр бүлд эмч мэс заслын өрөөнд байгаагаас өөрөөр ярьдаг шиг, та ч бас бидний захиастай танил биш хүмүүст зааж байгаа зүйлээ ойлгуулахын тулд ийм байдлаар ярьж сурах ёстой.

Танил биш үгнүүдийг ойлгоход нь бусдыг бэлтгэхийн тулд чухал тодорхойлолтуудын жагсаалтыг болон хичээл бүрийн “Заах Санаанууд” дахь нэр томъёонуудыг судал. Энд өгсөн тодорхойлолтуудтай танилц. Бусад үгсийн тодорхойлолтуудыг олохын тулд *True to the Faith* болон *Guide to the Scriptures*-ыг судал. Эдгээр тодорхойлолтуудыг судлах тэмдэглэлдээ бич. Өөрөө ойлгож байгаа эсэхийг шалгахын тулд эдгээр тодорхойлолтуудыг хамтрагчтайгаа болон бусадтай хуваалц. Хэрэв тодорхойлолтууд бусад хүмүүст ойлгомжгүй байвал, судалсан материал дээрээ тулгуурлан тодорхойлолтоо дахин хяна.

Та заахдаа, аль нэг үг буюу сургаал, зааж байгаа хүнд тань шинэ эсэхийг мэдэхийг хичээ. Мэдэхгүй үгс буюу зарчмуудыг тайлбарлах цаг гарга. Та өөрөө болон зааж байгаа хүмүүс тань “Сэнхэрч мөн хамтдаа баясахаар” (С ба Г 50:22) ойлгуулж заахаа сана.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Бүлэг 3 дахь “Есүс Христийн Сайн Мэдээний Сэргээлтийн Захиас” хичээлийг үз. “Заах Санаанууд” дахь чухал тодорхойлолтуудын жагсаалтыг унш. Өөрөө тодорхойлохыг хүссэн өөр гурван үгийг хичээлд оруул. Үг бүрийн тодорхойлолтыг бий болгоход дээрх зөвлөмжийг ашигла.

Суралцах Санаанууд ба Зөвлөмжүүд

Энэ хэсэг дэх санаа, зөвлөмж бүр нь таны суралцах цагийг илүү урамшуулагч шинжтэй, хүнлэг байдлын хувьд илүү өргөгч шинжтэй болгож чадна. Та судалгаагаа төлөвлөхдөө дараах зүйлийг анхаар.

- Үргэлж залбирлаар эхэл.
- Аврагчид итгэх итгэлийг тань төлөвшүүлэх суралцах үйл ажиллагаануудыг төлөвлө, мөн цагаа үр бүтээлтэй ашигла.
- Хүмүүс, тэдний хэрэгцээг тойруулан, баптисм болон гишүүний баталгаанд тэднийг бэлтгэхээр, түүнчлэн эцсээ хүртэл тэвчихээр судалгаагаа төлөвлө. Суралцах төлөвлөгөөгөө өдөр тутмын төлөвлөгөөндөө тэмдэглэ.
- Өнөөдөр би юу заах вэ? Заадаг хүмүүстээ хамгийн сайнаар туслахын тулд би судалгаагаа хэрхэн төлөвлөж болох вэ? Энэ хэсгээс аль санаанууд болон зөвлөмжүүдийг би судалгаандаа оруулах вэ? Асуулт асууж, судалгаагаа төлөвлө.

Суралцах үйл ажиллагаагаа төлөвлөхдөө бусдаас өөрийнхөө сурах зарим нэмэлт санаануудыг баримтлах буюу туршин хэрэглэ.

Сурсан Зүйлээ Хэрэглэж, Үүгээр Амьдар

- Сурсан зүйлээ өөртэйгөө “адилтга” (1 Нифай 19:23-ыг үз).
- Сурсан зүйлээрээ амьдрах зорилго тавь.
- Эзэн биетэй болгохын тулд судрын шүлэгт өөрийн нэрийг орлуулан тавь.
- “Сурсан зүйлийнхээ үр дүн болгон би хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэж өөрөөсөө асуу. Холбогдох зорилгуудыг тавь.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Дараах ишлэлүүдийн нэгийг сонго. Өөрийн сонгосон хэсгийг уншиж, тунгаан бодохдоо, амьдралдаа хэрэглэж болох хоёр буюу гурван арга замыг тогтоо.

- 2 Нифай 31
- Алма 32:26–43
- Моронай 7:32–48

Та өөрийнхөө заадаг зарчмуудаар хэр зэрэг амьдарч байгаадаа үнэлгээ өг. Өөрийн сайжирч болох нэг арга замыг сонгон, үүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө хий.

Суралц, тунгаан бод, тэгээд сана

- Бэлэн байдалд бай. Суралцахынхаа өмнө дасгал хий, асуу, залбир.
- Бичгийн ширээ буюу аль нэг ширээнд сууж суралц (орон дээр хэвтэх буюу сууж биш), суралцах материалуудаа зохион байгуул, тэгээд бэлэн байдалд бай.
- Ойлгохын төлөө залбир.
- Сэдэв сэдвээр суралц.
- “Зохиогч юу хэлж байна? Гол захиас нь юу вэ? Энэ нь надад хэрхэн холбогдох вэ?” гэж өөрөөсөө асуу.
- Суралцаж байгаа зүйлээ үзүүлэнжүүл. Жишээ нь, Лэмэнчүүдийн хааны өмнө зогсох нь Аммонд ямар байсныг төсөөлөн бод.
- Амьд бошиглогчдын үгсийг судал (зөвшөөрөгдсөн номлогчийн номын санд болон Сүмийн сэтгүүлүүдээс).
- Судлах тэмдэглэлдээ өөрийн асуултуудыг бич, тэгээд хариултуудыг олохын тулд судрууд, хожмын үеийн бошиглогчдын үгс болон судалгааны бусад эх сурвалжуудыг ашигла.
- Судрын ганцхан шүлэг хэд хэдэн санаа агуулсан байж болно. Тухайн шүлэг дэх санаануудыг ялган танихын тулд тэмдэг үгсийг буюу холбоо үгсийн доогуур зур.
- Сурсан зүйлээ бусад номлогч нартай хуваалц. Сургаал буюу зарчмыг өөр хүнд тайлбарласнаар та их зүйл сурч чадна.
- Судруудаа тэмдэглэж, тэдгээрт тэмдэглээ хий. Өөрийнхөө судалж байгаа хэсгүүдийг тодруулах судрын ишлэлүүдийг зах дээр нь бич.
- Зааж байгаа зарчмуудыг тань тайлбарлаж, дэмждэг судрын хэсгүүдийг цээжил.

Судалгааны Эх Сурвалжуудыг Ашигла

- Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн судруудын хэвлэл дэх суралцах тусламжуудыг (Topical Guide, Bible Dictionary, Joseph Smith Translation, судрын гурамсан ботийн

Тэмдэглэл

товъёог, бүлгийн толгой гарчиг, зүүвэр тайлбарууд болон газрын зургууд) ашигла.

- Номлогчийн хичээлүүд, номлогчийн зөвшөөрөгдсөн номын сан, Сүмийн сэтгүүлүүд болон энэ гарын авлагыг ашигла.
- Судрууд дахь бүлгийн толгой гарчгуудыг нэгтгэн дүгнэ. Ингэж нэгтгэн дүгнэх нь уг бүлэгт юуны тухай хайх санаануудыг танд өгөх болно.
- Сурч байгаа зүйлээ тэмдэглэж, зохион байгуулахын тулд судлах тэмдэглэлээ ашигла. Тэмдэглэсэн санаануудаа үе үе эргэн харж бай. Сурсан зүйлээ амархан эргэн санаж байхаар тэмдэглэлээ зохион байгуул.
- Энэ гарын авлагыг ажлын ном болгон ашигла. Тэмдэглэлд зориулсан зайг сэтгэгдэл болон санаануудыг тэмдэглэхэд ашигла.
- Энэ гарын авлагад жагсаасан судрын хэсгүүдийг судал. Энэ гарын авлага дотор буюу судлах тэмдэглэлдээ өөрийн олсон судрын бусад хэсгүүдийг тэмдэглэ.

Тойм Зургийг Гарга

- Тухайн ном, бүлэг буюу хэсгийг унших замаар, эсвэл толгой гарчгуудыг түргэн нэгтгэн дүгнэх замаар төсөөлөлтэй бол. Хам сэдэв болон үндэс суурийг ойлгохыг хичээ.
- Тухайн өгүүлбэр буюу богинохон догол мөрөн дэх хэсгийн гол санааг бичихийг хичээ.
- Газар зүй, хол ойрын зай, уур амьсгал болон газар нутгийг мэдэж авахын тулд Библи болон Сүмийн түүхийн газрын зургуудыг ашигла.
- Үйл явдлуудын дараалал болон соёл иргэншлийг нэгтгэн дүгнэ. Guide to the Scriptures, бүлгийн болон хэсгийн хураангуй дахь түүхийн мэдээллийг унш.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Доорх номнуудын бүлгийн хураангуйг уншиж, тухайн нөхцөл, гол үйл явдлууд, түүнчлэн ном тус бүрийн гол сургаалуудыг дүрсэлсэн тойм бич.

1 Нифай

Мосе

Үйлс

Нарийн Тодорхой Зүйлүүдийг Шинжлэн Судал

- Гол үгсийг хайж олон, тэдгээрийн утгыг ойлгоход анхаар. Зүүвэр тайлбарууд, Судруудын Удирдамж буюу өөр толь бичгийг тодорхойлолтуудын тулд ашигла. Эргэн тойрон дахь үгс буюу холбоо үгсийг эдгээр нь ямар утгатайг мэдэхийн тулд шалга.
- *Иймээс, мөн дахин, тийнхүү, ийм учраас* гэх мэт бусад холбоо үгсийг эрж ол. Тэгээд өмнөх болон дараах хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг ажигла.
- Адил үг өөр хам сэдвүүдэд хэрхэн хэрэглэгдсэнийг буюу эсвэл бусад бошиглогчид энэ үгийг хэрхэн хэрэглэснийг харахын тулд Судруудын Удирдамжийг ашигла.
- Мэдэхгүй үгс буюу холбоо үгсийг эрж олон тэдгээрийг ойлгоход анхаар.

Судруудад Тэмдэглээ Хийх нь

Судрууддаа тэмдэглээ хийх нь сайн мэдээний аль нэг хэсэг буюу сургаалын тухай гүнзгий бодоход танд тусалж чадна. Та судрууддаа тэмдэглээг олон янзаар хийж болно. Өөртөө тохирох аргыг ол. Судруудад тэмдэглээ хийх зарим удирдамжуудыг доор харуулав.

- Харандаа буюу өнгийн тэмдэглэгчийг ашигла. Цаасан дээр бэх дусаадаг үзэг хэрэглэхээс зайлсхий.
- Шүлгийн нэг хэсгийг, шүлгийг бүхэлд нь буюу эсвэл хэд хэдэн бүлэг шүлгийг бүхэлд нь сүүдэртүүлэн буд, доогуур нь зур эсвэл хүрээл.
- Хэт их тэмдэглээ хийхээс зайлсхий. Хэтэрхий олон тэмдэглээ, зураас, өнгө ашигласнаас болоод та тэмдэглээнүүдээ ойлгохгүйд хүрэх юм бол ямар ашиг байх билээ.
- Тухайн шүлэг, хэсэг буюу бүлгийг бүхэлд нь тодорхойлох хэдхэн гол үгсийг л зөвхөн доогуур нь зур.
- Гол үгсийг дугуйлах буюу доогуур нь зур, тэгээд ойрхон холбоотой үгсийг холбохын тулд шулуун зураасуудыг ашигла.
- Нэг шүлэг дэх цуврал хэсэг ойлголтууд хоорондоо холбоотой байвал уг ойлголтуудыг судрын зах дээр буюу сэдэв дотор нь дугаарла.
- Зүүвэр тайлбаруудыг сударт тэмдэглээ хийх болон тайлбарлах эх сурвалж болгон ашигла.
- Эргэн санах нь чухал гэж өөрийн бодсон гол шүлгүүдийн талаар судрын зах дээр бэлэгдэл байрлуул (шалгах тэмдэг гэхчлэн).

Судрууддаа тэмдэглээ хийх нь сурсан зүйлээ хэрэглэх болон бусдад заахад анхаарлаа төвлөрүүлэхэд танд туслах ёстой. Тохиромжтой бөгөөд номлогчийн хувьд өөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд тань өөртөө туслах арга барилыг хөгжүүл.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Аль зөвлөмжүүдийг та туршиж үзээгүй байгаа вэ? Хувиараа болон хамтрагчтайгаа суралцах дараагийн хэсгийн үеэр туршихын тулд “Санаанууд ба Зөвлөмжүүдийг Судал” хэсгээс нэг зөвлөмжийг тогтоо.

Үүнийг Сана

- Сурах хүсэлдээ хөтлөгдөх нь таны авралд, түүнчлэн номлогчийн хувьд таны амжилтанд чухал ач холбогдолтой юм.
- Та сайн мэдээг судалснаар, итгэлээр бас Ариун Сүнсний хүчээр сурдаг.
- Сурах нь баяр хөөр бөгөөд олон адислал авчирдаг.
- Өдөр бүр хувиараа болон хамтрагчтайгаа суралцах нь таны итгэлийг бас Сүнсээр заах таны чадварыг бэхжүүлдэг.
- Туршлагыг утга учиртай, баяр хөөртэй болгодог суралцах олон өөр аргыг ашигла.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- Дараах байдлаар өөртөө оноо өг (1=огт суралцдаггүй, 3=зарим үед, 5=бараг үргэлж).
 - Би суралцаж байхдаа заадаг хүмүүсийнхээ тухай боддог.
 - Өглөө судалсан зүйлийнхээ талаар би өдрийн турш боддог.
 - Суралцах явцад, өмнө нь надад бодогдож байгаагүй санаанууд санаанд минь орж ирдэг.
 - Сүнслэг сэтгэгдлүүд болон санаануудыг би зохих газарт нь тэмдэглэдэг.
 - Би суралцаж байхдаа унтчихдаг.
 - Би хувиараа суралцахыг хүсэн хүлээдэг.
 - Би хамтрагчтайгаа суралцахыг хүсэн хүлээдэг.

Хариултуудаа нэгтгэн дүгнэ. Та юуг сайн хийж байна вэ? Өөрийнхөө хариултуудаас аль нэг нь өөр байхыг та хүсдэг үү? Судалгааныхаа чанарыг дээшлүүлэх нэг буюу хоёр зорилго тавь.

- Энэ бүлгийн эхэн дэх “Үүнийг Анхаар” хэсгийн асуултуудыг нэгтгэн дүгнэ. Эдгээр асуултууд судалгаанд тань хэрхэн нөлөөлдөг вэ?
- “Суралцах Санаанууд ба Зөвлөмжүүдийг” нэгтгэн дүгнэ. Өөрийн ашиглаагүй төрөл бүрээс нэг зөвлөмжийг тогтоож, эдгээр санаануудыг хувиараа суралцах явцад туршин хэрэглэ.
- Сургаал ба Гэрээ 138:1–11-ийг унш. Эдгээр шүлгүүдийг уншихдаа, дараах асуултуудад хариул:
 - Оюун нь нээгдэхийн тулд Ерөнхийлөгч Смит юу хийх ёстой байсан бэ?
 - Тэрээр өөрийн бодож байсан сургаалын талаар ямар бодолтой байсан бэ?
- Мэдлэгийн тухай тодорхойлолтыг Судруудын Удирдамж болон жагсаасан ишлэлүүдээс унш. “Номлогчийн хувьд үр ашигтайгаар үйлчлэхэд ямар мэдлэг надад тусалж чадах вэ?” гэсэн асуултын хариуг судлах тэмдэглэлдээ бич.
- Өөрөө илүү сайн ойлгохыг хүссэн нэг сургаалыг бүлэг 3-аас сонгож ав. Өөрийн хариулахыг хүссэн асуултуудыг судлах тэмдэглэлдээ бич. Уг сургаалыг тодорхой хугацаанд (цөөхөн хоногийн дотор) анхааралтай судалж, ойлголтоо нэмэгдүүлэхийн тулд тусгайлан залбир. Сурсан зүйлээ бич.
- 1 Нифай 10:17; 11:1–6-г унш. Эдгээр шүлгүүдийг уншаад, “Нифай яагаад аавынхаа мэддэг байсан зүйлийг сурах боломжтой байсан бэ?” гэсэн асуултанд хариул.

Хамтрагчтайгаа Суралцах

- Дараах судрын хэсгүүдийг хамтдаа унш. “Яагаад бид бурханлиг гэрлийг эрэлхийлэх ёстой вэ?” гэсэн асуултад хариул.

С ба Г 11:11–14

Иохан 8:12

Дуулал 119:105

С ба Г 84:43–47

- Доорх судрын хэдэн хэсгийг хамтдаа уншаад, Бурханы үгийг судалснаас ирдэг адислалуудын тухай ярилц. Ямар хэсгүүд өөрийн тань заадаг хүмүүст хамгийн сайн тусалж чадах вэ?

Тэмдэглэл

1 Нифай 10:19	Алма 32:42–43	С ба Г 130:19
2 Нифай 32:3	Алма 37:44–46	Судруудын Удирдамж, “Судрууд,” дэд гарчиг: “Судруудын үнэ цэнэ,” 221–22
Мозая 1:6–7	Алма 49:30	
Алма 17:2–3	С ба Г 90:24	

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Өөрийн анхааралтай суралцсан номлогчийн хичээлүүдийн нэгнээс нэг сэдвийг сонгож ав. Дараах зүйлийг хий:
 - Тухайн хичээлийг заахад ашиг тустай байсан, судалгаанаасаа сурсан хоёр буюу гурван зүйлийг хуваалц.
 - Эдгээр зүйлүүдийг илрүүлэхэд өөрт тань тусалсан, судалгаандаа хэрэглэсэн арга барилыг (яаж уншсан, ашигласан эх сурвалжууд, өөрийн тань эрж байсан асуултууд гэхчлэн) дүрсэл.
 - Судалгааныхаа үр дүнг хэрхэн тэмдэглэж, зохион байгуулснаа харуул.

Хэрэв цаг байвал, мөн ингэхийг өөр хэдэн номлогчоос хүс.

- Энэ үйл ажиллагааг хувь хүмүүсээр буюу жижиг бүлгээр хийлгэж болно. Дараах асуултуудаас нэгийг сонгож авахыг номлогч нарт зааварла (эсвэл та өөрөө хэдэн асуулт зохиож болно). Асуултыг тэднээр бичүүл.
 - Гэр бүлүүд яагаад Бурханы төлөвлөгөөнд тийм их ач холбогдолтой байдаг вэ?
 - Яагаад хүмүүст гай зовлон тохиолддог вэ?
 - Хөрвүүлэгт Сүнс ямар үүрэгтэй вэ?

Дараах зүйлүүдийг тэд таваас долоон минутанд хийсэн байх ёстойг тайлбарла:

- Дээрх асуултад хариулах, судрын наад зах нь хоёр ишлэл ол.
- Тэдний сонгосон судрууд уг асуултад хэрхэн хариулж байгаа тухай энгийн тайлбар бич.
- Хариултыг санахын тулд тэд юу хийж байх ёстойг дүрсэл.
- Асуултыг улам гүнзгий суралцахын тулд тэд юу хийж болохыг дүрсэл.

Өөрсдийнхөө хариултуудыг хуваалцахад хэдэн номлогчийг (эсвэл бүлэг бүрийг) урь. Тэдний хариултуудыг ярилц.

- Бүлэг 3-ын хичээлүүдийн нэгнээс, тэд хариултыг нь олохыг хүссэн, сайн мэдээний зарчмууд болон сургаалуудын тухай нэг буюу хоёр асуулт бичихийг номлогч нараас хүс. Өөрсдийнхөө асуултуудыг бүлэгтэй хуваалцахад номлогч нарыг урь. Асуулт бүрийн талаар дараах байдлаар ярилц:
 - Энэ асуултад хариулах нь тэр номлогчийн амьдралыг хэрхэн адислах вэ?
 - Сонирхогчдын амьдралыг энэ нь хэрхэн адислах вэ?
 - Номлогч уг хариултыг хэрхэн олж чадсан бэ?
- Хамтрагчид нь тэдэнд заасан сайн мэдээний нэг зарчмыг хуваалцахыг хэдэн номлогчоос хүс. Уг зарчмыг болон хамтрагч нь үүнийг тэдэнд хэрхэн заасныг тайлбарлахыг тэднээс хүс.

Тэмдэглэл

- Номлогч нарыг хамтлагууд буюу жижиг бүлгүүд болгон зохион байгуул. Мормоны Номноос тус бүр нэг бүлэг уншихыг бүлгүүдэд даалга. “Суралцах Санаанууд ба Зөвлөмжүүд” хэсгийн таван төрөл бүрээс нэг санааг бүлэг бүрээр сонгуул. Тэд бүлгийг хамт уншихдаа асуулт бүрийг хэрэглэхэд бүлгүүдийг урь. Уншиж, ярилцахад 15–20 минут олго. Тэдний ашигласан зөвлөмжүүд хэр зэрэг сайн байсан, мөн тэд юу сурсныг нь бүлэг бүрээр тайлбарлуул.
- Өөрт нь холбогдох судрууд дахь түүх буюу үйл явдлын тухай бодоход номлогч бүрийг урь (амьдралын модны тухай Лихайн үзэгдэл, Хаан Бенжамины номлол, Уулан дээрх Номлол, эсвэл Нифайчууд дээр Христ хүрч ирсэн гэх зэрэг). Сонгосон шастируудаа хэрхэн үзүүлэнжүүлж болохыг тоймлох буюу дүрслэн үзүүлэхэд номлогч нараас урь. Үзүүлэнжүүлсэн зүйлээ хуваалцахад хоёр буюу гурван номлогчийг урь. Түүхүүдийг ярьж, тэдгээрийг хичээлүүдийн нэгэнд холбогдуулахыг бусад номлогч нараас хүс. Моронай 10:3-ыг уншиж, сүнсний мэдлэгийн талаар гүнзгий тунгаан бодохын үнэ цэнийг ярилц.

Номлолын Ерөнхийлөгч

- Судлах тэмдэглэлдээ ярилцлагуудад авчирч байхад номлогч нарыг урь. Нэг тэмдэглэлийг өөртэйгөө хуваалцахад тэднийг урь.
- Ярилцлагын үед дараах асуултуудаас заримыг нь асуу:
 - Саяхан судар судлахад тань танд ямар сэтгэгдэл төрсөн бэ?
 - Хамтрагч тань саяхан танд заасан, нэг сайн зарчмыг нэрлэнэ үү?
 - Энэ гарын авлагын ямар бүлэг буюу хэсэг өнгөрсөн хоёр долоо хоногт хамгийн их ашиг тус болсон бэ?
 - Сурахад танд хамгийн их тусалсан юуг та хувиараа суралцах талаар хийж байна вэ?
- Бүсийн чуулгануудын үеэр, хувиараа суралцах, хамтрагчтайгаа суралцахад тэдэнд тохиолдсон чухал учир холбогдолтой туршлагуудаа хуваалцахад номлогч нарыг урь.
- Бүсийн чуулгануудын үеэр, хувиараа суралцах санаануудыг хуваалцах боломжийг номлогч нарт олго.
- Хувийнхаа судалгаан дахь ойлголтуудыг номлогч нартай хуваалц. Өөрийнхөө судлах тэмдэглэлийн тэмдэглэлүүд болон сайн мэдээг судлахын ач холбогдлын тухай гэрчлэлээ номлогч нартай хуваалц.
- Тэднийг хамтрагчтайгаа суралцахад та боломжоороо номлогч нартай нэгдэж бай.
- Ярилцлагуудын үеэр номлогчийн хичээлүүдийн нэгнээс нь тэдний өөрсдийнх нь хичээлийн нэг төлөвлөгөөг хуваалцахад номлогч нарыг урь. Эдгээр сургаалууд тэдний хувьд ямар учир холбогдолтойг тэднээс асуу.



Би Юу Судалж, Юу Заах Вэ?

Энэ бүлэг дэх хичээлүүд нь таны судлах, итгэх, хайрлах, үүгээр амьдрах болон заах ёстой сургаалууд, зарчмууд мөн зарлигуудыг агуулдаг. Эдгээр нь амьд бошиглогчид болон төлөөлөгчдөөс таныг заахад чиглүүлж өгдөг тэр зүйл мөн. Эдгээр нь таныг Христийн сургаалуудыг тод томруунаар бусдад ойлгуулахад тань тусалж чадахуйцаар зохион байгуулагдсан байна.

Энэ бүлэг дэх хичээлүүд:

- Есүс Христийн Сайн Мэдээний Сэргээлтийн Захиас
- Авралын Төлөвлөгөө
- Есүс Христийн Сайн Мэдээ
- Зарлигууд
- Хуулиуд ба Ёслолууд

Эхний дөрвөн хичээлийг баптисмын өмнө заа. Өөрийн тань заадаг хүмүүс эдгээр хичээлүүд дэх бүх даалгаврыг хийж, хэрэгжүүлэх замаар баптисм болон гишүүнээр батлагдахад тэнцэхээр болсон байхад анхаар.

Бүрэн цагийн номлогч нар нь хэсгийн номлогч нар болон бусад гишүүдийн туслалцаатайгаар баптисмын өмнөх хичээлүүдийг заахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Баптисмын дараа эхний дөрвөн хичээлийг, түүнчлэн “Хуулиуд ба Ёслолуудыг” шинэ гишүүдэд дахин заана. Эдгээр хичээлүүдийг заах үүргийг хэсгийн номлогч нар эсвэл бүрэн цагийн номлогч нар хүлээх үү, түүнчлэн бүрэн цагийн номлогч нар үүнд хэр зэрэг удаан хугацаагаар оролцохыг хэсгийн удирдагчид шийднэ. Эдгээр хичээлүүд дэх бүх даалгаврыг хийхэд нь шинэ гишүүн бүрийг урамшуулан дэмж.

Та бас эдгээр хичээлүүдийг хувиараа болон хамтрагчтайгаа суралцах, дүүргийн хурлууд тэрчлэн сургалтын бусад хэлбэрүүдэд ашиглах хэрэгтэй. Та судрууд судалж, эдгээр хичээлүүд дэх сургаалуудыг оюун ухаандаа санах үед, тухайн тэр үед таны юу хэлэх ёстойг, мөн зааж байгаа зүйлүүдийн үнэний тухай гэрчлэлийг

Тэмдэглэл

The Sermon on the Mount, by Carl Bloch. Эх хувь нь Германы Фредриксберг Саси-ийн талхид хадгалагдаж байгаа. Фредриксбергтисеит-ийн эвлэлээр хуульчлаа. Хуулиудыг бичигч.

Тэмдэглэл

хүлээн авахад нь бусдад туслахын тулд таны юу хийх ёстойг Сүнс яг тэр цагт танд өгөх болно.

Та номлогчийн хувьд, зүрх сэтгэлээсээ мөн Сүнсээр заах агуу үүрэг хариуцлагатай билээ. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга нотлохдоо: “Бидний зорилго бол номлогч нар болон тэдний зааж байгаа хүмүүс аль алийг нь Сүнс чиглүүлэх тийм арга замаар сэргээгдсэн сайн мэдээний захиасыг заах явдал мөн” гэжээ. [Хичээлүүдийн] үзэл баримтлалуудыг мэдэх нь туйлын чухал юм, гэвч эдгээр үзэл баримтлалуудыг зөвхөн цээжилснээрээ заах ёсгүй. Номлогч Сүнсээр өдөөгдсөнийхөө дагуу өөрийн үгсийг чөлөөтэй ашиглах ёстой. Тэрээр зөвхөн цээжилсэн ишлэлүүдийг иш татах ёсгүй, харин өөрийн нэр томьёо ашиглан зүрх сэтгэлээсээ ярих хэрэгтэй. Сонирхогчийн сонирхол, эрэлт хэрэгцээний дагуу номлогч өөрт нь урам илчлэлт өгсөн зүйлийг зааснаар хичээлүүдийн дэс дарааг өөрчилж болно. Тэрээр өөрийн хувийн итгэл үнэмшлээр, өөрийн үгээр ярьж, өөрийн заадаг зүйлүүдийн үнэний тухай гэрчлэх ёстой (“Statement on Missionary Work”, Тэргүүн Зөвлөлийн захидал, 2002 оны Арванхоёрдугаар сарын 11). Та болон хамтрагч тань эдгээр хичээлүүдийг судалж, заахад бэлтгэхдээ эдгээр заавруудыг сайтар санагтун. Эдгээр хичээлүүд дэх бүх сургаалуудыг заахад анхаар.

Сүнсээр чиглүүлэгдээгүй бол, та эхний гурван хичээл тус бүрийн бүрэн агуулгыг тэдгээрийн бичигдсэн дэс дараагаар заах хэрэгтэй. Тэрчлэн цөөхөн тооны холбогдох зарлигийг багтааж болох буюу тусдаа хичээл болгон зааж болно.

Хичээл болгон нь баптисмын ярилцлагын асуултууд, даалгаврууд болон таны заах ёстой сургаалуудыг хураангуйлан оруулсан байна. Сургаалуудыг сайтар судал. Заадаг хүмүүстээ даалгавруудыг хийж, хэрэгжүүлэхэд нь туслахад үргэлж анхаарлаа төвлөрүүлж бай. Заадаг хүмүүсээ баптисм болон гишүүнээр батлуулахад нь бэлтгэхдээ баптисмын ярилцлагын асуултуудыг ашигла. Хичээлүүдэд бас заах санаанууд байгаа. Хичээлд хэрхэн бэлтгэх болон заахаа сайжруулахад эдгээр зөвлөмжүүдийг ашигла.

Цээжлэхийн Үүрэг

Хичээл заахдаа ашиглахын тулд судруудыг цээжил. Номлогчийн хичээл бүр дэх сургаалын асуудлуудын үр дагаврыг цээжээр тогтооход шийдвэр төгс бай. Хоёр дахь хэл сурч байгаа номлогч нар номлогчийн хичээл заах бэлтгэл дээрээ хэл сурах явдлыг төвлөрүүлэх ёстой. Тэд хичээл дээр гардаг үг хэллэг, холбоо үгс, загвар өгүүлбэрүүд, тэрчлэн сургаалын товч хэлсэн үгийг зөвхөн өөрт тань зохих утга учиртай болсны дараа цээжлэх хэрэгтэй. Хичээлийг бүхэлд нь цээжлэх хэрэггүй.

Тодорхой Байдлаар Заа

Эхний гурван хичээлийн төгсгөлд өөрийн тань заадаг хүмүүс мэдэхгүй байж болох үгсийн жагсаалт бий. Эдгээр үгсийг хэрхэн энгийнээр тодорхойлохыг мэдэж ав. Заах үедээ захиасыг хялбархан ойлгуулахын тулд чадах бүхнээ хий.

Судар Судлах

Таныг заахад юу чиглүүлдэг вэ?

Мозая 18:18–20

С ба Г 43:15–16

С ба Г 52:9

Та яагаад эдгээр хичээлүүд дэх сургаалуудыг судлах ёстой вэ?

Алма 17:2–3

С ба Г 84:85

Есүс Христийн Сайн Мэдээний Сэргээлтийн Захиас



© 1991 Greg K. Olsen. Хувиан олшруулж болохгүй.

Тэмдэглэл

Таны Зорилго

Та заах үедээ Сургаал ба Гэрээ 20:37 түүнчлэн баптисмын ярилцлагын асуултуудад заагддаг баптисмд тэнцэх чанаруудыг хангахад нь өөрийн сонирхогчдыг бэлтгэ. Дор жагсаасан даалгавруудыг хийж гүйцэтгэхийг сонирхогчдоо урьснаар энэхүү бэлтгэл хамгийн сайнаар хангагдана.

Баптисмын Ярилцлагын Асуултууд

- Бурхан бол бидний Мөнхийн Эцэг гэдэгт та итгэдэг үү?
- Есүс Христ бол Бурханы Хүү, дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдэгт та итгэдэг үү?
- Сүм болон Есүс Христийн сайн мэдээ Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн гэдэгт та итгэдэг үү?
- [Сүмийн одоогийн Ерөнхийлөгч] бол Бурханы бошиглогч гэдэгт та итгэдэг үү? Энэ нь таны хувьд юу гэсэн үг вэ?

Даалгаврууд

- Мормоны Ном бол Бурханы үг гэдгийг мэдэхийн тулд та үүнийг уншиж мөн залбирах уу?
- Иосеф Смит бошиглогч байсныг мэдэхийн тулд та залбирах уу?
- Та энэ Ням гарагт бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах бусад зарлигууд.

Бурхан бол Бидний Хайртай Тэнгэрлэг Эцэг

Бурхан бол бидний Тэнгэрлэг Эцэг. Бид Түүний хүүхдүүд. Тэрээр алдаршиж, төгс төгөлдөр болсон, мах болон ясан биетэй. Тэр бидэнд хайртай. Биднийг зовоход Тэр бидэнтэй хамт уйлж, бид зөв зүйлийг хийхэд бидэнтэй хамт баясдаг. Тэр бидэнтэй харилцахыг хүсдэг бөгөөд бид чин сэтгэлийн залбирлаар дамжуулан Түүнтэй харилцаж чадна.

Дэлхий дээрх энэхүү туршлагыг Тэр бидэнд өгсөн болохоор бид сурч мөн өсч хөгжиж чадна. Бид өөрсдийн сонголтууд болон Түүний зарлигуудад дуулгавартай байх явдлаар дамжуулан Түүнийг хайрлах хайраа харуулж чадна.

Тэмдэглэл

Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүд биднийг энэ амьдралд амжилттай байж, тэгээд Түүний дэргэд амьдрахаар эргэж очих арга замаар хангасан юм. Гэвч ингэхийн тулд бид дуулгавартай байдлаар дамжуулан цэвэр ариун байх ёстой. Дуулгаваргүй байдал биднийг Түүнээс холдуулдаг. Бидний Эцэгийн төлөвлөгөөний гол төв нь Есүс Христийн Цагаатгал юм. Цагаатгал нь Гетсеманийн Цэцэрлэг дэх Түүний шаналал мөн тэрчлэн загалмай дээрх Түүний зовлон хийгээд үхлийг багтаадаг. Цагаатгалаар дамжуулан бид өөрсдийн нүглүүдийн ачаа дарамтаас чөлөөлөгдөж, зовлон бэрхшээлүүдтэйгээ тулгарах итгэл хийгээд хүч чадлыг хөгжүүлдэг.

Бурханы талаарх итгэл

Өөрийн тань зааж байгаа хүн бүр Бурханы талаарх Христэд итгэгчийн итгэлийн тухай юу ойлгосныг нь тодорхойл. Өнөөгийн дэлхий дээрх олон хүмүүс нэг бол Бурханы тухай ойлголтгүй байдаг эсвэл Бурханы тухай нэн их ялгаатай ойлголттой байдаг.

Мормоны Номны хоёр номлогч, Аммон, Аарон хоёр Христийн тухай анхны мэдлэггүй хүмүүст заажээ. Тэд энгийн үнэнүүдийг зааж, тэгээд сонирхогчдоо залбирахыг урьсан аж. Лэмонай, түүний эцэг хоёр хөрвүүлэгджээ. Алма 18:24–40, 22:4–23-ыг уншиж, доорх асуултуудад хариул:

- Бурханы мөн чанарын тухай эдгээр номлогч нар юу заасан бэ?
- Та тэдний үлгэр жишээг хэрхэн дагаж болох вэ?

Судар Судлах**Бурхан Эцэг болон Есүс Христийн Мөн Чанар Юу Вэ?**

1 Нифай 17:36	3 Нифай 27:13–22	Иохан 3:16–17
2 Нифай 9:63	С ба Г 38:1–3	Үйлс 17:27–29
Мозая 4:9	С ба Г 130:22	Ром 8:16
3 Нифай 12:48	Мосе 1:39	Еврей 12:9
3 Нифай 14:9–11	Матай 5:48	1 Иохан 4:7–9

Сайн Мэдээ Гэр Бүлүүдийг Адисалдаг

Сэргээгдсэн сайн мэдээ эхнэр нөхрүүд, эцэг эхчүүд хийгээд хүүхдүүдийг гэр бүл дэх хүчтэй хэлхээ холбоо болон сүнслэг хүч чадлыг хөгжүүлэхээр хичээхэд тэднийг адисалж мөн тэдэнд тусалдаг. Эдгээр адислалууд эдүгээ хийгээд үүрд мөнхөд боломжтой байдаг. Эдүгээгийн асуудал, бэрхшээлүүдийг шийдэхэд Есүс Христийн сайн мэдээ тусалцаа үзүүлдэг.

Гэр бүлүүд Бурханаас томилогддог учраас тэдгээр нь энэ цаг мөч болон мөнхөд нийгмийн хамгийн чухал нэгж байдаг. Бурхан Өөрийн хүүхдүүдэд аз жаргал авчрахын тулд, хайр бүхий орчинд зөв зарчмуудыг сурах боломж олгох, түүнчлэн тэднийг мөнхийн амьдралд бэлтгэхийн тулд гэр бүлүүдийг үндэслэжээ. Гэр бол Есүс Христийн сайн мэдээний зарчмуудыг заах, суралцах түүнчлэн хэрэглэх хамгийн шилдэг газар юм. Сайн мэдээний зарчмууд дээр үндэслэгдсэн гэр орон толгой хоргодох хийгээд аюулгүй байдлын газар байх болно. Энэ бол Их Эзэний Сүнс орших, гэр бүлийн гишүүдийг амар амгалан, баяр хөөр хийгээд аз жаргалаар адислах газар байх болно. Үе үеийн бошиглогчид, түүний дотор манай өнөө үеийн бошиглогчдоор дамжуулан хувь хүмүүс болон гэр бүлүүдэд зориулсан, Өөрийн аз жаргалын төлөвлөгөөг Бурхан илчилсээр ирсэн билээ.

Тэнгэрлэг Эцэг Өөрийн Сайн Мэдээг Эрин Үе Болгонд Илчилдэг

Бурханы нэрийн өмнөөс Түүний хүүхдүүдийн авралын төлөө ажиллах санваарын хүч болон эрх мэдлийг тэдэнд олгосон бошиглогчдыг дууддаг нь Бурхан биднийг хайрладаг Өөрийн хайрыг харуулдаг нэгэн чухал арга зам мөн. Бошиглогчид илчлэлтээр Есүс Христийн сайн мэдээг мэдэж авдаг. Тэгээд тэд бусад хүмүүст сайн мэдээг зааж, Есүс Христийг Аврагч хийгээд Гэтэлгэгчийнх нь хувьд гэрчилдэг. Бошиглогчдын заадаг зүйлүүд нь судрууд хэмээн нэрлэгддэг ариун номнуудад байдаг.

Энэ амьдралд амжилттай байж, Түүнтэй хамт амьдрахаар эргэж оруулахын тулд Тэнгэрлэг Эцэгийн маань бидэнд зориулсан төлөвлөгөө нь уг төлөвлөгөөний төвд байдаг Есүсийн Цагаатгалтай Есүсийн Христийн сайн мэдээ гэж нэрлэгддэг. Хэрэв бид Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчлан, нүглүүдээс ангижрахын тулд усанд умбуулалтаар баптисм хүртэн, Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчих юм бол, бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан мөнх амьдралыг хүлээн авч чадна. “Зам нь энэ, мөн хүмүүн Бурханы хаант улсад аврагдаж чадах өөр тийм өгөгдсөн нэр болон зам гэж тэнгэрийн дор үгүй болой” (2 Нифай 31:21). Бүх хүмүүст сонголтын бэлэг байдаг, энэ нь бошиглогчид болоод төлөөлөгчдийн заадаг сайн мэдээг хүлээн авах буюу хүлээн авахгүй байх эрх чөлөө юм. Дуулгавартай дагахыг сонгодог хүмүүс адислагддаг, харин сайн мэдээг үл тоомсорлогчид Бурханы амласан адислалуудыг хүлээн авдаггүй.

Хүмүүс сайн мэдээний аливаа зарчим буюу ёслолыг үл тоомсорлох, дуулгаваргүй байх буюу мушгин гуйвуулахаар сонгосон аль ч үед, Их Эзэний бошиглогчдыг эсэргүүцсэн аль ч үед, эсвэл итгэлд тэвчээртэй байж чадаагүй аль ч үед тэд өөрсдийгөө Бурханаас холдуулж, тэгээд сүнсний харанхуйд амьдарч эхэлдэг. Энэ нь урвалт гэж нэрлэгддэг нөхцөл байдал уруу зайлшгүй хөтөлдөг. Урвалт өргөн цар хүрээгээр тохиосон үед сайн мэдээний ёслолуудыг заах болон гүйцэтгэх Өөрийн санваарын эрх мэдлийг Бурхан буцаан татдаг.

Бурхан өөрийн бошиглогчидтой ярилцсан олон тохиолдлыг Библийн түүх цэдэглэсэн байдаг бөгөөд энэ нь бас урвалтын олон тохиолдлын тухай өгүүлдэг. Нийтийг хамарсан урвалт бүрийн төгсгөлд Бурхан өөр бошиглогчийг дуудаж, Есүс Христийн сайн мэдээг сэргээн, санваарын заах эрх мэдлийг шинээр түүнд олгон, Өөрийн хүүхдүүдийг хайрлах хайраа харуулсаар иржээ. Чухамдаа бол, уг бошиглогч дэлхий дээрх Бурханы хаант улсыг харж хандах даамлын хувиар үйл ажиллагаа явуулдаг. Ийнхүү бошиглогчдоор чиглүүлэгдсэн буюу удирдуулсан цаг хугацааг эрин үеүд гэж нэрлэдэг.

Есүс Христийн сайн мэдээг Бурхан Адамд илчилж, түүнчлэн санваарын эрх мэдлийг түүнд олгожээ. Адам бол дэлхий дээрх анхны бошиглогч байлаа. Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсний харилцах хүн төрөлхтний зохих ёсны харилцаа; Есүс Христийн Цагаатгал хийгээд Амилуулалтын тухай; тэрчлэн сайн мэдээний анхны зарчмууд болон ёслолуудын тухай Адам илчлэлтээр мэджээ.



Тэмдэглэл

Тэмдэглэл

Адам Ева хоёр хийгээд эдгээр үнэнүүдийг хүүхдүүддээ зааж, итгэлээ хөгжүүлэн, амьдралынхаа бүхий л талуудад сайн мэдээний дагуу амьдрахад нь тэднийг урамшуулан дэмжиж байв. Адамын дараа өөр бошиглогчид байсан хэдий ч, цаг хугацаа өнгөрөх тутам Адамын үр удам сайн мэдээг эсэргүүцэн шударга бус байхыг сонгож, улмаар урвалтанд автагдсан билээ.

Тийнхүү Хуучин Гэрээний цэдэглэгдсэн түүхийн ихийг бүрдүүлсэн бошиглогчдын эрин үеүдийн загвар эхэлсэн юм. Ноа, Абрахам хийгээд Мосе гэхчлэн бошиглогчидтой шууд харилцах замаар Тэнгэрлэг Эцэг Өөрийн сайн мэдээг илчилсэн билээ. Сайн мэдээний шинэ эрин үе бүрийг эхлэхийн тулд бошиглогч болгон Бурханаар дуудагддаг байв. Эдгээр бошиглогч бүрт санваарын эрх мэдлийг олгож, мөнхийн үнэнүүдийг илчилж байв. Харамсалтай нь, эрин үе болгонд хүмүүс өөрсдийн сонголтыг сайн мэдээг эсэргүүцэхэд ашиглаж, улмаар урвалтанд автагдаж байлаа.

Бошиглогчид

Өөрийн тань зааж байгаа хүн бошиглогчдын тухай юу ойлгосныг нь тодорхойл. Ариун буюу сүнслэг урам бүхий хүмүүс Бурханаас зарим удирдамж, чиглүүллийн хэлбэрийг хүлээн авдаг гэж итгэдэг хүмүүс ихэнх орнуудад байдаг. Хэдий тийм ч, сэргээгдсэн сайн мэдээнд, сүнслэг урам бүхий хүмүүс Бурханы бошиглогчид биш юм. Шинэ эрин үеийг үндэслэн байгуулах нэг бошиглогчийг дуудсанаар Бурхан Өөрийн хаант улсыг дэлхий дээр үндэслэн байгуулдгийг тодорхой тайлбарла. Тэрээр уг бошиглогчид санваарын эрх мэдлийг олгодог. Тэгээд уг бошиглогч Бурхантай харилцах тэдний харилцаа, түүний дотор Есүс Христийн сайн мэдээгээр дамжуулан мөнх амьдралыг хэрхэн хүлээн авахыг ойлгоход нь хүмүүст тусалдаг.

Христийн тухай анхны ойлголт буюу Христийн тухай анхны мэдэгдэхүүнгүй юмуу соёлгүй хүмүүст заахад сайн мэдээний эрин үеүд хэрхэн холбогдох тухайд та гайхаж болно. Гэвч сайн мэдээний эрин үеүдийн түүхийн тухай товчхон өгүүлснээр Бурхан Өөрийн хүүхдүүдийг хайрладаг хийгээд Тэрээр өчигдөр, өнөөдөр басхүү үргэлжид адил байдгийг ойлгоход нь хүмүүст тусалж чадна.

Судар Судлах**Бошиглогчид**

Иаков 4:4, 6
Мозая 8:13–18

Үйлс 10:34–43

Амос 3:7

Эрин үеүд

С ба Г 136:36–38
Моце 5:4–12, 55–59

Моце 8:19–30

Bible Dictionary, “Dispensations”

Аврагчийн Дэлхий дээрх Тохинуулал

Есүс Христийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнө хүмүүс дахин урвалтад унажээ. Гэвч Аврагч Өөрийн мөнх бус байдал дахь тохинууллыг эхэлсэн үед Тэрээр Өөрийн Сүмийг дэлхий дээр дахин үндэслэн байгуулсан юм.

Бүх хүн төрөлхтний нүглүүдийг цагаатгаж, үхлийг даван туулахын тулд Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүүг дэлхий рүү илгээжээ: “Бурхан дэлхийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. . . Ингэснээр түүгээр дамжин дэлхий

Тэмдэглэл

аврагдаж болох ажгуу” (Иохан 3:16–17). Түүний зовлон шаналлаар, дэлхий дээр амьдрах бүх хүмүүсийн нүглүүдийг Түүн дээр авч, биеийн үхлийг даван туулахын тулд бидний Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүү, Есүс Христийг илгээсэн юм. Хэрэв бид Түүнд итгэх итгэлтэй байж, наманчлан, баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчих юм бол, бид нүглүүдийнхээ уучлалыг хүлээн авч, биднийг Бурханы оршихуй дахь мөнх амьдрал уруу хөтлөх замд орж, түүнийг дагаж чадахын тулд Аврагч хязгааргүй цагаатгагч золиослолыг хийсэн билээ (2 Нифай 31:13–21-ийг үз).



Аврагч дэлхий дэх Өөрийн тохинууллын үед Өөрийн сайн мэдээг зааж, олон гайхамшгуудыг үйлдсэн юм. Тэрээр арванхоёр эрэгтэй хүнийг Өөрийн Төлөөлөгчид болгохоор дуудаж, тэдний толгой дээр гар тавин, тэдэнд санваарын эрх

мэдлийг олгосон билээ. Тэрээр Өөрийн Сүмийг зохион байгуулж, бошиглалыг гүйцэлдүүлэн, мөн эсэргүүцэгдэж, улмаар цовдлогдсон юм. Хамгийн чухал нь, Тэрээр Цагаатгалыг гүйцэлдүүлжээ. Бурханы Хүү, Их Эзэн Есүс Христ Түүгээр хийлгэхээр Тэнгэрлэг Эцэгийнхээ илгээсэн тэр бүхнийг гүйцэлдүүлсэн юм.

Аврагчийн үхэл хийгээд Амилуулалтаас өмнө, Тэрээр Өөрийн сайн мэдээг заах, авралын ёслолуудыг гүйцэтгэх болон Түүний Сүмийг дэлхийд байгуулах эрх мэдлийг Өөрийн Төлөөлөгчдөд өгчээ.

Судар Судлах

Итгэлийн Тунхаг 1:5
Матай 10:1–10

Лук 6:13
Иохан 15:16

Еврей 5:4

Их Урвалт

Есүс Христийн үхлийн дараа, ёс бус хүмүүс Төлөөлөгчид болон Сүмийн гишүүдийг мөшгин хавчиж, тэднээс олныг нь алжээ. Төлөөлөгчид үхсэнээр санваарын түлхүүрүүд хийгээд тэргүүлэх санваарын эрх мэдэл дэлхийгээс авагджээ. Төлөөлөгчид сайн мэдээний сургаалуудыг цэврээр нь хадгалж, жаяг болон Сүмийн гишүүдийн зохистой байдлын жишгийг хадгалж үлдээсэн байна. Төлөөлөгчидгүйгээр сургаалууд цаг хугацаа өнгөрөх тутам ялзран доройтож, Сүмийн зохион байгуулалт хийгээд баптисм түүнчлэн Ариун Сүнсний бэлэг хүртээх зэрэг санваарын ёслолуудад эрх мэдэл олгогдоогүй өөрчлөлтүүд хийгдсэн байлаа.

Илчлэлт болон санваарын эрх мэдэлгүйгээр хүмүүс судрууд хийгээд Есүс Христийн сайн мэдээний зарчмууд болон ёслолуудыг тайлбарлах хүмүүний мэргэн ухаанд найдах болжээ. Худал хуурмаг санаануудыг үнэн мэтээр зааж байлаа. Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ, түүнчлэн Ариун Сүнсний үнэн мөн чанар, шинж байдлын тухай мэдлэгийн ихэнх нь алга болсон байв. Есүс Христэд итгэх итгэлийн тухай сургаалууд, наманчлал, баптисм, тэрчлэн Ариун Сүнсний бэлэг мушгин гуйвуулагдсан буюу мартагдсан байлаа. Христийн Төлөөлөгчдөд

Тэмдэглэл

өгөгдсөн санваарын эрх мэдэл дэлхий дээр байхаа больжээ. Энэхүү урвалт олон янзын сүм үүсэн бий болоход хүргэжээ.

Сүнсний харанхуй олон зуун жил үргэлжилсний дараа, үнэнийг эрэлхийлэгч эрэгтэй, эмэгтэйчүүд тухайн үеийн шашны зан үйлийн эсрэг тэмцэх болов. Сайн мэдээний сургаалууд хийгээд ёслолуудаас олон нь өөрчлөгдсөн буюу алга болсныг тэд мэдсэн байна. Тэд илүү агуу сүнслэг гэрлийг эрж хайн, үнэнийг сэргээх шаардлагын тухай олон хүн ярьж байлаа. Гэвч Бурхан өөрсдийг нь бошиглогч байхаар дуудлаа гэж тэд тунхаглаагүй юм. Үүний оронд, өөрчлөгдсөн буюу мушгин гуйвуулагдсан гэж өөрсдийн итгэдэг байсан заадаг зүйлүүд болон зан үйлүүдийг шинэчлэх гэж хичээж байв. Тэдний хүч чармайлт Протестантын олон сүмийг зохион байгуулахад хүргэжээ. Энэхүү Шинэчлэл нь, эцэстээ Сэргээлтэд хүрэх замыг нээсэн шашны эрх чөлөөнд онцгой анхаарал хандуулахад нөлөөлсөн байна.

Нийтийг хамарсан энэ урвалтын тухай Аврагчийн бошиглогчид угтан хэлсэн юм. Есүс Христийн сайн мэдээ болон Түүний Сүм дэлхий дээр нэгэн цагт сэргээгдэх болно гэдгийг тэд бас угтан хэлсэн билээ.

Судар Судлах

1 Нифай 13	Үйлс 20:28–30	Амос 8:11–12
2 Нифай 26:20–21	Галат 1:6–9	Guide to the Scriptures, “Apostasy”
2 Нифай 28	2 Тесалоник 2:1–12	<i>True to the Faith</i> , х. 13–14
4 Нифай 1:27	(Иосеф Смитийн Орчуулга, шүлэг 2, 3, 7–9)	<i>Our Search for Happiness</i> , х. 23–32
С ба Г 86:1–3		<i>Jesus the Christ</i> , бүлэг 40, “The Long Night of Apostasy”
Матай 24:9–11	1 Тимот 4:1–3	
Марк 12:1–9	2 Тимот 4:3–4	
Үйлс 3:19–21	2 Петр 2:1–2	

Их Урвалт

Есүс Христ болон Түүний Төлөөлөгчдийн үхлийн дараа нийтийг хамарсан урвалт тохиосныг сонирхогчид ойлгох ёстой. Хэрэв урвалт байгаагүй бол, Сэргээлтийн шаардлага байхгүй байх байсан. Хар дуулган дээр алмааз илүү гялалзан харагддаг шиг, Сэргээлт нь Их Урвалтын бараан өнгөн дээр цочирдмоор эсрэг тэсрэг байдалтай байлаа. Сүнсээр удирдагдсанаараа, сонирхогчдын эрэлт хэрэгцээ болон нөхцөл байдалд тохируулан Их Урвалтын тухай нарийвчилсан түвшинд тэдэнд заа. Таны зорилго бол Есүс Христийн сайн мэдээг Сэргээх шаардлагыг ойлгоход нь тэдэнд туслах явдал мөн.

Чухал Ойлголтууд

- Есүс Христийн Сүм төлөөлөгчид хийгээд бошиглогчдын суурин дээр байгуулагдсан юм (Ефес 2:19–20; 4:11–14-ийг үз). Эдгээр удирдагчид бурханлиг санваарын эрх мэдэлтэй юм. Илчлэлтээр дамжуулан тэд Сүмийн ажил хэргийг чиглүүлдэг. Тэд сургаалын цэвэр ариун байдлыг хадгалж, ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй байж, бусдыг дуудаж, санваарын эрх мэдлийг тэдэнд олгодог.
- Хүмүүс Есүс Христ болон Төлөөлөгчдийг эсэргүүцэж, улмаар алав (Матай 24:9; 1 Нифай 11:32–34; 2 Нифай 27:5-ыг үз). Төлөөлөгчид үхсэнээр санваарын тэргүүлэх эрх мэдэл Сүмээс алга болжээ. Үүний улмаас, Ариун Сүнснийг хүртээх буюу аврагч бусад ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэл байхгүй болжээ. Илчлэлт зогсож, сургаал гуйвуулагджээ.
- Бүр Төлөөлөгчдийн үхлийн өмнө ч гэсэн, сургаалын талаар олон зөрчил үүссэн ажээ. Эхний үед Христэд итгэгчдийг мөшгин хавчиж байсан Ромын Эзэнт Гүрэн хожим нь Христийн шашныг хүлээн авсан байна. Шашны чухал асуудлуудыг зөвлөлүүд шийддэг байв. Аврагчийн заадаг байсан энгийн сургаалууд болон ёслолуудыг шүүмжлэн,

Тэмдэглэл

дэлхийн гүн ухаанд тохируулан өөрчилжээ (Исаиа 24:5-ыг үз). Тэд тодорхой бөгөөд үнэт сургаалуудыг судруудаас хассанаар тэдгээрийг мөн өөрчилж байлаа (1 Нифай 13:26–40). Хуурмаг, өөрчлөгдсөн сургаал дээр суурилсан итгэл үнэмшил буюу итгэлийн нотолгоог тэд бий болгожээ (Иосеф Смит—Түүх 1:19-ийг үз). Бардамналын улмаас зарим хүмүүс нөлөө бүхий албан тушаалуудад санаархах болжээ (3 Иохан 1:9–10-ыг үз). Эдгээр хуурмаг санаануудыг хүмүүс хүлээн авч, бурханлиг үнэнээс илүүгээр тааламжтай сургаалуудыг заадаг байсан хуурамч багш нарт хүндэтгэл үзүүлдэг болсон байв (2 Тимот 4:3–4-ийг үз).

- Түүхийн туршид олон хүмүүс хуурмаг итгэл үнэмшил хийгээд сургаалуудад чин үнэнээсээ итгэдэг байв. Тэд өөрсдийн эзэмшдэг асан гэрлийн дагуу шүтэн биширч, залбирлуудынхаа хариуг хүлээн авдаг байв. Бүр тэд “үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас ердөө л үнэнээс хол байдаг” байлаа (С ба Г 123:12).
- Тиймээс, шинэчлэл биш, харин сэргээлт шаардагдаж байв. Төлөөлөгч Петрээс хойш амжилтын шугам тасарснаас болоод Санваарын эрх мэдэл үргэлжилж чадсангүй. Шинэчлэх гэдэг нь аль хэдийнэ оршиж байгаа зүйлийг өөрчлөх явдал юм; сэргээх гэдэг нь ямар нэг зүйлийг анхны хэлбэрт нь буцааж оруулах явдал мөн. Тийнхүү, Бурханлиг элч нараар дамжуулан санваарын эрх мэдлийг сэргээсэн нь Их Урвалтыг даван туулах цорын ганц боломжтой арга зам байлаа.

Есүс Христийн Сайн Мэдээ Иосеф Смитээр Дамжин Сэргээгдсэн нь

Тохиромжтой нөхцөл байдал бүрдсэн үед Тэнгэрлэг Эцэг хайраар Өөрийн хүүхдүүдэд гараа дахин сунган хүрсэн юм. Иосеф Смит гэдэг нэртэй залууг Тэрээр бошиглогчоор дуудав. Түүгээр дамжин Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдал дэлхий дээр сэргээгдсэн юм.

Иосеф Смит тухайн үед шашны эрх чөлөөг эдэлдэг байсан цорын ганц орон байсан Нэгдсэн Улсад амьдарч байлаа. Энэ бол Нэгдсэн Улсын зүүн хэсэгт шашин ихээр идэвхжсэн үе байв. Түүний гэр бүлийн гишүүд гүнзгий шүтлэг бишрэлтэй байсан бөгөөд үнэнийг байнга эрж байлаа. Гэвч олон тохинуулагчид өөрсдөд нь үнэн сайн мэдээ бий хэмээн мэдэгдэж байв. “Бүх бүлэглэлүүдээс аль нь зөв болохыг мэдэхийг” Иосеф хүсч байлаа (Иосеф Смит—Түүх 1:18). “Нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм” байдаг хэмээн Библи заадаг байлаа (Ефес 4:5). Иосеф олон өөр сүмд очиж үзсэн хэдий ч, тэр ямар сүмд нэгдэх ёстой тухайд төөрөлдсөн хэвээр байлаа. Хожим нь тэрээр бичихдээ:

“Шашны янз бүрийн бүлгүүдийн дундах будлиан хийгээд сөргөлдөөн тийм их байсан нь. . . миний мэт залуу хүний хувьд хэнийх нь зөв, бас хэнийх нь буруу байсан талаар ямар нэг тодорхой дүгнэлт хийх боломжгүй байв. . . . Үгийн болон санаа бодлын үймээн самуунтай энэхүү дайны дунд би: Яах билээ? Эдгээр бүх бүлэглэлүүдээс хэн нь зөв бол; эсвэл тэд бүгдээрээ буруу юу? Хэрэв тэднээс аль нэг нь зөв бол, аль нь бол, тэгвэл би үүнийг яаж мэдэх вэ? хэмээн өөрөөсөө олонтаа асуудаг байлаа” гэжээ (Иосеф Смит—Түүх 1:8, 10).

Янз бүрийн итгэлүүдийн дотор Иосеф үнэнийг эрж байхдаа тэрээр удирдамжийн төлөө Библид ханджээ. “Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг; тэгвэл энэ нь түүнд өгөгдөх болно” гэж тэр уншсан ажээ (Иаков 1:5). Энэ хэсгийн улмаас Иосеф яах талаараа Бурханаас асуухаар шийджээ. 1820 оны хавар тэр ойролцоох ойн цоорхойд очиж, залбиралд өвдөг сөгджээ. Тэрээр өөрт тохиолдсон зүйлийг дүрслэхдээ:

Тэмдэглэл

“Өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харлаа. . . . Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд алдар суу нь бүхий л устгалыг ялан дийлсэн хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—Энэ бол Миний Хайртай Хүү, Түүнийг Сонс!” (Иосеф Смит—Түүх 1:16–17).

Энэ үзэгдэлд Бурхан Эцэг, Түүний хүү Есүс Христ хоёр Иосеф Смит дээр хүрч иржээ. Сүмүүдийн алинд нь ч элсэхгүй байхыг Аврагч Иосефт хэлэв, учир нь тэд “бүгдээрээ буруу байсан” бөгөөд “тэдний бүхий л итгэл үнэмшил жигшүүрт хэрэг байлаа.” “Тэд уруулаараа надтай ойр боловч, зүрх сэтгэлээрээ надаас хол байдаг, тэд үүний хүчийг үгүйсгэдэг” гэж тэрээр өгүүлжээ (Иосеф Смит—Түүх 1:19). Хэдийгээр олон сайн хүмүүс Христэд итгэж, Түүний сайн мэдээг ойлгож, заахыг хичээж байсан ч гэсэн, үнэний бүрэн байдал буюу баптисм хүртээх болон аврагч бусад ёслолуудыг гүйцэтгэх санваарын эрх мэдэл тэдэнд байсангүй. Эрин үе болгон өмнөх эрин үеийнхээ үлдээсэн нөлөөгөөр тэд урвалтын байдал, түүний дотор сургаалууд болон баптисм зэрэг ёслолуудад оруулсан өөрчлөлтүүдийг залгамжлан авсан байна. Адам, Ноа, Абрахам, Мосе болон бусад бошиглогчдыг Бурхан дуудсаны нэгэн адилаар, түүгээр дамжуулан сайн мэдээний бүрэн байдлыг дэлхий дээр сэргээхийн тулд Иосеф Смитийг бошиглогч байхаар Тэрээр дуудсан билээ.



Эцэг Хүү хоёрыг хүрч ирсний дараа, тэнгэрлэг бусад элчүүд буюу сахиулсан тэнгэрүүд Иосеф Смит, түүний хамтран зүтгэгч Оливер Каудери уруу илгээгдсэн юм. Иохан Баптист хүрч ирэн баптисмын ёслолыг гүйцэтгэх эрх мэдлийг өөртөө багтаадаг Аароны Санваарыг Иосеф Смит, Оливер Каудери хоёрт олгожээ. Петр, Иаков, Иохан (Христийн анхны гурван Төлөөлөгч) нар хүрч ирэн Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Мелкизедек Санваар олгож, эрт дээр үед Христийн Төлөөлөгчдөд өгсөн тэрхүү эрх мэдлийг сэргээсэн байна. Иосеф Смит санваарын энэхүү эрх мэдэлтэйгээр Есүс Христийн Сүмийг дэлхий дээр дахин зохион байгуулахаар удирдуулагджээ. Түүгээр дамжуулан Есүс Христ арванхоёр Төлөөлөгчийг дуудсан билээ.

Библийн бошиглогчдын зааснаар бидний амьдарч байгаа үе бол эцсийн өдрүүд, хожмын үе буюу цаг хугацааны бүрэн байдлын эрин үе юм. Энэ бол Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн яг өмнөх үе мөн. Чухам ийм учраас Сүм нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэж нэрлэгддэг.

Өнөөдөр Сүмийг амьд бошиглогч удирддаг. Энэ бошиглогч нь, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч бөгөөд Иосеф Смитээр эрх мэдэл олгогдсон залгамжлагч юм. Тэр болон одоогийн Төлөөлөгчид нь Иосеф Смитээр дамжсан ёслолуудын тасраагүй гинжин хэлхээний эрх мэдлээрээ Есүс Христтэй холбогддог.

Иосеф Смит—Түүх 1:16–17-г цээжил

Эцэг, Хүү хоёрыг харсан тухай Иосеф Смитийн дүрслэлийг (Иосеф Смит—Түүх 1:16–17) цээжилж, түүний өөрийнх нь үгсийг ашиглан Анхны Үзэгдлийг дүрслэхэд үргэлж бэлэн бай. Үүнийг бүү түргэн гүйлгэн унш. Энэ нь үнэн гэдгийг мэдэж байгаа тухай чин сэтгэлийн гэрчлэлээ хэл. Энэхүү үнэнийг та яаж мэдсэнээ тайлбарлахдаа бүү эргэлзэж тээнэгэлз. Мөн үүнчлэн хийхийг хамтрагчаасаа хүс.

Гэрчлэлээ Авчир

Номлогчийн үүргийн нэг чухал хэсэг бол одоогийн бошиглогч хийгээд Сүмийн ерөнхийлөгчийн тухай гэрчлэх явдал мөн.

Судар Судлах

2 Нифай 3
С ба Г 112:30

Ефес 4:5
Иаков 1:5

*Бошиглогч Иосеф Смитийн
Гэрчлэл, Товхимол*

Тэмдэглэл

Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ

Харанхуйн олон зууны эргэлзээ, итгэлгүй байдал хийгээд буруу ташаа мэдээлэл хэвээр үлдэх болно гэдгийг мэдсэнээр биднийг хайрлагч Тэнгэрлэг Эцэг маань Есүс Христийн үүрдийн сайн мэдээний бүрэн байдлыг агуулсан, Библиетэй дүйцхүйц эртний ариун судрын ботийг урагш авчирсан билээ. Ариун судрын энэхүү боть нь Иосеф Смит бол Бурханы үнэн бошиглогч мөн гэдгийн итгэл үнэмшилтэй нотолгоог агуулдаг. Энэхүү цэдэг бол Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ юм.

Моронай хэмээх нэртэй тэнгэрлэг элчээр Иосеф Смит, олон зууны туршид алтан ялтсуудыг нуусан байсан нэгэн гүвээ рүү удирдуулагдсан юм. Эдгээр алтан ялтсууд

Америкийн эртний оршин суугчдын заримтай нь Бурхан харилцаж байсан тухай шастирыг өгүүлсэн бошиглогчдын бичээсүүдийг агуулж байжээ. Иосеф Смит Бурханы хүчээр эдгээр ялтсуудын агуулгыг орчуулсан юм. Мормоны Номон дахь бошиглогчид Аврагчийн үүрэг зорилгын тухай мэддэг байж, тэгээд Түүний сайн мэдээг зааж байжээ. Өөрийн Амилуулалтын дараа Христ эдгээр хүмүүст үзэгджээ. Тэрээр тэдэнд Өөрийн сайн мэдээг зааж, Өөрийн Сүмийг үндэслэн байгуулсан байна. “Бурхан хүмүүнд бурханлигаар нөлөөлж, эрт дээр үеийн нэгэн адил энэ үе хийгээд эрин зуунд тэднийг өөрийн ариун ажилд дууддагийг” (С ба Г 20:11) Мормоны Ном нотолдог. Мормоны Ном үнэн гэдгийг мэдэхийн тулд хүн үүнийг уншиж, тунгаан бодож, мөн үүний тухай залбирах ёстой. Үнэнийг чин шударгаар эрэлхийлэгч нь Мормоны Ном бол Бурханы үг мөн гэдэг мэдрэмжид удалгүй хүрэх болно.

Тэмдэглэл

Мормоны Номыг уншиж, тунгаан бодож, мөн үүний тухай залбирах нь хүн бүрэн, эргэлт буцалтгүй хөрвөхөд шийдвэрлэх ач холбогдолтой юм. Анх удаа Мормоны Номыг уншиж эхэлж байгаа хүмүүс Иосеф Смит бол Бурханы үнэн бошиглогч мөн үнэн Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг мэдэх чухал алхамыг хийдэг.

Сэргээлтийн Үнэнийг Батлахын Тулд Мормоны Номыг Ашигла

Дараах нь Мормоны Номыг танилцуулахад таны хэлж болох зүйлийн жишээ юм:

“Бурхан Өөрийн хүүхдүүдэд хайртай, тиймээс Тэрээр бидний ярьж байгаа зүйлийн үнэнийг батлахын тулд үнэмшүүлэх арга замаар хангадаг байлаа. Энэ бол Мормоны Ном юм. Уг номны удиртгалын сүүлчийн хоёр догол мөрийг та уншиж үзэх үү?” Хэрэв Мормоны Номны одоогийн орчуулга дээр удиртгал хэсэг ороогүй бол Англи Мормоны Номон дахь удиртгалын сүүлчийн 2 догол мөрийг уншаад, догол мөрний ерөнхий дүгнэлтийг өг.

Хоёр догол мөрөн дэх үзэл баримтлал бүрийн утгыг анхааралтай тайлбарлаж, Мормоны Номын хэсгүүдийг уншиж, энэ хоёр догол мөрөнд дүрслэгдсэн зарчмуудыг хэрэгжүүлэхээр амлахад сонирхогчийг урь.

Мормоны Номыг хүнд танилцуулахдаа номын нэг хувийг түүнд үзүүлж, агуулгынх нь талаар товч дурдаж, өөрийн тань хувьд утга учиртай, эсвэл тухайн хүний хувьд утга учиртай байж болох нэг буюу хоёр хэсгийг хуваалцах нь ашигтай.

Судар Судлах

Мормоны Номын Эхний Хуудас	С ба Г 1:17–23	Иосеф Смит—Түүх 1:27–64
Мормоны Номын Удиртгал, догол мөр 1–7	С ба Г 20:5–12	

Ариун Сүнсээр Дамжуулан Үнэнийг Мэдэхийн тулд Залбир

Сэргээлтийн захиас нэг бол үнэн эсвэл тийм биш. Моронай 10:3–5–д амлагдсан Ариун Сүнсээр энэ үнэн гэдгийг бид мэдэж чадна. Мормоны Номны захиасыг уншиж, тунгаан бодсоны дараа үнэнийг мэдэхийг хүсдэг хэн ч гэсэн, энэ нь үнэн үү гэдгийг Есүс Христийн нэрээр Тэнгэрлэг Эцэгт хандан залбиралд асуух ёстой. Үүнийг хийхийн тулд, бид Тэнгэрлэг Эцэгтээ ханддаг. Бид адислалуудынхаа төлөө Түүнд талархан, Мормоны Номны захиас үнэн эсэхийг мэдэхийн тулд асуудаг. Залбиралгүйгээр сүнслэг үнэнүүдийг хэн ч мэдэж чадахгүй.

Бидний залбиралуудын хариуд бидний мэдрэмжүүд хийгээд бодол санаагаар дамжуулан Ариун Сүнс үнэнийг бидэнд заах болно. Ариун Сүнснээс ирдэг мэдрэмжүүд хүчирхэг байдаг ч гэсэн бас тэдгээр нь уян зөөлөн, намуухан байдаг. Бидний мэдсэн зүйл үнэн гэдгийг бид мэдэрч эхлэхэд, Сэргээлтийн тухай өөрсдийн мэдэж чадах бүхнийг мэдэхийг бид хүсэх болно.

Мормоны Ном үнэн гэдгийг мэдэх нь Иосеф Смит бошиглогчоор дуудагдсан, мөн Есүс Христийн сайн мэдээ түүгээр дамжин сэргээгдсэн тухай мэдлэг рүү хөтөлдөг.

Залбирал

- Тэнгэрлэг Эцэгтээ ханд (Тэнгэр дэх Эцэг минь ээ, . . .)
- Зүрх сэтгэлийнхээ мэдрэмжүүдийг илэрхийл (талархал, асуултууд, Мормоны Ном үнэн эсэхийг батлах хүсэлт гэхчлэн).
- Хаалт (“Есүс Христийн нэрээр, амен”).

Залбирал

Залбирал нь олон шашин хийгээд соёлуудад үүрэг гүйцэтгэдэг ч гэсэн, залбирал Бурхан болон хүмүүний хоорондох харилцааны хоёр талт арга гэж тооцогдох нь ховор байдаг. Залбирахдаа өөрсдийнхөө зүрх сэтгэлийн мэдрэмжүүдийг ярьж болно гэдгийг ойлгоход нь заадаг хүмүүстээ тусал. Хичээл эхлэх буюу дуусгахдаа залбирдаг байдалдаа та үүнийг харуул. Тэдний залбирахдаа ашиглаж болох энгийн хэл яриаг ашигла. Тэнгэрлэг Эцэг маань ихэвчлэн зүрх сэтгэлийнх нь мэдрэмжүүд хийгээд оюун санааных нь бодлуудаар дамжуулан тэдний асуултуудад хариулах болно гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал. Хэрэв тэд чин үнэнээсээ хандаж, Бурхан байдаг эсэхийг мэдэхийг үнэхээр хүсэх юм бол, Тэрбээр тэдэнд хариулах болно. Хичээлийн төгсгөлд өвдөг сөгдөн залбирахыг гэр бүлийн тэргүүнээс хүс.

Судар Судлах

Алма 5:45–46
С ба Г 8:2–3

Иохан 14:26

Мормоны Номны Удиртгал,
догол мөр 8–9

Баптисм Хүртэх Урилга

Энэ буюу аль нэг хичээлийн үед баптисм хүртэж, гишүүнээр батлуулахад нь хүмүүсийг урихад бүү эргэлз.

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулахад хүмүүсийг урихад бэлтгэхийн тулд, бүх хүмүүс эрх мэдлээр баптисм хүртэхийн, нүглүүдийн ангижралыг хүлээн авахын, түүнчлэн Ариун Сүнсний гайхамшигт бэлгийн ач холбогдлыг олонтаа гэрчил. “Их Эзэн таны залбиралуудад хариулж, энэхүү захиас үнэн гэдгийг мэдэрсэн үедээ та баптисм хүртэж Есүс Христийн үлгэр жишээг дагах уу?” гэж асууж болно.

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулах урилга нь: “Бурханы санваарын эрх мэдлийг атгагч хэн нэгнээр та баптисм хүртэж Есүс Христийн үлгэр жишээг дагах уу? Бид (. . . сарын . . . өдөр) баптисмын үйлчилгээ явуулах болно. Энэ өдөр та баптисм хүртэхээр өөрийгөө бэлтгэх үү?” гэж хувь хүнд тухайлан хандаж шууд асуусан байх ёстой.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Заах Санаанууд

Энэ хичээлд бэлтгэх болон заахад таны ашиглах санаанууд энэ хэсэгт байгаа. Эдгээр санаануудыг хэрхэн ашиглахыг шийдэхдээ Сүнснийг залбиралтайгаар дага. Та хичээлийнхээ төлөвлөгөөнд сонголт хийх үедээ эдгээр санаануудыг нэм. Эдгээр санаанууд бол өөрийн тань заадаг хүмүүсийн эрэлт хэрэгцээг шийдвэрлэхэд өөрт тань туслах зөвлөмжүүд болохоос биш, шаардлагууд биш гэдгийг сана.

Богино Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (3–5 минут)

Олон зууны турш алга болсны дараа Есүс Христийн сайн мэдээг нэгэн амьд бошиглогчоор дамжуулан бидний хайрт Тэнгэрлэг Эцэг дэлхий дээр сэргээсэн юм. Мормоны Ном бол үүний нотолгоо мөн. Та үүнийг гартаа барьж болно. Та үүнийг уншиж, уг номон дахь захиас таны амьдралыг хэрхэн дээшлүүлж чадах тухай тунгаан бодоод, захиас нь Бурханы үг гэдгийг мэдэхийн тулд залбир.

- Бурхан Бол Бидний Хайрт Тэнгэрлэг Эцэг Мөн
- Сайн Мэдээ Гэр Бүлүүдийг Адисалдаг
- Тэнгэрлэг Эцэг Өөрийн Сайн Мэдээг Эрин Үе Болгонд Илчилдэг
- Дэлхий Дээрх Аврагчийн Тохинуулал
- Их Урвалт
- Есүс Христийн Сайн Мэдээ Иосеф Смитээр Дамжин Сэргээгдсэн нь
- Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ
- Ариун Сүнсээр Дамжуулан Үнэнийг Мэдэхийн Тулд Залбир

Даалгаврууд:

- Та Мормоны Ном нь Бурханы үг гэдгийг мэдэхийн тулд үүнийг уншиж, залбирах уу?
- Иосеф Смит бошиглогч байсныг мэдэхийн тулд залбирах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтыг товлож болох уу?
- Хичээл 4–өөс таны сонгож оруулах зарлигууд.

Дунд Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (10–15 минут)

Бидний захиас гайхамшигтай хийгээд энгийн юм. Бурхан бол бидний Эцэг. Бид Түүний хүүхдүүд. Бид бол Түүний гэр бүлийн нэг хэсэг. Тэр бидэнд хайртай. Дэлхийн эхлэлээс Тэр хайр болоод санаа тавилтын загварыг дагасан билээ. Өөрийнх нь хүүхдүүд түүнд хэрхэн эргэж очихыг мэдэж болохын тулд Есүс Христийн сайн мэдээг хайранд илчлэхээр Тэр олон удаа тэдэнтэй харилцсан юм. Тэрээр үүнийг Адам, Ноа, Абрахам болон Мосе мэтийн бошиглогчдод илчилсэн билээ. Гэвч хүмүүс сайн мэдээг дахин давтан эсэргүүцэх сонголт хийжээ. Хоёр мянган жилийн өмнө Есүс Христ Өөрийн сайн мэдээгээ Өөрөө зааж, Өөрийн Сүмийг үндэслэн байгуулсан билээ. Хачирхалтай нь, хүмүүс бүр Есүсийг ч эсэргүүцэв. Хүмүүс үнэн сургаалууд хийгээд ёслолуудыг үл ойшоох буюу мушгин гуйвуулсан үед Сүмийг удирдах Өөрийн эрх мэдлийг Бурхан буцаан татаж авдаг.

Танд болон бүх хүмүүст бидний хүргэх урилга бол таны аль хэдийн эрхэмлэн үнэлдэг үнэнүүд дээр нэмэх явдал мөн. Бидний Тэнгэрлэг

Тэмдэглэл

Эцэг болон Түүний Хүү Есүс Христ хоёр Бурханы хүүхдүүдэд хандсан хайранд дахин хүрч, сайн мэдээний бүрэн байдлыг нэгэн бошиглогчид илчилсэн тухай бидний нотолгоог анхааралдаа ав. Энэ бошиглогчийн нэр Иосеф Смит. Энэхүү алдар суут үнэний тухай нотолгоо, та нарын уншиж, тунгаан бодож, залбирч болох Мормоны Номонд байдаг. Хэрэв та чин сэтгэлээсээ, үнэнхүү зорилго хийгээд Христэд итгэх итгэлтэйгээр залбирах юм бол, энэ ном үнэн гэдгийг Бурхан Ариун Сүнсний хүчээр танд хэлэх болно.

Даалгаврууд:

- Та Мормоны Ном нь Бурханы үг гэдгийг мэдэхийн тулд үүнийг уншиж, залбирах уу?
- Иосеф Смит бошиглогч байсныг мэдэхийн тулд та залбирах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтыг товлож болох уу?
- Хичээл 4-өөс сонгож оруулах зарлигууд

Бүрэн Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (30–45)

- Бурхан бол Бидний Хайрт Эцэг
 - Бид Бурханы хүүхдүүд (Үйлс 17:29-ийг үз).
 - Бурхан бидэнд хайртай бөгөөд зөв сонголтууд хийхэд бидэнд туслах болно.
 - Есүс Христээр дамжин бид Бурхантай дахин хамт амьдарч чадна (Иохан 3:16–17-г үз).
- Сайн Мэдээ Гэр Бүлүүдийг Адисалдаг
 - Есүс Христийн сайн мэдээ илүү хүчтэй харилцааг хөгжүүлэхэд гэр бүлүүдэд тусалдаг.
 - Гэр бүлүүд Бурханаас томилогддог; тэдгээр нь энэ амьдрал болон үүрд мөнхөд нийгмийн хамгийн чухал нэгж мөн (С ба Г 49:15–16-г үз).
 - Гэр бүл бол сайн мэдээний зарчмуудыг заах, сурах болон хэрэглэхэд хамгийн тохиромжтой газар мөн (С ба Г 68:25; Эхлэл 18:19; Дэд хууль 6:7-г үз)
 - Гэр бүл нь аюулгүй байдал, амар амгалан болон баяр хөөрийн газар байж чадна.
- Тэнгэрлэг Эцэг Өөрийн Сайн Мэдээг Эрин Үе Болгонд Илчилдэг
 - Бурхан Өөрийн Сайн Мэдээг заахын тулд бошиглогчдыг дууддаг (Амос 3:7-г үз)
 - Урвалт гэдэг нь бошиглогчдыг хийгээд сайн мэдээг эсэргүүцнэ гэсэн үг.
 - Энэ үеүд бол бошиглогчид сайн мэдээг заасан цаг үеүд юм. Өмнөх эрин үеүд урвалтанд орсноор дуусч байжээ (С ба Г 136:36–38-ыг үз).

Тэмдэглэл

- Адам, Ноа, Абрахам, Мосе болон эртний бусад бошиглогчид бүгдээрээ сайн мэдээг зааж байв (Мосе 5:4–12–ыг үз).
- Дэлхий Дээрх Аврагчийн Тохинуулал
 - Бурханы Хүү сайн мэдээг сэргээж, мөн заав. Тэр олон гайхамшгийг үйлдэв (Bible Dictionary, “ Miracles,” 732–33–ыг үз).
 - Тэрээр Төлөөлөгчдийг дуудаж, сайн мэдээг номлох болон баптисм зэрэг аврагч ёслолуудыг гүйцэтгэх санваарын эрх мэдлийг тэдэнд олгов (Иохан 15:16-г үз).
 - Христ Өөрийн Сүмийг үндэслэн байгуулав.
 - Христ цовдлогдож, Түүний Төлөөлөгчид эсэргүүцэгдэж, мөн алагдав (Матай 27:35; Марк 15:25-ыг үз).
 - Христ Цагаатгалыг гүйцэлдүүлэв (Bible Dictionary, “Atonement,” 617-г үз).
- Их Урвалт
 - Бошиглогчоор дамжсан илчлэлтгүйгээр хүмүүс сүнсийн харанхуйд унадаг (Амос 8:11–12-ыг үз).
 - Бошиглогчид болон Төлөөлөгчид Их Урвалтыг угтан хэлэв (2 Тесалоник 2:1–3-ыг үз).
- Иосеф Смитээр дамжин Есүс Христийн Сайн Мэдээ Сэргээгдсэн нь
 - Иосеф үнэнийг эрж хайв (Иосеф Смит—Түүх 1:8, 10-ыг үз).
 - Бурхан, Есүс Христ хоёр Иосеф Смит дээр хүрч ирэв (Иосеф Смит—Түүх 1:16–17-г үз).
 - Эхний эрин үеүдийн бошиглогчдын нэгэн адил, Иосеф Смит энэ сүүлчийн эрин үеийн бошиглогчоор дуудагдав.
 - Бурхан Иосеф Смитээр дамжуулан сайн мэдээний бүрэн байдлыг сэргээв (С ба Г 35:17; 135:3-ыг үз).
 - Бусад тэнгэрлэг элчүүд санваарыг сэргээж, ингээд Христийн Сүм зохион байгуулагдав (С ба Г 13; 27:12-ыг үз).
 - Өнөөдөр амьд бошиглогч Сүмийг удирддаг.
- Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ
 - Мормоны Ном бол Иосеф Смит бошиглогч байсны итгэл үнэмшилтэй нотолгоо мөн.
 - Иосеф алтан ялтсуудыг Бурханы хүчээр орчуулав (Мормоны Номны Удиртгал, догол мөр 5-ыг үз).
 - Эрин үе болгонд байсны адилаар Бурхан бошиглогчдод сүнслэг урам өгдгийг Мормоны Ном нотолдог. (С ба Г 20:5–12-ыг үз).
 - Мормоны Ном Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг (С ба Г 20:8–9-ийг үз).
- Ариун Сүнсээр дамжуулан Үнэнийг Мэдэхийн тулд залбир

Тэмдэглэл

- Мормоны Ном үнэн гэдгийг та мэдэж болно (Моронай 10:3–5; Мормоны Номны Удиртгал, догол мөр 1, 8–9-ийг үз).
- Таны бодол санаа, мэдрэмжүүдээр дамжуулан Ариун Сүнс танд заах болно (С ба Г 8:2–3-ыг үз).

Даалгаврууд:

- Та Мормоны Ном нь Бурханы үг гэдгийг мэдэхийн тулд үүнийг уншиж, залбирах уу?
- Иосеф Смит бошиглогч байсныг мэдэхийн тулд та залбирах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтыг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах зарлигууд

Заасныхаа Дараа Асуух Асуултууд

- Бидний заасан зүйлийн талаар танд ямар асуултууд байна вэ?
- Хэрэв өнөөдөр дэлхий дээр амьд бошиглогч байгаа бол та түүнээс юу асуух вэ?
- Бурхан таны залбирлуудыг сонсдог гэж та боддог уу? Яагаад?
- Мормоны Ном үнэн гэдгийг та мэдэхийг хүсч байна уу? Яагаад?

Чухал тодорхойлолтууд

- **Бошиглогч:** Бурханаар дуудагдаж, Түүний өмнөөс ярьдаг хүн. Бурханы элчийн хувьд бошиглогч нь санваарын эрх мэдэл, зарлигууд бошиглолууд болоод илчлэлтүүдийг Бурханаас хүлээн авдаг. Түүний үүрэг бол Бурханы хүсэл болон зөв зан төлвийг хүмүүнд таниулж, хүмүүнтэй харьцах Түүний үйл хэргийн утга учрыг харуулах явдал мөн. Бошиглогч нүглийг шүүмжилж, үүний үр дагавруудыг угтан хэлдэг. Тэр бол зөв шударга ёсыг номлогч мөн. Бошиглогч хүн төрөлхтний ашиг тусын тулд үе үе ирээдүйг угтан хэлэхээр сүнслэг урам хүлээн авч болно. Гэвч түүний үндсэн үүрэг нь Христийн тухай гэрчлэх явдал мөн.
- **Гэтэлгэгч:** Есүс Христ Өөрийн Цагаатгалаар дамжуулан хүн төрөлхтний нүглүүдийн төлөө төлөөс төлж, улмаар бүх хүмүүсийн амилуулалтыг боломжтой болгосон учраас Тэр бол агуу Гэтэлгэгч мөн. Гэтэлгэх гэдэг нь төлбөр хийх замаар хүнийг боолчлолоос ангижруулах гэхчлэн чөлөөлөх, худалдаж авах буюу төлөөсийг төлөх явдал мөн. Гэтэлгэл нь Есүс Христийн Цагаатгал ба нүглээс чөлөөлөхөд холбогдох бөгөөд Есүсийн Цагаатгал бүх хүн төрөлхтнийг биеийн үхлээс гэтэлгэдэг. Гетсемани дахь болон загалмай дээрх Түүний зовлон шаналал мөн түүнчлэн Түүний Амилуулалтыг багтаадаг Түүний Цагаатгалаар дамжин Түүнд итгэх итгэлтэй хүмүүс тэрчлэн наманчилдаг хүмүүс сүнсний үхлээс гэтэлгэгддэг.
- **Илчлэлт:** Бурханаас дэлхий дээрх Өөрийн хүүхдүүдтэй харилцах харилцаа. Илчлэлт нь сүнслэг урам, үзэгдлүүд, зүүд буюу тэнгэр элчүүдийн айлчлалтын хэлбэрээр Христийн Гэрэл буюу Ариун Сүнсээр дамжин ирж болно. Илчлэлт нь итгэлтнүүдийг сэлэстиэл хаант улс дахь мөнхийн аврал уруу хөтлөх удирдамжаар хангадаг. Их Эзэн Өөрийн ажлыг Өөрийн бошиглогчдод илчилж, илчлэлтүүд үнэн гэдгийг итгэгчдэд баталдаг (Амос 3:7-г үз). Их Эзэн илчлэлтээр дамжуулан үүнийг эрэлхийлдэг тэрчлэн итгэлтэй, наманчилдаг,

Тэмдэглэл

Есүс Христийн сайн мэдээнд дуулгавартай байдаг хүн бүрийг нэг бүрчилсэн удирдамжаар хангадаг.

- **Санваар:** Хүн төрөлхтний авралын төлөөх бүх зүйлүүдийг Есүс Христийн нэр дээр үйлдэх, Бурханаас хүнд олгосон эрх мэдэл ба хүч.
- **Сонголт:** Бурханаас хүмүүст өгсөн өөрсдийнхөө төлөө сонгож, үйлдэх чадвар болон онцгой боломж.
- **Сэргээлт:** Сэргээх гэдэг нь өмнөх байдалд нь буцааж оруулах буюу буцааж авчрах гэсэн утгатай. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хэрэглэгдгээр Сэргээлт нь урвалтаар дамжин байхгүй болсон Есүс Христийн үнэн Сүмийг Есүс Христ анх зохион байгуулахад байсан тэр хэлбэрээр нь эргүүлэн авчирсан гэсэн утгатай. Шинэчлэлттэй адилгүй нь, Сэргээлт нь илчлэлтээр дамжсан бурханлиг эрх мэдлээр гүйцэлдсэн билээ.
- **Урвалт:** Хувь хүмүүс Сүм буюу улс үндэстэн бүхлээрээ үнэнээс эргэх. Энэ нь эрх мэдлийн эсрэг тэмцэж, бошиглогчдыг эсэргүүцэх явдлыг багтаадаг. Урвалтын нотолгоо нь Бурханы хуулиудыг зөрчих, сайн мэдээний ёслолуудыг өөрчлөх түүнчлэн гэрээнүүдийг зөрчих явдлыг өөртөө багтаадаг (Исаиа 24:5-ыг үз).
- **Шинэчлэгч:** Шинэчлэх гэдэг нь ямар нэг юмыг сайжруулахын тулд үүнд өөрчлөлт хийх гэсэн үг. Шинэчлэгч гэдэг нэр томъёо нь тухайн үед оршиж байсан сүмийн зан үйлийг шинэчлэх хэрэгтэй гэж үздэг байсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй (Мартин Лютер, Жон Калвин, Виллиам Тиндейл, Жон Виклиффе гэх мэт) холбогдоно.
- **Эрин Үе:** Ариун санваарын түлхүүрүүдийг атгадаг, эрх мэдэл олгогдсон, хамгийн наад тал нь нэг үйлчлэгч Их Эзэнд байдаг цаг хугацаа. Есүс Христээс гадна, Адам, Енох, Ноа, Абрахам, Мосе болон Иосеф Смит зэрэг бошиглогчид тус бүрдээ сайн мэдээний шинэ эрин үеийг эхэлжээ. Их Эзэн нэг эрин үеийг зохион байгуулахад, тухайн эрин үеийн хүмүүс авралын төлөвлөгөөний тухай мэдлэгийн хувьд өнгөрсөн эрин үеүдээс хамааралтай байхгүйн тулд, сайн мэдээ шинээр илчлэгддэг. Иосеф Смитийн эхэлсэн эрин үе “цаг хугацааны бүрэн байдлын эрин үе” гэж нэрлэгддэг.

Таны Заадаг Хүмүүст Хэрэгтэй Байж Болох Цаашдын Тодорхойлолтын Бусад Нэр Томъёонууд

- | | | |
|-----------------------|---|---------------------------------------|
| • Аврагч | • Залбирал | • Судрууд |
| • Авралын ёслолууд | • Зарлигуудад дуулгавартай, мөн дуулгаваргүй байх | • Төлөөлөгч |
| • Ажил үүрэг | • Нүгэл | • Түүний дэргэд амьдрахаар эргэж очих |
| • Ариун Сүнсний бэлэг | • Сайн мэдээ | • Эцсээ хүртэл тэвчих |
| • Библи | | |

Тэмдэглэл

Шинэчлэгчид ба Дэлхийн Шашны Удирдагчид

Дараах зүйл бол зөвхөн шаардлагатай үед хэрэглэгдэх суурь мэдээлэл юм.

Жон Виклиффе: 14-р зуунд Англид төржээ. Оксфордын Их Сургуулийн шашин судлаач эрдэмтэн. Католик Сүм санваарын түлхүүргүйг, Ариун Ючарист (эсвэл ариун ёслол) нь Христийн жинхэнэ бие биш болохыг, түүнчлэн уг сүм хүмүүсийн дээр улс төрийн хүчтэй байх ёсгүйг зааж байв. Библийг англи хэлэнд орчуулжээ. 1384 оны Арванхоёрдугаар сарын 31-нд нас баржээ.

Мартин Лютер: 1483 оны 11-р сарын 10-нд Германд төржээ. Эрфуртын болон Виттенбергийн Их Сургуульд сурч байв. Ромын Католик Сүмээс тухайн үед заадаг байсан олон зүйлийг, түүний дотор нүглүүдийнхээ өршөөлийн төлөө хүмүүсээр мөнгө төлүүлдэг зан үйлийг эсэргүүцсэн 95 мэдэгдлийг Кастл Сүмийн хаалган дээр хаджээ. 1546 оны 2-р сарын 18-нд нас барсан байна.

Виллиам Тиндейл: 1494 онд Уэльст төржээ. Оксфорд, Кембриджид сурч байв. Шинэ Гэрээг англи хэлэнд орчуулжээ. Хуурмаг сургаалууд болон шашны удирдагчдын ялзралыг жирийн хүмүүст илчлэхийн тулд судруудыг хүртээмжтэй болгосон байна. Тэрээр 1536 оны 10-р сарын 6-нд цаазаар авахуулжээ.

Жон Калвин: 1509 оны 7-р сарын 10-нд Францад төржээ. Санваартан болохын тулд Парист суралцаж байв. Католик Сүмийг шинэчлэх хөдөлгөөний гол удирдагч. Амьдралынхаа ихэнхийг Швейцарт өнгөрүүлсэн. Хүн төрөлх чанараараа завхарсан бөгөөд зөвхөн Бурханы нигүүлсэл л тэднийг аварч чадна гэж тэр заадаг байв. Библийн олон тайлбарыг бичжээ. 1564 оны 5-р сарын 27-нд нас баржээ.

Шинэчлэгчдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг номлогчийн номын санд дараах эх сурвалжуудаас үз: James E. Talmage, *Jesus the Christ*, 692–703; M. Russell Ballard, *Our Search for Happiness*, 26–32.

Шинэчлэгчдийн эрэлхэг зориг хийгээд зөгнөлөөр Христийн ертөнц адислагдахад, бусад олон үндэстэн хийгээд соёлууд (Түүний үгийн) “[Бурхан] түүний болно хэмээн үзсэн тэр хэсэг тэдэнд байх ёстой нь өгөгдсөн хүмүүсээр” (Алма 29:8) адислагдсан байлаа. Бусад шашны удирдагчдын заадаг зүйлүүд илүү иргэншсэн хийгээд илүү ёс зүйтэй болоход нь олон хүмүүст тусалжээ.

Тэмдэглэл

Будда (Готама): МЭӨ 563 онд Балбад Хинди омгийн удирдагчийнд төржээ. Өөрийнхөө эргэн тойрон дахь зовлон шаналалд санаа нь зовдог байв. Эцгийнхээ тансаг ордноос зугтаж, дэлхийг шүүмжлэн, ядуу зүдүү байдалд амьдарч байв. Тэрээр гэгээрлийг эрэлхийлэн, “чөлөөлөлтийн зам” гэж өөрийн нэрлэсэн зүйлийг нээн илрүүлжээ. Санаа тавих, өвдөх буюу гадаад бодит байдлыг мартаж, Нирваан байдал олохыг зорьж байв. Лам нарын хамтын нийгэмлэгийн багш болжээ.

Кунзи: МЭӨ 551 онд төржээ. Бага насандаа өнчирчээ. Хятадын анхны мэргэжлийн багш байв. Хятадын хамгийн агуу ёс суртахууны хийгээд нийгмийн сэтгэгч. Сүнсэн хүмүүн биетүүд буюу бурханлиг хүчнүүдийн тухай бага ярьдаг байжээ. Сайн болон зөв зүйлийн аврага байх ариун үүрэг зорилтыг тэнгэр түүнд итгэмжилсэн гэдэгт итгэдэг байв.

Авралын Төлөвлөгөө

Тэмдэглэл



Таны Зорилго

Та заах явцдаа, Сургаал ба Гэрээ 20:37 болон баптисмын ярилцлагын асуултуудад заагддаг баптисмд тэнцэх шинж чанаруудыг хангахад сонирхогчдоо бэлтгэ. Дор жагсаасан даалгавруудыг хийж, хэрэгжүүлэхэд сонирхогчдоо урьснаар үүнийг хамгийн сайнаар гүйцэлдүүлнэ.

Баптисмын Ярилцлагын Асуултууд

- Бурхан бол бидний Мөнхийн Эцэг гэдэгт та итгэдэг үү?
- Есүс Христ бол Бурханы Хүү, дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдэгт та итгэдэг үү?
- Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь сахих, түүний дотор долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж, гишүүн нөхөддөө үйлчлэл үзүүлэхийг хүсч байна уу?

Даалгаврууд

- Бидний заасан зүйл үнэн гэдгийг мэдэхийн тулд та залбирах уу?
- Та нүглүүдээ наманчлах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Та Аврагчийн үлгэр жишээг дагаж, (. . . сарын . . . өдөр) баптисм хүртэх үү?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах зарлигууд.

Есүс Христийн Тухай Мэдэхэд нь Бусдад Туслах

Номлогч нар Есүс Христийн тухай гэрчилж, тэд аврагдаж болохын тулд бүх хүмүүсийг Түүнд ирэхийг урих ёстой. Аврагчийн тухай нэг бүрчлэн заавраар хангах нь Түүний тухай бага буюу огт мэддэггүй хүмүүсийн хувьд чухал ач холбогдолтой юм. Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ нь “Өөрийгөө бүх үндэстэнд харуулах . . . тэр Есүс бол Христ” (Мормоны Номны эхний хуудас) мөн гэдгийг мэдэхэд нь бүх хүмүүст туслах зорилготой юм. Аврагчийн тухай заах хийгээд гэрчлэх хамгийн үр ашигтай арга замуудын нэг нь Мормоны Номноос хамтдаа унших явдал мөн. Бусад жишиг бүтээлүүдээс авсан хэсгүүд мөн л ашиг тустай байж чадна.

Тэмдэглэл

Доорх зөвлөмжүүдийг анхааралдаа ав. Үүнийг энэ болон бусад хичээлүүдийн нэг хэсэг болгох буюу эсвэл үүнийг өөрийг нь нэг хичээл болгож болно. Ашиг тустай байвал, баптисм болон гишүүний баталгааны өмнө болон дараа энэ үйл ажиллагааг хэдэн удаа давт.

Эхний хуудас болон удиртгал. Номны зорилгыг тодруул.

1 Нифай 10–11	Лихай, Нифай хоёр Аврагчийн тухай гэрчилдэг.
1 Нифай 19	Аврагчийн тохинуулал хийгээд Цагаатгалын тухай бошиглолуудыг Нифай хүүрнэдэг.
2 Нифай 2	Аврагч бол Гэтэлгэгч болох тухай Лихай гэрчилдэг.
2 Нифай 9	Цагаатгалын тухай Иаков гэрчилдэг.
2 Нифай 31–33	Христийн сургаалыг Нифай заадаг.
Инос	Инос Цагаатгалын хүчийг өөр дээрээ амсдаг.
Мозая 2–5	Хаан Бэнжамин Христийн тухай заадаг.
Мозая 12–16	Абинадай амь насаа Есүс Христийн тухай гэрчлэхэд зориулдаг.
Алма 5, 7	Алма Аврагчийн тухай гэрчилдэг.
Алма 17–22	Лэмэнчүүд Есүс Христийн тухай гэрчлэлийг хүлээн авдаг.
Алма 34	Амюлек Цагаатгалын тухай гэрчилдэг.
Алма 36	Алма Есүс Христийн Цагаатгалын хүчийг өөр дээрээ амсдаг.
Алма 40–42	Амилуулалт хийгээд Цагаатгалын тухай Алма гэрчилдэг.
Хиламан 5	Аврагчийн тухай гэрчлэхийн тулд Нифай, Лихай хоёр Бурханы мутарт зэмсэг болдог.
3 Нифай 9–10	Аврагч хүмүүсийг Өөртөө ирэхийг урьдаг.
3 Нифай 11–18	Эцэг болон Түүний сургаалын тухай Аврагч Нифайчуудад заадаг.
3 Нифай 27	Аврагч Өөрийн сайн мэдээг заадаг.
Ифэр 3	Жарэдын ах Аврагчийг харав.
Ифэр 12	Аврагч болон Түүний Цагаатгалын хүчний тухай Ифэр, Моронай хоёр гэрчлэв.
Моронай 7–8	Христийн цэвэр хайр хийгээд Түүний Цагаатгалын тухай Мормон заав.
Моронай 10	Бүхнийг Христэд ирж, Түүн дотор төгөлдөржихийг Моронай урив.
“Амьд Христ”	Аврагчийн тухай бошиглогчид болон төлөөлөгчид гэрчилдэг.

Дэлхийн Өмнөх Амьдрал: Бурханы Зорилго ба Бидэнд Зориулсан Төлөвлөгөө

“Бид хаанаас ирсэн бэ? Яагаад бид энд байгаа юм бэ? Бид хаашаа явж байна вэ?” хэмээн олон хүмүүс гайхдаг. Авралын төлөвлөгөө эдгээр асуултуудын хариултыг бидэнд өгдөг.

Бурхан бол бидний сүнснүүдийн Эцэг юм. Бид чухамдаа Түүний хүүхдүүд бөгөөд Тэр бидэнд хайртай. Бид энэ дэлхий дээр төрөхөөсөө өмнө Тэнгэр дэх Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүд болон амьдарч байжээ. Гэвч бид Тэнгэрлэг Эцэг шигээ байсангүй, мөн бид мөнх бус байдалд бие бялдартайгаа амьдарч үзэхгүйгээр Түүний таалдаг бүх адислалуудыг эдэлж, түүнтэй адилхан болж хэзээ ч чадахгүй юм.

Тэмдэглэл

Бурханы бүх зорилго—Түүний ажил болон Түүний алдар суу нь Түүний бүх адислалуудыг эдлэхийг хүн нэг бүрт боломжтой болгох явдал мөн. Тэрээр Өөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд төгс төлөвлөгөөгөөр хангасан юм. Бид дэлхийд ирэхээсээ өмнө энэ төлөвлөгөөг ойлгож, хүлээн авсан билээ. Судруудад Бурханы төлөвлөгөөг нигүүлсэнгүй төлөвлөгөө, аз жаргалын төлөвлөгөө, гэтэлгэлийн төлөвлөгөө, түүнчлэн авралын төлөвлөгөө гэж нэрлэдэг.

Есүс Христ бол Бурханы төлөвлөгөөн дэх гол төв нь юм. Есүс Христ Өөрийн Цагаатгалаар дамжуулан Эцэгийнхээ зорилгыг хэрэгжүүлж, үхэшгүй байдал болон мөнх амьдралыг эдлэх явдлыг хүн нэг бүрт боломжтой болгосон юм. Сатан буюу чөтгөр Бурханы төлөвлөгөөний дайсан юм.

Сонголт буюу сонгох чадвар бол Бурханаас Өөрийн хүүхдүүдэд өгсөн хамгийн агуу бэлгүүдийн нэг юм. Бидний мөнхийн дэвшил нь бид энэ бэлгийг хэрхэн ашиглахаас хамаарна. Бид Есүс Христийг дагах уу, эсвэл Сатаныг дагах уу гэдгийг сонгох ёстой.

Дэлхий дээрх амьдралынхаа үед бид бие махбодийн хувьд Бурханаас тусгаарлагдсан байдаг хэдий ч, Түүний хүүхэд нэг бүр нь энэ амьдралд амар амгаланг, мөн энэ амьдралын дараа Түүний дэргэд бүрэн баяр хөөрийг олоосой гэж Тэрээр хүсдэг билээ. Тэрээр биднийг Өөртэйгөө адилхан болохыг хүсдэг.

Судар Судлах

Бурханы хүүхдүүд

С ба Г 93:29
Үйлс 17:29

Еврей 12:9

Бурханы зорилго

Моце 1:39

Иохан 17:3

Мөнх Бус Байдлын Өмнөх Амьдрал

С ба Г 138:53–56
Моце 3:5

Абрахам 3:22–26
Иеремиа 1:5

Guide to the Scriptures,
“Premortal Life”

Бүтээлт

Есүс Христ Эцэгийн удирдлага дор бидний амьдрах болон туршлага хуримтлуулах газар болгож дэлхийг бүтээсэн юм. Өсч хөгжин, Бурхантай адил болохын тулд бидний хүн бүр биетэй болж, дэлхий дээрх сорилтын үед соригдох шаардлагатай байлаа. Бид дэлхий дээр байхдаа Бурханы бодит оршихуйгаас гадуур байдаг. Бид дэлхийн өмнөх амьдралаа санадаггүй. Бид хараагаар гэхээсээ илүүгээр итгэлээр алхлах ёстой.

Судар Судлах

1 Нифай 17:36
Алма 30:44
С ба Г 88:41–47:

Моце 2:1
Моце 6:63
Абрахам 3:24–25

ИСО, Иохан 1:1–3
2 Коринт 5:6–7

Тэмдэглэл

Сонголт ба Адам, Ева Хоёрын Уналт

Адам Ева хоёр бол дэлхий дээр ирсэн Бурханы анхны хүүхдүүд байлаа. Бурхан Адам, Ева хоёрыг бүтээж, тэднийг Едений Цэцэрлэгт байрлуулжээ. Адам, Ева хоёр Бурханы дүр төрхөөр, мах, ясан биетэйгээр бүтээгдсэн байлаа. Адам, Ева хоёр уг цэцэрлэгт байхдаа мөн Бурханы оршихуйд байсан бөгөөд үүрд мөнх амьдарч болох байв. Тэд гэнэн цагаан байдалд амьдарч байсан бөгөөд тэдний хэрэгцээг Бурхан хангаж байв.

Едений Цэцэрлэгт Бурхан Адам, Ева хоёрт сонголтыг нь өгсөн ажээ. Хориглогдсон жимс буюу сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс идэхгүй байхыг Тэрээр тэдэнд зарлиглажээ. Энэ зарлигийг дуулгавартай дагаснаар тэд цэцэрлэгт үлдэж болох байсан хэдий ч, тэд үүний эсрэгээр үхэлт байдлын туршлагагүйгээр дэвшин хөгжиж чадахгүй байв. Тэд уй гашуу, өвдөлтийн туршлагагүй байсан учраас тэд баяр хөөрийг мэдэж чадахгүй байлаа.

Сатан Адам, Ева хоёрыг хориглогдсон жимснээс идэхэд уруу татаж, тэгээд тэд үүнийг хийхээр сонгосон аж. Энэ бол Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг байв. Энэ сонголтын улмаас тэд цэцэрлэгээс хөөгдөж, Бурханы дэргэдээс таслагдсан юм. Энэ үйл явдлыг Уналт гэж нэрлэдэг. Бурханы дэргэдээс тусгаарлагдах нь сүнсний үхэл мөн. Адам, Ева хоёр мөнх бус байдалтай болж—биеийн үхэл буюу бие, сүнс хоёрын салалтад өртжээ. Одоо тэд өвчин болон бүхий л төрлийн зовлонг биеэр амсах болжээ. Тэд ёс суртахууны сонголт буюу сайн ба муугийн хооронд сонгох чадвартай байлаа. Энэ тэднийг сурч, өсч хөгжих боломжтой болгосон юм. Бас энэ нь буруу сонголтууд хийх буюу нүгэл үйлдэх явдлыг ч тэдэнд боломжтой болгосон юм. Түүнээс гадна, одоо тэд хүүхэдтэй болж чадна, иймээс Бурханы сүнсэн хүүхдүүдийн үлдсэн нь биетэй болж, соригдохоор дэлхий дээр ирж болох байв. Зөвхөн энэ замаар Бурханы хүүхдүүд өсч хөгжин, Түүнтэй адилхан болж чадах болно.

Уналтын тухай заах нь

Энэ сургаалыг анх заахдаа, энэ тухай мэддэг бүхнээ заа. Бурхан Өөрийн хүүхдүүдээс хоёрыг нь, Адам Ева хоёрыг дэлхий дээрх анхны эцэг, эх байхаар сонгосныг нэн энгийнээр тайлбарла. Тэдний зөрчлийн дараа тэд нүгэл, үхэл хоёрт аль алинд нь өртөмтгий болжээ. Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар тэд өөрсдөө эргэн очиж чадахгүй байлаа. Их Эзэн Адамтай ярьж, авралын төлөвлөгөө болон Их Эзэн Есүс Христээр дамжсан гэтэлгэлийг түүнд заажээ. Энэ төлөвлөгөөг дагаснаар Адам болон түүний гэр бүл энэ амьдралд баяр хөөртэй байж, Бурхантай хамт амьдрахаар эргэж очиж чадах байв (Алма 18:36; 22:12–14-ийг үз).

Судар Судлах**Цэцэрлэгт**

2 Нифай 2
Моце 2:26–31

Моце 3:15–17
Моце 5:11

Эхлэл 1:26–31
Эхлэл 2:15–17

Уналт

2 Нифай 2:25
Алма 12:22–34

Моце 4
Моце 5:10–12

Эхлэл 3

Дэлхий Дээрх Бидний Амьдрал

Дэлхий дээрх амьдрал бол боломж хийгээд адислал юм. Энэ амьдрал дахь бидний зорилго бол баяр хөөртэй байж, Бурханы оршихуйд эргэж очиход бэлтгэх явдал мөн. Мөнх бус байдалд бид биеийн болон сүнсний үхэл аль алинд нь өртдөг тийм нөхцөлд амьдардаг. Бурхан төгс төгөлдөр, алдар суут, мах яснаас бүтсэн үхэшгүй биетэй. Бурхантай адил болж, Түүний дэргэд эргэж очихын тулд бид бас төгс төгөлдөр, мах яснаас бүтсэн үхэшгүй биетэй байх ёстой. Хэдий тийм ч, Адам, Ева хоёрын Уналтын улмаас дэлхий дээрх хүн бүр төгс бус, мөнх бус биетэй бөгөөд эцэстээ зайлшгүй үхэх болно. Хэрэв Аврагч Есүс Христ байгаагүй бол үхэл нь Тэнгэрлэг Эцэгтэй ирээдүйд хамт орших бүхий л найдварыг эцэс болгох байсан биз ээ.

Биеийн үхлийн хамт нүгэл нь Тэнгэр дэх Эцэгтэйгээ адилхан болох хийгээд Түүний оршихуйд эргэж очихоос биднийг хөндийрүүлдэг гол саад тотгор юм. Өөрсдийн мөнх бус байдалд бид уруу таталт, Бурханы зарлигуудыг зөрчих болон нүглийн эрхшээлд автах нь олонтаа байдаг. Дэлхий дээрх амьдралынхаа үед бидний хүн болгон алдаа гаргадаг. Хэдийгээр энэ нь заримдаа өөр байдаг ч гэсэн, нүгэл нь ямагт аз жаргалгүй байдал уруу хөтөлдөг. Нүгэл нь гэм буруугийн болон ичих мэдрэмжийг төрүүлдэг. Нүглүүдийнхээ улмаас, хэрэв бид эхлээд өршөөгдөж, цэвэршихгүй бол Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар эргэж очих нь бидэнд боломжгүй юм.

Бид мөнх бус байдалд байхдаа бидэнд аз жаргалыг авчирдаг туршлагауудыг бид олж авдаг. Бид бас өөрсөддөө өвчин, уй гашуу авчирдаг тийм туршлагауудтай болдог, тэдгээрийн зарим нь бусад хүмүүсийн нүгэлт үйлдлүүдээр бий болсон байдаг. Эдгээр туршлагаууд нь сурах, өсч хөгжих, муугаас сайныг ялган таних, түүнчлэн сонголтууд хийх боломжуудаар биднийг хангадаг. Сайныг үйлдэхэд Бурхан бидэнд нөлөөлдөг бол; Сатан нүгэл үйлдэхэд биднийг уруу татдаг. Биеийн үхэл байгаа болохоор, нүглийн үр дагавруудыг бид өөрсдөө даван туулж чаддаггүй. Есүс Христийн Цагаатгалгүйгээр бид арчаагүй сул дорой юм.

Судар Судлах

Сорилт буюу Туршилтын Үе

2 Нифай 2:21	Алма 12:21–24	Абрахам 3:25–26
2 Нифай 9:27	Алма 34:31–35	
Мозая 3:19	Алма 42:2–10	

Сонголт

2 Нифай 2:26–29 Иошуа 24:15
Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө, “Сонгох Эрх Чөлөө ба Хариуцлага”

Сайн ба Муу

Моронай 7:12–19

Нүгэл

Ром 3:23 1 Иохан 1:8–10 1 Иохан 3:4

Цэвэр Биш Зүйл Бурхантай Хамт Байж Чадахгүй

1 Нифай 10:20–21 3 Нифай 27:19 Мосе 6:57
Алма 41:10–11

Тэмдэглэл

Тэмдэглэл

Цагаатгал

Дэлхий зохион байгуулагдахаас өмнө бидний Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг бидний Аврагч болон Гэтэлгэгч байхаар сонгожээ. Есүс Христийн цагаатгагч золиослол нь Уналтын үр дагавруудыг даван туулах явдлыг бидний хувьд боломжтой болгосон юм. Дэлхий эхэлснээс хойших үеийн бүх бошиглогчид Есүс Христийг бидний Гэтэлгэгч хэмээн гэрчилсээр байгаа билээ.

Бид бүгдээрээ биеийн үхлийг үзэх болно, гэвч Есүс Христ бидний төлөө биеийн үхлийн саад тотгорыг даван туулсан юм. Тэрээр загалмай дээр амьсгал хураах үед Түүний сүнс Түүний биенээс салсан юм. Гурав дахь өдөр нь Түүний бие болон Түүний сүнс хэзээ ч салахгүйгээр мөнхөд нэгдсэн билээ. Тэр олон хүмүүст үзэгдэн, мах яснаас бүрдсэн үхэшгүй биетэй болсноо тэдэнд үзүүлжээ. Бие болон сүнс нэгдэхийг Амилуулалт гэж нэрлэдэг бөгөөд энэ нь бидний хүн бүгдэд амлагдсан бэлэг юм. Есүс Христийн Амилуулалтын улмаас, бид энэ амьдралд сайныг эсвэл мууг үйлдсэнээс үл хамааран бүгдээрээ амилуулагдах болно. Бид өвчин, өвдөлт буюу үхэлд хэзээ ч дахин өртөхгүй мах, яснаас бүрдсэн, төгс, үхэшгүй биетэй болно. Амилуулалт нь Бурханы дэргэд эргэж очин шүүгдэх явдлыг боломжтой болгосон хэдий ч, Түүний дэргэд амьдрах баталгааг бидэнд өгч чадахгүй юм. Уг адислалыг хүлээн авахын тулд, бид бас нүглээс цэвэрлэгдсэн байх ёстой.

Биеийн үхлийн саад тотгороос гадна нүглийн саад тотгорыг даван туулахын тулд Бурхан Өөрийн Хайрт Хүү, Есүс Христийг илгээсэн юм. Адам, Ева хоёрын Уналтын төлөө бид хариуцлага хүлээдэггүй, харин өөрсдийн гэм нүглүүдийн төлөө хариуцлага хүлээдэг. Бурхан нүглийг хамгийн бага хэмжээгээр ч гэсэн хүлцэн тэвчиж чаддаггүй, мөн нүгэл нь Түүний дэргэд амьдрахад бидэнд саад болдог. Зөвхөн Аврагчийн ач ивээл, нигүүлслээр дамжин бид нүглээс цэвэршиж чадах бөгөөд ингэснээр бид Бурхантай дахин амьдарч чадна. Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, наманчлан, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, мөн эцсээ хүртэл тэвчсэн үед энэ нь боломжтой юм.

Авралын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд Христ бидний нүглүүдийн төлөөсийг төлсөн билээ. Тэр ганцаараа үүнийг хийх боломжтой байв. Тэрээр дэлхийн өмнөх амьдралд дуудагдан, мөн бэлтгэгдсэн ажээ. Тэр бол махан биед төрсөн Бурханы Хүү яах аргагүй мөн байв. Тэр нүгэлгүй, мөн Өөрийн Эцэгт төгс дуулгавартай байлаа. Тэр хэдийгээр соригдсон ч гэсэн, уруу таталтад хэзээ ч бууж өгөөгүй юм. Дэлхийн нүглүүдийн төлөөсийг төлөхийг Эцэг Өөрийн Хайрт Хүүгээс хүсэхэд, Есүс үүнд бэлтгэгдсэн, бас бэлэн байв. Цагаатгал нь Гетсеманийн Цэцэрлэг дэх Түүний шаналал мөн загалмай дээрх Түүний зовлон хийгээд үхлийг багтаадаг бөгөөд энэ нь Түүний Амилуулалтаар төгсгөл болсон юм. Тэр хэдийгээр ухаарч болохоос илүүгээр—бүр Түүний сүв бүрээс цус шүүртэл тийм ихээр зовон шаналж байсан ч гэсэн—Өөрийн Эцэг болон биднийг хайрлах хайрынхаа дээд илэрхийлэл болгон Тэрээр Эцэгийнхээ хүсэлд захирагдсан юм. Өөрийн зовлон шаналлаар сүнсний үхлийг мөн Өөрийн Амилуулалтаар биеийн үхлийг ялсан Есүс Христийн энэ ялгуусан ялалтыг Цагаатгал гэж нэрлэдэг.

Түүнд итгэх итгэлийг хөгжүүлж, наманчлан, усанд умбуулалтаар баптисмыг хүлээн авч, мөн Ариун Сүнсний бэлгийн тулд гар тавиулж, амьдралынхаа эцсийг



Тэмдэглэл

хүртэл Түүний зарлигуудыг итгэлтэйгээр сахихыг хичээн чармайх замаар Түүнийг хүлээн авсан нөхцөлд бидний нүглүүдийг мартаж болно хэмээн Христ амласан юм. Бид байнгын наманчлалаар дамжуулан өршөөлийг олж, Ариун сүнсний хүчээр нүглүүдээсээ цэвэршиж болно. Бид гэм буруугийн болон ичгүүрийн ачаа дарамтаа хөнгөвчилж, мөн бид Есүс Христээр дамжин Бурханы дэргэд эргэж очихоор зохистой болдог.

Бид Есүс Христийн Цагаатгалд найдвар тавьбал өөрсдийн зовлон зүдгүүр, өвчин эмгэгийг тэвчихэд Тэрээр бидэнд тусалж чадна. Бид баяр хөөр, амар амгалан хийгээд тайтгаралаар дүүрэн байж болно. Амьдралын талаарх шударга бус юм бүхэн Есүс Христийн Цагаатгалаар дамжин зөв болгогдож болно.

Есүс бидний нүглүүдийн төлөөсийг төлсөн хэдий ч бидний хувийн хариуцлагыг үгүй болгоогүй юм. Бид Түүнийг хүлээн авч, мөн Түүний зарлигуудыг дагах болно гэдгээ харуулах ёстой. Зөвхөн Цагаатгалын бэлгээр дамжин бид Бурхантай хамт амьдрахаар эргэн очиж чадна.

Судар Судлах

Амилуулалт

2 Нифай 9:6–7	С ба Г 88:27–32	Guide to the Scripture, “Death, Physical”, “Death, Spiritual” and “Resurrection”
Алма 11:42–45	Лук 24:1–10, 36–39	
Алма 40:23	1 Коринт 15:20–23	
Хиламан 14:15–19	ИСО, 1 Коринт 15:40 1 Коринт 15:41–42	

Цагаатгал

2 Нифай 2:6–8	С ба Г 19:15–19	1 Иохан 1:7
Алма 7:11–13	С ба Г 45:3–5	Guide to the Scriptures,
Алма 34:8–10	Иохан 3:16–17	“Atone, Atonement”

Сайн Мэдээ Бол Зам

2 Нифай 9:1–24	Алма 11:40	3 Нифай 27
2 Нифай 31	3 Нифай 11:31–41	Моронай 7:27–28

Сүнсний Дэлхий

Хэдийгээр Христ биеийн үхлийг байлдан дагуулсан ч гэсэн, бүх хүмүүс үхэх ёстой, учир нь үхэл бол мөнх бус байдлаас үхэшгүй байдалд шилжих бидний дэвшлийн нэг хэсэг юм. Үхэхэд бидний сүнс сүнсний дэлхийд очдог. Үхэл бидний хувь хүний шинж чанар, эсвэл сайн буюу мууг хүсэх бидний хүслийг өөрчилдөггүй. Энэ амьдралд Бурханыг дуулгавартай дагахаар сонгосон хүмүүс аз жаргал, амар амгалангийн байдалд амьдарч, зовлон бэрхшээл, сэтгэлийн зовиураас ангижирдаг. Энэ амьдралд дуулгавартай байхгүй байхыг сонгож, наманчлаагүй хүмүүс аз жаргалгүй байдалд амьдардаг. Дэлхий дээр байхдаа сайн мэдээг дуулгавартай дагаагүй буюу үүнийг сонсох боломж олдоогүй хүмүүст сайн мэдээ сүнсний дэлхийд номлогддог. Бид амилуулагдах хүртлээ сүнсний дэлхийд үлддэг.

Тэмдэглэл

Судар Судлах

Нас Барагсдад Номлогддог Сайн Мэдээ

С ба Г 138

1 Петр 3:19–20

1 Петр 4:6

Үхэл ба Сүнсний Дэлхий

Алма 34:34

Алма 40:11–14

Номлогчийн Үгс 12:7

Амилуулалт, Шүүлт ба Үхэшгүй байдал

Амилуулалтаар дамжин бидний бие болон сүнс дахин нэгдэхэд, бид шүүгдэхээр Бурханы дэргэд аваачигдах болно. Бид өөрсдийн зөв шударга байдал болон гэм бурууг төгс байдлаар санах болно. Хэрэв бид наманчилсан бол, нигүүслийг хүлээн авна. Бид өөрсдийн ажил үйлс болон хүслүүдийнхээ дагуу шагнагдах болно.

Амилуулалтаар дамжин бүх хүмүүс үхэшгүй болж—тэд үүрд мөнх амьдрах болно. Үхэшгүй байдал бол тэд зөв шударга байсан хийгээд ёс бус байсан эсэхээс үл хамааран, бүх хүмүүст өгсөн үнэгүй бэлэг юм. Гэвч мөнх амьдрал бол үхэшгүй байдалтай яг адилхан биш. Мөнх амьдрал бол зөвхөн Түүний сайн мэдээг дуулгавартай дагасан хүмүүст өгөгдсөн Бурханы бэлэг юм. Энэ бол бидний хүрч болох хамгийн эрхэм дээд байдал мөн. Энэ нь Христийн Цагаатгалаар дамжин нүгэл болон зовлонгоос чөлөөлөгдсөн хүмүүст ирдэг. Энэ бол мөнхийн гэр бүлүүдэд Бурхантай хамт үүрд мөнхөд амьдарна гэсэн утгатай өргөмжлөл юм. Энэ бол Бурхан, Есүс Христ хоёрыг мэдэж, тэдний таалдаг амьдралыг биеэр үзэх явдал мөн.

Амилуулалт ба Хойд Дүр

Зарим хүмүүс амилуулалтын сургаалыг хойд дүрийн үзэл баримтлалтай эндүүрч болох юм. Хойд дүрийн үзэл баримтлал бол өөр хэлбэрийг олж дэлхийд дахин төрөх явдал бөгөөд энэ нь хуурмаг сургаал юм. Амилуулалтын сургаал нь мах, яснаас бүрдсэн үхэшгүй биеийн мөнхийн шагналыг багтаадаг. Энэ бол үнэн сургаал мөн. Заадаг хүмүүс тань амилуулалтын сургаалыг тодорхой ойлгоход анхаар.

Алдар Суугийн Хаант Улсууд

Мөнх бус амьдралынхаа үед бид сайн ба мууд хамаарах сонголтуудыг хийдэг. Бидний ажил үйлс хийгээд хүслүүдийн дагуу Бурхан биднийг шагнадаг. Бурхан хүн бүрийг биендээ хийсэн үйлүүдийнх нь дагуу шагнадаг учраас Шүүлтийн дараа бидний томилогдон очих алдар суугийн өөр өөр хаант улсууд байдаг. Нүглүүдээ наманчилж, сайн мэдээний ёслолуудыг хүлээн авч, холбогдох гэрээнүүдийг сахисан хүмүүс Христийн Цагаатгалаар цэвэршигдэх болно. Сэлэстиэл хаант улс хэмээн бас нэрлэгддэг, хамгийн дээд хаант улсад тэд өргөмжлөлийг хүлээн авах болно. Тэд Бурханы дэргэд амьдран, Түүнтэй адилхан болж, бүрэн баяр хөөрийг хүлээн авах болно. Тэд үүнд тэнцсэн өөрсдийн гэр бүлийн хүмүүстэй хамт үүрд мөнх амьдрах болно. Судруудад энэ хаант улс алдар суугаараа нарны гэрэлтэй зүйрлэгдсэн байдаг.

Харин Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн аваагүй ч гэсэн ариун шударга амьдралаар амьдардаг хүмүүс тэррэстриэл хаант улсад байр хүлээн авах болно. Судруудад энэ хаант улс сарны алдар суутай зүйрлэгдсэн байдаг.

Нүглүүдээ үргэлжлүүлж, энэ амьдралд наманчлаагүй хүмүүс шагналаа тэлэстиэл хаант улс хэмээн нэрлэгддэг, хамгийн доод хаант улсад хүлээн авах болно. Судруудад энэ хаант улс оддын алдар суутай зүйрлэгдсэн байдаг.

Судар Судлах

Амилуулалт ба Сэргээлт

2 Нифай 9:14–15 Иаков 6:8–9 Алма 42:13–15, 22–23

Шүүлт

2 Нифай 28:23 Алма 5:15–21 С ба Г 132:12; 137:9
Мозая 3:23–25 Алма 12:12–14 Иохан 5:22


Алдар Суугийн Хаант Улсууд

3 Нифай 28:10 С ба Г 76 Матай 5:48
С ба Г 76: Удиртгал С ба Г 137 1 Коринт 15:41–42

Мөнх Амьдрал

2 Нифай 31:17–21 С ба Г 45:8 Иохан 3:16
С ба Г 14:7 С ба Г 93:19 Иохан 17:3
С ба Г 29:43–44

Авралын Төлөвлөгөө



Есүс Христийн Цагаатгал авралыг боломжтой болгодог.

Баптисм Хүртэх Урилга

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулах урилга нь: “Бурханы санваарыг атгагч хэн нэгнээр та баптисм хүртэж Есүс Христийн үлгэр жишээг дагах уу? Бид (...сарын . . . өдөр) баптисмын үйлчилгээ явуулах болно. Энэ өдөр та баптисм хүртэхээр өөрийгөө бэлтгэх үү?” гэж хувь хүнд тухайлан хандаж шууд асуусан байх ёстой.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Заах Санаанууд

Энэ хичээлд бэлтгэх болон заахад таны ашиглах санаанууд энэ хэсэгт байгаа. Эдгээр санаануудыг хэрхэн ашиглахыг шийдэх үедээ сүнсийг залбиралтайгаар дага. Та хичээлийнхээ төлөвлөгөөнд сонголт хийхэд эдгээр санаануудыг нэм. Эдгээр санаанууд бол өөрийн тань заадаг хүмүүсийн эрэлт хэрэгцээг шийдвэрлэхэд өөрт тань туслах зөвлөмжүүд болохоос биш, шаардлагууд биш гэдгийг сана.

Богино Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (3–5 минут)

Авралын төлөвлөгөө нь бид хаанаас ирснийг, бид яагаад энд дэлхий дээр байгаа болон энэ амьдралын дараа бид хаашаа явахыг бидэнд заадаг. Энэ нь мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус амьдрал, үхэл, амилуулалтаар дамжин бидний мөнх амьдрал хүртэл мөнхийн аяллыг маань зураглан харуулдаг. Уг төлөвлөгөө нь бас бид Түүний дэргэд эргэж очин, Түүнтэй адилхан болохын тулд энэ аяллыг амжилттай болгоход бидэнд туслахын тулд Тэнгэр дэх бидний хайрт Эцэг юу хийдгийг тайлбарладаг. Уг Төлөвлөгөө Уналтын үр дагавруудыг даван туулах болон мөнх амьдралыг бидний хувьд боломжтой болгох талаарх Есүс Христийн үүрэг зорилго хийгээд Цагаатгалд төвлөрдөг. Бид таныг энэ захиасын тухай тунгаан бодож, залбирахыг урьж байна.

- Дэлхийн Өмнөх Амьдрал: Бурханы Зорилго ба Бидэнд Зориулсан Төлөвлөгөө
- Бүтээлт
- Сонголт ба Адам, Ева Хоёрын Уналт
- Дэлхий Дээрх Бидний Амьдрал
- Цагаатгал
- Сүнсийн Дэлхий
- Амилуулалт, Шүүлт ба Үхэшгүй Байдал
- Алдар Суугийн Хаант Улсууд

Даалгаврууд

- Бидний заасан зүйл үнэн гэдгийг мэдэхийн тулд та залбирах уу?
- Та нүглүүдээ наманчлах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Та Аврагчийн үлгэр жишээг дагаж, (. . . сарын . . . өдөр) баптисм хүртэх үү?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4–өөс таны сонгож оруулах зарлигууд

Дунд Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (10–15 минут)

Бидний захиас амьдралын зорилго хийгээд өөрсдийгөө хэн бэ гэдгийг ойлгоход бидэнд тусалдаг. Энэ нь бидэнд найдвар төрүүлж, амар амгалан, баяр хөөр болон аз жаргалыг олоход бидэнд тусалдаг. Энэ бид хаанаас ирснийг, бид яагаад энд дэлхий дээр байгаа болон энэ амьдралын дараа бид хаашаа явахыг бидэнд хэлж өгдөг. Бурхан бол

Тэмдэглэл

бидний Эцэг, мөн Тэр бидэнд хайртай. Бид Түүний хүүхдүүд. Бид Түүний гэр бүлийн хэсэг бөгөөд бид энэ дэлхий дээр төрөхөөс өмнө Түүнтэй хамт амьдарч байсан билээ. Энэ амьдралын дараа Түүний дэргэд эргэж очихыг бидний хувьд боломжтой болгосон аз жаргалын төлөвлөгөө Түүнд байдаг. Бурханаас бидэнд өгсөн сонголт буюу сонгох чадварыг бид хэрхэн ашиглахаас бидний хөгжил дэвшил хамаарна. Энэ төлөвлөгөөний нэг хэсэг болсон Адамын Уналт дэлхий дээр ирж, бие бялдартай, туршлагатай, мөн өөрсдийн гэр бүлтэй болох явдлыг бидний хувьд боломжтой болгосон юм. Гэвч Уналт нь сүнс биенээс салах явдал болох биеийн үхэл, мөн Бурханаас тусгаарлагдах явдал болох сүнсний үхлийг авчирсан билээ.

Бурханы төлөвлөгөөн дэх гол төв нь Есүс Христ юм. Христийн цагаатгагч золиослол биеийн болон сүнсний үхэл нь аль алиных нь үр дагавруудыг даван туулсан юм. Бид бүгдээрээ амилуулагдаж, өвчин эмгэгээс чөлөөтэй бие бялдартайгаар үүрд мөнх амьдрах болно. Сүнсний үхлийг даван туулах явдлыг мөн Христ боломжтой болгосон юм. Бид сайн мэдээний дагуу амьдарсан үед Тэрээр бидний нүглүүдийг нигүүлсэнгүйгээр өршөөх болно. Тэр биднийг эдгээж, гэм буруу болон ичгүүрийг энэ амьдрал дахь амар амгалан хийгээд аз жаргалаар солих болно.

Бурханы нигүүлсэнгүй төлөвлөгөөний нэг хэсгийн хувьд бид бүгдээрээ биеийн үхлийг үзэх болно. Бидний сүнснүүд биенээс маань салж хэсэг хугацаагаар сүнсний дэлхийд амьдрах болно. Тэгээд бид бидний бие болон сүнс мөнхөд нэгдэх үхэшгүй биетэйгээр амилуулагдах болно. Бид өөрсдийн үйлүүд хийгээд хүслүүдийн дагуу шүүгдэх болно. Сайн мэдээний дагуу амьдарч байсан хүмүүс Тэнгэр дэх бидний Эцэгийн хамгийн агуу бэлэг, Түүний дэргэд мөнх амьдралаар амьдрах бэлгийг хүлээж авах болно.

Бидний Тэнгэрлэг Эцэг Өөрийн аз жаргалын төлөвлөгөөг Өөрийн хүүхдүүдэд хайранд дахин хүргэсэн юм. Таны уншиж, тунгаан бодож, энэ тухай залбирч болох Мормоны Номноос бид энэхүү гайхамшигт төлөвлөгөөний тухай мэддэг. Таныг сүмд очиж бидэнтэй хамт шүтэн бишрэхийг бид урьж байна.

Даалгаврууд

- Бидний заасан зүйл үнэн гэдгийг мэдэхийн тулд та залбирах уу?
- Та нүглүүдээ наманчлах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Та Аврагчийн үлгэр жишээг дагаж, (. . . сарын . . . өдөр) баптисм хүртэх үү?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4–өөс таны сонгож оруулах зарлигууд

Бүрэн Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (30–45 минут)

- Дэлхийн Өмнөх Амьдрал: Бурханы Зорилго ба Бидэнд Зориулсан Төлөвлөгөө

Тэмдэглэл

- Бурхан бол бидний Тэнгэрлэг Эцэг, бид Түүний хүүхдүүд (Үйлс 17:16–34; Еврей 12:9–ийг үз).
 - Бидний аз жаргалын төлөөх төлөвлөгөө Бурханд бий. Энэ төлөвлөгөөн дэх гол төв нь Есүс Христ юм.
 - Бурханы аз жаргалын төлөвлөгөө Түүний дэргэд эргэж очихыг боломжтой болгодог (Моше 1:39-ийг үз).
 - Бид өөрсдийн сонголтыг хэрхэн ашиглахаас бидний мөнхийн хөгжил дэвшил хамаарна (2 Нифай 2:27–29-ийг үз).
- Бүтээлт
 - Эцэгийн удирдлаган дор Есүс Христ Дэлхийг бүтээжээ (Еврей 1:1–3-ыг үз).
 - Сонголт ба Адам, Ева Хоёрын Уналт
 - Адам, Ева хоёр Бурханы дүр төрхөөр бүтээгджээ (Эхлэл 1:26–27-г үз).
 - Едений Цэцэрлэгт тэд гэнэн цайлган байж, Бурханы дэргэд амьдарч байв.
 - Тэд хориглогдсон жимснээс хүртсэний улмаас цэцэрлэгээс хөөгдөв (Моше 4:19–31-ийг үз). Үүнийг Уналт гэж нэрлэдэг.
 - Тэд мөнх бус болж, хүүхдүүдтэй болох боломжтой, бас нүгэл болон үхэлд өртөх болжээ (2 Нифай 2:22–25; Моше 5:11-ийг үз).
 - Дэлхий Дээрх Бидний Амьдрал
 - Амьдрал дахь бидний зорилго бол гэр бүлээрээ үүрдийн амар амгалан, баяр хөөр болон аз жаргалыг олж, Бурхантай хамт амьдрахаар эргэж очиход бэлтгэх явдал мөн.
 - Бид соригдохоор дэлхий дээр ирсэн (Абрахам 3:24–25-ыг үз).
 - Бид мах, яснаас бүрдсэн биетэй болсон хэдий ч, бид биемахбодийн үхлийг амсана.
 - Бурхан зарлигууд өгдөг. Хэрэв бид дуулгавартай дагах юм бол бид адислагддаг. Хэрэв бид дуулгавартай дагахгүй бол, бид нүгэл үйлдэж, үр дагавруудыг нь амсах болно.
 - Бүх нүглийн төлөөсийг нэг бол өөрсдөө, нэг бол Христ төлөх ёстой (С ба Г 19:15–20-ийг үз).
 - Бид сонголтуудыг хийдэг бөгөөд бид бүгдээрээ нүгэл үйлддэг (Ром 3:23-ыг үз).
 - Бидэнд аз жаргал, бас уй гашуу авчирдаг туршлагууд бидэнд бий.
 - Христгүйгээр бид биеийн болон сүнсний үхэл аль алиныг нь даван туулж чадахгүй.
 - Цагаатгал
 - Есүс Христ биеийн үхлийг даван туулсан учраас бид бүгдээрээ амилуулагдах болно (Алма 11:41–43-ыг үз).
 - Бид Бурханы дэргэд амьдрахаар эргэж очихын тулд Христийн Цагаатгалаар дамжин нүглээс цэвэршиж чадна (2 Нифай 9:8–9-ийг үз).

Тэмдэглэл

- Бид Түүнд итгэх итгэлтэй байж, наманчлан, баптисмыг түүнчлэн Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчих юм бол Христ бидний нүглүүдийг өршөөх болно.
- Сүнсний Дэлхий
 - Бүх хүмүүс үхэх ёстой.
 - Үхэхэд бидний сүнс сүнсний дэлхийд очдог.
 - Бид энэ амьдралд хэрхэн амьдарснаас хамааран нэг бол гай зовлонгийн байдалд, нэг бол амар амгалан хийгээд амралтын байдалд амьдардаг.
- Амилуулалт, Шүүлт ба Үхэшгүй Байдал
 - Амилуулалтад бидний сүнс, бие хоёр дахин нэгдэх болно (Алма 11:42–45; 40:23–ыг үз).
 - Бид өөрсдийн үйлүүд болон хүслүүдийнхээ дагуу шүүгдэхээр Бурханы дэргэд эргэж очих болно.
 - Хэрэв бид наманчлах юм бол, бид нигүүлслийг хүлээн авна.
 - Мөнх амьдрал бол Есүс Христийн сайн мэдээг бүрэн дуулгавартай дагадаг хүмүүст өгөгдсөн Бурханы бэлэг юм (С ба Г 14:7–г үз).
- Алдар Суугийн Хаант Улсууд (С ба Г 76; 137; 1 Коринт 15: 40–42–ыг үз).
 - Бид өөрсдийн үйлүүд хийгээд хүслүүдийнхээ дагуу шагналаа хүлээн авдаг (С ба Г 137:9–ийг үз).
 - Сайн мэдээг хүлээн авч, бүхий л амьдралынхаа туршид үүгээр шийдэмгийгээр амьдардаг хүмүүс сэлэстиэл хаант улсыг хүлээн авах болно. (С ба Г 76: 50–70–ыг үз).
 - “Хүмүүний башир аргаар харалган болсон” шударга сайн хүмүүс, түүнчлэн “[Христийн] гэрчлэлд нэн хүчтэй биш” хүмүүс тэррэстриэл хаант улсыг хүлээн авдаг (С ба Г 76:75, 79–ийг үз).
 - Нүгэл үйлдэж, мөн наманчилдаггүй хүмүүс зовж, нүглүүдийнхээ төлөөсийг төлсний дараа тэлэстиэл алдар сууг хүлээн авах болно.

Даалгаврууд

- Бидний заасан зүйл үнэн гэдгийг мэдэхийн тулд та залбирах уу?
- Та нүглүүдээ наманчлах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Та Аврагчийн үлгэр жишээг дагаж, (. . . сарын . . . өдөр) баптисм хүртэх үү?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4–өөс таны сонгож оруулах зарлигууд

Заасныхаа Дараа Асуух Асуултууд

- Бидний заасан зүйлийн талаар танд ямар асуултууд байна вэ?
- Танд болон танай гэр бүлд зориулсан Бурханы төлөвлөгөөний тухай та юу ойлгов?

Тэмдэглэл

- Бидний танд заасан зүйлээс Есүс Христийн үүргийн талаар та юу ойлгосон бэ? Энэ нь таны хувьд ямар утга учиртай вэ?

Чухал Тодорхойлолтууд

Олонтаа ойлгогддоггүй нэр томъёонуудыг дор өгөв. Таны зааж байгаа хүмүүс ойлгож, мэдэхийн тулд эдгээрийг тодорхой тайлбарлахад анхаар.

- **Аврал:** Биеийн болон сүнсний үхлээс аврагдах. Есүс Христийн үхэл ба Амилуулалтаар дамжин, Бурханы ач ивээлээр бүх хүмүүс биеийн үхлээс аврагдах болно. Мөн түүнчлэн хувь хүн бүр Есүс Христэд итгэх итгэлээр дамжин, Бурханы ач ивээлээр сүнсний үхлээс бас аврагдах болно. Энэхүү итгэл нь сайн мэдээний хуулиуд болон ёслолуудад дуулгавартай байдаг амьдралд, түүнчлэн Христэд үйлчлэх үйлчлэлд харагддаг.
- **Амилуулалт:** Үхлийн дараа сүнс, мах, яснаас бүрдсэн биетэй дахин нэгдэх. Амилуулалтын дараа сүнс, бие хоёр хэзээ ч дахин салахгүй бөгөөд уг хүн үхэшгүй болно. Есүс Христ үхлийг даван туулсан учраас дэлхий дээр төрсөн хүн болгон амилуулагдах болно.
- **Биеийн Үхэл:** Үүрд мөнх амьдарч, үхдэггүй сүнс бидний биенээс салах.
- **Гэтэлгэл:** Төлбөр төлөх замаар хүнийг боолчлолоос чөлөөлөх зэрэг чөлөөлөх, худалдаж авах буюу төлөөс төлөх. Гэтэлгэл нь Есүс Христийн Цагаатгалд, түүнчлэн нүглээс чөлөөлөхөд хамаарна. Есүсийн Цагаатгал бүх хүн төрөлхтнийг биеийн үхлээс гэтэлгэдэг. Түүний Цагаатгалаар дамжуулан Түүнд итгэх итгэлтэй бөгөөд наманчилдаг хүмүүс бас сүнсний үхлээс гэтэлгэгддэг.
- **Мөнх Бус Байдал:** Төрөхөөс биеийн үхэл хүртлэх хугацаа.
- **Мөнх Бус Байдлын Өмнөх Амьдрал** (мөнх бус байдлын өмнөх байдал; дэлхийн өмнөх байдал): Бид Тэнгэр дэх Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүдийн хувьд энэ дэлхий дээр ирэхээсээ өмнө Түүний дэргэд амьдарч байлаа. Мөнх бус байдлын өмнөх амьдралд бидэнд бие байгаагүй юм.
- **Өргөмжлөл:** Бурханы дэргэдэх мөнх амьдрал; Тэнгэр дэх Эцэгтэйгээ адилхан болж, Түүний дэргэд амьдрах. Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу нь. Өргөмжлөл нь Есүс Христийн Цагаатгалаар дамжин, мөн сайн мэдээний хуулиуд болон ёслолуудад дуулгавартай байх явдлаар дамжин ирдэг.
- **Сүнсний үхэл:** Бурханаас болон Түүний нөлөөнөөс тусгаарлагдах; зөв шударга ёсонд хамаарах зүйлүүдийн хувьд үхэх. Сүнсний үхэл Адамын Уналтаар дэлхийд бий болжээ (Алма 42:6–7-г үз). Хилэнцэт санаа бодол, үг яриа, үйлстэй мөнх бус хүмүүс дэлхийд амьд байдаг ч гэсэн, сүнсний хувьд үхсэн байдаг (2 Нифай 9:39-ийг үз). Есүс Христийн Цагаатгалаар дамжин, сайн мэдээний зарчмууд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар, эрэгтэй, эмэгтэйчүүд нүглээс цэвэршиж, сүнсний үхлийг даван туулж чадна.
- **Уналт (Адам, Ева Хоёрын):** Адам Ева хоёр хориглогдсон жимсийг идээд тэд мөнх бус болсон юм—энэ нь нүгэл, үхэл хоёрт өртдөг гэсэн үг. Адам дэлхий дээрх “анхны махан бодь” болжээ (Мосе 3:7). Уналт бол адислал байсан бөгөөд Адам, Ева хоёрт хүн төрөлхтний анхны эцэг эхчүүдийн хувьд хүндлэгдэх ёстойг хожмын үеийн илчлэлт тодорхой болгосон юм.
- **Үхэшгүй Байдал:** Биеийн үхэлд өртөлгүй, амилуулагдсан байдалд үүрд амьдрах нөхцөл.
- **Цагаатгал:** Судруудад хэрэглэгдсэнээр, цагаатгах гэдэг нь нүглийн үйлдлийн төлөө шийтгэлд зовж, наманчилдаг нүгэл үйлдэгчдээс нүглийн үр дагавруудыг зайлуулж, үүгээр дамжуулан тэднийг Бурхантай эвлэрүүлэх явдал мөн. Есүс Христ Гетсеманид болон загалмай дээр зовон шаналсан билээ. Тэр бол бүх хүн төрөлхтний төлөө төгс Цагаатгал хийх чадвартай цорын ганц хүн байв. Тэр бидний нүглүүдийн шийтгэлд зовон шаналж, улмаар загалмай дээр үхсэн юм.

Бид бүгдийн өвдөлт, өвчин, уруу таталтууд, зовлон зүдгүүр болон сул дорой байдлыг Тэр Өөр дээрээ авсан юм (Алма 7:11–12–ыг үз).

- **Шүүлт:** Бурхан Есүс Христээр дамжуулан, бидний хүлээн авах мөнхийн алдар сууг тодорхойлохын тулд биднийг нэг бүрчлэн шүүх болно. Энэхүү шүүлт Бурханы зарлигуудад бидний дуулгавартай байсан байдал, түүний дотор Есүс Христийн цагаатгагч золиослолыг хүлээн авсан байдал дээр тулгуурлах болно. Бидний үйлс болон хүслүүд сайн, эсвэл муу байсан эсэх дээр тулгуурласан өөрсдийн мөнхийн шагналыг бид хүлээн авах болно.

Таны Заадаг Хүмүүст Хэрэгтэй Байж Болох Цаашдын Тодорхойлолтын Бусад Нэр Томъёонууд

- | | | |
|------------------------------|---------------------------------|-----------------------------------|
| • Авралын төлөвлөгөө | • Мөнхийн дэвшил | • Сүнсний дэлхий |
| • Алдар суугийн хаант улсууд | • Наманчлал | • Сэлэстиэл |
| • Биеийн үхэл | • Нүгэл | • Тэлэстиэл |
| • Бүтээлт | • Өршөөгдөх [нүглээс] | • Тэврэстриэл |
| • Едений Цэцэрлэг | • Сайн ба муугийн мэдлэгийн мод | • Усанд умбуулалтаар хийх баптисм |
| • Итгэл | • Сорилт | • Цэвэршсэн [нүглээс] |
| • Мөнхийн амьдрал | • Сөрөг байдал | • Хориглогдсон жимс |

Тэмдэглэл

Тэмдэглэл

Есүс Христийн Сайн Мэдээ



Таны Зорилго

Та заах явцдаа, Сургаал ба Гэрээ 20:37 болон баптисмын ярилцлагын асуултуудад заагддаг баптисмд тэнцэх шинж чанаруудыг хангахад сонирхогчдоо бэлтгэ. Дор жагсаасан даалгавруудыг хийж, хэрэгжүүлэхэд сонирхогчдоо урьснаар үүнийг хамгийн сайнаар гүйцэлдүүлнэ.

Баптисмын ярилцлагын асуултууд

- Бурхан бол бидний Мөнхийн Эцэг гэдэгт та итгэдэг үү?
- Есүс Христ бол Бурханы Хүү, дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдэгт та итгэдэг үү?
- Сүм болон Есүс Христийн сайн мэдээ Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэнд та итгэдэг үү?

Даалгаврууд

- Түүний сайн мэдээний тухай мэдэхээ үргэлжлүүлснээр та Есүс Христэд итгэх итгэлээ цаашид хөгжүүлэх үү?
- Нүглүүдийн өршөөлийн тулд та наманчилж, мөн залбирах уу?
- Та (. . . сарын . . . өдөр) Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болж, баптисм хүртэх үү? Та гишүүнээр батлуулж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах зарлигууд

Бид Христээр Дамжин Нүглээс Цэвэршиж Чадна

Бурханы бүх хүүхдүүд үхсэнийхээ дараа Түүний дэргэд амьдрахаар эргэж очих боломжтой байхын тулд Тэрээр Өөрийн Хайрт Хүү Есүс Христийг дэлхий рүү илгээсэн юм. Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд амьдарч болохын тулд зөвхөн Аврагчийн ач ивээл болон нигүүлслээр дамжин нүглээс цэвэршиж чадна. Нүглээс цэвэрших нь сүнсний хувьд эдгээгдэнэ гэсэн үг юм (3 Нифай 9:13; 18:32-ыг үз).

Христийн Цагаатгал хийгээд Амилуулалтын улмаас бүх хүмүүс өөрсдийн ажил үйлс болон хүслүүдийн дагуу шүүгдэхээр Их Эзэний дэргэд буцаан аваачигдах болно (2 Нифай 9:10–16; Хиламан 14:15–18; 3 Нифай 27:14–22; С ба Г 137:9-ийг үз). Бид шударга ёс, нигүүлслийн хуулийн дагуу шүүгдэх болно.

Шударга ёс гэдэг бол үйлдлүүдийн үр дагавруудыг—Бурханы зарлигуудыг дуулгавартай дагасны төлөө адислалууд, түүнчлэн дуулгаваргүй байсны төлөө шийтгэлийг оноодог өөрчлөгдөшгүй хууль юм. Бид бүгдээрээ нүгэл үйлддэг. Нүгэл биднийг цэвэр биш болгодог бөгөөд, цэвэр биш зүйл Бурханы дэргэд амьдарч чадахгүй (1 Нифай 10:21; 3 Нифай 27:19; Мосе 6:57-г үз).

Нүглүүдээ наманчилдаг, мөн Түүний бүх зарлигуудыг сахихыг хичээдэг хүмүүсийн төлөөх шударга ёсны шаардлагуудыг Аврагч бидний оронд зогсон, бидний нүглүүдийн төлөө шийтгэл хүлээхдээ ханган биелүүлсэн юм. Энэ үйлдлийг Цагаатгал гэдэг. Энэхүү амь бие хайргүй үйлдлийн учир Христ бидний өмнөөс Эцэгээс гуйж чадна. Тэнгэрлэг Эцэг нигүүлсэнгүй байж, шийтгэлийг биднээс татан авч, Өөрийнхөө дэргэд биднийг баяртайгаар хүлээн авч чадна. Бидний Тэнгэрлэг Эцэг бидний нүглүүдийг өршөөж, Түүний дэргэд амьдрахаар эргэж очиход бидэнд туслахад Тэрээр нигүүлслийг харуулдаг.

Гэсэн хэдий ч, Есүс бидний хувийн хариуцлагыг үгүй болгоогүй юм. Бид Түүнийг хүлээн авч, наманчлан, мөн Түүний зарлигуудыг дуулгавартай дагахад Тэрээр бидний нүглүүдийг өршөөдөг. Цагаатгалаар дамжуулан, мөн сайн мэдээний дагуу амьдарснаар бид Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд байнга оршихоор очих зохистой болно. Бид Христийг хүлээн авснаа мөн Түүний зарлигуудыг сахиж, сайн мэдээний анхны зарчмууд болон ёслолуудыг дуулгавартай дагадгаа харуулах ёстой.

Нүгэл

“Нүгэл” гэдэг ойлголт янз бүрийн соёлуудад өөр өөр утгатай зүйл байдаг. Зарим соёлуудад энэ нь гэмт хэрэг гэсэн үзэл бодолтой нийцдэг. Бусдад энэ нь хүн ямар нэг буруу зүйл хийж баригдан, тийнхүү гэр бүл буюу хамт олондоо ичгүүрт байдал бий болгох явдал юм. Нүгэл бол Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахгүй байх явдал бөгөөд Бурханаас тусгаарлагдахад нөлөөлдгийг тодруул. Бидний хийдэг, боддог бүхнийг Бурхан мэддэг бөгөөд бид нүгэл үйлдсэн үедээ Түүнийг гомдоодог. Өнгөрсөн зөрчлүүдийнхээ тухай бүү ярилц. Өнгөрсөн зөрчлүүдийнхээ талаар сонирхогчид тань ярихад саад хийх буюу ярихгүй байхыг хүс.

Судар Судлах

Бурхан Хүүгээ Илгээсэн нь

Алма 11:40 Иохан 3:16–17

Христээр Дамжих Аврал

2 Нифай 2:6–8 Алма 34:8–9, 14–16
2 Нифай 9:21–24

Христ Бол Бидний Өмгөөлөгч

С ба Г 45:3–5

Нигүүлсэл ба Шударга Ёс

Мозая 15:9 Алма 42:22–25

Тэмдэглэл

Тэмдэглэл

Есүс Христэд Итгэх Итгэл

Сайн мэдээний нэг дэх зарчим бол Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл мөн. Христэд итгэх итгэлтэй байх нь Тэр бол Бурханы Цорын Ганц Төрсөн Хүү бөгөөд дэлхийн Аврагч ба Гэтэлгэгч гэдэг бат итгэлтэй байх явдал мөн. Зөвхөн Түүний Хүүгийн ач ивээл болон нигүүлсэлд найдсанаар бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахаар эргэж очиж чадна гэдгийг бид хүлээн зөвшөөрдөг. Бид Христэд итгэх итгэлтэй байхад Түүний Цагаатгал болон Түүний заадаг зүйлүүдийг хүлээн авч, амьдралдаа хэрэгжүүлдэг. Бид Түүнд болон Түүний хэлсэн зүйлд итгэдэг. Өөрийн амлалтуудыг хэрэгжүүлэх хүч Түүнд байдгийг бид мэднэ. Түүний Хүүг дуулгавартай дагах итгэлтэй хүмүүсийг Тэнгэрлэг Эцэг адисалдаг.



Христэд итгэх итгэл нь үйл хөдлөл рүү хөтөлдөг. Энэ нь чин сэтгэлийн удаан үргэлжлэгч наманчлал уруу хөтөлдөг. Итгэлтэй байх нь биднийг чадах чинээгээрээ Аврагчийн тухай мэдэж, Түүнтэй илүү адилхан болохыг хичээн чармайхад хүргэдэг. Түүний зарлигууд юу болохыг бид мэдэхийг хүсдэг бөгөөд дараа нь тэдгээрийг дуулгавартай дагадаг. Хэдийгээр бид алдаа гаргасаар байх боловч Түүний зарлигуудыг сахих болон нүглээс зайлсхийхийг хичээн чармайснаараа Түүнийг хайрлах хайраа харуулдаг.

Бид Христэд итгэдэг, мөн Тэрээр Өөрийн бүх зарлигуудыг сахиасай гэж биднээс хүсдэгт бид итгэдэг. Түүнийг дуулгавартай дагаснаар бид итгэлээ харуулахыг хүсдэг. Уруу таталтыг даван туулах хүч чадлын төлөөх итгэлд бид залбирдаг. Бас бид Мэргэн Ухааны Үг буюу аравны нэг гэх мэт тодорхой нэг зарчимд итгэх итгэлийг Түүний зарлигуудыг дуулгавартай дагахад хангалттай хүчтэйгээр Есүс Христэд итгэх нэг дэх итгэлээр хөгжүүлж болно. Бид аль нэг өвөрмөц зарлигаар амьдрахдаа үүний үнэнийг туршлагаараа мэддэг (Иохан 7:17-г үз). Бид бас Бурханы үгийг сонссоноор, (Ром 10:17-г үз) мөн Бурханы үгийг уншсанаар (Хиламан 15:7–8-ыг үз) итгэлд өсч хөгждөг.

Бид Бурханыг дуулгавартай дагахад Тэр биднийг адисалдаг. Тэр бидэнд амьдралын бэрхшээлүүдийг даван туулах хүчийг өгдөг. Зүрх сэтгэлийнхээ хүслүүдийг өөрчлөхөд Тэр бидэнд тусалдаг. Есүс Христэд итгэх бидний итгэлээр дамжуулан, Тэр биднийг бие бялдар, сүнсний аль алинаар нь эдгээж чадна.

Судар Судлах

Итгэл, Хүч ба Аврал

1 Нифай 7:12 Моронай 7:33–34
2 Нифай 9:23 Моронай 10:7
2 Нифай 25:23

Итгэлийн Тухай Сургаал

Алма 32 Bible Dictionary, "Faith"
Ефес 2:8

Итгэлийн Жишээнүүд

Ифэр 12 Еврей 11

Ажил Үйлс ба Дуулгавартай Байдал

1 Нифай 3:7 Иаков 2:17–26
С ба Г 130:20–21

Наманчлал дахь Итгэл

Алма 34

Наманчлал

Сайн мэдээний хоёр дахь зарчим бол наманчлал. Есүс Христэд итгэх бидний итгэл болон Түүнийг хайрлах бидний хайр нь Түүний хүсэлтэй нийцдэггүй өөрсдийн санаа бодол, итгэл болон зан авираа өөрчлөх буюу наманчлахад биднийг хөтөлдөг. Наманчлал нь Бурханы тухай, өөрсдийнхөө тухай түүнчлэн дэлхийн тухай шинэ үзэл бий болох явдлыг багтаадаг. Бид наманчлах үед бурханлиг харууслыг мэдэрч, тэгээд бид буруу зүйлүүдийг хийхээ больж, зөв зүйлүүдийг хийхээ үргэлжлүүлдэг. Наманчлалаар дамжуулан өөрсдийн амьдралыг Бурханы хүсэлтэй нийцүүлэх нь бидний амьдралын гол зорилго юм. Бид зөвхөн Христийн нигүүлслээр дамжин Бурхан Эцэгтэй хамт амьдрахаар эргэн очиж чадах бөгөөд зөвхөн наманчлалын нөхцөл дээр Христийн нигүүлслийг хүлээн авч чадна.

Наманчлахын тулд бид нүглүүдээ хүлээж, гэмшил буюу бурханлиг харууслыг мэдэрдэг. Бид нүглүүдээ Бурханд гэмшин хүлээдэг. Бид бас наманчлахад маань бидэнд тусалж чадах Бурханаас эрх мэдэл олгогдсон Сүмийн уудирдагчдад нэн ноцтой нүглүүдээ гэмшин хүлээдэг. Бид залбиралдаа өөрсдийгөө өршөөхийг Бурханаас хүсдэг. Бид өөрсдийн үйл ажиллагаанаас үүдэлтэй асуудлуудыг засч залруулахын тулд чадах бүхнээ хийдэг; үүнийг хохирлыг барагдуулах гэж нэрлэдэг. Биднийг наманчлахад бидний өөрсдийгөө болон дэлхийг үзэх үзэл маань өөрчлөгддөг. Бид өөрчлөгдсөнөөрөө Бурханы хүүхдүүд гэдгээ, мөн урьдын дутагдлуудаа цаашид дахин давтан гаргах ёсгүй гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Хэрэв бид чин сэтгэлээсээ наманчлах юм бол, бид нүглүүдээсээ эргэж, дахин нүгэл үйлдэхгүй байх болно. Нүгэл үйлдэх аливаа хүслийг бид эсэргүүцдэг. Бурханыг дагах бидний хүсэл улам улам хүчтэй болж өсдөг.

Чин сэтгэлийн наманчлал хэд хэдэн үр дүн авчирдаг. Бид амьдралдаа Бурханы өршөөл болоод Түүний амар амгаланг мэдэрдэг. Бидний гэм буруу, харамсал арилдаг. Бид Сүнсний нөлөөг илүү ихээр мэдэрдэг. Мөн бид энэ амьдралаас явахдаа өөрсдийн Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүүтэй хамт амьдрахад илүү бэлтгэгдсэн байх болно.

Бид бүр Христийг хүлээн авч, нүглүүдээ наманчилсны дараа ч алдаа гаргаж, дахин нүгэл үйлдэж болно. Эдгээр зөрчлүүдийг бид засч залруулахыг хичээхээ үргэлжлүүлэх ёстой. Түүнээс гадна, бид Христийнх шиг зан чанаруудаа хөгжүүлэн, мэдлэгээ өсгөн, мөн илүү үр ашигтай үйлчлэн, байнга сайжирч байх ёстой. Аврагч биднээс юу хүсэн хүлээдэг тухай бид илүү ихийг мэдсэнээр Түүнийг дуулгавартай дагах замаар өөрсдийн хайрыг харуулахыг хүсэх болно. Тийнхүү, бид өдөр бүр наманчилснаар амьдрал маань өөрчлөгдөж, сайжрахыг бид мэдэх болно. Бидний зүрх сэтгэл, бидний зан төрх Христийнхтэй улам адилхан болно. Өдөр бүр наманчилснаар бид агуу баяр хөөрийг мэдрэх болно.

Судар Судлах

Бид Бүгдээрээ Нүгэл Үйлддэг

Ром 3:23

1 Иохан 1:7–8

Гэтэлгэл ба Өршөөл

Хиламан 5:10–11

Наманчлал

Алма 34:8–17

2 Коринт 7:9–10

С ба Г 58:42–43

Guide to the Scriptures,

С ба Г 61:2

“Repent, Repentance”

Нигүүлсэл Нүглээ Наманчлахад Дууддаг

Алма 12:32–35

С ба Г 18:10–13

Алма 42:13, 21–24

Тэмдэглэл

Тэмдэглэл

Баптисм, Бидний Анхны Гэрээ

Есүс Христэд итгэх итгэл болон наманчлал нь биднийг баптисмын ёслолууд болон гишүүний баталгаанд бэлтгэдэг. Ёслол бол бид Бурхантай гэрээнд орсныг харуулдаг ариун нандин ёслол буюу ёс жаяг юм.

Бурхан Өөрийн хүүхдүүдээс гэрээнүүдийг хийхийг үргэлж шаардсаар иржээ. Гэрээ бол Бурхан хүн хоёрын хоорондын үүрэг хүлээсэн чанд тохиролцоо юм. Бурхан биднийг адислахыг амлаж, бид Түүнийг дуулгавартай дагахаар амладаг. Бид нэг бол хүлээж авах, нэг бол хүлээж авахгүй байх сайн мэдээний гэрээнүүдийн нөхцөлүүдийг Бурхан тогтоодог. Гэрээнүүдийг сахих нь энэ амьдралд адислалуудыг, ирэх амьдралд өргөмжлөлийг авчирдаг.



Гэрээнүүд нь Бурханд хийсэн өөрсдийн амлалтуудыг хүндэтгэх чанд үүргийн дор биднийг тавьдаг. Гэрээнүүдээ сахихын тулд бид эдгээр гэрээнүүдийг хүндэтгэн үзэхэд маань саад учруулдаг үйл ажиллагаа буюу ашиг сонирхлуудыг орхих ёстой. Жишээ нь, бид Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь сахихын тулд дэлгүүрээс юм худалдаж авах буюу зугаа цэнгэлийн зүйлүүдээс Ням гарагт татгалзах ёстой. Бурханаас бидэнд санал болгодог гэрээнүүдийг бид зохистойгоор хүлээн авч дараа нь тэдгээрийг сахихыг хичээх хүсэлтэй байх ёстой. Амьдралынхаа өдөр бүр наманчлахыг гэрээнүүд маань бидэнд сануулдаг. Гэрээнүүдийг сахиснаар, мөн бусдад үйлчилснээр бид нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч үүнийг өөрсөддөө байлгадаг.

Гэрээнүүд нь ихэвчлэн баптисм мэтийн ариун нандин ёслолуудын арга хэрэгслээр хийгддэг. Эдгээр ёслолуудыг санваарын эрх мэдлээр гүйцэтгэдэг. Жишээ нь, баптисмын ёслолоор дамжуулан, бид Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, Түүнийг үргэлж дурсан санаж, мөн Түүний зарлигуудыг сахихаар гэрээ хийдэг. Бид гэрээний өөрсдийнхөө хэсгийг биелүүлснээрээ Бурхан Ариун Сүнсний байнгын нөхөрлөл, нүглүүдээсээ ангижрах болон дахин төрөхийг бидэнд амладаг.

Баптисм болон гишүүний баталгаа зэрэг ариун нандин ёслолуудаар дамжуулан бид Бурханы хүчний тухай мэдэж, үүнийг өөрсөд дээрээ мэдэрдэг (С ба Г 84:20-ийг үз). Нүглүүдийн ангижралын тулд буюу эсвэл өөрсдийн нүглүүдийн өршөөлийн төлөө бид баптисм хүртэх ёстой гэж Есүс заадаг байв. Баптисм бол авралын амин чухал ёслол мөн. Баптисм хүртэхгүйгээр хэн ч Бурханы хаант улсад орж чадахгүй. Христ баптисм хүртсэнээр бидэнд үлгэр жишээ үзүүлсэн билээ.

Усанд умбуулалтаар хийх баптисм бол Аврагчийн үхэл, оршуулга болон Амилуулалтын бэлэгдэл юм. Үүнтэй адил хэлбэрээр энэ нь бидний хуучин нүгэлт амьдралын төгсгөл, Христийн шавь болж, шинэ амьдралаар амьдрах амлалтыг төлөөлдөг Баптисм бол дахин төрөх явдал мөн гэж Аврагч заадаг байв. Бид баптисм хүртээд дахин төрөх үйл явцыг эхэлж, Христийн сүнсний охид, хөвгүүд болдог (Мозая 5:7–8; Ром 8:14–17-г үз).

Бид сэргээгдсэн Сүм, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болж, тэнгэрийн хаант улсад эгнэгт орохын тулд баптисм хүртэх ёстой. Энэ ёслол бол Бурханы хууль бөгөөд Түүний эрх мэдлээр гүйцэтгэгдэх ёстой.

Бишоп буюу номлолын ерөнхийлөгч баптисм буюу гишүүнээр батлах зөвшөөрлийг санваар атгагчид өгөх ёстой.

Бяцхан хүүхдүүд баптисм хүртэх шаардлагагүй бөгөөд Есүс Христийн нигүүлслээр дамжин гэтэлгэгддэг (Моронай 8:4–24-ийг үз). Тэд хариуцлагын нас буюу найман нас хүртлээ баптисм хүртэх шаардлагагүй (С ба Г 68:27-г үз).

Баптисмын өмнө бид амьдралынхаа үлдсэн хэсэгт бүх зарлигуудыг сахихын тулд гэрээнд орох хүсэлтэй байгаагаа харуулдаг. Баптисмын дараа бид гэрээнүүдээ сахих замаар итгэлээ харуулдаг. Баптисм хүртэх үед хийсэн гэрээнүүдээ бид ариун ёслолоос хүртэх замаар бас тогтмол шинэчилдэг. Долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх нь зарлиг юм. Энэ нь Ариун Сүнсийг үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгахаар зохистой байхад бидэнд тусалдаг. Энэ бол бидний гэрээнүүдийг долоо хоног тутам сануулагч мөн. Есүс Христ Өөрийн Цагаатгалын яг өмнөхөн энэ ёслолыг төлөөлөгчиддөө танилцуулсан билээ. Тэр үүнийг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн юм. Санваарыг атгагчид Түүний бие болон бидний төлөө урсан Түүний цусыг төлөөлөн дурсаж ариун ёслолыг гүйцэтгэж байх ёстойг Аврагч зарлигласан юм. Ариун ёслолоос хүртсэнээр бид Түүний золиослолыг үргэлж санахыг амлаж, амлалтуудаа шинэчлэн, мөн Ариун Сүнсийг үргэлж бидэнтэй хамт байх болно гэдэг амлалтыг шинээр авдаг.

Баптисмын Өмнө

“[Сонирхогчид] Сургаал ба Гэрээ 20:37-д зарлигласны дагуу тэнцэхээр болохын тулд Христэд итгэх итгэлээ хөгжүүлэн, гэмүүдээ наманчилж, амьдралдаа хангалттай өөрчлөлт гаргасан байх ёстойг анхаар. Сонирхогчид ёс суртахууны зохистой байдлын зарчмууд, Мэргэн Ухааны Үгээр амьдарч, аравны нэгийг төлөхөд шийдвэр төгс байх ёстой. Хэрэв нэмэлт бэлтгэл хэрэгтэй гэж номлогч нарт санагдах юм бол, сонирхогчид жишгийг хангах хүртэл тэд баптисмыг хойшлуулах хэрэгтэй.

“Баптисмын өмнө сонирхогч бүр номлогчийн бүх [хичээлүүдийг] хүлээн авч, бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэй уулзан, ариун ёслолын хэд хэдэн цуглаанд оролцсон байх ёстой” (“Statement on Missionary Work,” Тэргүүн Зөвлөлийн Захидал, 2002 оны Арванхоёрдугаар сарын 11).

Судар Судлах

Христийн Үлгэр жишээ

2 Нифай 31:4–18 Матай 3:13–17

Баптисмын Гэрээ

Мозая 5:8–10 С ба Г 20:37
Мозая 18:8–10

Баптисмд Тэнцэх нь

2 Нифай 9:23 Моронай 6:1–4
Мозая 18:8–10 С ба Г 20:37
Алма 7:14–15 Үйлс 2:37–39
3 Нифай 11:23–27

Их Эзэн Ариун Ёслолыг Бий Болгосон нь

3 Нифай 18:1–18 Лук 22:15–20

Баптисмын Амлагдсан Адислалууд

Мозая 4:11–12, 26 Иохан 3:5
Моронай 8:25–26 Ром 6:4

Ариун Ёслолын Залбирлууд

Моронай 4, 5 С ба Г 20:75–79

Ариун Ёслолоос Хүртэх нь

С ба Г 27:2 1 Коринт 11:23–29

Эрх Мэдлийн Зайлшгүй Чухал нь

С ба Г 22 Еврей 5:4

Тэмдэглэл

Тэмдэглэл

Ариун Сүнсний Бэлэг

Бид усаар, түүнчлэн Ариун Сүнсээр баптисм хүртэх ёстой гэж Есүс заасан. Усаар баптисм хүртсэний дараа бид Сүнсээр баптисм хүртэх ёстой, эс тэгвэл энэ нь бүрэн биш юм. Бид зөвхөн баптисм болон Ариун Сүнсний бэлэг хүлээн авсан үед нүглүүдийн ангижралыг хүлээн авч, сүнсний хувьд бүрмөсөн дахин төрдөг. Тэгээд бид Христийн шавь нарын хувьд сүнсний шинэ амьдралыг эхэлдэг.

Хүн усаар баптисм хүртсэний дараа нэг буюу түүнээс олон санваартан уг хүний толгой дээр гараа тавин түүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр баталдаг. Тэгэхдээ тэд Ариун Сүнсний бэлэг өгдөг.

Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, зохистой байсан хүмүүс бүх амьдралынхаа туршид Түүний нөхөрлөлийг эдэлж чадна. Ариун Сүнс цэвэршүүлэгч, ариусгагч нөлөөг бидэнд үзүүлдэг. Ариун Сүнс Христийн тухай гэрчилж, үнэнийг мэдэхэд бидэнд тусалдаг. Тэрээр сүнслэг хүч чадлаар хангаж, зөвийг хийхэд бидэнд тусалдаг. Гай зовлонгийн буюу уй гашуугийн үед Тэр биднийг тайтгаруулдаг. Сүнсний болон биеийн аюулаас Тэр биднийг сэрэмжлүүлдэг. Ариун Сүнс бидэнд заах болон сурах хүчийг өгдөг. Ариун Сүнсний бэлэг бол Тэнгэрлэг Эцэгийн маань хамгийн үнэт бэлгүүдийн нэг юм. Ариун Сүнсний хүчээр дамжуулан бид Бурханы хайр болон бидэнд зориулсан чигийг мэдэрч чадна. Энэ бэлэг бол мөнхийн баяр хөөр болон мөнх амьдралын амлалтын бяцхан загвар юм.

Урвалтын улмаас олон зууны тэртээ татан авагдсан энэ ёслолыг гүйцэтгэхэд шаардлагатай санваарын эрх мэдэл Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн юм. Зөвхөн Сүм дэх гишүүнчлэлээр дамжуулан хүн Ариун Сүнсний бэлэг хүлээн авч чадна. Энэхүү эрх мэдэл нь Сүмийг дэлхий дэх аливаа бусад шашнаас өөр болгодог. Их Эзэний өөрийнх нь тунхагласнаар, энэ нь “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” юм (С ба Г 1:30).

Ариун Сүнсний Удирдамж

Сатан Бурханыг эсэргүүцэж, нүгэл үйлдэхэд хүмүүсийг уруу татдагийг өөрийнхөө зааж байгаа хүмүүст тайлбарла. Өөрсөддөө байгаа сайн мэдрэмжүүдийг номлогч нартай уулзахдаа хэвээр хадгалахын тулд тэд Мормоны Номыг уншиж, залбиран, сүмд очиж, мөн зарлигуудыг дуулгавартай дагах ёстой. Ариун Сүнсний байнгын удирдамжтай байх нь баптисм хүртэж, гишүүнээр батлуулсан хүмүүст ирдэг ашиг тусуудын нэг юм гэдгийг тайлбарла.

Судар Судлах**Ариун Сүнсний Мөн Чанар**

С ба Г 130:22–23
Иохан 3:1–8

Галат 5:22–23

Guide to the Scriptures, “Holy Ghost”

Ариун Сүнсний Адислалууд ба Нөлөө

2 Нифай 32:1–5
2 Нифай 33:1–2

Моце 6:61
Иохан 14:26

Guide to the Scriptures, “Holy Ghost”

Ариун Сүнсний Бэлгийн Ач холбогдол

2 Нифай 31:11–12, 18, 21
3 Нифай 18:36–37
3 Нифай 19:13

3 Нифай 27:19–20
С ба Г 19:31

С ба Г 33:15
Үйлс 19:1–6

Эцсээ Хүртэл Тэвчих

Есүс Христэд итгэх өөрсдийн итгэл, наманчлал, баптисмын ёслолууд болон гишүүний баталгаагаар нэгэнт бид нарийн бөгөөд шулуун замд орсон болохоор бид энэ зам дээр байхын тулд бүхий л хүч чармайлтаа дайчлах ёстой. Есүс Христэд итгэх итгэлээ байнга хөгжүүлж, наманчлан, амлалтуудаа биелүүлж, Сүнсийг дагаснаар бид үүнийг хийдэг.

Нэгэнт бид нүглүүдээсээ өршөөгдсөн болохоор бид Ариун Сүнсийг үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгахын тулд бид нүглээс хол байхыг өдөр бүр хичээж байх ёстой. Амьдралынхаа үлдсэн хугацаанд Түүний зарлигуудыг дуулгавартай дагах болно гэж бид баптисмын гэрээнд Тэнгэр дэх Эцэгтээ амладаг. Хэрэв бид бүтэлгүйтэх юм бол гэрээний адислалуудыг үлдээхийн тулд наманчлах ёстой. Бид сайн үйлүүд хийж, бусдад үйлчлэн, бас Аврагчийн үлгэр жишээг дагахаар амладаг. Судруудад энэхүү насан туршийн амлалтуудыг “эцсээ хүртэл тэвчих” гэж нэрлэх нь олонтаа байдаг.

Сайн мэдээний замыг дагаснаар бид Бурханд илүү ойртож уруу таталт ба нүглийг ялж, Ариун Сүнсийн бэлгийг илүү элбэг дэлбэгээр эдэлж чадна. Бүхий л амьдралынхаа турш тэвчээртэйгээр, итгэлтэйгээр бас нийцтэйгээр энэ замыг дагах юм бол бид мөнх амьдралд тэнцэх болно.

Христэд итгэх итгэл; наманчлал; гэрээнүүд хийж, шинэчлэн, сахих; түүнчлэн Сүнсээр цэвэршигдэх нь амьдралын загвар болдог. Өдөр тутмын амьдрал дахь бидний ажил үйлс эдгээр зарчмуудаар хэлбэрээ олж, мөн удирдагддаг. Энэ замыг дагаснаар амар амгалан хийгээд баяр хөөр ирдэг бөгөөд бид Христийнхтэй адил зан чанарт алгуур өсч хөгждөг. Бид энэ замыг дагаж, “Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлж . . . эцсээ хүртэл тэвчих аваас, та нарт мөнх амьдрал байх болно” хэмээн бидэнд амлагдсан юм (2 Нифай 31:20).

Судар Судлах

Эцсээ Хүртэл Тэвчих

2 Нифай 9:24

3 Нифай 27:16–17

Матай 10:22

2 Нифай 31:14–20

Тэвчсэн Хүмүүст Ирдэг Адислалууд

1 Нифай 13:37

3 Нифай 15:9

С ба Г 14:7

Баптисм Хүртэх Урилга

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулах урилга нь: “Бурханы санваарыг атгагч хэн нэгнээр та баптисм хүртэж Есүс Христийн үлгэр жишээг дагах уу? Бид (. . . сарын . . . өдөр) баптисмын үйлчилгээ явуулах болно. Энэ өдөр та баптисм хүртэхээр өөрийгөө бэлтгэх үү” гэж хувь хүнд тухайлан хандаж шууд асуусан байх ёстой.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Заах Санаанууд

Энэ хичээлд бэлтгэх болон заахад таны ашиглах санаанууд энэ хэсэгт байгаа. Эдгээр санаануудыг хэрхэн ашиглахыг шийдэхдээ Сүнснийг залбиралтайгаар дага. Та сонгосон санаануудаа хичээлийнхээ төлөвлөгөөнд нэм. Эдгээр санаанууд бол өөрийн тань заадаг хүмүүсийн эрэлт хэрэгцээг шийдвэрлэхэд өөрт тань туслах зөвлөмжүүд харин, шаардлагууд биш гэдгийг сана.

Богино Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (3–5 минут)

Есүс Христийн сайн мэдээ бол мөнх амьдралд хүрэх цорын ганц зам мөн. Түүний сайн мэдээний нэг дэх зарчмууд болон ёслолууд нь Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, нүглүүдээс ангижрахын тулд усанд умбуулалтаар хийх баптисм болон Ариун Сүнсний бэлэг юм. Тэгээд бид эцсээ хүртэл тэвчих ёстой. Бүх амьдралынхаа туршид бид эдгээр зарчмуудыг хэрэгжүүлснээр Аврагчийн үлгэр жишээг дагаж, Түүний зарлигуудаар амьдарч суран, Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлдэг. Бид нүглүүдийнхээ төлөө өршөөгдөж чадна, мөн Тэнгэр дэх Эцэгийнхээ дэргэд амьдрахаар эргэж очих боломжтой болно.

- Есүс Христээр Дамжин, Бид Нүглээс Цэвэршиж Чадна
- Есүс Христэд Итгэх Итгэл
- Наманчлал
- Баптисм, Бидний Эхний Гэрээ
- Ариун Сүнсний Бэлэг
- Эцсээ Хүртэл Тэвчих

Даалгаврууд

- Түүний сайн мэдээний тухай мэдэхээ үргэлжлүүлснээр та Есүс Христэд итгэх итгэлээ цаашид хөгжүүлэх үү?
- Та нүглүүдийнхээ өршөөлийн тулд наманчилж, залбирах уу?
- Та (. . . сарын . . . өдөр) Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болж, баптисм хүртэх үү? Та цааш үргэлжлүүлж, Ариун Сүнсний бэлэг хүлээж авах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах зарлигууд

Дунд Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (10–15 минут)

Бидний захиас бол итгэл, найдвар бүхий хүн юм. Бид Есүс Христийг хайрлаж, шүтэн биширдэг. Тэр бол бидний аз жаргалд зориулсан Бурханы төлөвлөгөөнд гол төв нь юм. Христийн цагаатгагч золиослол Бурханы дэргэдэх мөнх амьдралыг бидний хувьд боломжтой болгосон билээ. Бид Түүний сайн мэдээгээр амьдрах юм бол Тэр бидний нүглүүдийг нигүүлсэнгүйгээр өршөөх болно. Тэр биднийг эдгээж, гэм буруу болон ичгүүрийг энэ амьдрал дахь амар амгалан хийгээд аз жаргалаар солих болно.

Есүс Христийн сайн мэдээ энгийн юм. Энэ нь Есүс Христэд итгэх итгэлээр эхэлдэг. Бид Түүнд итгэдэг, найддаг мөн Түүнд хамааралтай

Тэмдэглэл

болдог. Ийм итгэл нь биднийг наманчлах—буруу зүйлүүд хийхээ больж, зөв зүйлүүд хийхээ үргэлжлүүлэхэд хөтөлдөг. Түүнд итгэх бидний итгэл бас баптисмыг оролцуулан, Түүний зарлигуудыг сахих замаар хайраа харуулахыг хүсэхэд биднийг хүргэдэг. Баптисмын дараа Тэр бидэнд Ариун Сүнсний бэлэг өгөхөөр амладаг. Ариун Сүнс биднийг удирдаж, биднийг тайтгаруулан, мөн үнэнийг мэдэхэд бидэнд туслах болно. Ариун Сүнс бидэнтэй хамт байгааг бид зүрх сэтгэлдээ мөн юун ухаандаа мэдэж чадна. Бид амар амгалан, хайр, баяр хөөрийн мэдрэмжүүдтэй байх болно. Бид бусдад үйлчлэхийг хүсэх болно. Бид бүх амьдралынхаа туршид Их Эзэнийг баярлуулахаар хичээн зүтгэх болно.

Есүс Христ Өөрийн сайн мэдээг хожмын үеийн нэгэн бошиглогчоор дамжуулан сэргээсэн юм. Таны уншиж, тунгаан бодож, мөн энэ тухай залбирч болох Мормоны Номноос бид сайн мэдээний тухай мэддэг. Үүнийг үнэн гэдгийг мэдсэнээрээ та нүглүүдийнхээ ангижралыг болон Ариун Сүнсний бэлэг хүлээн авч болохын тулд наманчилж, баптисм хүртэхийг хүсэх болно.

Даалгаврууд

- Түүний сайн мэдээний тухай мэдэхээ үргэлжлүүлснээр та Есүс Христэд итгэх итгэлээ цаашид хөгжүүлэх үү?
- Та нүглүүдийнхээ өршөөлийн тулд наманчилж, залбирах уу?
- Та (. . . сарын . . . өдөр) Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болж, баптисм хүртэх үү? Та цааш үргэлжлүүлж, Ариун Сүнсний бэлэг хүлээж авах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах зарлигууд.

Бүрэн Хэмжээний Хичээлийн Төлөвлөгөө (30-45 минут)

- Христээр Дамжин Бид Нүглээс Цэвэршиж Чадна
 - Бурхан Өөрийн Хайрт Хүү Есүс Христийг дэлхийд илгээв (Иохан 3:16–17-г үз).
 - Зөвхөн Христийн ач ивээл, нигүүлслээр дамжин, бид нүглээс цэвэршиж чадна (2 Нифай 2:6–8-ыг үз).
 - Бид Христийг хүлээн авч, наманчлан мөн дуулгавартай дагах үүрэгтэй.
- Есүс Христэд Итгэх Итгэл
 - Христ бол дэлхийн Аврагч гэдэгт бид итгэх ёстой.
 - Түүний заадаг зүйлүүдийг бид хүлээн авч, дагахыг Тэр биднээс хүсдэг.
 - Бид дуулгавартай дагаснаар адислалуудыг хүлээн авдаг (С ба Г 130:20–21-ийг үз).

Тэмдэглэл

- Наманчлал
 - Христэд итгэх итгэл наманчлал уруу хөтөлдөг (Алма 34-ийг үз).
 - Бурханлиг харууслыг бид мэдэрдэг (2 Коринт 7:9–10-ыг үз).
 - Бид буруу зүйлүүд хийхээ больж, зөв зүйлүүд хийхээ үргэлжлүүлдэг.
 - Бид нүглүүдээ хүлээж, наманчлахад бидэнд тусалж чадах Сүмийн удирдагчдад ноцтой нүглүүдээ гэмшин хүлээдэг (С ба Г 58:43-ыг үз).
 - Бид өршөөлийг хүлээн авдаг; гэм буруу болон харамсал амар амгалангаар солигддог (Алма 36:17–21-ийг үз).
- Баптисм, Бидний Эхний Гэрээ
 - Ёслол бол бидний Бурхантай гэрээ хийдэг ариун нандин ёс жаяг мөн.
 - Гэрээ бол Бурхан, түүний хүүхдүүдийн хоорондох чанд тохиролцоо мөн.
 - Гэрээнүүд адислалуудыг авчирдаг.
 - Бид нүглүүдээс ангижрахын тулд усанд умбуулалтаар баптисм хүртдэг (Итгэлийн Тунхаг 1:4).
 - Бид баптисм хүртээд Бурханд хийсэн амлалтын шинэ амьдралыг эхэлдэг (Ром 6:3–8-ыг үз).
 - Баптисм нь санваарын эрх мэдлийг атгагч нэгнээр гүйцэтгэгдэх ёстой.
 - Ариун ёслолоос долоо хоног бүр хүртсэнээр бид гэрээнүүдээ шинэчилдэг (С ба Г 20:77, 79-ийг үз).
- Ариун Сүнсний Бэлэг
 - Усанд умбуулалтаар хийх баптисмын дараа Сүнсний баптисм болдог; энэ хоёр салшгүй холбоотой.
 - Санваартнууд гар тавилтаар Ариун Сүнсний бэлгийг өгдөг.
 - Ариун Сүнс бидэнд зааж, биднийг цэвэршүүлэн, үнэний тухай гэрчилж, биднийг сэрэмжлүүлж, мөн биднийг чиглүүлдэг (2 Нифай 32:1–5; Мозая 5:1–6; Моронай 10:5; С ба Г 36:2-ыг үз).
- Эцсээ Хүртэл Тэвчих
 - Нэгэнт бид баптисм хүртэж, гишүүнээр батлагдсанаас хойш энэ замаар үргэлжлүүлэх ёстой.
 - Бид Ариун Сүнсний бэлгийг эдэлж болохын тулд нүглээс ангид байхаар чадах бүхнээ хийдэг.
 - Итгэл, наманчлал, гэрээнүүдийг хийж, сахих, мөн Ариун Сүнс хүлээн авах сайн мэдээний замыг итгэлтэй дагаснаар бид мөнх амьдралд тэнцэж чадна (2 Нифай 31:14–20-ийг үз).
 - Бид бүх амьдралынхаа туршид үргэлж залбирах ёстой (С ба Г 19:15–20-ийг үз).

Тэмдэглэл

Даалгаврууд

- Түүний сайн мэдээний тухай мэдэхээ үргэлжлүүлснээр та Есүс Христэд итгэх итгэлээ цаашид хөгжүүлэх үү?
- Та нүглүүдийнхээ өршөөлийн тулд наманчилж, залбирах уу?
- Та (. . . сарын . . . өдөр) Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болж, баптисм хүртэх үү? Та цааш үргэлжлүүлж, Ариун Сүнсний бэлэг хүлээж авах уу?
- Энэ Ням гарагт та бидэнтэй хамт сүмд очих уу?
- Бидний дараагийн уулзалтын цагийг товлож болох уу?
- Хичээл 4-өөс таны сонгож оруулах зарлигууд

Заасныхаа дараа асуух асуултууд

- Бидний заасан зүйлийн талаар танд ямар асуултууд байна вэ?
- Наманчлах гэсэн нь юу гэсэн үг вэ?
- Ариун Сүнсний бэлэг яагаад сайн мэдээний амин чухал хэсэг байдаг вэ?
- Баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах нь яагаад таны хувьд чухал юм бэ?
- Манай Сүмийн цуглаануудын талаар танд ойлгогдохгүй ямар нэг зүйл байсан уу?
- Манай Сүмийн цуглаануудаас юу нь танд таалагдсан бэ?

Чухал Тодорхойлолтууд

- **Ач ивээл:** Энэ амьдралд адислалууд авах болон бид итгэлтэй байж, наманчлан зарлигуудыг сахихын тулд дээд зэргийн хүч чармайлт гаргасны дараа мөнх амьдрал, өргөмжлөлийг олж авах боломжийг бидэнд олгодог, Есүс Христээс ирдэг хүч. Ийм бурханлиг тусламж буюу хүч чадал Есүс Христийн нигүүлсэл болон хайраар дамжин өгөгддөг. Адамын Уналтын улмаас, бас бидний сул дорой байдлын улмаас бид бүгдэд бурханлиг ач ивээл хэрэгтэй юм.
- **Гишүүний баталгаа:** Сүмийн гишүүн болгож, Ариун Сүнсний бэлэг өгөхийн тулд Мелкизедек Санваарыг атгагч хүмүүс толгой дээр гар тавих.
- **Гэрээ:** Бурхан болон Түүний хүүхдүүдийн хоорондох тохиролцоо. Уг тохиролцоонд бид тэгш эрхтэй гишүүд мэтээр ажилладаггүй. Гэрээний нөхцөлүүдийг Бурхан өгдөг бөгөөд биднээр Түүний хийлгэх гэсэн зүйлүүдийг хийхийг бид зөвшөөрдөг. Тэгэхэд Бурхан бидний дуулгавартай байдлын хариуд тодорхой адислалуудыг бидэнд амладаг. Гэрээгээр бид ёслолуудыг хүлээн авдаг. Бид ийм гэрээнүүд хийхдээ тэдгээрийг эрхэмлэхээр амладаг. Жишээ нь, Сүмийн гишүүд баптисмаар Их Эзэнтэй гэрээ хийж, ариун ёслолоос хүртсэнээр тэдгээр гэрээнүүдээ шинэчилдэг. Цаашдын гэрээнүүдийг бид ариун сүмд хийдэг. Их Эзэний хүмүүс бол гэрээт хүмүүс юм. Бид Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ сахсан үед агуу ихээр адислагддаг.
- **Мөнх амьдрал:** Бурханы дэргэд гэр бүлээрээ үүрд мөнх амьдрах (С ба Г 132:19–20-ийг үз). Мөнх амьдрал бол хүмүүнд өгсөн Бурханы хамгийн агуу бэлэг юм.

Тэмдэглэл

- **Нигүүлсэл:** Өрөвч, зөөлөн сэтгэл болон өршөөлийн сүнс. Нигүүлсэл нь Бурханы шинж чанаруудын нэг юм. Есүс Христ наманчлалын нөхцөл дээрх Өөрийн цагаатгагч золиослолоор дамжуулан бидэнд нигүүлслийг санал болгосон юм.
- **Сайн мэдээ:** Бурханы авралын төлөвлөгөө, Есүс Христийн Цагаатгалаар дамжин боломжтой болжээ. Сайн мэдээ нь мөнхийн үнэнүүд буюу хуулиуд, гэрээнүүд, түүнчлэн Бурханы дэргэд эргэж очиход нь хүн төрөлхтөнд шаардлагатай ёслолуудыг багтаадаг.
- **Хохирлыг нөхөн төлөх:** Авч явсан буюу алга болсон зүйлийг эргүүлж өгөх.
- **Эцсээ хүртэл тэвчих:** Уруу таталт, эсэргүүцэл болон бэрхшээлд бүх амьдралынхаа турш үл автан Бурханы зарлигуудад үнэнч хэвээр үлдэх.

Таны Заадаг Хүмүүст Хэрэгтэй Байж Болох Цаашдын Тодорхойлолтын Бусад Нэр Томъёонууд

- | | | |
|---------------|----------------------------|------------------|
| • Ариун ёслол | • Нарийн бөгөөд шулуун зам | • Өршөөл, уучлал |
| • Гэмшил | • Нүглээс цэвэр | • Уруу таталт |
| • Залбирал | | |

Зарлигууд

Баптисм болон Гишүүний Баталгаанд Бэлтгэх нь



Энэ Хичээлийг Заах нь

Энэ хичээл дэх зарлигуудыг заах олон арга байгаа. Жишээ нь, энэ хичээлийн зарлигуудаас цөөн хэдийг нь та эхний гурван хичээлийн хэсэг болгон заах буюу эсвэл хэд хэдэн зарлигийг нэг тусдаа хичээл болгон зааж болно. Таны хийх зүйл сонирхогчдын хэрэгцээгээр, мөн Сүнсний удирдамжаар тодорхойлогдох ёстой.

Заахад Бэлтгэх нь

Зарлигуудыг заах талаарх таны зорилго бол тэд баптисм болон гишүүний баталгаанд бэлтгэхдээ Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчлах замаар сайн мэдээгээр амьдрахад нь хүмүүст туслах явдал мөн. Зарлигуудыг дуулгавартай дагаснаар хүмүүс сайн мэдээний тухай гэрчлэлдээ өсч хөгжин, тэд “харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй” байгаагаа харуулж, өөрсдийнхөө бүх нүглүүдийг наманчилж эхлэх болно (Моронай 6:1–4; С ба Г 20:37-г үз).

Энэ хичээл эхний гурван хичээлээс өөрөөр зохион байгуулагдсан байгаа. Эхний гурван хичээл Есүс Христийн сайн мэдээний сургаалын үндэс суурийг тайлбарладаг. Энэ хичээл сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрэглэхэд бидэнд тусалдаг, Бурханаас өгсөн зарим зарлигуудыг тайлбарладаг.

Энэ хичээлийг заах олон арга бий. Таны заах арга сонирхогчдын хэрэгцээ болон Сүнсний удирдамжаар тодорхойлогдох ёстой. Сайн мэдээгээр амьдрахад нь сонирхогчдод хэрхэн туслахыг байнга бодож энэ тухайд залбир. Зарим санаанууд гэвэл:

- Нэг буюу түүнээс олон зарлигийг эхний гурван хичээлийн хэсэг болгон заах. Ингэхдээ, “Бурхан тэдэнд гэтэлгэлийн төлөвлөгөө мэдүүлсний дараа тэдэнд зарлигуудыг өгсөн юм” (налуу бичлэг нэмэгдэв) хэмээн Алма 12:32-т заагдсан зарчмыг авч үз. Залбирал болон судар судлах зэрэг зарим тодорхой зарлигуудыг эхний гурван хичээлийн хэсэг болгон заах нь нэн сайн байж болно. Бусад зарлигуудыг эхний гурван хичээлд гардаг сайн мэдээний сургаалын суурь үндсүүдийг тавьсныхаа дараа заах нь нэн тохиромжтой байж болно.

Тэмдэглэл

Тэмдэглэл

- Хоёр буюу гурван зарлигийг бие даасан нэг хичээл болгон заах.
- Нэг зарлигийг нэг хичээл болгон заах.
- Сайн мэдээний хам сэдэв дэх зарлигуудыг заах. Нэг буюу түүнээс олон зарлигийг заахын өмнө Есүс Христийн сайн мэдээний талаарх хичээлийг товчхон нэгтгэн дүгнэ. Та үүнийг хийснээр, Аврагчид итгэх итгэлээ хөгжүүлэх баптисм болон гишүүний баталгааны бэлтгэл болгон нүглээ наманчлах илүү том цар хүрээтэй зурагт зарлигууд хэрхэн тохирч байгааг харахад нь та сонирхогчдоо тусалж чадна. Тэд Есүс Христийн сайн мэдээ амьдралынх нь загвар болсныг харснаар амьдрал нь адислагдаж чадна.

Та зарим сонирхогчдод цөөхөн уулзалтаар заах боломжтой байхад, бусдад нь илүү олон уулзалт шаардлагатай байж болно. Баптисм болон гишүүний баталгаанд бүрэн бэлтгэхэд нь хүмүүст хамгийн сайн тусалж чадах ямар ч аргыг хэрэглэн хичээлүүдийг заахад та уян хатан байх хэрэгтэй. Таны зорилго бол зөвхөн хичээлийн материалыг бүрэн хамрах явдал биш; энэ бол Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах болон эцсээ хүртэл тэвчих тэвчээрээр дамжуулан Христэд ирэхэд нь бусдад туслах явдал мөн.

Нэг хичээл 45 минутаас хэтрэх нь ховор байдаг. Ердөө л богинохон хугацаанд уулзаж заахад хүргэх цаг хугацаа танд олдож болно. Энэ тохиолдолд, хичээлийн нилээд бага материалыг богино хугацааг хамран заах хэрэгцээ олонтаа гарч болно.

Энэ хичээлийг таны заах арга олон янз байж болно. Ямар зарлигийг заах, хэзээ үүнийг заах, мөн үүнд ямар хугацаа зарцуулах нь сонирхогчдын хэрэгцээ болон Сүнсний удирдамжаар хамгийн сайн тодорхойлогдоно.

Зарлигуудын болон Даалгавруудын Тухай Мэд

Та энэ хичээлийг судлахдаа, доорх загварыг баримтал:

- Зарлигийг дүрсэлдэг хэсгийг судалж, гурваас таван үндсэн асуудалтай энгийн хичээлийн төлөвлөгөө бич.
- Хоёр буюу гурван минутын хувилбарыг хамтрагчдаа заа. Та даалгавар бүрийг хэрхэн өгөх болон хэрхэн эргэлзээ тайлах талаар давтлага хий.
- Сонирхогчдын хүлээн авсан даалгавар бүрийг шалгах арга замуудыг ярилц.

Дуулгавартай Байдал

Бидний ашиг тусын тулд Бурхан бидэнд зарлигуудыг өгдөг. Зарлигууд нь бидний амьдрал аз жаргалтай байхад туслах Тэнгэр дэх бидний хайрт Эцэгээс ирдэг зааврууд юм. Тэр бас бидэнд сонголт буюу сайн муугийн хооронд сонгох чадвар буюу боломжийг олгодог. Бид Бурханыг дуулгавартай дагаснаар Сүнсний нөлөөг дагаж, Түүний хүсэлд тайтгарахаар сонгодог. Зарлигуудад дуулгавартай байх нь энэ амьдралд амар амгаланг, ирэх дэлхийд мөнх амьдралыг бидэнд авчирдаг. Дуулгавартай байдал нь Бурханыг хайрлах бидний хайрыг харуулдаг. Дуулгаваргүй байх нь бидэнд харамслыг авчирдаг.

Тэнгэрлэг Эцэг бидний сул дорой байдлыг мэддэг бөгөөд бидэнд тэвчээртэй ханддаг. Бид Түүний зарлигуудыг дуулгавартай дагахыг хичээсэн үед Тэр биднийг адисалдаг. Тэрээр биднийг адислахын тулд Түүнийг дуулгавартай дагахыг биднээс хүсэн хүлээдэг.

Судар Судлах

Сонголт

2 Нифай 2:26–29

Алма 12:31

С ба Г 58:26–29

С ба Г 82:8–10

Guide to the Scriptures, “Agency”

Дуулгавартай Байдал

С ба Г 130:20–21

Иохан 14:15, 21

Номлогчийн Үгс 12:13

Даалгавар

- Та Бурханы хуулиудыг дуулгавартай дагах уу?

Тэмдэглэл

Байнга Залбир

Түүнд хандан залбирч байхыг Бурхан бидэнд зарлигладаг. Та ямар ч үед ямар ч байдлаар залбирч болно. Хувь хүмүүсийн хувьд түүнчлэн гэр бүлийнхээ хамт өглөө, орой өвдөг сөгдөн залбирч байхыг Их Эзэн бидэнд заасан юм. Тэнгэрлэг Эцэг маань бидний залбирлуудыг сонсож, хариулдаг. Бид өдөр тутмын залбирлаар дамжуулан бурханлиг удирдамж болон адислалууд хүлээн авдаг. Бид үргэлж чин сэтгэлээсээ залбирах ёстой. Бас бид “үнэн хүсэлтэйгээр” залбирах ёстой, энэ нь бид хүлээж авсан хариуныхаа дагуу ажиллах шийдвэр төгс байх хэрэгтэй гэсэн үг юм.

Бид итгэлтэйгээр Тэнгэр дэх Эцэгтээ Есүс Христийн нэрээр залбирдаг (Моше 5:8-ыг үз). Тэр бидний Эцэг, бид Түүний хүүхдүүд учраас Тэр бидний залбирлуудад хариулах болно. Бид залбирлуудаа Тэнгэр дэх Эцэгтээ хандаж эхэлдэг. Бид залбирлуудаа “Есүс Христийн нэрээр, амен” гэж төгсгөдөг.

Залбиралд бид Тэнгэр дэх хайрт Эцэгтэйгээ илэн далангүй, шударгаар ярьдаг. Бид адислалуудынхаа төлөө талархал илэрхийлдэг. Бид Түүнийг хайрлах хайрынхаа тухай мэдэгдэж болно. Бас бид тусламж, хамгаалал, тэрчлэн өөрсдийн хэрэгцээний дагуу удирдамж хүсдэг.

Бид итгэл, чин сэтгэл хийгээд үнэн хүсэлтэйгээр залбирснаар Бурханы нөлөөг амьдралдаа харах болно. Тэр биднийг өдөр тутмын амьдралд маань удирдаж, зөв шийдвэрүүд гаргахад бидэнд туслах болно. Тэр тайтгарал болон амар амгалангийн мэдрэмжүүдээр биднийг адислах болно. Тэр аюул ослын тухай биднийг сэрэмжлүүлж, уруу таталтыг эсэргүүцэхэд бидэнд хүч чадал өгөх болно. Тэр бидний нүглүүдийг өршөөх болно. Бид Түүнд илүү ойр дотно байгаагаа мэдрэх болно. Бид өөрсдийн амьдрал дахь Түүний нөлөөг хүлээн зөвшөөрч сурах ёстой. Сүнсний анир чимээгүй, намуухан дуу хоолойг бид сонсож сурах ёстой.

Ариун Сүнс бидэнд үнэнийг зааж байгааг бид мэдэж чадна. Бидний оюун ухаан урам илчлэгч, өөдрөг санаа бодлуудаар дүүрэн байх болно. Бид гэгээрэх буюу шинэ мэдлэгтэй болох болно. Бидний зүрх сэтгэлд амар амгалан, баяр хөөр болон хайрын мэдрэмжүүд байх болно. Бид сайныг үйлдэж, бусдад тусч байхыг хүсэх болно. Эдгээр мэдрэмжүүдийг дүрслэхэд хэцүү, гэвч бид тэдгээрийг биеэр амссанаар таньж болно.

Тэмдэглэл

Судар Судлах2 Нифай 32:8–9
Инос 1:1–12
Алма 34:17–28
Моронай 10:3–5С ба Г 6:22–23
С ба Г 8:2–3
С ба Г 9:7–9С ба Г 19:28
Хаадын Дээд 19:11–12
Guide to the Scriptures, “Prayer”**Даалгавар**

- Та өдөр бүр хувиараа болон гэр бүлээрээ өвдөг сөгдөн залбирч байх уу?

Судруудыг Судал

Судрууд бол Ариун Сүнсний нөлөөн дор бошиглогчдоор цэдэглэгдсэн, Бурханаас Өөрийн хүүхдүүдэд хандсан ажил хэргийн тухай бичмэл цэдгүүд юм. Бид Бурханы илчлэгдсэн үгийг судалж, үүнд итгэн, мөн дуулгавартай дагах замаар итгэлээ харуулдаг. Үнэнийг ойлгохын тулд бид судруудыг хичээнгүйлэн судалдаг. Судрууд нь илчлэлтийн хаалгийг нээж юу хийх хэрэгтэй болон ямар болохыг бидэнд үзүүлдэг учраас бид тэдгээр дээр хуримладаг. Есүс Христийн болон Түүний сайн мэдээний тухай мэдэхийн тулд бид судруудыг судалдаг. Есүс Христэд итгэх итгэл бол Бурханы бэлэг бөгөөд Түүний үгийг мөн Түүний сайн мэдээг судалж, түүгээр амьдарснаар дамжин ирдэг. Сүмийн зөвшөөрөгдсөн судруудыг бас жишиг бүтээлүүд гэж нэрлэдэг бөгөөд тэдгээр нь Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ түүнчлэн Агуу Үнэт Сувд юм. Бид эдгээр ариун номнуудыг өдөр бүр судлах ёстой.

Судар Судлах1 Нифай 19:22–23
2 Нифай 9:50–51
2 Нифай 25:26
2 Нифай 29:1–132 Нифай 31:19–20
2 Нифай 32:3–5
Алма 32:28–30
Иохан 5:39Иохан 20:31
2 Тимот 3:14–17
2 Петр 1:20–21**Даалгавар**

- Та хувиараа болон гэр бүлээрээ судруудыг өдөр бүр уншиж байх уу?

Хүндэтгэлийн Өдрийг Ариунаар нь Сахь

Хүндэтгэлийн Өдрөөр бидний биеэ авч яваа байдал Бурханд хүндэтгэл үзүүлэх болон шүтэн бишрэх бидний амлалтын тусгал байдаг. Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь сахиснаар бид гэрээнүүдээ сахих хүслээ Бурханд харуулдаг. Хүндэтгэлийн Өдөр бүр бид Их Эзэнийг шүтэн бишрэхээр Түүний өргөөнд очдог. Тэнд бид Есүс Христ болон Түүний Цагаатгалыг дурсан санахын тулд ариун ёслолоос хүртдэг. Бид гэрээнүүдээ шинэчилж, нүглүүдээ болон алдаа дутагдлуудаа наманчлах хүсэлтэй байгаагаа харуулдаг.

Энэ өдөр бид хөдөлмөрөөсөө амардаг. Бид Сүмийн үйлчлэлүүдэд очиж, хамтдаа шүтэн биширснээр бид бие биенээ бэхжүүлдэг. Найз нөхөд болон

Тэмдэглэл

гэр бүлтэйгээ харилцсанаар бид өөрсдөө шинэчлэгддэг. Бид судруудыг судалж, сэргээгдсэн сайн мэдээний тухай илүү ихийг сурахад бидний итгэл бэхждэг.

Хамт олон буюу улс үндэстэн Хүндэтгэлийн Өдрийн үйл ажиллагаануудад хайхрамжгүй хандах нь ихсэх юм бол тэдний шашны амьдрал ялзран доройтож, улмаар амьдралын бүх талд сөргөөр нөлөөлдөг. Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахихтай холбоотой адислалууд байхгүй болдог. Хүндэтгэлийн Өдөр бид юм худалдаж авах болон эдүгээ Хүндэтгэлийн Өдрийг ариун бус болгох нь нийтлэг болсон бусад арилжаа, спортын үйл ажиллагаануудад оролцохоос татгалзах ёстой.

Хожмын Үеийн Гэгээнтнүүд шүтэн бишрэхийн сүнстэй байж, талархал илэрхийлэх, үйлчлэл болон гэр бүлд төвлөрсөн, Хүндэтгэлийн Өдөрт тохирох үйл ажиллагаануудад оролцоноор энэ ариун өдрийг дэлхийн үйл ажиллагаануудаас хол хөндий байлгах ёстой. Сүмийн гишүүд Хүндэтгэлийн Өдрийнхөө үйл ажиллагаануудыг Их Эзэний санаа бодол хийгээд Сүнстэй нийцэхээр явуулахад хүч чармайлт тавьсан тохиолдолд тэдний амьдрал баяр хөөр болон амар амгалангаар дүүрэх болно.

Судар Судлах

3 Нифай 18:1–25
С ба Г 59:9–15

Египетээс Гарсан нь 20:8–11
Египетээс Гарсан нь 31:12–17

Исаиа 58:13–14

Сүм Дээр Сонирхогчид буюу Гишүүдтэй Хамт Суу

Номлогч хамтрагчид ариун ёслолын цуглаанууд буюу гадасны чуулгануудад оролцохдоо сонирхогчид, саяхны хөрвөгчид буюу гишүүдтэй хамт суух ёстой. Тэд бусад номлогч нартай хамт суух ёсгүй.

Даалгаврууд

- Та Хүндэтгэлийн Өдрийг ариунаар нь сахих уу?
- Та ариун ёслолоос зохистойгоор хүртэхэд өөрийгөө бэлтгэх үү?

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- Хүндэтгэлийн Өдрийн тухай, түүний дотор долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх болон бусдад үйлчлэл үзүүлэх тухай та юу ойлгов? Та [баптисмынхаа өмнө] энэ хуулинд дуулгавартай байхыг хүсч байна уу?

Баптисм ба Гишүүний Баталгаа

Бурханы замыг дагах хүслээ харуулдаг арга зам нь баптисм болон гишүүний баталгаагаар дамждаг. Бид баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, түүнийг ямагт дурсан санаж, зарлигуудыг нь дагах болно хэмээх гэрээнд Бурхантай ордог. Бид бас ямарч цагт Бурханы гэрчлэгч болж, хэрэгцээтэй хүмүүст туслахыг амладаг (Мозая 18:8–9-ийг үз). Хариуд нь Ариун Сүнсний байнгын нөхөрлөл, нүглүүдээс ангижрах болон дахин төрөхийг Бурхан амладаг.

Тэмдэглэл

Даалгаврууд

- Та баптисм хүртэж, гишүүнээр батлуулах уу?
- Сонирхогчдыг баптисмын үйлчилгээнд оролцуулахаар та урих уу?
- Хэрэв боломжтой бол, хэн нэг нь гишүүнээр батлагдах ариун ёслолын цуглаанд сонирхогчдыг урь.

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- Баптисмын ярилцлагын бүх асуултууд

Баптисм Хүртэх Урилга

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулах урилга нь: “Бурханы санваарын эрх мэдлийг атгагч хэн нэгнээр та баптисм хүртэж Есүс Христийн үлгэр жишээг дагах уу? Бид (. . . сарын . . . өдөр) баптисмын үйлчилгээ явуулах болно. Энэ өдөр та баптисм хүртэхээр өөрийгөө бэлтгэх үү?” гэж хувь хүнд тухайлан хандаж шууд асуух ёстой.

Бошиглогчийг Дага

Үнэн гэдэг бол юмсын бодитойгоор байгаа, байсан, мөн байх тухай мэдлэг юм. Энэ нь нөхцөл байдал буюу цаг хугацаагаар өөрчлөгддөггүй. Цаг үе болон соёл бүрт үнэний үнэ цэнэ нь адилхан байдаг. Бурхан бол бүх үнэний эх сурвалж мөн. Тэр бидэнд зөвхөн үнэнийг заах болно гэдгийг бид мэддэг учраас бид Түүнд итгэх итгэлтэй байж чадна. Үнэнийг мэдэхийг Бурхан бүх хүүхдүүдээсээ хүсдэг. Тиймээс, Тэр бошиглогчид болон төлөөлөгчдөөр дамжуулан авралд шаардлагатай үнэнүүдийг илчилдэг. Судрууд болон хувь хүний илчлэлтээр дамжуулан Тэр үнэнийг бидэнд хүн нэг бүрт илчилдэг.

Бурханаар дуудагдаж, сонгогдсон бошиглогч нь агуу итгэлтэй зөв шударга хүн байдаг. Их Эзэн Ариун Сүнсээр дамжуулан түүнд үнэнийг илчилдэг. Үнэнийг бүх хүмүүст заахыг Тэрээр Өөрийн бошиглогчид зарлигладаг. Бошиглогчоороо дамжуулан илчилсэн Бурханы үгст итгэдэг хүмүүс адислагддаг.

Сүмийг илчлэлтээр удирддаг төлөөлөгчид болон бошиглогчдын суурин дээр Христийн Сүм баригддаг. Их Эзэн Иосеф Смитийг энэ эцсийн эрин үеийн анхны бошиглогч бөгөөд тэргүүнээр дуудсан юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг өнөөдөр удирдаж байгаа түүнийг залгамжлагчид бас бошиглогчид, төлөөлөгчид мөн. Өнөөгийн Сүмийн Ерөнхийлөгч бол амьд бошиглогч юм. Бид Бурханы сонгосон бошиглогчид итгэх итгэлтэй байж, түүний бурханлиг дуудлагын тухай итгэл үнэмшлийг олж, түүний заадаг зүйлүүдийг дагах ёстой.

Сүмийн удирдагчдыг нийтээрээ дэмжин батлах боломжууд бидэнд олонтаа гардаг. *Дэмжин батлах* гэдэг нь дэмжих гэсэн утгатай. Бошиглогчид болон төлөөлөгчидийг ярихад тэдний заадаг үнэнүүдийг Ариун Сүнс баталж болохын тулд бид өөрсдийгөө бэлтгэх учиртай, тийнхүү бид өөрсөддөө өгдөг тэдний зөвлөгөөг дагахаар шийддэг.

Амьд бошиглогч болон төлөөлөгчдийн зөвлөгөөг сонсож, дагадаг хүмүүс төөрөхгүй байх болно. Амьд бошиглогчдын заадаг зүйлүүд нь өөрчлөгддөг үнэт зүйлсийн дэлхийд мөнхийн үнэний тогтмол хэмжигдэхүүнээр хангадаг бөгөөд гай зовлон, уй гашуугаас зайлсхийхэд бидэнд тусалдаг. Дэлхийн будлиан болон маргаан биднийг няц дарах нь үгүй, мөн Бурханы хүсэлтэй нийцсэн байхын бат итгэлийг эдэлж чадна.

Судар Судлах

Мозая 15:11–12	С ба Г 21:1–7	Ефес 2:19–20
Алма 13:1–16	С ба Г 136:37–38	Ефес 4:11–14
3 Нифай 12:1–2	Иохан 15:16	Еврей 5:4
С ба Г 1:37–38	Үйлс 10:34–44	Амос 3:7

Даалгаврууд

- Та бишоптой уулзах уу?
- Та Сүмийн удирдагчдыг дэмжиж, зөвлөгөөг нь дагах уу?

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- [Сүмийн одоогийн Ерөнхийлөгч] бол Бурханы бошиглогч гэдэгт та итгэдэг үү? Энэ нь танд юу гэсэн үг вэ?

Арван Зарлигийг Сахь

Тэрээр бидэнд өгөхийг хүсдэг адислалуудыг (баяр хөөр, ухамсрын амар амгалан, удаан үргэлжлэх аз жаргал) хүлээж авахын тулд бид юу хийх болон юу хийхээс зайлсхийхийг мэдэхийн тулд Тэнгэрлэг Эцэг бидэнд зарлигууд өгдөг. Түүний хүмүүсийг удирдахын тулд Бурхан Мосед Арван Зарлигийг илчилжээ:

- “Чи надаас өөр бурхадтай байж болохгүй” (Египетээс Гарсан нь 20:3). Бусад “бурхад” нь эзэмшлүүд, хүч, нэр төрийг багтааж болно.
- “Чи өөртөө зориулан ямар нэг юмны дүрсийг бүү хий” (Египетээс Гарсан нь 20:4).
- “Чи өөрийн Бурхан Эзэний нэрийг дэмий бүү дурд” (Египетээс Гарсан нь 20:7).
- “Хүндэтгэлийн Өдрийг ариунаар сахихын тулд санагтун” (Египетээс Гарсан нь 20:8).
- “Эцэг эхээ хүндэл” (Египетээс Гарсан нь 20:12).
- “Чи хүн бүү ал” (Египетээс Гарсан нь 20:13).
- “Чи бүү завхайр” (Египетээс Гарсан нь 20:14).
- “Чи бүү хулгайл” (Египетээс Гарсан нь 20:15).
- “Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил” (Египетээс Гарсан нь 20:16).
- “Чи бүү шунахайр” (Египетээс Гарсан нь 20:17).

Арван Зарлиг өнөөдөр ч хүчинтэй хэвээр байна. Эдгээр нь Бурханыг шүтэн биширч, хүндэтгэл үзүүлэхийг бидэнд заадаг. Эдгээр нь бас бие биендээ хэрхэн хандахыг бидэнд заадаг.

Өөр Бурхад Байхгүй

Олон соёлд хүмүүс өөрсдөд нь Бурханыг буюу өвөг дээдсийг нь санагдуулдаг юмсыг эзэмшиж, хүндэтгэл үзүүлдэг. Заримдаа эдгээр баримал, шашны сүлд тэмдэг буюу бяцхан шүтээнүүд мэтийн юмс нь тэдний шүтээний гол зүйл байдаг. Хиймэл шүтээнүүдийг шүтэхгүй байхыг Их Эзэн бидэнд зарлигласныг ойлгоход нь тэдэнд тусал. Тэдний шүтэн биширдэг буюу хандан залбирдаг аливаа юмыг гэрээсээ зайлуулахад тэднийг урамшуулан дэмж. Өөрсдийн Тэнгэрлэг Эцэг, Есүст Христ хоёр дээр итгэл, шүтлэг бишрэлээ төвлөрүүлэхэд нь тэдэнд тусал. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ амьд Христ дээр анхаарал төвлөрүүлдгийг тэдэнд заа.

Тэмдэглэл

Сэргээгдсэн сайн мэдээнд Түүнийг хэрхэн дурсан санахыг Их Эзэн бидэнд заасан байдаг. Залбирал, ариун ёслол болон ариун сүмийн бишрэлээр дамжуулан бид Түүнийг дурсан санадаг. Номлолын тань ерөнхийлөгч зарим тодорхой асуудлуудаар удирдамж өгөх болно.

Судар Судлах

Мозая 13
С ба Г 59:5–6

Матай 22:36–40
Египетээс Гарсан нь 20:1–17

Дэд Хууль 5:6–21

Даалгавар

- Та Арван Зарлигийг сахих уу?

Ариун Явдлын Хуулиар Амьдар

Бурхан ариун явдалд баярлаж, бэлгийн харилцааны нүглийг үзэн яддаг. Ариун явдал нь гэрлэлтийн өмнөх бэлгийн харилцаанаас чанд хатуугаар татгалзаж, гэрлэлтийн дараа нөхөр буюу эхнэртээ туйлын үнэнч итгэлтэй байх явдлыг багтаадаг. Ариун явдлын хуулиар амьдардаг хүмүүс өөрсдийгөө хянахаас ирдэг хүч чадлыг эдэлдэг. Тэд гэр бүлийнхээ харилцаанд итгэлтэй үнэнч байдалд баясдаг. Тэд амьдралдаа Ариун Сүнсний нөлөөг илүү бүрэн дүүрнээр мэдэрч чадна. Энэ хуулийг зөрчдөг хүмүүс амьдралыг нь хүнд төвөгтэй болгодог ичгүүр болон гэм буруугийн урт удаан үргэлжилдэг мэдрэмжийн бай болдог.

Ариун явдал нь бодол санаа болон үйлдэл дэх итгэлтэй байдлыг шаарддаг. Бид бодол санаагаа цэвэр байлгаж, хувцаслалт, үг яриа, үйлдэлдээ даруу байх ёстой. Аливаа хэлбэрийн порнографиас бид зайлсхийх ёстой. Бурханаас өгсөн хүүхэд төрүүлэх хүч болон өөрсдийгөө бид ариун нандинаар нь байлгах ёстой. Баптисм хүртэх гэж байгаа хүмүүс, эрэгтэй хүн, эмэгтэй хүн хоёрын хоорондох хууль ёсны гэрлэлтээс гадуурх бэлгийн аливаа харилцааг хориглодог ариун явдлын хуулиар амьдрах ёстой. Тэд үр зулбуулах, ижил хүйстэнтэйгээ хурьцал үйлдэхэд оролцохгүй байх ёстой. Бэлгийн харилцааны нүгэл үйлдсэн хүмүүс наманчилж, мөн өршөөгдөж болно.

Хамт Амьдардаг Хосууд

Гэрлээгүй атлаа хамт амьдардаг эрэгтэй болон эмэгтэйчүүд эхлээд гэрлэх буюу тусдаа амьдрахгүйгээр баптисм хүртэж болохгүй. Нэгээс илүү хүнтэй нэг зэрэг гэрлэсэн хүмүүс баптисм хүртэж болохгүй. Энэ хоёр тохиолдлын аль алианаар нь танд онцгой чиг өгөх номлолынхоо ерөнхийлөгчөөс зөвлөгөө хүс.

Судар Судлах

Иаков 2:28
Мозая 13:22
Алма 39:3–5

3 Нифай 12:27–30
С ба Г 42:22–24
С ба Г 63:16

Матай 5:27–28
Ром 1:26–32
Ефес 5:3–5

Даалгавар

- Та ариун явдлын хуулиар амьдрах уу?

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- Хууль ёсоор холбогдсон эрэгтэй, эмэгтэй хоёр хүний гэрлэлтээс гадуурх бэлгийн аливаа харилцааг хориглодог ариун явдлын хуулийн талаар та юу ойлгов? Та [баптисмынхаа өмнө] энэ хуулийг дуулгавартай дагахыг хүсч байна уу?
- Та үр зулбуулалтад оролцож байсан уу? Ижил хүйстний бэлгийн харилцааны тухайд? [Анхааруулга: Энэ хоёр асуултанд тийм гэж хариулсан хүмүүс баптисм хүртэхийн өмнө номлолын ерөнхийлөгчтэй ярилцлагад орох ёстой.]

Мэргэн Ухааны Үгийг Дуулгавартай Дага

Мэргэн Ухааны Үг хэмээн нэрлэгддэг эрүүл мэндийн хуулийг Бошиглогч Иосеф Смитэд Их Эзэн илчилжээ. Бидний биеийн эрүүл мэндийг сахин хамгаалахын тулд түүнчлэн муу нөлөөнөөс хол байлгахын тулд бидний хэрэглэх ёстой болон хэрэглэх ёсгүй хоол хүнс болон бодисуудыг энэ хууль бидэнд заадаг. Эрүүл мэндийн адислалууд, хүч чадал, хилэнцэтийн эсрэг хамгаалал, түүнчлэн сүнсний үнэнүүдийг хүлээн авах илүү агуу чадварыг Их Эзэн амладаг.

Бидний биес ариун нандин юм гэдгийг санагтун. Бид биендээ хүндлэл болон хүндэтгэлтэйгээр хандаж байх ёстой. Бид эрүүл мэндэд тохирох хоол идэж байх ёстойг Мэргэн Ухааны Үг заадаг. Бид хортой бодисуудаас, түүний дотор архи, тамхи, цай кофеноос зайлсхийж байх ёстойг нэн тодорхой байдлаар заадаг. Түүнчлэн бид аливаа хэлбэрийн мансууруулах бодисоос бас зайлсхийж байх ёстой. Баптисм хүртэж, гишүүнээр батлуулахын тулд таны заадаг хүмүүс эдгээр бодисуудыг орхих ёстой. Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагадаг хүмүүс сүнсний үнэнүүдийг хүлээн авах илүү чадвартай байдаг.

Танай соёл дахь бусад зарим бодис Мэргэн Ухааны Үгэнд хамрагдах уу гэсэн асуултуудад танай номлолын ерөнхийлөгч хариулах болно.

Донтолтыг Даван Туулах нь

Доорх зарчмуудыг баримталснаар тамхи татах, архи болон бусад зуршлуудыг даван туулахын тулд тэмцэж байгаа хүмүүст та хамгийн сайнаар тусалж чадна. Доорх зөвлөмжүүд Мэргэн Ухааны Үгэнд тухайлан хамааралтай боловч түүнчлэн бас бусад донтолтуудыг даван туулахад хэрэглэгдэж болно.

1. Мэргэн Ухааны Үгээр хэзээ, хэрхэн амьдарч эхлэх талаар зорилго тавихад нь хүмүүст тусал.
2. Та тэдэнтэй хамт байхдаа хувийнхаа залбирлуудад тэдний төлөө залбир.
3. Бүр тэд муу зуршилдаа дахин орсон тохиолдолд ч өөдрөг бодолтой, сэтгэлээр дэмждэг бай.
4. Тэдэнд сайн мэдээг заахаа үргэлжлүүл. Хүч чадлын эх сурвалж болгон залбирал, итгэлийг хэрхэн ашиглахыг тэдэнд заа.
5. Сүмд тогтмол очих, Мэргэн Ухааны Үгээр амьдардаг бөгөөд мөн тийм донтолтыг даван туулсан хүмүүстэй нөхөрлөлийг хөгжүүлэхэд нь тэдэнд тусал.
6. Тохиромжтой үед, санваарын адислалууд өгөхийг тэдэнд санал болго.
7. Хортой бодисуудыг гэрээсээ зайлуулахад нь тэднийг урамшуулан дэмж.

Донтолтуудыг даван туулахад нь хүмүүст туслах талаар дэлгэрэнгүй зааврыг бүлэг 10-аас үз.

Тэмдэглэл

Судар Судлах

С ба Г 89

1 Коринт 3:16–17

1 Коринт 6:19–20

Даалгавар

- Та Мэргэн Ухааны Үгээр амьдрах уу?

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- Мэргэн Ухааны Үгийн тухай та юу ойлгов? Та [баптисмынхаа өмнө] энэ хуулийг дуулгавартай дагахыг хүсч байна уу?

Аравны Нэгийн Хуулийг Сахь

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэх гишүүнчлэлийн агуу адислалуудын нэг нь аравны нэгийг төлөх замаар Бурханы хаант улсын өсөлт хөгжилтөд хувь нэмэр оруулах онцгой боломж юм. Аравны нэг бол, эртний, бурханлиг хууль юм. Жишээ нь, Хуучин Гэрээний Бошиглогч Абрахам өөрийнхөө эзэмшдэг байсан бүхний аравны нэгийг төлдөг байжээ (Алма 13:15-ыг үз).

Аравны нэгийг төлдөг хүмүүст Их Эзэн . . . Тэрээр “тэнгэрийн цонхуудыг нээж . . . адислалыг хальтал асгах” болно хэмээн амлажээ (Малахи 3:10). Эдгээр адислалууд эд материалын буюу сүнслэг байж болно, гэвч тэдгээр нь бурханлиг энэ хуулийг дуулгавартай дагадаг хүмүүст ирэх болно.

Аравны нэг нь аравны нэг хэсэг гэсэн утгатай бөгөөд адислагдахын тулд дундаж орлого хэмээн ойлгогддог орлогынхоо аравны нэгийг өгөхийг Их Эзэн бидэнд зарлигласан юм. Аравны нэгийн хууль Түүний хаант улсыг байгуулахад туслах боломжийг бидэнд олгодог. Бидний аравны нэг Их Эзэнд ариун бөгөөд бид аравны нэгийг төлснөөр Түүнийг хүндэтгэдэг. Аравны нэгийг үнэнч шударгаар төлдөг хүмүүсийг элбэг дэлбэгээр адислахаар Бурхан амласан юм. Аравны нэгээ төлдөггүй хүмүүс Бурханыг дээрэмддэг (Малахи 3:8-ыг үз). Тэд Түүнд зүй ёсоор харьяалагддаг зүйлийг өөрсдийнхөө төлөө хадгалдаг. Бид эхлээд Бурханы хаант улсыг эрэлхийлэх ёстой, иймд аравны нэг бол үүнийг хийх нэг чухал арга зам мөн. Аравны нэгээ төлснөөр бид итгэлтэй байгаагаа илэрхийлж байгаа юм. Энэ бол Бурханд болон Түүний ажилд итгэх бидний итгэлийн гадаад тэмдэг юм.

Аравны нэгийн сан нь ариун сүмүүд болон цуглааны байруудыг ажиллуулах, бүх дэлхийд сайн мэдээг хүргэх, ариун сүмийн болоод гэр бүлийн түүхийн ажил хөтлөн явуулах болон дэлхий даяарх бусад үйл ажиллагаанууд гэх мэтийн Сүмийн тогтмолжсон үйл ажиллагаануудыг дэмжихэд ашиглагддаг. Сайн дураар үйлчилдэг Сүмийн орон нутгийн удирдагчдыг аравны нэгээр цалинжуулдаггүй.

Сүмийн орон нутгийн удирдагчид долоо хоног бүр хүлээн авсан аравны нэгийг шууд Сүмийн удирдах төвд илгээдэг. Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Тэргүүлэх Бишопын Зөвлөлөөс бүрдсэн зөвлөл аравны нэгийн ариун сангуудыг ашиглах өвөрмөц арга замуудыг тодорхойлдог.

Судар Судлах

Аравны Нэг

С ба Г 119

Еврей 7:1–2

Левит 27:30–33

С ба Г 120

Эхлэл 14:18–20

Малахи 3:7–12

Итгэл

3 Нифай 13:33

Ифэр 12:6

Даалгавар

- Та баптисм хүртсэн үеэсээ аравны нэгийн хуулиар амьдрах уу?

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- Аравны нэгийн хуулийн талаар та юу ойлгосон бэ? Та энэ хуулийг дуулгавартай дагахыг хүсч байна уу?

Тэмдэглэл

Мацгийн Хуулийг Мөрд

Мацаг барих Бурханы зарлигийг дуулгавартай дагадаг хүмүүст агуу адислалууд ирдэг. Мацаг барих гэдэг нь тодорхой хугацаанд хоол, ундгүйгээр явах гэсэн утгатай. Ихэвчлэн сар бүрийн эхний Ням гараг бол дараалсан хоёр хоолоор мацаг барьж, залбирах, мөн гэрчлэлээ хуваалцах тусгай өдөр байдаг. Мацаг залбирал хоёр хамтдаа байдаг. Бид итгэлтэйгээр мацаг барьж, залбирахад, Их Эзэнээс залбирлуудынхаа хариу болон адислалууд хүлээж авахад илүү дөхөмтэй болдог. Тэр биднийг байнга удирдах болно гэж бидэнд амласан билээ. Бид тодорхой зорилгуудын төлөө мацаг барьж, залбирах ёстой. Мацаг нь хувийн болон сүнслэг шинжтэй, мөн бид өөрсдийн барьж байгаа мацагт анхаарал хандуулах ёсгүй.

Үнэн шашин ядуусын төлөө тавих анхаарал халамжийг багтаадаг. Тэдний биеийн болон сүнсний хэрэгцээг хангахад бид тэдэнд туслах ёстой. Бид мацаг барихдаа, мөнгийг нь ядуус болон гачигдагсдыг халамжлахын тулд Сүмд хандивладаг. Үүнийг бид мацгийн өргөл гэдэг. Бид хамгийн багаар хоёр хоолноос хэмнэсэн мөнгийг өгдөг. Гэсэн хэдий ч, бид хоёр хоолны үнээр өөрсдийн хандивыг хязгаарлах шаардлагагүй. Биднийг хөрөнгө мөнгөнийхөө боломжоор өгөхийг урамшуулан дэмждэг. Ядууст анхаарал халамж тавьснаар бид баптисмын гэрээнүүдээ биелүүлэх болон нүглүүдийнхээ ангижралыг хадгалахад тусалж чадна.

Судар Судлах**Мацаг Барилт**

Омнай 1:26

Алма 17:2–3

С ба Г 88:76

Алма 5:45–46

Моронай 6:5

Матай 6:1–4, 16–18

Алма 6:6

С ба Г 59:12–16

Исаиа 58:6–11

Ядуусын Төлөө Тавих Анхаарал Халамж

Мозая 4:16–27

Алма 4:12–13

Иаков 1:27

Мозая 18:8–10

Матай 25:34–46

Исаиа 58:3–12

Даалгаврууд

- Дараачийн мацгийн Ням гарагт та зарим онцгой хэрэгцээний төлөө мацаг барьж, залбирах уу?
- Мацгийн өгөөмөр өргөлийг та [баптисм хүртсэнийхээ дараа] хандивлах уу?

Аравны Нэг болон Өргөлүүдийг Хэрхэн Хандивлах Вэ

Аравны нэг болон өргөлүүдийг сайн дурын үндсэн дээр төлдөг. Гишүүд аравны нэг болон өргөлүүдийг ямар ч үед төлж болно, гэвч аравны нэгийг орлого олсон үедээ, мацгийн өргөлүүдийг мацгийн өдөр төлөх нь хамгийн тохиромжтой юм. Гишүүд бишопын зөвлөлөөс авсан хандивын тасалбарыг бөглөж, хандиваа төлдөг. Гишүүн шар тасалбарыг өөртөө хадгалж, цагаан хувь болон хандивыг зориулалтын дугтуйнд хийж наана. Дугтуйг бишопын зөвлөлийн нэг гишүүнд өгдөг. Эдгээр хандивууд ариунд тооцогдож, Их Эзэнд харьяалагддаг. Бишопын зөвлөлийн нэг гишүүн болон бичиг хэргийн ажилтан бүх хандивуудын нууц тайланг анхаарал болгоомжтойгоор хадгалдаг.

Гишүүд жил бүрийн эцэст бишоптой аравны нэгийн тайлан хэлэлцүүлэгт орж, аравны нэг төлөлтийн үнэн зөв байдлыг тогтоодог. Энэхүү хувийн уулзалт дээр гишүүд өөрсдийн бүх хандивын жилийн эцсийн тайланг хүлээн авдаг. Санхүүгийн бүх мэдээллийг чанд нууц байдалд хадгалдаг.

Аравны Нэг болон Өргөлүүдийг Хэрхэн Хандивлахыг Заа

Хандивын хуудсыг үзүүлж, үүнийг хэрхэн ашиглахыг тайлбарла. Хөрвөгчид баптисм хүртсэний дараа уг хуудсыг бөглөхөд нь та тэдэнд туслах хэрэгтэй болж болно.

Хуулийг Дуулгавартай Дагаж, Дээдэл

Газар бүрийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд амьдарч байгаа улс орныхоо хуулиудыг дуулгавартай дагахад итгэдэг. Сайн иргэд байж, иргэний засгийн газар болон улс төрийн үйл хэрэгт оролцож, хамт олондоо үйлчлэл үзүүлж байхыг Сүмийн гишүүдэд зөвлөдөг. Гэвч тэд үүнийг Сүмийн төлөөлөгчдийн хувьд бус, харин санаачлагатай иргэдийн хувьд хэрэгжүүлдэг.

Судар Судлах

С ба Г 58:21
С ба Г 98:5

С ба Г 130:20–21
С ба Г 134

Итгэлийн Тунхаг 1:12

Даалгавар

- Та оршин суудаг орныхоо хуулиудыг дуулгавартай дагах уу?

Баптисмын Ярилцлагад Хэрэглэгддэг Асуултууд

- Та ноцтой гэмт хэрэг үйлдэж байсан уу? Хэрэв тийм бол, та одоо тэнсэнд байгаа юу, эсвэл хугацаанаас өмнө суллагдсан уу? [Анхааруулга: Эдгээр асуултуудын аль нэгэнд тийм гэж хариулсан хүн баптисм хүртэхийн өмнө номлолын ерөнхийлөгчтэй ярилцлаганд орох ёстой.]

Үйл ажиллагаа

Энэ хичээл дэх зарлиг бүрээр, уг зарлигийг сахидаг хүмүүст Их Эзэний өгсөн судрын амлалтуудыг жагсаа. Амьдралд тань хэрэгжсэн амлалтуудыг суралцах тэмдэглэлдээ бич.

Хуулиуд ба Ёслолууд

Баптисм ба Гишүүний Баталгааны дараа



© 1986 Dai Paison. Хувийн өмчлөлт болгогч.

Тэмдэглэл

Заахад Бэлтгэ

Хөрвөгчид баптисм хүртэж, гишүүнээр батлагдсаны дараа хэсгийн номлогч нар эсвэл бүрэн цагийн номлогч нар хичээлийг зааж эхлэх эсэхийг мөн бүрэн цагийн номлогч нар хэр зэрэг удаан хугацаагаар оролцохыг хэсгийн удирдагчид тодорхойлно. Шинэ гишүүдийг баптисм хүртэж, гишүүнээр батлагдсаны дараа удалгүй энэ хичээлийг тэдэнд заах ёстой. Эдгээр хуулиуд болон ёслолуудын талаар та тэдний баптисм болон гишүүний баталгааны хооронд эсвэл бүр баптисмаас өмнө ч зааж эхэлж болно. Баптисм хүртэх гэж байгаа хүмүүс хамгийн наад тал нь эдгээр хуулиуд болон ёслолуудын талаар баптисмаас өмнө мэдсэн байх ёстой.

Энэ хичээл нь хичээл 4-тэй их төстэй. Таны хэрэглэх арга саяхны хөрвөгчдийн хэрэгцээ болон Сүнсний удирдамжаар тодорхойлогдоно. Сайн мэдээгээр амьдрахад нь саяхны хөрвөгчдөд хэрхэн туслах тухай байнга бодож, мөн залбир. Санаанууд гэвэл:

- “Сэргээлтийн Талаарх Захиас,” “Авралын Төлөвлөгөө,” түүнчлэн “Есүс Христийн Сайн Мэдээ” хичээлүүдийг нэгтгэн дүгнэхдээ энэ хичээлийн хуулиуд болон ёслолуудыг шинэ гишүүн бүрт заах. Жишээ нь, Сэргээлтийн талаарх захиасыг нэгтгэн дүгнэх үед та санваар болон номлогчийн ажлын тухай заахыг хүсч болно; авралын төлөвлөгөөг нэгтгэн дүгнэхдээ та мөнхийн гэрлэлт, ариун сүмүүд болон гэр бүлийн түүхийн ажлын тухай түүнчлэн Сүмд заах болон суралцах тухай зааж болно. Есүс Христийн сайн мэдээг нэгтгэн дүгнэхдээ та нарийн ба шулуун замын тухай мөн Сүмд үйлчлэх тухай заахыг хүсч болно.
- Хоёр буюу гурван хууль ба ёслолыг нэгтгэн нэг хичээл болгож заах.
- Нэг хууль буюу нэг ёслолыг нэг хичээл болгож заах.

Эдгээр хуулиуд болон ёслолуудыг хүлээн авч, тэдгээрийн дагуу амьдрахад нь шинэ гишүүдэд туслахын тулд гишүүдтэй ажилла. Бурханы хуулиудыг сахиснаар тэд нүглүүдийнхээ ангижралыг хадгалж, мөнх амьдрал уруу чиглэсэн зам дээр үлдэх болно гэдгийг мэдэхэд нь шинэ гишүүдэд тусал. Тэд илүү агуу амар амгалан хийгээд баяр хөөрийг үзэх болно. Тэд амьдралын асуултуудын хариуг олж, өөрсдөө Есүс Христийн үнэн Сүмд харьяалагддаг гэдэг мэдлэгт бэхжих болно. Хуулиуд ба ёслолууд нь баяр хөөртэй, Есүс Христэд итгэх итгэлтэйгээр,

түүнчлэн Тэнгэр дэх Эцэгийнхээ дэргэд мөнх амьдрал хүлээн авах бат бөх найдвартайгаар амьдрахад чиглэл болж үйлчилдэг билээ.

Хуулиуд, Ёслолууд болон Даалгавруудын Талаар Суралц

“Хуулиуд ба Ёслолуудыг” судлахдаа та доорх загварыг баримтлах нь ашиг тустай.

- Сургаалыг дүрсэлж байгаа хэсгийг судалж, гурваас таван үндсэн зүйлтэй энгийн хичээлийн төлөвлөгөө бич.
- Хичээлийн хоёр буюу гурван минутын хувилбарыг хамтрагчдаа заа. Даалгаврын урилга бүрийг яаж өгөх, мөн асуудлуудыг хэрхэн шийдэх дадлага хий.
- Саяхны хөрвөгчид хүлээн авсан даалгавар бүрийг шалгах үр ашигтай арга замуудыг ярилц.

Санваар ба Хавсралт Байгууллагууд

Санваар бол Түүний хүүхдүүдийн авралын төлөө Бурханы нэрээр үйлдэхээр хүмүүнд олгогдсон хүч болон эрх мэдэл юм. Санваараар дамжуулан бид авралын ёслолууд, мөн түүнчлэн эдгээлтийн адислалууд, тайтгарал болон зөвлөгөө хүлээн авдаг.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм төлөөлөгчид болон бошиглогчдоор дамжин Есүс Христээр удирдагддаг. Эд бол Бурханаар дуудагдсан мөн санваар өгөгдсөн хүмүүс юм. Эрт дээр үед Христ Өөрийн Төлөөлөгчдийг томилж, тэдэнд санваар олгосон. Хүмүүс сайн мэдээг эсэргүүцэж, Христ болон Төлөөлөгчдийг алахад энэхүү эрх мэдэл байхгүй болсон юм.

1829 онд Иохан Баптист Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр ирэхэд санваарын эрх мэдэл сэргээгдсэн билээ. Тэр тэдний толгой дээр гараа тавьж Аароны Санваарыг тэдэнд өгсөн аж (С ба Г 13-ыг үз). Арай хожуухан анхны Арванхоёроос Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр гар тавин, Петр, Иаков, Иохан нар Есүс Христээс хүлээн авсан Мелкизедек Санваарыг тэдэнд олгожээ (С ба Г 27:12–13-ыг үз).

Зөвхөн эрх мэдэл бүхий нэгнээр гар тавиулах, зохих томилолтоор эрэгтэй хүн санваарын эрх мэдлийг хүлээн авч чадна. Санваар хүлээн авсан эрэгтэй хүнд гайхамшигт боломж олгогддог. Тэрээр ариун гэрээнүүдийг биелүүлэх, бусдад үйлчлэх болон Сүмийг байгуулахад туслахаар гэрээнд ордог. Тэрээр Бурханд үйлчлэх хүсэлтэй байж, мөн энэ хүчинд томилогдох ёстой (С ба Г 4:3; 63:57-г үз). Баптисм болон гишүүний баталгаа мэт ариун ёслолуудыг гүйцэтгэх нь санваар атгагчийн хувьд бас чухал юм. Санваарын эрх мэдлийг зохистойгоор ашиглахад Бурханы хүч үзүүлэгддэг. Санваарын хүчийг зөвхөн зөв шударга байдал, хайр болоод тэвчээрт ашиглаж болно.

Бүх санваар Бурханаас ирдэг. Сүмд Аароны Санваар, Мелкизедек Санваар гэсэн хоёр санваар байдаг. Аароны Санваар нь баптисм, ариун ёслол мэт ёслолуудыг гүйцэтгэдэг. 12 болон түүнээс дээших насны зохистой эрэгтэйчүүд баптисм болон гишүүний баталгааны дараа удалгүй Аароны Санваар хүлээн авдаг.

Насанд хүрсэн зохистой эрэгтэйчүүд дараа нь дээд буюу Мелкизедек Санваар хүлээн авдаг. Сүмийн гишүүд санваарын энэ хүчээр дамжуулан сүнслэг болон материаллаг олон адислал хүлээн авдаг. Зохистой Мелкизедек Санваартнууд Ариун Сүнсний бэлэг олгож, томилогдсон үед бусдыг санваарт томилон, ариулагдсан тосоор өвчтөнүүдийг тосолж, эдгээлтийн болон тайтгарлын адислалуудыг өгч болно. Мелкизедек санваар бүхий зохистой эр нөхрүүд болон эцгүүд өөрсдийн

Тэмдэглэл

эхнэр, хүүхдүүд болон гэр бүлийн бусад гишүүдэд тусгай адислалууд өгч болно. Гэрийн багш нар Сүмийн гишүүдийн гэрээр айлчилж, хувь хүмүүс болон гэр бүлүүдэд анхаарал халамж тавьдаг. Бишопууд болон гадасны ерөнхийлөгчид бол Сүм дэх шүүгчид юм. Нүгэл үйлдсэн Сүмийн гишүүдэд наманчлахад нь болон Сүмийн гишүүнчлэлийн бүрэн адислалуудыг хүрэхэд нь туслах санваарын эрх мэдэл тэдэнд байдаг. Ариун сүмд орох тэдний зохистой байдлыг тогтоохын тулд тэд хүмүүстэй ярилцлага хийдэг.

Хавсралт байгууллагууд санваарын удирдлага дор гишүүдийг бэхжүүлэхэд тусалдаг. Сонирхогчдыг олж заах, түүнчлэн шинэ хөрвөгчдийн нөхөрлөлд туслах тухайд тэд номлолын ажил дахь агуу эх сурвалж болдог. 18 болон түүнээс дээш насны эмэгтэйчүүд бол гэр бүлүүд, хувь хүмүүс түүнчлэн хамт олны доторх үйлчлэлд хүрч ажилладаг Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүд юм. 12-оос 18 хүртэлх насны залуу эмэгтэйчүүд бол Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөрийн гишүүд юм. Мөн энэ насны хөвгүүд Залуу Эрэгтэйчүүдийн хөтөлбөрт оролцдог. 3-аас 11 хүртэлх насны хүүхдүүд Хүүхдийн Хэсгийн байгууллагын нэг хэсэг юм. 12 болон түүнээс дээш насны бүх гишүүн Ням Гарагийн Сургуулийн ангиудад хамрагддаг.

Судар Судлах

Мозая 18:17	С ба Г 84:19–20	Лук 9:1–6
Алма 13:1–19	С ба Г 107	Иохан 15:16
С ба Г 20:38–65	С ба Г 121:34–46	Иаков 5:14–15

Даалгаврууд

- Та Аароны Санваар хүлээн авахад бэлтгэх үү (зөвшөөрөгдөх, 12 болон түүнээс дээших насны зохистой эрэгтэйчүүд)?
- Та Мелкизедек Санваар хүлээн авахад бэлтгэх үү (зөвшөөрөгдөх, насанд хүрсэн зохистой эрэгтэйчүүд)?
- Та холбогдох хавсралт байгууллагад идэвхтэй оролцох уу?

Номлогчийн Ажил

Сайн мэдээг хуваалцдаг гишүүд баяр хөөрийг мэдэрдэг бөгөөд Их Эзэний Сүнс илүү элбэг байдаг. Бид сайн мэдээг хуваалцсанаар энэ нь бидний хувьд хичнээн үнэ цэнэтэй, ямар утга учиртайг бид эрхэмлэн үнэлж, Бурханыг болон бусдыг хайрлах илүү агуу хайрыг мэдэрдэг. Бүх дэлхийд сайн мэдээг номлохыг Их Эзэн Өөрийн дагалдагчдад зарлиглан, үүнийг хүлээн авах буюу хүлээн авахгүй байх боломжийг хүн болгонд олгосон билээ. Хүмүүс баптисм хүртэхдээ тэд ямагт Бурханы гэрч болон үргэлж зогсохоор гэрээ хийдэг. Сайн мэдээг хараахан хүлээн аваагүй байгаа хүмүүстэй үүнийг хуваалцахаар тэдэнд зарлиг болгосон юм. Тэд сайн мэдээгээр итгэлтэй амьдарсан үед тэд үлгэр жишээ үзүүлж, сайн мэдээгээр амьдарснаас ирдэг агуу адислалуудыг гэр бүлийн гишүүд, найз нартаа харуулдаг. Тэд бас асуултуудад хариулах, хэвлэмэл болон харж, сонсох материалуудыг хуваалцах, сэргээгдсэн сайн мэдээний захиасын тухай илүү ихийг мэдэхэд бусдыг урих талаар давуу боломжуудтай байх ёстой. Гишүүд Сүмийн гишүүн биш хүмүүсийн төлөө залбирах ёстой. Номлогчийн боломжууд—манай итгэлийнх биш хүмүүст үйлчлэх болон тэдний итгэдэг зүйлийг хуваалцахын төлөө тэд залбирах ёстой. Тэд сайн мэдээг хуваалцахдаа юу хэлэх болон юу хийхийг мэдэхэд нь гишүүдэд туслахаар Их Эзэн амласан юм.

Тэмдэглэл

Судар Судлах

Иаков 5:70–75

С ба Г 19:29

С ба Г 84:74–76, 88

Мозая 28:3

С ба Г 33:8–11

С ба Г 88:81

С ба Г 18:10–16

С ба Г 38:40–42

С ба Г 100:5–8

Даалгаврууд

- Сүмд харьяалагддаггүй найз нөхөд болон төрөл төрөгсдөө сайн мэдээг заалгуулахаар урихад та бэлтгэх үү?
- Номлогч нарын төлөө бас сайн мэдээг хуваалцах боломжуудын төлөө та залбирах уу?
- Та номлолд үйлчлэхээр бэлтгэх үү?

Мөнхийн Гэрлэлт

Сүмийн үндсэн нэгж бол гэр бүл. Гэр бүлийн хүрээнд хүмүүс амьдралын хамгийн агуу олон баяр хөөр болон уй гашууг үздэг. Эрэгтэй хүн, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт Бурханаас томилогддог бөгөөд Түүний хүүхдүүдийн авралд зориулсан Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх гол төв нь юм. Энэ утгаараа бүтээгдсэн зуурдын амьдрал тэнгэрлэгээр томилогдож, гэрлэлтээр хамгаалагдсан. Аз жаргалын бурханлиг төлөвлөгөө биеийн үхлийн дараа гэр бүлийн харилцааг үргэлжлүүлэх боломжийг олгодог. Гэвч гэрлэлт нь, эрх олгогдсон санваартнууд ариун сүмүүдэд лацдалтын ёслолыг гүйцэтгэж, хамтдаа лацдан холбуулсан эхнэр, нөхөр хоёр өөрсдийн хийсэн гэрээнүүдийг сахисан үед мөнхийн байж чадна. Эхнэр нөхрүүд бие биенээ хайрладаг байх ёстой. Тэд зарлигуудыг сахиж, сайн мэдээний зарчмуудаар амьдрахад тэд бие биеийнхээ гэрлэлтийн тангаргийг туйлын үнэнчээр хүндэтгэх ёстой (“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхагийг үз,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 102; мөн С ба Г 42:22-ыг үз).

Гэр бүлийн амьдрал дахь аз жаргал Есүс Христийн заадаг зүйлүүд дээр үндэслэгдэж, эцэг эхчүүд гэр бүлээ тэргүүлэх үүрэг зорилготой болгосон үед ирдэг нь хамгийн их магадлалтай юм. “Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал мөн. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой” (*Ensign*, 1995 оны 11-р сар, 102). Эцэг эхчүүд хамтдаа Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүддээ зааж, үүгээр амьдрахад нь тэдэнд туслах ёстой.

Сатан гэр бүлүүдийг довтолоход ихэд анхаарч байна. Хэдэн жилийн өмнө Сүмийн удирдагчид Даваа гарагийн үдшийг гэр бүлийн үдэш болгон тогтоосон юм. Энэ цагийг эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээг заах, тэдний харилцааг өөрсөдтэйгөө бэхжүүлэх болон цагийг хамтдаа хөгжилтэйгөөр өнгөрүүлэхэд ашиглах ёстой. Гэр бүлийг бэхжүүлэх өөр арга замууд нь гэр бүлийн өдөр тутмын залбирал, судар судлах, гэр бүлээрээ сүм дээр шүтэн бишрэх болон бусдад үйлчлэх үйлчлэлийг багтаадаг. Тэнгэр бол өв тэгш гэрийн үргэлжлэл юм. Санваарын ёслолууд болон зөв шударга амьдралаар дамжуулан бид гэр бүлүүдээрээ Бурханы дэргэд мөнх амьдарч чадна.

Судар Судлах

Гэрлэлт

С ба Г 42:22

С ба Г 49:15

С ба Г 131:1–4

С ба Г 132:7

Эхлэл 2:24

Ефес 5:25

“Гэр Бүл: Дэлхий Дахинаа

Өргөх Тунхаг”

Гэр Бүл

Мозая 4:14–15

3 Нифай 18:21

С ба Г 130:2

1 Тимот 5:8

“Гэр бүл: Дэлхий Дахинаа

Өргөх Тунхаг”

Хүүхдүүдэд Заа

Алма 56:47

Алма 57:21

С ба Г 68:25–30

Мосе 6:55–62

Ефес 6:4

Сургаалт үгс 22:6

Даалгаврууд

- Та долоо хоног тутам гэр бүлийн үдэш, өдөр бүр гэр бүлээрээ залбирал хийж, өдөр бүр гэр бүлээрээ судар судалж, гэр бүлийн бусад үйл ажиллагаануудыг зохион байгуулж байх уу?
- Та ариун сүмд орж (1) өөрийнхөө хишгийг хүлээж авахаар, (2) энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлэхээр, (3) хэрэв гэрлэсэн бол үүрд мөнхөд эхнэр, нөхөр хоёр байхаар лацдан холбуулж, (4) мөн хүүхдүүдээ өөрсөдтэйгөө лацдан холбуулахаар бэлтгэх үү?
- Та Хүндэтгэлийн Өдөр гэр бүлээрээ шүтэн бишрэх үү?
- Та бусдад үйлчлэх үү?

Ариун Сүмүүд ба Гэр Бүлийн Түүх

Ариун сүмүүд барихыг Их Эзэн Өөрийн хүмүүст зарлигласан юм. Ариун сүмд бид ариун гэрээнүүдийг хийж, ариун сүмийн хишиг буюу хүчний болон мэдлэгийн бэлэг дээрээс олгогддог. Энэ хүч өдөр тутмын амьдралд маань бидэнд тусалж, Бурханы хаант улсыг байгуулах боломжийг бидэнд олгодог. Ариун сүмд бид бас энэ амьдралд болон үүрд мөнхөд гэрлэж болно, тийнхүү энэ нь Бурханы дэргэд үүрд хамтдаа байх боломжийг гэр бүлүүдэд олгодог. Гишүүн болсноос хойш наад тал нь нэг жилийн дараа, зохистой насанд хүрэгчид өөрийнхөө хишгийг хүлээн авахын тулд ариун сүмийн зөвшөөрлийн бичгийг бишпоосоо авах эрхтэй байдаг. Өөрийнхөө хишгийг хүлээн авсны дараа гэрлэсэн хосууд лацдан холбуулах буюу үүрд мөнхөд гэрлэж болно.

Аврагч бүх хүмүүсийг хайрлаж, тэдний авралыг хүсдэг. Гэвч сая сая хүмүүс Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний захиасыг сонсох буюу аврагч ёслолуудыг хүлээн авах ямар ч боломжгүйгээр нас барсан байдаг. Өөрийн хайрын ач ивээл болон нигүүлслээр дамжуулан мөнх бус амьдралынхаа үед сайн мэдээг хүлээн авч, ойлгон мөн дуулгавартай дагах боломжгүй байсан хүн болгонд Их Эзэн авралыг боломжтой болгосон билээ. Сайн мэдээ нь сүнсний дэлхий дэх нас нөхчсөн эдгээр хүмүүст номлогддог. Дэлхий дээрх Сүмийн гишүүд өөрсдийн нас нөхчсөн өвөг дээдэс болон бусад хүмүүсийн нэрийн өмнөөс аврагч ёслолуудыг гүйцэтгэдэг. Сүнсний дэлхийд амьдарч байгаа нас нөхчсөн хүмүүс сайн мэдээг хүлээн авах аль эсвэл хүлээн авахгүй байх боломжтой байдаг бөгөөд ёслолууд тэдний нэрийн өмнөөс гүйцэтгэгддэг.

Энэ шалтгааны учир Сүмийн гишүүд өөрсдийн өвөг дээдсийн тухай мэдээллийг эрж хайдаг. Тэд удмын бичиг болон гэр бүлийн цэдгийг бөглөж,

Тэмдэглэл

Тэмдэглэл

ариун сүмүүдэд тэдний нэр дээр гүйцэтгэгддэг. Аврагч ёслолууд шаардлагатай байгаа нас нөхцсөн төрөл төрөгсдийнхөө нэрсийг явуулдаг. Энэ бол гэр бүлийн түүхийн ажил юм. 12 болон түүнээс дээш насны зохистой гишүүд, түүний дотор шинэ гишүүд нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэхийн тулд зөвшөөрлийн бичгийг бишпоосоо хүлээн авч болно.

Гэр Бүлийн Түүх

Гэр бүлийн түүхийн ажлын нэвтрүүлэх болон тэдэнд олдох боломжтой эх сурвалжуудад нэвтрэхийн тулд шинэ гишүүдийг аль нэг гишүүнтэй уулзуулах буюу орон нутгийн гэр бүлийн түүхийн төвд (байдаг бол) очиход шинэ гишүүдийг урь. Гэр бүлийн түүхийн материалуудын нэг хувиар тэднийг ханга.

Судар Судлах

С ба Г 43:16	С ба Г 128	С ба Г 138	1 Петр 3:18–21
С ба Г 95:8–9	С ба Г 131	Дуулал 65:4	1 Коринт 15:29
С ба Г 124:22–42	С ба Г 132	Brochure, <i>Welcome to the Family History Center</i>	

Даалгаврууд

- Та ариун сүмийн адислалуудыг хүлээн авахаар бэлтгэх үү? (Баптисм болон гишүүний баталгааны дараа удалгүй, 12-оос дээш насны зохистой гишүүд ариун сүмд явж, нас барагсдын өмнөөс хийлгэх баптисмд оролцохын тулд зөвшөөрлийн бичиг авч болно.)
- Та гэр бүлийн түүхийн ажилд оролцож, ариун сүмийн төлөөлөн хийлгэх ёслолуудыг хүлээн авахын тулд өвөг дээдсийнхээ нэрсийг явуулах уу?

Үйлчлэл

Сүм дэх гишүүнчлэлийн агуу адислалуудын нэг нь үйлчлэх боломж юм. Бид хайрын үйлчлэлийг бусдад үзүүлэхдээ бид Бурханд үйлчилдэг. Бид баптисм хүртэхдээ ийм үйлчлэл үзүүлэх гэрээнд ордог (Мозая 18:8–10-ыг үз). Бид бусдын биеийн болон сүнсний хэрэгцээнүүдийг мэддэг байх ёстой. Тэгвэл бид өөрсдийн цаг зав, авъяас билиг, эд хөрөнгийг тэдний хэрэгцээг хангахад зориулж болно. Бусдад үйлчлэхээр ирдэг байсан Аврагчийн үлгэр жишээг бид дагадаг. Бид Есүстэй адилхан болохын тулд Түүний хийдэг байсан зүйлийг хийх ёстой.

Шинэ гишүүд баптисмын дараа удалгүй Сүмд туслах хариуцлагын нэг адислалыг санваартны удирдагчдаасаа хүлээн авдаг. Үүнийг дуудлага гэдэг. Сүм дэх бүх ажил сайн дурынх байдаг. Ийм үйлчлэлийн төлөө хэнд ч цалин төлдөггүй. Бид дуудлагууд авахдаа бусад гишүүд бидний дуудлагуудыг хүлээн зөвшөөрч, дэмжлэг үзүүлэхийн тулд бид Сүмийн цуглаан дээр нийтийн өмнө дэмжин батлагддаг. Бас дуудлагуудаа биелүүлэхэд бидэнд туслах тусгай адислалуудыг өгөхийн тулд санваартны нэг удирдагч биднийг онцгойлон адисладаг. Эдгээр харилцан адилгүй дуудлагуудыг эзэнтэй болгохын тулд гишүүн бүрийн авъяас билэг хийгээд чадавхи сүмд хэрэгтэй. Бүх дуудлагууд чухал бөгөөд Бурханы хаант улсыг байгуулахад тусалдаг. Бид ийм дуудлагуудыг хүлээн авч, үүргүүдээ мэдэж, тэдгээрийг биелүүлэхэд хичээл зүтгэл гарган ажиллах ёстой. Ингэсэн тохиолдолд бид итгэлд өсч хөгжин шинэ авъяас билгүүдээ, мөн үйлчлэх чадвараа илүү ихээр хөгжүүлж, үй олон тооны бусад адислалууд хүлээж авдаг.

Судар Судлах

Энэрэл

Моронай 7:43–48	С ба Г 88:125	Матай 22:36–40	1 Коринт 13:1–8
-----------------	---------------	----------------	-----------------

Ядууст Тавих Анхаарал Халамж

Мозая 4:26	Алма 34:28–29	С ба Г 52:40	Матай 25:40
------------	---------------	--------------	-------------

Бид Үйлчлэх Ёстой

Мозая 2:17	Мозая 18:8–10	С ба Г 42:29	С ба Г 107:99–100
------------	---------------	--------------	-------------------

Даалгаврууд

- Та дуудлагын үүргүүдийг хүлээн авч биелүүлэх үү (түүний дотор гэрийн багшийн болон айлчлагч багшийн ажил үүргийг)?
- Та бусдыг дуудлагуудад нь дэмжих үү?

Сүм Дээр Заах ба Суралцах нь

Гишүүдээ төгөлдөржүүлж, тэдний амьдралыг адислахын тулд Сүм зохион байгуулагдсан. Энэ нь сайн мэдээг бие биендээ заах, нөхөрлөж, мөн бие биендээ үйлчлэх, түүнчлэн авралын төлөөх бидний эрэлд бие биенээ дэмжих боломжийг бидэнд олгодог. Гэр бүлд, мөн Сүмээр дамжуулан гишүүн болгонд сайн мэдээний сургаалуудыг заадаг. Гишүүд заах ажил үүрэгт дуудагдахад тэдэнд материалууд олгож, ажилдаа амжилт гаргахад нь тусалдаг.

Судар Судлах

С ба Г 88:77–79	Ефес 4:11–14
-----------------	--------------

Даалгавар

- Та сүмд очих уу?

Эцсээ Хүртэл Тэвчих

Бид сайн мэдээгээр амьдрахаа үргэлжлүүлснээр Тэнгэрлэг Эцэгтээ улам ойр дотно болж өсдөг. Бид Аврагчийн Цагаатгалыг эдэлж, илүү ихээр үнэлэн дээдэлдэг. Манай гэр бүлүүд илүү ойртон нягтардаг. Цагаатгалаас ирдэг хайр, баяр хөөр, амар амгалангийн мэдрэмжүүдийг бид илүү ихээр мэдэрдэг. Бидний зүрх сэтгэл өөрчлөгдөж, сэргээгдсэн сайн мэдээгээр амьдрахад бид аюулгүй байдлыг олдог.

Христэд итгэх итгэл, наманчлалыг хөгжүүлэхээ үргэлжлүүлснээр бид гэрээнүүдээ шинэчилж, Ариун Сүнсний байнгын удирдамжийг эдэлдэг. Хэрэв бид гэрээнүүддээ үнэнч байж, амьдралынхаа эцсийг хүртэл тэвчих юм бол, бид мөнх амьдрал хүлээн авах болно.

Цөөн гишүүд тэвчдэггүй буюу бүрэн идэвхтэй үлддэггүй. Гэвч, эцсээ хүртэл тэвчих нь хувийн хариуцлага юм. Бид “[өөрсдийнхөө] авралыг биелүүлдэг” (Филиппой 2:12) бөгөөд идэвхгүй байдлын улмаас итгэл нь сул хөгжсөн хүмүүсийг хайрлаж, тэдэнд үйлчилдэг.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Судар Судлах

2 Нифай 31:20–21
Моронай 6:4

С ба Г 20:37
Итгэлийн Тунхаг 1:3

Иохан 14:15, 21
Ефес 4:11–14

Филиппой 2:12

Даалгавар

- Та бүх амьдралынхаа туршид баптисмын гэрээнүүдийг сахиж сайн мэдээгээр амьдрахаа үргэлжлүүлэх үү?



Би Хэрхэн Сүнсийг Танин Мэдэж, Ойлгох Вэ?

Тэмдэглэл

Үүнийг Анхаар

- Би яагаад хувийн илчлэлт хүлээн авах хэрэгтэй вэ?
- Ариун Сүнс гэж хэн бэ, Тэр яаж ажилладаг вэ?
- Би яагаад итгэлтэйгээр залбирах ёстой вэ?
- Номлогчийн ажилд Сүнсний үүрэг юу вэ?
- Сүнсний өдөөлтүүдийг би хэрхэн таних вэ?

Хувийн Илчлэлт

Илчлэлтгүйгээр аврал ирж чадахгүй; үүнгүйгээр тохинуулна гэдэг хэний ч хувьд дэмий хоосон зүйл” гэж Иосеф Смит хэлжээ (*History of the Church*, 3:389). Та хувийн илчлэлт хүлээн авч, дагаснаар ажилдаа амжилт гаргах болно. Иосеф Смит бас илчлэлт нь таны өдөр тутмын ажилд амин чухал юм гэдгийг мөн зааж: “Энэ бол тэнгэрийн засгийн газар—хаант улсын хүүхдүүд байрласан нөхцөл байдалд тохирсон илчлэлтээр удирдагддаг зарчим юм” гэжээ (*History of the Church*, 5:135).

Бурхан танд мөн Өөрийн бүх хүүхдүүдэд хайртай. Бурхан бодит болон өвөрмөц бэрхшээлүүдийг тань даван туулахад таныг дэмжих гэж санаа тавьдаг. Юу хийхийг мэдэх урам илчлэлтийг танд амлаж, мөн үүнийг хийх хүч танд өгөгдсөн билээ (С ба Г 43:15–16-г үз). Тэр таныг судрыг хичээнгүйлэн судлахаар дамжуулан Сүнсийг танин мэдэж, ойлгохыг хичээхэд тань туслах болно. Сэргээлтийн захиасыг хүлээн авах хүмүүс рүү Тэр таныг хөглөх болно. Уг захиасыг хүргэж, Христ болон Түүний Сайн мэдээний тухай гэрчлэх хүчийг Тэр танд өгөх болно.

Ариун Сүнсний бэлгээр дамжуулан Тэр тан дээр Өөрийн адислалуудыг цутгах болно. Тэрээр танаас энэ бэлэг болон та асууж, эрэлхийлж, тогшиж болохын тулд зохистой хэвээр байхыг хүсдэг (С ба Г 4:7; Матай 7:7–8-ыг үз).

Бид Мормоны Номын бошиглогчдын бошиглосон үе болох—хүмүүс “өөр хоорондоо зөрчилдөх; өөрийн суралцсанаас заах, мөн зааврыг өгөх Ариун Сүнсийг үгүйсгэх” тэр үед амьдарч байна (2 Нифай 28:4; мөн 3 Нифай 29:6; Мормон 9:7–8-ыг үз). Гэвч олон хүмүүс бас сүнсний зүйлүүдийг хүсдэг. Ариун Сүнс ярих хүчийг танд өгдөг (1 Нифай 10:22-ыг үз) учраас та хувийн илчлэлтийг хүлээн авч сурснаар хүч болон эрх мэдлээр заах болно (Алма 17:3-ыг үз).

Баптисм хүртэж, гишүүнээр батлуулахад нь хүмүүст туслахдаа та Ариун Сүнсээр дамжуулан хувийн илчлэлтийг эрэлхийлж, хүлээн авах хэрэгтэй. Таныг өдрөөс өдөрт удирдах хувийн илчлэлийг та хүлээн авах болно гэсэн итгэлтэй бай. Ажлын тань тал бүрт Ариун Сүнс танд туслах болно.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Моронайн төгсгөлийн гэрчлэлд тэрээр “ухуулах замаар хэдэн үг ” бичжээ (Моронай 10:2). Моронай 10-ыг уншиж, Мороной Мормоны Номны уншигчид юуг хий хэмээн ухуулсныг өөрийнхөө үгээр бич. (Ухуулах гэдэг нь ямар нэг юм хийхийг хэн нэгэнд хүчтэйгээр урамшуулан дэмжих буюу шавдуулах гэсэн утгатай.)

Христийн Гэрэл

Хүн баптисм хүртэж, гишүүнээр батлуулахаасаа өмнө сүнслэг удирдамж хүлээн авч чадна. Энэхүү сүнслэг нөлөө нь “тэрбээр сайныг хилэнцэтээс ялган мэдэж болохын тулд хүн бүрт өгөгддөг” Христийн Гэрлээр эхэлдэг (Моронай 7:16; түүнчлэн бас шүлэг 14–19-ийг үз).

Христийн Гэрэл бол “Христээр дамжин Бурханаас ирж, мөн бүх зүйлд амьдрал болон гэрлийг өгдөг тэнгэрлэг эрч, хүч буюу нөлөө юм. Энэ бол тэнгэр болон дэлхий дээрх бүх зүйл удирдагддаг хууль мөн. Энэ нь түүнчлэн хүмүүст сайн мэдээний үнэнийг ойлгоход мөн аврал уруу хөтөлдөг сайн мэдээний тэрхүү зам дээр гарахад нь тусалдаг.

“Христийн гэрлийг Ариун Сүнстэй хольж хутгах ёсгүй. Христийн гэрэл бол хүн биш. Энэ бол Бурханаас ирж, хүнийг Ариун Сүнсийг хүлээн авахад нь бэлтгэдэг нөлөө юм. Энэ нь бүх хүмүүсийн амьдрал дахь сайн сайхны төлөөх нөлөөлөл юм.

“Христийн гэрлийн нэг илрэл бол зөв ба буруугийн дундаас сонголт хийхэд хүнд тусалдаг ухамсар юм. Сайн мэдээний тухай хүмүүс илүү ихийг сурах тусам тэдний оюун ухаан илүү мэдрэмтгий болдог. Христийн гэрлийг анхаардаг хүмүүс Есүс Христийн сайн мэдээ рүү хөтлөгддөг” (The Guide to the Scriptures, “Light, Light of Christ; мөн түүнчлэн С ба Г 84:46–47-г үз).

“Христийн Гэрлээр дамжуулан Ариун Сүнс ажилладгийг мэдэх нь . . . номлогчийн хувьд . . . чухал юм. Сайн мэдээний үнэнүүдийн багш нь насанд хүрсэн хүн буюу хүүхдэд ямар нэг гадаадын буюу шинэ зүйлийг суулгадаггүй. Харин, номлогч буюу багш нь тэнд аль хэдийн байгаа Христийн Сүнстэй холбоо тогтоодог. Сайн мэдээ тэдэнд танил юм шиг сонсогдох болно” гэж Ерөнхийлөгч Байд К.Пакер хэлжээ (“The Light of Christ,” номлолын шинэ ерөнхийлөгчдөд зориулсан семинар дээр хэлсэн үг, 2004 оны 6-р сарын 22, 2).

Ариун Сүнс

Ариун Сүнсний хүн болох нь. Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтний гурав дахь гишүүн. Тэр бол сүнсэн хүн бөгөөд яс, махнаас бүрдсэн биегүй юм (С ба Г 130:22-ыг үз). Тэр бол Аврагчийн бүх дагалдагчдад бүх зүйлийг зааж, тэдэнд Түүний заасан бүх зүйлийг сануулах болно гэж Түүний тэдэнд амласан Тайтгаруулагч юм (Иохан 14:26-г үз).

Ариун Сүнсний хүч. Баптисмын өмнө чин сэтгэлээсээ хандаж байгаа сонирхогчдод ирдэг гэрчлэл нь Ариун Сүнсний хүчээр дамжин ирдэг. “Ариун Сүнсний хүч нь хүнд баптисмын өмнө ирж болох бөгөөд сайн мэдээ үнэн гэдгийг гэрчилдэг” (The Guide to the Scriptures, “Holy Ghost”). Энэ нь хүнд Есүс Христ, түүний ажил болон дэлхий дээрх түүний үйлчлэгчдийн ажлын тухай гэрчлэлийг өгдөг. Ариун Сүнс үнэний тухай гэрчилдэг. Бүх хүмүүс Ариун Сүнсний хүчээр дамжуулан Мормоны Номны үнэнийг мэдэж чадна. “Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” (Моронай 10:5).

Ариун Сүнсний бэлэг. Гэрчлэл хүлээн авсан сонирхогчид Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийн амлалтыг арай хүлээж аваагүй байдаг. “Ариун Сүнс, Ариун Сүнсний бэлгийн хооронд ялгаа бий. Корнел баптисм хүртэхээсээ өмнө Ариун Сүнснийг хүлээн авсан юм. Энэ нь Сайн мэдээний үнэний тухай түүнд ирсэн Бурханы үнэмшүүлэгч хүч байсан боловч тэрээр баптисм хүртсэнийхээ дарааг хүртэл Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч чадаагүй юм. Энэхүү тэмдэг буюу ёслолыг тэр өөр дээрээ аваагүй байсан бол Бурханы тухай үнэнийг түүнд үнэмшүүлсэн Ариун Сүнс түүнийг орхиж болох байсан” гэж Иосеф Смит хэлжээ (History of the Church, 4:555).

“... хүн зохистой байхдаа Ариун Сүнсний байнгын нөхөрлөлтэй байх эрх нь Есүс Христийн үнэн Сүм дэх эрх мэдэл бүхий баптисмын дараа зөвхөн Мелкизедек Санваартнаар гар тавиулан хүлээн авч болдог бэлэг юм” (The Guide to the Scriptures, “Holy Ghost”).

Та Сүмийн гишүүний хувьд санваарын эрх мэдлээр Ариун Сүнсний бэлэг хүлээн авсан. Хэрэв та үүний хувьд зохистой хэвээр байвал энэхүү бэлэг нь Ариун Сүнсстэй байнга нөхөрлөх боломжийг танд олгодог. Сүнсний удирдамжийн төлөө залбирч, хүлээж авдаг өдөөлтүүдийг шийдэмгийгээр дага.

Амлалтын Ариун Сүнс. Ариун Сүнснийг бас Амлалтын Ариун Сүнс гэдэг (С ба Г 88:3-ыг үз). Амлалтын Ариун Сүнсээр лацдагдах гэдэг нь зөв шударга үйлс, ёслолууд болон гэрээнүүд нь Бурханы хувьд хүлээн авч болохоор юм гэдгийг Ариун Сүнс баталдаг гэсэн үг юм. Аврагч ёслолууд зохих ёсоор гүйцэтгэгдсэнийг мөн тэдгээртэй холбоотой гэрээнүүд сахигдаж байгааг Амлалтын Ариун Сүнс

*“Хүн наманчилж,
зохистой болсны дараа
Ариун Сүнсний бэлэг
ирдэг. . . . Ариун Сүнс
үнэний тухай гэрчилж,
Бурхан Эцэг болон Хүү
Есүс Христийн бодит
байдлын тухай, дэлхийн
хүч буюу эрх мэдэл
түүнийг энэ мэдлэгээс
тусгаарлаж
чадахааргүйгээр тийм
гүн сэтгэгдлийг бодгальд
төрүүлдэг.”*

—ЕРӨНХИЙЛӨГЧ ЖЕЙМС И. ФАУСТ
“АРИУН СҮНСНИЙ БЭЛЭГ—БАТ НАЙДВАРТАЙ ЛУУЖИН,
ENSGN, 1996 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР, 4

Эцэгт гэрчилдэг. Амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан хүмүүс Эцэгт байгаа бүхнийг хүлээн авдаг (С ба Г 76: 51–60; Ефес 1:13–14-ийг үз). Бүх гэрээнүүд болон гүйцэтгэлүүд нь энэ амьдралын дараа хүчинтэй байхын тулд Амлалтын Ариун Сүнсээр лацдагдах ёстой (С ба Г 132: 7, 18–19, 26-г үз). Гэрээнүүдээ зөрчих нь лацдалтыг байхгүй болгож болно.

Сүнсний бэлгүүд. Сүнсний бэлгүүд бол зохистой хувь хүмүүст тэдний ашиг тусын тулд, мөн тэд бусдыг адислахад ашиглаж болохын тулд Их Эзэнээс өгөгддөг сүнсний тусгай адислалууд юм. Жишээ нь, шинэ хэл сурах ёстой номлогч нар уг хэлийг сурахад өөрсдөд нь тэнгэрлэг тусламж үзүүлэх хэлний бэлэг хүлээн авч болно. Сүнсний нилээд хэдэн бэлгийг Моронай 10:8–10; Сургаал ба Гэрээ 46:11–13; мөн 1 Коринт 12:1–12-т дүрсэлсэн байдаг. Эдгээр нь Сүнсний олон бэлгийн зөвхөн зарим жишээ нь юм. Таны итгэлтэй байдал, таны хэрэгцээ, түүнчлэн таны үйлчилдэг хүмүүсийн хэрэгцээнээс хамааран Их Эзэн таныг өөр арга замуудаар адисалж болно. Та сүнсний бэлгүүдийг хүсч, тэдгээрийг чин сэтгэлээсээ эрэлхийлэх ёстой (С ба Г 46:8; 1 Коринт 12:31; 14:1, 12-ыг үз). Эдгээр бэлгүүд нь Бурханы хүслийн дагуу залбирлаар, итгэлээр, ажил үйлсээр, ирдэг (С ба Г 63:9–12; 84:64–73-ыг үз).

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Доорх ишлэлүүдийг унш:

- The Guide to the Scriptures, “Holy Ghost,” “Light, Light of Christ,” “Spirit.”
- *Our Search for Happiness*, 84–86, 91–92.
- *True to the Faith*, “Holy Ghost,” 81–84, болон “Spiritual Gifts,” 165–67.

Ариун Сүнсний мөн чанар, үүргийн тухай тодорхойлолт бич.

Үйлс 4:23–33-ыг унш.

- Петр, Иохан нар сүнсний бэлгүүдийг хэрхэн эрэлхийлж байсан бэ?
- Тэдний залбирлуудад Их Эзэн хэрхэн хариулсан бэ?
- Та өөрийнхөө ажлын талаар энэ явдлаас юу сурч болох вэ?

Хөрвүүлэлт дэх Сүнсний Хүч

Хөрвүүлэлтэнд Ариун Сүнсний хүч гол төв нь юм. Хөрвүүлгийн сургаал болон мөн хөрвүүлгийн туршлагыг ойлгохыг хичээ. Хөрвүүлэг дэх Сүнсний гол төв үүргийг Ахлагч Боид К.Пакер тайлбарлахдаа:

“Хөрвүүлэг Ариун Сүнсний хүчээр дамжин болдог. Номлогчийн ажилд амжилттай байхад эдгээр гурван зүйлс зайлшгүй тохиох ёстой:


“Хөрвүүлгийг хүлээн авахын тулд сонирхогч юу мэдрэх ёстойг бид ойлгох ёстой.

“Ариун Сүнсний хөрвүүлэгч хүчээр заахын тулд номлогч ямар сэтгэгдэлтэй байх ёстойг бид ойлгох ёстой.

“Тэгээд дараа нь хөрвүүлгийн туршлагад оролцоход амжилт гаргахын тулд гишүүн ямар сэтгэгдэлтэй байх ёстойг бид ойлгох ёстой” гэжээ (номлолын ерөнхийлөгчдийн чуулган, 1985 оны 4-р сарын 3).

Та сонирхогчид, номлогч нар болон гишүүдийг Сүнсний гэрчлэлийг хүлээн авах үедээ ямар сэтгэгдэлтэй байгааг илүү сайн ойлгохын хэрээр өөрийнхөө үүргийг илүү сайн ойлгох болно, энэ нь:

- Судруудыг судалж, сургаалыг заах үедээ сүнслэг байдлаараа хүчтэй болсон бай, оюун ухаанаа гэгээрүүл.
- Заах үед тань Ариун Сүнс гэрчилж байх тийм уур амьсгалыг бүрдүүл. Та үүнийг сэргээлтийн захиасыг зааж, гэрчилснээр хийдэг. Сүнсээр удирдуулж заа, зааж байгаа зүйл тань үнэн гэдгийг Ариун Сүнсний хүчээр мэддэгээ гэрчил.
- Захиасыг хүн бүрийн хэрэгцээнд тохируулахдаа Сүнсний удирдамжийг дага.
- Хүмүүсийг ямар нэгэн зүйл хийхийг урь. Тэднийг наманчилж, зарлигуудыг дуулгавартай даган гэрээнүүдийг хийж, тэдгээрийг сахихын хэрээр тэдний итгэл өсөх болно.



Сүнсний хүчний тухай Ахлагч Рассел М.Баллард ярихдаа: “Үнэн хөрвүүлэг нь Сүнсний хүчээр дамжин ирдэг. Сүнс зүрх сэтгэлд хүрэхэд, зүрх сэтгэл өөрчлөгддөг. Хувь хүмүүс . . . Сүнснийг өөрсөдтэй нь хамт ажиллаж байгааг мэдрээд, эсвэл Их Эзэний хайр болон нигүүлслийн нотолгоог тэд амьдралдаа үзсэнээрээ тэд гэгээрч, сүнслэг байдлын хувьд хүчирхэгжиж, Түүнд итгэх итгэл нь өсдөг. Эдгээр тохиолдлууд нь хүн үгсийг турших хүсэлтэй байхад аяндаа Сүнсстэйгээр дагалддаг байна. Энэ бол бидний сайн мэдээг *мэдэрдэг* байдал юм. (“Now Is the Time,” *Ensign*, 2000 оны Арваннэгдүгээр сар, 75).

Ариун Сүнс эдгээр өөрчлөлтүүдийг авчрахаар хүмүүсийн зүрх сэтгэлд ажилладаг. Хүмүүс амлалтуудыг биелүүлэхийг сонгосноороо Ариун Сүнсний хүчийг илүү хүчтэйгээр мэдэрч, Христийг дуулгавартай дагахын тулд итгэлээ хөгжүүлэх болно. Тийнхүү, та өөрийнхөө хамт ажилладаг хүмүүсийг наманчлахад болон амлалтуудыг хийж, биелүүлэхэд урьснаар итгэлдээ өсөхөд нь туслах ёстой.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

- Дараах хэсгүүдээс нэг буюу хоёрыг уншаад хөрвүүлэгдэхийн тулд сонирхогч юу мэдэрсэн байх ёстойг тунгаан бод. Өөрийн мэдрэмжүүд болон сэтгэгдлүүдийг судлах тэмдэглэлдээ тэмдэглэ. Өөрийнхөө санаануудыг бусад номлогч нар болон гишүүдтэй ярилц.

2 Нифай 4:16–35; Инос 1; Мозая 4–5; 18:7–14; 27–28; Алма 5; 17–22; 32; 36; 38

- Дараах хэсгүүдээс нэг буюу хоёрыг унш, тэгээд хөрвүүлэх хүчээр заахын тулд та номлогчийн хувьд мөн гишүүний хувьд юу мэдэрсэн байх ёстойг тунгаан бод. Өөрийн мэдрэмжүүд болон сэтгэгдлүүдийг судлах тэмдэглэлдээ тэмдэглэ. Өөрийнхөө санаануудыг бусад номлогч нар болон гишүүдтэй ярилц.

1 Нифай 8:11–12; Мозая 28:1–4; Алма 26; 29; 31:26–38; 32; Моронай 7:43–48; С ба Г 4; 18:10–16; 50:21–22

Судар Судлах

Таны ажлын Сүнсний хүчний тухай эдгээр судрууд юу заадаг вэ?

2 Нифай 33:1–2
С ба Г 42:11–17С ба Г 50:13–22
Үйлс 2:37–381 Коринт 2:11–14
Guide to the Scriptures, “Conversion,
Convert”

Ажилдаа Сүнсний хүчийг байлгахын тулд та юу хийж болох вэ?

Алма 32:27–28

С ба Г 42:14

Иохан 7:17

Өөрийн мэддэг, мөн итгэдэг зүйлийг заах нь яагаад чухал вэ?

Алма 5:43–47

С ба Г 52:9

С ба Г 80:4

Итгэлтэйгээр Залбир

Зөвхөн Сүнсний хүчээр та Их Эзэний арга замаар зааж чадна, та мөн итгэлийн залбирлаар дамжуулан Сүнсийг хүлээн авдаг. “Мөн уг Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно; хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй” (С ба Г 42:14) гэж Их Эзэн хэлжээ. Таныг заалтандаа тусламж хүсч залбирахад Ариун Сүнсний хүч таны заадаг зүйлүүдийг “хүмүүний үрсийн зүрх сэтгэлд” хүргэх болно (2 Нифай 33:1).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли энэ зарчмыг өөрийн номлолд тохиолдсон явдлаас өгүүлэн дүрслэхдээ:

“Миний номлолд үйлчилж байсан хоёр залуу эрэгтэйчүүдийг би үргэлж санадаг. Нэг нь гаргуун од байлаа. Тэр боловсролтой хүн байв. Тэр гэрэл гэгээтэй байлаа. Тэр түргэн шуурхай байв. Тэр бага зэрэг их зантай байлаа. Нөгөөх нь замын тэмдэг будагч байлаа. Тэр замын тэмдгийн дэлгүүрээс ирсэн, маш бага боловсролтой байсан боловч, тэр өөрийнхөө хангалтгүй байдлыг мэддэг байсан бөгөөд тэр Их Эзэнд найддаг байв. Тэр залбирч байхдаа Их Эзэнтэй ярьж байгаагаа мэддэг байв. Бусдын хувьд шаардлагатай зүйлийг ямар ч зорилгогүйгээр хийх, зүгээр л нэг цээжилсэн зүйл тэр залуу хувьд гайхамшгуудыг үйлдсэн харилцан яриа байсан юм. Нэг хүнд байсан тэрхүү хүч нөгөөд нь байхгүй нь илт байлаа. Их Эзэнийг дууд. Тэр урилга өгсөн юм, тэгэхлээр Тэр хариулах болно” (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 469).

Чин сэтгэлээсээ, үнэн санаагаар, “зүрх сэтгэлийнхээ бүхий л эрч хүчээр” (Моронай 7:48) залбирахыг хичээ. Үр ашигтай залбирал агуу хүч чармайлт шаарддаг (Моронай 10:3–4; С ба Г 8:10; 9:7-г үз). Өөрийн зан чанар мөн өөрийн хэрэглэж байгаа үгстээ санаа бодлоо буурь суурьтайгаар хандуул. Залбирахдаа дараах зүйлийг анхаар:

- Тэнгэрлэг Эцэгийг та хайрлаж, хүндэтгэдгээ харуулах залбирлын хэлийг ашигла. Та ямар ч хэлээр ярилаа гэсэн тохирох, хүндэтгэлийн хэлийг ашигла. Жишээ нь, англи хэлэнд Та, Таны, Таных гэдэг үгний судрын дуудлага нь *Thee, Thou, Thy, and Thine* юм.



- Адислалуудынхаа төлөө үргэлж талархал илэрхийл. Талархалтай байх ухамсрын хүч чармайлт Их Эзэн таны амьдралд хичнээн нигүүлсэнгүй байдгийг мэдэхэд тань танд туслах болно.
- Ариун Сүнсний удирдамж, тусламжийн төлөө тусгайлан залбир. Сүнсний өдөөлтүүдэд мэдрэмтгий байж, ойлгосноор та энэ адислалыг үнэлдгээ харуул. Тэгээд эдгээр өдөөлтүүдийг зоригтойгоор дага.
- Хайр, энэрлээр залбир. Хүмүүсийн төлөө нэрээр нь залбир. Тэдний хэрэгцээг ойлгож, хангахад танд туслах сүнслэг урмыг хүс. Холбоотой байдаг хүмүүс, сонирхогчид, шинэ хөрвөгчид түүнчлэн идэвх султай гишүүдэд халамж тавихын төлөө залбир. Өөрийнхөө бүс дэх гишүүд, санваартны болон хавсралт байгууллагуудын удирдагчдын төлөө залбир. Гэр орондоо байгаа гэр бүлийнхээ төлөө залбир. Хамтрагчийнхаа төлөө, бусад номлогч нарын төлөө түүнчлэн номлолынхоо ерөнхийлөгчийн төлөө залбир. Бусдад хэрхэн тусалж болохыг мэдэхийн төлөө залбир, тэгээд тэдний төлөө золиослол хийх хүсэлтэй бай.
- Хаашаа явах болон юу хийх нь танд үзүүлэгдэхийн төлөө залбир. Сэргээлтийн захиасыг хүлээн авахаар бэлтгэгдэж байгаа хүмүүс рүү та удирдагдахын төлөө залбир. Тэднийг та танихын төлөө залбир.
- Танд юу хэрэгтэй байгааг Тэнгэрлэг Эцэг тань танаас илүү мэддэг гэдгийг мэд. Юуны төлөө залбирахыг мэдэхийн тулд Ариун Сүнсэнд найд (3 Нифай 19:24; С ба Г 46:28, 30).
- Шөнийн залбирлууддаа, өдрийнхөө үйл ажиллагаануудын тайланг Их Эзэнд тавьж бай. Тэгээд маргаашийнхаа төлөвлөгөөг Түүнтэй хэлэлцэн хянаж бай. Сүнсний өдөөлтүүдийг сонс.
- Уруу таталтыг даван туулахын тулд залбир. Уруу таталтад автагдах нь Сүнсэнд саад болдог.
- Залбирч, тохиромжтой үедээ тусгай зорилгоор мацаг барьж бай.
- Судруудын талаар залбирч, тунгаан бодож бай. Судрууд илчлэлтийг оруулах цонхыг нээж өгдөг.

“Өглөө бүр номлогч нар өвдөг сөгдөн, хэлийг нь чөлөөтэй болгон өгч, өөрсдийнх нь заах хүмүүсийг адислахын тулд тэднээр дамжуулан ярихыг Их Эзэнээс гуйдаг. Хэрэв тэд ингэх юм бол, тэдний амьдралд шинэ гэрэл ирэх болно. Ажлын төлөө агуу урам зориг бий болно. Тэд бол Их Эзэний тухай Түүний нэрийн өмнөөс ярьж байгаа үйлчлэгчид гэдгээ нэн бодит мэдрэмжээр мэдэх болно. Тэд өөрсдийнхөө заадаг хүмүүсээс янз бүрийн хариуг олох болно. Тэд үүнийг Сүнсээр хийх юм бол, сонирхогчид нь мөнхүү тэр Сүнсний нөлөөн дор хариулах болно.”

—ЕРӨНХИЙПӨГЧ ГОРДОН Б.ХИНКЛИ

“MISSIONARY SERVICE,” ДЭЛХИЙ ДАХИНЫ УДИРДЛАГЫН СУРГАЛТЫН АНХНЫ
ХУРАЛ, 2003 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН 11, 20

- Таны залбирлуудад Бурхан хариулах болно гэдэгт итгэ. Бурханы бодол санаа таны бодол санаа биш гэдгийг (Исаиа 55:8–9-ийг үз) мэдэж, таны залбирлуудад Бурхан Өөрийнхөө арга замаар, Өөрийнхөө цаг хугацаанд хариулна гэдэгт итгэ.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Чин сэтгэлийн залбирлын талаарх дараах үгсийг тунгаан бод:

“Бидний ихэнх залбирлуудад байдаг тусгүй зүйл бол бид утсаа авч, хүнсний зүйл захиалаад утсаа буцааж тавьж байгаа юм шиг тийм залбирлууд хэлдэг явдал мөн. Бид залбирч байгаа зүйлийнхээ талаар бясалган, сайтар эргэцүүлэн бодоод дараа нь, нэг хүн нөгөөтэйгөө ярьж байгаа юм шигээр Их Эзэнд хандан ярих хэрэгтэй. (Gordon B. Hinckley, *Teachings of Gordon B. Hinckley*, 469).

“Хэрэв залбирал нь зөвхөн хямралт цаг үеийн гэнэтийн дуудлага байх юм бол энэ нь амин хувиа хичээсэн зүйл байдаг бөгөөд бид Бурханыг зөвхөн онцгой шаардлага гарсан үед бидэнд туслах ёстой засварчин юм уу, үйлчилгээний товчоо шигээр үзэхэд хүрнэ. Бусад бүх тусламж хэрэггүй болж, бидэнд тусламж яах аргагүй хэрэгтэй болсон зөвхөн тэр үед биш— харин өдөр шөнийн бүх цагт Бүхнээс Дээдийг үргэлж санаж байх ёстой.” (Howard W. Hunter, *The Teachings of Howard W. Hunter*, хянагч Clyde J. Williams [1997], 39).

Дараах хэмжүүрийг ашиглан, өөрийнхөө залбирлуудад хувийн үнэлгээ өг. Энэ хэмжүүрийн хаана нь та өөрийгөө тавих вэ? Энэ хэмжүүрийн хаана нь та баймаар байна? Та хэрхэн өөрчлөгдөх гэж байна? гэх мэт асуултуудын хариуг судлах тэмдэглэлдээ бич.

	Муу	Дунд зэрэг	Сайн
Христэд итгэх итгэл сул	←	→	Христэд итгэх итгэл хүчтэй
Талархалтай бус	←	→	Дүүрэн талархалтай
Ажилдаа анхаарал төвлөрүүлэхэд санаа тавьдаггүй	←	→	Ажилдаа анхаарал төвлөрүүлэхэд санаа тавьдаг
Залбирлууд нь үйлдлүүдэд холбоогүй	←	→	Үйлдлүүд нь залбирлуудыг хэрэгжүүлдэг
Нэг хэвийн буюу давтагдсан	←	→	Өнөөдрийн хэрэгцээнд төвлөрсөн
Нэг хэвийн бодол санаатай	←	→	Гэгээрүүлсэн, шинэ сэргэг
Цэвэр бус санаа бодолд анхаарал төвлөрүүлсэн	←	→	Цэвэр санаа бодолд анхаарал төвлөрүүлсэн
Өөр дээрээ төвлөрүүлсэн	←	→	Бусад хүмүүст санаа тавьсан
Ерөнхий, тодорхой зүйлд хандсан биш	←	→	Тодорхой зүйлд хандсан, ерөнхий биш
Сүнс байхгүй	←	→	Сүнс залбирлыг удирддаг
Хариултуудыг таньж мэддэггүй	←	→	Бурхан залбирлуудад хариулна гэдэгт итгэлтэй байдаг

Судар Судлах

Та яагаад Сүнсний төлөө залбирах ёстой вэ?

2 Нифай 32:8–9

С ба Г 42:14

С ба Г 50:13–22

Та юуны төлөө залбирах ёстой вэ?

Алма 6:6

Алма 37:36–37

С ба Г 50:29–30

Алма 13:28

3 Нифай 18:20

Guide to the Scriptures, “Prayer”

Алма 34:17–27

3 Нифай 19:9

Сүнсийн Өдөөлтүүдийг Таньж Сур

Сүнс таныг удирдаж, чиглүүлэхэд үргэлж бэлэн байдаг. Гэсэн хэдий ч Сүнс таны мэдрэмжүүдээр мөн түүнчлэн оюун ухаанаар тань дамжин анир чимээгүй ярьдаг. Танд болон хамт ажилладаг хүмүүст тань тохиолддог нэг сүрхий бэрхшээл бол Ариун Сүнсийн тэрхүү анир чимээгүй, нарийн өдөөлтүүдийг таних явдал мөн.

Ахлагч Бойд К.Пакер заахдаа: “Сүнсийн дуу хоолой нь ‘чанга’ ч биш, ‘ахир’ ч биш хэмээн сударт дүрслэгдсэн байдаг. Энэ бол аянгын дуу хоолой ч биш, бас . . . их үймээн шуугианы дуу хоолой ч биш. Харин шивнэх мэт, төгс зөөлөн байдлын ‘намуухан дуу хоолой бөгөөд энэ нь бүр яг тэрхүү бодгаль уруу цоо хатгаж, [зүрх сэтгэлийг] шатах мэт болгож чадна’ (3 Нифай 11:3; Хиламан 5:30; С ба Г 85:6–7-г үз.) Елиа Их Эзэний дуу хоолойг салхин дотор ч биш, газар хөдлөлтөд ч биш, гал дотор ч биш, сонссон нь ‘намуун хүнгэнэх дуу хоолой’ байсныг сана. (Хаадын дээд 19:12.)

“Сүнс бидний анхаарлыг хашгирах, эсвэл биднийг хүч түрэмгий гараар угзчин бидний анхаарлыг татдаггүй. Харин үүнээс илүүгээр тэр шивнэдэг. Энэ нь, хэрэв бид урьдчилан өөрсдийгөө бэлтгэхгүй бол, үүнийг огт мэдрэхгүй өнгөрч болохоор тийм намуухан энхрий сонсогддог. (Мэргэн Ухааны Үг бидэнд илчлэгдсэнд гайхах юун, харин архичин юм уу донтогч тийм дуу хоолойг хэрхэн мэдрэх билээ?)

“Заримдаа энэ нь бидний хувьд анхаарал тавих нь хангалттай байх тийм хэмжээгээр биднийг шавдуулдаг. Гэвч ихэнх тохиолдолд бид Сүнснээс гардаг тэрхүү намуун зөөлөн дуу хоолойг анхаардаггүй бөгөөд эрт дээр үед Самуел [Эзэн], айлдаж хайрла, учир нь боол тань сонсож байна’ гэсэнтэй адил бид эрэлхийлэн, сонсож, мөн өөрсдийн маяг болон илэрхийллээр хандтал тэр биднээс холдоод, хүлээж байдаг билээ (1 Сам. 3:10.)” (“The Candle of the Lord,” *Ensign*, 1983 оны Нэгдүгээр сар, 53).

Таны анхаарлын төлөө дэлхийн олон дуу хоолой өрсөлддөг, хэрэв та болгоомжгүй байх юм бол тэд сүнслэг сэтгэгдлүүдийг хялбархан живүүлж чадна.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

Дараах жагсаалтыг судал. Доорх жагсаалтад дүрсэлсэн мэдрэмжүүд, бодол санаанууд буюу сэтгэгдлүүдээс та нарт тохиолдож байсан үеийнхээ тухай бод. Та нар судалж, туршлага хуримтлуулсан үедээ энэ жагсаалтад бусад зүйлүүдийг нэм. Сүнсийг мэдэрч, танихад нь бусдад туслахын тулд эдгээр зарчмуудыг хэрхэн ашиглаж болох тухай бод.

С ба Г 6:23; 11:12–14; Ром 15:13; Галат 5:22–23	Хайр, баяр хөөр, тэвчээр, номхон дөлгөөн байдал, эелдэг зөөлөн байдал, итгэл болон найдварын мэдрэмж төрүүлдэг.
С ба Г 8:2–3	Оюун ухаанд санаануудыг, зүрх сэтгэлд мэдрэмжүүдийг өгдөг.
С ба Г 128:1	Оюун ухааныг эзэмдэж, мэдрэмжүүдэд нөлөөлдөг.
Иосеф Смит—Түүх 1:11–12	Хүчтэй нөлөөлөхөд нь судруудад тусалдаг.
С ба Г 9:8–9	Хэрэв ямар нэг зүйл зөв байвал заахад сайн мэдрэмжүүд төрүүлдэг.
Алма 32:28; С ба Г 6:14–15; 1 Коринт 2:9–11	Оюун ухааныг гэгээрүүлдэг.
Алма 19:6	Харанхуйг гэрлээр сольдог.
Мозая 5:2–5	Муугаас зайлсхийж, зарлигуудыг сахих хүслийг батжуулдаг.
Иохан 14:26	Үнэнийг зааж, үүнийг сануулдаг.

Тэмдэглэл

Иохан 14:27	Амар амгалан хийгээд тайтгарлын мэдрэмжүүдийг төрүүлдэг.
Иохан 16:13	Үнэн рүү удирдаж, ирэх зүйлүүдийг үзүүлдэг.
Моронай 10:5	Үнэнийг илчилдэг.
С ба Г 45:57	Удирдаж, хууран мэхлэлтээс хамгаалдаг.
2 Нифай 31:18; С ба Г 20:27; Иохан 16:14	Бурхан Эцэг, Есүс Христ хоёрыг алдаршуулж, тэдний тухай гэрчилдэг.
С ба Г 42:16; 84:85; 100:5–8; Лук:12:11–12	Даруухан багш нарын үгсийг удирддаг.
Иохан 16:8	Нүглийг танин мэдэж, залруулдаг.
Моронай 10:8–17; С ба Г 46:8–26; 1 Коринт 12	Сүнсний бэлгүүдийг өгдөг.
Алма 10:17; 12:3; 18:16, 20, 32, 35; С ба Г 63:41	Бусдын санаа бодлыг хүлээн авах буюу ялган танихад тусалдаг.
С ба Г 46:30; 50:29–30	Юуны төлөө залбирахыг хэлдэг.
2 Нифай 32:1–5; С ба Г 28:15	Юу хийхийг хэлдэг.
1 Нифай 10:22; Алма 18:35	Зөв шударга хүмүүст хүч болон эрх мэдлээр ярихад нь тусалдаг.
С ба Г 21:9; 100:8; Иохан 15:26	Үнэний тухай гэрчилдэг.
2 Нифай 31:17; Алма 13:12; 3 Нифай 27:20	Цэвэршүүлж, нүглүүдийн ангижралыг авчирдаг.
1 Нифай 2:16–17; 2 Нифай 33:1; Алма 24:8	Сонсогчийн зүрх сэтгэлд үнэнийг хүргэдэг.
1 Нифай 1:1–3; Египетээс Гарсан нь 31:3–5	Ур чадвар, чадваруудыг өргөжүүлдэг.
1 Нифай 7:15; 2 Нифай 28:1; 32:7; Алма 14:11; Мормон 3:16; Ифэр 12:2	Урагш түлхэх (урагш хүчлэх) буюу түдгэлзүүлдэг (барьж байх).
С ба Г 50:13–22	Багш, суралцагчид аль алиныг нь сэнхрүүлдэг.
С ба Г 88:3; Иохан 14:26	Тайтгарлыг өгдөг.

“Сүнсний өдөөлтүүдийг бид хэрхэн таньж мэддэг вэ?” гэсэн асуултад Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хариулахдаа Моронай 7:13, 16–17-г уншаад: “Эцсийн эцэст энэ бол сорилт юм. Энэ нь хүнийг сайныг үйлдэхэд, өсч өндийхөд, өндөрт зогсоход, зөв зүйлийг хийхэд, найрсаг байхад, өгөөмөр өглөгч байхад ятгадаг биз дээ? Тэгвэл энэ нь Бурханы Сүнс мөн. . . .

“Хэрэв энэ нь сайныг үйлдэхэд урьдаг бол, энэ нь Бурханаас байна. Хэрэв энэ нь мууг үйлдэхэд урьдаг бол, энэ нь чөтгөрөөс байна. . . . Хэрэв та зөв зүйлийг хийж байвал, мөн хэрэв та зөв замаар амьдарч байгаа бол, Сүнс танд юу хэлж байгааг та зүрх сэтгэлдээ мэдэх болно.

“Тэгээрүүлдэг, төлөвшүүлдэг, нааштай болон зөвшөөрсөн, мөн дээш өргөсөн, түүнчлэн биднийг илүү дээр бодол санаа, илүү дээр үгс рүү, илүү дээр үйл хэрэг рүү хөтөлдөг Сүнсний үр жимсүүдээр та Сүнсний өдөөлтүүдийг танин мэдэж байгаа бол энэ нь Бурханы Сүнснээс байна” гэж хэлжээ (*Teachings of Gordon B. Hinckley*, 260–61).

Хувийн сүнслэг урам болон илчлэлтээр дамжуулан Бурхан таны залбирлуудад хариулдаг. Таныг сэргээгдсэн сайн мэдээг заахад, тэрчлэн таныг идэвх султай гишүүд болон шинэ хөрвөгчдийг хүчирхэгжүүлэхэд Ариун Сүнсээр дамжуулан Тэрээр хүч чармайлтад тань (заах хүмүүс олох) таныг удирдах болно. Таны зорилт бол зохистой амьдарч, эрч хүчтэй залбиран, Сүнсийг таньж сурч, удирдамжийг нь шийдэмгийгээр дагах явдал мөн.

Сүнсэнд Найдах нь

Их Эзэний үйлчлэгчийн хувьд та Түүний ажлыг Түүний арга замаар мөн Түүний хүчээр хийх ёстой. Зарим номлогч нар хэрхэн амжилт олохыг өөрсдөө мэднэ гэдэгт итгэлтэй байдаг. Заримд нь ийм итгэл дутдаг. Гэвч, таны итгэл найдвар өөртөө биш, Христэд байх ёстойг сана. Өөрийн авьяас чадвараас илүүгээр Сүнсэнд найд. Ажлын тань тал бүрээс Сүнс таныг удирдаж байхаар итгэл хүлээлгэ. Сүнс бол заах болон номлоход үндэс суурь нь байдгийг Бошиглогч Иосеф Смит заахдаа:

“Ариун Сүнсгүйгээр сайн мэдээг хэн ч номлож чадахгүй” (*History of the Church*, 2:477).

“Зарим цөөн хүмүүс илчлэлтийн болон бошиглолын Сүнсээр дуудагдаж, томилогддог, тэгээд Сүнс тэдэнд заасны дагуу номлож эхэлдэг хэдий ч, сулхан байдаг нь тэд Бурханы Сүнсний хүчээр хүчирхэгжих хэрэгтэй байгаа нь тэр” (*History of the Church*, 4:538).

Тэнгэрээс доош илгээгдсэн Ариун Сүнсээр тэд номлож болохын тулд [Иосеф Смит] Сайн Мэдээг номлох талаар Ахлагчдад заавар өгч эхлэн, Сүнсийг олж авах нь зайлшгүйг тэдэнд шавдуулдаг байв” гэжээ (*History of the Church*, 4:13).

Долоо хоног тутмын болон өдөр бүрийн төлөвлөх цагаараа та зарим үндсэн асуултуудыг өдөр бүр—тэр ч байтугай өдөр бүр олон удаа асуух хэрэгтэй болно (Асуултуудын жишээнүүд байгаа Судар Судлах хайрцгийг үз). Нөхцөл бүрт тохирох арга замаар эдгээр асуултуудад хариулах сүнслэг урмыг эрэлхийл. Хариултууд нь дараа нь өөрийн тань төлөвлөгөөнүүдэд ашиглагдах ёстой. Гэвч та мөн л Сүнсийг дагах хүсэлтэй байж, өмнө нь олж хараагүй боломжууд бий болсон үед төлөвлөгөөгөө өөрчлөх хэрэгтэй.

Дараах судруудыг судалж, өдөр бүр таны асуух ёстой эдгээр чухал асуултуудад тэд хэрхэн хариулахыг анхаар. Заах хүмүүс олох таны хүч чармайлт, төлөвлөх цаг, хувиараа болон хамтрагчтайгаа суралцахад тань эдгээр хэсгүүд ямар учир холбогдолтой болохыг анхаар. Мөн тэдгээр нь таныг хичээл заахад, хүмүүсийг даалгавар авахад урих, даалгавруудыг шалгах, шинэ гишүүд болон идэвх султай гишүүдийг хүчирхэгжүүлэх болон гишүүдтэй ажиллахад ямар учир холбогдолтой болохыг анхаар.

Судар Судлах

Би хаашаа явах ёстой вэ?

Хиламан 10:17 С ба Г 75:26–27
С ба Г 31:11 С ба Г 79:1–2

Би юу хийх ёстой вэ?

1 Нифай 4:6 С ба Г 28:15
2 Нифай 32:2–5 С ба Г 52:3–4

Би юу хэлэх ёстой вэ?

2 Нифай 33:1	С ба Г 33:8–10	Матай 10:19–20
Алма 5:43–46	С ба Г 50:13–22	Марк 13:11
Алма 11:22	С ба Г 68:1–4	1 Коринт 2:4–5, 12–13
Хиламан 5:18	С ба Г 75:3–11	Египетээс Гарсан нь 4:10–12
Хиламан 13:3–5	С ба Г 100:5–8	

Би зааж байгаа зүйлээ сонирхогчдынхоо хэрэгцээнд хэрхэн тохируулах вэ?

Алма 12:7

3 Нифай 17:2–3

С ба Г 84:85

Алма 41:1

С ба Г 71:1

Би ямар судруудыг ашиглах ёстой вэ, мөн тэдгээрийг хэрхэн ашиглах ёстой вэ?

Мозая 18:19–20

С ба Г 32:4

С ба Г 71:1

Мозая 27:35

С ба Г 42:11–17

С ба Г 80:4

С ба Г 18:32–36

С ба Г 68:1–4

Пук 24:13–32

Анхааруулах Үг

Та Сүнслэг урмын төлөө залбирахдаа бас өөрийнхөө мэдрэмжүүдийг батлах ёстой. Жишээ нь, өөрийнхөө шийдвэрүүдийг судрууд болон амьд бошиглогчдын заадаг зүйлүүдтэй харьцуул. Тэдгээр мэдрэмжүүд тань таны ажил үүрэгтэй тохирч байгаа нь тод байхад анхаар; жишээ нь, орон нутгийн бишоп дуудлагаа хэрхэн гүйцэтгэх ёстойг хэлснээр та илчлэлт хүлээн авахгүй. Өөрийн шийдвэрүүд болон дүгнэлтүүдийг тохиромжтой үед хамтрагчтайгаа, дүүргийн удирдагчтай эсвэл номлолын ерөнхийлөгчтэйгөө ярилц.

“Анхааруулах үг хэлэхийг надад зөвшөөрнө үү. . . . Хэрэв бид анхааралгүй байх юм бол . . . , бид зохисгүй хийгээд мэхлэх арга хэрэгслээр Их Эзэний Сүнсний үнэн нөлөөг хиймлээр дуурайлгахыг хичээж эхлэхэд хүрч болно. Хүчтэй сэтгэл хөдлөл буюу дорхноо асаргад нулимс Сүнс байгаатай тэнцдэг гэдэг тухайд би санаа зовдог. Их Эзэний Сүнс хүчтэй сэтгэл хөдлөлийн мэдрэмжүүд, түүний дотор нулимс авчрах нь тодорхой хэдий ч, гадаад үзүүлэлт нь Сүнс өөрөө байгаатай хольж хутгах ёсгүй” гэсэн энэ зөвлөгөөг Ерөнхийлөгч Ховард В. Хантер өгчээ (*The Teachings of Howard W. Hunter*, 184). Их Эзэний Сүнс үргэлж гэгээрүүлдэг.

Илчлэлт болон сүнслэг тохиолдлууд нь ариун нандин юм. Тэдгээрийг нууц байлгаж, зөвхөн тохиромжтой нөхцөлд л ярилцдаг байх ёстой. Номлогчийн хувьд та амьдралынхаа эхэн үеийг бодвол сүнслэг тохиолдлуудыг илүү ихээр мэддэг болно. Эдгээр тохиолдлуудын талаар чөлөөтэй ярьж, уруу таталтыг эсэргүүц.

Ахлагч Бойд К. Пакер зөвлөхдөө:

“Сэтгэгдэл төрүүлэхүйц сүнслэг тохиолдлууд бидэнд тийм их олонтаа ирдэггүйг би мэдсэн юм. Ийм тохиолдлуудтай учирсан тохиолдолд тэдгээр нь ерөнхийдөө бидний хувийн гэгээрэл, заавар буюу залруулгын тулд байдаг. Хэрэв бид үүнийг хийх зохих эрх мэдлээр дуудагдахгүй бол, тэдгээр нь бусдад зөвлөх буюу тэднийг залруулах эрх мэдлийг бидэнд өгдөггүй.

“Хэрэв зохистой байвал, бид өөрсдийнхөө төлөө, эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ төлөө, түүнчлэн Сүмийн гишүүдийн дуудлагууддаа илчлэлтүүдийг хүлээн авах эрхээр хангагдах болно. Гэвч бусдын төлөөх илчлэлтийн эрх нь таны өөрийн тань ажил үүргээс гадуур байдаггүй.”

– ЕРӨНХИЙЛӨГЧ ЖЕЙМС И. ФАУСТ
“Communion with the Holy Spirit,” *Ensign*, 2002
оны Гуравдугаар сар, 4

“Ер бусийн сүнслэг тохиолдлуудын тухай үргэлж ярих нь ухаалаг бус гэдэгт би бас итгэхэд хүрсэн билээ. Тэдгээрийг санаа тавин хамгаалж, зөвхөн Сүнс өөрөө, бусдын адислалын тулд тэдгээрийг ашиглахыг танд өдөөсөн үед л хуваалцаж байх учиртай” гэжээ (*Ensign*, 1983 оны 1-р сар, 53).

Судар Судлах

Сүнсэнд найдах нь Сүнсийг үгүйсгэх буюу нуун дарахгүй байхыг Их Эзэн бидэнд нэн хүчтэйгээр сэрэмжлүүлдгээрээ их чухал юм. Судрын дараах хэсгүүдээс та нар юу сурдаг вэ?

Иаков 6:8–9

Мормон 9:7–9

С ба Г 11:25–26

3 Нифай 29:5–6

Моронай 10:7–8

1 Тесалоник 5:19–20

Үүнийг сана

- Залбирлууд тань хариулагдахаар тийм итгэлтэйгээр залбир.
- Сүнсний өдөөлтүүдийг ойлгож, таньж, дагаж сур.
- Таныг хаашаа явах, юу хийх, юу хэлэхийг үзүүлэх Сүнсэнд найдаж сур.
- Сүнсийг хэрхэн танин мэдэхийг бусдад заа.

Тэмдэглэл

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- Сүнслэг тохиолдлуудаа тэмдэглэлдээ тэмдэглэ. Жишээ нь: Би ямар нэг зүйлийг судруудыг судалснаараа илүү сайн ойлгов уу? Захиацыг хуваалцаж болох хүмүүстэй танилцах ер бусын боломжууд надад байсан уу? Надад яг хэрэгтэй байсан тэр үед хэлэх үгс надад өгөгдсөн үү? Танилцсан хүмүүсээ хайрлах хайрын хүчтэй мэдрэмжүүд надад байсан уу? Миний залбирлууд хэрхэн хариулагдсан бэ? гэх мэт асуултуудад хариул.
- Нэг хуудсыг хоёр багана болгон хуваа. Нэг баганыг “Их Эзэн Юу Хийсэн Бэ,” нөгөөг нь “Лихай Эсвэл Нифай Юу Хийсэн Бэ” гэж хаягла. Лиахонагийн түүх мөн хугарсан нумны тухай (1 Нифай 16:9–30) эсвэл Нифай хөлөг онгоц барьсан тухай түүхийг (1 Нифай 17:7–16; 18:1–6) унш. Уншихдаа холбогдох багануудад нь түүхээс үйл явдлуудыг жагсаа. Сүнслэг урмын мөн чанарын тухай уг түүх танд юу зааж байгааг анхаар.
- Тэмдэглэлээ шүүж, өөрөө Сүнсээр удирдагдсан буюу илчлэлт мэдэрсэн эсвэл Сүнсний өөр бэлэг хүлээн авсан тохиолдлуудыг ол. Хэзээ, хаана, мөн яагаад эдгээр тохиолдлууд тохиосон тухай бод. Ийм тохиолдолд өөрийгөө бэлтгэхийн тулд та тухайлан ямар нэг зүйл хийсэн үү? Уг тохиолдолд Их Эзэний гар хэрхэн үзүүлэгдсэн бэ? Та хэрхэн мэдэрсэн бэ? Иймэрхүү тохиолдлуудтай болохын тулд та юу хийж болох вэ? Эдгээр тохиолдлуудыг санах нь Сүнсийг танин мэдэж, дахин хүлээн авахад тань танд тусалж чадна.
- Библи дэх Үйлсийн номыг “Төлөөлөгчдөөр дамжсан Ариун Сүнсний Үйлсийн Ном” гэж нэрлэдэг. Үйлсийн номнууд дахь үйл явдлуудыг товчлон уншиж, яагаад энэ нэр тохиромжтой байгааг тайлбарла. Өөрийн тайлбарыг зөвтгөх нотолгоог ол.
- Дараах зөвлөгөөг судалж, тунгаан бод. Энэ нь таныг өдөр тутмын номлох үйл ажиллагаанд хэрхэн холбогдох вэ?

“Их Эзэний Сүнс тэднийг зөвөөр удирдаж, хадгалахын тулд даруу, итгэлтэй байхад анхаарахыг ах нарт хэл. Анхааралтай бай, анир чимээгүй, намуухан дуу хоолойноос бүү нүүр буруул; энэ нь тэдэнд юу хийхийг мөн хаашаа явахыг нь заах болно; энэ нь хаант улсын үр жимсийг өгөх болно. Ариун Сүнс тэдэнд ирэхэд зүрх сэтгэл нь үүнийг хүлээн авахад бэлэн байхын тулд зүрх сэтгэлээ итгэл үнэмшилд нээлттэй байлгахыг ах нарт хэл. Их Эзэний Сүнсний тэд бусад бүх сүнснээс ялгаж чадна—энэ нь тэдний бодгальд амар амгалан хийгээд баяр хөөрийг шивнэх болно; энэ нь хорсол, үзэн ядалт, зөрчил тэмцэл болон хилэнцийг тэдний зүрх сэтгэлээс зайлуулах болно, мөн тэдний бүхий л хүсэл нь сайныг үйлдэхэд байх болно” (*Juvenile Instructor-оос иш татав*, 1873 оны Долдугаар сарын 19, 114).

Иосеф Смитийн үхлээс хойш бараг гурван жилийн дараа Бошиглогч Иосеф Смит энэ зөвлөгөөг Бригам Янгад зүүдэнд нь өгчээ. Хэрэв та Бригам Янгийн оронд байсан бол яах байсан бэ?

- Алма 33:1–12; 34:17–29, 38-ыг судал. Алма ямар асуултуудад хариулсан бэ? (Алма 33:1–2-ыг нэгтгэн дүгнэ.) Эдгээр асуултуудад Алма хэрхэн хариулсан бэ? Бурхан залбирлуудыг сонсож, хариулдаг ямар баттай нотолгоог тэр өгсөн бэ?
- Олон чухал арга замаар Сүнс биднийг удирдах болно гэж Их Эзэн амласан билээ. Та нар дараах хэсгүүдийг уншихдаа Сүнсний удирдамж шаардах өөрсдийн ажлын хэсгүүдийг тогтоо. Дараах судруудад агуулагдсан зарлигууд болон амлалтууд таны хувиараа болон хамтрагчтайгаа суралцахад, түүнчлэн дүүргийн хурлууд, бүсийн чуулганууд, баптисмын үйлчилгээнүүд болон бусад цуглаануудын хувьд ямар учир холбогдолтой вэ?

Залбирах нь

3 Нифай 19:24 С ба Г 50:30
С ба Г 46:30 Ром 8:26

Цуглаануудыг хөтлөх нь

Моронай 6:9 С ба Г 20:45 С ба Г 46:2

Бичих нь

С ба Г 9:9 С ба Г 47:4 С ба Г 124:4
С ба Г 24:6 С ба Г 104:81 Мосе 6:6

- Дараах судрын хэсгүүдийг (түүний дотор эдгээр хэсгүүдийн толгой гарчгуудыг) унш.

С ба Г 60:1–5 С ба Г 61:1–4, 21–22 С ба Г 62:4–8

Энэ шастирт, Их Эзэнд юу маш чухал байсан бэ?

Их Эзэнд юу хамаагүй байсан бэ?

Ахлагч Даллин Х.Өүксийн дараах нотолгоог анхаар:

“Сүнсээр удирдагдах хүчтэй хүсэл [хүнд байж болно] гэвч . . . энэ хүсэл нь юм бүхэнд удирдагдахыг хүсэхдээ тулах юм бол ухаалаг бус болно. Их Эзэнээр удирдуулах хүсэл бол хүч чадал юм, гэвч Тэнгэрлэг Эцэг маань бидний хувийн сонголтуудын төлөө олон шийдвэрийг орхисныг ойлгох ойлголттой энэ нь дагалдах хэрэгтэй юм. Хувийн шийдвэр гаргах нь мөнх бус байдалд бидний туулах ёстой өсөлт хөгжилтийн эх сурвалжуудын нэг юм. Гаргах бүх шийдвэрээ Их Эзэнд шилжүүлэхийг хичээж, сонголт бүхэндээ илчлэлт хүсдэг хүмүүс удирдамжийн төлөө залбираад хариуг нь хүлээн авдаггүй тийм нөхцөл байдалд удалгүй орох болно. Жишээ нь, сонголтууд нь нэг бол ялихгүй жижигхэн, нэг бол хүлээн авч болохуйц байдаг тийм үй олон тооны нөхцөл байдалд бий болдог бололтой.

“Биднийг Бүтээгч бидний дотор байрлуулсан учир шалтгаан бүхий хүчүүдийг ашиглан, бид юмсыг оюун ухаандаа гүйцэд судлах ёстой. Тэгээд бид удирдамжийн төлөө залбирч, үүнийг хүлээн авсан бол үүн дээрээ ажиллах ёстой. Хэрэв бид удирдамж хүлээж аваагүй бол, бид өөрсдийнхөө хамгийн сайн шүүлт дүгнэлтээр ажиллах ёстой. Их Эзэн биднийг чиглүүлэхээр сонгоогүй зүйлүүдээр илчлэлийн удирдамж эрэлхийлэн шаргуу зүтгэдэг хүмүүс өөрсдийнхөө уран зөгнөл буюу өөрсдийнхөө таалалд нийцүүлсэн хариуг зохиох буюу, тэрч байтугай хуурмаг илчлэлтийн арга хэрэгслээр дамжуулан хариу хүлээн авч болно” (“Our Strengths Can Become Our Downfall,” *Ensign*, 1994 оны Аравдугаар сар, 13–14).

Таны дараах хувийн шүүлт дүгнэлт болон Сүнсэнд найдахын хооронд ямар холбоо байдаг вэ?

Хамтрагчтайгаа Суралцах

- Хамтаараа хийсэн залбирлуудынхаа тухай ярилц. Тэдгээр нь Ариун Сүнсээр удирдагдсан уу? Та нар залбирлууддаа хариу авсан уу? Хамтаараа залбирах үед та нар:
 - Зөв шударга байдалд хүссэн зүйлийг тань Бурхан өгөх болно гэдэгт итгэдэг үү?
 - Залбирлуудынхаа хариуг мэдэж, талархдаг уу?
 - Хүмүүсийн төлөө нэрээр нь залбирч, тэдний хэрэгцээг анхаардаг уу?
 - Бие биенийхээ төлөө мөн Сүнс та нарыг удирдахын төлөө залбирдаг уу?
 - Залбирлууддаа хариу хүлээн авдаг уу?

Та нар Сүнсийг хэрхэн илүү чин сэтгэлээсээ эрэлхийлэхийг хамтран ярилц.

- Ариун Сүнсний нөлөөг хүмүүс дүрсэлдэг янз бүрийн арга замуудыг ярилц. Сайн мэдээг сурч, даалгаврууд авч байхад хичээх талаар сонирхогчид ямар туршлагатай болсон тухай тайлбар бич. Энэхүү ариун нандин нөлөөг таньж мэдэхэд нь та бусдад хэрхэн тусалж чадах вэ? Ингэхдээ та мэхлэлтээс хэрхэн зайлсхийж болох вэ?
- Дараах зөвлөгөө танд хэрхэн холбогдохыг анхаарч, ярилц: “Сүнслэг зүйлүүдийг та албадаж болохгүй. Албадах, шахах, тулгах, шахалт үзүүлэх, шаардах гэх мэтийн үгс нь Сүнстэй харьцах бидний онцгой боломжийг дүрсэлдэггүй. Вандуй нахиалах буюу өндөг хагарахыг цагаас нь өмнө албадаж болдоггүйн нэгэн адил та хариулахыг Сүнснээс албадаж чадахгүй. Өсөлт, тэжээлт, хамгаалалтыг хөхүүлэн дэмжих уур амьсгалыг та бүрдүүлж чадна; гэвч та албадах буюу шахах болохгүй: та өсөлтийг хүлээх ёстой” (Boyd K. Packer, “The Candle of the Lord,” *Ensign*, 1983 оны Нэгдүгээр сар, 53).
- Дараах хэлсэн үгсийг ярилц, эдгээр зарчмууд таны залбирлууд болон ажлыг тань хэрхэн өөрчилж чадах вэ. Залбирлууд тань таны төлөвлөлт, зорилго тавилт, ажил болон үйл ажиллагаануудад өдөр бүр хэрхэн нөлөөлж чадах вэ?
 “Өргөн утгаараа, бидний ажил үйлс бол бидний залбирлуудын үр дүн юм. Залбираад дараа нь бид ажилладаг; бидний зохих ёсны гуйлтууд бидний хувьд биеэ авч явах зөв шударга замыг тоймлон харуулахад нөлөө үзүүлдэг” (Bruce R. McConkie, “Why the Lord Ordained Prayer,” *Ensign*, 1976 оны 1-р сар, 12).
 “Бид аливаа адислал хүсэх буюу эсвэл үүний төлөө бидний ажиллах ариун журам нь үүнийг тэжээн тэтгэхэд үйлчилж байвал энэ нь чин сэтгэлийн залбирал болдог” (David O. McKay, *Secrets of a Happy Life*, 114–15).
 “Тэр таныг хаана тавихыг хүсдэг тэр газарт тавихыг, мөн Тэр танаар юу хийлгэхийг хүсдэгийг өөртөө хэлж өгөхийг [Бурханаас] хүсч, мөн та үүнийг хийхэд бэлэн байна гэж бод” (Brigham Young, *Discourses of Brigham Young*, түүвэрлэсэн. John A. Widtsoe [1954], 46).

Дүүргийн Хурлууд ба Бүсийн Чуулганууд

- Залбиралд тохирох, хүндэтгэлтэй хэл ашиглах талаар нэг хичээл заа.
- Тохиромжтой үед, саяхны гэрчлэлийн цуглаан дээр сонссон түүх буюу тохиолдол, заасан туршлага буюу бусад зүйлийн талаар номлогч нараар хуваалцуул. Бусад хүмүүсийн ярьсан сүнслэг түүхүүд болон туршлагууд нь итгэлээ хөгжүүлж, Сүнсний нөлөө өргөн хэмжээгээр мөн олонтаа үзүүлэгддэгийг танин мэдэхэд танд тусалж чадна.
- Таны ажилд Их Эзэний гар оролцсоны төлөө талархлаа илэрхийл (С ба Г 59:21-ийг үз). Талархал илэрхийлэх нь Их Эзэн таныг адисалдаг тэрхүү багаахан хэрнээ их ач холбогдолтой арга замуудыг харахад танд хэрхэн тусалдгийг ярилц (Ифэр 3:5-ыг үз).
- Номлол болон Ариун Сүнсний хүчний тухай үг хэлэхийг номлогч нараас хүс.
- Сонирхогч байхдаа Сүнсээр хэрхэн нөлөөлөгдөж байсан тухайгаа үг хэлэхийг саяхны нэг хөрвөгчөөс хүс.

Номлолын Ерөнхийлөгч

- Танд бичдэг долоо хоног тутмын захидалдаа холбогдох сүнслэг тохиолдлуудаа оруулж байхыг номлогч нараас үе үе хүсч бай.
- Ярилцлагуудад тэдний өглөө, оройн залбирлуудынх нь талаар үе үе асууж бай. Тэд залбирлынхаа утга учрыг мэдэрсэн эсэхийг тэднээс асуу.



Мормоны Номны Үүрэг Юу Вэ?


Үүнийг Анхаар

- Мормоны Ном хэрхэн манай шашны шаантаг чулуу болдог вэ?
- Бодгалийн агуу асуултуудад Мормоны Ном хэрхэн хариулдаг вэ?
- Хөрвүүлгийн үйл явцад Мормоны Ном яагаад тийм их хүчирхэг байдаг вэ?
- Итгэлийг төлөвшүүлж Бурханд ойр байхад нь бусдад туслахын тулд би Мормоны Номыг хэрхэн ашиглах ёстой вэ?
- Мороднай 10:3–5 дахь амлалт яагаад номлолын ажил дахь төв нь болдог вэ?

Мормоны Ном бол Христийн бурханлиг чанарын хүчирхэг нотолгоо юм. Энэ нь бас Бошиглогч Иосеф Смитээр дамжсан Сэргээлтийн нотолгоо мөн. Хөрвүүлгийн амин чухал хэсэг бол Мормоны Ном үнэн гэдэг гэрчлэлийг Ариун Сүнснээс хүлээн авах явдал мөн. Номлогчийн хувьд та эхлээд Мормоны Ном үнэн гэдэг хувийн гэрчлэлтэй байх ёстой. Энэ гэрчлэл нь хөрвүүлгийн үед Мормоны Номны хүчинд итгэх гүн гүнзгий, байнга орших итгэл рүү хөтөлж чадна. Мормоны Номыг уншиж, тунгаан боддог, мөн чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр мөн Христэд итгэх итгэлтэйгээр үүний үнэн эсэхийг Бурханаас асуудаг хэнд ч гэсэн Ариун Сүнс гэрчлэх болно гэдэг итгэлтэй бай. Ариун Сүнсний энэ гэрчлэл таны заалтын гол төв байх ёстой.

Мормоны Ном Бол Манай Шашны Шаантаг Чулуу

Мормоны Ном бол “манай шашны шаантаг чулуу” мөн гэж Бошиглогч Иосеф Смит заажээ (Мормоны Номын удиртгал). Өөр нэг тохиолдолд тэрээр өгүүлэхдээ: “Мормоны Ном болон илчлэлтүүдийг авчих юм бол манай шашин хаана байх вэ? Бидэнд юу ч байхгүй болно” гэжээ (*History of the Church*, 2:52).



Тэмдэглэл

Нуман тулгуур бол шаантаг хэлбэртэй хэсгүүдийг бие биенд нь налуулан хийсэн уран барилгын бат бөх хийц юм. Дунд талын хэсэг буюу тулгуурын чулуу нь бусад шаантгуудаас илүү том бөгөөд бусад чулуунуудыг байранд нь түгждэг. Иосеф Смит Мормоны Номыг “манай шашны тулгуурын чулуу” гэж нэрлэснээр Мормоны Ном бол манай шашныг бүхэлд нь барьж байдаг гэдгийг заажээ. Мормоны Ном бол наанадаж л гурван талаар тулгуурын чулуу юм гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн байдаг:

Христийн гэрч. “Мормоны Ном бол бидний хийдэг юм бүхний суурийн чулуу нь болох Есүс Христийн тухай бидний гэрчлэл дэх тулгуурын чулуу мөн. Энэ нь Түүний бодит байдлын тухай хүч болон тодорхой байдалтайгаар гэрчилдэг.”

Сургаалын бүрэн байдал. “Мормоны Ном ‘Есүс Христийн бүрэн сайн мэдээг’ агуулдгийг Их Эзэн Өөрөө хэлсэн байдаг (С ба Г 20:9). Бидний авралд шаардлагатай сургаалуудын бүрэн байдлыг бид Мормоны Номонд олох болно. Бүр хүүхдүүд хүртэл аврал болон өргөмжлөлийн арга замуудыг мэдэж чадахаар тийм тодорхой энгийн байдлаар тэдгээр нь заагддаг.”



Гэрчлэлийн суурь. “Шаантаг чулууг нь авчих юм бол нуман тулгуур нурж унадаг шиг бүх Сүм Мормоны Номны үнэнээс хамааран үлдэх буюу унадаг. Сүмийн дайснууд үүнийг тодорхой ойлгодог. Чухам иймээс тэд Мормоны Номыг гутаах гэж урт удаан хугацаагаар хичээж байгаа билээ, учир нь үүнийг гутааж чадах юм бол Бошиглогч Иосеф Смит үүнтэй хамт явдаг шүү дээ. Мөн санваарын түлхүүрүүд, түүнчлэн илчлэлт, мөн сэргээгдсэн Сүмийн тухайд ч бидний мэдэгдэл адил юм. Гэвч энэ байдлаар; хэрэв Мормоны Ном үнэн юм бол—мөн сая сая хүмүүс эдүгээ тэд Сүнсний энэ нь яах аргагүй үнэн хэмээн гэрчилсэн юм бол Сэргээлтийн тухай мэдэгдлийг мөн үүнийг дагалддаг бүхнийг хүлээн авах ёстой” (*A Witness and a Warning* [1988], 18–19).

Сүнстэй нэгдсэн Мормоны Ном бол хөрвүүлэг дэх таны хамгийн хүчирхэг эх сурвалж юм. Энэ бол дэлхий дээрх аль ч номноос хамгийн зөв нь юм (Мормоны Номны удиртгалыг үз). Энэ нь Христийн сургаалыг, ялангуяа сонирхогчдод таны заадаг хичээлүүдэд бүрч тодорхой заагддаг. Сэргээгдсэн сайн мэдээг заах гол эх сурвалжаа болгон үүнийг ашигла. Дараах зүйл нь таны сонирхогчдодоо заах, Мормоны Номонд тод томруунаар заагддаг үнэнүүдийн жишээнүүд юм.

Номлогчийн хичээл	Сургаалууд	Ишлэлүүд
Есүс Христийн Сайн Мэдээний Сэргээлтийн Захиас	Урвалт, Сэргээлт, Иосеф Смит, санваарын эрх мэдэл	1 Нифай 12–14 2 Нифай 3; 26–29 Мозая 18
Авралын Төлөвлөгөө	Адамын Уналт, Цагаатгал, Амилуулалт хийгээд Шүүлт бүхий “Мөнхийн Бурханы агуу төлөвлөгөө,”	2 Нифай 2; 9 Мозая 3; 15 Алма 12; 40–42
Есүс Христийн Сайн мэдээ	Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг, түүнчлэн эцсээ хүртэл тэвчих	2 Нифай 31–32 3 Нифай 11; 27
Зарлигууд; Хуулиуд ба Ёслолууд	Баптисм, гишүүний баталгаа, санваарын томилолт ариун ёслол зэрэг ёслолууд	3 Нифай 11:22–28; 18 Моронай 2–6

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Судлах тэмдэглэлдээ дараах асуултуудын хариуг бич.

- Мормоны Номыг судалсан нь Есүс Христийн тухай таны гэрчлэлд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Бусдын гэрчлэлийг бэхжүүлэхийн тулд та Мормоны Номыг хэрхэн ашиглаж болох вэ?

Судар Судлах

Мормоны Номны тухай Аврагч юу гэж хэлсэн бэ?

С ба Г 1:29

С ба Г 19:26–27

С ба Г 42:12

С ба Г 3:19–20

С ба Г 20:5–16

Моце 7:62

С ба Г 17:6

С ба Г 33:16



Гэрэл зургийг: © Harrison Company Co., Inc.-ийн зөвшөөрлөөр нийтлэв. Хувиараа олшруулж болохгүй.

Мормоны Ном Христийн Тухай Гэрчилдэг

Мормоны Номны гол зорилго бол Есүс бол Христ мөн гэдэгт бүх хүмүүсийг үнэмшүүлэх явдал мөн (Мормоны Номны эхний хуудсыг үз). Энэ нь Түүний амьдралын бодит байдал, үүрэг зорилго болон хүчийг батлах замаар Христийн тухай гэрчилдэг. Энэ нь авралын төлөвлөгөөний суурь—Цагаатгалын тухай үнэн сургаалыг заадаг. Мормоны Номонд бичээсүүд нь хадгалагдан үлдсэн хүмүүсийн нилээд хэд нь Христийг биеэрээ харсан ажээ. Жаредын ах, Нифай, түүнчлэн Иаков мөнх бус байдлын өмнөх Христийг харжээ. Мормон, Моронай хоёр амилсан Христийг харжээ. Түүнээс гадна, нифайчуудын дундах Аврагчийн богинохон атлаа хүчирхэг тохинууллын үеэр олон хүмүүс байсан ажээ (3 Нифай 11–28-ыг үз). Аврагчийн

тухай бага мэддэг буюу юу ч мэддэггүй хүмүүс Мормоны Номыг уншиж, тунгаан бодож мөн үүний талаар залбирснаар Түүний тухай мэдэх болно.

Мормоны Номын тухай гэрчлэл нь Есүс бол Бурханы Төрсөн Ганц Хүү бөгөөд дэлхийн Аврагч гэдэг Библийн гэрчлэлийг баталдаг. Та Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг зааснаар, дэлхийн Аврагч хийгээд Гэтэлгэгчийн тухай олонтаа гэрчлэх болно. Ариун Сүнсний хүчээр та энэ захиасын үнэний тухай өөрийн амьд гэрчлэлийг нэмэх болно.

Судар Судлах

Мормоны Номны бошиглогчид өөрсдийн цэдгүүдийг бичих ямар шалтгаануудыг нэрлэсэн бэ?

1 Нифай 6:4–6

2 Нифай 33:13–15

Мормоны Үгс 1:3–8

1 Нифай 9:3–5

Иаков 1:4–7

Алма 37:2, 14

2 Нифай 4:15–16

Иаков 4:1–6, 12

3 Нифай 5:14–15

2 Нифай 25:23–29

Инос 1:13

Мормон 8:35

2 Нифай 26:15–16

Жэром 1:2

С ба Г 3:16–20

2 Нифай 29:11–14

Омнай 1:25–26

С ба Г 10:46–48

Тэмдэглэл

Мормоны Ном Библи Хоёр Бие Биенээ Дэмждэг

Библийн тухай хүмүүсийн итгэл маш их өөр байдаг. Библи бол үнэмлэхүй төгс, алдаа мадаггүй, энэ бол аврагдахад бидэнд шаардлагатай бүх зүйл мөн гэдэгт зарим хүмүүс итгэдэг. Библи бол судалбал зохих утга зохиол гэж бусад нь боддог хэдий ч, энэ бол Христийн бурханлиг чанар болон гайхамшгуудын нотолгоо буюу Бурханаас шууд ирсэн илчлэлт гэдгийг үгүйсгэдэг. Зарим хүмүүс Библийг үл ойшоохоор сонгосон байхад бусад нь Библийг огт үзээгүй буюу үүнийг унших боломж олдоогүй байдаг.

Хожмын Үеийн Гэгээнтнүүд “Библи нь зөв орчуулагдсан байхын хэрээр Бурханы үг гэдэгт итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:8). Мормоны Ном Библитэй өрсөлддөггүй, харин үүнийг дэмжиж, үүнийг уншихыг бидэнд уриалан, үүний захиасын үнэний тухай гэрчилдэг. Та Мормоны Ном, Библи хоёрыг нэг нэгэнд нь тулгуурлан ашиглах ёстой.

Мормоны Ном Бурханаас Өөрийн хүүхдүүдтэй хийсэн эртний гэрээнүүдийн тухай өгүүлдэг; Библи мөн эдгээр гэрээнүүдийг итгэлээр хүлээн авдаг байсан агуу бошиглогчдын тухай өгүүлдэг. Мормоны Ном Христ болон Түүний Цагаатгалын тухай гэрчилдэг; Библи Түүний төрөлт, тохинуулал, үхэл, Цагаатгал хийгээд Амилуулалтын тухай шастираар хангадаг. Тийнхүү, Библи, Мормоны Ном хоёр хослон, нэг нэгнээ баяжуулдаг.

Библийн Хаан Жеймсийн Хувилбарын Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн англи хэл дээрх хэвлэл болон Мормоны Ном нь Иудейн саваа (Библи), Иосефын саваа (Мормоны Ном) хоёрыг бидний гарт нэг болгон өгсөн харьцуулах ишлэлүүд болон судлах тусламжуудтай билээ (Езекиел 37:15–17; мөн 1 Нифай 13:34–41; 2 Нифай 3:12; 29:8-ыг үз). Та заахдаа Мормоны Номын хэсгүүдийг давуутай ашигла, гэвч Мормоны Ном, Библи хоёр хэрхэн нэг адил зарчмуудыг заадгийг бас харуул.

Библийн хэсгүүдийг тодруулах болон тайлбарлахад Мормоны Номыг ашигла. Жишээ нь, “бүх зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн” (Матай 3:14–15) тулд баптисм хүртсэнийг Шинэ Гэрээ нотолдог. Бүх зөвт байдлыг гүйцэлдүүлэх гэдэг нь ямар утга учиртайг Мормоны Ном тайлбарладаг (2 Нифай 31:5–9-ийг үз).

Мормоны Ном, Библи хоёрыг судрын хослол боть болгон ашиглахад тэдгээр нь зөрчилдөөнийг даван туулж, хуурмаг сургаалыг залруулах болно (2 Нифай 3:12).

Библи гэрчүүдийн хуулийн тухай дараах зүйлийг заадаг: “Хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүхэн батлагдах болно” (2 Коринт 13:1). Энэ хуулийн дагуу Мормоны Ном, Библи хоёр аль аль нь Христийн тухай гэрчилдэг.

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Дараах сэдвүүдээр харьцуулах ишлэлүүдийг Мормоны Ном болон Библиэс ол. Жишээнүүдийг сэдэв бүрийн дараа хаалтанд өгсөн байгаа. Өөрийн хэсгүүд болон сэдвүүдийг нэм.

- Бошиглогчид (Амос 3:7, Иаков 4:4–6)
- Урвалт (2 Тимот 4:3–4, 2 Нифай 28)
- Сэргээлт (Үйлс 3:19–21, 1 Нифай 13:34–42)
- Бурханы хүүхдүүд (Үйлс 17:29, 1 Нифай 17:36)

Судар Судлах

Мормоны Номын тухай Библи юу өгүүлдэг вэ?

Иохан 10:16
Исаиа 29:4, 11–18

Езекиел 37:15–17

Guide to the Scriptures, “Ephraim,” дэд
гарчиг: *The Stick of Ephraim or Joseph*

Библийн тухай Мормоны Ном юу өгүүлдэг вэ?

1 Нифай 13:20–29, 40–41
2 Нифай 29:3–14

3 Нифай 23:1

Мормон 7:8–9

Энэ хоёр ном ямар байдлаар Христийн гэрээнүүд болдог вэ?

2 Нифай 29:8

Иохан 20:31

Үйлс 10:43

Бодгалийн Тухай Асуултуудад Мормоны Ном Хариулдаг

Номлогч нар “[Мормоны Ном] бодгалийн агуу асуултуудад хэрхэн хариулдгийг харуулах хэрэгтэй” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (“Flooding the Earth with the Book of Mormon,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 5).

“Бодгалийн тухай агуу асуултууд” нь: Бурхан үнэхээр байдаг уу? Би төрөхөөсөө өмнө байсан уу? Үхсэнийхээ дараа би амьдрах уу? Амьдралын зорилго юу вэ? Есүс үнэхээр Аврагч мөн үү? гэх зэрэг асуултуудыг багтааж болно.

Бусад асуултууд илүү цаг зуурын хэрэгцээнүүд дээр төвлөрсөн байж болно: Би ханьтайгаа харилцах харилцаагаа хэрхэн сайжруулах вэ? Өөрийнхөө өсвөр насны хүүхдүүдийг мансууруулах бодис болон ёс суртахуунгүй явдлаас зайлсхийхэд нь би хэрхэн тусалж болох вэ? Гэр бүлээ тэтгэхийн тулд би яаж ажил олох вэ? гэх мэт.

Есүс Христийн сайн мэдээ эдгээр хоёр төрлийн асуултуудад хоёуланд нь хариулахад бидэнд тусалдаг. Бид Мормоны Ном үнэн гэдэг итгэлтэй болоход энэ нь бидний амьдралын зорилго болон мөнх амьдралын найдварын тухай асуултуудад хариулж эхлэх болно. Утга учиртай, хэтийн төлөвтэй амьдралыг өгдөг аз жаргалын төлөвлөгөөг Мормоны Ном дүрсэлдэг. Дараах мэтийн асуултуудын хариуг Мормоны Номонд тод томруунаар заасан байдаг.



- Бурхан байдаг уу? (Алма 22)
- Есүс Христ надаас юу хүсэн хүлээдэг вэ? (2 Нифай 9)
- Есүс Христэд итгэх итгэл надад хэрхэн тусалж чадах вэ? (Алма 36)
- Үхлийн дараа амьдрал байдаг уу? (Алма 40)
- Амьдралын зорилго юу вэ? (Алма 34)
- Яагаад Бурхан хилэнц болон зовлон тохиолдохыг зөвшөөрдөг вэ? (2 Нифай 2; Алма 14:9–11; 60:13)
- Нялх хүүхэд баптисм хүртэх хэрэгтэй юү? (Моронай 8)

Тэмдэглэл

- Бурхан намайг мэддэг үү? (Алма 5:38, 58)
- Бурхан залбирлуудад хариулдаг уу? (Инос 1)
- Амар амгалан, баяр хөөрийг би хэрхэн олж чадах вэ? (Мозая 2, 4)
- Гэр бүл маань хэрхэн илүү аз жаргалтай, илүү нэгдмэл байж чадах вэ? (Мозая 2)
- Би гэр бүл, ажил албаа хэрхэн тэнцүү байдлаар авч явж болох вэ? (3 Нифай 13)
- Би ханьтайгаа харилцах харилцаагаа хэрхэн бэхжүүлж болох вэ? (3 Нифай 14)
- Гэр бүлд минь заналхийлдэг хилэнцүүдээс би хэрхэн зайлсхийж чадах вэ? (Алма 39)
- Нүглээс би хэрхэн зайлсхийж болох вэ? (Хиламан 5)

Мормоны Номыг бид Сүнсний удирдамжтайгаар уншсанаар энэ нь хувийн асуултуудад хариулахад бидэнд тусалдаг. Залбирал, илчлэлт бол тодорхой асуудлуудыг шийдвэрлэх түлхүүр мөн гэж энэ нь заадаг. Бурхан бидний залбирлуудад хариулах болно гэдэг итгэлтэй байхад энэ нь бидэнд тусалдаг.

Бурханы зарлигууд бол хийж болох, хийж болохгүй зүйлүүдийн хориглосон жагсаалт биш, харин аз жаргалтай, элбэг дэлбэг амьдрал уруу хөтлөх удирдамж мөн гэдгийг ойлгоход Мормоны Ном бас бидэнд тусалдаг. Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд бол элбэг дэлбэг амьдралд хүрэх зам мөн гэдгийг бид ойлгож эхэлснээр бид эдгээр зарчмууд ямар ч асуултад хариулж, ямар ч хэрэгцээг хангахад тусалдгийг үнэлэх болно. Жишээ нь, наманчлал, уучлал, бусдад үйлчлэх гэрээ нь бид өөрсдийн эхнэр буюу нөхөртэйгөө харилцах харилцааг сайжруулахад амин чухал юм. Бид энэхүү Христэд итгэх итгэл, гэрээнүүдийг хүлээн авч, сахин, Сүнсний өдөөлтүүдийг дагах нь тэдний эргэн тойронд байдаг хүчтэй уруу таталтуудаас зайлсхийхэд өсвөр насныханд тусалж чадахыг хардаг.

Сайн мэдээ бараг бүх асуудал буюу хэрэгцээг шийдвэрлэж чадна. Та нар “сайн мэдээний бүрэн байдал дотор нь байгаа Мормоны Номон дахь миний сайн мэдээний зарчмуудыг заах” ёстойн учир энэ юм (С ба Г 42:12).

*“Хэзээ хэзээнээс илүү аюултай дэлхийд . . .
Мормоны Ном:
Есүс Христийн
Бас Нэгэн Гэрээ нь
дэлхийн харангалагч
сүнснүүдийг эдгээн
тэтгэгч хүчтэй юм.”*

—ЕРӨНХИЙЛӨГЧ БОИД К.ПАКЕР
“THE BOOK OF MORMON: ANOTHER TESTAMENT OF
JESUS CHRIST,” *ENSIGN*, 2001 ОНЫ 11-П САР, 64

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Сонирхогчдын асуусан “бодгалийн тухай агуу асуултуудын” жагсаалт хий. Эдгээр асуултуудад хариулдаг шүлгүүдийг Мормоны Номноос ол. Хариултуудыг судлах тэмдэглэлдээ бичиж, заахдаа тэдгээрийг ашигла.

Мормоны Ном Хүмүүсийг Бурханд Ойртуулдаг

Мормоны Номын талаар Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ, “бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” гэжээ (Мормоны Номны удиртгал). Мормоны Ном бол гэрчлэл болон хувийн илчлэлт рүү хөтлөх гишгүүр мөн. Сүнслэг туршлагауудтай болоход нь,

ялангуяа энэ ном өөрөө үнэн гэдэг гэрчлэлийг Ариун Сүнснээс хүлээн авахад нь хүмүүст туслахын тулд Мормоны Номыг ашигла. Мормоны Номонд байдаг зарчмуудаар амьдрахад хүмүүсийг шаргуу урьснаар та Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, Бурханд ойртоход нь тэдэнд тусална.

“[Мормоны Номыг] залбиралтайгаар уншсан хүмүүс баян, ядуу, эрдэм мэдлэгтэй, үгүй ч байна уу ялгаагүй үүний хүчин дор өссөн юм. . . . Хэрэв та нар үүнийг өмнө нь хичнээн удаа уншсаныг үл харгалзан, Мормоны Номыг залбиралтайгаар унших юм бол . . . Их Эзэний Сүнс зүрх сэтгэлд тань ирэх болно гэдгийг би ямарваа тайлбаргүйгээр та нарт амлаж байна. Түүний зарлигуудад дуулгавартайгаар алхах хүчирхэг шийдэмгий байдал ирэх болно, мөн Бурханы Хүүгийн амьд бодит байдлын тухай илүү хүчирхэг гэрчлэл ирэх болно” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли тунхаглажээ (“The Power of the Book of Mormon,” *Ensign*, 1988 оны 6-р сар, 6).

Эсэргүүцлүүдэд Хариулахын Тулд Мормоны Номыг Ашигла

Таны заадаг бүхэнд олон хүмүүс итгэхгүй байх болно. Ийм нөхцлүүдэд хариулахад Мормоны Ном хэрхэн гол эх сурвалж байж болохыг Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон заахдаа:

“Сүмийг эсэргүүцэх эсэргүүцлийг зохицуулахад бид Мормоны Номыг ашиглах ёстой. . . .

“ . . . Бүх эсэргүүцэл, тэр нь үр зулбуулах ч байна уу, олон эхнэр авах ёс ч байна уу, долоо дахь өдрийн шүтлэг ч байна уу, ялгаагүй, үндсэндээ Иосеф Смит болон түүний залгамжлагчид бурханлиг илчлэлт хүлээн авдаг байсан, мөн одоо хүлээн авч байгаа Бурханы бошиглогчид мөн үү гэдэг асуудалд хамаатай байдаг. . . .

“ . . . Ганцхан асуудал нь эсэргүүцэгч өөрийнхөө хувьд Мормоны Ном үнэн эсэхийг шийдэх ёстой юм. Учир нь, хэрэв Мормоны Ном үнэн бол, Есүс бол Христ мөн, Иосеф Смит түүний бошиглогч байсан, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм үнэн бөгөөд энэ нь өнөөдөр илчлэлт хүлээн авдаг бошиглогчоор удирдагдаж байгаа нь үнэн билээ.

“Бидний гол зорилго бол сайн мэдээг тунхаглаж, мөн үүнийг үр ашигтай болгох явдал мөн. Бид эсэргүүцэл бүрт хариу өгөх үүрэгтэй биш. Эцэстээ хүн болгон итгэлийн хананд босон зогсох болно, мөн тэрээр өөрийнхөө байр суурийг бий болгох ёстой” гэжээ (*A Witness and a Warning*, 4–5).

Жишээ нь, чин сэтгэлт сонирхогчид Мэргэн Ухааны Үгийн талаар таны заасныг эсэргүүцэж болно. Энэ эрин үед энэ зарлиг шинэчлэгдэхэд Иосеф Смит Бурханы бошиглогчийн хувиар ярьж байсан уу гэдэг нь тэдний бодит асуулт гэдгийг мэдэхэд нь тэдэнд тусал. Энэ сургаалыг хүлээн авах итгэлтэй байх нь энэ зарлиг Бурханаас Бошиглогч Иосеф Смитэд өгсөн илчлэлтээр дамжин бидэнд ирсэн гэдэгт итгэх ба ноцтой итгэлийг шаардах болно. “Иосеф Смит бол Бурханы бошиглогч гэдгийг мэдэх арга зам бол Мормоны Номыг уншиж, үүний тухай залбирах явдал мөн” гэж та хэлж болно.

Сонирхогчид өөрсдийн санаа зоволтууд болон эсэргүүцлүүдийг өөрсдөө шийдвэрлэх ёстой. Есүс Христэд итгэх тэдний итгэлийг та—Мормоны Номыг



Му. Селуэнт, Лосерн © 2004 The Nelson A. Rockefeller Foundation Arts, American Folk, Utah 94003-ын эвлэлдүүлэгч хуульчлаа.

уншиж, үүний талаар залбирах дээр тулгуурлан хүчирхэгжүүлэхэд төвлөрүүлбэл та тэдэнд тусалж чадна. Тэд Сэргээлтийн тухай гэрчлэлээ бэхжүүлэхэд, эсэргүүцлүүд болон санаа зоволтуудаа даван туулах хүч чадал тэдэнд байх болно.

Санаа зоволтуудад хариулахдаа бидний ойлголтууд өнөө үеийн бошиглогчид—Бурханаас илчлэлтийг шууд хүлээн авдаг Иосеф Смит болон түүний залгамжлагчдаас ирдгийг санагтун. Тийм учраас, сонирхогчийн хувьд, хариулах эхний асуулт нь Иосеф Смит бошиглогч байсан уу гэсэн асуулт бөгөөд уг сонирхогч Мормоны Номыг уншиж, үүний тухай залбирснаар энэ асуултад хариулж чадна.

Иосеф Смит ба Мормоны Ном

Иосеф Смит бол Бурханы бошиглогч гэдгийг мэдэх нэг арга зам бол Мормоны Номыг уншиж, энэ тухай залбирах явдал мөн.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Дараах эсэргүүцлүүд буюу асуудлуудад хариулахад Иосеф Смит хийгээд Мормоны Номноос та хэрхэн иш татахаа судлах тэмдэглэлдээ бич:

- “Бурхан хүмүүстэй ярьдаг гэдэгт би огт итгэдэггүй.”
- “Аль нэг зохион байгуулагдсан шашнаар дамжуулахын оронд би Бурханыг өөрийнхөө арга замаар шүтэн биширч болно гэдэгт би итгэдэг.”
- “Хэрэв би танай сүмд элслээ гэхэд яагаад би хоолныхоо үеэр дарс уухаа болих ёстой юм бэ?”
- “Шашин надад яагаад хэрэгтэй юм бэ?”

Та Мормоны Номыг Хэрхэн Ашиглах Ёстой Вэ?

Олон сонирхогчид Мормоны Номыг нэг бол уншдаггүй, нэг бол уншсанаа ойлгодоггүй. Мормоны Номыг уншдаггүй буюу ойлгодоггүй хүмүүст энэ ном үнэн гэдэг гэрчлэлийг хүлээн авах нь хэцүү байх болно.

Мормоны Номыг Сонирхогчидтойгоо Хамт Унш

Та нар хамт уншихдаа, Мормоны Ном үнэн гэдгийг Ариун Сүнс сонирхогчдод гэрчлэхийн төлөө залбир.



Мормоны Номыг тэдэнтэй хамт уншсанаар та сонирхогчдод тусалж чадна. Тэдний санаа зоволтууд болон асуудлуудад хандсан хэсгүүдийг сонгож авахад туслалцаа хүсч залбир. Та заах ажил үүргийн нэг хэсэг болгох буюу шалгах уулзалтын үеэр судрын хэсгүүдийг тэдэнтэй хамт уншиж болно. Та бас гишүүдийг сонирхогчидтой хамт уншуулахаар зохион байгуулж болно.

Эхний хуудас, удиртгал (ялангуяа сүүлчийн хоёр догол мөр) түүнчлэн Моронай 10:3–5 нь зарим онцгой чухал хэсгүүдийг агуулдаг. Мормоны Номын тухай гэрчлэлийг хэрхэн олж авахыг ойлгоход нь эдгээр хэсгүүд сонирхогчдод тусалдаг. Мормоны Номыг эхнээс нь, түүний дотор гурван гэрчийн гэрчлэл, найман гэрчийн гэрчлэл, түүнчлэн Бошиглогч Иосеф Смитийн гэрчлэлийг уншихад нь тэднийг урамшуулан дэмж.

Богинохон хэсгүүдийг (1 Нифай 3:7 буюу Мозая 2:17 гэхчлэн) мөн илүү урт хэсгүүд буюу бүтэн бүлгүүдийг (2 Нифай 31, Алма 7 буюу 3 Нифай 18 гэхчлэн) уншиж, ярилц.

Сонирхогчидтой хамт уншихдаа, үе үе зогсож уншсан зүйлээ ярилц. Тэдэнтэй хамт уншихдаа эрж олох гол захиасууд буюу чухал сургаалуудыг заан тэмдэглэ. Холбогдох ойлголтууд, мэдрэмжүүд, гэрчлэлүүд болон хувийн туршлагуудыг хуваалц. Мормоны Номын сүнслэг хүчийг мэдрэхэд нь бусдад тусал. Ийм замаар та тэдэнд үнэн сургаалыг Мормоны Номноос шууд зааж чадна. Заадаг хүмүүс тань унших чадвараа дээшлүүлж, бие даан залбирч чадахын тулд ийм зуршлыг дараагийн уулзалтуудаар үргэлжлүүл.

Мормоны Номын бошиглогчдын үгсийг ашиглан зарчмууд болон сургаалуудыг заа. Хэсгийн суурь үндэс болон хам сэдвийг тайлбарла. Танил биш үгс, холбоо үгсийг тайлбарла.

Өөрт тань хувь хүний хувьд болон сонирхогчдод тань холбогдох хэрэглээнүүдийг олж, уншсан зүйлээ өөртэйгөө болон сонирхогчидтойгоо “адилтга” (1 Нифай 19:23-ыг үз.) “Адилтгах” гэдэг нь сургаалыг ойлгох болон уг сургаалаар амьдрахын хооронд оюуны гүүр бий болгоно гэсэн үг юм. Чин сэтгэлээсээ, үнэн санаанаасаа уншихын тулд та өөрөө болон заадаг хүмүүс тань сургаал дээр үйлдэх, үүнийг өдөр тутмынхаа амьдралтай холбож, шаардлага гарсан үед наманчлах хүсэлтэй байх ёстой. Сургаалаар амьдарснаар та энэ нь үнэн гэдэг баталгааг авах болно. Жишээ нь, та сонирхогчдодоо:

- “Таны нэгэн адил Нифай хүнд бэрхшээлтэй тулгарсан юм. Гэвч Их Эзэний зарлигласныг ‘явж, хийх’ итгэлийг хөгжүүлснээр, тэр амжилт олох боломжтой байв. (1 Нифай 3:7-г унш.) Мэргэн Ухааны Үгээр амьдрах арга замыг Бурхан танд бэлтгэх болно гэдгийг би мэднэ” гэж хэлж болно.
- “Жон, та гэм буруугийн мэдрэмжээс чөлөөтэй байхаар хүсч байгаа нь сайн байна. Хэрэв та наманчилж, баптисм хүртэн, Ариун Сүнсний бэлэг хүлээж авах юм бол, яг л Их Эзэн Нифайчуудад амласан шиг, та ‘Эцэгийн өмнө гэм буруугүй байх’ болно” (3 Нифай 27:16-г унш.)

*“Мормоны Номыг эргэлзэх
байдалд бүү аваач.*

*Мормоны Ном таны
номлолд хэрхэн илүү үр
ашигтайгаар ашиглагдаж
болох тухайд
үзэгдэл хүсч залбир.*

*Ингэсэн тохиолдолд та
баримтлах ёстой тэр
чиглэлд оюун ухаан тань
гэгээрэх болно гэдгийг би
та нарт амлаж байна.”*

—АХЛАГЧ ИОСЕФ Б.ВӨРФЛИН
НОМПОЛЫН ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН
СЕМИНАР, 1999 ОНЫ ЗУРГАДУГААР САРЫН 23

Моронай 10:3–5 дахь амлалтад найд. Энэ номыг чин сэтгэлээсээ уншиж, үүний тухай залбирах хүн бүр Ариун Сүнсний хүчээр үүний үнэнийг тодорхой байдлаар мэдэж чадна. Сонирхогчдод туслахын тулд чадах бүхнээ хий:

- Мормоны Номыг уншиж, Есүс Христийн талаарх үүний захиасыг тунгаан бод.
- Мормоны Ном үнэн, Иосеф Смит бол Сэргээлтийн бошиглогч мөн гэдэг гэрчлэл хүлээж авахын тулд Есүс Христэд итгэх итгэлтэйгээр Бурханд хандан залбир.
- Чин сэтгэлээсээ залбирч, Бурханаас хүлээн авсан хариун дээрээ ажиллах хүсэлтэй байна гэсэн утгатай үнэн хүсэлтэй бай.

Та ч бас Мормоны Номны тухай өөрийн гэрчлэлийг бэхжүүлж, байнга шинэчилж байхын тулд энэ амлалтад хандаж байх ёстой. Энэхүү шинэчлэгдсэн гэрчлэл нь энэ амлалтад хандсан хэн ч гэсэн хариу хүлээн авах болно гэдэгт бат бөх итгэлтэй байхад танд туслах болно.

Ажлынхаа Хэсэг Бүрт Мормоны Номыг Ашигла

Мормоны Ном бол хөрвүүлэг дэх хүчирхэг эх сурвалж юм. Сэргээгдсэн үнэнийг заах гол эх сурвалж болгон үүнийг ашигла.

Үүнийг Сана:

- Мормоны Ном бол Христийн тухай бидний гэрчлэл, бидний сургаал түүнчлэн бидний гэрчлэлүүдийн шаантаг чулуу юм.
- Мормоны Ном номлогчийн хичээлүүдэд байдаг сургаалыг тод томруунаар заадаг.
- Бодгалийн тухай асуултуудад хариулах, түүнчлэн Сүмийг эсэргүүцсэн эсэргүүцлүүдэд хариулахад Мормоны Номыг ашигла.
- Өөрийн сонирхогчид болон шинэ хөрвөгчидтэй хамт Мормоны Номноос шаргуу уншиж бай. Тэд өөрсдөө өдөр бүр уншиж, сурч мэдсэн зүйлээ амьдралдаа хэрэглэхэд нь тэдэнд туслахын тулд чадах бүхнээ хий.
- Мормоны Номыг чин сэтгэлээсээ уншиж, үүний тухай залбирдаг хүн бүр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр мэдэх болно гэсэн Их Эзэний амлалтад итгэ.

Заах Санаанууд ба Хэрэглэгдэх нь

Тэмдэглэл

Хувиараа Суралцах

- 2 Нифай 2, 9, 30, 31, 32-ыг уншиж, Есүс Христийн тухай ишлэл бүрийг онцгой анхаар. Эдгээр бүлгүүдэд ашигласан Христийн өөр өөр нэрнүүдийн жагсаалтыг хий. Христийн тухай хэлсэн үгнүүдийн доогуур зур. Түүний зан чанарууд болон Түүний үйлдлүүдийг онцгой анхаар. Та Мормоны Номыг бүхэлд нь уншихдаа энэ зуршлыг үргэлжлүүлж болно.
- Мормоны Ном үнэн гэдэг сүнсийг гэрчлэлийг анх хүлээж танд хэрхэн санагдсаныг судлах тэмдэглэлдээ бич.
- Сургаал ба Гэрээ 20:17 Мормоны Номоор заагдаж, тодруулагддаг сургаалуудыг танилцуулахад “бидний мэддэг эдгээр зүйлүүдээр” холбоо үгсийг ашигласан байдаг. Сургаал ба Гэрээ 20:15–35-ыг уншиж, дурдсан сургаалуудын жагсаалт хий. Эдгээр сургаалуудын нэгийг сонгож, өөрийнхөө жагсаалтыг, эдгээр сургаалуудын талаар Библи юу гэж заадагтай харьцуулахын тулд Guide to the Scriptures-г ашигла.
- Матай 5–7 дахь Уулан дээрх Номлолыг, 3 Нифай 12–14 дэх ариун сүм дэх номлолтой харьцуул. Мормоны Номоор дамжин сэргээгдсэн тодорхой болон эрхэм үнэт үнэнүүдийн жагсаалт хий.
- Сонирхогчдын асуусан асуултуудын жагсаалт хий. Эдгээр асуултуудад хариулдаг Мормоны Номны хэсгүүдийг олж, өдөр тутмынхаа заалтад хэрэгтэй болсон үед тэдгээрийг ашигла.
- Амьдралыг тань өөрчилсөн Мормоны Номны нэг судрыг ол. Энэ судрын тухай бодлуудаа судлах тэмдэглэлдээ тэмдэглэ.
- Хэн нэгний залбирлын үгс цэдэглэгдсэн Мормоны Номон дахь жишээ бүрийг ол. Эдгээр залбирлуудын нийтлэг элементүүдийг судлах тэмдэглэлдээ бич.
- 2 Нифай 33:10–15, Моронай 10:27–29, 34-ийг унш. Та Мормоны Номыг ашигладаг тухайгаа шүүлтийн байранд Нифай, Моронай хоёрт юу гэж хэлэх вэ? Хариултаа бичиж, сайжрах зорилго тавь.
- Мозая 11–16-гийн бүлгийн толгой гарчгуудаас Абинадайн заасан зүйлүүдийн хураангуйг бич. Эдгээр бүлгүүдийг уншиж, хураангуйг дэлгэрүүл.
- Мозая 2–5-ын бүлгийн толгой гарчгуудаас Хаан Бенжамины заасан зүйлүүдийн хураангуйг бич. Эдгээр бүлгүүдийг уншиж, хураангуйгаа дэлгэрүүл.
- Та Мормоны Номноос өдөр бүр уншиж, өөрт тань сэтгэгдэл төрүүлсэн хэсгүүдийг судлах тэмдэглэлдээ тэмдэглэ. Эдгээрийг амьдралдаа хэрхэн хэрэглэхээ бич.

Хамтрагчтайгаа Суралцах

- Мормоны Номны хэсгүүдийг хамтдаа унш. Сурсан буюу бодогдсон зүйлээ хуваалц. Мөн гэрчлэлүүдээ бие биентэйгээ хуваалц.
- Та Мормоны Номны аль бошиглогч буюу номлогчтой адилхан байхыг хүсэх вэ? Яагаад? Хариултаа хамтрагчтайгаа хуваалц.
- Алма 26, 29-ийг хамтран унш. Номлолынхоо талаар юу гэж бодогоо хуваалц. Бодлуудаа судлах тэмдэглэлдээ бич.

- Алма 37:9-ийг уншиж, Аммон түүний нөхөд номлогч нарын хувьд судрууд хэрхэн шийдвэрлэх учир холбогдолтой байсан тухай ярилц. Тэд судруудыг хэрхэн ашиглаж байсан тухай дүрсэлдэг ишлэлүүдийг ол.
- Алма 11–14-ийг хамтрагчтайгаа уншихдаа, нэг нь Алма буюу Амюлекийг, нөгөө нь буруутгагчдыг орлон тогло. Хэцүү асуултуудад эдгээр номлогч нар хэрхэн хариулсныг ажигла.
- Дараах үнэн шастирыг уншиж, Мормоны Номны ач холбогдол болон хүчний талаар юу мэдсэнээ ярилц (нэрсийг өөрчилсөн байгаа).

“Бид Снайдерынхныг баптисм хүртэж, гишүүнээр батлуулахыг урихад Снайдер Эгч бэлэн байсан боловч, Снайдер Ах, ‘Хэтэрхий их найдах хэрэггүй. Би ер нь үүнийг хийж чадахаа мэдэхгүй л байна шүү, Ахлагч нар аа!’ гэх нь тэр. Снайдер Ах бидний заасан зүйлийг хүлээн авч, зөлдөг, нөхөрсөг байсан хэдий ч, түүнийг өөр сүмд нэгдэх тухайд гэр бүл нь хэрхэн хариу үйлдэл үзүүлэх тухайд санаа нь гүнээ зовсон байлаа.

“Снайдер ахыг өөртэйгөө хэдэн долоо хоног тэмцсэнийг харсны дараа, миний хамтрагч бид хоёр 3 Нифай 11-ийг Снайдерынхантай хамт дахин уншъя гэж бодлоо. Тэр орой юу болсныг би хэзээ ч мартажгүй. Бид Мормоны Номыг нээхэд, “Та санаж байгаа байх, энэ бүлэг Мормоны Номон дахь хүмүүст Аврагч айлчилсан тухай өгүүлдэг шүү дээ. Эндээс бид эдгээр хүмүүсийг хайрлах Аврагчийн хайр болон Тэрээр тэдэнд юу заасан тухай уншъя. Бид ээлжлэн нэг юм уу хоёр шүлэг” уншив. Шүлэг 5-ыг дуустал уншсаны дараа, миний хамтрагч үгээ тасалж, ‘Энд тэдний сонссон дуу хоолойны талаарх дүрслэл надад үргэлж гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг. Тэр дуу хоолой хахир хатуу биш, чанга биш атлаа намуухан байлаа, энэ нь тэдэнд хүчирхэг, нэвт хатгах мэт нөлөө үзүүлсэн юм. Энэ дуу хоолойг тэд чихээрээ сонссон төдийгүй, харин энэ нь тэдний зүрх сэтгэлд ярьсан юм’ гэж хэлэв. Снайдерынхан миний хамтрагчийг үнэн сэтгэлээсээ сонсож байхыг би харав.

“Залбирлын тухай, мөн Сүнсийг сонсох тухай хэсэг ярилцсаны дараа Снайдер ахын унших ээлж болж, ‘Мөн болгоогтун, гурав дахь удаад нь тэд сонссон дуу хоолойгоо ойлгосон болой; мөн энэ нь тэдэнд хэлэв: Миний Хайрт Хүүг, миний ихэд таалсан түүнийг, би өөрийнхөө нэрийг алдаршуулсан түүнийг болгоогтун— та нар түүнийг анхаарагтун’ гэж уншив. Снайдер Ах өөрийнхөө Мормоны Номыг зориуд нэг хараад зогсолт хийв. Тэгээд тэр над уруу харж, ‘Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүүгээр үнэхээр бахархсан байгаа биз, тийм үү?’ гэж хэллээ. ‘Тийм ээ’ гэж би хэлэв. Снайдер Ах номоо эргэж дахин нэг хараад тэрээр гүн бодолд автах мэт номны нээлттэй хуудсуудыг ширтэн байлаа. Эцэст нь тэр, ‘Тэнгэрлэг Эцэг бас надаар бахархаасай гэж би хүсч байна. Тэр намайг яаж танилцуулах бол гэж би гайхаж байна. Хэрэв би . . . тийм ээ, хэрэв би түүнийг надаар бахархахыг хүсэх юм бол, надаар хийлгэхийг Түүний хүсдэг тэр зүйлийг би илүү сайн хийх сэн’ гэж хэллээ. ‘Тийм ээ, ингэх нь чухал гэж би бодож байна’ гэж би хариулав. ‘Тийм ээ,’ гэж Снайдер Ах үргэлжлүүлээд, ‘Бусад хүн бүр юу боддог болон Бурханы боддог зүйлийн талаар тэд хангалтгүй боддог тухайд миний сэтгэл нэн их зовдог гэж би боддог л доо’ гэв. Хэсэгхэн зуур дуугүй байсны дараа Снайдер Ах толгой дохиж, шийдсэн байдалтай харцаар, ‘Би баптисм хүртэх нь дээр гэж бодож байна’ гэж хэллээ. Түүний хариулт огт санамсаргүй байсан болохоор хамтрагч бид хоёр түүнийг цоо ширтэн харж байв. Эцэст нь, ‘Тийм энэ бол хийх ёстой зөв зүйл мөн. Үнэндээ бол, энэ бүлэгт арай хожуухан Аврагч заах даа . . .’ хэмээн миний хамтрагч өгүүлэв. Хамтрагчийгаа ярьж байх зуур, зүрх сэтгэлд минь шатах мэт болж, Мормоны Номны хүчинд талархах сэтгэл төрөв.”

Эдгээр номлогч нар Мормоны Номыг хэрхэн ашигласан бэ? Та болон таны хамтрагч номлолынхоо хүчин чармайлтад үүнийг хэрхэн илүү үр ашигтайгаар ашиглах вэ?

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Энэ бүлгийн гол толгой гарчгуудад дурдсан арга замууд тус бүрт Мормоны Номыг ашиглах дадлага хий.
- Сонирхогчдын тавьсан асуултууд болон эсэргүүцлүүдийг жагсаа. Мормоны Номыг ашиглан эдгээр асуултуудад хэрхэн хариулахаа бие биендээ тайлбарла.
- Мормоны Номны хэсгүүдийг хамт унш. Мэдлэг, бодол санаанууд болон гэрчлэлээ хуваалц.
- Сэргээлтийн захиасыг батлахын тулд Мормоны Номыг ашиглах дадлага хий.
- Мормоны Номын агуу бошиглогчдын нэгийг сонго. Энэ номлогчийн зан чанаруудыг номлогч нараар жагсаан бичүүлж, ярилц. Эдгээр зан чанаруудын нэгийг хэрэглэх зорилго дэвшүүлэхэд номлогч бүрийг урь. Мормоны Номны бошиглогчдыг тогтмол ашиглан энэ үйл ажиллагааг давт.
- Хөрвүүлгийн үйл явцад сонирхогчдод нь Мормоны Ном тусалсан туршлагауудыг хуваалцахад номлогч нарыг урь.
- Бодгалийн тухай асуултад хариулах Мормоны Номны шилдэг хариуг номлогч нараар хуваалцуул.

Номлолын Ерөнхийлөгч

- Сэргээлтийн захиасын үнэнийг батлахын тулд Мормоны Номыг хэрхэн ашиглах тухай номлогч нарт заа.
- 1 Нифай 1-ийг сонирхогчидтой хамт уншиж үүнийг Иосеф Смитийн туршлагатай харьцуул.
- Мормоны Номны нимгэн хавтастай цэвэрхэн хувиар номлогч нарыг ханга. Тэдгээрт доорх зүйлүүдийг өөр өөр өнгөөр тусгайлан тэмдэглүүл:
 - Есүс Христийн тухай ишлэл бүрийг (Түүний аливаа нэрс буюу түүнд хамаарах биеийн төлөөний үгсийг).
 - Түүний үгсийг (Түүгээр өөрөөр нь буюу бошиглогчдоор, “Их Эзэн ийнхүү хэлдэг” гэж хэлснийг).
 - Түүний хандлагуудыг.
 - Мормоны Номонд агуулагддаг сургаалууд болон зарчмуудыг.

Хуудас бүрийн төгсгөлд иш татагдсан зүйлүүдийн нийт тоог тоолж гаргахыг номлогч нараас хүс. Ярилцлагуудад болон дүүргийн хурлуудын үеэр хоёр буюу гурван сарын хугацаанд энэ үйл ажиллагаанд зориулан, сурсан зүйлийг нь номлогч нараар бие биентэй нь хуваалцуул. Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг буюу сайн мэдээний аливаа суурь зарчмуудын тухай онцлон тэмдэглэсэн ишлэлүүдийг нийт номлолд зориулж хийх үүнтэй төстэй үйл ажиллагаанд ашиглахыг та анхаарч болно.

- Ярилцлагуудын үеэр амьдралыг нь өөрчилсөн Мормоны Номны судруудаас өөртэйгөө хуваалцахад номлогч нарыг урь.
- Мормоны Ном номлогчийн хичээлүүдээс сургаалуудыг хэрхэн заадгийг харахад нь номлогч нарт тусал. Жишээ нь, хэрэв сэдэв нь Цагаатгал байсан бол, Мормоны Номонд заагддаг Цагаатгалын гол чухал элемент бүрийг, түүний дотор үүний ишлэлүүдийг номлогч нараар нэг багананд

Тэмдэглэл

бичүүл. Дараа нь, хоёр дахь багананд мөн нөгөөх элементүүдийг хажуу талд нь тэднээр бичүүл. Библид байхгүй буюу заагдаагүй элементүүдийг номлогч нараар хоосноор нь үлдээлгэ. Энэ нь Мормоны Ном хэрхэн манай сургаалын шаантаг чулуу байдгийг номлогч нар нотлох чухамхүү тэр нотолгоо болох болно. Мөн ийм үйл ажиллагааг номлогч нарын заадаг бусад сургаалуудын хувьд хийж болно.

- Танай номлол дахь хүмүүсийн хувьд бодгалийн тухай байнгын асуултууд юу байхыг тогтоо. Хариултуудыг Мормоны Номноос олоход номлогч нарыг урь.



Христийнхтэй Адил Зан Чанаруудыг Би Хэрхэн Хөгжүүлэх Вэ?

Тэмдэглэл

Үүнийг Анхаар

- Есүс Христийн сайн мэдээний илүү хүчирхэг хийгээд идэвхтэй тохинуулагч болгох зан чанаруудыг би хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлэх нь номлогчийн хувиар зорилгуудаа биелүүлэхэд минь надад хэрхэн туслах вэ?
- Ямар зан чанарыг би илүүтэй хөгжүүлэх хэрэгтэй вэ?

Мөнх бус амьдралынхаа тохинууллын эхэнд Есүс Христ Галилын тэнгисийн эргээр алхаж мөн Андрей, Петр хэмээх хоёр загасчинг дууджээ. “Намайг дага, Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно” (Матай 4:19; мөн Марк 1:17–г үз) хэмээн Тэр хэлжээ. Түүнчлэн Их Эзэн Өөрийнхөө ажилд таныг дуудсан бөгөөд Өөрийгөө дагахыг Тэрээр танаас хүсч байна. Христийг дага гэсэн урилга нь Түүний үлгэр жишээг дагаж, мөн Түүнтэй адил бол гэсэн урилга юм.

“Миний Сайн Мэдээг Номло” доторх зарим бүлгүүд—хэрхэн судлах, хэрхэн заах, хэрхэн цагаа зөв ашиглах зэрэг номлогчийн хувиар таны юу хийх хэрэгтэйд төвлөрсөн байдаг. Хэдий тийм ч, та юу хийх нь маш чухлын адилаар та хэн байх нь мөн чухал юм.

Сэргээгдсэн сайн мэдээ таныг Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй адил болох боломжтой болгоно. Аврагч уг замыг үзүүлсэн билээ. Тэрээр төгс жишээ үзүүлсэн юм, мөн Тэрээр Өөртэйгөө адил болохыг бидэнд зарлигласан билээ (3 Нифай 27:27). Түүнээс суралц мөн Түүний зан чанаруудыг амьдралынхаа нэг хэсэг болгохыг

эрэлхийл. Түүний Цагаатгалын хүчээр та энэ зорилгодоо хүрч, бусдыг үүнд хүрэхэд удирдаж чадна.

Та номлогчийн хувиар мөн амьдралынхаа турш Христийнхтэй адил зан чанарыг аажмаар хөгжүүлэх нь нэн чухал хэмээн судруудад дүрсэлжээ. Энэ бүлэг дэх судрын хэсгүүдийг судалж мөн бусад судрын хэсгүүдийг судлахдаа Христийнхтэй адил зан чанарын жишээг эрэлхийл.

Христийнхтэй адил зан чанар нь Бурханы бэлэг юм. Тэдгээр нь таныг сонголтоо зөв шударгаар ашиглах үед ирдэг. Эдгээр зан чанаруудаар адислахыг Тэнгэрлэг Эцэгээсээ хүс; Түүний тусламжгүйгээр тэдгээрийг та хөгжүүлж чадахгүй. Бурханы тааллыг хүртэх хүсэлтэйгээр сул дорой байдлаа ухамсарлан, илүү сайн болох чинхүү хүсэлтэй болно.

Судар Судлах

Есүс Христийн жишээг дагах талаар эдгээр судрууд юу өгүүлдэг вэ?

3 Нифай 12:48

Иохан 13:1–16

1 Петр 2:21

3 Нифай 27:21, 27

Сайн мэдээний анхны зарчмууд, Христийнхтэй адил зан чанар хоёр хоорондоо ямар холбоотой вэ?

Моронай 8:25–26

Энэ Бүлгийг Судлахад Зориулсан Санаанууд

Энэ бүлгийг судлахад зориулсан олон арга зам байдаг. Доорх санаануудаас нэгийг хий:

- Энэ бүлгийн төгсгөлд байгаа “Зан Чанарын Үйл Ажиллагаа” биелүүлэхдээ өөрт тань хамгийн хэрэгтэй эсвэл хөгжүүлэхийг хүсч байгаа зан чанаруудаа тодорхойл. Тухайн зан чанарын талаар өгүүлэх хэсгийг судалж, түүнийгээ хөгжүүлэх зорилго тавь.
- Судраас суралцалгүйгээр бүлгийг уншаад ямар зан чанарын талаар илүү судлахыг хүсч байгаагаа олж тогтоо. Дараа нь уг зан чанартай холбоотой гол судруудыг судал. Уг зан чанарын талаар заадаг, энэ бүлэгт ороогүй нэмэлт судруудыг эрж ол. Уг зан чанарыг хөгжүүлэхэд зориулсан санаануудыг судлах тэмдэглэлдээ тэмдэглэ.
- Судлахыг хүсч байгаа зан чанараа олж тогтоо. Энэ бүлгийн төгсгөл дэх “Христийнхтэй Адил Зан Чанарыг Хөгжүүлэх нь” гарчигт байгаа загварыг дага.

Есүс Христэд Итгэх Итгэл

Христэд итгэх итгэлтэй байвал, Тэрээр Бурханы Хүү, Эцэгийн Махан Биед Төрсөн Ганц гэдэгт итгэнэ. Та Түүний Аврагч, Гэтэлгэгч гэдгийг хүлээн зөвшөөрч мөн Түүний заасан зүйлсийг дагах болно. Түүний Цагаатгалаар дамжин гэм нүглүүд тань өршөөгдөнө гэдэгт та итгэнэ. Түүнд итгэнэ гэдэг нь та Түүнд итгэж, Тэрээр танд хайртай гэдэгт итгэлтэй байна гэсэн үг юм.

Итгэл нь наманчлах, дуулгавартай дагах, мөн бүхнээ зориулсан үйлчлэл зэрэг үйлдэл рүү хөтөлдөг. Есүс Христэд итгэх итгэлтэй байхдаа, хэдийгээр учир шалтгааныг нь бүрэн ойлгохгүй байгаа ч, Түүний зарлигуудыг дагахуйц хангалттайгаар Их Эзэнд итгэх болно. Биелүүлэхийг тань Их Эзэн хүссэн тэр зүйлийг та биелүүлэх болно. Өөрсдийнхөө амьдралд болон бусдын амьдралд сайныг авчрахад та туслах болно. Их Эзэний хүсэл зоригийн дагуу гайхамшгуудыг үйлдэх чадвартай байна. Хичээнгүй байдал хийгээд үйлсээр таны итгэл илэрхийлэгдэх болно.



© 1989, Cornerstone Unlimited Investments, Inc. Хувиан олшруулж болохгүй.

Итгэл бол хүч чадлын зарчим юм. Бурхан хүч чадлаар ажилладаг, харин Түүний хүч чадал ихэнхдээ итгэлд хариулснаар хэрэгждэг (Моронай 10:7-г үз). Тэрээр Өөрийнхөө хүүхдүүдийн итгэлээр дамжин ажилладаг. Эргэлзээ болон айдас нь итгэлд харш юм.

Таны итгэл хичээнгүй судалгаа, залбирал, бүхнээ зориулсан үйлчлэл болон Ариун Сүнсний өдүүлбэр хийгээд зарлигуудад дуулгавартай байсны улмаас өсөн нэмэгдэх болно.

Есүс Христэд итгэх итгэл тань та Түүнийг болон Түүний заасан зүйлсийг илүү танин мэдэх тусам өсөн нэмэгдэх болно. Судруудыг шинжлэн судалж мөн тэдгээрийг эрэлхийлснээр та Түүний замууд, бүх хүмүүст зориулсан Түүний хайр, Түүний зарлигуудыг сурах болно.

Ариун Сүнсний үүрэг болон хүч чадалд итгэлтэй байх нь итгэлд багтдаг. Итгэлээр дамжуулан та залбирлууддаа хариулт мөн Их Эзэний ажилд таныг удирдах хувийн сүнслэг урмыг хүлээн авна.

Судар Судлах

Итгэл гэж юу вэ?

Алма 32:21
Ифэр 12:6

Еврей 11:1; зүүвэр тайлбар 6-г үз
Guide to the Scriptures, "Faith"

True to the Faith, "Faith," 52-54

Итгэлийг хэрхэн олж авах вэ, мөн итгэлээр дамжуулан та юу хийж чадах вэ?

2 Нифай 25:29
2 Нифай 26:13
Мозая 4:6-12

Алма 32
Хиламан 15:7-8
Ифэр 12:7-22

Моронай 7:33
Ром 10:17
Еврей 11

Итгэлээр дамжин ямар адислалууд ирдэг вэ?

Мозая 3:17
Мозая 5:1-15

Хиламан 5:9-12

Иохан 14:6

Найдвар

Найдвар бол Их Эзэн танд зориулсан Өөрийнхөө амлалтуудыг гүйцэлдүүлнэ гэсэн тогтвортой итгэл юм. Энэ нь итгэл, өөдрөг үзэл, урам зориг болон цөхрөшгүй тэвчээрт илэрдэг. Энэ нь ямар нэг зүйл тохиолдоно гэдэгт итгэх итгэл мөн хүсэн хүлээх хүлээлт юм. Найдвартаа байвал та зовлон зүдгүүр хийгээд хүнд хэцүү үед ажиллахдаа бүх зүйлс хамтдаа таны сайн сайхны төлөө ажиллах болно

Тэмдэглэл

гэдэгт итгэнэ. Урам хугарах явдлыг ялан дийлэхэд тань танд найдвар тусална. Есүс Христэд найдах найдвар нь сэлэстиэл хаант улсад мөнх амьдралыг өвлөнө гэсэн итгэл найдвар юм гэдгийг судруудад олонтаа дүрсэлдэг.

Ерөнхийлөгч Жеймс И.Фауст заахдаа:

“Найдвар бол бодгалийн маань зангуу юм . . .

“Найдвар бол Бурханы амлалтуудад итгэх итгэл юм, хэрэв бид үйл хөдлөлөөрөө үзүүлэх итгэлтэй бол бидний хүсч байгаа адислалууд ирээдүйд биелэх болно. . . .

“Найдварын маань бүтэлгүйтэхгүй эх сурвалж бол бид Бурханы хөвгүүд охид мөн Түүний Хүү Их Эзэн Есүс Христ биднийг үхлээс аварсан явдал юм” (“Hope, an Anchor of the Soul,” *Ensign*, 1999 оны Арваннэгдүгээр сар, 59–60).

“Найдвараар адислагдсан бид бүгдээрээ аливаа шалтгаанаар ‘сайн мэдээний найдвараас хөдөлсөн’ бүх хүмүүст хүрч тусалцаая (Колосай 1:23). Ямар ч найдваргүйгээр доош унжсан гаруудыг татан авахаар гараа сунгацгаая.”

–АХПАГЧ НИП А.МАКСВЕЛЛ
“BRIGHTNESS OF HOPE,” *ENSIGN*, 1994 ОНЫ
АРВАННЭГДҮГЭЭР САР, 36

Судар Судлах

Найдвар гэж юу вэ мөн бид юунд найддаг вэ?

2 Нифай 31:20

Моронай 7:40–48

Ром 8:24–25

Алма 58:10–11

С ба Г 59:23

Еврей 6:10–20

Ифэр 12:4, 32

С ба Г 138:14

Guide to the Scriptures, “Faith”

Энэрэл ба Хайр

Нэгэн хүн Есүсээс “Хууль дахь агуу тушаал нь аль вэ?” хэмээн асуужээ. Есүс хариулахдаа: “Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн. Удаахи нь Чи хөршөө өөрийн адил хайрла” гэжээ (Матай 22:36–39).

Энэрэл бол “Христийн цэвэр хайр” (Моронай 7:47) юм. Үүнд Өөрийнхөө бүх хүүхдүүдийн төлөөх Бурханы мөнхийн хайр багтдаг. Бид тийм төрлийн хайрыг хөгжүүлэхээр эрэлхийлэх ёстой.

Энэрлээр дүүрсэн үедээ та Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж, бусдад үйлчлэхийн тулд чадах бүхнээ хийж, сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь тэдэнд тусална.

Энэрэл бол Бурханы бэлэг юм. “Бид энэ хайраар дүүргэгдэж болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирах” (Моронай 7:48) ёстой хэмээн бошиглогч Мормон хэлжээ. Энэ зөвлөгөөг дагаж, зөв шударга үйлүүдийг үйлдэхийг хичээснээр бүх хүмүүст, ялангуяа таны дунд нь хөдөлмөрлөж буй



© 2001 Simon Dewey. Хувиан олшруулж болохгүй.

хүмүүсийн төлөөх таны хайр өсөн нэмэгдэх болно. Бусад хүмүүсийн мөнхийн халамж болон аз жаргалын талаар үнэн сэтгэлээсээ санаа зовних болно. Та тэднийг Тэнгэрлэг Эцэгтэй адил болох боломжтой Бурханы хүүхдүүд гэдгийг харж мөн та тэдний төлөө хөдөлмөрлөх болно. Уур, атаархал, хүсэл тачаал, эсвэл шунахай сэтгэл зэрэг эсрэг сэтгэгдлүүдээс зайлсхий. Бусдыг шинжин, тэднийг шүүж, эсвэл тэдний тааламжгүй зүйл ярихаас та зайлсхийх болно. Та тэднийг өөрсдийнх нь нүдээр харахыг хичээх болно. Та тэдэнд тэвчээртэй хандаж, зовж зүдрэн мөн сэтгэлээр унах үед нь тэдэнд туслахыг оролдох болно. Энэрэл нь итгэлтэй адилаар үйл хөдлөл рүү хөтөлдөг. Бусдад үйлчилж, мөн өөрийгөө зориулах боломжийг эрэлхийлснээр та энэрлийг хөгжүүлэх болно.

Судар Судлах

Энэрэл гэж юу вэ?

Моронай 7:45–48 1 Коринт 13 Guide to the Scriptures, “Charity”

Есүс Христ энэрлийг хэрхэн үзүүлсэн бэ?

1 Нифай 19:9 Ифэр 12:33–34 Лук 7:12–15
Алма 7:11–13

Эдгээр шүлгүүд энэрлийн талаар танд юу заадаг вэ?

2 Нифай 26:30 Алма 7:24 1 Тимот 4:12
Мозая 2:17 Ифэр 12:28 1 Петр 4:8; зүүвэр тайлбар а-г үз
Мозая 28:3 С ба Г 88:125

Ариун Нандин Чанар

Ариун нандин чанар нь таны дотоод сэтгэлийн бодлууд болон хүслүүдээс үүсдэг. Энэ бол ёс суртахууны өндөр жишиг дээр тулгуурласан бодол санаа болон зан авирын загвар юм. Ариун Сүнс цэвэр ариун бус табернеклд оршдоггүй учраас Сүнсний зааварчилгааг хүлээн авах ариун нандин чанарын шаардлагууд гэж бий. Ганцаараа мөн хэн ч хараагүй байхад юу сонгож юу хийх тань ариун нандин чанарын тань хамгийн хүчтэй хэмжүүр юм.

Ариун нандин чанартай хүмүүс сүнсний хувьд цэвэр мөн ариун байдаг. Тэд зөв шударга мөн сэтгэл сэргээх бодлуудад анхаарлаа хандуулж, зохимжгүй үйлдэл уруу хөтлөх зохисгүй бодлуудыг толгойноосоо авч хаядаг. Тэд Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж, Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дагадаг. Тэд уруу таталтыг эсэргүүцэх хүч болон зөв зүйлийн төлөө залбирдаг. Аливаа нүгэл болон буруу хийсэн зүйлээ тэд маш хурдан наманчилдаг. Тэд ариун сүмийн эрхийн бичиг авахад зохистойгоор амьдардаг.

Таны оюун санаа бол театрын тайзтай яг адил боловч нэг удаад зөвхөн нэг жүжигчин тайзан дээр байж болно. Хэрэв тайзны зүүн тал хоосон бол харанхуйн болон нүгэлт бодлууд уруу татахын тулд тайзан дээр ойр ойрхон гарч ирдэг. Гэвч оюун санаа тань цээжилсэн сүмийн дуулал эсвэл судрын шүлэг гэх мэт сайн сайхан бодлуудаар дүүрсэн бол та уруу татагдах тэр мөчдөө үүнийгээ дуудаж болно. Оюун санааныхаа тайзыг хянаснаар уруу таталтанд бууж өгөх байнгын шаардлага болон нүглийг өөгшүүлэх байдлыг амжилттай эсэргүүцэж чадна. Та цэвэр мөн ариун нандин чанаруудтай болж чадна.

Судар Судлах

Ариун нандин чанартай байна гэдэг нь ямар утгатай вэ?

С ба Г 4:6

С ба Г 46:33

2 Петр 1:3–8

С ба Г 25:2

С ба Г 121:45–46

Guide to the Scriptures, "Virtue"

С ба Г 38:24

Итгэлийн Тунхаг 1:13

Мэдлэг

“Судлахаар мөн түүнчлэн итгэлээр суралцахыг эрэлхийл” (С ба Г 88:118) хэмээн Их Эзэн зарлиглажээ. Мөн түүнчлэн “Юу ч мэдэхгүйгээр аврагдах нь хүмүүний хувьд боломжгүй юм” (С ба Г 131:6) хэмээн Тэрээр сэрэмжлүүлжээ. Мэдлэгийг тэр тусмаа сүнслэг мэдлэгийг эрэлхийл. Судраас өдөр бүр судал мөн түүнчлэн амьд бошиглогчдын үгсийг судал. Судалгаа болон залбирлаар дамжуулан тодорхой нэг асуулт, шалгуур болон боломжуудад тусламж эрэлхийл. Судрын хэсгүүдэд онцгой анхаар, ингэснээр та сэргээгдсэн сайн мэдээний талаар зааж мөн үүний талаарх асуултуудад хариулахдаа ашиглаж болно.

Сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрхэн ашиглаж болох талаар бод. Та хичээнгүйлэн, залбиралтайгаар мөн цэвэр хүсэлтэйгээр судлах аваас Ариун Сүнс оюун санааг тань гэгээрүүлж, мөн зааж, мөн судрууд болон амьд бошиглогчдын заасан зүйлсийн утгыг ойлгоход тусалдаг. Бусад хүмүүсийг, ялангуяа Сүмийн удирдагчдыг харж, сонссоноор та мэдлэгээ арвижуулах болно. Нифайн адил та “Дотоод сэтгэл минь судруудад баясана, мөн зүрх минь тэдгээрийг тунгаадаг . . . Болгоогтун, сэтгэл минь Их Эзэний зүйлүүдэд баясч; мөн зүрх минь өөрийн үзсэн мөн сонссон зүйлийг үргэлж тунгаадаг” (2 Нифай 4:15–16).

Судар Судлах

Мэдлэг нь Их Эзэний ажлыг хийхэд хэрхэн тусалдаг вэ?

Алма 17:2–3

С ба Г 88:77–80

Мэдлэгийг хэрхэн олж авах вэ?

2 Нифай 32:1–5

С ба Г 42:61

С ба Г 88:118

Моронай 10:5

С ба Г 76:5–10

Guide to the Scriptures, "Knowledge"

Тэвчээр

Тэвчээр нь саад, зовлон зүдгүүр, эсэргүүцэл, эсвэл шаналлыг уурлаж, сэтгэлээр унаж, эсвэл айдас түгшүүргүйгээр даван туулах боломж юм. Энэ нь Бурханы хүсэл зоригийн дагуу үйлдэж мөн Түүний цаг хугацааг хүлээн зөвшөөрөх чадвар юм. Тэвчээртэй байснаар та зовлон зүдгүүрт тэсвэртэй байж, өрсөлдөгчтэй тайвнаар мөн найдвартайгаар тулгарах

“Амьдрал бэрхшээлээр дүүрэн байдаг бөгөөд зарим нь жижиг, зарим нь маш ноцтой байдалтай байдаг. Хүн бүрт зориулсан сорилтууд нь хангалттай, төгсөшгүй мэт санагддаг. Тэвчээртэй байдлын тэнгэрлэг ариун нандин чанар байнга шаардагддагийг мартсанаас асуудлуудаа бид маш хурдан шийдэх гэж хүсэн хүлээдэг.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ ТОМАС С.МОНСОН

"PATIENCE—A HEAVENLY VIRTUE," ENSIGN, 1995 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САР, 59

боломжтой байна. Тэвчээртэй байдал нь найдвар болон итгэлтэй холбоотой бөгөөд та Их Эзэний амласан адислалууд биелэгдэхийг хүлээх ёстой.

Та өдөр тутмын явдлууд болон харилцаандаа ялангуяа хамтрагчтайгаа тэвчээртэй хандах хэрэгтэй. Та бүх хүмүүстэй, тэр тусмаа алдаа мөн сул дорой байдал дээрээ ажиллахдаа тэвчээртэй байх ёстой.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

- Мозая 28:1–9-ийг судал. Мозаягийн хөвгүүдийн хүсэл юу байсан бэ?
- Тэдгээр номлогч нарт Их Эзэн юу зөвлөсөн бэ? (Алма 17:10–11 мөн 26:27–г үз)
- Тэдний тэвчээртэй байдал болон хичээл зүтгэлийн зарим үр дүн юу байсан бэ? (Алма 26-г үз)
- Судлах тэмдэглэлдээ хариултаа бич.

Судар Судлах

Тэвчээртэй байдал яагаад чухал вэ? Тэвчээртэй байдал болон итгэл хэрхэн холбоотой вэ?

Мозая 23:21

Алма 34:40–41

2 Коринт 6:1–10

Мозая 24:9–16

С ба Г 101:38

Иаков 5:10–11

Алма 31:31

Ром 5:3–5

Дуулал 46:10

Алма 32:41–43

Ром 8:24–25

Guide to the Scriptures, "Patience"

Даруу Байдал

Даруу байдал бол Их Эзэний хүсэл зоригийг нэгдүгээрт тавьж мөн гүйцэлдүүлсэн зүйлийнхээ төлөө Их Эзэнд хүндлэлийг өгөхөд бэлэн байх нь юм. Үүнд Түүний адислалуудад талархах мөн Түүний бурханлиг тусламж бидэнд байнга хэрэгтэйг ойлгох нь багтдаг. Даруу байдал нь сул дорой байдлын тэмдэг биш; энэ нь сүнслэг хүч чадлын тэмдэг юм. Түүнд даруухнаар итгэж, Түүний хүч болон нигүүлслийг ойлгохдоо та Түүний зарлигууд өөрийн тань сайн сайхны төлөө гэдэгт итгэлтэй байх болно. Түүнд найдсанаар та Их Эзэний шаардсан аливаа зүйлийг хийж чадна гэсэн итгэлтэй байх болно. Түүнчлэн Түүний сонгосон үйлчлэгчдэд итгэж, тэдний зөвлөгөөг дагахад та бэлэн байна. Дуулгавартай байж, хичээнгүй ажиллаж, аминч үзэлгүйгээр үйлчлэхэд тань даруу байдал танд туслах болно.

Даруу байдлын эсрэг тал бол судруудад буруушаасан бардамнал юм. Бардам зантай байх гэдэг нь Бурхан эсвэл Түүний үйлчлэгчдээс илүүтэйгээр өөртөө агуу ихээр итгэх гэсэн утгатай. Энэ нь түүнчлэн дэлхийн зүйлсийг Бурханы зүйлсээс дээгүүрт тавих гэсэн утгатай юм. Бардам хүмүүс Бурханд алдар сууг өгөхөөс илүү өөртөө алдар хүндийг авахыг хичээдэг. Бардамнал бол өрсөлдөгч юм; бардам хүмүүс илүү их зүйлтэй байхыг эрэлхийлж, мөн өөрсдийгөө бусдаас илүүд



тооцдог. Бардамнал нь уур болон үзэн ядах сэтгэлийн үр дүн бөгөөд энэ бол агуу тээглэх чулуу юм.

Судар Судлах

Даруу байх гэдэг нь ямар утгатай вэ?

2 Нифай 9:28–29

Алма 5:26–29

Матай 26:39

Мозая 4:11–12

Алма 26:12

Guide to the Scriptures, “Humble, Humility”

Өөрийгөө даруусгаснаар та ямар адислалуудыг хүлээн авдаг вэ?

Алма 32:1–16

С ба Г 67:10

Матай 23:12

Ифэр 12:27

С ба Г 112:10

С ба Г 12:8

С ба Г 136:32–33

Өөрсдийнхөө бардам байдлыг хэрхэн танин мэдэж чадах вэ?

1 Нифай 15:7–11

2 Тимот 3:1–4

Сургаалт үгс 15:10

1 Нифай 16:1–3

Сургаалт үгс 13:10

Сургаалт үгс 28:25

Хичээнгүй Байдал

Хичээнгүй байдал бол Их Эзэний ажлыг хийх бат бөх, тогтвортой, ул суурьтай, идэвхтэй хүчин чармайлт юм. Хичээнгүй—шургуу мөн агуу хүчин чармайлттай мөн халамжтай ажиллахыг Их Эзэн танаас хүсэн хүлээдэг. Хичээнгүй номлогчийн ажлууд хичээл зүтгэлтэй мөн үр дүнтэй байдаг. Номлогчийн ажил дахь хичээнгүй байдал нь Их Эзэн болон Түүний ажлыг хайрлах бидний хайрын илрэл юм. Хичээнгүй байснаар өөрийнхөө ажилд баяр баясал болон сэтгэл ханамжийг та олох болно.

Хүсэл зоригийнхоо дагуу олон сайн сайхан зүйлсийг хий (С ба Г 58:27–г үз). Юу хийхийг удирдагч нар тань хэлэхийг бүү хүлээ. Хэдийгээр ядарсан ч гэсэн өөрийнхөө чадах бүхнийг хийж дуустлаа үргэлжлүүл. Хамгийн чухал зүйлд анхаарлаа хандуулж, цаг дэмий үрэхээс зайлсхий. Зааварчилгаа болон хүч чадлын төлөө залбир. Тогтмол мөн үр дүнтэйгээр төлөвлө. Санаа бодлууд, эсвэл үйлүүдийг тань үймүүлэх аливаа зүйлээс зайлсхий.

*“Номлогчийн ажлын хамгийн агуу нууцуудын нэг бол ажил хэмээн би олонтаа хэлж байсан!
Хэрэв номлогч ажиллавал,
тэрээр Сүнстэй байх болно;
хэрэв тэрээр Сүнстэй байвал
тэрээр Сүнсээр заах болно;
хэрэв тэрээр Сүнсээр заах аваас
хүмүүсийн зүрх сэтгэлд тэрээр
хурч мөн аз жаргалтай байх болно.
Ямар ч гэрээ санаж, гэр бүлийнхээ
төлөө санаа зовох асуудалгүй байх
болно, учир нь бүх цаг, авьяас
болон сонирхол нь тохинуулах
ажилд төвлөрөх болно.
Ажил, ажил, ажил—ялангуяа
номлогчийн ажлыг солих ямар
ч хангалттай зүйл үгүй.”*

—ЕРӨНХИЙПӨГЧ ЭЗРА ТАФТ БЕНСОН
THE TEACHINGS OF EZRA TAFT BENSON (1988), 200

Судар Судлах

Хичээнгүй байх гэдэг нь ямар утгатай вэ?

Моронай 9:6
С ба Г 10:4

С ба Г 107:99–100

Guide to the Scriptures, “Diligence”

Хичээнгүй байхыг Их Эзэн яагаад танаас хүсэн хүлээдэг вэ?

С ба Г 75:2–5
С ба Г 123:12–14

С ба Г 127:4

С ба Г 130:20–21

Хичээнгүй байдал нь сонгох эрхтэй хэрхэн холбоотой вэ?

Мозая 4:26–27

С ба Г 58:26–29

Дуулгавартай Байдал

Номлогчийн хувьд, зарлигуудыг дуулгавартай сахиж, номлолын дүрмүүдийг дагаж, мөн удирдагчдынхаа зөвлөгөөг дагахыг танаас хүсэн хүлээдэг. Дуулгавартай байдал бол тэнгэрийн хамгийн эхний хууль юм. Энэ нь итгэлийн үйлдэл юм. Зарим тохиолдолд бүрэн ойлгохгүй байгаа зүйлийг хийхийг танаас шаарддаг. Дуулгавартай дагаснаар таны итгэл, мэдлэг, мэргэн ухаан, гэрчлэл, хамгаалалт, мөн эрх чөлөө өсөн нэмэгдэх болно. Их Эзэн, амьд бошиглогч, мөн номлолын ерөнхийлөгчөө дуулгавартай дагахыг эрэлхийл.

“Сахилга баттай байхад өдөр тутмын дуулгавартай байдал, цэвэр ариун амьдрах мөн мөнх бус амьдралын турш саад болох уруу таталтуудаас хамгаалж мөн аюулгүй байлгахын тулд таны эргэн тойронд баригдах сайхан амьдрал багтдаг.”

–АХПАГЧ Л.ТОМ ПЕРРИ

“CALLED TO SERVE,” *ENSIGN*, 1991 ОНЫ ТАВДУГААР САР, 39

Судар Судлах

Дуулгавартай байх гэдэг нь ямар утгатай вэ?

1 Нифай 2:3
Мозая 5:8
Мозая 15:7

С ба Г 82:8–10
Матай 7:24–27
Иохан 7:17

Иохан 14:15
Guide to the Scriptures, “Obedience, Obedient, Obey”

Эдгээр судруудаас дуулгавартай байдлын талаар та юу сурч чадах вэ?

1 Нифай 3:7

С ба Г 105:6

Хаадын дэд 5:1–14

Хиламаны их цэргийн залуу дайчид яагаад яг таг дуулгавартай дагасан бэ? Тэд хэрхэн адислагдсан бэ?

Алма 56:45–48

Алма 57:21–27

Христийнхтэй Адил Зан Чанарыг Хөгжүүлэх нь

Энэ бүлэгт дүрсэлсэн зан чанарууд болон судрууд дахь бусад зан чанаруудыг судалж мөн хөгжүүлэхээр эрэлхийлэхэд тань доорх загвар тусалж болох юм:

- Хөгжүүлэхийг хүсч байгаа зан чанарыг тодорхойлох.
- Уг зан чанарынхаа тодорхойлолт болон дүрслэлийг бич.
- Судалж байхдаа хариулах асуултуудыг тэмдэглэ.
- Зан чанарын талаар заадаг судруудын хэсгүүдийг жагсаан бичиж мөн судал.
- Өөрийн бодол санаа болон сэтгэгдлийг тэмдэглэ.
- Уг зан чанарыг амьдралдаа хэрэгжүүлэх зорилго тавьж мөн төлөвлөгөө гарга.
- Уг зан чанарыг хөгжүүлэхэд тань туслахын төлөө Их Эзэнд залбир.
- Зан чанар бүрийг хөгжүүлэх өсөлтөө тогтмол шалга.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Энэ бүлэг, эсвэл судруудаас зан чанаруудыг олж тогтоо. Зан чанарыг илүү сайн ойлгож мөн хөгжүүлэх төлөвлөгөө гаргахын тулд дээрх загварыг дага.

Нэрийн тэмдгийг хар. Нэрийн тэмдэг тань компаний ажилчны зүүдэг нэрийн тэмдэгээс хэрхэн ялгардаг вэ? Хамгийн чухал хоёр хэсэг бол өөрийн тань мөн Аврагчийн нэр болохыг анхаар. Шавь нарынх нь нэгний хувьд Аврагчийг төлөөлж байгаагаа та хэрхэн батлах вэ? Өөрийн тань нэр Аврагчийнхтай эерэг талаараа холбоотой байх нь хүмүүсийн хувьд яагаад чухал вэ? Судлах тэмдэглэлдээ бодлуудаа бич.



Судар Судлах

Судруудад ямар зан чанаруудыг жагсаасан байдаг вэ?

Мозая 3:19

С ба Г 121:41–45

Филиппой 4:8

Алма 7:23

Итгэлийн Тунхаг 1:13

2 Петр 1:5–8

С ба Г 4

Үүнийг Сана

- Та зүгээр нэг номлогчийн зүйлсийг *хийдэг* бус харин Христийнхтэй адил номлогч *байх* хэрэгтэй.
- Христтэй адил болохыг амьдралынхаа турш эрэлхийл.
- Нэг удаагийн нэг үйлдэл болон шийдвэрээр та Христийн жишээг дагаж—Түүний зан чанаруудыг хөгжүүл.
- Христийнхтэй адил болохоор өөрчлөгдөхөд итгэл, наманчлалыг хөгжүүлэх, гэрээнүүдийг сахих, Ариун Сүнсний өсөн нэмэгдэх хэмжүүрийг хүлээн авах, мөн эцсээ хүртэл тэвчих нь шаардагддаг.

Заах Санаанууд ба Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- Энэ бүлэгт өгүүлсэн зан чанаруудын нэгээр таван минутын яриа бэлтгэ.
- Судруудын Удирдамжийг ашиглан энэ бүлэгт дүрсэлсэн зан чанаруудыг Аврагч үлгэр жишээ болгон үзүүлсэн арга замуудыг эрж ол. Сурсан зүйлээ судлах тэмдэглэлдээ бич.
- Энэ бүлгийн төгсгөл дэх “Зан Чанарын Үйл Ажиллагааг” тогтмол бөглө.
- Энэ бүлэг дэх чанаруудыг олж тогтоо. Өөрөөсөө асуу.
 - Энэ зан чанарыг би хэрхэн хөгжүүлэх вэ?
 - Энэ зан чанарыг хөгжүүлэхийн тулд би зүрх сэтгэл, оюун ухаан, болон үйл хөдлөлдөө ямар өөрчлөлт хийх ёстой вэ?
 - Гэрээнүүдийг сахих нь энэ зан чанарыг хөгжүүлэхэд надад хэрхэн туслах вэ?
 - Энэ зан чанарыг хөгжүүлэх нь Ариун Сүнсэнд тэнцэхүйц болж, Есүс Христийн сайн мэдээний хүчирхэг тохинуулагч болоход надад хэрхэн туслах вэ?
- Судрууд дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амьдрал дахь Христийнхтэй адил зан чанарын жишээг ол. Өөрийнхөө сэтгэгдлийг судлах тэмдэглэлдээ бич.

Хамтрагчтайгаа Суралцах

- Номлогчийн номын сан дахь Христийнхтэй адил зан чанаруудын заалтуудыг судал.
- Өөр өөр зан чанаруудын хоорондох холбоо хамаарлыг ярилц. Жишээ нь:
 - Итгэл, хичээнгүй байдал хоёр ямар холбоотой вэ?
 - Даруу байдал, хайр хоёр аль талаараа холбоотой вэ?
 - Мэдлэг хэрхэн тэвчээрийг хүчирхэгжүүлэх вэ?

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Дүүргийн хурал болон бүсийн чуулганаас хэдэн өдрийн өмнө энэ бүлэг дэх, эсвэл судрууд дахь зан чанаруудаас нэгийг сонгоод өөрт нь тусалсан судруудыг оролцуулан таван минутын яриа бэлтгэхийг номлогч бүрээс хүс.

Хуралд хэдэн номлогч нарт өөрсдийнхөө яриаг хуваалцах цаг гарга.

- Номлогч нарыг гурван бүлэгт хуваагаад доорх даалгавруудыг тэдэнд өг:

Бүлэг 1: 1 Нифай 17:7–16–г уншаад доорх асуултуудад хариул:

- Нифай итгэлээ хэрхэн ашигласан бэ?
- Христийнхтэй адил ямар зүйлийг Нифай хийсэн бэ?
- Итгэлтэй байж, зарлигуудыг сахих аваас ямар амлалтуудыг Их Эзэн Нифайтай хийсэн бэ?
- Энэ шастир номлогчийн ажилд хэрхэн ашиглагдах вэ?

Бүлэг 2: Иаков 7:1–15–ыг уншаад доорх асуултуудад хариул:

- Шеремийн довтолгоог эсэргүүцэхэд Иаковын итгэл яагаад хангалттай байсан бэ?

Тэмдэглэл

- Шеремтэй ярьж байхдаа Иаков итгэлээ хэрхэн ашигласан бэ?
- Иаковын хийсэн үйлдлүүд хэрхэн Христийнхтэй адил байсан бэ?
- Иаковтай адилаар итгэлээ хөгжүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ?

Бүлэг 3: Иосеф Смит—Түүх 1:8–18-ыг уншаад доорх асуултуудад хариул:

- Ямар замаар Иосеф Смит Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлсэн бэ?
- Түүний итгэлийг хэрхэн сорьсон бэ?
- Христийнхтэй адил ямар зүйлийг тэр хийсэн бэ?
- Иосеф Смитийн үлгэр жишээг дагахын тулд бид юу хийж чадах вэ?

Бүлгүүд дууссаны дараа номлогч нарыг хамтад нь цуглуулаад ярилцсан зүйлсээ хуваалцахыг хүс.

- Өөр хүний итгэлээр дамжин адислагдаж мөн бурханлигаар нөлөөлөгдсөн тохиолдлоо хуваалц.
- “Зан Чанарын Үйл Ажиллагаа” номлогч нараар уншуул. Тэдний хариултыг бичиж болох хуудас цаасыг номлогч бүрт өг.

Цаасан дээрх ажлаа дуусахад нь тэднээс хувийн зорилго тавихыг урь.

Цаасан дээрх ажлыг биелүүлэхдээ юу мэдэрсэн болохыг хэдэн номлогчоос асуу.

Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлэх нь чухал болох талаар өөрсдийн гэрчлэлээ хуваалц.

Номлолын Ерөнхийлөгч

- Шинэ Гэрээн дэх дөрвөн Сайн Мэдээний нэгийг, эсвэл 3 Нифай 11–28-ыг уншихыг номлогч нараас хүс. Өөрсдөө хийж чадах Аврагчийн хийсэн тэр зүйлийг тэднээр доогуур нь зуруул.
- Номлогч нарт хичээнгүй байдлыг заахын тулд зорилго тавих болон хэрхэн төлөвлөхийг ашигла. Хүмүүст хандах хичээнгүй байдал нь хэрхэн хайрын илрэл болохыг үзүүл.
- Ярилцлага хийхдээ номлогч нартай хөгжүүлэхийг хичээж буй зан чанарынх нь талаар ярилц.
- Бүсийн чуулганаар, өөрсдийнх нь хүндэлдэг, хамтрагчид нь буй Христийнхтэй адил зан чанарын талаар ярихыг номлогч нараас хүс.

ЗАН ЧАНАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Доорх зүйлсийг анхааралтай унш. Хэлсэн үгс нь таны тухайд хэр үнэн болохыг шийдээд хариулах түлхүүрээс хамгийн тохирох түлхүүрийг сонго. Хэсэг бүр дэх өөрийн хариултыг судлах тэмдэглэлдээ бич. Сүнснэг өсөлт нь алгуур явц бөгөөд хэн ч төгс төгөлдөр биш тиймээс та зарим хэсэг дээр бусдаасаа илүү сайн үнэлгээтэй байх болно.

Хариулах Түлхүүр 1=хэзээ ч 2=заримдаа 3=ихэнхдээ 4=бараг ихэнхдээ 5=үргэлж

Итгэл

- ___ 1. Би Христэд итгэж, Түүнийг өөрийнхөө Аврагч хэмээн хүлээн зөвшөөрдөг. (2 Нифай 25:29)
- ___ 2. Бурхан надад хайртай гэдэгт би итгэдэг. (1 Нифай 11:17)
- ___ 3. Би Аврагчдаа, хүсэл зоригийг нь хүлээн зөвшөөрч мөн асуусан аливаа зүйлсийг нь хийхээр хангалттайгаар итгэдэг. (1 Нифай 3:7)
- ___ 4. Есүс Христийн Цагаатгалаар дамжин бүх нүглүүдээсээ өршөөгдөнө гэдэгт би баттай итгэдэг. (Инос 1:5–8)
- ___ 5. Залбирлынхаа хариултыг авахын тулд Христэд би хангалттай итгэдэг. (Мозая 27:14)
- ___ 6. Өдрийн турш би Аврагчийн тухай бодож, Тэрээр миний төлөө юу хийснийг санадаг. (С ба Г 20:77, 79)
- ___ 7. Өөрийнхөө амьдрал, эсвэл бусдын амьдралд сайн зүйлс тохиолдоход туслалахад хэрэгтэй итгэл надад бий. (Ифэр 12:12)
- ___ 8. Ариун Сүнсний хүчээр Мормоны Номыг үнэн гэдгийг би мэднэ. (Моронай 10:3–5)
- ___ 9. Түүний миний хийхийг хүссэн аливаа зүйлийг, хэрэв шаардлагатай бол бүр гайхамшиг үйлдэхийг гүйцэлдүүлэх хангалттай итгэл надад бий. (Моронай 7:33)

Найдвар

- ___ 10. Миний хамгийн их хүсч буй зүйл бол Бурханы сэлэстиэл хаант улсад мөнх амьдралыг өвлөх нь юм. (Моронай 7:41)
- ___ 11. Би номлолоо аз жаргалтай мөн амжилттай гүйцэтгэнэ гэдэгтээ итгэдэг. (С ба Г 31:3–5)
- ___ 12. Ирээдүйн талаар би амар амгалан болон өөдрөг байдлыг мэдэрдэг. (С ба Г 59:23)
- ___ 13. Хэзээ нэгэн цагт би Бурхантай хамт амьдарч, Түүнтэй адил болно гэдэгтээ гүнээ итгэдэг. (Ифэр 12:4)

Энэрэл ба Хайр

- ___ 14. Бусад хүмүүсийн мөнхийн халамж болон тэд аз жаргалтай байгаасай хэмээн би чин сэтгэлээсээ хүсдэг. (Мозая 28:3)
- ___ 15. Залбирахдаа би энэрэл—Христийн цэвэр ариун хайрыг гуйдаг. (Моронай 7:47–48)
- ___ 16. Би бусдын сэтгэлдлийг ойлгож мөн тэдний харсныг харахыг хичээдэг. (Иуда 1:22)
- ___ 17. Намайг гомдоож мөн намайг буруутгасан бусад хүмүүсийг би уучилна. (Ефес 4:32)
- ___ 18. Зовж зүдрэн, эсвэл сэтгэлээр унасан үед нь бусад хүмүүст туслахыг би хичээдэг. (Мозая 18:9)

- ___ 19. Боломжтой үедээ, би бусад хүмүүст хайртай бөгөөд тэдний төлөө санаа зовдог гэдгээ хэлдэг. (Пук 7:12–15)
- ___ 20. Би хүмүүст үйлчлэх боломжийг хайдаг. (Мозая 2:17)
- ___ 21. Хүмүүсийн талаар би эерэг зүйлсийг хэлдэг. (С ба Г 42:27)
- ___ 22. Хэдийгээр хүмүүстэй таарч тохирох нь хэцүү ч тэдэнтэй би найрсаг мөн тэвчээртэй байдаг. (Моронай 7:45)
- ___ 23. Бусдын амжилтанд би баярладаг. (Алма 17:2–4)

Ариун Нандин Чанар

- ___ 24. Би зүрх сэтгэлдээ цэвэр мөн ариун. (Дуулал 24:3–4)
- ___ 25. Сайныг үйлдэхээс өөр ямар ч хилэнцэд хүсэл надад байхгүй. (Мозая 5:2)
- ___ 26. Би биеэ даасан—Би хийнэ гэж хэлсэн зүйлээ гүйцэтгэдэг. (Алма 53:20)
- ___ 27. Би зөв шударга, урам зориг өгөх бодлуудад анхаарлаа хандуулж мөн эрүүл мэндэд хортой бодлуудыг оюун санаанаасаа авч хаяна. (С ба Г 121:45)
- ___ 28. Би нүглүүдээ наманчилж мөн сул дорой байдлаа ялан дийлэхээр хичээх болно. (С ба Г 49:26–28)
- ___ 29. Би амьдралдаа Ариун Сүнсний нөлөөллийг мэдэрдэг. (С ба Г 11:12–13)

Мэдлэг

- ___ 30. Сайн мэдээний сургаалууд болон зарчмуудыг ойлгох ойлголтондоо би итгэлтэй байна. (Ифэр 3:19–20)
- ___ 31. Би өдөр бүр судруудыг судална. (Иохан 5:39)
- ___ 32. Үнэнийг ойлгохыг би чин сэтгэлээсээ хичээж, асуултууддаа хариулт олно. (С ба Г 6:7)
- ___ 33. Сүнсээр дамжуулан би мэдлэг болон зааварчилгаа хүлээн авдаг. (1 Нифай 4:6)
- ___ 34. Сайн мэдээний сургаалууд болон зарчмуудыг би хайрлаж мөн дэмжинэ. (2 Нифай 4:15)

Тэвчээр

- ___ 35. Их Эзний адислалууд болон амлалтуудын биелэлтийг би тэвчээртэйгээр хүлээнэ. (2 Нифай 10:17)
- ___ 36. Би аливаа зүйлийг санаагаар унаж, мөн гомдоллохгүйгээр хүлээх чадвартай. (Ром 8:25)
- ___ 37. Номлогч байх сорилтуудад би тэвчээртэй, тэсвэртэй хандана. (Алма 17:11)

- ___ 38. Би бусдын алдаа дутагдал болон сул дорой байдалд тэвчээртэй хандана. (Ром 15:1)
- ___ 39. Би өөртөө тэвчээртэй хандаж, сул дорой байдлаа ялан дийлэхийн төлөө ажилладаа Их Эзэнд найдна. (Ифэр 12:27)
- ___ 40. Саад тогтор болон зовлон зүдгүүрүүдэд тайван мөн найдлагатайгаар тулах болно. (Алма 34:40–41)

Даруу Байдал

- ___ 41. Би нигүүлсэнгүй хийгээд номхон даруу зүрх сэтгэлтэй. (Матай 11:29)
- ___ 42. Тусламжийн төлөө би Их Эзэнд найддаг. (Алма 26:12)
- ___ 43. Их Эзэнээс хүлээн авсан адислалууддаа би чин сэтгэлээсээ талархдаг. (Алма 7:23)
- ___ 44. Миний залбирлууд ул суурьтай мөн чин сэтгэлийнх. (Инос 1:4)
- ___ 45. Удирдагчид болон багш нарынхаа удирдамжинд би талархдаг. (2 Нифай 9:28)
- ___ 46. Юу ч байсан хамаагүй, би Их Эзэний хүсэл зоригт дуулгавартай байхыг хичээдэг. (Мозая 24:15)

Хичээнгүй Байдал

- ___ 47. Хэдийгээр дарамт шахалтанд орж, эсвэл сорилтод ороогүй ч гэсэн би идэвхтэйгээр ажиллана. (С ба Г 58:26–27)
- ___ 48. Би хүчин чармайлтаа хамгийн чухал зүйлд хандуулна. (Матай 23:23)
- ___ 49. Өдөрт би дор хаяж хоёр удаа хувийн залбирал хийнэ. (Алма 34:18–27)
- ___ 50. Би бодол санаагаа номлогчийн дуудлагадаа төвлөрүүлнэ. (С ба Г 4:2, 5)
- ___ 51. Би зорилго тавьж, тогтмол төлөвлөх болно. (С ба Г 88:119)
- ___ 52. Ажил амжилттай биелэгдэх хүртэл би шаргуу ажиллана. (С ба Г 10:4)
- ___ 53. Би ажлаасаа баяр баясал болон сэтгэл ханамжийг олно. (Алма 36:24–25)

Дуулгавартай Байдал

- ___ 54. Залбирахдаа би уруу таталтыг эсэргүүцэх мөн зөв зүйлийг хийх хүч чадлыг гуйх болно. (3 Нифай 18:15)
- ___ 55. Ариун Сүмийн зөвшөөрлийн бичиг авахад зохистой байхад шаардлагатай зарлигуудыг сахих болно. (С ба Г 97:8)
- ___ 56. Би номлолын дүрмүүдийг дуулгавартай дагаж, удирдагчдынхаа зөвлөгөөг дагах болно. (Еврей 13:17)
- ___ 57. Би сайн мэдээний хуулиуд болон зарчмуудад нийцэхээр амьдрахыг хичээнэ. (С ба Г 41:5)



Би Номлолынхоо Хэлийг Хэрхэн Илүү Сайн Сурах Вэ?

Үүнийг Анхаар

- Хэлнийхээ чадварыг би яагаад цаашид сайжруулах ёстой вэ?
- Номлолынхоо хэлээр ярьж мөн заах чадвараа би хэрхэн сайжруулж чадах вэ?
- Хэлний бэлгийг би хэрхэн олж авах вэ?

Өөрийгөө Сүнслэгээр Бэлтгэ

“Энэхүү хүчинд томилогдсон тэднээр дамжуулан хүн болгон сайн мэдээний бүрэн байдлыг төрөлх хэл дээрээ, мөн өөрийн хэлээр сонсох болно” (С ба Г 90:11) хэмээн Их Эзэн тунхаглажээ. Өөрийн үгстээ хөрвүүлэх хүчийг авчрахын тулд хувийн гэрчлэлээ хүчирхэгжүүл. Эхлээд сургаалууд болон хичээлүүдийг өөрийнхөө төрөлх хэлээр судал. Тэрхүү ойлголт, гэрчлэл мөн таны итгэл үнэмшилтэйгээр зааж, гэрчлэх боломжийг тань хүчирхэгжүүлэх болно. Ингэснээр та Сүнсний удирдлага дор номлолынхоо хэлээр Сэргээлтийн захиасыг илэрхийлж сурах болно.

Доор жагсаасан зүйлс бол номлолынхоо хэлээр зааж мөн гэрчлэхэд тань Их Эзэн тусална гэсэн итгэлийг тань хүчирхэгжүүлэх арга замууд юм:

- Бошиглогчоор дамжуулан Бурханаас дуудагдсан гэдгээ ойлгох.
- Ариун Сүнсний нөхөрлөлд зохистой байхаар амьдрах.
- Зарлигууд болон номлогчийн жишгүүдэд дуулгавартай байх.
- Тэнгэрлэг тусламжийн төлөө чин сэтгэлээсээ залбирах.
- Өдөр бүр номлолын хэлийг суралцаж, дадлага хийж, мөн ашигла.

Тэмдэглэл

Бүхнээ Зориулж мөн Хичээнгүй Байх нь

Номлолынхоо хэлээр үр дүнтэй зааж сурахад хичээнгүй хүчин чармайлт шаардагдана. Эхлээд уг шалгуур нь хэцүү байвал бүү гайх. Хэл сурахад цаг хугацаа хэрэгтэй. Өөртөө тэвчээртэй бай. Хамтрагч, гишүүд, сонирхогч болон бусад номлогч нараас тусламж эрэлхийл.

Хүмүүс өөрийг тань ойлгож эхлэх үед хэлнийхээ ур чадварыг сайжруулахаа зогсоож болохгүй. Уг хэлээр ярих чадамж тань өсөн нэмэгдэх тусам хүмүүс аливаа зүйлийг та яаж хэлж байгааг сонсохоосоо илүү юу хэлж байгааг тань анхаарах болно. Зүрх сэтгэлдээ байгаа сэтгэгдлээ хэрхэн хүргэх талаар та санаа зовох нь багасна. Сонирхогчдынхоо хэрэгцээ хийгээд Сүнсний өдүүлбэрт та илүү сайн хариулах боломжтой болно.

Номлолынхоо турш болон буцаж ирснийхээ дараа уг хэлээр гарамгай болохыг хичээ. Их Эзэн таныг маш ихээр адисалсан бөгөөд Тэрээр хожмын тань амьдралд таны хэлний чадварыг ашиглах болно. Ахлагч Жеффри Р.Холланд тайлбарлахдаа: “Номлогч бүр . . . уг хэлээр заах шинэ арга барилыг сурч, үүнд боломжтой бүх боломжуудад шилдэг нь болно хэмээн бид найдаж байна. . . . Ийнхүү үйлдсэнээр таны заах мөн гэрчлэх арга барил сайжрах болно. Та илүү олон сонирхогчтой болж, тэдний сэтгэлийг илүү сүнслэгээр хөдөлгөх болно. . . . Зөвхөн номлогчийн үгийн санд бүү сэтгэл хана. Хэлний мэдлэгээ илүү тэл, ингэснээр та хүмүүсийн зүрх сэтгэлийг илүү ихээр мэдрэх болно” (номлогчийн хиймэл дагуулаар дамжуулсан шууд нэвтрүүлэг, 1998 оны Наймдугаар сар).

Номлолын хэлийг сурахдаа та ганцаардахгүй. Зарлиг өгөх бүртгээ Их Эзэн түүнийгээ гүйцэлдүүлэх замаар хангаж өгдөг (1 Нифай 3:7-г үз). Түүний тусламжийг эрэлхийл. Судлахдаа хичээнгүй бай. Номлогчийн хувьд зорилгоо биелүүлэхэд тань шаардлагатай хэлний арга барилыг цаг хугацаа өнгөрөх тусам та эзэмших болно.

Англи Хэл Сур

Хэрэв та Англи хэлээр ярьдаггүй бол номлогчийн хувьд үүнийг та сурах ёстой. Энэ нь номлолын тань явцад болон амьдралын тань турш адислах болно. Англи хэл сурах нь Их Эзэний хаант улсыг барихад тань илүү ихээр тусалж мөн танд болон гэр бүлд тань адислал ирэх болно. Энэ бүлэг дэх олон зөвлөгөө танд туслах болно. Ялангуяа доорх зөвлөгөөнд илүү анхаар:

- Хамтрагчтайгаа Англиар ярих зорилго тавь. Хэрэв хамтрагч тань Англи хэлийг аль хэдийн сурсан бөгөөд өөрийн тань хэлийг сурахыг хичээж байгаа бол өрөөндөө Англи хэлээр ярьж, өрөөнөөсөө гадуур номлолынхоо хэлээр ярихаар сонгож болно.
- Хамтрагчтайгаа хамт Мормоны Номыг Англи хэлээр унш. Түүнчлэн та нөгөө талаар сонгож болно. Та өөрөө нэг шүлгийг англиар уншихад хамтрагч тань нэг шүлгийг номлолынхоо хэлээр уншиж болох юм. Бие биенийхээ дуудлага болон хэллэгийг засч өг.
- Хэрэв өөрт тань байхгүй бол Англи хэлний энгийн дүрмийн зөвлөгөөг номлолын ерөнхийлөгчөөсөө асуу.

Хэл Сурах Зарчмууд

Энэ хэсэгт хэлийг илүү үр дүнтэй сурч, мөн сурахад тань туслах зарчмуудыг дүрсэлсэн болно.

- **Хариуцлага хүлээх.** Хэл сурах тогтмол зорилго мөн төлөвлөгөө гарган тавих, эсвэл бүрэн соль. Боломж гарах бүр хэлээ ашиглахыг эрэлхийл.
- **Сурахаа үр дүнтэй болго.** Өөрөөсөө асуу: Үүнийг би юуны учир сурч байна вэ? Илүү сайн ойлголцоход минь надад энэ хэрхэн туслах вэ? Сурч буй зүйлээ амьдралд болон өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигла. Өөрийнхөө хэлэхийг хүсч байгаа зүйлээ хэлэхэд тань туслах хэлний хэсгүүдийг суралц. Жишээ нь: зааж буй зүйлдээ оролцуулахыг хүсч байгаа судрын түүх байх аваас үүнд шаардагдах үгсийн сан болон дүрмийг сур.
- **Ярилцахыг хичээ.** Уг хэлний дүрэм болон зохион байгуулалтыг судлах, өдөр тутмынхаа үйл ажилагаагаар суралцах хоёрын дундах тохиромжтой тэнцвэрийг эрэлхийл. Уг хэл төрөлх хэл нь болох хүмүүстэй ярихаас илүү үүнийг орлох ямар ч зүйл үгүй билээ.
- **Байнга шинэ зүйлийг сур.** Сурч мэдсэнээ тогтмол хэрэглэж, шинэ зүйлээрээ байнга дадлага хийх аваас та хэлний зарчмуудыг илүү үр дүнтэй ашиглах мөн давтах боломжтой байх болно.

Хэл Сурах Төлөвлөгөө Гарга

Хэл сурах төлөвлөгөө нь номлолынхоо хэлээр ярих чадвараа сайжруулахын тулд өдөр бүр хийх зүйлдээ анхаарлаа хандуулахад нь шинэ, туршлагатай номлогч нарын аль алин тусална. Төлөвлөгөөнд тань хэл сурах цагаараа юу хийх мөн өдрийн турш юу хийхийн аль алийг нь багтаадаг.

Шаардлагатай бол, хэл судлах цагийнхаа заримыг судлах төлөвлөгөө зохиож мөн засч сайжруулахад зориул. Тэгээд өглөө бүр хэл судлах цагаараа тухайн өдрийнхөө үйл ажиллагаанд шаардагдах хэлийг сур. Хэл сурах төлөвлөгөө зохиоход тань доорх зааварчилгаанууд танд туслах болно:

1. **Зорилго тавь.** Долоо хоногийн болон өдөр тутмын зорилго нь номлолынхоо хэлийг сурахад тань танд туслах болно. Заах томилолтууд, олох боломжууд болон хэсгийн зөвлөлийн хурал гэх мэт хувиар гаргасан үйл ажиллагаануудынхаа үеэр ярих мөн заах чадвараа сайжруулахад тань таны зорилгууд төвлөрөх ёстой. Хэл сурах зорилгодоо хүрэх өсөлт хөгжилтийг нэгтгэн дүгнэ. Хувиар гаргасан үйл ажиллагааны үеэр илүү цэвэр мөн хүчтэйгээр ярихын тулд юу хийж чадахаа өөрөөсөө асуу.
2. **Ямар арга барил ашиглахаа сонго.** Хэл сурах доорх арга барилуудыг нэгтгэн дүгнээд зорилгодоо хүрэхийн тулд алийг нь ашиглаж болохыг олж тогтоо.

Тэмдэглэл

- Номлолын тань хэл дээрх жишиг бүтээлүүд.
- Номлолын тань хэл дээрх хичээлүүд.
- Халаасны толь бичиг.
- Жижигхэн дүрмийн ном.
- НБТ-ийн хэл сурах материалууд.
- Тэмдэглэл хөтлөх картууд.
- Халаасны тэмдэглэлийн дэвтэр.
- Номлолын тань хэл дээрх Сүмийн бусад материалууд.



3. Шинэ үг болон хэлцүүдийг цээжил. Зорилгоо биелүүлэхэд тань туслах шинэ үг болон хэлцүүдийг олж тогтоо. Хэл сурах төлөвлөгөөндөө доорх санаануудыг багтааж болох юм:

- Заах үедээ ашиглаж болох хичээлүүд, товхимолууд, судрууд болон Сүмийн бусад хэвлэлүүд дэх шинэ үг болон хэлцүүдийг олж тогтоо.
- Өөрийнхөө мэдэхгүй үгс болон хэлцүүдийг тэмдэглэлийнхээ дэвтэрт тэмдэглэ. Жижигхэн толь бичиг авч яван эдгээр үгсийг хар.
- Өдрийн турш сурахын тулд тэмдэглэл хөтлөх карт авч яв. Үг болон хэлцүүдийг нэг талд нь мөн тайлбарыг эсрэг талд нь бич. Сурсан үгсээ хадгал. Бүгдийг нь мэддэг болтлоо үлдсэн үгсийг судал.
- Хувиараа суралц, заах үедээ болон өдрийн турш өгүүлбэр дэх шинэ үгс болон хэлцүүдийг ашигла.
- Шинэ үгс болон хэлцүүдийг чанга хэлэх замаар дуудлагаа сайжруул.
- Номлолын хэлээр гол судруудыг цээжил.
- Хичээлүүд эсвэл товхимолуудаас сайн мэдээний гол зарчмуудыг илэрхийлэх энгийн мэдэгдэлүүдийг цээжил. Эдгээр санаануудыг илэрхийлэх өөр арга замуудыг ол.

4. Дүрэм сур. Зорилгоо биелүүлэхэд тань туслах дүрмийн зарчмуудыг олж тогтоохын тулд хэл сурах арга барилуудаа ашигла. Хэрэв шаардлагатай бол хамтрагч, туршлагатай номлогч, эсвэл гишүүнээс тусламж хүс. Доорх санаануудын заримыг нэгтгэн тунгааж үз:

- Хичээлүүд, товхимолууд болон судрууд дахь дүрэм болон өгүүлбэрийг ойлгоход тань туслах НБТ-д хүлээн авсан дүрмийн текстүүд, эсвэл номлолын ерөнхийлөгчийн зөвшөөрсөн текстийг ашигла.
- Эдгээр дүрмийн зарчмуудыг хувиар гаргасан хөтөлбөрүүддээ ашиглахын тулд өгүүлбэрүүдийг бэлтгэ. Уг өгүүлбэрүүдээ хэлэх мөн бичих дасгал хий.
- Уг хэлний үгсийн дараалал мөн үгс болон тэдгээрийн хэсгүүдэд анхаар.
- Судалж буй дүрмээ өдөр бүр туршиж, мөн ашиглах боломжийг эрэлхийл.

5. Анхааралтай сонс. Доорх зүйлсийг анхаарч үз:

- Төрөлх хэлтнүүдийг анхааралтай сонс. Сонссон зүйлээ дуурайн хэл.
- Өөрийнхөө сонссоноос ойлгоогүй зүйлээ бичиж аваад ямар утгатай болохыг олж мэд. Шинэ үг болон өгүүлбэрийн загварыг ашиглах дасгал хий.
- Сонсож байх үедээ саяхны сурсан шинэ үг болон загваруудаа олж тогтоо.
- Аливаа хэлцийг өөрийн тань хэлэхээс өөр арга замаар илэрхийлэхийг сонссон бол бичиж аваад дадлага хий. Хэдий тийм ч, Их Эзэний үйлчлэгчийн хувьд үргэлж зөв зохистой хэл ашигла, хар яриа хэрэглэж болохгүй.
- Төлөвлөсөн үйл ажиллагаануудын үеэр хүмүүсийн хэлж болох зүйлсийн жагсаалт гарга. Эдгээр хариултуудтай холбоотой үгс болон хэлцүүдийг анхаар. Өөрийнхөө хариулж болох арга замуудыг төлөвлөж мөн дадлага хий.

6. Унших мөн бичих чадвараа сайжруул. Шинэ үг, хэлц сурч мөн дүрэм, дуудлага мөн чөлөөтэй ярьж, бичих дадлага хийхийн тулд номлолынхоо хэлээр Мормоны Номыг унш. Сурч буй хэл дээрх судрыг ашиглах нь маш их хүчийг агуулдаг. Түүнчлэн доорх санаануудын талаар бодож үз:

- Өөрийнхөө төрөлх хэлний үсэг, бичлэг эсвэл дүрсийг уншиж мөн бичиж сур. Дүрс бичигт тулгуурлан бичдэг системийн хувьд унших арга барил, ялангуяа судар унших нь заах үед тань танд тусалж болох юм.
- Номлолынхоо хэлээр Мормоны Ном, бусад судрууд эсвэл Сүмийн сэтгүүлүүдийг чангаар унш. Танил бус үг, хэлц, мөн дүрмийг анхаар. Хэрэв ямар нэг үгийг ойлгохгүй байгаа бол, толь бичгээс харахаасаа өмнө хам сэдвээс нь уг үг ямар утгатай болохыг ойлгох гэж хичээ. Тэмдэглэх картан дээрээ уг үгийг нэм. Хэрэв шаардлагатай бол өөрийн төрөлх хэл дээрх болон номлолын хэл дээрх хоёр судрыг хамтад нь ашигла.
- Таныг уншиж байхад хэн нэгэн нь дуудлага, аялга болон зогсоц дээр хяналт тавиг.
- Номлолынхоо хэлээр бичих дасгал хий—жишээ нь хувийн зурвас, сануулга, захидлууд, баярласнаа илэрхийлэх зурвасууд болон урам зориг өгөх зурвасууд гэх мэт. Тараах Мормоны Номон дээрээ гэрчлэлээ бич.

7. Өөрт тань туслахыг бусад хүмүүсээс хүс. Доорх санаануудын талаар бодож үз:

- Хэрэв хамтрагч тань төрөлх хэлээрээ яригч бол тогтмол асуулт асууж, санал хүсэлтийг нь асуух замаар энэ агуу боломжийг ашигла.
- Хамтрагч болон уг хэлээр яригч хүмүүсээс өөрийг тань засч өгөхийг мөн сайжруулах арга замыг зөвлөхийг хүс. Хэрэв тэд таны ойлгохгүй байгаа үгийг ашиглаж байгаа бол уг үгийг тайлбарлаж өгөхийг тэднээс хүс. Хүүхдүүд болон өвөө эмээ нар туслахад үргэлж бэлэн байдаг.



- Зааж буй хүмүүсээ өөрт тань туслахыг хүс. “Би танай хэлийг сурч байгаа юм. Надад туслаарай. Намайг үг сонгоход хүндрэлтэй байх үед надад туслаарай” хэмээн тайлбарла.

- Тодорхой нэг тусламж хүсэхдээ бүү эргэлз: “ _____ юу гэж хэлдэг вэ?” “ _____ үгийг яаж дууддаг вэ?” “ _____ ямар утгатай вэ?” “Дахиад нэг давтаж хэлэхгүй юу?” Хариултуудыг бичиж аваад судал.
- Тэмдэглэлийн картан дээрх үгийг эсвэл үгсийн сангийн жагсаалтаар өөрийгөө сорихыг мөн судруудыг чангаар уншихад туслахыг гишүүдээс хүс.

8. Судлах төлөвлөгөөндөө үнэлэлт өгч мөн шинэчил. Үнэлэлт өгөхийн тулд судлах төлөвлөгөөгөө болж буй эсэхийг нь шалгахын тулд долоо хоног бүр нэгтгэн дүгнэ. Сайжруулах хэсэгт нь зөвлөгөө өгөхийг хамтрагч болон номлолын удирдагчдаасаа хүс.

Номлолынхоо хэлийг боломж гарах бүрт ашигла. Өдрийн турш уг хэлээр хамтрагчтайгаа аль болох их ярь. Залбирлыг зөв сурахын тулд ганцаарчлан болон олны дунд уг хэлээр залбир мөн зүрх сэтгэлдээ байгаа тэр үгийг илэрхийлж сур.

Алдаа гаргахаас бүү эмээ. Шинэ хэл сурч байгаа хүн бүхэн алдаа гаргадаг. Хүмүүс ойлгох болно, мөн тэд өөрсдийнх нь хэлийг сурах гэж буй өөрийн тань хүчин чармайлтад талархах болно. Хэлц болон судруудыг цээжлэх нь таныг алдаа гаргахаас сэргийлэх болно, гэвч алдаа гаргахгүйн тулд та цээжилсэн, эсвэл бэлтгэсэн зүйл ашиглан ярих ёсгүй.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Дээр дүрсэлсэн зааварчилгааг ашиглаж сурах төлөвлөгөө гарга. Өөрийнхөө төлөвлөгөөг хамтрагч, эсвэл номлолын удирдагчтайгаа нэгтгэн дүгнэ.

Хамтрагчтайгаа Хамт Судлах нь

Хэл маш хурдан сурахад амжилт олж, итгэлтэй болоход нь хамтрагч нартаа тусал. Хамтрагчид болон бусад номлогч нарт өсөлт хөгжилтөд нь чин сэтгэлээсээ мөн ойр ойрхон талархаж буйгаа илэрхийл. Тэдний итгэлийг сулруулах аливаа зүйл хэлэхээсээ болгоомжил, гэхдээ тэднийг сурахгүй байхад нь бүү худлаа дүр үзүүл. Хэрэгтэй үед нь тусламж өгөхөөсөө бүү татгалз. Амжилттайгаар зааж мөн гэрчлэх олон боломжуудыг тэдэнд олгож өг. Хамтрагчтайгаа хамт суралцах доорх санаануудыг бодож үз:

- Бие биендээ сурсан дүрэм болон шинэ үгийг заа.
- Номлолынхоо хэлээр заах дасгал хий. Эхэндээ шинэ номлогч нар маш энгийнээр зааж, энгийнээр гэрчлэл хуваалцаж, цээжилсэн судруудаа хуваалцаж болно. Өөртөө итгэх итгэл, чадвар нь нэмэгдэх тусам тэд сонирхогчдод заах үйл явцад илүү идэвхтэй оролцох чадвартай болох юм.
- Номлогч нарт тохиолддог нийтлэг нөхцөл байдалд уг хэлийг ашиглан харилцах дадлага хий.
- Бие биендээ энгийн, бодитой санал хүсэлтээ найрсагаар өгч бай. Санал хүсэлтийг ямар нэг гомдол гаргахгүйгээр хүлээн авах нь чухал.

Доорх үнэн түүхээс илүү туршлагатай номлогч хамтрагчдаа хэрхэн тусалж байгааг анхааралтай унш.

Намайг дөнгөж хоёр дахь бүсдээ ирсний дараа нэг өдөр хамтрагч маань энэ удаад оройн хоолон дээр сүнсэлэг бодлоо хуваалцах миний ээлж хэмээн надад хэлсэн юм. Эхний хамтрагч маань заахдаа үргэлж дуртай байсан бөгөөд хичээлийн үед би бага зэрэг яриад хамтрагч маань цааши өргөжүүлэн, аливаа асуултанд хариулдаг байсанд би бүр дасчихсан байв.

Өөрийг нь сүнсэлэг бодлоо хуваалцах ёстой хэмээн хамтрагчаа ятгахыг би оролдсон боловч тэрээр намайг даалгавраа хий хэмээн зоригжуулсан юм. Би түүний тусламжтайгаар дадлага хийсэн юм.

Цаг нь болоход би судраа нээгээд 3 Нифай 5 мөн 7-г уншив. Надад хэцүү байсан боловч би сонгосон судрын хэсэг маань яагаад чухал болохыг тайлбарласан бөгөөд дууссандаа миний сэтгэл амрав. Асуулт асуухад нь хариулт эрэн хамтрагч уруугаа харсан боловч тэр ам нээсэнгүй. Миний амнаас ойлгогдохоор Франц хэлээр хариулт урсан гарахад нь би өөрөө гайхав. Миний харилцах арга барил муу байгааг уг гишүүн анзаараагүйд нь би бүүр ч их гайхав. Миний Франц хэл бодож байснаас минь илүү байгааг би ухаарч өөртөө итгэх итгэл маань нэмэгдсэн юм.

Өдөр хоногууд өнгөрсөөр, бүр хийж чадна гэж бодоогүй байхад минь, бүр намайг хийж чадна гэдэгт—өөрөө эргэлзэж байгаа үедээ ч гэсэн хамтрагч маань надад заах боломжуудыг олгосоор байлаа. Ярьж, сонсож, заахад минь тэрээр намайг зоригжуулдаг байсан учраас миний хэлний чадвар илүү хурдан өсч, зүгээр өөр нэг ахлагчийн дуугүй хамтрагч байхын оронд Тэнгэрлэг Эцэгийн зэмсэг болсон гэсэн мэдрэмж надад төрдөг байсан юм.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

- Хэрэв та шинэ номлогчтой хамт ажиллаж байгаа бол, хэл сурахад нь хамтрагчдаа яаж тусалж чадах вэ?
- Хэрэв та шинэ номлогч бол ахлах номлогчоосоо ямар тусламж хүсэх вэ?

Зан Заншил болон Хэл Сурах нь

Хэл зан заншил хоёр маш их уялдаатай. Зан заншлыг ойлгох нь уг хэл яагаад хэрэглэгдэж байгааг тайлбарлахад тусалдаг. Хүмүүсийн зан заншлыг ойлгохыг хичээ, ингэснээр Сэргээлтийн захиасын ер бусын үзэл баримтлалыг та тэдэнд ойлгомжтой замаар зааж чадна.

Хүмүүсийн итгэл хийгээд хайр хүндэтгэлийг олж авахын тулд таны хийж чадах хамгийн агуу зүйлсийн нэг бол, тэдний зан заншлыг тохиромжтой замаар өөрийн болгох явдал юм. Олон агуу номлогч нар ийнхүү үйлдсэн байдаг (1 Коринт 9:20–23-ыг үз). Хүмүүс таныг болон өөрсдийн тань хэлийг хүлээн авах боломжийг эрэлхийл.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

- Азид номлолд үйлчилж байна гэж төсөөл. Хэн нэгэнд та амилуулалтын талаар заахаар төлөвлөж байгаа бөгөөд Буддистууд дахин төрөх үйл явцад итгэдэг гэдгийг та мэднэ. Энэ сургаал нь дахин төрөх үйл явцаас хамаагүй өөр гэдгийг сонирхогч ойлгох тийм замаар амилуулалтын талаар та хэрхэн заах вэ? Энэ шалгуурыг давахын тулд та ямар үг болон хэлцүүд сурах шаардлагатай вэ?
- Зааж буй хүмүүсийнхээ зан заншил болон шашны байдлын талаар бод. Сайн мэдээний сургаалыг буруу ойлгоход тэднийг хөтөлж болох аливаа зүйлсийг олж тогтоо. Эдгээр сургаалуудыг товч тодорхой заах арга замуудыг төлөвлө.

Хэлний Бэлгүүд

Хэлнүүдийн бэлэг болон хэлнүүдийн хөрвүүлэг зэрэг Сүнсний бэлгүүдийг эрэлхийл. Өөр бусад юунаас ч илүүгээр номлол дахь хүмүүсийнхээ хэлийг ойлгож, ярихад танд энэ нь тусална. Өөрийнхөө хувийг үйлдэн хүчин чармайлт гаргалгүйгээр энэ бэлгийг эзэмшиж чадахгүй; та үүнийг идэвхтэйгээр эрэлхийлэх хэрэгтэй. Хэлнүүдийн бэлгийг эрэлхийлэхийн нэг хэсэг бол хөдөлмөрлөж мөн хичээл зүтгэл гаргаж мөн уг хэлийг сурахын тулд хийж чадах бүх зүйлийг хийх явдал юм. Амьдрах ёстой замаар амьдрахад тань Сүнс тусална гэдэгт итгэ, мөн бүх чадлаараа гүйцэтгэ. Хэлнүүдийн бэлэгтэй байж, энэ нь үнэн мөн үүнийг хамгийн ойлгомжтойгоор ухамсарлана гэсэн итгэлтэй бай.

Өөрийнхөө хүссэнээр товч тодорхойгоор өөрийгөө илэрхийлэх гэж зовж байгаа бол Бурханы бүх хүүхдүүдийн зүрх сэтгэлд Сүнс ярих чадвартай гэдгийг сана. Ерөнхийлөгч Томас С.Монсон заахдаа: “Номлогч бүрт нийтлэг нэг хэл байдаг нь Сүнсний хэл юм. Үүнийг зохиолч хүний бичсэн номноос сурч болохгүй, эсвэл үүнийг уншиж мөн цээжилснээр эзэмшиж чадахгүй. Сүнсний хэл нь Бурханыг мэдэхийг зүрх сэтгэлээрээ эрэлхийлж, Түүний бурханлиг зарлигуудыг сахьдаг хүнд ирдэг. Энэ хэлэнд туршлагажихыг саад бэрхшээлийг даван гарч, хүмүүний зүрх сэтгэлд хүрч чадах хүнд зөвшөөрдөг” (“The Spirit Giveth Life,” *Ensign*, 1997 ххоны Зургадугаар сар, 2).

Үүнийг Сана

- Эхлээд зааж буй сургаалууд болон хичээлүүдийг төрөлх хэлээрээ судал.
- Эдгээр сургаалуудыг болон эдгээрийн талаарх өөрийн сэтгэгдлээ номлолынхоо хэлээр илэрхийлж сур.
- Хэл сурах төлөвлөгөө гарга, мөн номлолынхоо хэлний чадварыг сайжруулахын тулд шинэ санаануудыг тогтмол оролд.
- Номлол дахь хүмүүстэй харилцаж, тэднийг ойлгоход тань туслах Сүнсний удирдамжуудыг эрэлхийл.

Заах Санаанууд ба Хэрэглэгдэх нь

Тэмдэглэл

Хувиараа Суралцах

- Энэ бүлэг дэх зөвлөгөөнүүдийг нэгтгэн дүгнэ. Оролдож үзээгүй зөвлөгөөнүүдийг олж тогтоо, мөн ирэх хэдэн өдөр үүнийг оролдож үзэх зорилго тавь.
- Дараачийн дүүргийн хурал дээр тухайн хэлийг сайн эзэмшсэн туршлагатай номлогчоос хэл сурахын тулд юу хийснийг нь асуу.
- Ахлагч Ричард Ж.Скоттын доорх мэдэгдлийг уншаад ярилц: “Хэрэв тухайн үндэстний уламжлалууд, эсвэл ёс заншил Бурханы заасан зүйлстэй харшилж байвал тэдгээрийг хойш тавь. Хэрэв уг уламжлалууд, эсвэл ёс заншлууд Түүний заасан зүйлстэй нийцэж байвал тэдгээрийг хүндэтгэх ёстой” (“Removing Barriers to Happiness,” *Ensign*, 1998 оны Тавдугаар сар, 87). Үйлчилж буй бүсийн тань зан заншил өөрийнхөөс тань ялгарч буй эсэх талаар бод. Ялгаануудыг жагсаан бич. Тэгээд сайн мэдээний заасан зүйлст харшилж буй зүйлсийг нь дар. Үлдсэн зүйлсийн талаар бодож үз, мөн эдгээр зан заншлуудыг хэрхэн өөрийн болгох талаар бод.
- Доорх зүйлсээс номлолын тань хэлний хувьд таныг бэлтгэж болох нэг зүйлийг судлах төлөвлөгөө гарга:
 - Иосеф Смитийн түүхийг ярь.
 - 3 Нифай 11–ийг хураангуйл.
 - Алма 32–ыг хураангуйл.
 - Нифай болон гуулин ялтсуудын тухай түүхийг ярь (1 Нифай 3–5–ыг үз).
 - Эрин үеүдийг тайлбарла.
 - Хувийнхаа тохиолдсон явдлаас ярь.
- Хичээлүүдийн нэгнээс мэдэхгүй үгсийг тэмдэглэх карт хий. Тэдгээр үгсээ сурах хүртлээ уг картнуудаа авч яв.

Хамтрагчтайгаа Суралцах

- Номлолынхоо хэлээр номлогчийн хичээлүүдийг бие биендээ заах дасгал хий.
- Дуудлагыг тань сонсож, сайжрахад тань туслахыг хамтрагчаасаа хүс.
- Заахдаа ашиглахыг хүсч байгаа судрын түүх болон хэсгүүдийг сонго. Тэдгээрийг өөрийнхөө үгээр хураангуйлах дасгал хий.
- Энэ бүлэг дэх санаануудыг нэгтгэн дүгнэ. Ирэх долоо хоногт хамтрагчтайгаа суралцахдаа ашиглаж болох зөвлөгөөнүүдийг ярилц.
- Хэрэв та шинэ номлогчийг сургаж байгаа бол хамтрагч тань ойлгохгүй байж болох нөхцлүүдэд тэмдэглэл хөтөл. Хамтрагчид тань тусламж болох холбоо үгс, хэлцүүд, эсвэл дүрмийн жагсаалт гарга. Жагсаалт дээрх үгсийг ирэх мөн төлөвлөсөн үйл ажиллагаанууд дээр хэрхэн ашиглахыг тайлбарлаж мөн дасгал хий.

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Унаган хэлтэй хүмүүсийг хуралд урьж оролцуул. Номлогч нар тэдэнд зааж болохуйц жижигхэн бүлэгт тэднийг хуваа. Номлогч нарын хэлний талаар тэмдэглэл хөтөлж, санал хүсэлтээ хэлэхийг унаган хэлтэй хүмүүсээс хүс.

Тэмдэглэл

- Хэл сурахад хэрхэн амжилт олсон тухай нь яриулахын тулд нэг эсвэл хоёр номлогчийг өмнө нь томил. Тэдгээрээр санаануудыг нь хуваалцуул.
- Ихэнх тохиолдолд номлогч нарын хувьд хэцүү байдаг хэлний талаар товч тайлбарлахыг нэг туршлагатай номлогчоос хүс. Үр дүнд хүрсэн жишээнүүдийг танилцуулж номлогч нараар тэдгээрийг давтуул.
- Тухайн газрынхаа зан заншилтай номлогч нараар тус болох зүйлсийг хуваалцуул.

Номлолын Ерөнхийлөгч

- Сурч буй хэлнийх нь талаар үе үе номлогч нартай ярилцах.
- Номлогч нар хэлний хувьд хэрхэн сайжрах талаарх санаануудыг орон нутгийн удирдагчдаас асуу.
- Номлолын хэлийг сурч буй номлогч нарын хийдэг хамгийн нийтлэг алдаануудыг олж тогтоо. Эдгээр алдаануудыг засах талаар бүсийн чуулган дээр зааварчилгаа өг.
- Сүнслэг бэлгүүдийн талаарх сургаалыг номлогч нарт заа.
- Уг хэлээр ярин зааж байхад нь номлогч нараа ажигла.
- Тухайн хэлийг ашиглан номлогч нартайгаа хамт заах боломжийг эрэлхийл.



Би Цагийг Хэрхэн Ухаалгаар Ашиглах Вэ?

Тэмдэглэл

Үүнийг Анхаар

- Илүү идэвхтэй номлогч байхад минь зорилгууд надад хэрхэн туслах вэ?
- Зорилгууд маань юунд төвлөрөх ёстой вэ?
- Төлөвлөх арга замууд болон эх сурвалжууд гэж юу вэ, мөн тэдгээрийг би хэрхэн ашиглах вэ?
- Бүсийн ном яагаад чухал вэ?
- Долоо хоног тутмын болон өдөр тутмын төлөвлөгөөг би хэрхэн хөтлөх вэ?
- Миний зорилго болон төлөвлөгөөнүүд Их Эзэний ажлыг урагшлахад тус болж байгааг би хэрхэн мэдэх вэ?

Та тодорхой нэг бүсэд Их Эзэний ажлыг хийхээр томилогдсон билээ. Хайр болон агуу их халамжтайгаар өөрийнхөө бүсийг хайрлан хамгаалж байхыг Тэрээр танаас хүсдэг. Таны зорилго бол баптисм болон гишүүний баталгаагаар дамжуулан Түүнд ирэхэд нь бусад хүмүүст туслах явдал юм.

Тухайн бүсийг өөрийгөө ирэхэд байснаас илүү хүчирхэг болгон үлдээхийн тулд чадах бүхнээ хий. Их Эзэний танаас шаардах зүйлийг гүйцэлдүүлэхэд үр дүнтэй зорилгууд болон анхааралтай хийгдсэн төлөвлөгөө туслах болно. Томилогдсон бүсийнхээ хүмүүст анхаарал тавьснаар та Түүнд болон номлолынхоо удирдагчдын өмнө хариуцлага хүлээх болно.

Номлолын тань дуудлагад: “Хувийн бусад ажил хэргээ ардаа орхин, Их Эзэнд үйлчлэхэд бүх цаг зав, анхаарлаа зориулах нь танаас хүсэн хүлээгдэх болно. Эдгээр зүйлсийг хийснээр Их Эзэн таныг адисалж, та үр дүнтэй өмгөөлөгч мөн үнэний элч болох болно. Энэ нандин томилолтыг гүйцэлдүүлэх үүрэг хариуцлагуудтай

тулгарахад тань Их Эзэн танд туслаасай хэмээн залбирч, мөн танд итгэж байна” гэсэн байдаг. Зорилго тавих, төлөвлөх, мөн хариуцлагатай байх зэрэг нь олон хүмүүс Сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад хэрхэн тусалдаг болохыг мэдэхэд энэ бүлэг танд туслах болно.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

Иаков 5:11–13, 61–64, 74–75-ыг уншаад эдгээр асуултуудад хариул:

- Өөрийнхөө хүүхдүүдийн талаар Их Эзэн ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?
- Өөрийнхөө үйлчлэгчдээс Их Эзэн ямар хүч чармайлтыг шаарддаг вэ?

Хөрвүүлэгт Зориулсан Үндсэн Үзүүлэлт

Өөрсдийнхөө энэ олон үүргүүдээс аль нь хамгийн чухал болох талаар та бодож байж болох юм. Энэ асуултанд хариулах боломжтой байхын тулд та өөрийнхөө зорилгыг ойлгож, цагийг үр дүнтэй ашиглах нь энэ зорилгуудыг биелүүлэхэд хэрхэн тусалж чадахыг мэддэг байх ёстой.

Таны зорилго бол Есүс Христэд итгэх итгэл, Түүний цагаатгал, наманчлал, баптисм, Ариун Сүнснийг хүлээн авч мөн эцсээ хүртэл тэвчсэнээр сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь бусад хүмүүст тусалснаар тэднийг Христэд ирэхийг урих нь юм. Энэ зорилгод анхаарлаа төвлөрүүлэхэд тань туслахын тулд Сүмийн удирдагчид үндсэн үзүүлэлтүүдийг тогтоож өгсөн. Эдгээр үндсэн үзүүлэлтүүдэд анхаарлаа төвлөрүүлснээр баптисм, гишүүний баталгаа, Сүмд идэвхтэй хэвээр үлдэх мөн цааш үргэлжлэх хөрвүүлэг өөд урагшлах хөгжил дэвшилд нь та хүмүүст тусалж чадна.

Тайлан болон Бүртгэлийн Үндсэн Үзүүлэлт

- Баптисм хүртэж мөн гишүүнээр батлагдсан сонирхогчид
- Баптисмын өдрөө төвлөсөн сонирхогчид
- Ариун ёслолын цуглаанд оролцдог сонирхогчид
- Гишүүдийг оролцуулан сонирхогчдод заасан хичээлүүд
- Заасан бусад хичээлүүд
- Өсч хөгжиж буй сонирхогчид
- Хүлээн авсан болон холбоо тогтоосон бусдын зааж өгсөн хүмүүс
- Шинэ сонирхогчид
- Саяхны хөрвөгчид болон идэвх султай гишүүдэд заасан хичээлүүд

Эдгээр үзүүлэлтүүд нь тухайн хүний жинхэнэ хөрвүүлэг өөд өсч хөгжиж буй үйл явц болон нөхцөл байдлыг харуулдаг. Үндсэн үзүүлэлт бүрийн товч тайлбарыг дор өгсөн болно:

Баптисм хүртэж мөн гишүүнээр батлагдсан хөрвөгчид: Баптисм болон гишүүнээр батлагдах ёслолуудыг хүлээн авсан хөрвөгч бүр.

Баптисмын өдрөө төвлөсөн сонирхогчид: Тодорхой нэг өдөр баптисм хүртэж, гишүүнээр батлагдахыг хүлээн зөвшөөрсөн сонирхогч бүр.

Ариун ёслолын цуглаанд оролцдог сонирхогчид: Ариун ёслолын цуглаанд оролцсон сонирхогч бүр.

Гишүүдийг оролцуулан сонирхогчдод заасан хичээлүүд: Бүх сонирхогчдод гишүүн оролцож заасан нийт хичээлийн тоо. Хичээлүүдээс сайн мэдээний нэг буюу түүнээс олон зарчмыг зааж, нээлтийн болон хаалтын залбирал, мөн амлалт авах урилга зэрэг нь жирийн хичээлд багтана. Хичээл дэх бүх зарчмуудыг зааснаар бүрэн хичээл гэж тооцох шаардлагагүй. Та хэр идэвхтэй заах нь Аврагчид итгэх тэдний итгэл өсч, гэмүүдээ наманчилж, баптисм болон гишүүний баталгааны ёслолуудыг хүлээн авахад чин сэтгэлээсээ бэлтгэж байгаа зэргээр хэмжигдэнэ.

Заасан бусад хичээлүүд: Гишүүн оролцолгүйгээр сонирхогчдод заасан нийт хичээлийн тоо.

Өсч хөгжиж буй сонирхогчид: Хоёр буюу түүнээс илүү хичээлүүд заагдаж, залбирах, Мормоны Номноос унших, сүмд очих, мөн баптисм болон гишүүнээр батлагдахад бэлтгэх зэрэг амлалтуудыг сахсан нийт сонирхогчдын тоо. Сайн мэдээний талаар үргэлжлүүлэн сурахад бэлэн боловч амлалтуудыг биелүүлэх нь хүндрэлтэй байгаа сонирхогчид нь энд тодорхойлсонтой адил өсч хөгжиж буй сонирхогчид биш юм. Тэд бол шинэ сонирхогчид эсвэл бусад сонирхогчдын аль нэгэнд багтана.

Хүлээн авсан болон холбоо тогтоосон бусдын зааж өгсөн хүмүүс: Заасан эсвэл дахин уулзах тодорхой цаг товлон таны холбоо тогтоосон бусдын зааж өгсөн нийт хүмүүсийн тоо. Бусдын зааж өгсөн хүнтэй та нэгэнт холбоо тогтоосон бол бусдын зааж өгсөн хүн хичээл авах хүмүүсийн сангаас шилжиж, цаашид дахин уулзахын тулд тэмдэглэгдсэн шинэ сонирхогч, эсвэл сонирхогчдын жагсаалтнаас хасагдсан хүн болно. Хэрэв та олон удаа хичээсэн ч уг хүнтэй уулзаж чадаагүй эсвэл хаяг нь буруу байсан бол уг хичээл авах хүнтэй холбоо тогтоосонд тооцогдоно. Эдгээр бусдын зааж өгсөн хүмүүсийн жагсаалтыг яагаад холбоо тогтоож чадаагүй болохыг дүрсэлсэн тэмдэглэлийн хамт номлолын албанд буцаан илгээх ёстой.

Хүлээн авсан нийт бусдын зааж өгсөн хүний тоо нь холбоо тогтоож амжаагүй байгаа өөрийн тань хүлээн авсан бүх бусдын зааж өгсөн хүний тоог хэлдэг (гишүүд, сонирхогчид, Сүмийн төв байрнаас болон өөр бусад эх сурвалжаас ирсэн бусдын зааж өгсөн хүний талаарх мэдээлэл).

Шинэ сонирхогчид: Хичээл авч мөн буцаж уулзах тодорхой товыг хүлээн авсан хувь хүмүүсийн нийт тоо.

Саяхны хөрвөгчид мөн идэвх султай гишүүдэд заасан хичээлүүд: Гишүүн болоод нэг жил болоогүй хөрвөгчдөд болон идэвх султай гишүүдэд заасан нийт хичээлийн тоо.

Зорилго тавьж, төлөвлөгөөнүүд гаргахдаа эдгээр үндсэн үзүүлэлт бүрийн хүмүүсийн тоог нэмэгдүүлэх хүч чармайлт гаргах хугацаанд юу хийж чадахыгаа дүгнэ. Таны зорилго бол үндсэн үзүүлэлт бүрийн тоо нэмэгдсэн байх явдал юм.

Гудамжинд холбоо тогтоох, эсвэл хувиараа болон хамтрагчтайгаа суралцах зэргээр үндсэн үзүүлэлтэд дүрслээгүй олон зүйлийг хийж болно. Эдгээр чухал үйл ажиллагаанууд үндсэн үзүүлэлтүүдийн нэг эсвэл илүү олон үзүүлэлтэд нөлөөлөх болно. Жишээ нь, өөрийнхөө хүчин чармайлтаар дамжуулан олсон хүмүүст заах бол та шинэ сонирхогчдыг заах санд нэмэх ёстой. Түүнчлэн, та хувиараа болон хамтрагчтайгаа суралцах чанар тань таны шинэ бөгөөд өсч хөгжиж байгаа сонирхогчдыг адислах Сүнсээр заах чадварыг тань нэмэгдүүлэх болно. Олох мөн заах хүч тань үндсэн үзүүлэлт бүрт нөлөөлөх болно. Өөрсдийн тань хийж буй зүйл эдгээр үзүүлэлт дээрх хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд

Тэмдэглэл

тулгуурлаж буй эсэхийг үнэлж дүгнэ. Номлох үйл ажиллагаа нэг эсвэл илүү олон үндсэн үзүүлэлт дээрх хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд хэрхэн тусалдгийг хамтрагчтайгаа хоёулаа харж чадахгүй байгаа бол үйл ажиллагаа та нарын цагт нийцэж буй эсэхэд дүгнэлт хийх хэрэгтэй.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Судлах тэмдэглэлдээ өнгөрсөн гурван өдөрт хийсэн номлох үйл ажиллагаа бүрээ жагсаан бич. Үйл ажиллагаа бүр үндсэн үзүүлэлтийн аль нэгэнд нөлөөлсөн эсэхийг олж тогтоо. Хэрэв нөлөөлсөн бол хажууд нь *тийм* гэж бич. Хэрэв нөлөөлөөгүй бол *үгүй* гэж бич. *Тийм* гэж тэмдэглэсэн үйл ажиллагаа бүрт энэ нь хэрхэн нөлөөлсөн болохыг дүрслэн бич. *Үгүй* гэж тэмдэглэсэн үйл ажиллагаа бүрийн хувьд яагаад үүнийг хийснээ болон ирээдүйд энэ үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн хийх эсэхээ шийд. Хийсэн жагсаалтаа хамтрагчтайгаа ярилцаад, яагаад зарим үйл ажиллагааг *тийм* заримыг нь *үгүй* гэж тэмдэглэснээ тайлбарла. Аль үйл ажиллагааг зогсоох хэрэгтэй байж болохыг ярилц.

Бүсийн Ном болон Төлөвлөх, Тайлагнах Арга Хэрэгслүүд

Баптисм болон гишүүний баталгаагаар өөрийнх нь өдрүүдэд Сүмд хүлээн авагдсан хүмүүсийн талаар Моронай заахдаа, “Тэднийг зөв замд байлгахын тул, Бурханы сайн үгээр дурсагдан мөн тэжээгдэхийн учир тэдний нэрс нь тэмдэглэгддэг байв” гэжээ (Моронай 6:4).

Зааж буй хүмүүсийнхээ талаарх чухал мэдээллийг тэмдэглэхэд тань туслах арга хэрэгслүүд танд өгөгдсөн билээ. Эдгээр арга хэрэгслүүд нь түүнчлэн өөрсдөд нь хэрэгцээтэй байгаа хүмүүст зөв мэдээллийг хуваалцахад танд доорх бүдүүвчид үзүүлсний дагуу туслах болно.

Мэдээллийн Пирамид		Арга хэрэгслүүд:
Номлолын Ерөнхийлөгч	Мэдээллийн Цар Хүрээ	Номлогчийн Долоо Хоногийн Тайлан
Номлолын Удирдагчид		Утсаар Өгөх Өдрийн Тайлан
Хэсгийн Зөвлөл		Өсөлтийн Тайлан
Номлогч Нар		Номлогчийн Өдрийн Төлөвлөгөө; Бүсийн Ном

Эдгээр арга хэрэгслүүд болон таны хийх ажилд шаардлагатай бүх мэдээллүүд бүсийн ном болон Номлогчийн Өдрийн Төлөвлөгөөнд хадгалагддаг. Бүсийн ном нь доорх байдлаар зохион байгуулагддаг:

- **Бүсийн Газрын Зураг**
 - Бүсийн хилийг тодруулсан газрын зураг
- **Өсөлтийн Тайлан**
 - Өсөлтийн Тайлангийн маягтууд
- **Баптисмын болон Гишүүнээр Батлагдах Өдрийн Товлосон Сонирхогчид**
 - Заах Бүртгэлийн маягтууд
- **Өсч Буй Сонирхогчид**
 - Заах Бүртгэлийн маягтууд
- **Шинэ болон Бусад Сонирхогчид**
 - Заах Бүртгэлийн маягтууд
- **Гишүүн Болж Болох Сонирхогчид**
 - Гишүүн Болж Болох Сонирхогчдын маягтууд
 - Мэдээллийн дагуу олж авсан бусдын зааж өгсөн хүмүүсийн хүсэлт болон бусад бусдын зааж өгсөн хүмүүсийн мэдээллүүд
- **Хуучин Сонирхогчид**
 - Заах Бүртгэлийн маягтууд
- **Саяхны Хөрвөгчид болон Идэвх султай Гишүүд**
 - Заах Бүртгэлийн маягтууд
 - Хөрвөгчийн Ажил Хэргийн Жагсаалтын маягтууд
- **Хэсэг болон Номлолын Тайлан**
 - Хэсгийн жагсаалт
 - Хэсгийн албан тушаалын жагсаалт
 - Хэсэг болон номлогчийн хурлын хуваарь
 - Хэн нэг нь гишүүн гэр бүлүүдийн жагсаалт
 - Дүүрэг эсвэл бүс дэх номлогч нарын лавлагаа
- **Удирдлага**
 - Утсаар Өгөх Өдрийн Тайлан
- **Бүсийн Талаарх Мэдээлэл**
 - Байрны тухай мэдээлэл
 - Нийтийн унаа
 - Үсчин
 - Угаалгын газар
 - Худалдаа хийх газар
 - Зайлсхийх газар
 - Холбоо тогтоосон хүмүүс

Бүсийн Ном

Номлох бүс бүрт өдөр тутмын хүч чармайлтын тань үргэлжилсэн бүртгэлийг хөтөлсөн мэдээлэл болох бүсийн ном байдаг. Гол мэдээллийг өдөр бүр сэргээж, долоо хоногийнхоо төлөвлөх хэсэгтээ үүнийгээ харж бай. Үүнийг цэвэр, нямбай, алдаа мадаггүй хөтөл, ингэснээр дараачийн номлогч нар таны бурханлигаар нөлөөлөгдөн өгсөн үйлчлэлийг цааш үргэлжлүүлэх болно. Нэгтгэн дүгнэж, илүү үр дүнтэй хэрхэн ашиглахыг мэдэхэд тань туслахын тулд номлолын удирдагчийг хүсэлт гаргахад ярилцлага эсвэл бүсийн чуулганы үеэр бүсийн номоо авч очих ёстой.

Өөрсдийнхөө төлөвлөгөөг шинэчилж, мөн засахдаа өдөр бүр бүсийн номны аливаа нэг хэсгийг лавлан харах шаардлагатай. Бүсийн чуулганууд болон ярилцлагын үеэр бүсийн номоо авч ирснээр номлолын удирдагчид тэдгээрийг нь нэгтгэн дүгнэж болох юм. Таныг шилжин явсны дараа энэ ном байранд тань үлдэх ёстой бөгөөд ингэснээр ирээдүйн номлогч нар уг мэдээллийг ашиглаж чадна.

Бүсийн номондоо өөрсдийн зааж буй бүх хүмүүсийн алдаа мадаггүй хөтөлсөн, бүрэн, нямбай мэдээллийг хадгал. Арга замыг доор хангаж өгсөн болно.

Заах Бүртгэл: Энэ маягт нь таны зааж буй сонирхогчид, шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдийн өсөлтийн талаарх нарийвчилсан мэдээллийг тэмдэглэхэд танд тусална.

- Хувийн мэдээлэл.
- Багтисм болон гишүүний баталгааны өдрүүд.

ЕCУC ХРИСТИЙН ХОЖМИН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮДИЙН СУМ

Заасан Хүмүүсийн Талаарх Тэмдэглэл

Номлож буй бүс нутаг _____ Хэсэг буюу салбар _____ Гадас буюу дүүрэг _____

Хувийн Мэдээлэл (Нэмэлт хувийн мэдээллийн талаар маягтын ар талыг үзэж үзү.)

Хүний буюу гэр бүлийн хосуудын нэр (с)	Төрөл	Нас	Анх удаа бэлтгэгч өсөр	Төлөөлөл бэлтгэгч өсөр	Балтисм болгох өсөр	Гишүүнээр батлуулах өсөр	Хүүхдүүдийн нэрс (Өөр нэрсийг маягтын ар талыг боловсрол Гэр бүлийн Мэдээлэл хэсэгт бичиж болно.)
							Нэс Нэс Нэс

Ханг _____ Утасны дугаар _____ Анх зааж эхэлсэн номлогчид _____

Сүмийн гишүүн нэг нар болон гэрлийн мөн айтчигч болч нарын нэрс _____ Утасны дугаар _____ Ханг _____

*Төрөл: С – Сонирхогч; СХ – Саяхны хөрвөгч; ИСГ – Идэвх султай гишүүн; Г – Гишүүн; ГБНХГ – Гэр бүлийн нэг хэсэг нь гишүүн

Хичээл болон Зарчмуудыг Заасан Өдөр (Хэрэв сүмийн гишүүний хамт заасан бол дурдвал)	Сэргээлийн Захис		Зарлигууд		Сонирхогчид буюу Гэр бүлийн Тэргүүнд Зориулсан Үйл Ажиллагаа буюу Амалтунданд Байдал	
	Балтисмын Өмнө	Балтисмын Дараа	Балтисмын Өмнө	Балтисмын Дараа	Урьдчилсан	Дотоодын Байдал
Бурхан бол бидний хайрт Тэнгэрлэг Өдөр			Дуугаартай байдал			Мормоны Номноос Угш
Сайн мэдээ гэр бүлүүдийг ашиглах			Олонгаа залбар			Иосиф Смит болон Мормоны Номноо талаар Залбар
Сайн мэдээний эрэн үе			Сударуудыг судал			Ариун ёслол болон бусад үзлүүдэнд оролц
Дэлхий дээрх Аардгийн тохиолуул			Хүндэтгэлийн өдрийг ариунд нь сал			Хүүхдүүд Хүчтэйн Хэсэгт, Залуу Эргэлтүүд буюу Залуу Эмэгтэйчүүдэд оролцуул
Их Уурвал			Балтисм ба гишүүнээр батлуул			Номлогчид гэр бүл болон найз нараа танилдуул
Сэргээлт: Иосиф Смит			Бөхшигчидыг дага			Балтисмын үйл ажиллагаанд оролц
Мормоны Ном			Ариун Зарлигийг Сал			Бишлал болон хэсгийн зөвлөлийн гишүүдтэй уулзаж танилц
Залбарал, Ариун Сүнс			Ариун нэгдлийн хуулиар амьдар			Хэсгийн гишүүдтэй нөвсрөг хөлболог тогтоо
Аардлын Төлөвлөгөө			Моргэн Ухааны Үгийг Дуугаартай Дага			Ариун Зарлигийг Сал
Дэлхийн өмнөх амьдрал			Аардны нэгдлийн хуулийг сал			Ариун нэгдлийн хуулиар амьдар
Бүтээлт			Мэргэлийн хуулийг мөрд			Моргэн Ухааны Үгийг Дуугаартай Дага
Сонгох Эрх чөлөө ба Угшлал			Аардны нэг болон оролцууцдаг хэсгийн хандлага нь			Аардны нэгдлийн хуулийг сал
Дэлхий дээрх бидний амьдрал			Хуулийг дуугаартай дагаж, дээдэл			Мэргэлийн хуулийг мөрд
Цагаатгал			Хуулиуд ба Ёслолууд			Угш орны хуулийг мөрд
Сүнсний дэргэл			Санаар ба хавсралт байгуулагууд			Балтисм болон гишүүнээр батлуулахаар ирилцгээнд ор
Амалтунданд, шүүлт, ба үхэлгүй байдал			Номлогчийн амил			Тэдний балтисм болон гишүүнээр батлуулах ёслолд гэр бүл, найз нарыг үр
Ачааг сүлийн хаант улсууд			Мөхөлийн гэрээлт			Балтисм хүртэж, гишүүнээр батлуул
Есүс Христийн Сайн Мэдээ			Ариун Хүүхдүүд ба гэр бүлийн Түүх			Өдөр тутам хувиараа залбарч, судраас суралц
Нүгэлээс шэвэрлэсэн			Үйлчил			Өдөр тутам гэр бүлээрээ залбарч, судраас суралц
Есүс Христэд Итгэх Итгэл			Сүм дээр зааж ба суралцах нь			Долоо хоног бүр гэр бүлийн удирдгийг заажон нөөл
Намандар			Эцэс хургал тэвчих			Санаар хурт
Балтисм, бидний эхний гэрээ			Балтисмын Арилдлагын Ажилгуудыг Дага			Сүмийн дугаарыг хүлээн ав
Ариун Сүнсний бэлэг						Төлөөлөл хайртай балтисмд оролц
Эцэс хургал тэвчих						

(Нэмэлт хувийн мэдээллийн талаар маягтын ар талыг үзэж үзү.)

© 2004 BY, 704, 704, АНУ-д хэвлэв. 36687363

(Урд тал)

- Таван хичээл бүрийн зарчмуудыг хэзээ заасан мөн гишүүн байсан эсэх тэмдэглэл. Энэ хэсэг нь хичээл дэх зарчмуудын дэс дараанаас үл хамааран зааж байгаа зүйлээ тэмдэглэж авахдаа уян хатан байх боломж олгодог.
- Та нар багтисмын өмнө заагдсан хичээлүүд болон багтисмын дараах хичээлүүдийг тэмдэглэж авч болно.
- Сонирхогчдийн гүйцэтгэж буй даалгавруудын явцыг тэмдэглэ. Энэ хэсэгт та урилга өгсөн өдрийг тэмдэглэж, тэд даалгаврыг биелүүлсэн эсэхийг тэмдэглэ.

шинэчилж болно. Хэрэв хийж болохуйц бол, бишоп, хэсгийн номлолын удирдагч, мөн хэсгийн зөвлөлийн бусад гишүүдэд энэ тайлангийн нэг хувийг долоо хоног бүр, эсвэл хэрэгцээтэй тохиолдолд өгч болно. Өсөлтийн Тайлангийн маягт дээрх мэдээлэл бүрэн, зөв, мөн цэвэр хөтлөгдсөн байхад анхаар. Хэсгийн зөвлөлийн гишүүдийн танд итгэх итгэлийг энэ нь бэхжүүлэх болно.

Сонирхогч Байж Болох Хүмүүс: Энэ маягт нь сонирхогч байж болох хүмүүсийн тайланг бичиж тэмдэглэх боломжийг танд олгоно.

- Сонирхогч байж болох хүмүүсийн байдал. (Тухайн эрэгтэй эсвэл эмэгтэй хичээл сонирхохоо больсон, тухайн эрэгтэй эсвэл эмэгтэй эдүгээ заагдаж байгаа, эсвэл цаашид уулзах хэрэгтэй байгаа эсэх?)
- Тухайн хүн бусдын зааж өгсөн, эсвэл номлогч нарын олсон эсэх.
- Тухайн хүнтэй холбоо тогтоосон огноо.
- Чухал мэдээллүүд.

Сонирхогч байж болох хүмүүс

ЕСУС ХРИСТИЙН
ХОЖМИН ТЭГНИН
ГЭЗЭЭГИЙН СҮМ

Заж өгсөн хүмүүс буюу та нарын холбоо барьсан хүмүүст цааш нь холбоо тогтоосноор сэргээгдсэн сайн мэдээний тухай орон зайтайг хурдан зохионоорон байдлын талаарх мэдээллийн талбай.

Номлогчийн бүр бүс тусгай
Хэсэг буюу салбар
Галд буюу өгөр

Статус	Нэр	Ханг	Угсны дугаар	Тань хүлээж байна	Холбоо барьсан өдөр	Тайлбар (Сонирхох тухайн өдөр эсвэл цааш уулзах үйлдвэл)

* A – Алдсан; B – Үнэгт байгаа; Ш – Шаглах * * F – Гялгууны зааж өгсөн хүн; C – Сонирхогч зааж өгсөн хүн; FБ – Гялгуу бус хүний зааж өгсөн хүн;
СҮБ – Сүмийн хариуцах байгууллага зааж өгсөн хүн; H – Номлогч холбоо тогтоосон

Номлогчийн Өдрийн Төлөвлөгөөн дэх Сонирхогч байж болох хүмүүс хэсгээс чухал мэдээллийг Сонирхогч Байж Болох Хүмүүс маягтад хувилж бич. Цаашдын уулзалтууд, хэсгийн номлолын удирдагчтай гишүүний номлолын ажлыг нэгтгэн дүгнэх, мөн эдгээр хүмүүст сэргээгдсэн сайн мэдээг сонирхож эхлэхэд нь туслах бусад үйл ажиллагаануудыг төлөвлөхөд энэ мэдээллийг ашигла. Энэ маягт нь түүнчлэн цаашид уг бүсэд томилогдох номлогч нарт зориулсан түүхэн бүртгэл маягаар үйлчилнэ. Өөр бүс рүү шилжихдээ Номлогчийн Өдрийн Төлөвлөгөөн дэх бүх мэдээллээ хувилж өгөхөд анхаар.

Зорилгуудаа Хэрхэн Тавих Вэ?

Зорилгууд бол бидний зүрх сэтгэлийн хүслийг болон бидний биелүүлж чадах зүйлсийн төсөөллийг илэрхийлдэг. Зорилгууд болон төлөвлөгөөнүүдээр дамжуулан найдварууд маань үйл хөдлөлд шилждэг. Зорилго тавьж мөн төлөвлөх нь итгэлийн үйлдэл юм. Залбиралтайгаар төлөвлөх нь “бүх үндэстэнд зааж, тэдэнд Эцэг мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээ” (Матай 28:19) хэмээн Аврагчийн хэлсэнтэй нийцэхүйц юм.

Үндсэн үзүүлэлт бүр дээр зорилго тавь. Түүнчлэн та хувийнхаа өсөлт хөгжилтийн төлөө зорилго тавьж болох юм. Бусдын сонголтыг хүндэтгэж, зорилгодоо хүрэхийн тулд чадлынхаа хэрээр бүх зүйлийг хий. Амжилтын хамгийн гол хэмжүүр бол дан ганц зорилгодоо хүрэх бус харин таны үзүүлсэн үйлчлэл болон бусад хүмүүсийн өсөлт юм. Зорилгууд нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд дунд олон сайн зүйлсийг авчрахад танд туслах арга хэрэгсэл юм. Тэдгээрийг алдар хүнд олохын тулд ашиглах ёсгүй.

Анхааралтай тунгаан бодсон зорилгууд танд жинхэнэ удирдамж өгч мөн Аврагчид итгэх итгэлээ хүчирхэгжүүлж, баптисм, гишүүний баталгаа өөд өсч хөгжиж, Сүмд бүрэн идэвхтэй байхад нь хүмүүст туслах үйл ажиллагаануудаар таны өдрийг дүүргэх болно. Сорилттой зорилгууд нь идэвх зүтгэлтэй ажиллахад тань танд тусалж мөн бүх хүчээ шавхаж, өсөх замд таныг хөтлөх болно. Зорилго тавихдаа доорх зааварчилгааг дага:

- Сүнсийг дага.
- Үндсэн үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуул.
- Хүмүүст анхаарлаа хандуул. Хэдийгээр та тоонуудыг ашиглах боловч хүмүүсийн нэрсээр уг тоонуудаа дэмжих боломжтой бай.
- Тодорхой болоод үнэн бодитой бай, гэвч өөрийнхөө хүрэх хэмжээнд тулгуурлан зорилго тавь.
- Долоо хоног тутмын болон өдөр тутмын зорилгууд тавь.
- Хэрэв өөр хэл сурч байгаа бол хэл судлахыг багтаасан хувийн болон хамрагчтайгаа биелүүлэх зорилгууд тавь.
- Өдөр бүр, долоо хоног бүр, мөн зургаан долоо хоног бүр өөрийн өсөлтийг шалга. Зорилгоо биелүүлж чадахгүй болсон үедээ өөрийн хүч чармайлтаа дүгнээд, уг зорилгыг биелүүлэх арга замуудыг эрэлхийл. Хэрэв шаардлагатай бол, өөрийн хүсэн хүлээж буй зүйлээ өөрчил.

“Хэрэв амьдралдаа зорилго тавихгүй, мөн уг зорилгодоо хүрэх амьдралын арга барилыг хэрхэн сайн эзэмшихийг сурахгүй бол бид өмнөх үеийнхэнтэйгээ ижил байдалд хүрч мөн амьдралаа эргэн харахдаа бүх боломжуудынхаа зөвхөн өчүүхэн хэсгийг ашигласан болохыг мэдэх болно гэдэгт би маш их итгэдэг. Аливаа хүн зорилго тавих зарчмуудыг илүү сайн эзэмшнээр тэрээр энэ амьдралд олж авсан үр дүнгээ агуу ихээр өөрчилж чадах боломжтой байх болно.”

—АХПАГЧ М.РАССЕП БАЛПАРД
СОЛТ ЛЕЙЖИЙН БУСИЙН ЗАЛУУ НАСАНД ХҮРЭГЧДЭД ХЭЛСЭН
УГ, 1981 ОНЫ АРАВДУГААР САРЫН 18

Таны зорилгыг дээшлүүлж мөн итгэлийг тань нэмэгдүүлэхийн тулд үе үе удирдагчид тань гарамгай байдлын жишгүүдийг бий болгодог. Дүүрэг, бүс, болон номлолын жишгүүд нь өсч хөгжин, идэвхтэй ажиллаж, мөн гүйцэтгэлийн өндөр түвшинд хүрэхэд тань танд туслах болно. Тэдгээр нь танд болон хамтрагчид тань тодорхой зорилгыг тулгах ноогдол мэтээр ашиглагдах ёсгүй.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Үзүүлэлт бүрт тохирсон долоо хоног тутмын зорилгуудыг тавь. Зорилго бүрийн хувьд өөрөөсөө асуу:

- Нэрс тоонуудтай харилцан хамааралтай байна уу?
- Энэ зорилго тодорхой байна уу?
- Энэ зорилго бодитой юу?
- Энэ зорилго биднийг өсгөж хөгжүүлэх үү?
- Энэ зорилгыг биелүүлэхийн тулд бид бүхнээ зориулах уу?

Зорилго бүрийг ярилц. Хэрэв шаардлагатай бол, үүнийг хэрхэн өөрчлөхийг болон яагаад гэдгийг олж тогтоо.

Долоо Хоногийн Төлөвлөгөө

Зорилгоо тавьсны дараа тэдгээрийг хэрхэн биелүүлэхээ шийд. Хамтрагчтай хамт долоо хоног тутмын төлөвлөх хэсгийг Пүрэв эсвэл Баасан гарагийн өглөө гэх мэт номлох ажил хийхэд үр дүн муутай өдөр мөн цагт хийх ёстой. Номлолын ерөнхийлөгч тань долоо хоног тутмын төлөвлөгөө гаргах өдөр мөн цагийг тогтоож өгөх болно. Долоо хоног тутмын төлөвлөгөө гаргаж дуусахад хоёр юм уу гурван цаг орно.

Та нарын ярилцлага хүмүүсийн хэрэгцээнүүд болон тэднийг өсч хөгжихөд нь хэрхэн туслах тал дээр төвлөрөх ёстой. Долоо хоногийн төлөвлөгөө гаргах явцдаа өнгөрсөн зорилгуудаа нэгтгэн дүгнэж, ирэх долоо хоногийн шинэ зорилгуудыг тавь. Номлох боломж бүрийг авч үз.

Ням гарагийн үдэш нь долоо хоног тутмын утсаар авах тайланд зориулагддаг. Ихэнх баптисм болон гишүүний баталгаа Бямба эсвэл Ням гарагуудад болдог учраас Ням гарагийн үдшийн тайлан нь номлолыг хамгийн зөв мөн цагаа олсон мэдээллээр хангадаг.

Долоо хоногийн төлөвлөгөө гаргах өдөр тань тайлагнах өдрөөс ерөнхийдөө өөр байх учраас долоо хоногийнхоо төлөвлөгөөг 10 өдөр байхаар бодож хий. Жишээ нь, хэрэв долоо хоногийн төлөвлөгөө гаргах өдөр тань Пүрэв гараг бол тухайн долоо хоногт зорилгуудынхаа биелэлтийг нэгтгэн дүгнэх болно, мөн Ням гараг хүртэл эдгээр зорилгуудаа биелүүлэхийн тулд юу хийх шаардлагатайгаа та төлөвлөх болно. Тэгээд, ирэх долоо хоногийн төлөвлөгөөгөө Даваа гарагаас Ням гараг хүртэл төлөвлөх болно. Ням гарагийн үдэш өнгөрсөн долоо хоногийнхоо зорилгыг нэгтгээд үр дүнг нь тайлагнах бөгөөд та нарт ирэх долоо хоногийн төлөвлөгөө аль хэдийн бэлэн байх болно. Төлөвлөх зааварчилгаа нь долоо хоног тутмын төлөвлөгөөнд хэрхэн ашиглагдахыг дор дүрсэлсэн болно.

1. Залбирч мөн бурханлиг нөлөөллийг эрэлхийл. Эхлэхээсээ өмнө Номлогчийн Өдрийн Төлөвлөгөө болон бүсийн номыг ойр байлга. Төлөвлөгөө гаргахаасаа өмнө залбир. Хүмүүсийн хэрэгцээг ярилцаж, мөн тэдэнд хэрхэн үйлчилж, сайн мэдээнд өсч хөгжихөд нь тэдэнд туслах төлөвлөгөө гарга. Ялангуяа сонирхогчдынхоо төлөө

залбир. Залбирлуудад нь хариулж, сүмд явах хүсэлтэй болгох зэргээр тэднийг адислахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйх итгэлтэй бай.


2. Ирэх долоо хоногт сонирхогчдоо баптисм хүртэж мөн гишүүнээр батлагдах зорилго

тавьж мөн төлөвлөгөө гарга. Баптисм хүртэхээр эсвэл ирэх долоо хоногт гишүүнээр батлагдахаар амлалт авсан хүн бүрийн Заах Бүртгэлийг нэгтгэн дүгнэ. Баптисмын ярилцлагууд, үйлчлэлүүд болон гишүүний баталгаануудад шаардлагатай бэлтгэл ажлыг ярилц. Заах Бүртгэлийг ашиглаж эдгээр хүмүүс дагахад хэцүү байгаа аливаа даалгаврууд болон та нар тэдэнд хэрхэн тусалж чадахаа ярилц. Тэдэнтэй өдөр бүр холбоо барихаар төлөвлө. Ариун ёслолын цуглаан дээр тэднийг гишүүнээр батлахад бишоптой хамтран ажиллахад нь хэсгийн номлолын удирдагчид хэрхэн тусалж чадахаа ярилц.

3. Баптисмын өдрөө товлосон сонирхогчдын төлөө зорилгууд тавьж мөн төлөвлөгөө гарга. Ирэх долоо хоногт баптисм хүртэх хүн бүрийн Заах Бүртгэлийг нэгтгэн дүгнэ. Тэдэнд заах хэрэгтэй хичээлүүдийн талаар ярилц. Тэд баптисм болон гишүүний баталгаанд бэлтгэхэд нь та нар хэрхэн тусалж чадахаа бодож үз. Товлосон өдрөө баптисм хүртээгүй сонирхогчдын талаар ярилц. Тэдний хэрэгцээнүүдийг анхааралтай авч үзэн мөн ярилц. Баптисмын гэрээнд орж мөн гишүүний баталгааны ёслолыг хүлээн авч чадах тодорхой өдөр мөн цаг товлон тийш өсч хөгжихөд нь тэдэнд туслах шинэ зорилго тавьж мөн төлөвлөгөөнүүд гарга. Заах Бүртгэлдээ заахаар төлөвлөж буй зарчмууд болон сахихад нь тэдэнд туслах даалгавруудыг харандаагаар тэмдэглэ. Эдгээр хичээлүүдийг хүлээн авч мөн эдгээр даалгавруудыг сахихад нь тэдэнд туслахын тулд юу хийж чадахаа олж тогтоо.

4. Ариун ёслолд ирэхэд нь сонирхогчдод туслах зорилгууд тавьж мөн төлөвлөгөөнүүд гарга.

Сонирхогч бүрийн Заах Бүртгэлийг нэгтгэн дүгнэ, мөн түүний ариун ёслолд хэр ирж буй талаар ярилц. Ариун ёслолын цуглаанд тогтмол ирж байгаа сонирхогчдын хувьд, цаашид урам өгөх тохиолдлуудтай байхад нь тэдэнд туслахын тулд юу хийх хэрэгтэйгээ ярилц. Ариун ёслолын цуглаанд хэзээ ч ирж байгаагүй хүмүүс, зөвхөн ганц удаа ирсэн хүмүүс, мөн үе үе ирдэг хүмүүсийн хувьд ирэхэд нь юу саад болж буйг ярилц. Жишээ нь, тэдэнд унаа хэрэгтэй байж болно, тэд Хожмын Үеийн



Гэгээнтнүүдийн нийтлэг бус үйлчлэлүүдээс эмээдэг байж болно, эсвэл өнгөрсөн хугацаанд тэд таагүй явдлуудтай учирсан байж болох юм. Эдгээр саад бэрхшээлүүдийг даван туулахад нь тэдэнд та нар хэрхэн тусалж чадах талаар ярилц. Дараагийн ариун ёслолын цуглаанд ирүүлэх сонирхогчдыг төлөвлө. Тэдгээр хүмүүсийг сүмд авчрах хүмүүс, тэдэнтэй мэндлэх хүмүүс, цуглааны үеэр тэдэнтэй хамт суух хүмүүсийг төлөвлө. Сонирхогчийн оролцох чуулга, болон туслах бүлгийн удирдагчид мөн ангиудыг хариуцсан багш нартай холбоо барихаар төлөвлө. Бишопт танилцуулахаар төлөвлө. Өсөлтийн Тайланд хэсгийн зөвлөлийн тусалж чадах арга замуудыг жагсаан бич. Тэдгээр хүмүүсийг ирэхэд бэлтгэхийн тулд долоо хоногийн өдөр бүр юу хийх хэрэгтэй болох төлөвлөгөө гарга.

5. Өсч буй сонирхогчдод заагдах хичээлүүдэд зориулан зорилго тавьж мөн төлөвлөгөө гарга.

Гишүүн оролцож заагдсан өсч буй сонирхогч бүрийн Заах Тайланг нэгтгэн дүгнэ. Тэднийг захиасыг хүлээн авч байхад өөртөө төрсөн сэтгэгдлээ ярь. Заах Бүртгэлээс сахихад эсвэл дүүргэхэд нь тэдэнд хүндрэлтэй байгаа даалгаврууд болон үйл явдлуудыг нэгтгэн дүгнэ. Тэдний өсөлтөд хэсгийн гишүүд болон хэсгийн зөвлөл хэрхэн оролцсон хэвээр байх талаар ярилц. Заах хичээлүүд; биелүүлэхэд нь тэдэнд туслах даалгаврууд, ялангуяа сүмд нь ирэх; мөн ирэх хэд хэдэн долоо хоногт тэдэнд тохиолдох чухал явдлуудад туслахаар зорилгууд тавь.

Гишүүн оролцуулалгүйгээр заасан өсч буй сонирхогч бүрийн Заах Бүртгэлийг нэгтгэн дүгнэ. Эдгээр сонирхогчид нь та нарын хүчин чармайлтаар олдсон хүмүүс байж болно. Тэдэнтэй нөхөрлүүлэхэд аль санваарын болон туслах бүлгийн удирдагчид боломжтой талаар ярилц. Өөрсдийн заах хичээлүүд болон сахихад нь тэдэнд та нарын тусалж чадах даалгавруудыг нэгтгэн дүгнэ. Та нарын заах хичээлүүд, гишүүдийг хэрхэн оролцуулах, мөн ариун ёслолын цуглаанд ирэхэд нь тэдэнд та нар хэрхэн тусалж чадах талаар зорилго тавь. Эдгээр зорилгуудаа Заах Бүртгэл дээр тэмдэглээд шаардлагатай төлөвлөгөөнүүд гарга.

6. Бүх сонирхогчдод заах ёстой хичээлүүдийн талаар зорилго тавьж мөн төлөвлөгөө гарга.

Өсөхгүй байгаа сонирхогч бүрийн Заах Бүртгэлийг нэгтгэн дүгнэ. Сонирхогч бүр яагаад даалгавруудыг биелүүлэхгүй байгааг ярилц. Эдгээр сонирхогчидтой нөхөрлөхөд санваарын болон туслах бүлгийн удирдагчдыг хэрхэн оролцуулах талаар ярилц. Алхам 5-д зөвлөсөн ижил төстэй олон зүйлсийг ярилц. Эдгээр хүмүүсийг өсөхөд нь туслах зорилгууд тавьж мөн төлөвлөгөө гарга. Эдгээр зорилгуудаа Заах Бүртгэл дээр бич.

7. Гишүүд, сонирхогчид, гишүүн бус хүмүүс, болон Сүмийн удирдлагын төвөөс хүлээн авсан бусдын зааж өгсөн хүмүүстэй холбоо тогтоож мөн заах зорилгууд тавьж, мөн төлөвлөгөө гарга.

Сонирхогч Болж Болох Хүмүүсийн маягтыг нэгтгэн дүгнэ. Өөрсдийнхөө хүлээн авсан бусдын зааж өгсөн хүмүүсийн талаарх бүх мэдээллийг нэгтгэн дүгнэ. Холбоо тогтоож амжаагүй байгаа бусдын зааж өгсөн хүмүүсийн талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэ. Тухайн долоо хоногт аль болох олон бусдын зааж өгсөн хүнтэй — болбол бүх бусдын зааж өгсөн хүнтэй холбоо тогтоох зорилго тавьж мөн төлөвлөгөө гарга. Хэрэв боломжтой бол, Сүмийн удирдлагын төвөөс ирсэн бусдын зааж өгсөн хүмүүстэй 24 цагийн дотор холбоо тогтоох ёстой. Тухайн хүн болон гэр бүл бүртэй хэрхэн уулзах мөн ямар захиасыг тэдэнд зааж болох талаар ярилц. Хэрэв бусдын зааж өгсөн хүмүүсийн тухай мэдээлэл нь Сүмийн удирдлагын төвөөс ирсэн бол тэдний хүсэлт тавьсан видео, ном, эсвэл бусад материалыг ашиглан сайн мэдээний захиасыг хэрхэн заах талаар ярилц. Тэдний хүсэлт тавьсан зүйлсийг авч явахаа бүү март. Хэрэв тохиромжтой бол, бусдын зааж өгсөн хүнтэй утсаар холбоо тогтоож уулзах болзоо тавь. Дахин уулзахдаа юу хийх талаараа ярилц.

8. Гишүүд, сонирхогчид болон гишүүн бус хүмүүсээс бусдын зааж өгсөн өөр хүмүүс олох зорилгууд тавьж мөн төлөвлөгөө гарга. Уулзаж болох бусад гишүүд болон сонирхогчдыг залбиралтайгаар олж тогтоо. Сэргээгдсэн сайн мэдээний талаар сурахад нь гишүүд болон гэр бүлийнхээ гишүүдийг урихад тэдэнд хэрхэн тусалж болох талаар ярилц. Номлогчийн ажилд оролцохыг тэднээс хэрхэн хүсэх талаар ярилц. Уулзах цаг тохирч, шаардлагатай төлөвлөгөөнүүд гарга.

9. Саяхны хөрвөгчид болон идэвх султай гишүүдэд хичээлүүд заах зорилгууд тавьж, мөн төлөвлөгөө гарга. Зааж байгаа саяхны хөрвөгч болон идэвх султай гишүүн бүрийн

талаарх Заах Бүртгэл дээрх мэдээллийг нэгтгэн дүгнэ. Заах хичээлүүдээрээ зорилго тавьж мөн төлөвлөгөө гарга. Эдгээр хүмүүс ариун ёслолын цуглаанд ирж мөн бусад даалгавруудыг гүйцэтгэхэд нь тэдэнд хэрхэн тусалж болохыг олж тогтоо.

10. Шинэ сонирхогчид олох зорилгууд тавьж мөн төлөвлөгөөнүүд гарга. Бусдын зааж өгсөн хүмүүс, үйлчлэх боломжууд, болон хувийн олох үйл ажиллагаагаар дамжуулан өнгөрсөн долоо хоногт шинэ сонирхогчид олохын тулд гаргасан хүчин чармайлтуудаа нэгтгэн дүгнэ. Бүсийн номон дахь “Сонирхогч Болж Болох Хүмүүс” хэсэг дэх мэдээллүүдийн талаар ярь. Яагаад зарим хүмүүс шинэ сонирхогчид болж мөн бусад нь болдоггүйг ярилц. Энэ долоо хоногт хэдэн шинэ сонирхогч олох талаар зорилгууд тавь. Сонирхогч болох магадлалтай хүмүүсийг олж тогтоо. Түүнчлэн айлчлан очихыг хүсч байгаа гишүүд болон гэр бүлийн зарим нь гишүүн; бусдын зааж өгсөн хүмүүс мөн эрэлхийлж буй үйлчлэх боломжуудыг олж тогтоо. Дамжуулах карт, видео кассетууд, DVD-нүүд, судрууд эсвэл товхимолууд гэх мэт ямар олох арга хэрэгслийг ашиглахаа төлөвлө. Мөн хаашаа явж хүмүүстэй холбоо тогтоох, өдөр бүр хэдэн хүнтэй холбоо тогтоох, заалгах хүмүүсийн талаар асуух, айлчлан очих ёстой хуучин сонирхогчид, хэсгийн зөвлөлүүд туслах арга замууд гэх зэргийг ярилц. Дараачийн өдрийн тодорхой төлөвлөгөөнүүд гарга. Үлдсэн цаг хугацааг зорилгодоо хүрэхэд тань туслах олох үйл ажиллагаануудаар дүүргэ. Их Эзэн замд тань тааралдуулах аль болох олон хүнтэй ярих зорилгууд тавь. Үргэлж заах хүмүүс олохыг хичээ.

11. Хэсгийн зөвлөлтэй хэрхэн ажиллахаа төлөвлө. Бишоп бол тэргүүлэх эрх мэдэлтэн. Түүний эрх мэдлийг хүндэтгэж, эрхэмлэ. Түүний удирдлага дор, зохицуулах хурал эсвэл хэсгийн зөвлөлийн хурлаар өмнөх номлогч нарын ашиглаж байсан Өсөлтийн Тайланг нэгтгэн дүгнэ. Бишоп эсвэл хэсгийн номлолын удирдагчаас хүлээж авсан томилолтуудыг ярилц, мөн тэдгээрийг биелүүлсэн эсэхээ тайлагна. Хэсгийн номлолын удирдагч, санваарын болон хавсралт байгууллагын удирдагчид хийгээд бусад гишүүд зэрэг тусалж чадах бусад хүмүүсийг хэрхэн оролцуулах талаар ярилц. Дараагийн хэсгийн зөвлөлийн хурал, санваарын гүйцэтгэх хорооны хурал, эсвэл номлогчийн зохицуулах хуралд зориулан Өсөлтийн Тайланг анхааралтай бэлтгэ. Энэ нь нямбай бичиж тэмдэглэсэн мөн цэвэр байхад анхаар. Хэсгийн удирдагчидтай зохицон ажиллах зорилгууд тавьж мөн төлөвлөгөө гарга. Боломжтой үедээ хуралд оролцох хэсгийн удирдагчдад зориулан Өсөлтийн Тайланг хувилж бэлтгэ.

12. Байнга болдог хурлуудын хуваарь гарга. Дүүргийн хурлууд, бүсийн чуулганууд, ярилцлагууд, мөн Сүмийн цуглаанууд зэрэг тогтмол болдог хурлуудыг Номлогчийн Өдрийн Төлөвлөгөөн дээр тэмдэглэ. Эдгээр хурлуудын өмнө гүйцэтгэх шаардлагатай даалгавруудыг ярилц, тэдгээрийг Тэмдэглэл/Хийх Ажлын Жагсаалт дээрээ нэмж бич.

13. Хамтрагчтайгаа хийх ярилцлагыг хөтлөн явуул. Долоо хоног тутмын төлөвлөгөө гаргах хэсгийн төгсгөлд хамтрагчтайгаа боломжтой зорилгуудыг хуваалцаж, тэдгээрийг гүйцэтгэхийн тулд түүний тусламжийг хүс. Та хоёрын хоорондох харьцаа хэр хүчтэй байгааг хамтрагчтайгаа ярилц. Хамтрагчтайгаа нэгдэн ажиллах эсвэл дуулгавартай байхад саад болж буй аливаа сорилтуудыг ярилц. Аливаа асуудал байвал шийд. Хамтрагчийнхаа хүч чадлын талаар ямар бодолтой байгаагаа хамтрагчтайгаа хуваалц. Хэрхэн сайжирч болох талаар зөвлөгөө ав. Хэрэв шаардлагатай бол, хоорондох харьцаагаа сайжруулах зорилгууд тавь. Төгсгөлд нь залбир.

Өдрийн Төлөвлөх Цаг

Төлөвлөх хэсгийг өдөр бүрийн төгсгөлд явуул. Хэрэв хичээл зааж байгаа бол та нар 21:30 хүртэл гадуур явж болох юм. Өөрөөр, байрандаа 21:00 цагт буцаж ирээд өдөр тутмын төлөвлөх хэсгийг 21:00–аас 21:30 хүртэл хий. (Тухайн орон нутгийн нөхцөл байдлаас үүдэн уг хуваарийг номлолын ерөнхийлөгч өөрчлөх эрх мэдэлтэй.) Өдрийн төлөвлөх цагт мөрдөж байсан нэг ижил зарчмууд болон зааварчилгааг, гэхдээ энгийн аргаар ашигла. Хувиараа болон хамтрагчтайгаа суралцахдаа төлөвлөгөөнд тань туслах судалж болохуйц хичээлүүд эсвэл сэдвүүдийг ярилцахдаа залбиралтай бай. Өдрийн цагийн хуваарь дээр хангаж өгсөн зайд эдгээр сэдвүүдээ бич. Өдрийн цагийн хуваариа нэгтгэн дүгнэ. Өдрийн цаг бүрийг үр дүнтэй үйл ажиллагааг төлөвлө. Ням гарагийн төлөвлөх хэсгийн үеэр долоо хоног тутмын Утсаар Өгөх Өдрийн Тайлангаа нэгтгэж мөн батал, тэгээд номлолын ерөнхийлөгчид бичих долоо хоног тутмын захидлыг бич, мөн ирэх долоо хоногийн төлөвлөгөөнүүдийг нэгтгэ.

Дараачийн өдөр байрнаасаа гарахаасаа өмнө зорилгууд, төлөвлөгөөнүүд, мөн цагийн хуваариа нэгтгэн дүгнэ. Хэрэв шаардлагатай бол дахин засвар хий. Байрнаасаа гарахаасаа өмнө үргэлж залбир. “Одоо би юу хийх ёстой вэ?” хэмээн бусдаас асуух шаардлагагүй болсон үед л өдөр тутмын тань төлөвлөгөөнүүд хэр үр дүнтэй болохыг та хэлж чадна.

Хариуцлагатай Байх нь

Хариуцлагатай байх зарчим нь Бурханы мөнхийн төлөвлөгөөний үндэс суурь юм. Эцсийн шүүлтийн үеэр бид бүгд Их Эзэний өмнө зогсож, Түүний бидэнд өгсөн боломжуудыг хэрхэн ашигласнаа тайлагнах болно (Алма 5:15–19; С ба Г 137:9-ийг үз). Амьдралын тань турш ашиг тусаа өгөх хариуцлагатай байдлын талаар маш их зүйлийг та номлолдоо сурч чадна. Хэрэв та доорх зүйлийг хийх аваас хариуцлагатай байх зарчим таныг адислах болно:

- Зорилго тавих мөн төлөвлөх хүч чармайлт тань залбирлаар дамжуулан номлолын удирдагч мөн Их Эзэнд хариуцлага хүлээнэ гэсэн бодолтой ойртуул.
- Их Эзэний танд өгсөн нандин итгэлд хувийн хариуцлагатайгаа мэдэр.
- Үр дүн бүхий зорилгууд тавих.
- Их Эзэнд болон номлолын удирдагчиддаа ажлынхаа төлөө хариуцлага хүлээхдээ санаачлагатай байхыг сонго. Асуухыг бүү хүлээ. Ойр ойрхон бусад хүмүүс таны араас эргэн шалгаж байхыг бүү шаард. Өөрийнхөө хөдөлмөрийг өөрөө хариуцах хүсэлтэй бай.
- Өөрийнхөө хүч чармайлтыг бүрэн хариуцахыг хүлээн зөвшөөр. Хүнд нөхцөл байдал эсвэл өсч хөгжихгүй байгаадаа бусдыг бүү буруутга.
- Удирдагчдаасаа суралцахыг эрэлхийл, мөн та сайжирч болох арга замуудыг зөвлөхийг тэднээс хүс.
- Чадлынхаа хэрээр хөдөлмөрлөх сонирхолтой бай.

“Гүйцэтгэл хэмжигдэх үед гүйцэтгэл сайжрах болно. Гүйцэтгэл хэмжигдэж мөн тайлагнахад сайжралын хэмжээ хурдсах болно.”

–АХПАГЧ ТОМАС С.МОНСОН

“THOU ART A TEACHER COME FROM GOD,”
IMPROVEMENT ERA, 1970 ОНЫ АРВАНХОЁРДУГААР
САР, 101

Тэмдэглэл

Хариуцлагатай байх нь зөвхөн номлолын тань төгсгөлд ирдэггүй. Энэ нь та хэрхэн эхэлсэн, танд Их Эзэний өгсөн үүрэг хариуцлагын талаар юу бодож, ямар сэтгэгдэлтэй байгаа, ажлаа хэрхэн холбож байгаа, та хэрхэн тэвчих зэрэгт нөлөөлөх зарчим юм. Номлолдоо тохиолдох зүйлст хандаж буй хандлага тань Тэнгэрлэг Эцэг мөн Түүний Хүүг хайрлах таны хайр, мөн санваарыг хэрхэн хүндэтгэж буйн тусгал.

Хувиараа болон хамтрагчтайгаа залбирахдаа өдөр бүр юу хийх ёстой зүйлдээ бурханлиг илчлэлтийг эрэлхийл. Төлөвлөгөөнүүдээ дагахдаа зааварчилгааны төлөө Их Эзэнд залбирч, мөн түүнээс асуу. Хаашаа явах, юу хийх, юу хэлэхэд тань Сүнс тусалж болохын тулд өдрийн турш зүрх сэтгэлдээ залбир. “Би илүү юу хийж чадах вэ?” гэж өөрөөсөө асуу. Өдрийн төгсгөлд залбирахдаа хийсэн ажлаа дүгнэ.

Утсаар Өгөх Өдрийн Тайланг ашиглан долоо хоног бүр та дүгнэлтээ номлолын удирдагчидад өгөх болно. Хэрэв та номлолын удирдагч бол, та бусад номлогч нараас энэ мэдээллийг хүлээн авах болно. Зөвхөн тоонд анхаарахаас илүү тэдний амьдрал, мөн тэдний зааж буй хүмүүсийн амьдралд анхаар. Эдгээр хэрэгслүүд эсвэл хүлээн авсан мэдээллээ хянаж шалгах, эсвэл зохицуулах арга хэрэгсэл болгон бүү ашигла. Эдгээр арга хэрэгслээр хүлээн авах мэдээлэл номлогч нарыг бүхнээ зориулсан үйлсийг дэмжих боломжийг та олгож мөн цаашдын сургалтад хэрэглэх арга барилуудыг олж мэдэхэд тусална.

Судар Судлах

Хариуцлагатай байх гэдэг нь ямар утгатай вэ?

С ба Г 58:26–33

С ба Г 101:78

Езекиел 33:1–6

Хариуцлагатай байхад сонголт яагаад чухал вэ?

2 Нифай 2:26–29

Хиламан 14:30–31

Номлогч, номлолын удирдагч хоёр хэрхэн хамтран ажиллах ёстой вэ?

С ба Г 38:23–25

Еврей 13:17–18

Үүнийг Сана

- Зорилгууддаа гаргаж буй хүч чармайлтаа анхаар.
- Үндсэн үзүүлэлтийн дагуу зорилгуудаа тавь.
- Зорилгууд болон төлөвлөгөөнүүдийнхээ төлөө хүчирхэг залбирал хий.
- Хүмүүс итгэлээ хөгжүүлж, наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчихэд нь туслахын тулд бүсийн ном болон Номлогчийн Өдрийн Төлөвлөгөөг ашигла.
- Үндсэн үзүүлэлт бүр дээр таныг өсч, итгэлээ хөгжүүлж, мөн үр бүтээлтэй ажиллахад туслах зорилгууд тавь.
- Бусад хүмүүс сайн мэдээнд өсч хөгжихөд нь туслахад анхаарсан долоо хоногийн болон өдрийн төлөвлөх цагийг хөтлөн явуул.
- Их Эзэнд болон номлолын удирдагчиддаа хүч чармайлтаа тайлагна.

Заах Санаанууд ба Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- “Үүнийг Анхаар” хэсэгт байгаа асуулт бүрт нэг өгүүлбэр бүхий хариултуудыг судлах тэмдэглэлдээ бич.
- Номлолын талбар дахь хамгийн сүүлчийн өдрийнхөө тухай хэдэн минут бод. Тэр өдөр болоход:
 - Номлогчийн хувьд ямар зүйл хийсэн гэж хэлэхийг хүсч байна вэ?
 - Та юуг болсон байхыг хүсч байна вэ?
 - Өөрт тань ямар өөрчлөлтүүд гарсныг бусад хүмүүс ажиглаарай гэж та бодож байна вэ?

Эдгээр асуултуудын хариултыг судлах тэмдэглэлдээ бич. Эдгээр зорилгуудыг бодит болгохын тулд юу хийх хэрэгтэйгээ олж тогтоо. Санаанд тань орж ирсэн төлөвлөгөөнүүдээ бич.

Хамтрагчтайгаа Суралцах

- Бүсийн номоо ашиглан доорх асуултуудад хариул:
 - Бүх мэдээллүүд шинэчлэгдсэн, зөв, мөн уншихад хялбар байна уу?
 - Энэ бүсэд шинээр ирэх номлогч бүсийн номыг нэгтгэн дүгнэж, хүмүүс сүнслэг байдлынхаа хувьд хаана байгаа мөн тэдэнд туслахын тулд юу хийх хэрэгтэйг мэдэж чадах уу?
 - Уг бүсэд шинээр ирсэн номлогч шинэ сонирхогчид олох хүч чармайлтаас тань ашиг тусыг олж болох уу?
 - Бүсийнхээ хүмүүсийн төлөө хэрхэн анхаарч байснаа тайлагнахаар Их Эзэнд бүсийн номоо үзүүлж байгаагаар төсөөл. Таны хүч чармайлтыг Их Эзэн таална гэж бодож байна уу?
- Сонирхогчдынхоо нэгний талаар ярилц. Номлогчийн Өдрийн Төлөвлөгөөн дээрээ нэг хуудсыг “Баптисм, Гишүүний Баталгаа, мөн Сүмд Идэвхтэй Болгох Үйл Явдлууд” гэж гарчигла. Нэг үйл явдлыг сонгоод, энэ үйл явдлыг тохиолдуулахын тулд хийж чадах бүх зүйлийн жагсаалт бич. Уг үйл явдал боломжийн хэрээр эрт болж болохын тулд эдгээр даалгавруудыг хэрхэн төлөвлөж болохоо ярилц.
- Доорх адилтгалыг хамтрагчтайгаа ярилц. Өдөр бүр усанд шидэх таны дэгээ хэр урт байдгийг үнэл.

“Бидний хэн ч бүхэл өдөржингөө загасчилж байна гэж бодох боловч үнэн хэрэгтээ ихэнх цагаа гол руу явах, мөн буцах, мөн өдрийн хоол идэж, хэрэгслээ гял цал болгоход зориулдаг загасчинтай адил байх ёсгүй. Загасчилж амжилт олох нь байрнаасаа хэдэн цаг хол байгаатай бус харин хэр удаан дэгээгээ усанд тавихтай холбоотой. Зарим загасчид гэрээсээ арванхоёр цаг хол байж, дэгээгээ арван цаг усанд тавьдаг. Бусад загасчид гэрээсээ арванхоёр цаг хол байж, дэгээгээ усанд зөвхөн хоёр цаг тавьдаг. Яагаад бусадтай адилхан амжилт гаргахгүй байгаадаа хоёр дахь төрлийн хүмүүс гайхдаг.”

“ ‘Хүмүүсийн загасчид’ хэмээн Эзэний нэрлэсэн номлогч нарт үүнтэй ижил зарчмаар үйлчилдэг. Аливаа номлогч байраа орхин гарах тэр мөчөөс түүний дэгээ загастай усанд тавигдах ёстой” (Даллин Х.Оакс, шинэ номлолын ерөнхийлөгч нарт зориулсан семинар, 2000 оны Зургадугаар сарын 20).

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Доорх нөхцлүүдээс нэгийг номлогч нарт уншиж өг. Баптисм болон гишүүний баталгаа өөд өсч хөгжиж буй эдгээр жишээнүүдийн хүмүүст туслах зорилгууд болон төлөвлөгөөнүүдийг номлогч нар жижигхэн бүлэг болон ярилцаг. Бүлэг бүр санаануудаа хуваалцаг.

Нөхцөл нэг: Та Парри, Бет хоёртой халамжийн хоол хийх үйлчлэл хийж байхад нь танилцжээ. Та тэдэнд нэг хичээл заасан бөгөөд тэд эдүгээ илүү ихийг мэдэхийг хүсч байна. Тэд Сүмийн ямар ч гишүүнийг мэддэггүй. Бет Христэд итгэдэг, харин Парри ямар нэг тодорхой шашныг сонирхдоггүй. Тэд гэрлээгүй боловч хамтдаа амьдардаг. Парри 16 цагаас шөнийн 12 цаг хүртэл ажилладаг. Бет өдрийн цагаар ажилладаг.

Нөхцөл хоёр: Стив бүх хичээлүүдийг авсан бөгөөд сард дор хаяж хоёр удаа сүмд явдаг. Иосеф Смит бол бошиглогч, Мормоны Ном үнэн гэдэгт тэрээр итгэдэг. Түүний гэр бүлийн гишүүд Католик сүмийн идэвхтнүүд бөгөөд түүнийг номлогч нартай уулзахыг зөвшөөрдөггүй.

Нөхцөл гурав: Жийл бол коллежийн оюутан. Тэрээр Сүмийн гишүүн найзтай. Түүний гишүүн найз түүнийг тантай уулзахыг түүнээс хүсчээ. Та түүнд хоёр хичээл заав. Гишүүн найз нь хоёуланд нь оролцсон байна. Тэрээр Сүмд очоогүй бөгөөд гэрийн даалгавраа хийх гээд завгүй байгаа учраас Мормоны Номноос уншихад түүнд хэцүү байгаа.

- Зорилго тавьж, төлөвлөгөө хийснээр хүмүүст туслах боломжтой болсон тохиолдлуудаа хуваалцахыг номлогч нараас хүс:
 - Аврагчид итгэх илүү агуу итгэлийг хөгжүүлэх.
 - Наманчилж, тэднийг Бурханд илүү ойрхон авчрах өөрчлөлтүүдийг хийх.
 - Баптисм болон гишүүний баталгааны гэрээнүүдийг хүлээн авах.
 - Сүмд буцан ирж, баптисмын гэрээнүүдээ шинэчлэх.
- Номлогч нарыг гурван бүлэгт хуваа. Бүлэг бүр чухал томилолт хүлээн авах болно гэдгийг тайлбарла. Тэгээд бүлэг бүрт дараах даалгавруудын нэгийг өг:
 - Номлох шинэ бүсийг нээ.
 - Бүсийн чуулганд Мормоны Номыг сонирхогчдод танилцуулах талаар сургалтын хэсгийг бэлтгэ.
 - Сонирхогчийн гэр бүлийг хэсэгт нэгтгэ. Уг гэр бүл гурван хүүхэдтэй: 8 настай охин, 12 настай охин, мөн 16 настай хүү.

Төлөвлөгөө зохиоход найман минут байгааг номлогч нарт хэл. Номлогч нарын нэг нь төлөвлөгөөг өдөр тутмын үйл ажиллагааг оролцуулан бичих ёстой.

Бүлэг бүр өөрсдийнхөө төлөвлөгөөг танилцуулаг. Танилцуулга бүрийн дараа асуу:

- Нөхцөл бүрийн хувьд номлогч нар юу мэдэх шаардлагатай вэ?
- Хэрэв та нар гол үйл ажиллагаануудыг төлөвлөхгүй бол, эсвэл бүр юу ч төлөвлөхгүй бол ямар үр дүнтэй байх вэ?

Бүх танилцуулгын дараа, асуу:

- Төлөвлөх болон зорилго тавих нь хэрхэн хайрын илрэл болох вэ? Хэрхэн итгэлийн илрэл болох вэ?

Тэмдэглэл

Номлолын Ерөнхийлөгч

- Бүсийн номоо бүсийн чуулган эсвэл ярилцлаганд авчрахыг номлогч нараас хүс. Өөрөө бүсийн номнуудыг нэгтгэн дүгнэхээс гадна, номлолын удирдагчид эсвэл эхнэр тань бүсийн номлогч нар бүсийн номнуудыг нэгтгэн дүгнэхэд анхаар.
- Үе үе номлогч нарын долоо хоног тутмын болон өдөр тутмын төлөвлөх үйл явцыг ажигла.
- Үе үе номлогч нарын амьдарч байгаа байранд ярилцлага хөтлөн явуул. Ингэхдээ эхнэр тань эсвэл ерөнхийлөгчийн туслахууд номлогч нарын бүсийн ном болон өдөр тутмын төлөвлөгөөг нэгтгэн дүгнэ.
- Номлогчийн өдрийн төлөвлөгөөг ойр ойрхон нэгтгэн дүгнэ.
- Хэсгийн зөвлөлийн хуралд үе үе оролц.



Заах Хүмүүсийг Би Хэрхэн Олох Вэ?

Үүнийг Анхаар

- “Таныг хүлээн авах тэднийг ол” (С ба Г 42:8) гэсэн нь ямар утгатай вэ?
- Заах хүмүүсийг олно гэсэн итгэлээ би хэрхэн нэмэгдүүлэх вэ?
- Олох хүчин чармайлтдаа би яагаад гишүүдийг оролцуулах ёстой вэ?
- Хэвлэл мэдээлэл болон Сүмийн удирдах төвийн хичээл авах хүмүүсийн мэдээллийн үүрэг юу вэ?
- Олох мөн заах хоёрын хоорондын холбоо хамаарал нь юу вэ?
- Заах хүмүүсийг олох үйлчлэлийн үүрэг юу вэ?
- Миний оролдож үзээгүй заах хүмүүс олоход зориулсан ямар санаанууд байдаг вэ?

Олох Итгэлийг Хөгжүүлэх нь

Энэ бүлэг дэх сургаал болон зарчмууд нь таныг болон сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авах хүмүүсийг Их Эзэн бэлтгэдэг гэсэн итгэлийг тань хүчирхэгжүүлэх болно. Тэрээр таныг тэдэн рүү хөтөлнө, эсвэл Тэрээр тэднийг та нар уруу хөтлөх болно. Олох нь дэлхийн өөр өөр хэсгүүдэд өөр өөр байдаг. Номлогч нар болон номлолын ерөнхийлөгч нар тухайн нөхцөл байдалд тохируулах хэрэгтэй болдог. Хэдий тийм ч, энэхүү ялгааг үл харгалзан, олох зарчмууд нь нийтлэг юм.

Бурханы Гэр бүл. Мөнх бус амьдралын өмнөх амьдралд дэлхий дээрх бүх хүмүүс Бурханы гэр бүлийн гишүүд байсан юм (Үйлс 17:26–29; Еврей 12:9-ийг үз). Энэ амьдралд бид Бурханы гэр бүлийн нэг хэсэг бөгөөд ирэх амьдралд Түүний гэр бүлийн гишүүдийн хувьд бид бүр илүү агуу адислалуудыг хүртэх болно. Бурханы гэр бүлд бид бүгдээрээ ах эгч нар билээ. Энэ мэдлэг бидэнд бидний адил тал болон хаана харьяалагддаг болохыг мэдүүлдэг. Энэ нь Бурханы оршихуй дахь мөнх амьдралд найдах найдварын шалтгааныг бидэнд өгдөг. Сэргээлтийн улмаас

Тэмдэглэл

бид энэ энгийн үнэнүүдийг ойлгодог. Сэргээгдсэн үнэнүүдийг ах эгч нартаа заах нь таны үүрэг хариуцлага хийгээд адислал юм. Урвагч Зорамчуудын төлөө тусламж эрэлхийлж байсан Алмагийн адил та: “Ай Их Эзэн, тэднийг дахин Христээр танд авчрахад амжилттай байхыг та бидэнд зөвшөөрнө үү. Болгоогтун, Ай Их Эзэн, тэдний бодгаль нь эрхэм үнэт . . . ; тиймийн тул, Ай Их Эзэн, хүчин чадал мөн мэргэн ухааныг бидэнд өгөөч, бид тэднийг, ах дүүсээ дахин танд авчирч болохын тул болой” (Алма 31:34–35).

“Таныг Хүлээн Авах Тэднийг Ол.” “Таныг хүлээн авах тэднийг” (С ба Г 42:8) олсноор Сүмийг та байгуулдаг. Та Их Эзэний үйлчлэгчид гэдгийг тэдгээр хүмүүс таних болно. Тэд таны захиасыг хүлээн авахад бэлэн байх болно. “Тэд үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас [гагцхүү] үнэнээс хол байдаг” (С ба Г 123:12) олон хүмүүс бий.

Эдгээр хүмүүс хэн болохыг ихэнхдээ та мэдэхгүй. Та Их Эзэний үйлчлэгчид гэдгийг тэд тэр даруй танихгүй байж болно. Агуу амар амгалан, чиглүүлэл, болон амьдралын зорилго өөр бусад зүйлсээс илүүтэйгээр сэргээгдсэн сайн мэдээгээр дамжин ирэх болно гэдгийг тэд ойлгохгүй байж болно. Өөрсдөө олох хүртлээ сэргээгдсэн сайн мэдээг өөрсдийнх нь эрж байгаа зүйл гэдгийг ихэнхдээ тэд ухаардаггүй. Жишээ нь: нэгэн хөрвөгч хэлэхдээ, “Сайн мэдээг сонсох үед энэ нь байдаг гэдэг нь миний мэддэггүй байсан зүрхэн дэх нүхийг минь дүүргэсэн юм” гэжээ. Өөр нэгэн хэлэхдээ, “Хайж байснаа мэддэггүй байсан тэр эрлээ би төгсгөл болгосон” гэжээ.

Та хаана ч үйлчлэхээр дуудагдсан нь, Их Эзэн “энэ газарт таныг очихыг зөвшөөрч байгаа юм; учир нь энэ нь бодгалиудын авралын тулд [Түүнд] шаардлагатай байна” гэдгийг сана. “Энэ хүмүүст дуу хоолойгоо өргөгтүн; зүрх сэтгэлд тань Их Эзэний тавих бодлуудыг ярихын тулд идэвхтэй ажилла. Хэрэв та ийнхүү үйлдэх аваас та хүмүүсийн өмнө мадлагдах нь үгүй, мөн та юу хэлэх ёстой нь яг тухайн цагт та нарт өгөгдөх болно” (С ба Г 100:4–6) хэмээх амлалтыг та хүлээн авах болно. Сүнсээр олох нь Сүнсээр заахтай адил чухал юм. Заахын хувьд, хэрэв та Сүнсээр хөтлөгдөх аваас олох таны хүчин чармайлт үр дүнтэй байна. Юу заах мөн өөрсдийг тань хүлээн авах тэдгээр хүмүүсийг олохын тулд юу хийхийг мэдэх болно гэсэн итгэлтэй бай.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Таны айлчлан очих гишүүдийн ихэнх нь Сүмийн хөрвөгчид байж болох юм. Тэд Сүмтэй хэрхэн холбоо тогтоосон мөн номлогч нар тэдэнд үнэнийг зааж байгааг тэд хэрхэн мэдсэн талаар тэднээс асуух цагийг төлөвлө. Тэдний тохиолдлуудыг судлах тэмдэглэлдээ хураангуйлж бич.

Судар Судлах

Бурханы хүүхдүүд хэрхэн бэлтгэгдэж мөн сэргээгдсэн сайн мэдээ уруу хөтлөгддөг вэ?

Алма 13:24

С ба Г 29:7

С ба Г 84:45–47, 88

Алма 16:16–17

С ба Г 33:6

С ба Г 136:32–33

Хүн Бүхэнтэй Ярь

Бошиглогч Иосеф Смитийг бүлэг номлогч нартай хамт Миссури Голоор аялж явахад нь Их Эзэн “хоёр талд оршин суугчид итгэлгүйд мөхөж буй үед . . . миний ахлагч нарын хувьд шаламгайлан урагш ахих нь . . . шаардлагагүй” (С ба Г 61:3) хэмээн илчилжээ. Төлөвлөсөн үйл ажиллагаанд шаламгайлан урагш ахихдаа та төлөвлөгдөөгүй үйлчлэх мөн “итгэлгүйдээ мөхсөн” хүмүүст заах боломжуудыг харах чадварын төлөө залбир. Боломжуудыг танин мэдэх сүнслэг мэдрэмжийн төлөө залбир. Бурхан замыг тань бэлтгэж байгааг та олж харах болно. Түүний бэлтгэгдсэн хүүхдүүд сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авна.



Заах хэн нэгнийг олох хүртэл тань номлолын ажилд юу ч тохиолдохгүй. Өдөр бүр өөрийнхөө боломжийн хэрээр олон хүмүүстэй ярилц. Хүмүүстэй ярилцах нь зарим талаараа сүрдмээр зүйл байдаг нь хэвийн зүйл боловч амаа нээхдээ болон сэргээгдсэн сайн мэдээг тунхаглахдаа илүү зоритой байх итгэл мөн хүч чадлын төлөө та залбирч болно. Тааралдсан хүн бүхэнтэй ярихыг эрэлхийлэхдээ доорх санаануудыг ашиглахыг хичээ:

- Хүмүүстэй тэдний гэр бүлийн тухай ярь. Сэргээгдсэн сайн мэдээ тэдний гэр бүлд хэрхэн адислал болж чадахыг харахад нь тэдэнд тусал.
- Хүмүүстэй хэрхэн яриа эхлэхийг мэдэхэд тань туслах гэрт байгаа зүйлс, эсвэл цэцэрлэг, хувцсан дээрх бичиг, эсвэл хүүхдүүдтэйн шинж тэмдэг зэрэг санаануудыг олж хар.
- Хүмүүсийн танд хэлж буй зүйлсийг чин сэтгэлээсээ сонс.
- Дотно, нөхөрсөг, мөн хөгжилтэй бай. Тусламж өг.
- Юу заахыг зүрх сэтгэл болон оюунд тань Сүнс хийнэ гэдэгт итгэ.
- Сэргээгдсэн сайн мэдээний талаар сурахыг хүн бүрт урь.
- Тараах хуудас өг.
- Захиасыг тань сонирхож болох таньдаг хүмүүсийнх нь нэрсийг асуу.

Доорх болсон явдлыг уншихдаа номлогч нарыг хүлээн авахад уг хүн хэрхэн бэлтгэсэн мөн түүнд сайн мэдээг заах төлөвлөгдөөгүй боломжийг номлогч нар хэрхэн ашигласныг анхаар.

Хүүхэд байхаас минь л Библи уншихыг надад заагаагүй юм. Ням гарагт би Сүмд явдаг байсан боловч би ямар ч зүйл хандивлаж мөн юу ч мэдрэлгүйгээр буцаж ирдэг байсан юм. Би шашиныхаа улмаас төөрөлдсөн. . . Би . . . Бурхан ер нь оршдог эсэхийг мэдэхийг хүсэн Түүнийг эрэлхийлсэн билээ. Түүнийг болон Түүний үгсийг мэдэхээр би цангаж байлаа. Гэвч хайж буй зүйлээ олж чадахгүй байгаа сэтгэгдэл надад төрдөг байв.

Цангаж буй зүйлдээ хүрэхэд ойрхон мэт сэтгэгдэл төрөх үе байдаг байлаа. Би өөрийнхөө гараар анхныхаа хүүхэд болох охиноо тэврэхдээ Бурхан үнэхээр оршдог гэсэн мэдрэмж надад төрсөн юм. Олон жилийн дараа охины маань дүү нь төрөхөд надад мөн л адил мэдрэмж төрсөн юм. . . Хэдий тийм ч, ихэнх үед миний бодгалийг тайлбарлашгүй хүнд зүйл дардаг байлаа. Би сүнслэгээр цангасан бөгөөд цангаа тайлах газраа олж чадахгүй байсан юм.

Тэмдэглэл

Тэмдэглэл

1994 оны Дөрөвдүгээр сард би Мексикийн Монтеррей хотод амьдарч, таксины жолооч хийн амь зуух мөнгө олж байв. Нэг өдөр олон цагийн турш үргэлжлэн бороо орж, уулнаас ус хуйлран бууж байлаа. Бороон дундуур олон цаг давхисны дараа би Монтеррейгоос найман километрийн (таван миль) зайтай жижигхэн сууринд ирсэн байв. Бараг гэртээ харих цаг . . . болчихсон байсан. Гэнэт би хоёр залуу эрэгтэй алхаж явааг олж харав. Тэд хар хүрэм, цагаан цамц өмссөн бөгөөд толгойноосоо хөлөө хүртэл шалба норсон байв.

Тэднийг дөхөн ирэхэд нь би таксиныхаа хаалгыг онгойлгоод “Суу, би Монтеррей уруу явах гэж байна” хэмээн хэлсэн юм.

Царайлаг, өндөр нэг нь “Бидэнд ямар ч мөнгө байхгүй” хэмээн хариулав.

“Үнэгүй,” гэж намайг хариулахад.

Тэд маш хурдан таксинд суув.

Явж байхдаа бид ярилцав. Есүс Христийн тухай захиасыг хуваалцаж болох эсэхийг тэд асуув. Би зөвшөөрч, хаягаа тэдэнд өгсөн юм.

Гэртээ ирээд би эхнэрээ сэрээж хоёр залуу эрэгтэйн талаар хэлэв. “Ямар сонин тохиолдол байв аа”, “Нэг нь Мексик, нөгөө нь Америк, тэд хоёулаа Ахлагч гэдэг нэртэй юм” хэмээн би хэлэв.

“Ахлагч гэдэг тань номлогч гэсэн үг” хэмээн Сүмийн талаар бага зэрэг мэддэг эхнэр маань хариулав.

Миний дотор ямар нэг сэтгэлийн хөөрөл мэдрэгдэж байв. Эдгээр залуу эрэгтэйчүүд зүрх сэтгэлд минь хүчтэй гайхах сэтгэгдлийг үлдээсэн юм. Цангааг минь гаргах ус олоход ойрхон мэт сэтгэгдэл надад төрсөн бөгөөд энэ нь ойрхон байсан юм.

Номлогч нар гэрт маань Зургаан сарын 5-нд ирсэн бөгөөд тэднийг сонсохдоо би баяртай байв. Хоёр долоо хоногийн дараа Зургаан сарын 19-нд би баптисм хүртэв. Дөрвөн сарын дараа Арван сард эхнэр маань баптисм хүртсэн юм. Том охин маань сургууль дээрээ шашины сургалтыг хүлээн авав. Тэрээр анх удаа сүмд явахдаа “Аав аа, энэ нь сургууль дээрээ миний сурдаг зүйлээс илүү дээр юм!” хэмээн уйлав. Тэр ч мөн адил Арван сард баптисм хүртсэн юм.

1995 оны Арванхоёрдугаар сард Мексикийн Мексик Хотын Ариун сүмд бид энэ амьдрал болон мөнхөд лацдан холбогдсон юм. Эдүгээ бид таарамж, амар амгалан, мөн аз жаргалыг мэдэрсэн гэр бүл болоод байна. Хэнийг шүтэн биширч буйгаа бид мэднэ. Бид хаанаас ирсэн мөн хаашаа явахаа бид мэднэ. Бурханы үг, ялангуяа Мормоны Номонд бид хайртай, мөн бид Түүний Сүм, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хайртай. Эдгээр бэлгүүдээр бид Самарийн эмэгтэйд



Аврагчийн хэлсэн амьд усны худгийн талаар мэдэж авсан юм: “Өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно” (Иохан 4:14). [Victor Manuel Cabrera, “Thirsting for the Living Water,” Ensign, 2001 оны Наймдугаар сар, 60–61]

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

- Сэргээгдсэн сайн мэдээнд уг хүн хэрхэн бэлтгэгдсэн бэ?
- Сайн мэдээний захиасыг хуваалцахын тулд уг ахлагч нар хэзээ ч амаа нээгээгүй бол юу тохиолдох байсан бэ?
- Өчигдөр юу хийснээ нэгтгэн дүгнэ. Та боломжийнхоо хэрээр олон хүнтэй ярьсан уу? Хэрэв үгүй бол, өнөөдөр хийх төлөвлөгөө гаргаж, зорилгууд тавь.

Судар Судлах

Амаа нээх талаар Их Эзэн юу хэлсэн бэ? Та юу заах ёстой вэ? Танд юу амлагдсан бэ?

С ба Г 24:12

С ба Г 33:7–15

С ба Г 60:2–3, 7–8

С ба Г 28:16

Тэмдэглэл

Олж Байхдаа Зааж, Зааж Байхдаа Ол

Олох мөн заах нь хоорондоо хамааралтай, холбоотой үйл ажиллагаанууд юм. Хүмүүстэй уулзахдаа та сэргээгдсэн үнэний товч хураангуйг заахад бэлтгэ, ингэснээр та бол Их Эзэний үйлчлэгч гэдгийг Ариун Сүнс гэрчлэх болно. Олон тохиолдолд, та захиасыг минут юм уу үүнээс бага хугацаанд танилцуулж чадах чадвартай болно. Хүмүүс богино, хүчтэй мэдэгдлүүдэд дасал болсон байдаг. Жишээ нь, Сэргээлтийн тухай захиасыг та зөвхөн хоёр юм уу гурван өгүүлбэрээр гэрчилж болох юм:

Бурханы жинхэнэ үнэн (Есүс Христийн сайн мэдээ) олон зуун жил алдагдсаны эцэст амьд бошиглогчоор дамжин хайрын Бурханаар сэргээгдсэн юм. Та энэхүү үнэнийг өөрөө сурахын тулд үүнийг та гартаа барьж, уншиж, зүрх сэтгэлдээ тунгаан бодож, мөн залбирч болох нотолгоо бидэнд байна. Биднийг . . . та зөвшөөрч байна уу?

Хэрэв илүү цаг байгаа бол та нар цааш нь үргэлжлүүлж болно:

Бидний захиас маань энгийн. Бурхан бол бидний Эцэг. Бид бол Түүний хүүхдүүд. Бид бол Түүний гэр бүлийн нэг хэсэг. Тэрээр бидэнд хайртай. Дэлхийн эхлэлээс Тэр хайрын мөн халамжийн загварыг дагасаар ирсэн. Өөрийнх нь хүүхдүүд Түүнд хэрхэн буцаж очихыг мэдэж чадахын тулд олон удаа Тэрээр Есүс Христийн сайн мэдээг илчлэхийн тулд хайрын холбоо тогтоосон. Адам, Ноа, Абрахам, болон Мосе зэрэг бошиглогчдод Тэрээр үүнийг илчилсэн юм. Гэвч зарим хүмүүс уг сайн мэдээг байнга эсэргүүцэх сонголт хийсэн билээ. Хоёр мянган жилийн өмнө, Есүс Христ Өөрийнхөө сайн мэдээг Өөрөө заасан юм. Сонирхолтой нь, хүмүүс бүр Есүс Христийг хүртэл эсэргүүцсэн юм. Үнэн сургаалууд хийгээд ёслолуудыг үл ойшоож, эсвэл мушгин гуйвуулах бүрт Бурхан Сүмийг удирдах Өөрийнхөө эрх мэдлийг татан авч байсан.

Бидний урилга бол таны аль хэдийн нандигнадаг үнэнүүд дээр нэмэх явдал юм. Тэнгэрлэг Эцэг маань дахин Өөрийн хүүхдүүдээ бошиглогчид илчилсэн үнэн сургаалууд болон ёслолуудын хайраар хүрээлүүлсэн билээ. Энэ бошиглогчийг Иосеф Смит гэдэг. Энэхүү бурханлиг үнэний үйл явц Мормоны Ном гэсэн номонд тэмдэглэгдсэн юм. Та үүнийг гартаа барьж, үүнийг уншиж, үүний үнэнийг оюун, зүрх сэтгэлдээ тунгаан бодож чадна.

“ . . . тухай захиасыг заах хэдэн минут танд байна уу?” гэх зэрэг зүйлсийг хэлэх хандлагаас зайлсхий. Үүний оронд хүмүүстэй уулзах тэр мөчөөс зааж мөн гэрчилж эхлэх зуршлыг хөгжүүл. Гэрчилж мөн Ариун Сүнсний хүчийг мэдрэхийг хүмүүст олгосноор та заах илүү олон хүн олох болно.

Эхлээд уулзах ямар ч тохиолдолд сайн мэдээний Сэргээлтийг маш хурдан мөн энгийнээр заа, учир нь энэ бол дэлхийд өгөх бидний онцгой захиас юм. Таны зааж буй хүмүүст ихэнхдээ сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад бэлтгэгдсэн найз нөхөд эсвэл хамаатанууд байдаг. Олох, сонирхогчдод заах, гишүүдтэй ажиллах зэрэг заах бүх тохиолдолд—“Энэ захиасыг сонирхож, мөн энэ ашиг тусаа өгөх ямар хүнийг та мэдэх вэ?” гэж асуу. Хичээл авах хүнийг олсныхоо дараа, “бидний захиас ашиг тусаа өгөх өөр хэнийг та мэдэх вэ?” гэж асуу. Дараа дараагийн уулзалтууддаа үүнийг дахин дахин асуухаасаа бүү эргэлз. Таныг заахад сайн мэдээний адислалуудыг мэдэрсэн хүмүүсийн үүнийг хуваалцах хүсэл өсөх болно

(1 Нифай 8:12-ыг үз). Ихэнх тохиолдолд сайн мэдээг сурах явцдаа тэд шинэ найз нөхөдтэй болдог. Энэ зарчмыг ашигладаг номлогч нар ихэнхдээ заах хүмүүс олонтой байдаг.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

- Аль нэг хичээлд тулгуурласан нэг минутын захиас бэлтгэ. Олох үйл ажиллагаанд энэ хичээлийг заах арга замын тухай бод.
 - Энэ захиасыг Сэргээлттэй хэрхэн хурдан холбож болохыг олж тогтоо.
 - Уг захиасаа хамтрагчдаа хуваалц.
 - Заах сандаа шинэ сонирхогч нэмэхийн тулд өнөөдөр тохиромжтой үед энэ захиасыг заах зорилт тавь.
-
- Одоогоор зааж байгаа хүмүүсийн жагсаалтыг нэгтгэн дүгнэ. Хичээл авах хүн асуусан болон асуугаагүй хүмүүсийн жагсаалт гарга. Хоёр бүлэг хүмүүст хичээл авах хүмүүсийг асуух хүсэлт хэрхэн тавих дасгал хий. Төлөвлөгөөндөө дараачийн уулзалтаар энэ хүсэлтийг тавихаар тэмдэглэ.

Гэр Бүл Чухал Болох Талаар Ярих нь

Есүс Христийн сайн мэдээний Сэргээлт нь гэр бүлүүдийг адисалдаг. Сэргээгдсэн сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар гэр бүлүүд хүчирхэгжиж, амар амгалан, баяр баясгалан хийгээд харьяалагддаг мөн ялгарах мэдрэмжийг мэдрэх болно.

Өдөр бүр уулзаж буй хүмүүстэйгээ гэр бүл чухал болох талаар ярих нь заах хүмүүс

олоход тань танд тусална. Ихэнх хүмүүст гэр бүлийн талаар сонирхох төрөлхийн сонирхол байдаг. Олох олон тохиолдолд гэр бүлийн талаар ихэнх хүмүүсийн мэддэг зүйлийг та Сэргээлтийн захиастай хурдан холбож чадна. Олохдоо та доорхтой адил ямар нэг зүйлийг хэлж болох юм:

Гэр бүлээс маань өөр хамгийн чухал зүйл бидэнд байхгүй. Гэр бүл маань бие биетэйгээ холбоотой байж, бидэнд нэр өгч, тэдэнд бид хэрэгтэй мөн хайрладаг гэсэн мэдэмжийг мэдрэхэд бидэнд тусалдаг. Гэр бүлээсээ бид бие хүний зан чанарын онцлог, хамаарлууд, мөн бие бялдрын онцлогууд, бидэнд өгсөн онцгой төлөвшилийг өвлөн авдаг.

Хүчтэй, аз жаргалтай гэр бүлтэй байх нь дэлхий дээрх олон хүмүүсийн хувьд хамгийн эн тэргүүнд тавих зүйл юм. Энэ зорилгыг биелүүлэх нь ихэнхдээ хэцүү байдаг. Өнөөдрийн энэ дэлхийд хүүхэд өсгөж, хүчирхэг гэр бүлтэй байх нь хилэнцэт байдал бидний эргэн тойронд байхад бараг боломжгүй мэт байж болно.

Тэгээд Сэргээлтийн захиас уруу та нар шилжиж болно:

Гэр бүлийнхээ төлөө хайр, зовнил мөнх бөгөөд бидний бодгальд гүн шингэсэн байдаг. Тэдгээр нь Бурхантай харилцах бидний харьцаанд төвлөрсөн байдаг. Төрөөсөө өмнө та Бурханы гэр бүлийн нэг хэсэг байсан. Тэр бол бидний Эцэг юм. Тэр бидний Эцэг учраас бид ах эгч нар билээ.



Биднийг эргэж ирэн, Түүний гэр бүлийн нэг хэсэг болон Түүнтэй амьдрахыг Тэнгэрлэг Эцэг хүсдэг. Энэ дэлхий дээрх гэр бүлүүд Бурханы гэр бүлтэй холбоотой. Энэ амьдралын дараа гэр бүлүүд хамтдаа амьдарч чадна. Бид үүнийг мэднэ, яагаад гэвэл олон зуун жилийн турш алдагдсаны эцэст сургаалууд болон умбуулах баптисм зэрэг ёслолууд амьд бошиглогчдоор дамжуулан хайрт Тэнгэрлэг Эцэгээр дэлхий дээр сэргээгдсэн юм. Эдгээр сэргээгдсэн үнэнүүд нь зөвхөн Бурханы гэр бүл дэх байраа ойлгоход маань бидэнд туслаад зогсохгүй, энэ амьдралд хүчтэй, аз жаргалтай гэр бүлтэй байх бидний хамгийн агуу найдвар юм. . . . Талаар бид танд илүү ихийг зааж өгч болох уу?

Аз жаргал, дайсан, амьдралын зорилго, эсвэл үхэл зэрэг өөр бусад сэдвүүдээр ижил зүйл хийж болно. Олох уулзалт тань ямар ч бай, үүнийг дэлхийд өгөх бидний онцгой захиастай хурдан холбох ёстойг сана.

Гишүүдийн Ач Холбогдол

Заах хүмүүс олохдоо Сүмийн гишүүдтэй хамтран ажилла. Нэн тохиромжтой нөхцөл бол гишүүд бусдыг заалгахыг урьж, заалгахаар авчирдаг. Үүнийг гишүүд хийснээр илүү олон хүмүүс баптисм хүртэж мөн Сүмд идэвхтэй хэвээр үлддэг. Гишүүдтэй харилцаатай байх нь чухал, яагаад гэвэл, энэ нь хүмүүсийн зүрх сэтгэлийг зөөллөж, ихэнх тохиолдолд сэргээгдсэн сайн мэдээг сонирхох зам руу тэднийг хөтөлдөг. Энэ нь ихэнхдээ идэвхтэй, идэвх султай гишүүд, саяхны хөрвөгчид, мөн гэр бүлийн нэг хэсэг нь гишүүн гэх зэрэг хүмүүсийг багтаасан Сүмийн гишүүдийн найз нөхдийн хүрээнд тэднийг авчирна гэсэн үг юм.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заахдаа:

“Бидний олонх маань номлогчийн ажлыг зүгээр нэг шашны товхимол тараах ажил гэж боддог. Энэ ажлыг мэддэг хүн бүр илүү сайн арга бий гэдгийг мэддэг. Тэрхүү арга бол Сүмийн гишүүд юм. Сонирхогчийг гишүүн танилцуулсан тохиолдолд дэмжих сүлжээ бий болдог. Гишүүн энэ ажлын үнэний талаарх гэрчлэлээ хуваалцдаг. Сонирхогч найзынхаа аз жаргалтай байдалд тэрээр санаа зовдог. Сайн мэдээг сурахдаа найз нь өсөлт гаргаж байгаад тэрээр их баярлах болно.

“Бүрэн цагийн номлогч нар жинхэнэ заах үйл ажиллагааг хийдэг ч, боломжтой үедээ гишүүд энэхүү номлогчийн үйлчлэлийг цааш үргэлжлүүлэхийн тулд орон гэртээ уг заасан зүйлсийг давтах болно. Тэрээр энэ ажлын бурханлиг чанарын талаар чин сэтгэлээсээ гэрчлэх болно. Номлогч нар байхгүйд тэрээр асуултанд нь хариулах болно. Маш том мөн ихэнхдээ хүнд хэцүү өөрчлөлтийг хийхэд нь тэрээр хөрвөгчийн найз нөхөр байх болно. . . . Шинэ хүмүүсийг Сүмд авчрах үйл явц бол дан ганц номлогч нарын үүрэг хариуцлага биш юм. Шинэ сонирхогчид олохын эх сурвалж нь гишүүд болсон тэр үед тэд маш их амжилт гаргах болно” (Ensign, 1999 оны Тавдугаар сар, 105–6).

Гишүүдтэй баттай харилцаа тогтоохоор эхлэх цэг бол бишоп юм. Тусламж үзүүлж, түүний хүссэн аливаа зөв шударга замаар үйлчил. “Би бишопт адислал болж байна уу эсвэл ачаа болж байна уу?” гэж өөрөөсөө байнга асуу. “Би яаж тусалж чадах вэ?” гэдэг үзлийг хөгжүүл. Хэрэв та нар хайрлах, үйлчлэх, мөн заах боломжийг эрэлхийлэх аваас бишоп болон хэсгийн гишүүд гэр бүлийнхээ гишүүд болон найз нөхдөө танд итгэл хүлээлгэн өгөх болно.

“Энэ бүхнийг хийсний дараа, хамгийн агуу мөн хамгийн чухал үүрэг бол Сайн мэдээг номлох нь юм.”

–БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТ
TEACHINGS OF THE PROPHET JOSEPH SMITH, 113

Нэгэн номлогчийн номлолынхоо ерөнхийлөгчид бичсэн захидлаас авсан доорх хэсгийг авч үз:

Хүндэт Ерөнхийлөгч өө,

Ерөнхийлөгчийн туслахууд өнөөдөр утасдаад, намайг шилжиж байгааг надад хэллээ. Намайг ийш нь илгээсэнд баярлаж байгаагаа бичих ёстой гэсэн сэтгэгдэл надад төрлөө. Өмнө минь тулгарч байгаа сорилтуудын талаар та надад хэлж байсан нь дөнгөж өчигдөр мэт санагдаж байна.

Бидний эхний Ням гараг таны хэлснийг баталж өгсөн юм. Биднийг энэ хэсэг тийм ч халуун дотно бус угтаж авсан юм. Тэр анхны Ням гарагийн цорын ганц гэрлийн цаураг нь хэсгийн шинэ номлолын удирдагч Скотт байсан юм. Тэрээр Агаарын Хүчний баазад сарын өмнө шилжиж ирсэн бөгөөд хэсгийн номлолын удирдагчаар хоёр долоо хоног үйлчилж байсан юм. Ажлаа урагшлуулахын тулд юу хийх талаар ярилцахын тулд Скотт тэр Ням гарагт биднийг гэртээ оройн хоол идэхийг урьсан юм. Оройн хоолны дараа бид өвдөг сөхрөн суугаад Тэнгэрлэг Эцэгээс Түүний удирдамжийг хүсэн залбирсан. Залбирч байхдаа бид амар амгалан мөн шийдвэр төгс байдлыг мэдэрсэн билээ. Ажлаа урагш явуулах хамгийн шилдэг арга зам бол гишүүдийн итгэлийг олж авах гэж бид шийдэцгээсэн билээ. Бид Аммоны жишээг дагаж, тэдэнд үйлчлэхээр шийдэв.

Бид бишопоос эхлэв. Уг бус нутагт баттисм багасч, өмнөх номлогч нарын хичээл зүтгэл дутмаг байсан учраас түүнтэй уулзах бидний хүсэлтэд тэр бодож байснаас илүү дурамжхан байв. Эцэст нь тэрээр биднийг гэртээ оройн хоолонд урьсан юм. Тэрээр зочныхоо өрөөний шалны хивсийг авч, доорх модон шалыг нь солих гэж байгааг бид мэдэж авсан юм. Бид сайн дураараа туслахаа хэлж, тэр ч зөвшөөрөв. Уг ажлын дараа бишоп биднээс ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхийг хүсэв. Бид үүнийг тэрээр бидэнд итгэж эхэлж байгаагийн эхлэл гэж хүлээн авав.

Бусад гишүүдтэй уулзахдаа бид энэхүү загварыг дагах болсон юм. Бид тэдэнд туслах олон төрлийн энгийн арга замуудыг олох боломжтой байв. Гишүүдтэй уулзаагүй үедээ бид хаалга цохиж чадах хэрээрээ олон хүмүүстэй сэргээгдсэн сайн мэдээний талаар ярилцаж байв. Бид заах хүмүүсээр адислагдаж, мөн бид өөрсдөө олсон хүмүүсийг сүмд авчиргахыг гишүүд харах. Бүхэл хэсгийнхний хандлага өөрчлөгдөж эхэлсэн юм. Номлогчийн ажлын талаарх баяр хөөр нэмэгдэж байв. Гишүүд бидэнд нэгэнтээ итгэсний дараа ажил урагшилж байлаа. Олон хүн баттисм хүртсэн билээ.

Сүмийн олон гишүүд номлогчийн ажил хийхээсээ зүрхшээдэг. Хаанаас эхлэх, юу хэлэхээ олонх нь мэддэггүй. Хэрэв сайн мэдээг хуваалцвал ойр дотны найз нөхдөө алдана гэж олон хүмүүс эмээдэг. Гишүүдэд туслах олон арга байдаг. Жишээ нь, Сэргээлтийн захиас болон хичээлийн бусад сургаалуудыг тэдэнд зааснаар тэдний итгэлийг бий болго. Сүнс болон захиасны маань хүчийг мэдрэхэд нь тэдэнд тусал. Христийн сургаалыг ойлгох тэдний ойлголтыг нэмэгдүүлэх нь танд итгэх тэдний итгэлийг нэмэгдүүлэх мөн номлогчийн ажлыг хийх тэдний баяр хөөрийг бий болгохоор хийх өөр бусад зүйлсээс илүү их зүйлийг хийх болно. Сэргээгдсэн сайн мэдээнд өргөл өргөхийг ойлгоход тэдэнд туслах нь гэр бүлийн гишүүд болон найз нөхдөө хайрлаж, мөн үйлчлэхээр эрэлхийлэх харилцаануудыг илүү энгийн болгоно. Энэ бүлэг дэх “Сайныг Үйлдэхээр Яв” хэсгийн зарчмуудыг тэдэнд заа. “Бурханыг [мэдээ]–гүй тэдний бодгалиудын зол жаргалын төлөө мацаг барьж мөн хүчирхэг залбиралд нэгдэхийг” (Алма 6:6) гишүүдэд уриал. Гишүүдтэй хийх бүх зүйлдээ номлолын ажлыг хийхэд тэдэнд туслахын тулд тэдний итгэлийг урамшуулж мөн хүчирхэгжүүл.



Идэвхтэй гишүүдтэй ажиллахаас гадна, ирээдүйн ахлагч, идэвх султай гишүүд, мөн шинэ гишүүдээр дамжуулан заах хүмүүс олохыг хичээ. Эдгээр гишүүдэд өөр итгэлтэй олон найз нөхөд байдаг бөгөөд сэргээгдсэн сайн мэдээг тэд гэр бүлийнхээ гишүүд болон найз нөхөдтэйгөө хуваалцсанаар маш ихээр адислагдах болно.

Гишүүдтэй уулзах бүрдээ, доорх зүйлсийг хийхэд нь тэднийг урамшуулахын тулд чадах бүхнээ хий:

- Залбирч мөн Сүнснийг дага.
- Үйлчил.
- Нөхөрлө.
- Сэргээгдсэн сайн мэдээг хуваалцах тэднийг нээлттэй болго.
- Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэх зүйлс хийхийг бусдад уриал.

Гишүүдээс хүлээн авсан хичээл авах хүн бүрийн мэдээлэлд үнэ цэнэтэй зүйл мэтээр ханд. Утасдаж мөн айлчлах найз нөхдийнхөө нэрийг гишүүд өгсөн бол хурдан хариулж, мөн уг гишүүнд үр дүнг нь буцаан мэдэгд.

Гишүүдэд Туслах Санаанууд

Номлогчийн ажилд оролцоход нь гишүүдийг урамшуулах олон арга замууд байдаг. Доорх санаануудыг бодож үз:

- Бишоп болон хэсгийн бусад удирдагчдын зааварчилгааг эрэлхийл. Энэ талаар нэмэлт тусламж хэрэгтэй бол бүлэг 13-ыг үз.
- Сэргээлтийн тухай захиас болон бусад хичээлүүдийг Сүмийн удирдагчид болон гишүүдэд заа.
- Хөршүүд болон найз нөхдөө хайрлаж мөн үйлчлэхийг тэдэнд заа.
- Номлогч хийх боломжтой байхын төлөө мацаг барьж мөн залбирахад нь тэднийг урамшуул.
- Саяхан амьдралд нь амьдралыг нь өөрчлөх зүйл тохиолдсон хүмүүсийнд зочлон очиход нь тэднийг дэмж (төрөлт, гэр бүл дэх үхэл, гэрлэлт, эсвэл саяхан нүүж ирсэн).
- Заахад тань танд туслахыг тэднээс хүс. Бодит нөхцөлд сонирхогчтой нэг ижил сүмд байсан Сүмийн гишүүн тантай хамт байх ёстой.
- Сэргээлтийн тухай захиасыг заалгахаар найз нөхдөө урих өдөр товлоход нь тэдэнд тусал.
- Мормоны Номны хувь, дүрс бичлэгүүд болон тараах картууд зэрэг тэдний бусад хүмүүст өгч болох зүйлсийг тэдэнд үзүүл.
- Сүм, эсвэл гэр бүлийн үдэшт ирж Сүмээс гаргасан дүрс бичлэг үзүүлэхээр мөн сайн мэдээний тухай яриа өрнүүлэхээр найз нөхдөө урихыг тэднээс хүс.
- Найз нөхдөдөө юу хэлж болохыг тэдэнтэй дадлага хий.
- Үр дүн нь ямар байхаас үл хамааран сайн мэдээг хуваалцах нь яагаад үнэ цэнэтэй болохыг тэдэнд заа.

Илүү оролцоход нь гишүүдэд туслах өөр олон арга зам байдаг. Энэ жагсаалт дээр нэмэх зүйлийг номлолынхоо турш эрэлхийл. Өөрийнхөө санаануудыг бусад номлогч нартай хуваалц.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Бишоп болон бусад удирдагчдад үйлчилж мөн туслахын тулд өнгөрсөн сард юу хийснээ хамтрагчтайгаа ярилц. Тэдэнтэй хүчтэй харилцаа хөгжүүлэхийн тулд ирэх сард юу хийж чадахаа ярилцаж мөн төлөвлө.

“Гишүүдэд Туслах Санаанууд” хайрцагт жагсаасан санаануудыг нэгтгэн дүгнэ. Оролдож үзээгүй санаануудыг олж тогтоо. Өдөр тутмын төлөвлөгөөний хуудсаа ашиглан ирэх долоо хоногт оролдож үзэх зарим санаануудын төлөвлөгөө гарга.

Мэдээллийн Хэрэгсэл болон Сүмийн Удирдах Төвөөс Ирсэн Бусдын Зааж Өгсөн Хүмүүсийн Мэдээлэл

Бусдын зааж өгсөн хүмүүсийн мэдээлэл бол сэргээгдсэн сайн мэдээнд бэлтгэгдсэн хүмүүсийг олох өөр нэг эх сурвалж юм. Гишүүнээс ирсэн бусдын зааж өгсөн хүмүүсийн мэдээллээс гадна Бурханы хүүхдүүдэд Сүм олон арга замаар хүрдэг. Мэдээллийн сурталчилгаа, айлчлах төвүүд, түүхийн дурсгалт газрууд, халамжийн болон хүмүүнлэгийн тусламж мөн Интернет (www.mormon.org, www.lds.org, www.familysearch.org) зэрэг хүчин чармайлтуудаар дамжуулан Сүм хүмүүсийн сонирхлыг төрүүлж байгаа. Мэдээллийн хэрэгсэл болон Сүмийн удирдах төвөөс хүлээн авсан бусдын зааж өгсөн хүмүүс ямар нэг зүйлийг (Ариун Библи эсвэл Мормоны Ном зэрэг) зочлон очих Сүмийн төлөөлөгчид хүргэж өгөхийг мөн Сүмийн талаар заалгахыг хүлээн зөвшөөрсөн хүмүүс юм. Энэхүү зааж боломжуудыг ариун үүргийнхээ хувиар номлогч нар үзүүлэх ёстой.

Бусдын зааж өгсөн хүнтэй уулзахаасаа өмнө хүсэлт тавьсан зүйлийг сайн мэддэг байхад анхаар. Тэр зүйлээс Сэргээлтийн захиас зааж уруу шилжих богино хэмжээний хичээл төлөвлө. Зарим тохиолдолд бусдын зааж өгсөн хүмүүс таныг Бурханы бэлтгэсэн бусад хүмүүс уруу хөтөлдөг. Хэрэв таны холбоо тогтоосон хүмүүс сонирхохгүй байгаа бол сонирхож болох өөр хэн нэгнийг мэдэх эсэхийг тэднээс асуу. Түүнчлэн уг гэрийн бусад гишүүд болон тэдний хөршүүдтэй ярилц. Хүн бүрээс таны захиасыг сонирхож болох өөр хэн нэгнийг мэдэх эсэхийг асуу. Уг гэр дэх өөр хэн нэгэн эсвэл хөршүүд сайн мэдээнд бэлтгэгдсэн учраас тa энэ хүнээр хөтлөгдөн энд ирсэн байж болно.

Бусдын зааж өгсөн хүмүүстэй ярилцахдаа доорх зүйлсийг сана:

- Тэдэнтэй 24 цагийн дотор холбоо тогтоо.
- Хэрэв боломжтой бол айлчлан очих цаг тохирохын тулд өмнө нь утасд. Хэрэв тэд гэртээ байхгүй бол тэр өдрийнхөө өөр цагт дахин оч.
- Хүссэн зүйлийг хүргэж өгөөд, өөрсдийг тань айлчлан очихыг тэд зөвшөөрсөн гэдгийг тэдэнд сануул. Сонсгохын тулд гэрт байгаа бүх хүмүүсийг цуглуул.
- Сэргээлтийн захиасыг заа.
- Христэд итгэх тэдний итгэлийг хөгжүүлэх урилга өг.
- Бусдын зааж өгсөн хүмүүсийг асуу.
- Дахин ирэх цаг тохир.
- Уулзалтаа дууссаны дараа тэр хэсэгт ажиллахаар төлөвлө.
- Хэрэв уг хүн гэртээ байхгүй бол хөршүүдтэй нь ярилц.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Өнгөрсөн сард өөрсдийнхөө бүсэд хүлээн авсан бүх бусдын зааж өгсөн хүмүүсийн талаарх мэдээллийг цуглуул. Холбоо тогтоогоогүй, мөн айлчилж очоогүй ямар нэг хүн байгааг олж тогтоо. Өмнө нь холбоо тогтоосон хүмүүсээс хэнийд дахин очих ёстойг шийд.

Гэр Бүлийн Түүх

Гэр бүлийн түүх болон удмын бичиг нь заах хүмүүс олох өөр нэг боломжийг бий болгоно. Гэр бүлийн түүх эдүгээ дэлхийд хамгийн өргөн тархсан хоббины нэг болоод байна. Елиагийн Сүнс эцэг өвгөдөө олж мэдэхийг хүссэн дэлхий дээрх сая сая хүмүүст нөлөөлсөн. Гэр бүлийнхээ үргэлжилсэн хэлхээ холбоонд холбогдохыг олон хүмүүс хүсдэг. Энэ нь Бурханы гэр бүл дэх хэлхээ холбоо болон онцгой чанарыг олох хүсэл уруу хөтөлдөг.

Уг бүсэд гэр бүлийн түүхийн ямар эх сурвалжууд боломжтой болохыг олж тогтоо. Жишээ нь, та хүмүүсийг орон нутгийн гэр бүлийн түүхийн төвд авч очиж эсвэл тэдэнд эцэг өвгөдийнхөө эхний шугамыг хайхад нь тэдэнд тусалж чадах гишүүдтэй тэднийг танилцуулж болох юм. Хэрэв танд Сүмийн гишүүд тусалж байгаа бол гэр бүлийн түүхийн талаар та маш их мэдлэгтэй байх шаардлагагүй. Дэлхий дээрх олон оронд гэр бүлийнхээ үр үндсийг эрж олоход нь бусад хүмүүст тусалж чадах гишүүд байдаг.

Гишүүдийг оролцуул, ингэснээр

сонирхогчид хүмүүстэй уулзаж мөн тэдэнтэй нөхөрлөх болно. Гэр бүлийн түүхийн төвийг үнэ төлбөргүйгээр ашиглаж болно гэдгийг тайлбарла.

Хаалга тогшиж сайн мэдээг түгээж явахдаа та орон нутаг дахь гэр бүлийн түүхийн төвийн утасны дугаарыг дээр нь бичсэн гэр бүлийн түүхийн тараах картуудыг хүмүүст өгч гэр бүлийн уг гарлаа үнэ төлбөргүйгээр хайхыг санал болго. Карт үлдээсэн айлдаа нэг эсвэл хоёр өдрийн дараа дахин оч. Эдгээр картуудыг найз нөхөд эсвэл хамаатнууддаа өгч чадах сонирхогчдод өг. Өөрийнхөө дөрвөн үеийн түүхийн хүснэгтийг авч яван, түүнийгээ өөртэй тань ижил овогтой хүмүүст үзүүлэх нь сайхан санаа юм.

Эхлэхээсээ өмнө, доорх зүйлсийг хийхэд анхаар:

- Хэрэв уг бүсэд байдаг бол гэр бүлийн түүхийн төвд оч.
- Өдөр бүр уулзах хүмүүстэйгээ гэр бүлийн түүхийн тал дээр туслахыг хүсч байгаагаа бишоп болон хэсгийн зөвлөлтэй ярилц.
- Энэ ажлыг хэрхэн хамгийн сайнаар зохицуулж болохыг хэсгийн удирдагчидтай ярилц:
 - Хэсгийн гишүүдэд туслахад тань бишоп дуртай байна уу?
 - Аль хэсгийн гишүүд гэр бүлийн түүхийн төвд үйлчилдэг эсвэл гэр бүлийн түүхийн ажлын туршлагатай вэ?

“Номлогчийн ажил, ариун сүм болон удмын бичгийн ажлын хооронд гарах хиймэл хил хязгаарыг үгүй болгоход бид анхаарна хэмээн би найдаж байна, учир нь энэ нь нэг ижил агуу гэтэлгэх ажил юм!”

–ЕРӨНХИЙЛӨГЧ СПЕНСЕР В.КИМБАЛЛ
“THE THINGS OF ETERNITY—STAND WE IN JEOPARDY?” ENSIGN, 1977
ОНЫ НЭГДҮГЭЭР САР, 3

- Эдгээр гишүүдээс тусламжийг хамгийн сайн яаж асууж болох вэ?
- Угийн бичгийн хүснэгт эсвэл гэр бүлийн гишүүдийн тайланг түгээхэд тань хэн тантай хамт явж чадах вэ?

Ахмад номлогч нарт тохиолдсон доорх түүхийг унш. Тэрхүү хосын хөрвүүлэлтэд гэр бүлийн түүх хэрхэн оролцсоныг анхаар.

Милдред Шүлтц өөрийнхөө сүмийн идэвх зүтгэлтэй гишүүн байв. Номлогч нар түүний хаалгыг тогшиход тэднийг чилээлгүйгээр оруулж, ингэснээр тэрээр “үнэнээ” тэдэнд хэлжээ. Номлогч нарыг түүнд заахад сэргээгдсэн сайн мэдээний үнэн түүнд хүрч мөн баптисм хүртжээ. Заах бүх үеийн турш түүний нөхөр Франк ер сонсдоггүй байв.

Энэ үеэс би тэдэнтэй танилцсан юм. Ахлагч нар биднийг Шүлтц Эгчтэй танилцуулсан юм. Бид түүнд гэр бүлийнхээ модыг эхлүүлэхэд нь тусалж, дараа нь гэр бүлийн түүхийн төвд ирж бидэнтэй уулзахыг түүнээс хүссэн юм. Уулзах өдөр маань болоход, өөрийнхөө эцэг өвгөдийг хайж олохын тулд ирж болох уу хэмээн Франк асуув. Мэдээж, тэрээр энэ дэвшилд маш их баярлаж байсан бөгөөд тэд уг төв уруу явав.

Ахлагч нар өдөр нь бидэнтэй тэнд уулзахаар тохирсон байв. Тэднийг ирэхээс өмнө бид Франк, Милдред хоёрт номын сангаа үзүүлж, тэднийг Райт Эгчтэй танилцуулсан юм. Райт Эгч гэр бүлийн түүхийн мэргэжилтэн байсан бөгөөд Франкийн эцэгийн талаарх мэдээлэл олоход нь туслахаар амлав. Тэрээр түүний нэрийг номон дээрээс олж мөн эцэгийнх нь төрсөн газрыг харуулсан Германы газрын зургийн хамт Франкад өгөв. Уг олсон зүйлд тэр маш их баярлаж байсан бөгөөд ахлагч нарыг ирэхэд тэрээр тэдэнд зургуудаа үзүүлж мөн гэр бүлийнхээ түүхийг хуваалцахын тулд тэднийг оройн хоолонд урьсан юм. Елиагийн Сүнс түүний зүрх сэтгэлд хүрч мөн зөвлүүлсэн бөгөөд түүний амьдралд сайн мэдээ орж ирэх үүдийг нээжээ.

Сайн мэдээг сонирхоход нь Франкад туслахын тулд юу ярьж болох талаар Милдред тэр үдэш бодож байв. Нэгэн асуулт толгойд нь орж иржээ. “Франк, энэ амьдрал дууссаны дараа ч гэсэн чи надтай мөнхөд хамт байхыг хүсч байна уу? Чи мөнхийн гэр бүлтэй болохыг хүсч байна уу?” гэж тэр асуув. “Өө, Милдред минь, мэдээж би хүсч байна. Би үүнийг яаж хийх вэ?” хэмээн тэрээр хурдан хариулав. Энэ асуулт бол түүний хүлээн залбирч байсан зүйл мөн байв. “Номлогч нарын хэлэхийг сонс” хэмээн тэр хариулав. Тэрээр зөвшөөрчээ. Ахлагч нарыг зааж байхад Сэргээлтийн захиасны дулаан уур амьсгал түүний эргэлзээ хийгээд айдсыг хайлуулжээ. Тэрээр номлогч нарын хуваалцсан үнэнүүдийг тэр дор нь зөвшөөрсөн байна. Тэрээр баптисмын урилгыг хүлээн зөвшөөрөв. Түүнээс хойш Франк, Милдред хоёр хүчтэй мөн Сүмд идэвхтэй хэвээр байна.

Гэр бүлийнх нь төлөө аврах ёслолууд гүйцэтгэгдэж болохын тулд Франк Милдред хоёр уг ажлыг дүүргэхээр шургуу ажиллажээ. Гэр бүлийнхээ гишүүдийн өмнөөс баптисм хүртсэн тэр өдөр хамгийн баярт өдөр байв. Ариун сүмийн ажлыг дуусахад Шүлтц ах эцэгийнхээ талаар зүүд зүүдэлжээ. Эцэг нь хүүхэд байхдаа амьдарч байсан гэрийнхээ ферм дээр байгааг тэрээр харжээ. Эцэг нь довжоон дээрх савлуурын дэргэд, цагаан хувцастай, гараа хүү рүүгээ сунган зогсож байв. Франк зүүднээсээ хаширан сэргээ. Тэдний хийсэн ажлыг эцэг нь хүлээн зөвшөөрснийг тэрээр мэдсэн юм.

Үйл Ажиллагаа: Хамтрагтайгаа Суралцах

- Номлогч нар өөрт нь заахыг зөвшөөрөх шийдвэр гаргахад Франкад юу нөлөөлсөн бэ?
- Гэр бүлийн түүхийн ажлыг гэр бүлүүдэд зориулсан Бурханы төлөвлөгөөтэй та яаж илүү сайн холбож чадах вэ?
- Гэр бүлийн түүхийг олох арга хэрэгсэл болгон та хэр ашиглаж байна вэ? Өдөр бүр уулзаж байгаа хүмүүстэйгээ гэр бүлийн түүхийн мэдээллийг ямар замаар та өгч чадах вэ? Гэр бүлийн түүхийг олох хүч чармайлтдаа илүү түлхүү ашиглаж эхлэх төлөвлөгөө гарга.

Гэр бүлийн түүх бол сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад Их Эзэний бэлтгэсэн хүмүүсийг олоход ашигладаг хамгийн хүчирхэг эх сурвалж юм. Гэр бүлийн түүхийг олох хүч чармайлтдаа ашиглах боломжуудтай байхын төлөө залбир. Гэр бүлийн талаар ярихдаа ихэнх хүмүүс сүнслэг мэдрэмжүүдтэй байдаг. Бид яагаад гэр бүлийн түүхийн ажил хийдэг талаар сургаалыг заалгахдаа тэд Сүнснийг мэддэг. Үүнээс гадна, шинэ гишүүд гэр бүлийнхээ угсааг эрэлхийлж, мөн эцэг өвгөдийнхөө өмнөөс нандин ёслолуудыг гүйцэтгэснээр хөрвөгчдийн идэвх нэмэгдэнэ.

Судар Судлах

Елиагаар дамжуулан Их Эзэн дэлхийд юуг сэргээсэн бэ?

С ба Г 110:14–16

С ба Г 138:32–34

Малахи 4:5–6

С ба Г 128:16–18

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Гэр бүлийн түүхийн ажил сайн мэддэг гишүүнтэй хамт орон нутгийн гэр бүлийн төвд очих цаг тохир. Гэр бүлийн түүхийн төвийг үзэж сонирхохдоо тэнд ямар төрлийн үйлчлэлүүд боломжтой болохыг олж мэд. Уг төв хэдийд онгойдог, уг төвд ямар хүмүүс үйлчилдэг, өдөр бүр холбоо тогтоох хүмүүст юу санал болгох зэрэг бусад мэдээллүүдийг олж мэд.

Уулзсан хүмүүстээ гэр бүлийн түүхийн тусламжийг хэрхэн өгөх дасгал хий. Олох хүч чармайлтууддаа гэр бүлийн түүхийг өгөх төлөвлөгөө гарга.

Гэр бүлийн түүхийн ажлын илүү сайн ойлголттой болохын тулд *True to the Faith* номон дээрх “Гэр Бүлийн Түүхийн Ажил болон Угийн Бичиг” гэснийг уншаад ярилц. Юу сурснаа судлах тэмдэглэлдээ бич.

Хуучин Сонирхогчид

Хуучин сонирхогчид бол заах хүмүүс олох хамгийн үнэтэй эх сурвалж юм. Хүмүүс Сүмийг сонирхохоо зогсоох олон шалтгаан байдаг. Уг шалтгаануудад номлогч нар шилжих, сонирхогчид аяллаар явах, хэдийгээр сонирхогчид дахин ирэхийг нь хүлээж байсан ч номлогч нар очихоо болих, мөн өөрсдөд нь заах ямар ч шинэ зүйл номлогч нарт байхгүй гэдэгт сонирхогчид итгэх зэрэг багтана. Ихэнх хуучин сонирхогчид номлогч нартай дахин уулзахыг зөвшөөрдөг.

Хуучин сонирхогчдыг олж тогтоохын тулд бүрийн номоо ойр ойрхон нэгтгэн дүгнэ. Сонирхогч Сүмтэй анх яаж холбоо тогтоосон, тэдэнд юу заасан, тэд хэрхэн хүлээж авсан, мөн сайн мэдээг тэд яагаад сонирхохоо больсон зэрэг бүсийн ном дээрх мэдээллүүдийг залбиралтайгаар үз. Хэрэв хуучин сонирхогчдод зааж мөн нөхөрлөхөд гишүүд оролцсон бол уг явдлаас юу санаж байгааг нь гишүүдээс асуу. Уг мэдээлэл дээр тулгуурлан сонирхогчтой дахин холбоо барих төлөвлөгөө гарга.

Хэрэв таны зааж буй хэн нэгэн сайн мэдээг сонирхохоо зогсоосон бол ирээдүйд тэдэнтэй холбоо барих номлогч нарт тус болох мэдээллүүдийг бүсийн номондоо тэмдэглэ.



© 2001 Dei Favore. Хуучин сонирхогчид.

Доорх явдлыг уншихдаа хуучин сонирхогчидтой холбоо тогтоосон хүчийг анхаар.

Маш сонирхолтой нь жилийн өмнө том эгч маань үйлчилж байсан номлолд би үйлчлэхээр дуудагдсан юм. Номлолын талбарт очоод хэдэн сар болсны дараа би эгч маань өмнө нь үйлчилж байсан бүс нутгуудийн нэгэнд шилжиж очсон юм. Намайг шилжиж очих болсныг сонсоод хамтрагчтайгаа зааж байсан гэр бүлд зочилж очихыг эгч маань надаас хүссэн захидал бичсэн юм. Норманы гэр бүлд ямар хайртай мөн ойр дотно байсан хийгээд тэд Сүмийг сонирхохоо зогсоосон гэдгийг сонсоод хэрхэн урам хугарсан болохоо тэрээр бичсэн байв.

Би хамтрагчтайгаа Норманд очиж, тэд биднийг халуун дотно хүлээн авав. Сэргээгдсэн сайн мэдээг дахин сонсох урилгыг тэд хүлээн зөвшөөрөв. Энэ удаад тэд ямар ялгаатай байгааг би сайн мэдэхгүй байсан ч бидний захиасыг хүлээн зөвшөөрөхөд тэд бүрэн бэлэн байв. Гэр бүлээрээ баптисм хүртэж мөн гишүүнээр батлуулав.

Энэ явдлын дараа би эгч маань ажиллаж байсан өөр хуучин сонирхогчдын талаар бодов. "Норманы гэр бүлд энэ болсон юм бол, түүний зааж байсан бусад хүмүүст ч энэ тохирч болох юм гэж бодов." Түүний зааж байсан бусад хүмүүстэй холбоо барих санаануудыг асуухаар эгчдээ захиа бичихээр шийдэв. Тэрээр тэмдэглэлээ үзэж байгаад уг бүс дэх бусад хуучин сонирхогчдын нэрсийг надад явуулсан юм.

Дараагийн долоо хоногт нь би хамтрагчтайгаа хамт тэдгээр хүмүүстэй холбоо барив. Баярламаар зүйл нь, тэдний бараг хагас нь сэргээгдсэн сайн мэдээг дахин сонсох урилгыг хүлээн зөвшөөрсөн юм. Энэ бүлэг хүмүүсийн нилээд олон нь баптисм хүртэж мөн гишүүнээр батлуулсан билээ. Эдгээр хуучин сонирхогчидтой уулзах үеэрээ түүнчлэн бидний захиасыг сонирхох найз нөхөд мөн хамаатан садангуудынхан талаар асууж мэдсэн юм. Үүний үр дүнд бид заах нэмэлт хүмүүсийг олсон. Энэ нь номлолын минь хамгийн завгүй өдрүүд байсан билээ.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

- Бүсийн номон дахь бүх хуучин сонирхогчдыг олж тогтоо.
- Дараачийн 24 цагийн дотор аль болох олон хүнтэй холбоо тогтоох төлөвлөгөө гарга.

Өөрсдийн Хүч Чармайлтаар Олох нь

Бурхан Өөрийн хүүхдүүдээ Сэргээлтийн захиасыг хүлээн авахад бэлтгэж байгаа гэсэн итгэлээ хүчирхэгжүүлэхийг хичээ. Заах хүмүүс олохын тулд Ариун Сүнсний удирдамж дор өөрсдийн чадах бүх зүйлийг хий, Их Эзэн тийм хүмүүсийг таны замд тавих болно.

Сэргээгдсэн сайн мэдээнд бэлтгэгдсэн хүмүүсийг олох олон сайн арга замууд байдаг. Бэлтгэгдсэн тэдгээр хүмүүсийн замд байхын тулд өөрсдийн чадах бүх зүйлийг хийх хэрэгтэй. Доорх санаанууд өөрийнхөө хүч чармайлтаар заах хүмүүсийг олоход өөрсдөд нь тусалсан болохыг номлогч нар олж мэджээ. Уг жагсаалтыг нэгтгэн дүгнэхдээ өөрсөддөө шинэ санаануудыг оролдож үзэх төлөвлөгөө гарга. Энэ жагсаалт түүнчлэн заах хүмүүс олох бусад шинэ санаануудыг бодож олох эхлэл болж үйлчлэх болно.



- Саяхан хүүхэдтэй болсон, уг бүсэд нүүж ирсэн, эсвэл гэр бүлд нь үхэл хагацал тохиолдсон хүмүүсийг олж, холбоо тогтоохын тулд бишоп болон хэсгийн зөвлөлтэй хамтарч ажилла.
- Энгийн үйлчлэл хийх боломжуудыг эрэлхийл.
- Сэргээлтийн захиасыг идэвхтэй, идэвх султай гишүүд, саяхны хөрвөгчид, мөн гэр бүлийн хагас нь гишүүн хүмүүст заа. Зааж болох хүмүүстэй танилцуулж өгөхийг тэднээс хүс.
- Гишүүд найз нөхдөө авчирч болох, эсвэл ингэснээр та сайн мэдээг зааж мөн хичээл авах хүмүүсийг асууж болохын тулд гишүүдэд зориулсан галын дэргэдэх ярилцлагыг зохион байгуул.
- Гэр бүлийн үдшийг хэрхэн явуулдгийг хүмүүст зааж өг.
- Цуглааны байраар хамт явж үзэхийг уулзах хүмүүсээсээ асуу.
- Бишоптой уулзуулах цаг тохир.
- Хүмүүст www.mormon.org-оор орж үзэхийг урь.
- Судар судлах анги зохион байгуул.
- Хоёр дахь хэл болох Англи хэлийг заа.
- Семинар эсвэл институтэд явахыг тухайн насны хүмүүсээс хүс.
- Айлаас айлд зочилж, мөн гудамжинд хүмүүстэй ярилц.
- Тараах картууд, DVD-нүүд, дүрс бичлэгүүд, мөн товхимолууд ашигла.
- Саяхны сонирхогчид, хуучин сонирхогчид, идэвх султай гишүүд, ирээдүйн ахлагч нар, мөн уулзах бүх хүмүүсээс бусдын зааж өгсөн хүмүүсийг эрэлхийл.
- Номлолын үйлчлэлийн талаар орон нутгийн сонинд өгүүлэл нийтлүүлэхийн тулд Сүмийн орон нутгийн хэрэг эрхэлсэн төлөөлөгчидтэй хамтран ажилла.
- Сүмийн цуглаанууд, үйл ажиллагаанууд болон нээлтийн ажиллагаанд хүмүүсийг урь.
- Багтисмын үйлчилгээнүүдэд хүмүүсийг урь. Энэ нь Сүмийг хүмүүст таниулах сайхан боломжийг олгох бөгөөд сонирхогчид Сүнснийг мэдрэх онцгой боломжийг олгох чармайлт юм.

Сайныг Үйлдэхээр Яв

Заах хүмүүс олох нь таны итгэл, үйл хөдлөлөөр тань дамжин харагдах болно. Мөнх бус тохинууллынхаа үеэр Аврагч “өөртөө үйлчлэгчийн дүрийг авчээ” (Филиппой 2:7). Тэрээр “сайныг үйлдэж” (Үйлс 10:38) мөн “сайн мэдээг номлохоор (Матай 4:23) явжээ. Энэ жишээг дагаснаар өөрсдийг тань хүлээн авах хүмүүсийг та олох болно.

Үйлчлэлээр дамжуулан та болон сэргээгдсэн сайн мэдээнд бэлтгэгдсэн хүмүүс хүчирхэг, бурханлигаар нөлөөлөгдсөн арга замаар хамтдаа нэгдэх болно. Таныг Бурханы үйлчлэгч гэдгийг хүмүүс ойлгоход сайн үйлс тань тусалж, мөн сэргээгдсэн сайн мэдээг заах боломж уруу хөтлөх болно.

Тэмдэглэл

Олон номлогч нарын үйлчлэлийн тохиолдлууд хэн нэгэнд нүүхэд нь тусалж, Сүмийн фермд үйлчилж, эсвэл ногооны газрыг цэвэрлэх зэрэг төлөвлөсөн “үйлчлэх төслүүдэд” номлолоосоо өмнө оролцсоноор эхэлдэг. Номлогчийн хувьд та тийм төлөвлөсөн үйлчлэлийг долоо хоног бүр хийх болно (нэмэлт мэдээллийг *Номлогчийн Гарын Авлагаас* үз).



Энэ хэсэгт дүрсэлсэн үйлчлэлийн төрөл нь төлөвлөгдөөгүй боломжуудад төвлөрөх болно. Энэ төрлийн үйлчлэлд Бурханы хүүхдүүдэд таны өгч чадах жижигхэн, мөн энгийн найрсаг боломжуудыг олж мэдэхийн тулд Сүнснийг сонсох нь багтдаг. Бүх өдрийн турш сайныг үйлдэхээр залбирч мөн үүнд анхаар. Сайныг үйлдэхийг эрэлхийлснээр та сэргээгдсэн сайн мэдээнд бэлтгэгдсэн хүмүүс уруу хөтлөгдөх болно.

Дараах түүхийг уншихдаа номлогч нар хэрхэн “сайныг үйлдэж,” мөн сайн мэдээг номлосныг анхаар.

Долоо хоног тутмын англи хэлний хичээл дээр маань Пабло тогтмол ирдэг байв. Тэрээр англи хэл сурч, өвчтэй эхнэрийнхээ асуудлыг толгойноосоо авч хаяхыг хүссэн тэтгэвэртээ гарсан хүн байв. Нэг долоо хоногт тэр ирсэнгүй. Яагаад гэдгийг нь хэн ч мэдэхгүй байлаа. Сар орчмын дараа, тэр дахин ангидаа ирэв. Тэр их өөр харагдаж байв. Тэрээр турж, мөн ядарсан харагдаж байв. Тэрээр өмнөх шигээ хичээлд оролцсонгүй, мөн түүнтэй ярихаас өмнө тэрээр явчихсан юм.

Дараачийн долоо хоногийн дундуур, би хамтрагчтайгаа хамт Пабло дахин ирж, биднийг түүнтэй яриулж өгөөч хэмээн залбирав. Тэрээр дараагийн хичээл дээр ирснээр бидний залбирал хариулагдсан юм. Хичээлийн дараа бид түүнтэй ярилцахад, эхнэр нь нас барсан болохыг бидэнд хэлсэн юм. Тэрээр юу болсон талаар бидэнд бага зэрэг ярьж бид ч мөн харамсаж буйгаа илэрхийлсэн юм. Эхнэртэйгээ хэрхэн дахин хамт байж болохыг ойлгоход нь түүнд туслахыг хүсч байгаагаа түүнд бид хэлэв. Тэрээр толгойгоо өргөөд, нүд рүү минь харж, уур хилэн болон гишүүдлын нулимстайгаар, “хэрэв та нар надад туслахыг хүсч байгаа юм бол гэрт маань ирээд амьдралыг минь хэвийн болгож надад туслаач. Энэ тань номлогч нарын хийдэг зүйл биш гэж үү? Гэр орон мөн бусад зүйлсээ хэвийн болгоход надад тусламж хэрэгтэй байна” гэж тэрээр хэлэв.

Паблогийн хэлсэн зүйлд бид гайхаж мөн даруусгагдав. Түүнд хэрэгтэй бүх зүйлээр тусаллаа. Тэр үеэс л тэрээр бидний төлөвлөгөөнд итгэж эхэлсэн байх гэж би боддог. Маргааш гэрт нь ирээд мод тайрахад туслахыг тэрээр биднээс хүсэв. Бид болзсон цагтаа тэднийг очиж, түүнтэй хамт ажиллаж эхлэв. Тэрээр олон сараар эхнэрээ асарсан учраас цэцэрлэг болон гэрийнхээ эргэн тойрон дахь хогийн ургамлуудыг зөнд нь хаясан байв. Бид гуравт хийх ажил хангалттай их байв. Энэ нь түүний гэрт хийх долоо хоног тутмын үйлчлэл болсон юм. Бид мод тайрч, хогийн ургамал зулгааж, мөн жимс түүв. Бид зааж эхлээгүй юм—бид эхлэхийг

“Та аз жаргалтай байхыг хүсч байна уу? Өөрсдийгөө мартаад энэ агуу шалтгаанд уусан од. Хүч чармайлтаа хүмүүст туслахад зориул. . . . Өндөрт гар, дорой өвдөгтэй хүмүүсийг өргө, доош унжсан хүмүүсийн гарыг өргө. Есүс Христийн сайн мэдээгээр амьдар.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ ГОРДОН Б.ХИНКЛИ
TEACHINGS OF GORDON B. HINCKLEY, 597

оролдох үед тэрээр маш хурдан яриагаа зогсоодог байлаа. Биднийг түүний амьдрал, мөн гэр бүлийн талаар ярихад түүнд таатай байдаг байв. Ихэнхдээ тэрээр зөвхөн сонсдог байлаа.

Бараг сар хагасын дараа Пабло “Би үнэхээр эхнэртэйгээ дахин уулзах болов уу?” хэмээн асууж биднийг гайхшруулав. Уулзах болно хэмээн бид баяртайгаар хариулав. Мөнхийн гэр бүлүүдийн талаар гэрчлэлээ хуваалцаж мөн энэ асуултанд бид чадлынхаа хэрээр хариулав.

Бид Паблод авралын төлөвлөгөөг заав. Тэрээр сургаалуудад дуртай байлаа. Биднийг явахаас өмнө тэрээр “намайг түүнийг дахин харахад эхнэр маань бие махбодтой байх уу?” мөн “бид өвчин мөн шаналаасаа салах уу?” гэх зэрэг жагсаан бичсэн асуултуудыг биднээс асуув. Бид эдгээр асуултуудад хариулаад, Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний зарчмуудыг хуваалцах өөр цаг болзов.

Үүнээс хойш удалгүй Паблогийн төрх байдал өөрчлөгдөв. Тэрээр ойр ойрхон инээж, илүү амар тайван болсон мэт санагдсан юм. Үнэндээ “илүү сайн дэлхийн найдвар” (Ифэр 12:4) түүнд байлаа. Бидний үйлчлэл түүнд зааж буй зүйлсэд маань итгэх итгэлийг өгсөн юм.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

- Энэ түүхэнд номлогч нар ямар замаар “сайныг үйлдсэн” бэ?
- Сайн мэдээ заалгах Паблогийн шийдвэрт үйлчлэл ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
- Өдөр бүр та сайныг үйлдэх боломжийг эрэлхийлдэг үү? Энэ хэсгээ та сайжруулж чадах уу?

Заах илүү олон хүмүүс олохын тулд өдрийн турш та хэрхэн илүү сайн зүйл хийж чадахыг судлах тэмдэглэлдээ бич, эсвэл хамтрагчтайгаа ярилц.

Сэргээлтийн захиасыг хүлээн авахад бэлэн хүмүүсийг замд тань байрлуулах болно гэдэгт итгэ. Түүнчлэн номлогч нарыг, Сүмийн гишүүдийг хүлээн авах хүмүүсийг таны сайн үйлс болон үгс бэлтгэх тэр газарт таныг Бурхан байрлуулах болно. Олох бүх хүч чармайлтдаа залбирч мөн үйлчлэх, туслах, мөн бусдыг дэмжих боломжийг хай. Үйлчлэл хийж байхдаа уулзаж буй бүх хүмүүстэй ярилц. Сэргээгдсэн сайн мэдээг хуваалцана гэсэн итгэлтэй бай.

Ямар ч замаар үйлчилсэн, ах эгч нартаа хайртай учраас үүнийг хийх ёстой, тиймээс тэдэнд сэргээгдсэн сайн мэдээг тэдэнд заана хэмээн найдаж, залбирч, мөн чин сэтгэлээсээ хүс.



Удирдамжууд

Сайныг үйлдэхээр эрэлхийлэхдээ доорх удирдамжуудыг сана:

- Хамтрагчтайгаа хамт бай.
- Дуудлагынхаа нандин чанарыг хадгал.
- Номлогчийн дүрмүүдийг сахь, мөн мөнгөө хандивлаж эсвэл ашиглаж болохгүй.
- Долоо хоног тутмын олон нийтийн үйлчлэлийн талаарх удирдамжуудыг *Номлогчийн Гарын Авлагаас* үз.

Судар Судлах**Аврагчийн амьдрал дахь үйлчлэл нь ямар үүрэгтэй байсан бэ?**

3 Нифай 17:7, 21

Матай 9:1–8

Иохан 4:46–54

Матай 8:1–4

Марк 1:21–28

Аммоны болон Аароны номлол дахь үйлчлэлийн үүрэг юу байсан бэ?

Алма 17:19–25

Алма 18:8–10

Алма 22:3

Их Эзэн таныг юу хийхийг хүссэн бэ?

3 Нифай 27:21

Ямар ч Хүч Чармайлт Дэмий Үрэгдэх Ёсгүй

Хүмүүс сэргээгдсэн сайн мэдээг сонирхохоо зогсоосон ч гэсэн таны ажил дэмий үрэгдээгүй. Чадлынхаа хэрээр олон хүмүүст үйлчилж мөн заах байнгын хүч чармайлт бол Өөрийнх нь үйлчлэгчдийг яваандаа хүүхдүүд нь хүлээн авах Бурханы бэлтгэсэн нэг зам юм. Тэрээр ойр ойрхон танаар дамжин Өөрийн хүүхдүүддээ хүрдэг. Сайн мэдээг сурах боломжийг хүмүүс хүлээн зөвшөөрдөггүй ч, таны үйлчлэл болон үгс нь тэдний төлөөх Бурханы хайрын илрэл бөгөөд ирээдүйн номлогч нар хийгээд Сүмийн гишүүд хураах үрийг суулгаж болох юм.

Хүмүүс сайн мэдээг хүлээн зөвшөөрөхгүй байвал бүү сэтгэлээр уна. Та сэрэмжлүүлгийн дуу хоолойг өргөсөн билээ. Та тэдэнд ойлгомжтой сонголтыг өгсөн. Хүмүүсийг наманчлахыг сонгоогүйд Христийн шавь нар гашууддаг, гэвч тэд хэн болох мөн тэд юу хийж байгаа талаарх бодлыг тэр хүмүүс хардаг. Тэд маш хичээнгүй урагшилдаг.

Үүнийг Сана

- “Таныг хүлээн авах тэднийг” олсноор Сүмийг байгуул (С ба Г 42:8).
- Олохдоо Сүнснийг эрэлхийлж, мөн дага.
- Таны бүс дэх хүмүүс сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад бэлтгэгдсэн.
- Сүмийн идэвхтэй, идэвх султай гишүүд, ирээдүйн ахлагч нар, мөн саяхны хөрвөгчид бол заах, баптисм хүртээх, мөн гишүүнээр батлах хүмүүсийг олох таны хамгийн сайн эх сурвалжууд юм.
- Бишоп болон гишүүдтэй бат бөх харилцаа бий болго.
- Олохдоо зааж мөн заахдаа ол.
- Төлөвлөгдөөгүй олох боломжуудыг ухаар.
- Сайныг үйлдэх боломжуудын төлөө залбир мөн Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн захиасыг номло.
- Заах хүмүүсийг олох олон арга замууд байдаг. Зөвхөн нэг эсвэл хоёр аргад анхаарлаа төвлөрүүлэхээс зайлсхий.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Тэмдэглэл

Хувиараа Суралцах

- Номлогчийн эцэг эхдээ бичсэн доорх захидлыг унш: “Би нэг гайхалтай эмэгтэйд автобусан дотор заасан юм. Бид дүүргийн хурлаас буцаж явсан бөгөөд ганцхан сул байсан суудал дээр би суугаад захиануудаа үзэж эхэлсэн юм. Мэдээж, хамгийн түрүүнд унших захидал бол нялх Иваны зурагтай та нарын захидал байсан юм. Миний хажууд нэг нүд зураг уруу харж байгааг анзаарав мөн би дээш харахад настай эмэгтэйн нүдтэй тулгарав. Тэрээр над руу харж инээмсэглэсэнээ цонх руу харав. Тэгээд тэрээр яг унтах гэж байгаа мэт нүдээ анив. ‘Тэнгэрлэг Эцэг минь, би энэ эмэгтэйтэй ярихыг хүсч байна. Надад туслаач’ хэмээн би залбирав. Минутын дараа тэрээр нүдээ нээгээд цэх суув, энэ үед би хурдхан шиг ‘тэр хөөрхөн байна уу?’ хэмээн хэлэв. Би түүнд нялх Иваны зургийг үзүүлээд, гэр бүлийнхээ тухай ярьж эхлэв. Би түүнээс хүүхдүүдийнх нь тухай асуухад түүний нүдэнд нулимс хурж, охин нь түүнийг ямар их үзэн яддаг хийгээд өөртэй нь юу ч хийхийг хүсдэггүй болохыг надад яриу. Тэрээр уйлж мөн би ч түүнтэй хамт уйлсан юм. Би түүнд авралын төлөвлөгөөний талаар мөн Тэнгэрлэг Эцэг түүнийг мэддэг бөгөөд түүнд юу тохиолдож байгааг мэддэг болохыг хэлсэн юм. Би уйлж, би надад хайртай эхийн охин, мөн би түүнд хайртай учраас охин нь ч бас түүнд хайртай гэдгийг хэлэв. Зарим үед хүмүүс муу шийдвэрүүд гаргадаг бөгөөд охинд нь сонголт байгааг би түүнд тайлбарласан юм. Тэрээр инээмсэглээд, ‘Ээж чинь чамайг маш их санаж байгаад би итгэлтэй байна, тэрээр чамтай уулзаад дахин явуулахгүй байх’ гэж хэлэв. Тэрээр надтай ярилцсанд нь талархаад сайн мэдээг түүнтэй хуваалцаж болохын тулд өөрийнхөө хаягийг өгсөн юм. Автобуснаас буухдаа тэрээр, ‘Би буруу автобусанд суучихсан юм, гэвч би буугаагүй. Чамайг ирэх хүртэл хэн ч миний хажууд суугаагүй . . . тэгээд юу болсныг хар. Бурханы төлөвлөгөө төгс юм!’ гэв.

Энэ бүлгийн ямар зарчим уг түүхэнд байгааг та олсон бэ? Бүлгийг нэгтгэн дүгнээд судлах тэмдэглэлдээ жагсаалт гарга. Энэ зарчмуудаас алийг нь та өнөөдөр ашиглахаар хичээж байна вэ?

- Иохан 15:12–13; 21:15–17; 1 Тесалоник 2; мөн Мозая 18:8–10-ыг унш. Бусдыг хайрлаж мөн үйлчлэх үүрэг хариуцлагаа та хэр сайн биелүүлж байна вэ? Судлах тэмдэглэлдээ хариултуудаа бич.
- Таныг Их Эзэний үйлчлэгч гэдгийг хүмүүс хэрхэн мэдэж болох вэ? Энэ асуултыг тунгаан бодож байхдаа Моронай 7:3–5; Матай 7:20; Иохан 13:34–35-ыг судал. Бодлуудаа судлах тэмдэглэлдээ бич.
- 3 Нифай 18:31–32; Алма 8:16; Алма 24:7–8 болон Алма 32:41-ийг унш. Хуучин сонирхогчидтой ажиллах талаар эдгээр шүлгүүд юу зааж байгааг авч үз. Сурсан зүйлээ судлах тэмдэглэлдээ тэмдэглээд мөн хамтрагчдаа зааж өг.

Хамтрагчтайгаа Суралцах

- Өдөр тутмын төлөвлөх хуудсаа ашиглан саяхны хөрвөгдөгчидтэй уулзах төлөвлөгөө гарга. Сайн мэдээнд хэрхэн бэлтгэгдсэн тухайгаа хуваалцахыг тэднээс асуу. Сүмтэй анх ямар холбоогоор холбогдсон бэ? Эцэст нь юу номлогч нартай уулзахыг ятгасан бэ? гэсэн асуултыг асуу. Мэдэж авсан зүйлээ судлах тэмдэглэлдээ бич.
- Доорх сэдэв бүрийг нэгтгэн дүгнэ. Хичээлүүд ашиглан олох энгийн үгсийг бэлтгэ. Олохдоо зааж мөн сэдэв бүрийг Сэргээлттэй хурдан холбох дасгал хий.
 - Амьдралд илүү удирдамж мөн зорилго хэрэгтэй гэсэн мэдрэмж төрөх.
 - Бурханд илүү ойрхон байхыг хүсэх.
 - Чухал шийдвэрүүд гаргахад тусламж хэрэгтэй байх.

Тэмдэглэл

- Гэр бүлийн түүхийн ажлын сургаалын суурийг илүү сайн ойлгохын тулд *Our Search for Happiness* номны 66–68 дугаар хуудсыг, мөн *True to the Faith* номны 59–64–дүгээр хуудсыг унш. Гэр бүлийн түүхийн ажлын талаар үг хэлэхэд бэлтгэ, мөн үүнийгээ хамтрагчтайгаа хуваалц.
 - Хамтрагчтайгаа хамт шинэ бүсэд шилжиж ирсэн гэж төсөөл. Цэвэр нямбай бүсийн номыг та хоёр олов, гэвч ямар ч сонирхогч байсангүй. Маш хурдан заах сандаа хүмүүс нэмэхийн тулд та юу хийх вэ? Эдгээр санаануудыг өнөөдөр хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга.
 - Доорх санаанууд нь олон номлогч болон гишүүдэд амжилт үзүүлсэн юм. Эдгээр санаануудыг хамтрагчтайгаа уншиж мөн судал.
 - Сайн мэдээг хуваалцаж болох найз нөхөд, хамаатан садангууд болон харилцдаг хүмүүсийнхээ нэрсийг жагсаан бичихэд нь гишүүдэд тусал. Энэ жагсаалтыг гишүүдтэй нэгтгэн дүгнээд сайн мэдээг сонсоход нь тэдний туслахыг хүсч байгаа хэн нэгнийг залбиралтайгаар сонгоход нь тэдэнд тусал.
 - Тэд (а) гэртээ хэн нэгэн хүн эсвэл гэр бүлийг хичээл заалгахаар ажиллах эсвэл (б) тэднийг бэлтгэхийн тулд өөр ямар нэгэн нөхөрлөх үйл ажиллагааг хийх өдөр товлоход тэдэнд тусал. Өдөр товлох нь гишүүдийг зорилготой болгож мөн итгэлээ хөгжүүлэхэд нь тэдэнд тусална.
 - Одоогоос товлосон өдөр хүртэл юу хийж болох талаар тэдэнд тусал.
 - Тэднийг дэмжиж мөн зоригжуулахын тулд тэдэнтэй байнга эргэн уулз. Амжилт болон асуудлуудаа хуваалцахыг тэднээс хүс.
- Энэ санааг үйлчилж буй бүсдээ хэрхэн ашиглаж болохыг ярилц.

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- “Өөрсдийн Хүч Чармайлтаар Олох нь” хэсгийг уншаад ярилц.
 - Заах хүмүүсийг олоход нь номлогч нарт энэ санаанууд хэрхэн тусалж байсныг ярилц.
 - Заах хүмүүсийг олох өөр санаануудыг самбарт бич. Өөрсдийн санаануудаа үзүүлэхийг номлогч нараас хүс.
 - Олох хүч чармайлтаа сайжруулах хувийн зорилгууд тавихыг номлогч нараас хүс.
- Олох нөхцлүүдийн жагсаалт гарга.
 - Нөхцлүүдээс номлогч бүрт нэгийг өг. Сэргээлтийн захиасыг хэрхэн заахаа бэлтгэхэд нь номлогч бүрд 5 минут өг. Хэрэв шаардлагатай бол “Есүс Христийн Сайн Мэдээний Сэргээлтийн Захиас” хичээлийг тэдэнд заа.
 - Нөхцөл байдалд тааруулан захиас хэр хурдан үргэлжлэхийг зохицуулахын чухлыг онцол. Жишээ нь, номлогч нар дэлгүүрт тааралдах хэн нэгэнд заахаасаа гишүүдийн гэрт заахдаа илүү цаг зарцуулж болох юм.
 - Цаг байвал томилсон нөхцөлд Сэргээлтийн захиасыг аль болох олон номлогч заахыг зөвшөөр.
- “Олохдоо Заа, мөн Заахдаа Ол” хэсэг дэх зарчмуудыг заа.
 - Олох явцад номлогч хуваалцаж болох нэг минутын захиасыг номлогч бүрээр бэлдүүл. Энэ захиасууд нь номлогчийн хичээлүүд дэх сургаал дээр үндэслэгдсэн байх ёстой.
 - Нэг минутын захиасуудаа бие биендээ хуваалцаж дасгал хийхийг номлогч нараас хүс. Гишүүний гэрт заах, хаалган дээр заах, явган хүний зам дээр

заах, эсвэл хичээл авах хүмүүстэй холбоо тогтоох зэрэг янз бүрийн байдлаар олох нөхцлүүдийг бий болгож болно. Эдгээр нөхцөл бүрт номлогч нараар заах дадлага хийлгэ.

Номлолын Ерөнхийлөгч

- Гэр бүлдээ гишүүн номлогчийн ажлын үлгэр жишээ бий болго. Өөрт тохиолдсон явдлаа номлогч нар болон гишүүдтэй хуваалц.
- Номлолд тань номлогч нар заах хүмүүс олох хамгийн сайн аргыг санваарын удирдагчидтай зөвлө.
- Номлолынхоо сонирхогчдод хандан өөрөө үг хэлж болох номлогчийн галын дэргэдэх ярилцлага зохион байгуул. Галын дэргэдэх ярилцлагад найз нөхдөө гишүүд авчрах боломжийн талаар орон нутгийн номлолын удирдагчидтай ярилц. Энэ галын дэргэдэх ярилцлагын нэг хэсэг болгож өөрийг тань үг хэлэхээс өмнө саяхан хөрвөгч болсон нэг хүнийг гэрчлэлийг нь хуваалцуулж мөн хөрвүүлэгдсэн түүхийг нь хуваалцуул. Өөрийн хэлэх үгээ Сэргээлтийн захиаст төвлөрүүл.
- Дөрвөн үеийн түүхийн хүснэгтээ номлогч нартай хуваалцаж мөн олох хүч чармайлтдаа үүнийг хэрхэн ашигладаг болохоо тайлбарла.
- Заах хүмүүс олоход нь номлогч нарт туслахын тулд үе үе тэдэнтэй хамт яв.

Тэмдэглэл



Заах Арга Барилаа Би Хэрхэн Сайжруулах Вэ?

Үүнийг Анхаар

- Судруудаас би хэрхэн заах ёстой вэ?
- Заахдаа би яагаад асуулт асуух ёстой вэ?
- Ямар хэлбэрийн асуултуудыг би асуух ёстой вэ?
- Зааж буй хүмүүс болон Сүнснийг би хэрхэн илүү сайн сонсож чадах вэ?
- Асуудлаа шийдэхэд нь би хүмүүст хэрхэн тусалж чадах вэ?
- Муу зуршлууд болон донгоосоо салахад нь бусад хүмүүст би хэрхэн тусалж чадах вэ?

Та өөрийг тань хүлээн авах аль болох олон хүмүүст сэргээгдсэн сайн мэдээг заахаар дуудагдсан билээ. Заах нь таны хийж буй зүйлийн цөм юм. Итгэж үнэмшүүлэх хүчээр заахын тулд та Христтэй адил зан чанарыг хөгжүүлж, номлогч нарын хичээлүүдийг судалж, номлолын хэлээрээ ярих чадвараа сайжруулж, Сүнсэнд найд. Их Эзэн үүнийг маш энгийнээр амлалттай зарлиг маягаар мэдэгдсэн:

“Миний үгийг тунхаглахыг бүү эрэлхийл, харин эхлээд миний үгийг олж авахыг эрэлхийл, мөн тэгвэл хэл тань чөлөөтэй байх болно; тэгээд хэрэв та хүсэх аваас миний Сүнс мөн миний үг, тийм ээ, хүмүүнийг итгүүлэх Бурханы хүч чамд байх болно” (С ба Г 11:21).

“Мөн та нар юу хэлэхээ урьдаас бүү бод; харин амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл, мөн хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсэг нь яг тэр цагт та нарт өгөгдөх болно.” (С ба Г 84:85).

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга мэдэгдэхдээ: “Бидний зорилго бол сэргээгдсэн сайн мэдээний захиасыг номлогч нар болон заалгаж буй

Тэмдэглэл

хүмүүс аль алийг нь Сүнс чиглүүлэхийг зөвшөөрөх тэрхүү арга замаар заах явдал юм. Номлогчийн хичээлүүдийг сурах нь чухал боловч эдгээрийг цээжилсэн танилцуулга мэтээр заах ёсгүй. Номлогч нар Сүнсээр өдөөгдсөний дагуу өөрийнхөө үгийг чөлөөтэй ашиглах ёстой. Тэрээр цээжилсэн зүйлээ ярих ёсгүй, харин зүрх сэтгэлээсээ өөрийнхөө хэлэх зүйлээ ярих ёстой. Тэрээр хичээлүүдийг дэс дараагаар нь заахаас зайлсхийж, сонирхогчийн сонирхол болон хэрэгцээний дагуу хийхээр бурханлигаар урамшуулагдсан зүйлээ хийж болно. Өөрийнхөө итгэл үнэмшилийн дагуу өөрийнхөө үгээр ярихдаа тэрээр заасан зүйлийнхээ үнэний талаарх гэрчлэлийг хуваалцах ёстой” (“Statement on Missionary Work,” First Presidency letter, 2002 оны Арванхоёрдугаар сарын 11).

Танд юу хэлж мөн юу хийх ёстойг өгөх Сүнсэнд найдахыг сур. Энэ бүлэг дэх заах арга барилуудыг судалж, хөгжүүлж, мөн ашигласнаар та Их Эзэний мутар дахь хамгийн чадварлаг зэмсэг болох болно. Илүү хүчтэйгээр заахад тань туслахын тулд Сүнс таны хөгжүүлсэн мэдлэг болон арга барилтай нэгдэх болно. Таны заах чанар болон хүч өөрсдөд нь зориулсан сэргээгдсэн сайн мэдээний чухлыг бусад хүмүүс ойлгож мөн мэдрэхэд туслах болно. Таны хувийн зөв зохистой байдал тань тэдний ойлголтод нөлөөлөх болно. Та хэр сайн тэдэнд анхаарал тавьж, мөн сайн мэдээг хэр сайн тайлбарлаж, судруудыг ашиглаж, гэрчлэлээ хуваалцаж, асуулт асууж, амлалтууд хийж мөн сахихыг тэднээс хүсэх нь түүнчлэн тэдний ойлголтод нөлөөлөх болно.

Сүнсийг Дага

“Сүнс нь энэ ажил дахь цорын ганц хамгийн чухал элемент юм. Таны дуудлагыг Сүнсээр чанаржуулснаар номлолын талбарт Их Эзэнд зориулан та гайхамшгуудыг үйлдэх болно. Таны авьяас болон ур чадвараас үл хамааран, Сүнсгүй бол та хэзээ ч амжилтад хүрэхгүй” (Ezra Taft Benson, seminar for new mission presidents, 1986 оны Зургадугаар сарын 25)

Сүнсийг Урих нь

Доорх зөвлөгөөнүүд нь заахдаа Сүнсийг урихад тань танд тусална:

- Залбирах
- Судруудыг ашиглах
- Гэрчлэлээ хэлэх
- Тохиолдсон явдлуудаа хуваалцах
- Их Эзэнд болон бусдад хайраа илэрхийлэх

Заахаа Хэрхэн Эхлэх Вэ?

Сонирхогчидтой байх эхний хэдэн минут бол маш чухал юм. Сонирхогчид танд найдаж сурах ёстой. Анхны айлчлалаа халуун дулаан, хүндэтгэсэн, илэн далангүй байдлаар эхэл. Тэдний шашин шүтлэг, таны айлчлалаас тэд юу хүсч байгааг ойлгоход танд туслах хэдэн энгийн асуулт асуу. Жишээ нь, “Таны амьдралд шашин ямар үүрэгтэй вэ?” гэж асуу. Хэдий тийм ч, тэднийг эвгүй байдалд оруулж болох хувийн асуултууд бүү асуу.

Эхлэхээсээ өмнө байгаа бүх хүмүүсийг хичээлд оролцохыг урь. Их Эзэний Сүнсэнд саад болохгүйн тулд зурагтаа унтрааж, саад болох бусад зүйлсийг холдуулахыг тэднээс хүс.

Хичээлээ эхэлж мөн дуусгахдаа залбирал хийхийг хүсч байгаагаа тайлбарла. Та өөрөө нээлтийн залбирал хийнэ гэдгээ хэл. Зааж буй хүмүүсийн тань амьдралыг

бүх талаар нь, ялангуяа тэд таны зааж буй зүйлс үнэн гэдгийг мэдрүүлэхээр Их Эзэн адислана хэмээн энгийн боловч чин сэтгэлээсээ залбир.

Сонирхогчдын төлөө чин сэтгэлээсээ байж, тэднийг хайрлаж мөн сайн мэдээний хөрвүүлэх хүчинд итгэж буйгаа харуул (Моронай 7:43–48-ыг үз). Сүнсээр удирдагдахдаа, доорхтой ижил бодлуудыг сонирхогчидтойгоо хуваалцаж болох юм:

- Бурхан бидний Тэнгэрлэг Эцэг учраас бид бүгдээрээ ах, эгч нар юм. Бид та нарыг ах, эгч гэж дуудахыг хүсч байна.
- Бидний зааж байгаа хүн бүрт өөрсдийн гэсэн сорилтууд болон асуудлууд байдаг. Та нарын хэрэгцээ эсвэл асуудлаас үл хамааран Аврагч, Түүний заасан зүйлс—сайн мэдээ—та нарт туслах болно.
- Бидний захиас амьдралынхаа байдлыг сайжруулах боломжийг та нарт олгоно. Энэ нь бид бүгдийн амьдралд тулгардаг асуудлууд болон сорилтуудыг даван гарахад та нарт туслах болно.
- Есүс Христ дээр төвлөрсөн бидний захиас бол агуу үнэ цэнэтэй хийгээд чухал юм.
- Бид бүгдээрээ амьдралд алдаа гаргадаг бөгөөд эдгээр алдаанууд нь гэм болон ичгүүртэй мэдрэмжийг бий болгодог. Эдгээр мэдрэмжүүд нь наманчлал хийгээд өршөөлгүйгээр чөлөөлөгдөхгүй. Тэдгээр нь Христийн Цагаатгалаар дамжин бүрэн эдгэрч чадна.
- Бидний захиасыг нэг дор бүгдийг нь сурах боломжгүй юм. Ойлголт нь залбирал, судалгаа, болсон явдлууд, мөн Бурханы зарлигуудыг сахиснаар дамжин аяндаа ирдэг.
- Бусад хүмүүсийн адил бидэнд ч сул тал байдаг. Бид танай хэлээр тийм сайн ярьж чадахгүй, эсвэл та нарын бүх асуултанд хариулах боломжгүй байж болох юм. Гэвч бид өөрсдийн мэддэг зүйлсээ хуваалцахын тулд Бурханы бошиглогчоор дуудагдсан юм. Захиас маань үнэн гэдгийг бид мэднэ.
- Бид хөтөч байх болно, тиймээс та нар бидний захиасын үнэнийг өөрсдөө сурч чадна. Энэ захиасыг хүлээн зөвшөөрч мөн үүний дагуу үйлдэхээр сонгох нь таны хэрэг юм. Тиймээс, та нар чөлөөтэйгөөр асуулт асууж болно.
- Бидний захиасыг ойлгохоор чин сэтгэлээсээ эрэлхийлэхдээ та нар сорилтуудтай тулгарах болно, гэвч Бурхан та нарт туслах болно.
- Бидний захиасыг хүлээн зөвшөөрснөөр та нар Бурхантай хэрхэн гэрээнүүд эсвэл амлалтууд хийхийг сурах болно. Амьдралыг тань Түүний заасан зүйлстэй нийцэхэд ойр болгох өөрчлөлтүүдийг хэрхэн хийхийг та нар сурах болно. Та нар Есүс Христийн заасан зүйлсийг дагаж мөн зөв эрх мэдэл бүхий хүнээр баптисм хүртээлгэхийг хүсэх болно (Иохан 3:5-ыг үз).


Хичээл дэх сургаалуудыг заахаасаа өмнө юу заах гэж буй тухай энгийн тайлбар өгөхөд анхаар. Тэдний хувьд энэ нь хувийн ач холбогдолтой байх болно гэдгийг харахад нь хүмүүст тусал. Таны зааж буй сонирхогчдын ихэнхийг Их Эзэн бэлтгэсэн байдаг (Алма 16:16–17-г үз). Хэрэв та эхний уулзалтаараа сүнслэг тохиолдлуудаа хуваалцвал таныг Их Эзэний үйлчлэгчид гэдгийг тэд мэдэх болно.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Хамтрагчтайгаа хамт эдгээр зөвлөгөөнүүдээс хэд хэдийг ашиглан хичээл эхлэх өөр өөр арга замуудаар дасгал хий.

Хэрэгцээнүүдэд Тохируулан Заах Аргаа Өөрчил

Таны заадаг хүн эсвэл гэр бүл бүр өөр билээ. Хэдийгээр тэд нарын бүх сонирхлууд, амжилтууд, хэрэгцээнүүд болон асуудлуудыг ойлгохгүй ч, тэдний нөхцөл байдлуудыг мэдрэх ёстой. Хэрэгцээ хийгээд асуудлуудаас үл хамааран, бүх хүмүүс сайн мэдээг хүлээн зөвшөөрч мөн үүгээр амьдарснаар хамгийн сайн тусламжийг хүлээн авдаг. Сүнсний өдүүлбэрийг сонссоноор та зааж буй байдлаа өөрчлөх боломжтой байх болно.



Сонирхогчдын сонирхлууд болон хэрэгцээнүүдэд тохируулахаар бурханлигаар нөлөөлөгдөхийн тулд хичээлүүдийн дарааллыг өөрчилж болно. Нэг хичээлийн зарчмуудыг заахын тулд танд нэгээс дээш удаа уулзах шаардлага гарч болно, мөн зарим үед хоёр хичээлд үзэх зүйлийг нэг уулзалтаар зааж болох юм. Тэнгэрлэг Эцэг Өөрийнхөө хүүхдүүдийг мэднэ, тиймээс заахдаа эдгээр шийдвэрүүдийг гаргахын тулд бурханлиг илчлэлтэд найд. Ялган таних бэлгийн төлөө залбир, мөн юу заах талаар оюун эсвэл зүрх сэтгэлд тань орж ирэх бодлуудад анхаарал хандуул.

Сонирхогчдын сахихад илүү хэцүү байгаа гэрээнүүдэд илүү анхаарахын тулд заах зүйлээ өөрчлөх шаардлага танд гарна. Жишээ нь, нэг хүн Мормоны Номыг Бурханы үг хэмээн илүү амархан хүлээн зөвшөөрч байхад, өөр нэг хүн Библиээс өөр зүйлийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байж болох юм. Нэг хүний хувьд тамхиа хаях нь хэцүү байдаг ч аравны нэгийн хуулийг амархан хүлээн зөвшөөрч болно.

Тодорхой нэг сургаалуудыг заахаар төлөвлөхдөө хэдий хэмжээний шинэ мэдээлэл хуваалцах тал дээр мэдрэмтгий бай. Сонирхогчдод таатай байх газарт заа. Зарим хүмүүс бусдаас илүү хурдан эсвэл удаан өсч хөгждөг. Таны танилцуулж буй сургаалуудыг сонирхогч хэр хурдан мөн хэр сайн сурч, мөн ашиглаж байгаа талаар чанд ойлголттой болохын тулд хангалттай асуулт асууж, хариултуудыг нь анхааралтай сонсоход анхаар.

Цагийн хувьд мэдрэмжтэй бай. Ихэнх заах болзоонууд 45 минутаас илүү явагдах ёсгүй. Хэдий тийм ч, хэрэгтэй бол 15 эсвэл 20 минутанд заах хичээл бүрэн дуусч болно. Хэрэв тухайн хүнд тантай уулзах 15 минут байгаа бол уг хүсэлтийг хүндэтгэх үүднээс зааж буй зүйлээ зохицуул.

Сүнс “юу хэлэх ёстойг тухайн цагт та нарт өгөх болно” (С ба Г 100:6-г үз) гэсэн амлалтанд найд.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Та гудамжаар алхаж явтал нэгэн хөгшин хүн хүнд уутыг хогийн саванд хийж чадахгүй байгааг анзаарлаа хэмээн төсөөл. Хамтрагчтайгаа хоёулаа түүнд тусалсны дүнд тэрээр та нар юун хүмүүс болохыг асуужээ. Хэсэг ярилцсаны дараа тэрээр та нарын захиасыг сонсохыг зөвшөөрч гэртээ урьжээ. Эхний хэдэн үг солилцсоны дараа тэрээр та нарт хэлэх нь:

- Эхнэр нь жилийн өмнө нас барсан бөгөөд тэрээр эхнэрээ их санадаг.
- Зүрхний ачааллын улмаас тэрээр маш амархан ядардаг.

- Бурхан байдаг эсэхийг тэрээр урьд өмнөхөөсөө илүү бодох болжээ. Та нар түүнд юу зааж болох вэ? Түүний хэрэгцээ мөн асуудлуудад хамгийн сайн тохируулахын тулд зааж буй зүйлээ хэрхэн өөрчлөх вэ?

Судар Судлах

“Хүн бүрд тохирох хувийг” өгөх гэсэн нь ямар утгатай вэ?

Алма 29:8

С ба Г 84:85

Итгэлтэй номлогч нарт Их Эзэн юу амласан бэ?

С ба Г 68:2–4

С ба Г 100:5–8

Матай 10:19–20

Хамтрагчтайгаа Нэгдэж Заа

Их Эзэн зарлиглахдаа, “Мөн та нар миний сайн мэдээг номлож, хоёр хоёроороо миний Сүнсний хүчээр урагш одох ёстой” гэжээ (С ба Г 42:6). Хэрэв хамтрагчтайгаа хоёулаа нэгдмэл ажиллах юм бол таны зааж буй зүйл илүү хүчтэй мөн сонирхолтой байх болно. Өдөр бүр төлөвлөж мөн судлахдаа та нар нэгдэж мөн нэгэн дуу хоолойгоор заахын тулд хэрхэн заах талаар ярилц.



Хэрэв хамтрагчтайгаа хичээлийн богино хэсгийг ээлжлэн заавал таны зааж буй зүйл илүү хүчтэй байх болно. Захиасыг танилцуулахдаа нэг хэвийн байдалд орохоос зайлсхий. Хамтрагчийнхаа гэрчилсэн үнэний хоёр дахь гэрч болж хамтрагчаа дэмж. Ямар нэг зүйл хэлүүлэхээр Сүнс өдөөх үед сэтгэлийн хөдөлгөөнөө дага. Хамтрагчийн хувьд Сүнсний зааварчилгаанд саад болохгүйн тулд бие биендээ туслахад бэлэн бай. Ярихдаа сонирхогчидтой нүдээрээ холбоо тогтоо. Яриагүй байхдаа хамтрагчийнхаа төлөө залбирч, сонирхогчийн хариултуудыг анхааралтай ажигла.

Судар Судлах

Хамтрагч нар бие биенээ хэрхэн дэмжих вэ?

Алма 12:1

С ба Г 42:6

С ба Г 52:9–10

Заахдаа Туслуулахаар Гишүүдийг Урь

Боломжтой үедээ гишүүдийг тэр тусмаа саяхны хөрвөгчдийг заахдаа туслуулахаар урь. Урьд нь сонирхогчтой нэг ижил сүмд явдаг байсан Сүмийн гишүүдийг оролцуулах нь бодит нөхцөл юм. Хичээлийн хувийг гишүүдэд үзүүлж, мөн тэдэнд юу заахыг хүсч байгаагаа ярь. Хамтдаа хэрхэн ажиллах талаар ярилц. Жишээ нь, хэрэв боломжтой бол гишүүдээр уг хичээлийн тодорхой нэг зарчмыг хэрхэн сурч, хүлээн зөвшөөрч мөн амьдарч байгааг нь хуваалцуул. Сүмд орох шийдвэрийг хэрхэн гаргасан болохыг тэднээр тайлбарлуул. Гишүүд заахад нэгдэн оролцсоноор

номлолын ажлын баяр баяслыг мэдрэх боломжтой байх болно. Энэ нь түүнчлэн сонихогчидтой нөхөрлөх боломжийг олгоно. Ерөнхийлөгч Томас С.Монсон заахдаа:

Заах үйл явцын үеэр сонирхогчид саяхны жилүүдэд баптисм хүртэж мөн гишүүн болох алхам хийсэн гэр бүлийн хос гишүүдийн улмаас хүчирхэгжиж чадна. Канадын Онтарио мөн Кубек Номлолд гэр бүл маань амьдарч, намайг номлолыг тэргүүлж байхад хүн амын ихэнх хэсэг нь Ромын Католик, Анжиликан, мөн Канадын Нэгдсэн Сүм гэсэн гурван гол итгэлд нэгдсэн байв. Номлолын хот бүхэнд эдгээр итгэлүүдээс шинээр баптисм хүртсэн гэр бүлийг шинэ сонирхогчид заалгуулахаар номлогч нартай хамт явуулж, ингэснээр тэдгээр гишүүн хосууд номлогч нартай хоёр дахь эсвэл гурав дахь уулзалтанд хамт явах баг болдог байв.

Жишээ нь, номлогч нар Канадын Нэгдсэн Сүмийн хүмүүстэй ажиллахдаа Канадын нэгдсэн Сүмээс гишүүн болсон Виллиам Стоунеман Ах Эгч хоёрын гэрчлэлийн хүч чадалд талархдаг байв. Хэвлэгч Стоунеман ах “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд орохдоо би Нэгдсэн Сүмийн ахлах хэвлэгч байсан юм. Би ажлаа алдсан. Гэхдээ би илүү дээр ажил олсон. Үүнээс илүүтэй би үнэнийг бүрэн байдлаар нь олсон юм. Та нар ч гэсэн энэ өөрчлөлтийг хийж чадна. Та нар ч мөн адил шийдвэр гаргаж чадна. Үнэндээ Ням гарагийн өглөө бид та нарыг ирж авъя, тэгээд сүмд хамтдаа явцгаая. Тэгээд та нар өөрсдөө сонсож мөн мэдэрч чадна. Би та нарын баруун талд байх болно” гэж хэлэх байсан.

Антони болон Едит Белфигло хоёр Ромын Католикаас гаралтай хүмүүст мөн адил нөхөрлөх хос болсон юм. Үр дүн нь адилхан байв. Энэ нь хийгдэх болно. Ийм хөрвөгчид хөрвүүлэгдсэн хэвээр үлддэг юм. Үүнээс гадна, энэ үүргийг биелүүлэхээр сонгосон хосууд өөрсдийн үндсээ сайн мэдээний баян хөрсөнд илүү гүн оруулдаг юм. Стоунеман Ах, Белфигло Ах хоёр хоёулаа патриархаар томилогдсон юм. Энэхүү тодорхой хамтын ажиллагаан дахь гишүүд болон номлогч нарын хамтарсан хүч чармайлт үнэт бодгалиудын баян цугларалтад ашиг тусаа өгдөг юм (номлогчийн сургалтын хиймэл дагуулын шууд нэвтрүүлэг, 2003 оны Дөрөвдүгээр сарын 25).

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Гишүүний гэрт хичээл заах анхны болзоо тавьсан гэж төсөөл. Заахдаа туслуулахаар доорх гишүүн бүрийг хэрхэн бэлтгэж болохыг шийд:

- Бүрэн цагийн номлолоос саяхан буцаж ирсэн хэсгийн номлогч
- Санваартан
- Саяхны хөрвөгч
- Бишоп

Судруудыг Ашигла

Сүмийн жишиг бүтээлүүд бол Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг заахад тус болох энгийн эх сурвалжууд юм. Та түүнчлэн амьд бошиглогчдын үгсийг ашиглаж болно. Судрууд ашиглах нь яагаад заах зүйлийн тань үндэс болдог олон шалтгаан байдаг. Жишээ нь:

- Их Эзэн болон Түүний бошиглогчид биднийг ийн үйлдэхийг зааварчилсан (С ба Г 42:12, 56–58; 71:1-ийг үз). Хожмын үеийн бошиглогч зөвлөхдөө, “Үгс болон Мормоны Номонд тэдгээрийг Их Эзэний ашигласан арга замыг бид сайн мэдээний зарчмуудыг заахдаа ашиглах ёстой” гэжээ (Ezra Taft Benson, “The Book of Mormon and the Doctrine and Covenants,” *Ensign*, 1987 оны Тавдугаар сар, 84).
- Судрууд нь зааж буй зүйлд тань Ариун Сүнснийг урьж авчирдаг. Тэдгээр нь Бурханы үгийг хүчтэйгээр заадаг (Алма 31:5-ыг үз).

- Судрууд бодгалийн агуу асуултуудад хариулдаг (2 Нифай 32:3; Иаков 2:8-ыг үз).
- Бүр Христэд итгэдэггүй бүсэд ч судрууд таны заасан зүйлд эрх мэдэл мөн нотолгоог өгдөг.

Судруудаас хүчтэйгээр заах таны чадвар тэдгээрийг бие даан судлахаар зарцуулах цаг хугацаанаас ихээхэн хамааралтай. Өдөр бүр уг үгэн дээр хуримласнаар судруудаас заах таны чадвар сайжрах болно. Түүнээс гадна, та ижил зүйлийг амьдралдаа хийж байгаа учраас судруудыг судалж мөн тунгаан бод гэсэн урилга тань илүү хүчтэй байх болно. Судруудад, тэр тусмаа илчлэгдсэн үнэний эх сурвалж болсон Мормоны Номонд итгэх хүмүүсийн итгэл өсөхөд нь тэдэнд тусал. Хүмүүс судруудад итгэхэд та сургаалуудыг зөвөөр ойлгоход нь хүмүүст туслах илүү чадвартай байх болно. Доорх зөвлөгөөнүүд тусалж болох юм.



© Олег К. Сива. Хувилан олшруулж болохгүй.

Судрыг танилцуул. Өөрсдийнхөө ашиглах судрын хэсгийн гарал мөн агуулгыг товч дүрсэл. Судрын хэсэг дэх тодорхой нэг зүйлийг анхаарахыг сонирхогчоос хүс. Судруудын талаар бага ойлголттой хүмүүст заахдаа уг захиасын агуулгыг дүрсэлснээр эхэлж, тэд ойлгож чадах үгсийг ашигла. Судрыг танилцуулах жишээг дор дурдав:

- Бидэнд байгаа энэ Иосеф Смитийн түүхэнд залбирахын тулд ой руу явахад өөртөө юу тохиолдсоныг Иосеф өөрийнхөө үгээр хэлж байна. Тэрээр, Би гэрлэн баганыг харсан юм . . . гэжээ.
- “Энэ судрын хэсэгт бошиглогч Алма Бурханы үгэнд итгэлээ хөгжүүлэхдээ дутмаг хүмүүст зааж байна. Тэрээр Бурханы үгийг бидний зүрх сэтгэлд суулгасан үртэй адилтгажээ. Та . . . шүлгээс эхлээд уншина уу?”

Судрын хэсгийг унш. Шүлгүүдийг чангаар унш эсвэл чангаар уншихыг сонирхогчоос хүс. Уншихдаа тааруу хүмүүстэй болгоомжтой харьц. Хэрэв тэдний хувьд судрын хэсэг нь ойлгоход хэцүү бол тэдэнтэй хамт анхааралтай уншиж, илүү хүнд хэсгүүдийг ойлгоход нь тэдэнд тусал. Эсвэл тэднээр илүү амархан судрын хэсгийг уншуул. Түүнчлэн та хэцүү үг болон хэлцүүдийг тайлбарлаж болно:

- “Бүх хүнд өгөөмрөөр буруушаалгүй (буруушаалгүй гэдэг нь Бурхан алдаа эрж мөн тохохгүй гэсэн утгатай) өгөгч Бурханаас гуйг, тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5).

Зарим судрын хэсэг тодорхой, тайлбарлах шаардлагагүй байдаг. Өөр бусдын хувьд, та цаг гаргаж уншсан зүйлийг тайлбарлах шаардлагатай.

Судрыг Ашигла. Тухайн зарчмууд өнөөдөр ямар хамааралтай болохыг үзүүлснээр судруудыг өөрсөдтэйгөө болон сонирхогчидтой адилтга (1 Нифай 19:23-ыг үз). Зарчмуудыг амьдралдаа хэрхэн ашиглаж болохыг сонирхогчдод үзүүл. Ийнхүү

Тэмдэглэл

үйлдсэнээр тэд тухайн сургаал үнэн болохыг мэдэх болно. Тухайн зарчмын талаарх гэрчлэлээ хуваалцаж мөн адислалуудыг тэдэнд амла. Жишээ нь:

- “Яг тантай адилаар Алмагийн хүмүүсийн дээр маш хүнд, бараг тэд тэсч чадахааргүй тийм ачаа байсан юм. Гэвч тэд итгэлээ хөгжүүлж, Бурханд хандан хүчирхэгээр залбирсан юм. Тэрээр тэднийг хүчирхэгжүүлж, ингэснээр тэд сорилтуудыг тэсч гарч чадсан бөгөөд дараа нь тэднийг зовлонгоос нь чөлөөлсөн билээ. Эдгээр хүмүүст үйлдсэнийхээ адилаар хэрэв та . . . аваас Бурхан таны зовлонгуудыг хөнгөлөх болно.”
- “Мормоны усан дээр хүмүүст өгсөн Алмагийн зааварчилгаа бидэнд өнөөдөр ашиглагддаг. Жон, та . . . бэлэн байна уу?”

Таны зааж буй хүмүүс нандин бичлэгийг хэрхэн харж байгаа, Библийг хэр мэддэг, судрын хэллэгийг хэр сайн ойлгож байгаа, Библи Бурханы үгийг агуулдаг гэдэгт хэр гүнзгий итгэдэг зэргээрээ маш их ялгардаг. Бүх сонирхогчдынхоо судруудад талархаж байгаа сэтгэлийг нэмэгдүүлэхэд тусал. Заахдаа судруудыг үр бүтээлтэй ашигласнаар сонирхогчид өөрсдөө судруудаас сурч эхлэхэд нь та тусалж чадна. Уулзалт бүрийнхээ дараа, тэдэнд уншуулахын тулд тодорхой бүлэг эсвэл шүлгүүдийг тэдэнд санал болго. Дараагийн уулзалт дээр ярилцаж болохын тулд уншиж байхдаа авч үзэх асуултуудыг тэдэнд өг. Энэ нь тэд гэртээ, Сүмийн цуглаанууд болон ангиуд дээр судар ашиглагдах газруудад өдөр бүр судруудаас судлах боломжийг тэдэнд олгоно.

Судруудын Соёлын Хандлага

Ихэнх шашнууд нандин бичээсүүд, эсвэл судруудтай байдаг боловч Сүмийн гишүүд судруудыг хэрхэн авч үзэж байгаагаас хамааран тэднийг ашиглах байдал нь өөр өөр байдаг. Жишээ нь, судруудаа тэмдэглэсэн нь судруудад заасан зүйлийг ойлгож мөн ашиглах хүсэл болохоос биш үл хүндэтгэсэн байдлын тэмдэг биш гэдгийг тайлбарлах хэрэгтэй байж болно. Бурханы бошиглогчдоор бичигдсэн Их Эзэний үгийг агуулдаг, мөн үнэн гэдгийг нь бид хүлээн зөвшөөрдөг учраас жишиг бүтээлүүд нь чухал гэдгийг харахад нь зааж буй хүмүүстээ тусал.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Доорх судрын хэсгүүдээс нэгийг нэгтгэн дүгнэ. Та нар хэрхэн . . . шийд:

- Судрын хэсгийг танилцуулах
- Агуулгыг нь тайлбарлах
- Судрын хэсгийг уншаад мөн утгыг нь тайлбарлах
- Хэцүү үгсийг тайлбарлах
- Үүнийг сонирхогчид амьдралдаа хэрэглэхэд нь туслах

Мормоны Номны Нүүрний хуудас; 3 Нифай 11; Моронай 10:3–8; Иохан 17:3; Ром 8:16–17; 1 Коринт 15:29; Иаков 1:5; 1 Петр 3:19–20; Амос 3:7

Судар Судлах

Судруудаас заах нь яагаад чухал вэ?

1 Нифай 19:23

С ба Г 20:7–12

2 Тимот 3:15–17

2 Нифай 4:15–16

Ойлгомжтой Заах нь

Хүмүүс захиасыг ойлгосон үедээ Сайн Мэдээний Сэргээлтийн тухай захиаст итгэх илүү боломжтой болно.

Ерөнхийлөгч Жеймс И.Фауст хэлэхдээ:

“Судруудыг, ялангуяа Мормоны Ном болон Шинэ Гэрээг судалж, тунгаан бодож, мөн заа. Ойлгомжтой ярьж болохын тулд үнэнийг мэд. Б.Х.Робертс бичихдээ, Үнэн мэдэгдсэн байх гэдэг нь юу хэлж байгаа нь илүү ойлгомжтой мөн илүү бүрэн, уг ажил үнэн гэдгийг тухайн хүний бодгалд Ариун Сүнс гэрчлэх илүү боломжтой байх ёстой. [*New Witnesses for God*, 3 vols. (1909), 2:viii]. Өөрөө хөрвүүлэгдэлгүйгээр хүмүүсийг та нар хөрвүүлж чадахгүй” гэжээ (“What I Want My Son to Know before He Leaves on His Mission,” *Ensign*, 1996 оны Тавдугаар сар, 41)

Заахдаа судруудын талаар ярилцаж мөн сэнхрүүлэхээр та зарлигдуулсан билээ (С ба Г 68:1-ийг үз). *Сэнхрүүлэх* гэдэг нь тодруулж мөн тодорхой тайлбарлах гэсэн үг юм. Сайн мэдээг сэнхрүүлэх гэдэг нь та сургаалууд болон судрын хэсгийн утгыг энгийн мөн тодорхой тайлбарлаж, хэлэх зүйл руу тань Сүнс хөтлөнө гэдэгт найдахыг хэлнэ. Сургаалын зарчмыг ойлгоход нь хүмүүст туслахын тулд та эмх цэгцтэй боловч ярианы хэлийг ашигла. Тухайн зарчмуудыг бодоход нь тусалж мөн заасан зүйлийг тань ойлгож мөн хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг нь мэдэхийн тулд та асуулт асуудаг.

Бүлэг 3 дахь эхний гурван хичээлүүдийн төгсгөлд зааж буй хүмүүст тань танил биш үгнүүдийг жагсаан бичсэн байгаа. Ойлгомжтой заахын нэг хэсэг бол тань бусад хүмүүс илүү сайн ойлгож болохын тулд үгнүүд, хэлцүүд, болон санаануудыг тайлбарлах нь чухал. Та доорх зүйлсийг хийснээр сайн мэдээг тайлбарлах чадвараа өсгөж чадна:

- Ашиглаж байгаа үгсээ ойлгох нь.
- Бусдын ойлгож чадахааргүй үгнүүдийг тайлбарла. Сүмийн гишүүдийн хувьд онцгой зүйлийг заадаг олон үгсийг *Guide to the Scriptures* болон *True to the Faith* хэсгүүдэд энгийнээр тайлбарласан байдаг.
- “. . . энэ үг ямар утгатай болохыг та мэдэх үү?” эсвэл “Бидний сая ярьсан зүйлийг та өөрийнхөө үгээр хэлэхгүй юу?” гэх мэт асуултуудыг хүмүүсээс асуу.

Бүлэг 3 дахь сургаалийг судлахдаа сонирхогчид ойлгохгүй байх хэмээн бодсон хүнд үгнүүдийг олж тогтоо. Бүлэг 3 дахь сургаалийг заахдаа сонирхогчид ойлгоход хэцүү байгаа үгс, хэлцүүд болон санаануудыг тэмдэглэ. Дээр дурдсан арга хэрэгслүүд ашиглан тэдгээр үгнүүдийг олж тогтоо. Олсон үгийн тайлбараа сонирхогчид болон саяхны хөрвөгдөгчдийнхтэй харьцуул.

“Үл мэдэгдэх мөн дотор
нь агуу зүйл агуулагдаж буй
сэдвийг хүн хүүхэд ойлгож
болохуйц энгийн мөн товч
болгож чадах нь хүмүүний
жинхэнэ ухамсар юм.”

—ЕРӨНХИЙЛӨГЧ ЖОН ТЕЙПОР
THE GOSPEL KINGDOM, SEL. G. HOMER DURHAM (1943), 270

Судар Судлах

Сургаалуудыг бид яагаад анхааралтай сэнхрүүлж мөн тайлбарлах ёстой вэ?

Мозая 8:3

Алма 12:1

С ба Г 68:1–5

Мозая 27:35

3 Нифай 26:1

С ба Г 71:1

Бид хэрхэн сурах вэ? Мэдээллийг товчилж мөн аажмаар нээх нь яагаад чухал вэ?

2 Нифай 28:30

Иозая 2:9

С ба Г 98:11–12

Иаков 4:13

Тодорхой байх нь яагаад чухал вэ?

2 Нифай 25:4, 7, 28

Алма 13:23

Иехемиа 8:8

2 Нифай 32:7

Их Эзэн хүүхдүүдтэйгээ хэрхэн харьцдаг вэ?

2 Нифай 31:3

С ба Г 1:24

Асуултуудыг Асуу

Зарчмуудыг тунгаан бодож мөн ашиглахад нь хүмүүст туслахын тулд Есүс Христ ихэнхдээ асуулт асуудаг байсан. Түүний асуултууд бодол төрүүлсэн, сүнсийг эрэлхийлсэн, мөн амлалт хүссэн байв.

Сайн асуултууд нь бусдын сонирхол, асуудлууд, болон асуултуудыг ойлгоход тусалдаг. Тэдгээр нь зааж буй зүйлийг тань өргөжүүлж, Сүнсийг урьж, мөн сурахад нь сонирхогч нарт тусалдаг.

Муухан асуултууд нь сонирхогчдыг айлгаж, уурлуулж мөн гомдоодог. Тэдгээр нь түүнчлэн зааж буй зүйлээ хянаж чадахаа болих нөхцөлд таныг оруулна. Доор заасан асуултуудыг асуух гэж оролд:

- Энгийн мөн ойлгоход амархан.
- Зааж буй зүйлийг тань хүмүүс бодож үзэхэд туслах.
- Зааж буй зүйлийг тань сонирхогчид хэр сайн ойлгож байгааг харахад танд туслах.
- Сурсан зүйлээ ашиглахад нь хүмүүст туслах.

Зааж буй хүмүүст тань ийм асуултуудад хариулснаар нээлттэй ярьж болох юм гэсэн мэдрэмж төрдөг. Сайн асуултууд нь сонирхогчидыг ойлгохгүй байхад, асуудалтай байгаа үед нь, эсвэл тэд юу хийх ёстойгоо мэдэхийг хүсэхдээ танаас асуулт асуух зам уруу хөтөлдөг. Сайн асуултууд нь зааж буй хүмүүс тань өөрсдийн бодлоо хуваалцахад тусална, ингэснээр гэрчлэл нь хэр өсч байгааг нээж гаргах болно. Үр дүнтэй асуултуудын жишээнүүдэд:

- Бидний заасан зүйлсийн талаар танд ямар асуулт байна вэ?
- Тэнгэрлэг Эцэг танд хайртай гэдэгт та итгэдэг үү? Яагаад?



- Энэ түүхэн дэх хүмүүсийн хийсэнтэй адил алдааг бид заримдаа яаж хийдэг вэ?

Асуултуудад хариулахад нь зааж буй хүмүүстээ туслахын тулд та “Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалахын чухлыг би танд тайлбарласнаар, Миний хувьд энэ зарлиг ямар ач холбогдолтой вэ?” гэж өөрөөсөө асууж болно. Доорх төрлийн асуулт асуухаас зайлсхий:

- Нэгээс илүү санаануудыг багтаасан.
- Заагаагүй сургаалуудыг оролцуулсан.
- Тодорхой зорилгогүй.
- Байцаасан мөн шаардлагагүйгээр бусдын хэрэгт оролцсон.

Ялангуяа эхний уулзалт дээрээ маш олон асуулт асуух нь та “байцаалт” явуулж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Чухал биш мөн илэрхий нарийн ширийн зүйлийн талаар тодорхой хариулт сонирхогчоос шаардсан асуулт бүү асуу. Энэ нь заах сайхан орчныг тааж тоглодог тоглоомын орчин болгож өөрчилдөг. Хэрэв танд тодорхой хариулт хэрэгтэй бол бодит баримттай асуулт асуух эсвэл мэдээллийг өөр замаар танилцуулах нь хамгийн сайн. Хэрэв хариултыг нь мэдэхгүй бол хэн нэгнийг ичээх асуулт асуухаас зайлсхий. Гол зарчмуудыг зааж мөн гэрчилсний дараа асуусан асуултууд нь хамгийн үр дүнтэй байдаг. Үр ашиггүй асуултуудын жишээг дор үзүүлэв:

- Эхний бошиглогч хэн байсан бэ? (Эрин үеүдийн тухай заахаасаа өмнө асуусан.)
- Бие махбодио цэвэр ариун байлгах нь Сүнстэй хамт байж мөн Бурханы бошиглогчийг дагахад бэлэн гэдгээ харуулахад бидэнд хэрхэн туслах вэ? (Нэгээс илүү санаа.)
- Бурханы зарлигуудыг мэдэх нь чухал уу? (Гийм-үгүй хариулт мөн дэндүү илэрхий.)
- Мормоны Номны талаар та ямар бодолтой байна вэ? (Уншихаас нь өмнө.)
- Бурханд ойрхон байгаага мэдэрхийн тулд бид өдөр бүр юу хийж болох вэ? (Залбирах гэсэн тодорхой хариулт авах гэсэн бүдэг бадаг асуулт.)
- Ноагийн дараачийн бошиглогч хэн байсан бэ? (Тэднийг таа хэмээн асуух.)

Сүнс өдөөсөн үед асуулт асууж сур. Зөв үед зөв асуулт асуух нь зааж буй хүмүүст тань сайн мэдээг сурахад мөн Сүнсийг мэдрэхэд туслах болно. Үүний адилаар буруу асуултууд мөн буруу үед асуусан асуултууд нь тэдний сурч буй зүйлд саад болдог. Тохиромжтой үед зөв асуулт асуухад танаас Сүнстэй нэгдмэл байх, зааж буй хүмүүсээ сонсох, мөн зааж байхдаа анхааралтай байх зэргийг шаарддаг. Үр дүнтэй заах нь шургуу ажил байж чадах бөгөөд таны болон хамтрагчийн тань талаас төвлөрөлт мөн хүч чармайлтыг шаарддаг.



© 1985 Robert T. Barrett. Хувиан олшруулж болохгүй.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

Хэрэв сонирхогч тань доорх нөхцөл байдалд орчихсон мөн та үүнийх нь талаар хэзээ ч олж мэдээгүй бол түүнд юу тохиолдох вэ?

- Сүнслэг зүйлсийг байнга шоолдог хамт ажиллагсад
- Гэр бүлийн гишүүд нь өөр сүмийн идэвхтэй гишүүд
- Мормончууд бол Христэд итгэдэггүй гэдэгт итгэдэг найз нөхөд
- Мормоны Номноос уншсан сүнслэг тохиолдол.

Дээрх нөхцөл байдал бүрийн талаар мэдэж авахын тулд ямар асуулт асууж болох талаар бод. Асуултуудаа судлах тэмдэглэлдээ бич. Энэ үйл ажиллагаанд зориулан бичсэн асуултуудаа хэрхэн сайжруулж болох талаар хамтрагчтайгаа ярилц.

Сонсох

Бусдыг анхааралтай сонссоноор та тэднийг илүү сайн ойлгох болно. Өөрсдийнх нь бодол мөн сэтгэгдлүүд танд чухал гэдгийг мэдсэнээр тэд таны зааж буй зүйлийг амархан хүлээн авч, мөн хувийн тохиолдлуудаа хуваалцаж, мөн амлалтууд хийх болно. Сонссоноор та зааж буй зүйлээ тэдний хэрэгцээ мөн сонирхолд илүү амархан шилжүүлж чадна.

Ялангуяа Сүнсний шивнээг сонс. Бусад хүмүүс сэтгэгдлээ тантай хуваалцаж байхад Сүнсээр чиглүүлэгдсэн бодлууд эсвэл санаанууд оюунд тань орж ирж болох юм. Түүнчлэн та бусад хүмүүс ямар зүйл илэрхийлэхийг хичээж байгааг ойлгох чадвартай болно.

Бусад хүмүүс чамтай ярьж байхад юу хэлэх тухайгаа бодохыг хичээхээс зайлсхий. Хариулахаа бодохын оронд ярьж буй хүндээ илүү анхаарал төвлөрүүл. Ахлагч Жефффри Р.Холланд заахдаа: “Ярихаас илүү чухал зүйл бол сонсох. Эдгээр хүмүүс нь баптисмын тоо бөглөх амьгүй зүйлс биш. Тэд бол Бурханы хүүхдүүд, бидний ах, эгч дүү нар, мөн тэдэнд бидэнд байгаа зүйлс хэрэгтэй. Бодитой бай. Чин сэтгэлээсээ харьц. *Тэдний* хувьд хамгийн чухал зүйл юу болохыг энэ найз нараасаа асуу. *Тэд* юунд баярлаж мөн юуг эрхэмлэдэг вэ? Тэгээд сонс. Хэрэв энэ зөв байвал та тэд юунаас айдаг, тэд юунд инээдэг, эсвэл амьдралдаа юуг тэд үгүйлж байдаг болохыг тэднээс асуу. *Тэдний* хэлэх зүйл дэх *ямар нэг юм үргэлж* таны гэрчилдэг мөн таны тэдэнд өгч чадах тэрхүү сайн мэдээний үнэнийг тодруулан гаргаж ирдгийг би танд амлаж байна. . . . Хэрэв бид хайраар сонсох юм бол юу хэлэхээ бодох шаардлага бидэнд байхгүй. Энэ нь бидэнд Сүнсээр мөн найз нөхдөөр маань дамжин өгөгдөх болно” (“Witnesses Unto Me,” *Ensign*, 2001 оны Тавдугаар сар, 15; эх хувь нь налуу бичлэгээр бичигдсэн).

Хүмүүс түүнчлэн сууж байгаа байдал, нүүрний хувирал, гараараа хийж байгаа хөдөлгөөн, дууны өнгө болон нүдний хөдөлгөөнөөр холбогддог. Эдгээр дуу гардаггүй захиасуудыг ажигла; зааж буй хүмүүс тань ямар сэтгэгдэлтэй байгааг ойлгоход тань эдгээр зүйл тусална. Түүнчлэн өөрсдийнхөө биеийн хэлэнд анхаар. Чин сэтгэлээсээ сонссоноор сонирхож буй мөн баярлаж байгаа захиас дамжуул.

Чимээгүй байхаас бүү ай. Асуулганд хариулж мөн сэтгэгдлээ илэрхийлэхийн тулд чимээгүй байх хугацаа хүмүүст хэрэгтэй байдаг. Асуулт асуусныхаа дараа, сүнслэг тохиолдол хуваалцсаныхаа дараа, эсвэл өөрсдийгөө илэрхийлэх нь хүмүүст хэцүү байгаа үед түр чимээгүй байж болно. Таныг хариулахаас өмнө бодож буй зүйлээ гүйцээх цагийг хүмүүст өгөхөд анхаар мөн тэднийг ярьж байх үед бүү саад бол.

Хэлсэн зүйлийг нь ойлгож байна гэж бодвол ойлгосон болохоо харуулахын тулд “Тэгэхээр таны хэлж байгаа тань _____ гэсэн үг байна. Зөв үү?” эсвэл “Хэрэв би ойлгосон бол та _____ бодож байна” зэрэг тайлбар хий. Ойлгосон эсэхдээ эргэлзэж байгаа бол тодруулж өгөхийг уг хүнээс хүс.

Зарим хүмүүс ярианы сэдвийг өөрчилж мөн сэргээгдсэн сайн мэдээг заахаас таныг холдуулахыг оролддог. Та ийм нөхцөл байдлуудыг баримттайгаар хянаж сурах хэрэгтэй. Жишээ нь, “бидэнтэй хуваалцахыг хүсч байгаад тань баярлалаа, гэвч энэ сэдвээр бид дараа ярилцаж болох юм. Дараа уулзахдаа энэ талаар ярихаа мартахгүйн тулд бичиж авахыг би хамтрагчаасаа хүсье”. Есүс Христийн сайн мэдээг зааснаар та хүмүүст хамгийн их тусалдаг гэдгийг сана.

Таныг анхааралтай сонсох үед юу хэлэхээ мэдэхэд тань Сүнс туслах болно. Сонсох нь хүч чармайлт мөн анхаарал шаарддаг. Нэгэн номлогч доорх болсон явдлыг хуваалцсан юм (нэрүүдийг өөрчилсөн):

Хамтрагч бид хоёр Санчесийн гэр бүлд зааж байв. Мааш халуун байсан бөгөөд хүүхдүүд нь мааш их чимээ гаргаж байв. Санчес эгчээс би Мормоны Ном хэр уншиж буй талаар асуув. Түүнийг тайлбарлаж эхлэхэд тэдний хүү хамтрагчийн маань тэмдэглэлийн дэвтрийг булааж аваад гэр дотуур гүйн агаарт даллаж байгааг би анзаарав. Хэдийгээр би Санчес Эгч уруу харж байсан ч оюун маань өөр газарт байв. Би дотроо, “ямар халуун юм бэ, энэ хүүхэд нь томоотой байдаггүй юм байх даа. Энэ ерөөсөө болохгүй байна” гэж бодож байв. Ийм зүйл бодон завгүй байх зуур Санчес эгч ярих гэж хичээж байв. Сонс гэсэн хоёр дахь бодол оюунд маань орж ирэв. Халуун агаар болон шуугианыг намдаах гэж би тэмцэж байв. Түүнийг ярьж байхад нь би нүүр рүү нь анхааралтай харав. Тэрээр газар ширтэж байв, тэгээд хамтрагч бид хоёр уруу ээлжлэн харав. Нөхөр нь хүүхдүүдээ чимээгүй болгохыг хичээж байв. Хэсэг чимээгүй болов, тэгтэл чичирсэн хоолойгоор тэрээр, “Би та нарын хий гэснийг хийсэн. Та нарын намайг уншихыг хүссэн бүлгийг би уншиж мөн залбирсан” гэж хэлэв. Тэрээр дахин чимээгүй болж доошоо харав. Тэрээр хүүхдүүд рүүгээ хальт харснаа харц нь минийхтэй тулгарсан юм. “Би хариулт авсан. Энэ бол үнэн, би үүнийг үнэн гэдгийг мэднэ” хэмээн тэрээр инээмсэглэн, нүдэндээ нулимс цийлэгнүүлэн хариулав. Сүнс өрөөг дүүргэв. Сонссондоо зүрх сэтгэл минь баяраар дүүрсэн би инээмсэглээд “Тийм ээ, энэ үнэн” гэж хэлсэн юм.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

Дээрх түүхийг нэгтгэн дүгнэснийхээ дараа доорх асуултуудад хариулан судлах тэмдэглэлдээ бичиж эсвэл хамтрагчтайгаа ярилц.

- Хэрэв уг номлогч өөрийнхөө ая тух эсвэл хамтрагчийнхаа тэмдэглэлийн дэвтрийн талаар илүү санаа зовсоор байсан бол юу болох байсан бэ?
- Номлогч нар сонссон учраас энэ сонирхогч хэрхэн адислагдсан бэ?

Доорх асуултуудад хариул:

A = Миний хувьд хэзээ ч үнэн байгаагүй B = Миний хувьд ихэнхдээ үнэн байдаг
B = Миний хувьд заримдаа үнэн байдаг G = Миний хувьд үргэлж үнэн байдаг

- Хүмүүстэй ярихдаа би анхааралтай сонсохын оронд хуваалцаж болохуйц ижил төстэй тохиолдлуудын талаар боддог.
- Бусад хүмүүсийг сэтгэгдлээ хуваалцаж байхад би байсан бол ямар сэтгэгдэлтэй байхыг ойлгохын тулд тэдний байранд өөрийгөө тавьж үздэг.
- Сонирхогчдод заахдаа би юу хэлэх талаараа болон дараа нь юу заах талаар санаа зовдог.
- Сонирхогчид их ярихыг хүсэхэд миний урам хугардаг.
- Бусад хүмүүсийн надад хэлэхээр хичээж байгаа зүйлийг дагаж мөн ойлгоход надад хэцүү байдаг.

- Хамтрагчаа зааж байхад оюун маань хэсүүчилдэг.
- Хэн нэгэн надтай ярьж байхад бусад хүмүүс миний анхаарлыг сарниулж мөн таслах юм бол би их гомддог.
- Ямар нэг зүйл хэлж эсвэл хийх сүнслэг өдүүлбэрийг би хүлээн авдаг, гэвч би тэдгээрийг тоодоггүй.

Сонсох чадвараа сайжруулахын тулд юу хийж чадахаа олж тогтоо.

Сонирхогчидтой Баттай Сайн Харилцааг Хөгжүүл

Гомдоохоос зайлсхийхийн тулд зарим хүмүүс асуултанд хариулахдаа жинхэнэ сэтгэгдлээ хуваалцахаас илүү тэдний сонсохыг хүсч байгаа хариултыг өгдөг. Тантай тэд жинхэнэ сэтгэгдлээ хуваалцахдаа тохиромжтой байх тийм харилцааг хөгжүүлэхийг эрэлхийл.

Асуудлуудаа Шийдэхэд нь Хүмүүст Тусал

Зааж буй хүмүүсийн тань зарим нь амлалтуудыг биелүүлэх итгэлээ алдаж, зарим нь эсэргүүцэлтэй тулгарч мөн зарим нь таны заах бүх зүйлийг үргэлж хүлээн зөвшөөрөхгүй байх болно. Тэд өөрсдөө шийдвэр гаргах ёстой, гэвч тэдний асуултуудад хариулахын тулд чадах бүхнээ хийж, асуудлуудаа шийдвэрлэхэд нь мөн эсэргүүцлийг даван туулахад нь туслахыг хүсэх болно.

Зарим үед хүмүүсийн асуудлууд яг мөсөн уултай ижилхэн юм. Зөвхөн жижигхэн хэсэг нь гадаргуу дээрээ харагддаг. Эдгээр асуудлууд нь шийдэхэд төвөгтэй мөн хэцүү байж болно. Энэ нөхцөлд та Сүнснийг дагаж мөн тухайн нөхцөлд хамгийн сайн тохирох маягаар хариулах хэрэгтэй. Ялган таних бэлгийн төлөө залбирч мөн сэтгэлийн хөдлөлүүдээ дага. Тэнгэрлэг Эцэг бүх хүмүүсийн зүрх сэтгэл мөн тохиолдсон зүйлсийг мэддэг (бүхэл мөсөн уул) мөн хүн бүрийн хувьд юу хамгийн сайн гэдгийг мэдэхэд танд туслах болно.

Бусад хүмүүст асуудлуудаа шийдвэрлэхэд туслахдаа эхлээд асуулт асууж мөн сонссоноор тэдний асуудлуудыг ойлгохыг эрэлхийл. Асуудлуудаа шийдэхэд нь тэдэнд хэрхэн туслахыг та мэдэж болохын тулд Сүнсэнд найд. Жишээ нь, баптисм хийхэд шаардлагатай асуудлуудлын талаарх асуудлыг мэдэхийн тулд та судар ашиглаж болно, эсвэл та Бошиглогч Иосеф Смитийн талаарх гэрчлэлээ хуваалцаж болно.

Ихэнх тохиолдолд асуудлууд сургаалын байхаас илүү нийгмийн чанартай байдаг. Жишээ нь, хэрэв сонирхогчид Сүмд орвол гэр бүлийн гишүүдийн эсэргүүцлээс айж болно. Эсвэл тэд ажил дээрх найз нарынхаа эсэргүүцлээс айж болох юм. Ямар ч асуудал байсан, сонирхогчид тань асуудлынх нь нэг хэсэг болсон таны ойлгохгүй өнгөрсөн явдал эсвэл бусад нөлөөллүүд байж болно. Олон



Хувилан олшруулж болохгүй.

тохиолдолд гишүүд ойлгоход тань мөн тэдний асуудлуудад туслахад тань тусалж болох юм.

Сонирхогчийн асуудалд хэрхэн хандах тань тухайн асуудлын мөн чанараас хамаардаг. Тухайн хүнд Сэргээлтийн үнэний талаар сүнслэг баталгаа байхгүй учраас эсвэл үнэн зарчмаар амьдрахыг тухайн хүн хүсдэггүй учраас уг асуудал гарч ирсэн эсэхийг олж тогтоо. Энэ замаар асуудлын эх сурвалжийг ойлгох нь гэрчлэл дээр тулгуурлах уу эсвэл амлалтууд дээр үү гэдгийг мэдэхэд тань тусална.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Хичээлүүдийг зааж байхдаа өгч болох нэг даалгаварыг сонго. Тэгээд уг даалгаврыг хүлээн зөвшөөрч эсвэл сахихаас хэн нэгнийг холдуулж болох өөр өөр асуудлуудыг олж тогтоо. Тэдгээр асуудлуудыг шийдэхэд нь хүмүүст яаж тусалж чадахаа ярилцаж мөн дасгал хий.

Наманчлал болон Донгоос Салгах нь

Наманчлал бол даруу байдал, гэмээ хүлээх, нөхөн төлөх, мөн тухайн нүглийг дахин үйлдэхгүй байх гэсэн сүнслэг үйл явдлуудыг багтаадаг. Энэ бол бодол санаа хийгээд үйл хөдлөлийн байнгын өөрчлөлт юм. Үнэндээ тодорхой нэг нүглийг наманчлах нь зөвхөн ганц удаа байх ёстой. Хэдий тийм ч, хэрэв уг нүглийг давтан хийвэл наманчлал нь эдгэрэх гэсэнтэй адил боломжтой юм (Мозая 26:30; Моронай 6:8; С ба Г 1:31–32-ыг үз).

Наманчлалд сэтгэл санааны болон биеийн үйл явц оролцож болно. Хүмүүс цааш үргэлжлэх мөн нэвчсэн зохисгүй үйлдлээ зогсоох ёстой. Хүсэшгүй үйлдлүүд нь эрүүл мөн зохистой зан чанараар солигдох ёстой.

Иймээс, наманчлал мөн солигдох үйл явц хоёр хоёулаа цаг хугацаа шаарддаг. Заримдаа хамгийн зөв хүсэл зорилготой хөрвөгчид агуу хувийн сахилга батыг хөгжүүлэхээр өсч хөгжих явцдаа уруу таталтанд ордог. Ийм тохиолдолд, уруу таталтыг даван туулж мөн бүрэн наманчлахын тулд хөрвөгчид номлогч нартай бус харин санваарын удирдагчидтай ажиллах хэрэгтэй.

Баптисм болон гишүүний баталгаагаар хүмүүс эдгээр сорилтуудыг даван туулах чадварыг нь хүчирхэгжүүлдэг Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг. Гэвч баптисм болон гишүүний баталгаа нь эдгээр зан чанаруудтай хамт явдаг сэтгэл санааны болон биеийн хүсэл тэмүүллийг бүрэн эцэс болгохгүй байж болох юм. Хэдийгээр тухайн хүн эхэн үеийн амжилтуудыг гаргаж байгаа ч, сэтгэл санааны цаашдын эдгэрэлд бүрэн гүйцэд наманчлал мөн өөрчлөлт шаардлагатай байж болно.

Үйл Ажиллагаа: Хувиараа буюу Хамтрагчтайгаа Суралцах

- Аливаа донг даван туулахыг хичээж байгаа сонирхогч, саяхны хөрвөгч, эсвэл идэвх султай гишүүний талаар бод.
- Бүлэг 3 дахь “Есүс Христийн Сайн мэдээ” хичээлээс “Есүс Христэд Итгэх Итгэл” мөн “Наманчлал” гэсэн бүлгүүдийг нэгтгэн дүгнэ.
- Донгоосоо салахад нь тухайн хүнд туслахын тулд та энэ хичээлээс болон энэ бүлгээс юу зааж болох вэ?
- Энэ хүнд туслахын тулд хичээлийн төлөвлөгөө гарга.

Наманчлал болон Донгоосоо Ангижрах Явдлыг Ойлгоход нь Сонирхогч болон Саяхны Хөрвөгчид Туслах нь

Донтох тухай асуултууд болон асуудлуудад хариулахыг танаас хүсч болно. Түүнчлэн та эдгээр асуудлуудтай холбоотой хэцүү асуултуудын хариуг олоход нь хүмүүст туслахыг хүсч болох юм. Доорх санаанууд тус болж болно:

- Сайн мэдээний эдгэрэх мөн чанар, ялангуяа Цагаатгалын талаарх гэрчлэлээ хуваалц (Алма 7:11–13-ыг үз).
- Сүнслэг эдгэрэлийн гайхамшгийг ганцхан Бурхан л гүйцэлдүүлж чадна гэдгийг гэрчил (Дуулал 147:3-ыг үз).
- Эдгэрлийн бэлэг бие болон сүнс аль алинд нь нөлөөлдөг болохыг тайлбарла.



© 2000 Simon Dawey, Хувилан олшруулж болохгүй.

Сэтгэл санааны эдгэрэлд нь хүмүүст туслах энгийн үйл явдлуудад:

- Асуудлыг ялган таньж мөн хүлээн зөвшөөрөх. Үүнд өөрийгөө анхааралтай мөн үнэнчээр шалгах нь шаардагддаг.
- Уг ааш авирыг хүлээн зөвшөөрөх нь хор хөнөөлтэй. Энэ нь бусад нөлөөлж мөн өөрчлөлтийг шаарддаг.
- Даруу болж мөн уй гашууг мэдрэх.
- Хор хөнөөл учруулсан бусад хүмүүсээс уучлал эрж мөн өөрийгөө уучлах.
- Донтуулах үйлдлүүдийг зогсоож, эрүүл зүйлсийг эхлэх.
- Итгэлтэй хэвээр байж, баптисмын гэрээнүүдээ сахьж, үйлчлэл үзүүлэн, Ариун Сүнснээс тусламж эрэн залбирч, мөн Бурханы зарлигуудыг сахих хүсэлтэйгээ үзүүлэх.
- Хэдийгээр хүүхдүүд нь алдаа гаргаж, мөн хуучин хүсэл тачаалдаа бууж өгсөн ч Их Эзэн Өөрийнхөө хүүхдүүдийг үргэлж хайрладаг гэдгийг ойлгох. Наманчлал болон эдгэрэх зам нь үргэлж боломжтой байдаг.

Донтох Ааш Авирыг Даван Туулах Төлөвлөгөө

Донтох явдлыг даван туулахын тулд юу хийж болохыг сонирхогчид, мөн шинэ, идэвх султай гишүүд асууж болно. Зааварчилгаа болон дэмжлэг үзүүлэх таны чадварт тэд найддаг. Доорх зөвлөгөөнүүд тусалж болох юм:

- Тэд ааш авирыг бий болгодог цаг хугацаа, газрууд мөн хүмүүсийн жагсаалтыг хийг. Тэгээд уг жагсаалтаа эхнэр эсвэл нөхөр, бишоп, хэсгийн номлогч, эсвэл найдаж буй өөр найз нартайгаа ярилц. Жагсаалт дээрх зүйлсийг өөрчилж мөн зайлсхийхийн тулд тэд юу хийх хэрэгтэй талаар ярилц.
- Эдүгээ тэд юу алдахад уг ааш авир нөлөөлсөн болохыг мөн хэрэв засахгүй бол, ирээдүйд тэд юу алдахад нөлөөлөхийг тэднээр бичүүл.
- Зохисгүй ааш авираас зайлсхийж мөн татгалзахын тулд тэдний хийж чадах өөр өөр зүйлсийг тэднээр бичүүл. Үүнд хэн нэгний эхнэр эсвэл нөхөртэй ярих,

дэмжлэгийн төлөө бишоп эсвэл найз нөхөд рүү утасдах, дасгал хийх, мөн уруу таталтаас зайлсхийхэд нь тэдэнд туслах бусад үйл ажиллагаанууд багтана.

- Тогтмол залбирч, мөн судраас судалж, сэтгэл сэргээх хөгжим сонсож, мөн сайхан номнууд уншихад нь тэднийг урамшуул.
- Санваарын адислал эрэлхийлэхэд нь тэднийг урамшуул.
- Асуудлуудаа ялан дийлж мөн Их Эзэнд ойрхон болоход нь тэдэнд туслах Сүмийн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцоход нь тэднийг урамшуул.
- Зүй зохистой дэмжлэг үзүүлдэг бүлэгт элсэж, эсвэл мэргэжлийн тусламж авахад нь тэднийг урамшуул. Зарим газруудад Хожмын Үеийн Гэгээнтний Гэр бүлийн Үйлчлэлүүд боломжтой байдаг.
- Хэзээ ч бууж өгөхгүй байхад нь тэднийг урамшуул! Хэдийгээр үүнд цаг хугацаа хэрэгтэй ч Их Эзэн тэдэнд туслах болно.



Шинэ гишүүдийг идэвхтэй хэвээр байлгахад идэвхтэй Хожмын Үеийн Гэгээнтнүүд тэдний найз байснаар хамгийн сайн тусалж чадна. Сонирхогчид, мөн шинэ гишүүдийг гишүүд халуун дулаан, эерэг байдалтайгаар хүлээн авах ёстой. Инээмсэглэн мэндлэхэд, мөн амьдрал хэр байгаа талаар нь тэднээс асуухад, мөн цуглааны үеэр тэдний дэргэд суухад, мөн тэднийг гэр бүлийн оройн хоол, эсвэл гэр бүлийн үдэшд урихад сонирхогчид эсвэл шинэ хөрвөгчид халуун дотноор хүлээн авах болно.

Зарим хүмүүс донтсон зүйлээ дахин хийж эхэлж болох учраас хэрэв сонирхогч эсвэл шинэ гишүүд тийм асуудалд зовж байгааг мэдсэнээр санваарын удирдагчид мөн гишүүд цочирдож эсвэл сэтгэлээр унах ёсгүй. Хэрэв тухайн хүн хуучин хүсэл тачаалдаа бууж өгсөн бол тэд уг хүнд шүүмжлэлтэй хандах бус харин итгэж байгаа гэдгээ үзүүлэх ёстой. Тэдний энэ үйлдэл бол түр зуурын мөн ойлгож болохуйц зүйл гэсэн байдлаар хандах ёстой. Аливаа зүйлд донтсон сонирхогч эсвэл хөрвөгчийг буруушаах нь хэзээ ч тус болж байгаагүй бөгөөд яваандаа сэтгэлээр унах байдал, бүтэлгүйтэл, мөн идэвхгүй байдал уруу хөтөлдөг. Гэнэт Сүмд ирэхээ больсон шинэ хөрвөгч хуучин донтож байсан зүйлдээ буцан орж, мөн зохисгүй сэтгэгдэлтэй болж мөн сэтгэлээр унасан байдаг. Тэр даруй зочлон очиж урам зориг өгч мөн дэмжих нь тухайн хүн амжилт гаргахад тусалж чадна. Хөрвөгдөгсдийг хүлээн зөвшөөрч байгаагаа гишүүд үг болон үйл хөдлөлөөрөө үзүүлэх ёстой (3 Нифай 18:32-ыг үз).

Сүмд идэвхтэй хэвээр үлдэж, мөн итгэлтэй байхыг хичээх нь хүн аливаа донтох асуудлыг ялан гарахад хамгийн чухал зүйл юм.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Гараа дуугаргах, нүдний шилээ засах, их идэх, эсвэл хэт их унтах зэрэг бодолгүйгээр байнга хийдэг зарим ааш авирынхаа талаар бод. Одоо үүнийгээ хийлгүйгээр нэг өдөр явахыг хичээ. Амжилттай болбол, бүтэн долоо хоног үүнийг хийхгүйгээр явахыг хичээ. Тохиолдсон зүйлээ хамтрагчтайгаа ярилц. Тэгээд тамхи, эсвэл архиийг хэтрүүлэн хэрэглэх зэрэг зүйлд донтсоноо ялан давах нь сонирхогчийн хувьд ямар их хэцүү болохыг төсөөлөхийг хичээ.

Ямар Нэг Зүйл Үлдээх нь

Заах айлчлал бүрийн төгсгөлд дараачийн уулзалтад бэлтгэхийн тулд уншиж мөн тунгаан бодох ямар нэг зүйлээр сонирхогчийг ханга. Мормоны Номноос бүлгүүдийг уншуулахаар тэдэнд та өгч болох юм. Та тэдэнд юу заасан мөн дараагийн уулзалтаар юу заах гэж буйг тэмдэглэсэн товхимолыг өгөх, эсвэл энэ нь өөр ном буюу дүрс бичлэгийн танилцуулга байж болно. Хэрэв тэд Интернеттэй бол www.mormon.org-д орохыг тэднээс хүс. Тэдэнд үргэлж бодох, тунгаан бодох, мөн залбирах ямар нэг зүйл өгөх ёстой. Энэ нь дараагийн уулзалт дээр яриа эхлүүлэх сэдэв болж өгнө.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Товхимол, дүрс бичлэгийн танилцуулга зэрэг сонирхогчид үлдээж болох боломжтой өөрсөддөө байгаа зүйлсийг нэгтгэн дүгнэ. Та сонирхогчидтой хуваалцаж болох өөр ямар зүйлийг олж авч болох вэ? Захиалж болох зүйлсийнхээ жагсаалтыг төлөвлөх хуудсан дээрээ бич.

Энэ долоо хоногт заахаар цаг тохирсон сонирхогч бүрийнхээ талаар бод. Мормоны Номны ямар бүлгүүд тэдэнд хамгийн их туслах вэ? Өөр ямар зүйлүүд тэдэнд ашигтай вэ? Төлөвлөх хуудсан дээрх Тэмдэглэл/Хийх зүйлийн жагсаалтад сонирхогч бүртээ юу авахаар төлөвлөж байгаагаа мөн дараагийн уулзалт дээрээ юуг нягтлах тухайгаа бич.

Христийн Шашинтан Бус Хүмүүст Сэргээгдсэн Сайн Мэдээг Заах нь

Таны заах зарим хүмүүс Тэнгэрлэг Эцэг мөн Есүс Христэд итгэдэггүй эсвэл Христэд итгэх уламжлалгүй байж болно. Хэдий тийм ч, эдгээр хүмүүсийн ихэнх нь өөрсдөө эрхэмлэн нандигнадаг итгэл, дадал зуршил, мөн газартай байдаг. Бурханы үйлчлэгчийн хувьд тэдний итгэл мөн уламжлалуудыг зөв зүйтэйгээр хүндлэх нь чухал юм. Тэдэнд чухалд тооцогдох зүйлсийг хүндлэхгүй ямар нэг зүйл бүү хий.

Та энэ хүмүүст заах аргаа хэрхэн өөрчлөх ёстойгоо бодож байж болно. Энэ нь Бурханы бүх хүүхдүүд гарал үүслээсээ үл хамааран хөрвүүлэгдэхийн тулд Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, баптисм болон гишүүний баталгааны ёслолуудыг хүлээн авч мөн зарлигуудыг сахиснаар эцсээ хүртэл тэвчиж мөн үйлчлэх ёстой. Хүмүүс Есүс Христэд итгэх итгэлийг бий болгоход туслах зарчмууд нь бүх ёс заншилд ижилхэн юм.

Бурхан бол Тэнгэрлэг Эцэг гэсэн зөв ойлголтоо нэмэгдүүлэх хийгээд зөвхөн Бурханы мөн чанарыг зүгээр хэлэхийн оронд өөрсдөө сүнслэг тохиолдолтой байхад нь тусалснаар Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд нь хүмүүст тусалж чадна. Жишээ нь, доорх ойлголтыг нэмэгдүүлэхэд нь та хүмүүст тусалж болно:

- Бурхан, Эцэг мөн Түүний Хүү Есүс Христ Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирсэн хэмээх сүнслэг итгэлийг олж авахад нь.
- Есүс Христийг яагаад дагах болсон зэрэг сайн мэдээний талаар чин сэтгэлээсээ зааж мөн гэрчлэхийг тань сонсоход нь.
- Таныг болон бусад хүмүүсийг Тэнгэрлэг Эцэгт хандан энгийнээр мөн сэтгэл хөдөлгөм залбирахыг байн байн сонсоход нь.
- Хүчирхэг гэрчлэл хуваалцахыг тань сонсоход нь.
- Тантай хамт мөн өөрсдөө хувиараа залбирахад нь.
- Тэдэнтэй хамт уншиж мөн ярилцсанаар судруудын талаар ямар сэтгэгдэлтэй байгааг тань мэдэхэд нь.
- Өдөр бүр судруудаас Бурханы үгийг уншихад нь (ялангуяа Мормоны Ном).
- Сүмд явах, ингэснээр бид Их Эзэнийг хэрхэн шүтэн биширдгийг харахад нь.
- Тэнгэрлэг Эцэг мөн Есүс Христэд хэрхэн итгэдэг болсноо тайлбарлаж чадах Сүмийн гишүүдтэй уулзахад нь.
- Зарлигуудыг сахихад нь.

Эдгээр үйл ажиллагаанууд нь таны заах бүх хүмүүст ашигтай боловч эдгээр тохиолдлуудтай өмнө учирдаггүй учраас Христийн шашинтан бус хүмүүст тэр тусмаа чухал юм.

Христийн шашинтан бус олон хөрвөгч номлогч нарын хэлж байгаа зүйлийн ихэнхийг ойлгодоггүй боловч Сүнснийг мэдэрч мөн номлогч нарын хүссэн зүйлийг хийхийг хүсдэг хэмээн хэлсэн байдаг. Сайн мэдээний сургаалуудыг ойлгоход нь сонирхогчдод туслахын тулд та чадах бүхнээ хийх ёстой. Хүмүүс харьцуулж мөн дотроо бодож буй зүйлээ илэрхийлж сурахад нилээд хугацаа шаардагдах учраас тэвчээртэй байж мөн дэмжлэг үзүүл. Тэднийг ойлгоход нь туслахын тулд зааж байгаа зүйлийнхээ явц мөн утгыг өөрчлөх хэрэгтэй болно. Христийн шашинтан бус хүмүүст заахаар бэлтгэхэд тань доорх зөвлөгөөнүүд тус болж болох юм:

- Хичээл бүрийн энгийн утга санаа болон тоймыг бэлтгэ.
- Тэд юу ойлгосон мөн тэдэнд юу тохиолдсон талаараа өөрт тань хэлэхийг тэднээс хүс.
- Онц чухал үгс болон зарчмуудыг тайлбарлах цаг гарга. Таны заахдаа ашиглах олон үгтэй зааж байгаа хүмүүс тань танил биш байж болно.
- Сургаалыг илүү тодорхой заахын тулд өмнө нь заасан хичээлээ дахин тайлбарла. Зааж байх ямар ч үед энэ хэрэгтэй байж болох юм.

Судрын Жишээнүүд

Бурханд итгэдэггүй эсвэл Түүний жинхэнэ дүр төрхийг буруу ойлгосон хүмүүст зааж байсан номлогч нарын жишээгээр судрууд дүүрэн байдаг. Доорх судруудыг судал мөн тэгээд Бурхан оршдог гэсэн гэрчлэлийг олж авахад нь хүмүүст уг номлогч нар хэрхэн тусалсныг хамтрагчдаа хэлж, эсвэл судлах тэмдэглэлдээ бич.

- Алма, Амюлек хоёр (Алма 9–12; 15)
- Аммон, Аарон хоёр (Алма 17–22)
- Алма (Алма 30)
- Алма болон бусад хүмүүс (Алма 31–35)
- Паул (Үйлс 17:16–34)

Тэмдэглэл

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

Боломж гарсан үед номлогч нартай уулзахаасаа өмнө Христэд итгэдэг уламжлалын нэг хэсэг байгаагүй хөрвөгчийг олж тогтоо. Түүнтэй уулзах болзоо тогтоож, түүний хөрвөгдсөн тохиолдлын талаар асуу. Жишээ нь, уг хүнийг Бурханд итгэхэд, анх удаа залбирахад, анх удаа залбирлынхаа хариултыг мэдрэхэд юу нөлөөлсөн, хөрвүүлэг дэх судруудын үүрэг, мөн Ням гарагийн ёслолуудад оролцоход ямар байсныг асууж болох юм. Сурсан зүйлээ судлах тэмдэглэлдээ бич.

Үүнийг Сана

- Хүмүүс сэргээгдсэн сайн мэдээг заалгаж мөн түүгээр амьдрахад тэдний хэрэгцээ биелэх болно.
- Нэгдмэл байж, мөн нэгэн дуу хоолойгоор заахын тулд хамтрагчтайгаа өдөр бүр төлөвлөж мөн суралц.
- Гэрчлэлээ ойр ойрхон хуваалц.
- Судрууд, ялангуяа Мормоны Ном бол заах хамгийн чухал эх сурвалж тань юм.
- Энэ бүлэгт дүрслэгдсэн арга барилуудыг хэдийд ашиглахаа мэдэхийн тулд ялган таних бэлгийн төлөө залбир.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Тэмдэглэл

Хувиараа Суралцах

- Доорх нөхцөл байдалд та орж байсан гэж таамаглаж байна. Эдгээр хүмүүст өсч хөгжихөд нь туслахын тулд энэ бүлэг дэх зарчмууд болон арга барилуудыг та хэрхэн ашиглаж болох вэ? Доорх нөхцөл бүрт тэдгээрийг хэрхэн ашиглаж болохыг төлөвлө.
 - Цэцэрлэг дотуур алхаж явахдаа сандал дээр нэгэн эмэгтэй хүүтэйгээ сууж байгааг харжээ. Уг эмэгтэй уйлж байв.
 - Баптисмд бэлтгэж байгаа сонирхогчийн гэрт иржээ, мөн тэд тантай дахин уулзахыг хүсэхгүй байна гэдгээ хэлэв.
 - Хоёр жилийн турш хэд хэдэн номлогч нар зааж байгаа сонирхогчтой та долоо дахь удаагаа уулзаж байна. Тэдэнд өсч хөгжиж буй хэд хэдэн тэмдэг гарч байв.
 - Та нэгэн гишүүн гэр бүлд сайн мэдээний захиасыг зааж эхлэх гэж байна, тэгтэл тэд “Бид өөрсдийнхөө таньдаг хүн бүрээс номлогч нартай уулзахыг хүсч байгаа эсэхийг асуусан, тэд бүгдээрээ үгүй гэж хэлсэн” тухай ярьжээ.
- Номлогчийн хичээлүүдийн нэгийг сонго. Гол зарчмаас нэг, эсвэл хоёр судрын хэсгийг олж тогтоо. Энэ бүлгийн “Судруудыг Ашиглах нь” хэсэгт онцолсон тэдгээр захиасуудаас заах дасгал хий.
- Хэдэн долоо хоногийн турш бүлэг болгон Сайн Мэдээнд (Матай, Марк, Лук, Иохан) Аврагчийн заасан зүйлс мөн 3 Нифайг нэгтгэн дүгнэ. Судлах тэмдэглэлдээ Түүний асуусан асуултуудыг жагсаан бич. Тэдгээр асуултуудыг өөрийнхөө байнга асуудаг асуултуудтай харьцуул.
- Алма 18 дахь Аммон, Хаан Лэмонай хоёрын тухай түүхийг мөн Алма 22:4–18 дахь Аароны түүхийг унш. Унших явцдаа Аммон, Аарон хоёр хэрхэн доорх зүйлсийг хийснийг олж тогтоон мөн дүрсэл:
 - Сүнсийг дагаж мөн хайраар заасан.
 - Зааж эхэлсэн.
 - Хэрэгцээнүүдэд тохируулан тэдэнд заахыг сонгосон.
 - Гэрчлэлээ хэлсэн.
 - Судрууд ашигласан.
 - Асуулт асууж, сонсож, мөн асуудлуудыг шийдсэн.
 - Заалгасан хүмүүсийг даалгавруудыг биелүүлэхэд нь урамшуулсан.
- Ерөнхийлөгч Харолд Б.Лигийн ойлголтын төлөө заах тухай хэлсэн дараах үгийг тунгаан бод. Сайн мэдээний сургаалуудыг та хэр ойлгомжтой заадгаа дүгнэ. Юу сурснаа судлах тэмдэглэлдээ бич.

“Та нар судрын агуулгыг хэвээр хадгалж мөн үүнийг ойлгомжтой байдлаар болгож болно” (*The Teachings of Harold B. Lee*, sel. Clyde J. Williams [1996], 444).

“Эдүгээ багш нар болох та нар шинэ сургаал заахын тулд илгээгдээгүй юм. Та нар хуучин сургаалуудыг тэд зөвхөн ойлгох төдий байхаар тийм тодорхой бус заах ёсгүй, харин та нар бүх хүнд ойлгогдохоор Сүмийн сургаалуудыг заах ёстой” (*The Teachings of Harold B. Lee*, 458).

Хамтрагчтайгаа Суралцах

- Саяхан заасан хичээлээс хичээлийн төлөвлөгөөгөө нэгтгэн дүгнэ. Төлөвлөгөөндөө онцолсон гол зарчмууд бүрт нэг асуулт бич. Мөн тэдгээр нь энэ бүлэгт заагдсан зүйлтэй зохицож буй эсэхийг мэдэхийн тулд асуултуудаа

Тэмдэглэл

нэгтгэн дүгнэ. Дараа нь, асуулт бүрийг сонирхогч хариулж буй лугаа адил хариул. Шаардлагатай үед асуултуудаа зас. Асуултуудаа хамтрагчтайгаа хуваалц. Хамтдаа асуултуудаа харьцуул.

- Зааж буй сонирхогчийнхоо хэрэгцээг олж тогтоо. Таны асуултуудад тэр хэрхэн хариулж болохыг ярилц. Түүнчлэн эдгээр асуултууд Сүнснийг хэрхэн урьж мөн сайн мэдээг сурахад нь сонирхогчдод туслахыг ярилц.
- Шинэ сонирхогч бүрийнхээ талаар бод. Өсч хөгжиж буй сонирхогч болоход нь тэдэнд туслахын тулд та юу хийж болохыг ярилц. Санаануудаа судлах тэмдэглэлдээ бичиж мөн өдөр тутмын төлөвлөгөөн дээрээ төлөвлөгөө гарга.

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Гишүүд эсвэл саяхны сонирхогчдыг уулзалтандаа урьж оролцуул. Чухал захиасуудыг хуваалцах номлогчийн арга барилаа сайжруулахыг хүсч байгаагаа уг бүлэг хүмүүст тайлбарла. Хичээл болон арга барилыг сонго. Таны олж тогтоосон арга барилд анхаарлаа төвлөрүүлэн, сонгосон хичээлийг номлогч нар гишүүд эсвэл сонирхогчдод 20 минут зааг. 20 минутын дараа тэд хичээлээ сольж болно. Номлогч нар заасны дараа бүлгийг хамтад нь цуглуулж, гишүүд мөн сонирхогчид хамгийн үр дүнтэй эсвэл сайжруулж болох нэг арга замыг номлогч нарт хэлэг.
- Номлогч нар хүмүүст зааж эсвэл холбоо тогтоож байгаа жишээг харуулсан дүрс бичлэгийг үзүүл. Арга барилыг сонгоод дүрс бичлэг дээрх номлогч нар уг арга барилын зарчмуудыг хэрхэн ашиглаж байгааг бүлэг болгон ярилц.
- Арга барил эсвэл арга барилын чухал үзэл баримтлалыг сонго, мөн уг арга барилыг үр дүнтэй болгох сургаал эсвэл судрын хэсгүүдийг олж тогтоо. Арга барилын сургаалын үндсийг номлогч нарт заа.

Номлолын Ерөнхийлөгч

- Заахад нь үе үе номлогч нартай хамт яв. Заахад хэрхэн оролцож болохоо төлөвлө.
- Заахаар явахад нь номлогч нартай хамт явж мөн алдаа оноог нь дүгнэхэд санваарын удирдагчдыг урамшуул.
- Бүсийн чуулганууд болон ярилцлагуудын үеэр номлогч нарт заахдаа судрууд, асуултууд, мөн сонсохыг үр дүнтэй ашиглахыг жишээн дээр үзүүл.



Амлалтуудыг Хийж, Биелүүлэхэд нь Би Хүмүүст Хэрхэн Туслах Вэ?

Үүнийг Анхаар

- Би яагаад хүмүүсийг амлалт өгөхийг урихад анхаарах хэрэгтэй?
- Амлалтууд хөрвүүлэлтэд хэрхэн хамаарах вэ?
- Би хэрхэн гэрчлэлээ даруухнаар хуваалцах вэ?
- Би ямар адислалуудыг амлаж болох вэ?
- Хүмүүсийг амлалтууд өгөх үед тэдгээрийг шалгах нь миний хувьд ямар ач холбогдолтой вэ?

Амлалт Өгөхийг Урих

Та номлогчийн хувьд бодгалиудын авралыг хүсдэг (Мозая 28:3-ыг үз). Та хүмүүсийг Христэд ирж, зөвхөн наманчлалын нөхцлөөр аврагдана гэдгийг мэднэ (С ба Г 18:10–16-г үз). Хүслүүдээ биелүүлэх нэг арга бол наманчлалыг тунхаглах явдал (Алма 5:49; С ба Г 15:6; 16:6-г үз) бөгөөд хүмүүсийн итгэлийг наманчлалд хүртэл хөгжүүлж, ус болон Сүнсээр баптисм хүртэж, мөн итгэлтэйгээр эцсээ хүртэл тэвчихийг зоригтойгоор урих явдал юм (3 Нифай 27:16–20; Мормон 7:10-ыг үз).

Амлалт бол наманчлалын амин чухал хэсэг юм. Энэ нь өөрийгөө үйл хэргийн явцад үүрэг хариуцлагатай болгож, дараа нь тэр шийдвэрээ хичээнгүйгээр дагах үйл билээ. Хүмүүс үнэнчээр амлалт авахдаа хийхээр амласан зүйлээ бүрэн хийнэ гэж бодон үнэн хүсэлтэй болдог. Тэд өөрчлөгдөхийн тулд өөрчлөгдөшгүй бөгөөд бодолтой шийдвэр гаргадаг. Тэд Христэд хайртай болдог ба өөрсдийгөө Түүний

Тэмдэглэл

сайн мэдээнд зориулдаг. Тэдний амлалтуудаа биелүүлэх байдал нь тэд хэрхэн “нүглүүдээсээ ангижрахын тулд Христийн Сүнсийг хүлээн авснаа өөрсдийн ажлуудаар үнэнхүү тунхаглах” (С ба Г 20:37) явдал юм. Та заасан зүйлийнхээ нэг хэсэг болгон амлалтуудыг асуухдаа сонирхогчийг наманчлахад урьж байгаа билээ.

Амлалтууд өгч мөн сахихад нь хүмүүст туслах хамгийн сайн арга замуудын нэг бол амлалт өгөхийг урих урилга юм. Урих мөн нэхэн шалгах амлалтын урилга нь чухал юм, яагаад гэвэл:

- Сурч мэдсэн зарчмуудаараа амьдрахдаа хүмүүс хөрвүүлэгдэн (Иохан 7:17-г үз) мөн хийж байгаа зүйл нь Тэнгэрлэг Эцэгийнх нь таалалд нийцнэ гэдгийг батлах Сүнсийг мэдэрдэг.
- Наманчлал болон өөрчлөлт нь хүмүүст сорилтуудыг ялж, өөрсдийн ичгүүр болон гэмээ авч хаян мөн Бурханы өршөөлийн амар амгалан, баяр баяслыг мэдрэхэд нь хүмүүст тусална.
- Амлалтуудыг сахих нь нандин гэрээнүүдийг хийж мөн сахихад хүмүүсийг бэлтгэнэ.



© 2001 Simon Dewey. Хувилан ошшруулж болохгүй.

Наманчилж, амлалтуудаа сахихад нь тэдэнд туслахын тулд та нэхэн шалгаснаар хүмүүсийг хайрлах хайраа болон Бурханы амлалтуудад итгэдэг итгэлээ харуулж чадна.

Баптисмд шаардлагатай амлалтуудыг эхний дөрвөн хичээлд жагсаасан болно. Баптисм болон гишүүний баталгааны дараах сүнслэг өсөлт хөгжилтэй хамаатай амлалтуудыг хичээл 5-д жагсаасан болно. Христэд итгэх итгэлийг нь хүчирхэгжүүлэх зүйлс хийхийг хүмүүсээс урих ёстойг байнга анхаар. Доорх зарчмуудыг сана:

- Гишүүд, бусдын зааж өгсөн хүмүүс, эсвэл хувиараа холбоо тогтоох зэрэг бүх олох боломжууд ихэнхдээ Сэргээлтийн захиасын талаар илүү ихийг сурах гэсэн үйлдлийн урилга уруу хөтлөх ёстой.
- Цөөн тохиолдолд, хэрэв байдаг бол та Христэд итгэх итгэлийг нь хүчирхэгжүүлэх ямар нэг урилга өгөлгүйгээр хүмүүстэй ярилцаж эсвэл заах ёстой.
- Заахдаа нэг буюу илүү олон амлалтууд дээр анхаарлаа төвлөрүүл. Хэрэв та хүмүүст эдгээр амлалтуудыг хийхийг урихгүй аваас, та тэднийг наманчилж мөн Христэд ирэхийг тэднээс асуугаагүй гэсэн үг юм.
- Хамтрагчтайгаа суралцаж, хичээл заахад бэлтгэх явцдаа сонирхогч бүрийн хэрэгцээ болон байдлыг авч үзэн, хичээлийн төлөвлөгөөндөө нэг буюу илүү олон амлалтуудыг багтаа.
- Хичээлийн явцад та төлөвлөснөөсөө өөр бусад амлалтууд хийхийг урихаар бурханлигаар нөлөөлөгдөж болно. Хүмүүсийг наманчил хэмээн байнга урь.
- Амлалтууд хийхийг хүмүүсээс урихдаа зоригтой мөн итгэлтэй бай (Алма 38:12-ыг үз). Зоригтой байдал нь Их Эзэний зарлигуудад дуулгавартай байгаа таны итгэл адислалуудыг авчирдаг гэдгийг харуулдаг.
- Хүмүүсээс ийнхүү үйлдэхийг урихгүй аваас тэд өөрчлөгдөж чадахгүй.

Судар Судлах

Амлалт авахуулах нь яагаад чухал байдаг вэ?

Алма 5:62

Моронай 7:13

Амлалтууд нь яагаад чухал вэ?

2 Нифай 31

Алма 32:27

С ба Г 20:37

Мозая 2:41

С ба Г 14:7

Иохан 7:17

Алма 7:14–16

Шууд Чиглэсэн Асуулт Асуух нь

Амлалтуудын урилга нь ихэнхдээ *тийм*, эсвэл *үгүй* гэсэн хариулт шаарддаг тэгэх үү гэсэн асуултын хэлбэрийг ихэнхдээ агуулдаг. Урилга нь өвөрмөц, шууд чиглэсэн мөн тодорхой байх ёстой. Тэдгээр нь ямар нэг үйлдэл хийхээр шийдэхэд хүмүүсийг урьсан эсвэл чиглүүлсэн байдаг. Тэдгээр нь хүмүүсээс амлалтууд авч, тэдэнд таны заасан зарчмуудад итгэлээ идэвхтэйгээр хөгжүүлэхийг тэднээс шаарддаг.

Доорх санаанууд нь амлалт мөн гэрчлэл урган гарах сайн урилгуудын жишээнүүд юм:

- Маргааш 19:00 цагт биднийг ирэхээс өмнө та [3 Нифай 11, Моронай 10:3–5, энэ товхимол]–ыг унших уу? Үүнийг хийх нь . . . гэдгийг би мэднэ. Мормоны Ном бол . . . гэдгийг би мэднэ.
- Иосеф Смит бошиглогч байсан эсэхийг та Бурханаас асуун залбирах уу? Хэрэв та залбирах аваас Бурхан . . . гэдгийг би мэднэ. Иосеф Смит бошиглогч байсан гэдгийг би мэднэ . . .
- Энэ Ням гарагийн 9:00 цагт та бидэнтэй хамт сүмд очих уу? Хэрэв та очвол, . . . Христийн Сүм сэргээгдсэн гэдгийг би мэднэ . . .
- Бидний тайлбарласны дагуу та одооноос эхлэн ариун явдлын хуулиар амьдрах уу? Энэ хуулиар амьдарснаар . . . Их Эзэний үйлчлэгчийн хувьд ариун амьдрах нь . . . гэдгийг би гэрчилж байна.
- Баасан гарагаас өмнө [нэр]–ийг та бидэнтэй уулзаж сайн мэдээний талаар сурч эхлүүлэхээр урих уу? Сүнс танд тусална . . . сайн мэдээг хуваалцах нь амьдралыг тань адисална . . .
- Бид танай гэрт ирж, Бурхан эрт үед дуудсаныхаа адил өнөө үед бошиглогчийг хэрхэн дуудсан талаар илүү зүйлийг танд хэлж өгч болох уу? Та үүнийг ойлгосноор илүү зорилго, чиглүүлэл мөн амар амгалан амьдралд тань ирэх болно. . . Бурхан . . . дахин дуудсан гэдгийг би гэрчилж байна.

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Хичээл дахь амлалт бүрд энгийн, шууд чиглэсэн, мөн тодорхой урилгуудыг судлах тэмдэглэлдээ бич. Хэрэв та энэ даалгаврыг өмнө нь хийсэн бол дахин хийж, шинэ урилгуудаа өмнө нь бичсэн урилгуудтайгаа харьцуул. Амлалт авахуулах чадвар тань сайжирсан эсэхийг өөрөөсөө асуу.

Тэмдэглэл

Хамтрагчтайгаа хамт бичсэн урилгуудаа нэгтгэн дүгнэ. Урилга бүрийн хувьд, дараах асуултуудыг ярилц.

- Урилга өгөхдөө Их Эзэний амласан адислалуудыг би тайлбарласан уу? Хэрэв үгүй бол яагаад?
- Энэ урилгыг өгөхөөсөө би зайлсхийсэн үү? Тийм бол яагаад?
- Энэ урилгыг өгч байхад надад эвгүй байсан уу? Би яаж сайжруулах вэ?
- Энэ урилга миний хувьд хэр чухал вэ?
- Өгсөн урилгуудаа шалгахад би хэр ойрхон санадаг вэ? Би хэрхэн сайжруулах вэ?

Өөрийнхөө мэдэх сонирхогч, эсвэл идэвх султай гишүүдийн талаар бод, мөн хэдий та эдгээр хүмүүст танилцуулж байгаа ч эдгээр урилгуудыг өгөх дасгал хий.

Шаардлагатай бол, хичээлийн төлөвлөгөөн дэх урилгуудыг өөрчил. Энэ өдөр болон долоо хоног урилгуудыг өгөхөд тань туслах тодорхой зорилгуудыг тавь.

Хүмүүст Адислалуудыг Амла

Бодол санаа болон үйл хөдлөлүүдээ өөрчлөх шалтгаан хүмүүст хэрэгтэй байдаг. Амлагдсан адислалууд нь ихэнхдээ Бурханыг дуулгавартай дагах хүчтэй сонирхлыг төрүүлдэг. Их Эзэн зарлигийг өгөхдөө уг зарлигыг сахиснаар ирэх адислалуудыг амалдаг (С ба Г 130:20–21). Тодорхой зарлигийг дуулгавартай дагахад нь хүмүүсийг бэлтгэхдээ тэдэнд дараахыг заа:

- Зарлигуудаар амьдрах нь Бурхан болон Түүний Хүүг хайрлах хайрыг харуулдаг.
- Зарлигуудыг нь дагаснаар тэд Бурханд итгэх итгэлээ үзүүлдэг.
- Ингэснээр, тэд Түүний амласан адислалуудыг хүлээн авах болно.

Зарлигуудын талаар гэрчлэхдээ уг зарлигаар амьдарснаар хүлээн авсан адислалуудын тухай ярь. Зааж буй хүмүүс тань мөн ижил адислалуудыг хүлээн авах болно гэдгийг тэдэнд амла.

Амлалтуудаа биелүүлэхээр хүмүүс хичээх үед нь Тэнгэрлэг Эцэгээс тэдэнд өгсөн адислалуудын тухай ярихыг тэднээс хүс. Хэдийгээр амьдралд нь хүнд хэцүү үеүд ирэх боловч, тэд Түүний хүсэл зоригийг дуулгавартай дагах аваас Түүний адислалууд цаашид ирсээр байх болно гэдгийг тэдэнд анхааруул.

Судар Судлах

Биднийг адислах Өөрийнхөө хүслийн талаар Их Эзэн юу хэлсэн бэ?

Алма 37:17

С ба Г 1:37

С ба Г 76:5–10

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Сургаал ба Гэрээ 82:10 болон 130:20–21-ийг унш. Дараа нь, дараах судруудыг судал. Судлах тэмдэглэлдээ хоёр багана гарга. Нэг талд нь хэсэг бүр дэх зарлигийг бич. Нөгөө талд нь уг зарлигийг сахьснаар ирэх адислалыг бич.

С ба Г 11:21

С ба Г 89:18–21

С ба Г 100:5–8

С ба Г 84:85

С ба Г 95:8–9

Малахи 3:10–12

Номлогчийн хичээлүүдийн нэг дээр жагсаан бичсэн амлалтуудыг нэгтгэн дүгнэ. Амлалт бүрийн хувьд эдгээр асуултуудад хариул:

- Энэ амлалтыг сахин биелүүлдэг хүмүүст Их Эзэн ямар адислалуудыг амласан бэ?
- Энэ зарчмыг дуулгавартай дагах нь итгэл болон гэрчлэлээ нэмэгдүүлэхэд хүмүүст хэрхэн туслах вэ?
- Энэ амлалт нь наманчилж, мөн Сүнсийг илүү мэдрэхэд хүмүүст хэрхэн туслах вэ?

Гэрчлэлээ Ойр Ойрхон Хуваалц

Гэрчлэл бол Ариун Сүнсээр өгөгдсөн сүнслэг гэрч болон баталгаа юм. Гэрчлэлээ хуваалцах гэдэг нь сайн мэдээний үнэний талаарх итгэл, мэдрэмж, баталгаа, итгэл үнэмшлийн энгийн шууд тунхаглалыг өгөх гэсэн үг юм. Гэрчлэлээ ойр ойрхон хуваалцах нь Сүнсийг урьж, мөн бусад хүмүүст Сүнсийг мэдрэхэд туслах хамгийн хүчирхэг арга замуудын нэг юм. Энэ нь судруудаас таны заасан үнэнүүдэд хамгийн сүүлчийн, хувийн гэрчлэлийг нэмдэг. Идэвхтэй номлогч Есүс Христэд итгэх итгэлийг бий болгох зүйлс хийхийг бусдад зааж, гэрчилж мөн урьдаг. Үүнд, үнэн зарчмуудаар амьдарснаар ирэх амлалтуудыг хийхийг багтаадаг. Жишээ нь, номлогч “Та Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалснаар зүрх сэтгэлдээ илүү амар амгаланг олох болно гэдгийг би мэднэ” хэмээн хэлж болно.

Гэрчлэл тань илүү итгүүлэх хүчтэй байхын тулд та чин сэтгэлээсээ байх ёстой. Хүчирхэг гэрчлэл бол хэл хэр сайн эзэмшсэн эсвэл дуу хоолойны тань чангаас бус харин зүрх сэтгэлийн тань итгэл үнэмшлээс хамаардаг. Өөрийнхөө заах сургаалууд болон зарчмуудыг ойлгох ойлголт болон итгэл үнэмшлээ хүчирхэгжүүлэхийг өдөр бүр хичээ. Өөрийнхөө зааж буй зарчмууд эсвэл сургаалын үнэнийг лацдан холбохын тулд ойр ойрхон гэрчлэлээ хуваалц. Аль болох боломжоороо ойрхон зааж, дараа нь гэрчилж мөн заах үедээ гэрчил.

“Есүс Христ бол Бурханы Хүү”, эсвэл “Мормоны Ном үнэн гэдгийг би өөрөө сурч авсан” гэх мэт гэрчлэл тань аль болох энгийн байж болно. Түүнчлэн энэхүү мэдлэгийг хэрхэн олж авсан талаарх товч тохиолдлоо хуваалцаж болох юм. Хичээл бүрд зөвхөн төгсгөлд нь бус, хэд хэдэн удаа гэрчлэлээ хуваалц. Хамтрагчийн тань заасан зүйлс Бурханаас ирсэн хэмээх гэрчлэл хуваалц. Одоо зааж гэж байгаа зарчмыг сонирхогчид дагах аваас тэдний амьдралыг адислах болно гэдгийг гэрчил. Уг зарчмаар амьдарсан нь таны амьдралыг хэрхэн адисалсан болох талаар ярь.

*“Хүний гэрчлэлийн хувьд,
татгалзалгүйгээр хуваалцах
хүн гэрчлэлээ хадгалж
үлддэг байхад хувиа бодон
хадгалах тэрээр алддаг. . . .*

*Зааж мөн гэрчил. Өөр
ямар ч нэгдэл гэж үгүй.”*

–АХПАГЧ ТОМАС С.МОНСОН
PATHWAYS TO PERFECTION [1973], 100–101



Тэмдэглэл

Тэмдэглэл

Таны зааж байгаа зүйлийн талаар хүмүүс заримдаа ухаалагаар эргэлзэж болох боловч чин сэтгэлийн, зүрх сэтгэлээсээ гэрчилсэн гэрчлэлд эргэлзэх нь хүнд юм. Гэрчлэхдээ зааж буй хүмүүс тань Ариун Сүнсний гэрчлэлийн баталгааг мэдрээсэй хэмээн залбир. Гэрчлэх үедээ сонирхогчид таны үнэнийг гэрчлэх Ариун Сүнсийг мэдрэх орчныг бий болгоход нь та сонирхогчдод тусал. Энэ нь таны өгөх амлалтуудыг хүлээн зөвшөөрөхөд тэднийг бэлтгэх болно.

Сэргээгдсэн сайн мэдээний талаар анхлан сурч байсан эхний жилдээ Бригам Янг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртээгүй юм. Гэвч тэрээр хөрвөлтийнхөө тухай хэлэхдээ: “Хэрэв дэлхийн бүх авьяас, ур чадвар, мэдлэг болон шинэчлэлт Мормоны Номтой хамт над уруу илгээгдэж, мөн дэлхий дээрх уран үгсийн хамгийн дээдээр үүний үнэнийг тунхаглаж, үүнийг мэдлэг болон дэлхийн мэргэн ухаанаар батлахыг оролдсон бол тэдгээр нь миний хувьд замхран одох утаа адил байх байсан биз ээ. Гэвч уран илтгэх ур чадваргүй хүн, ‘Ариун Сүнсний хүчээр би Мормоны Ном үнэн, Иосеф Смит бол Их Эзэний Бошиглогч гэдгийг би мэдэж авсан’ хэмээн хэлэхийг сонсоход уг хүнээс гарах Ариун Сүнс ойлголтыг минь гэрэлтүүлж, гэрэл, алдар суу, мөн мөнх бус байдал миний өмнө байлаа. Би тэдгээрээр хүрээлүүлж, тэдгээрээр дүүргэгдэж, тэр хүний гэрчилсэн зүйл үнэн болохыг би өөрийн биеэр мэдсэн юм” гэжээ (in *Journal of Discourses*, 1:90)

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Доорх хэсгүүд нь гэрчлэл хуваалцсан жишээнүүд юм. Асуулт болон судар бүрийг унш. Судлах тэмдэглэлдээ хариултыг бич.

- Эдгээр шүлгүүдэд төлөөлөгчид болон бошиглогчид юуг гэрчилж байна вэ?
- Хэлж байгаа зүйлдээ тэд хэр хүчтэй итгэж байна вэ? Тэд уг үнэнд итгэсэн гэдгийг та яаж хэлж чадах вэ?
- “_____ үнэн гэдгийг би мэднэ” хэмээн хэлж байгаа тань ямар утгатай вэ? Өөрийнхөө итгэл үнэмшлийг үзүүлэхийн тулд өөр ямар үгсийг хэрэглэж болох вэ?

Иаков 7:7–12

С ба Г 76:22–24

Үйлс 2:14–38

Алма 5:45–48

Иохан 3:3–11

Үйлс 10:34–44

Алма 34:1, 8

Судар Судлах

Гэрчлэлээ хуваалцах талаар ямар зарчим болон амлалтууд байдаг вэ?

2 Нифай 33:1

С ба Г 84:61

Иохан 15:26

С ба Г 62:3

С ба Г 100:5–8

Шалгах нь

Шалгахгүйгээр урилга өгөх нь аялалаа эхлээд дуусгахгүй байх, эсвэл концертын билет авчихаад театрт очихгүй байхтай адил юм. Бүрэн гүйцэд үйл хөдлөлгүйгээр амлалтууд нь хий хоосон зүйл юм.

Өөрчлөлт нь хүнд хэцүү байж болно. Таны үүрэг бол өөрчлөлт хийхийн тулд асуудлуудаа шийдэхэд нь хүмүүсийг хүчирхэгжүүлэхэд туслах юм. Амлалтуудаа биелүүлэхэд нь хүмүүст туслахын тулд та өөрийн чадах бүхнээ хийх ёстой.

Бодит наманчлал нь зөв шударга үйлдлүүд, ялангуяа ариун явдал, Мэргэн Ухаан, болон аравны нэг зэрэг зарлигууд гэх мэт удаан хугацааны үйлдлүүдээр нотлогддог.

Хүмүүст амлалтуудаа биелүүлэхэд нь туслахын тулд та болон хэсгийн удирдагчид тэднийг ойлгож буйгаа үзүүлэх ёстой. Тэвчээртэй боловч шургуу бай. Хүмүүс эдгээр амлалтуудаар амьдарч, эсвэл өөр үгээр, тэд наманчлах (3 Нифай 18:32–ыг үз) хүртэл та тохинууллаа зогсоох ёсгүй. Наманчлал уруу хөглөх зарчмуудад итгэх хангалттай хүчтэй итгэлийг хөгжүүлэхэд нь хүмүүст туслахын тулд зарим үед хэд хэдэн айлчлал хийх шаардлагатай байж болно.

Шалгах нь таны айлчлан очиж мөн хүмүүст зааснаар эхэлдэг:

- Амлалтуудыг нь өөрийнхөө үлдээсэн товхимол, эсвэл нэр болон утасныхаа дугаарыг бичсэн хуудсан дээр тэднээр бичиж авахуул.
- Заах айлчлалуудынхаа хооронд өдөр бүр богино айлчлал хийх болно гэдгийг хүмүүст хэлэхээ бүү март. Таны зорилго бол тэднийг дэмжин туслах явдал гэдгийг тайлбарла. Эдгээр уулзалтуудаараа юу хийх тухай товч санаануудыг тэдэнд хэл.
- Өнөөдөр өгсөн амлалтын урилга бүрийг маргааш шалгахын тулд төлөвлөгөөн дээр Тэмдэглэл/Хийх Зүйлсийн Жагсаалт дээрээ тодорхой тэмдэглэ.

Амлалтуудаа хүмүүс хэр биелүүлж байгааг мэдэж аван, асуултуудад нь хариулж, нэмэлт хичээлүүд зааж, Мормоны Номноос уншиж, судруудын хэсгээс эсвэл дүрс бичлэгийн материалуудаас хуваалцахын тулд боломжтой бол өдөр бүр ойр ойрхон холбоо барь. Хүмүүстэй ойр ойрхон уулзахдаа та нар хүмүүст Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн захиасыг заахад тэдэнд мэдрэгдсэн сүнслэг мэдрэмжийг хүчирхэгжүүл. Сүнсний энэ дэмжих нөлөөлөл нь амин чухал юм. Амлалтуудаа биелүүлэхийг нь хүмүүст сануулж, зоригжуулах хэрэгтэй цаг та нарт гарч болох юм.

Амлалтуудыг биелүүлснээр өөрсдийнхөө хүлээн авсан адислалуудыг олж мэдэхэд нь сонирхогчдод тусал. Ялангуяа захиасын үнэнийг Сүнс гэрчилсэн хэмээх мэдрэмж тэдэнд төрсөн хэмээх сэтгэгдлээ дүрслэхэд нь тэдэнд тусал.

Амлалтуудаа биелүүлэхдээ амжилт олж байгаа хүмүүст баяр хүргэж, урамшуул. Сонирхогчид өөрсдийнхөө амьдралаа өөрчилж байгаа юм. Тэдэнд сурах мөн хийх маш их зүйл бий. Тэднийг чин сэтгэлээсээ, ойр ойрхон магт. Өсч хөгжиж байгаад нь талархаж буйгаа үзүүлж, мөн тэд амжилт гаргана гэдэгт итгэж байгаагаа илэрхийл. Тэдэнтэй хамт байхдаа тэднийг байнга зоригжуул.

Амлалтаа биелүүлэхдээ хүмүүс алдаж, мөн адислалуудыг хүртэх боломжгүй байгаа хүмүүст санаа зовж мөн урам хугарч буйгаа илэрхийл.

Үйл Ажиллагаа: Хувиараа эсвэл Хамтрагчтайгаа Суралцах

Сонирхогч бүртэй өдөр бүр уулзах төлөвлөгөөг өдөр тутмын төлөвлөгөөндөө бич. Сонирхогчдыг шалгахын тулд хэдэн өдрийн дараа юу хийх талаар төлөвлөгөө гарга.

Хичээлүүдийг зааж байхдаа өгөх нэг амлалтын урилгыг сонго. Тэгээд уг амлалтыг хүлээн зөвшөөрөх, эсвэл сахихад хэн нэгэнд саад болж болзошгүй өөр өөр асуудлуудыг олж тогтоо. Асуудлуудаа шийдэхээр ажиллаж байхад нь хүмүүст хэрхэн сайн туслах талаар ярилцаж мөн дасгал хий.

Тэмдэглэл

Үүнийг Сана

- Олох, эсвэл заах нөхцөлд амлалт авахуулахаар Сүмийн гишүүн бус болон Сүмийн гишүүн хүмүүс аль алийг нь урихад анхаарлаа төвлөрүүл.
- Хөрвүүлгийг мэдрэхэд нь хүмүүст туслахын тулд амлалт авах урилгуудыг өг.
- Адислалуудыг амла.
- Гэрчлэлээ хэл.
- Амлалтуудаа биелүүлэхэд нь хүмүүст туслахын тулд шалга.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Тэмдэглэл

Хувиараа Суралцах

- 4, эсвэл 5 дугаар хичээлд жагсаасан зарлигуудыг олж тогтоо. Энэ зарлигуудыг дуулгавартай дагаснаар хүлээн авсан адислалуудаа бод, мөн тэдгээрийг тэмдэглэлдээ бич.
- Тодорхой нэг зарлигийг дуулгавартай дагаснаар хэрхэн адислагдсан болохыг гэр бүлийнхээ гишүүдээс асуун захидалдаа бич (жишээ нь, аравны нэг).
- Амлалтууд авахуулах талаар ямар сэтгэгдэлтэй буйгаа бич. Та зоригтой, эсвэл ичимхий байдаг уу? Хүмүүс адислагдана гэдэгт та итгэлтэй байдаг уу, эсвэл эргэлздэг үү? Өдөр тутам холбоо барихдаа та нэг ижил, тэвчээртэй, мөн туслах хүсэлтэй байдаг уу? Өөрсдийг нь та хайрладаг болохыг хүмүүс мэддэг үү? Урилга өгөхдөө олж мэдсэн аливаа сул дорой байдлаа та хэрхэн засч залруулах вэ?
- Хичээл бүрийн хичээлийн төлөвлөгөөг нэгтгэн дүгнэ. Тодорхой амлалтуудыг та багтаасан уу? Хичээлийн тань төлөвлөгөө шууд амлалт уруу хөтөлдөг үү?

Хамтрагчтайгаа Суралцах

- Өдөр тутмын төлөвлөгөөнөөсөө сонирхогчид болон гишүүдийг оролцуулаад өнгөрсөн хоёр өдөр холбоо барьсан хүмүүсийнхээ нэрийг жагсаа. Хүн тус бүрийн хувьд, тэдний хийсэн амлалт(ууд) болон та нар өгч болох мөн ёстой бусад урилгуудыг бич. Эдгээр хүмүүсийн заримд нь яагаад амлалтууд өгөх боломжтой байсан болон бусдаас амлалтуудыг олж авахад юу саад болсон талаар ярилц. Эдгээр амлалтуудыг шалгахын тулд та нар юу хийж болох вэ?
- Өдөр тутмынхаа төлөвлөгөөг хараад дараагийн нэг эсвэл хоёр өдөр заах сонирхогчдынхоо нэрсийг жагсаан бич. Хичээл 4, 5–д жагсаасан ямар зарлигуудаар амьдрахыг тэднээс хүсэхээ бодож үз. Уг амлалтыг хэрхэн өгөх болон дуулгавартай байснаар ирэх ямар тодорхой амлалтуудыг та нар тэдэнд амлаж болох талаар ярилц.
- Тэднээс юу хүсэн хүлээгдэж байгааг тэдэнд мэдүүлэхийн тулд Заах Тайланг сонирхогчдод үзүүлэх талаар бодож үз. Хэрэв боломжтой бол тэдэнтэй нэг хувийг хуваалц.
- Өгсөн урилга бүрээ шалгах томилолтуудаа бичсэн эсэхийг мэдэхийн тулд өнгөрсөн гурван өдрийн төлөвлөгөөн дээрх Тэмдэглэл\Хийх Зүйлсийн Жагсаалтыг нэгтгэн дүгнэ.

Дүүргийн Хурал болон Бүсийн Чуулганууд

- Сонирхогчидтой өдөр тутам холбоо барих үр дүнтэй болон бүтээлч санаануудыг ярилц. Номлогч нар гишүүдтэй хэрхэн үр дүнтэй ажиллаж байна вэ? Хэвлэсэн, эсвэл дүрс бичлэгийн ямар материалууд үр ашигтай вэ? Хэрэв хүмүүс гэртээ байхгүй, эсвэл тантай уулзах завгүй бол юу хийж болох вэ?
- Хичээл 4, 5 дахь зарлигуудыг номлогч нар үр дүнтэй заасан арга замуудыг ярилц.
- Саяхны сонирхогчдын тодорхой асуудлуудын тухай ярилц. Эдгээр асуудлуудын дүр төрх юу вэ? Асуудлуудыг шийдэхийн тулд номлогч нар юу хийж чадах вэ?

Номлолын Ерөнхийлөгч

- Заримдаа номлогч нарыг хичээл зааж байхад нь хамт сууж бай. Хүмүүсийг амлалт өгч, үүнийгээ биелүүлэхэд нь тусал.

Тэмдэглэл

- Сонирхогчидтой өдөр тутам холбоо тогтоохдоо идэвхтэй оролцохыг санваартны удирдагчид болон гишүүдийг уриалан дэмж.
- Урилга урихдаа өөрийнхөө номлогчийн хичээл зүтгэлдээ мөн өөрийнхөө үйлчилж буй номлогч нарт үлгэр жишээ бай.



Баптисм болон Гишүүнээр Батлагдахад нь Хүмүүсийг Би Хэрхэн Бэлтгэх Вэ?

Үүнийг Анхаар

- Би хүмүүсээ баптисм болон гишүүнээр батлагдахад бэлтгэхэд нь туслахын тулд юу хийх хэрэгтэй вэ?
- Би баптисмын ярилцлагыг хэрхэн үр дүнтэйгээр явуулах вэ?
- Сүнслэг баптисмын үйлчилгээг хэрхэн төлөвлөн явуулах вэ?
- Би хөрвөгсөд гишүүнээр батлагдах эсэхэд баттай болохын тулд бишоптой яаж ойр дотно ажиллах вэ?
- Баптисм болон гишүүний баталгааны бүртгэлийг хөтлөх нь яагаад чухал вэ?

Хүмүүсээ Баптисм болон Гишүүнээр Батлагдахад Бэлтгэ

Заахын тань гол зорилго нь бусдын Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлэн нүглүүдээс ангижрахад туслах явдал юм. Мормон заахдаа, “наманчлалын анхны үр жимс нь баптисм” (Моронай 8:25) гэжээ. Баптисмын ярилцлага нь нэрийн оруулсан хүн болгон Их Эзэний баптисмын жишигт хүрч, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахад бэлтгэгдсэн эсэхийг батлахад Сүмийн бий болгосон арга юм. Энэхүү ярилцлагын турш, баптисм хүртүүлэхээр нэрийг нь оруулсан хүн Сүмийн эрх мэдэлтэй төлөөлөгчийн өмнө сударт заагдсан шаардлагын дагуу үнэхээр “бүх нүглүүдээ наманчлан” (С ба Г 20:37) гүйцэтгэдэг.

Тэмдэглэл

Сонирхогчийн хийх амлалт нь баптисмын гэрээг хийж, сахихад бэлтгэдэг. Амлалтаа биелүүлсэн хүмүүсийг Сүмийн ярилцлага, гишүүнчлэл мөн идэвхтэй байхад бэлтгэн тэднийг урь.

Сонирхогчид заан мөн баптисм болон гишүүнээр батлагдахад туслахдаа, тэднийг баптисмын шалгуурт тэнцэх эсэхийг батал.

Баптисмын Шалгуур

Сургаал ба Гэрээ 20:37

- Бурханы өмнө өөрсдийгөө даруусга.
- Баптисм хүртэх хүсэлтэй байх.
- Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр ирэх.
- Бүх нүглүүдээ наманчлах.
- Христийн нэрийг өөрсөд дээрээ авахад хүсэлтэй байх.
- Христэд эцсээ хүртэл үйлчлэх шийдвэр төгс байх.
- Нүглүүдийнхээ ангижралын төлөө Христийн Сүнснийг хүлээн авсан гэдгээ үйлээрээ харуулах.

Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулга:

- Сургаал ба Гэрээ 20:37–д зарлигласан зүйлд дүйцэхийн тулд амьдралдаа дорвитой өөрчлөлтүүд гаргах.
- Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх.
- Гэмүүдээ наманчлах.
- Ёс суртахууны зохистой байдлын зарчмуудаар амьдрах.
- Мэргэн Ухааны Үгээр амьдрах.
- Аравны нэг төлөхөөр шийдэх.
- Номлогчийн бүх хичээлийг заалгах [Заах Тайлан дахь хичээл 1–4 болон дагалдах амлалтууд].
- Бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэй уулзах.
- Хэд хэдэн ариун ёслолд оролцох.

(“Statement on Missionary Work,” Тэргүүн Зөвлөлийн захидал, 2002 оны Арванхоёрдугаар сарын 11)

Сонирхогчийн баттай баптисмын өдөр тогтоогдсон үед та нар баптисм болон гишүүний баталгаа уруу хөтлөх бүх үйл явцыг бүрэн гүйцэтгэх хуваарийг өдөр тутмын тань төлөвлөгөөнд жагсаасны адил хуваарил. Заах Тайлан дахь гол сургаалуудыг зааж мөн баптисмын ярилцлагын асуулт бүрт хариулахад нэрээ оруулсан хүн бэлтгэгдсэн эсэхэд анхаар. Дараагийн уулзалтаараа энэ хуваариа уг хүнтэй нэгтгэн дүгнэ. Хэрэв боломжтой бол уг хүн өөрийнхөө баптисмаас өмнө баптисмын үйлчилгээнд оролцсон байх ёстой.

Хэрэв зааж байгаа хүнд тань нэмэлт бэлтгэл хэрэгтэй гэж та нар бодож байгаа бол уг сонирхогч жишгүүдэд нийцэхүйц болох хүртэл ярилцлагыг бүү товлло. Хэрэв уг нэр оруулсан хүн бага насных бол эцэг эх буюу асран хамгаалагч нь зөвшөөрсөн байхыг, мөн түүнийг баптисм хийлгэж болно гэдгийг бичгээр зөвшөөрсөн байхыг анхаар.

Хүмүүсийг баптисмын ярилцлагад бэлтгэж байхдаа тэдэнд ярилцлагын зорилгын талаар хэлж өг. Баптисм болон Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахын ариун чанарын талаар тэдэнд зааж мөн гэрчил. Өөрсдийн тань заасан

зарчмуудыг болон өөрсдөө хийх гэрээгээ тэд ойлгож буй эсэхийг мэдэхийг хүсч байна гэдгээ тэдэнд тайлбарла. Ярилцлага бол Их Эзэний төлөөлөгчийн өмнө тэд өөрсдийгөө эдгээр ариун ёслолуудад бэлэн болохоо харуулах боломж гэдгийг нь тайлбарла. Баптисм болон гишүүний баталгааны үеэр хийсэн гэрээнүүдээ сахьснаар тэд нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авах болно. Чухал сургаалууд, өнгөрсөн нүглүүдээ наманчилсан эсэх болон Есүс Христийг амьдралынхаа турш дуулгавартай дагана хэмээн гэрээнд ороход бэлэн эсэхийг мэдэхээр ярилцлага хийгч асуух асуултуудыг тэдэнтэй ярилцана. Усаар хийх баптисм нь гишүүний баталгаа хийгээд Ариун Сүнсний бэлэггүйгээр бүрэн бус гэдгийг онцлон тэмдэглэ.

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

- Доорх хэсэг бүрийг унш, баптисм болон гишүүний баталгааны судар дахь чанаруудын жагсаалтын хураангуй гарга.

2 Нифай 9:23; 31:4–13

3 Нифай 27:13–21

С ба Г 20:37

Мозая 18:8–10

Моронай 6:1–4

С ба Г 22

Алма 7:14–15

Моронай 8:25–26

Үйлс 2:37–39

- Баптисмын ярилцлагад нэр оруулагчдаас тэд өөрсдийнхөө дээр Христийн нэрийг авахад бэлэн эсэхийг асуух болно. Энэ асуултыг ойлгоход нь тэдэнд туслахын тулд та нар юу хийж болох вэ? Энэ асуултын талаар бодож байхдаа доорх судруудыг судал:

Мозая 4–5

Мозая 26:18, 21–27

3 Нифай 27:1–10

Мозая 18:1–11

Энэ зарчмыг ойлгоход тань туслах бусад хэсгүүдийг харахыг түүнчлэн та нар хүсч болох юм.

Ярилцлагыг Хэрхэн Удирдан Явуулах Вэ

Ярилцлагыг удирдан явуулж байгаа хүн баптисм хүртэхээр нэрээ оруулж буй хүн Сургаал ба Гэрээ 20:37–д дүрсэлсэн чанаруудад нийцэж буй эсэхийг тогтоохын тулд баптисмын ярилцлагын асуултуудыг Сүнсний зааварчилгааны хамт ашиглах ёстой. Түүнчлэн тэрээр нэрээ оруулагчийн нас болон биеийн байдалд тохируулан асуултуудаа өөрчлөх ёстой.

Хэрэв нэрээ оруулагч баптисмын ярилцлагын асуултуудад нийцэхгүй байвал баптисм болон гишүүний баталгаа хойшлогдох ёстой. Сонирхогч бүрэн цагийн номлогч нараас нэмэлт хичээл авч мөн хэсгийн гишүүдтэй нөхөрлөх ёстой.

Ярилцлагыг удирдан явуулж байгаа дүүргийн удирдагч эсвэл бүсийн удирдагч доорх зүйлийг хийх ёстой:

- Ярилцлагыг тохитой, хүнгүй, Их Эзэний Сүнсийг мэдрэхэд түлхэц өгөх газар явуул. Ярилцлага хийгчийн хамтрагч ойрхон байх ёстой.
- Залбирлаар эхэл.
- Нэрээ оруулагчийг аятайхан сэтгэгдэлтэй байхад тусал.
- Ярилцлагыг сүнслэг байдлыг нэмэгдүүлэх байдалтай болго.
- Нэрээ оруулагч ярилцлагын зорилгыг ойлгож байгаа эсэхэд анхаар.
- Баптисмын ярилцлагын асуултуудыг асуу. Уг хүний гэрчлэлийн хүч болон наманчлалдаа хэр чин сэтгэлээсээ хандсаныг мэдэхийн тулд лавлан асуух асуултуудыг ашигла.

- Нэрээ оруулагчийн асуултуудад хариул.
- Гэрчлэлээ болон өөрийнхөө сэтгэгдлийг хуваалцахыг уг хүнээс хүс.
- Хэрэв уг хүнд гэрчлэл эсвэл зохистой байдлын талаар асуудал байвал, тэрээр илүү сайн бэлтгэх хүртэл баптисмыг хойшлуулах нь дээр гэдгийг тайлбарла.

Баптисмын Ярилцлагын Асуултууд

1. Бурхан бол бидний Мөнхийн Эцэг гэдэгт та итгэдэг үү? Есүс Христ бол Бурханы Хүү, Дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдэгт та итгэдэг үү?
2. Сүм болон Есүс Христийн сайн мэдээ Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн гэдэгт та итгэдэг үү? Сүмийн одоогийн ерөнхийлөгч бол Бурханы бошиглогч гэдэгт та итгэдэг үү? Энэ нь таны хувьд ямар утгатай вэ?
3. Наманчлах гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ? Өнгөрсөн гэмүүдээ бүгдийг наманчилсан гэж та бодож байна уу?
4. Та урьд өмнө нь ноцтой гэмт хэрэг хийж байсан уу? Хэрэв тийм бол, та одоо тэнсэн харгалзахтай байгаа юу эсвэл хугацаанаасаа өмнө суллагдсан уу? Та урьд өмнө нь үр хөндүүлж байсан уу? Ижил хүйстэнтэйгээ харьцаа бий юу?
5. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн гишүүнчлэлд багтана гэдэг нь сайн мэдээний жишгүүдээр амьдрахыг багтаадгийг заалгасан. Доорх жишгүүдийн талаар та ямар ойлголттой байдаг вэ? Тэдгээрийг дуулгавартай дагахад та бэлэн байна уу?
 - а. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох хууль ёсны гэрлэлтийн холбооноос гадуурх аливаа бэлгийн харилцааг хориглосон ариун явдлын хууль.
 - б. Аравны нэгийн хууль.
 - в. Мэргэн Ухааны Үг.
 - г. Долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж, уг үйлчлэлийг бусад гишүүдэд үзүүлэхийг багтаасан Хүндэтгэлийн Өдөр.
6. Баптисм хүртэхдээ та Христийн нэрийг өөр дээрээ авч, түүний зарлигуудыг амьдралынхаа турш сахихад бэлэн хэмээн Бурхантай гэрээ хийдэг. Та энэ гэрээг хийж мөн үүндээ итгэлтэй байхыг хичээхэд бэлэн үү?

Үр дүнтэй ярилцлагын төгсгөлд нэрээ оруулагчид баяр хүргээрэй. Бусад номлогч нартайгаа нэгдэн баптисмын үйлчилгээ дээр юу болохыг тайлбарла.

Гишүүний баталгаа нь өөрийнх нь харьяалагддаг хэсгийн ариун ёслолын цуглаан дээр бишопын удирдлага дор явагддаг болохыг тайлбарла.

Баптисмыг хойшлуулах шаардлагатай бол дүүргийн удирдагч, эсвэл бүсийн удирдагч, болон бусад номлогч нар уг асуудлыг нарийн мөн тусад нь авч үзэх ёстой. Нэрээ оруулагчийг тэрээр амжилт гаргахад анхаарч, зарим гэмүүдийг наманчлахад илүү цаг хэрэгтэй байдгийг тайлбарла. Ёслолуудын дүр төрхийн ариун чанар зохистой байдлын дээд жишгийг шаарддаг гэдгийг тайлбарла. Та нар болон бусад хүмүүс түүнийг дэмжихийн тулд чадах бүхнээ хийхэд анхаар. Тэгээд амлалтаа биелүүлэхийн тулд итгэлтэйгээр дага.

Баптисм болон Гишүүний Баталгаа: Асуулт болон Хариулт**Баптисм болон гишүүний баталгааны ярилцлагыг хэн удирдан явуулах вэ?**

Ерөнхийдөө, дүүргийн удирдагч дүүргийнхээ номлогч нарын заасан баптисм хийлгэхээр нэрээ оруулсан хүмүүсийг, түүнчлэн бүсийнхээ удирдагчийн заасан нэрээ оруулагч нарын баптисмын ярилцлагыг удирдан явуулдаг. Дүүргийн удирдагчийн заасан нэрээ оруулагчтай бүсийн удирдагч ярилцлага хийдэг. Ноцтой нүгэлд холбогдсон хүмүүстэй номлолын ерөнхийлөгч эсвэл түүний томилсон хэн нэгэн нь ярилцлага хийх ёстой. Номлолын ерөнхийлөгч хийлгэхээр томилохоос бусдаар дүүргийн эсвэл бүсийн удирдагч өөрийнхөө дүүрэг болон бүсээс гадуурх баптисмд нэрээ оруулагчтай ярилцлага хийж болохгүй.

Баптисмаар хөрвөгчийн тодорхойлолт юу вэ?

Баптисмаар хөрвөгчид бол доорх баптисмууд юм:

- Сүмийн гишүүн болж урьд өмнө нь баптисм хүртэж, гишүүнээр батлуулж байгаагүй ес болон түүнээс дээш насны хүмүүс.
- Эцэг эх хоёр нь хоёулаа сүмийн гишүүн бус эсвэл эцэг эх нь хүүхэдтэйгээ нэг адил баптисм хүртэж, мөн гишүүнээр батлуулж байгаа найман нас хүрсэн хүүхдүүд.

Бага насны хүүхдэд баптисм хүртээх зөвшөөрөл надад хэрэгтэй юу?

Зөвшөөрөгдсөн наснаас доошхи сонирхогчдод зааж мөн баптисм хүртээхээсээ өмнө эцэг эх болон хууль ёсны асран хамгаалагчаар гараар бичсэн зөвшөөрөл авах ёстой. Үүнээс гадна, уг хүүхэд баптисмын гэрээг ойлгож мөн Сүмийн цуглаануудад итгэлтэйгээр явах гэх мэт сайн мэдээнд дуулгавартай байх бүх хүчин чармайлт гаргана гэдэгт итгэлтэй байх ёстой.

Нөхөр эсвэл эхнэрт нь баптисм хүртээхийн тулд эхнэр эсвэл нөхрөөс нь зөвшөөрөл авах хэрэгтэй юу?

Тийм. Эхнэр эсвэл нөхрөөс нь зөвшөөрөл авалгүйгээр гэрлэсэн хүмүүст баптисм хүртээж болохгүй.

Хэрэв гэр бүлийн эцэг нь баптисмд бэлэн биш бол гэр бүлийнхэнд нь баптисм хүртээх үү, эсвэл эцэг нь бэлэн болохыг хүлээх үү?

Хэрэв гэр бүлийн эцэг нь баптисм болон гишүүний баталгаанд бэлэн бус боловч гэр бүлийн гишүүдийн бусад нь бэлэн бол Сүм өрхийн тэргүүнийг хүндэлдэг учраас, мөн гэр бүлийн нэгдмэл байдалгүйгээр гэр бүлийн гишүүд сайн мэдээнд өсч хөгжихгүй учраас гэр бүлийн гишүүдэд нь түүнгүйгээр баптисм хүртээхгүй гэдгийг эцэгт хэл. Хэрэв эцэг татгалзсаар байвал, түүний зөвшөөрлөөр гэр бүлийн бусад гишүүдэд баптисм хүртээж мөн гишүүнээр баталж болно.

Гэр бүлийнхээ бусад гишүүдэд баптисм хүртээж болохын тулд эцэгийг нь баптисм хүртсэн тэр даруйд Аароны Санваарт томилох нь сайхан санаа мөн үү?

Үгүй. Эцэгийг ариун ёслолын цуглаан дээр гишүүнээр батлах ёстой бөгөөд бишоп ярилцлага хийсний дараа Аароны Санваар хүртээхийн тулд дэмжигддэг. Эцэг нь өөрөө баптисм хүртээж болохын тулд гэр бүлийн гишүүдийн баптисмыг хойшлуулах ёсгүй.

Сүмээс хөөгдсөн хүнд би зааж мөн баптисм хүртээж болох уу?

Сүмээс хөөгдсөн хүний баптисм нь хөрвөгчийн баптисм биш учраас тийм хүний баптисмыг номлогч нар ярилцлага хийх хэрэггүй. Та нар тийм хүнтэй зөвхөн номлолын ерөнхийлөгч болон бишопын удирдлага дор ажиллаж болно.

Хэрэв хүн баптисмын өдрөө товлосон боловч бүх амлалтуудаа биелүүлэхгүй байгаа бол яах вэ?

Хэрэв зааж байгаа хүмүүсийн тань хэн нэгэнд нэмэлт бэлтгэл хэрэгтэй гэж бодож байвал уг сонирхогч амлалтуудаа биелүүлж, мөн жишгүүдэд нийцэх хүртэл нь баптисмын ярилцлагыг бүү товло.

Баптисм хүртэхийг хүсч байгаа боловч гэрлэлгүйгээр хамтдаа амьдарч байгаа хүмүүсийн хувьд би юу хийх вэ?

Эсрэг хүйсийнхээ хүнтэй гэрлэлгүйгээр хамт амьдарч байгаа баптисмд нэрээ оруулсан хүмүүс баптисм хүртэхээсээ өмнө нэг бол гэрлэж эсвэл хамт амьдрахаа зогсоох ёстой.

Баптисмын ярилцлагын асуулт 4–д асуухдаа хэрэв тухайн хүн үр хөндөлт, ижил хүйстэнтэйгээ харьцаанд орох, эсвэл ноцтой гэмт хэрэг гэх мэт ноцтой нүгэлд оролцсон бол хэмээн асуудаг. Хэрэв хүн ийм нүгэл үйлдсэнээ хүлээн зөвшөөрвөл би юу хийх ёстой вэ?

1. *Номлогч нарт заах зааварчилгаа.* Та нарыг зарлигуудын тухай зааж мөн амлалтууд авахыг урих талаар заах үед тань иймэрхүү нүглүүдийн талаарх мэдээллээ зарим сонирхогчид сайн дураараа өгч болох юм. Хэдий тийм ч, хэрэв тэд ямар нэг зүйл хэлээгүй боловч ямар нэг асуудал тэдэнд байна хэмээн бодож байвал эдгээр нүглүүдийн аль нэгэнд оролцсон уу хэмээн тэднээс асуун баптисмын ярилцлагад тэднийг бэлтгэ. Хэрэв та ноцтой нүгэл байгааг ухамсарласан бол уг нүглийн нарийн ширийн зүйлийг бүү асуу. Баптисмын өдрийг товлож эсвэл баптисм болон гишүүний баталгаанд тэнцэх болно хэмээх амлалтуудыг бүү хий. Хайраа илэрхийлж, мөн наманчлалын зарчмыг давтан заа. Эдгээр нүглүүд нь ноцтой бөгөөд арай ахимаг настай, туршлагатай хүн (номлолын ерөнхийлөгч эсвэл түүний томилсон хэн нэгэн) тэдэнтэй ярилцаж мөн эдгээр асуудлуудад нь туслах болно гэдгийг найрсагаар тайлбарла. Тэгээд баптисмын ярилцлагын хүсэлтийг шууд номлолын ерөнхийлөгчид илгээ.
2. *Баптисм болон гишүүний баталгааны ярилцлагыг удирдан явуулах хүнд зориулсан зааварчилгаа.* Хэрэв номлогч нар уг нэрээ оруулсан хүнд баптисмын ярилцлагаас өмнө зүй зохисоор нь заасан бол, эдгээр асуудлууд, хэрэв тэд байдаг бол тэднийг шууд номлолын ерөнхийлөгчид хамааруул. Хэрэв тэдгээр нь гарч ирвэл, хайраа илэрхийлж, зарлигууд болон наманчлалын зарчмыг нэгтгэн дүгнэ. Эдгээр нүглүүд нь ноцтой бөгөөд арай ахимаг настай, туршлагатай хүн (номлолын ерөнхийлөгч эсвэл түүний томилсон хэн нэгэн) тэдэнтэй ярилцаж мөн эдгээр асуудлуудад нь туслах болно гэдгийг найрсагаар тайлбарла. Дараа нь баптисмын ярилцлагын хүсэлтийг шууд номлолын ерөнхийлөгчид илгээ.

Үйл Ажиллагаа: Хувиараа Суралцах

Хэрэв та нар ярилцлагад оролцож байгаа бол ямар сэтгэгдэлтэй байх талаар бод. Доорх асуултуудыг тунгаан бод:

- Ярилцлагын ямар зүйл нь таны хувьд хачирхалтай байж болох вэ? Танд амар болгохын тулд ярилцлага хийгч юу хэлж мөн хийж болох вэ?
- Ярилцлага хийгч тантай хэрхэн харилцахыг та хүсч байна вэ?
- Хэрэв та эргэлзээ эсвэл үл ойлголтыг илэрхийлсэн эсвэл хэрэв та ноцтой нүглүүд үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн бол ярилцлага хийгч яаж хүлээж авахыг та хүсч байна вэ?

Эдгээр асуултуудын хариултыг судлах тэмдэглэлдээ бич.

Баптисм болон Гишүүний Баталгааны Бүртгэлийг Хөтөл

Ярилцлагыг удирдан явуулах номлогч баптисмын бүртгэлийн маягтыг бөглөх ёстой. Гишүүнчлэлийн мэдээлэл нь баптисмын бүртгэлээс бий болдог бөгөөд шинэ гишүүдийн тухай мэдээлэл болон тэдний хүлээн авсан ёслолуудын тухай чухал мэдээллийг агуулдаг болохыг тайлбарлах ёстой. Гишүүд нүүх үед гишүүнчлэлийн тайлан шинэ нэгж уруу шилжиж ингэснээр тэдний шинэ бишоп нөхөрлөл болон тусламжаар хангаж чадах болно. Ярилцлагын үеэр маягт дахь мэдээллийг батлахын тулд номлогч нар нэрээ оруулагчаас асуух ёстой. Гишүүнчлэлийн бүртгэлгүйгээр тухайн хувь хүн ариун сүмийн эрхийн бичиг хүлээн авч чадахгүй.

Бишоп маягт дээрх зааварчилгааны дагуу нэрээ оруулагч бүрт гишүүнээр батлагдсаны маягт бөглөгдсөн эсэхийг баталдаг.

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Мозая 6:1–3 болон Моронай 6:1–4–ыг судал. Баптисм болон гишүүний баталгааны зөв бүртгэлийг хадгалах үүрэг хариуцлагатай тань эдгээр судрын хэсгүүд хэрхэн холбогдож байна вэ?

Баптисмын Үйлчилгээ

Баптисм болон гишүүний баталгааг гүйцэтгэх ариун ёслолд Сүнс маш хүчтэйгээр илэрхийлэгддэг. Баптисмын үйлчилгээ болон удаах гишүүний баталгаа нь шинэ хөрвөгчийн хувьд сүнслэг онцгой үйл явдал байх ёстой. Баптисмын үйлчилгээ зохион байгуулалттай, бурханлигаар нөлөөлөгдсөн мөн дурсамжтай байхад анхаарахын тулд та нар болон хэсгийн номлолын удирдагч чадах бүхнээ хийх ёстой. Идэвхтэй хэвээр үлдэх гэсэн амлалтад нь шинэ хөрвөгчдийг энэ үйлчилгээ хүчирхэгжүүлэх ёстой.

Бишопын зөвлөл, чуулга болон хавсралт байгууллагын удирдагчид мөн гэрийн болон айлчлагч багш (хэрэв томилогдсон бол) нарыг баптисмын үйлчилгээнд оролцохыг урь. Хөрвөгчдийн найз нөхөд, хамаатан садангууд болон та нарын одоогийн сонирхогчид баптисмын үйлчилгээнд болон гишүүний баталгаа болох ариун ёслолд уригдсан байх ёстой. Энэ явдлууд нь Сүнсийг мэдэрч мөн сайн мэдээний талаар илүү ихийг сурах урилгыг хүлээн зөвшөөрөхөд тэднийг бэлтгэхэд тэдэнд туслах ёстой. Нэрээ оруулагчийн найз нөхөд болон хамаатан саданг оролцуулахаар урихын тулд баптисмд нэрээ оруулагч болон хэсгийн номлолын удирдагчтай ажилла. Дараа нь, тохиолдсон явдлынх нь талаар ярилцаж мөн найз нөхөд нь яагаад баптисм хүртэхээр сонгосон талаар сурахыг тэднээс хүсэхийн тулд үйлчилгээний дараа шалга.

Уг үйлчилгээг зохион байгуулахын тулд баптисмд нэрээ оруулагчид заасан номлогч нар хэсгийн номлолын удирдагчтай хамтран ажилладаг. Юу



төлөвлөгдсөн болон яагаад гэдгийг баптисмд нэрээ оруулагчид тайлбарла. Зохистой хувцаслалт, үүний дотор нэрээ оруулагчид баптисмын үйлчилгээнд зориулан өмсөх цагаан хувцсыг яаж өгөх талаар ярилц. Баптисм болох газар болон цаг хугацааны талаар зөвшилц. Ихэнхдээ бишопын зөвлөлийн гишүүн эсвэл хэсгийн номлолын удирдагч уг үйлчилгээг удирдан явуулдаг. Доорх зүйлс нь төлөвлөж мөн зохион байгуулахад чухал шаардлагатай зүйлс юм.

Баптисмын үйлчилгээнд доорх зүйлс багтдаг:

1. Өмнөх хөгжим.
2. Үйлчилгээг удирдан явуулж буй санваарын удирдагчийн товч мэндчилгээ (бишопын зөвлөлийн гишүүн тэргүүлэх ёстой).
3. Нээлтийн дуу болон залбирал.
4. Баптисм, Ариун Сүнсний бэлэг гэх мэт сайн мэдээний сэдвээр нэг эсвэл хоёр богино яриа.
5. Хөгжмийн номер.
6. Баптисмын гүйцэтгэл.
7. Баптисмд оролцсон хүмүүс хуурай хувцас сольж байх үед хүндэтгэлийн байдалтай байх цаг. Үүнд хөгжмийн номер сонсох, сайн мэдэх сүмийн дуулал болон Хүүхдийн Хэсгийн дуу дуулах, Сүмийн дүрс бичлэг үзэх, эсвэл гэрчлэлээ хуваалцах зэрэг багтана.
8. Хэрэв хүсвэл, шинэ хөрвөгчид гэрчлэлээ хуваалцах боломж.
9. Хаалтын дуу болон залбирал.
10. Төгсгөлийн хөгжим.

Гишүүний Баталгаа

Баптисм хүртсэнийхээ дараа хүн гишүүний баталгааны ёслолыг хүлээн авдаг (С ба Г 20:41). Баптисм болон гишүүний баталгааг гүйцэтгэсний дараа шинэ хөрвөгчийг Сүмийн гишүүн хэмээн тооцно (Иохан 3:5; С ба Г 33:11-ийг үз). Шинэ хөрвөгчдийг баптисмын үйлчилгээнд бус харин тэдний харьяалагддаг хэсгийн ариун ёслолын цуглаан дээр гишүүнээр батлах болно. Баптисмын дараа тохиромжтой үед аль болох түргэн гишүүний баталгааг явуулахад бишоп анхаарах үүрэгтэй. Бишоп эсвэл түүний аль нэг зөвлөх гишүүний баталгаанд оролцдог. Хөрвөгчид заахад тусалсан номлогч ахлагч нарыг гишүүний баталгаанд оролцохыг бишоп урьж болно. Энэхүү чухал шаардлагатай ёслолыг гүйцэтгэхэд анхаарахын тулд бишоп болон хэсгийн номлолын удирдагчтай ойр ажилла.



Баптисм болон Гишүүний Баталгааны Дараа

Бишопын удирдлага дор, номлогч нар шинэ гишүүдтэй цаашид нөхөрлөж болно. Тэдэнд заахаа үргэлжлүүлж, мөн заалгасан зүйлсийг нь нэгтгэн дүгнэ. Тэднийг урамшуулан дэмжиж, тэдэнтэй хамт Мормоны Номноос уншиж, гэр бүлийн гишүүд болон найз нөхөдтэйгөө сайн мэдээг хуваалцахад нь тэдэнд тусал. Хэрэв тохиромжтой бол, өөрсдийн заасан хүмүүстэй бүх амьдралынхаа турш холбоотой байж, тэднийг урамшуулан дэмж.

Гишүүний баталгааны дараа Заах Тайланг ашиглан хичээл 1–4-ийг дахин хичээл 5-ыг заах өсөлт хөгжилтөө тэмдэглэ. Идэвхтэй хэвээр байж, Есүс Христийн Цагаатгалын бүх адислалуудыг хүлээн авахад нь шинэ хөрвөгчид туслахын тулд хэсгийн номлолын удирдагч болон хэсгийн удирдагчидтай хамтран ажилла.

Үүнийг Сана

- Баптисм болон гишүүний баталгааны ярилцлагад баптисмд нэрээ оруулагчийг зүй зохистойгоор бэлтгэ.
- Баптисм болон гишүүний баталгааны шаардлагатай нэрээ оруулагч танилцсан эсэхэд анхаар.
- Баптисмын үйлчилгээнүүд сүнслэг байдлаар өргөхийг батлахад нь тусал.
- Баптисмын үйлчилгээ болон гишүүний баталгааг олох боломж болгон ашигла.
- Баптисмын болон гишүүний баталгааны маягтыг зөвөөр бөглө.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- Баптисмд нэрээ оруулагчид тулгарч болох сорилтуудын жагсаалт гарга. Нэрээ оруулагч Сүмийн гишүүдийн хайр болон нөхөрлөлийг мэдрэх нь яагаад чухал вэ?
- Моронай 6 болон Сургаал ба Гэрээ 20:68–69. Баптисм болон гишүүний баталгаанд хүмүүсийг бэлтгэх талаар эдгээр шүлгүүдээс юу сурах вэ? Сурсан зүйлээ бичиж, хамтрагчтайгаа суралцахдаа өөрийнхөө бодлыг хамтрагчтайгаа хуваалц.

Хамтрагчтайгаа Суралцах

- Ахлагч Хенри Б.Айринг дээд жишгүүд яагаад чухал вэ гэдгийг тайлбарласан билээ. Энэ зөвлөгөөг хамтрагчтайгаа ярилцаж, эдгээр жишгүүдэд нийцэхэд нь хүмүүст туслахдаа зоригтой байх талаар юу бодож байгаагаа үнэл. “Тэрээр биднийг адислахын тулд Их Эзэн Өөрийнхөө жишгүүдийг тогтоосон. Тэдгээр адислалуудын талаар бод: Жишгүүдэд нийцсэн хүмүүст Ариун Сүнсний тусламжийг Тэрээр амласан. Тэрээр хувийн амар амгаланг амласан. Өөрийнх нь өргөөнд ариун ёслолуудыг хүлээн авах боломжийг Тэрээр амласан. Мөн Түүний жишгүүдээр амьдрахад тэвчих хүмүүст мөнх амьдралыг тэрээр амласан. . . . үйлчилж буй хүмүүстээ бид хайртай учраас Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдийг Их Эзэний бүх адислалуудтай байхад хэрэгтэй итгэл мөн ариун чанарыг авахад нь тэднийг илүү өргөдөг. . . Их Эзэний жишгүүдийг товч тодорхой хийгээд харамсалгүйгээр өргөж эхэл. Дэлхийн муу муухай ихсэж тэдгээрийг шоолох тусам үүнийг хийхдээ бид илүү зоригтой байх ёстой” (“Standards of Worthiness,” *First Worldwide Leadership Training Meeting*, 2003 оны Нэгдүгээр сар, 10–11).
- Хүмүүсийг баптисм болон гишүүний баталгаанд бэлтгэх талаар энэ бүлгээс сурсан зүйлсээ хамтрагчтайгаа хуваалц.
- Хамгийн сүүлд оролцсон баптисмын үйлчилгээгээ нэгтгэн дүгнэ. “Баптисмын Үйлчилгээ” гарчигийг доорх зааварчилгаануудтай харьцуул. Юу нь сайн болсон бэ? Юуг сайжруулж болох вэ? Та нарын төлөвлөсөн үйлчилгээ сүнслэг мөн урам өгсөн байхад хэрхэн анхаарахыг ярилц.
- Баптисмын ярилцлагад тодорхой нэг сонирхогчийг хэрхэн бэлтгэж болох дасгал хий.
- Баптисмын ярилцлагын асуултуудыг нэгтгэн дүгнэ. Доорхтой ижил өөр өөр нөхцлүүдэд та нар хэрхэн хандахыг бодож үз:
 - Саяхан үйлдсэн гэмт хэргийнхээ тухайд батлан даалтад байгаагаа нэрээ оруулагч танд хэлээгүй бол.
 - Иосеф Смит бошиглогч байсан эсэхийг асуусан залбиралдаа хүчтэй хариулт уг хүн хүлээн аваагүй бол.
 - Нэрээ оруулагч хоёр өдрийн өмнө тамхи татсан бол.
 - Залбирлынхаа хариуг хүлээн авсан эсэхдээ нэрээ оруулагч эргэлзэж байгаа бол.
 - Найз нарынхаа эсэргүүцэлтэй тулгарсан гэр бүл баптисмд бэлэн эсэхээ сайн мэдэхгүй байгаа бол.
- Баптисмын Бүртгэл, Гишүүний Баталгааны Бүртгэл болон Баптисм болон Гишүүний Баталгааны Гэрчилгээний маягтыг нэгтгэн дүгнэ. Өөрсдийн тань хангаж өгөх мэдээлэл зөв хийгээд бүрэн гэдгийг та нар хэрхэн батлах вэ?

Тэмдэглэл

Дүүргийн Хурлууд болон Бүсийн Чуулганууд

- Баптисмын ярилцлага чухал болохыг нэгтгэн дүгнэ. Сонирхогчдыг ярилцлагад номлогч нар хэрхэн бэлтгэх талаар ярилц.
- Баптисмын үйлчилгээ болон гишүүний баталгааг олох боломж болгон хэрхэн ашиглаж болохыг ярилц.

Номлолын Ерөнхийлөгч

- Өсөлтийн Тайланг үр дүнтэй ашиглахад анхаарахын тулд орон нутгийн санваарын удирдагчидтай хамтран ажилла.
- Баптисмын эхний ярилцлагыг үе үе удирдан явуул.
- Баптисмын ярилцлагыг хэрхэн удирдан явуулахыг дүүргийн удирдагчид болон бүсийн удирдагчдад заа.
- Ноцтой нүглүүд үйлдсэн баптисмд нэрээ оруулагчийн баптисмын ярилцлагыг хэрхэн хөтлөн явуулах талаар номлолын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд болон санваарын удирдагчдад зааварчилгаа өг.



Би Гадас болон Хэсгийн Удирдагчидтай Хэрхэн Ажиллах Вэ?

Тэмдэглэл

Үүнийг Анхаар

- Шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүд Сүмийн идэвхтэй гишүүд болохын тулд юу хийх хэрэгтэй вэ?
- Номлолын ажил, идэвхтэй хэвээр нь байлгах болон идэвхжүүлэхэд гадас, хэсгийн удирдагчид ямар үүрэг хариуцлагатай вэ?
- Хэсгийн удирдагчдыг Сүмийг зохион байгуулахад би хэрхэн тусалж чадах вэ?
- Хэсгийн номлолын удирдагчидтай хийдэг долоо хоног тутмын хамтарсан хуралдаан дээр юу хийгдэж байх ёстой вэ?

Та номлолынхоо турш олон удирдагчид болон гишүүдтэй ажиллах агуу боломжтой байдаг. Та нар хамтдаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг хүчирхэгжүүлж, бэхжүүлэх болно. Сүмийн удирдагчидтай байгуулсан нөхөрлөл тань чамайг үлдсэн амьдралын тань турш адисална. Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг сэргээгдсэн сайн мэдээнд авчрахыг эрэлхийлж байгаа та болон Сүмийн гишүүдийн хувьд нөхөрлөл их чухал юм. Хэсэгт хэрхэн ажиллах талаарх үндсэн ойлголт тань таныг агуу анхаарал, хүчтэйгээр урагш тэмүүлэхэд тусалдаг.

Шинэ болон Идэвх Султай Гишүүдийг Хүчирхэгжүүлэх нь

Шинэ хөрвөгчид баптисм хүртэж, гишүүнээр батлуулахдаа үлдсэн амьдралынхаа турш дагах, мөн Бурхан болон бусдад үйлчлэх нандин амлалтуудыг хийдэг. Тэд сэлэстиэл хаант улс дахь авралын төлөөх нэр дэвшигчид болдог. Амлагдсан адислалуудыг хүлээн авахын тулд тэд Есүс Христэд итгэх итгэлтэйгээр эцсээ хүртэл тэвчих ёстой. Шинэ хөрвөгчдийн идэвхтэй, итгэлтэй хэвээр үлдэхэд туслах үйл хэрэгт Сүмийн гишүүд зайлшгүй чухал юм.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Хичээл зүтгэлийнхээ үр жимснээс барьж авч чадахгүй л юм бол номлогчийн ажил хийх нь ямарч утгагүй юм. Энэ хоёрыг салгаж ойлгох аргагүй. . . . Гишүүн бүрийн агуу хийгээд хүндтэй үүрэг хариуцлага билээ” гэжээ (“Find the Lambs, Feed the Sheep,” *Ensign*, 1999 оны Тавдугаар сар, 108).

Бишопын удирдлага дор хэсгийн зөвлөл шинэ гишүүд болоод идэвх султай гишүүдийг хүчирхэгжүүлэхэд анхан шатны үүрэг хариуцлагыг хүлээдэг. Тэд шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдийг найз нөхөдтэй болж, Бурханы үгээр тэжээгдэж, дуудлагууд хийгээд хариуцлагуудыг хүлээн авсан эсэхийг баталдаг. Тэд бүрэн цагийн номлогч нарыг гэрийн багшлалт (буюу номлогч эгч нарыг айлчлагч багшлалт), шинэ гишүүд, идэвх султай гишүүд хийгээд ирээдүйн ахлагч нарынхаар айлчлахад туслалгыг хүсч болно. Ийм уулзалтуудад гишүүдтэй хамт явах нь илүү сайн юм.

Та ч бас эдгээр хүмүүсийн төлөө хариуцлага хүлээдэг. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Номлогч та нар ч . . . хөрвөгчдөө Сүмтэй холбоотой байлгах энэ үүрэг хариуцлагын нэгээхэн хэсэг нь юм. Та нар тэдэн дээр үргэлжлүүлэн айлчлан очсоор байж чадахгүй байж болно. Гэвч та нар тэдэнд үе үе заха бичиж, урам зоригийг өгч чадна. Гэртээ хариад тэднийг битгий мартаарай. Цаг үргэлж тэдний итгэл найдварт зохистой байхаар амьдраарай. Тэдэнд өгсөн өөрийн хайраа бататгаж үе үе заха бичиж бай” гэсэн (*Ensign*, 1999 оны Тавдугаар сар, 109).

Сүмийн цуглаанд очоод та болон таны хамтрагч дэмжиж, хүчирхэгжүүлэхээр очсон сонирхогчидтойгоо эсвэл сүмийн гишүүдтэй зэрэгцэн суух ёстой. Та бусад номлогч нартайгаа бөөгнөрөн сууж болохгүй.

Сүмийг зохион байгуулж, үйлчилж байгаа нэгжээ хүчирхэгжүүлэх нь номлолын тань чухал хэсэг юм. Шинэ хөрвөгчдийг идэвхтэй хэвээр нь үлдээх, идэвх султай гишүүдийг эргэж идэвхтэй болоход тусалснаар та өөрийн хэсгийг хийх болно. Үүргүүдийн тань нэг нь хэсгийн номлогч нартай хамтран эхний дөрвөн хичээлийг мөн 5-р хичээлийг заах явдал юм. Хэсгийн номлогч нар, гэрийн багш нар, айлчлагч багш нар эдгээр зарчмуудыг заахад мөн тусалж чадна.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли шинэ хөрвөгчдөд тулгардаг олон сорилтуудын талаарх дараах зүйлсийг бидэнд хэлсэн:

Би нэгэн өдөр ихэд сонирхолтой заха хүлээн авсан юм. Үүнийг жилийн өмнө Сүмд нэгдсэн нэгэн эмэгтэй бичсэн байлаа. Тэр ингэж бичжээ:

“Миний Сүм рүү хийсэн аялал ганцаардангүй, мөн маш их сорилттой байлаа. Энэ өнгөрсөн жил амьдралын минь хамгийн хүнд жил байв. Энэ бас их бүтэлтэй, анхаарууштай жил болж өнгөрсөн. Шинэ гишүүний хувьд би өдөр бүр үргэлжлүүлэн сорилтуудтай тулгарсаар байх болно.”

Тэр үргэлжлүүлэн хэлэхдээ, түүнийг Сүмд нэгдэхэд тэр хэсгийнхээ удирдагч нараас ямар ч дэмжлэгийг мэдэрдэггүй байсан гэсэн. Бишоп нь түүнд шинэ гишүүнийх нь хувьд хайхрамжгүй хандаад байх шиг санагджээ. Тэр ингэж татгалзагдаж байсан учраас тэр өөрт нь боломжуудыг нээж өгсөн номлолынхоо ерөнхийлөгчид хандсан байна.

Тэр “Сүмийн гишүүд шинэ гишүүн байх нь ямар болохыг мэддэггүй. . . . Иймээс тэдэнд биднийг хэрхэн дэмжихээ мэдэж авах нь бараг боломжгүй зүйл юм” гэж хэлжээ.

Ах, эгч нар минь хэрэв та нар энэ нь ямар болохыг мэддэггүй бол, энэ нь ямар байхыг төсөөлж үзэхийг хичээгээч гэж би та нарт уриалж байна. Энэ нь аймшигтай ганцаардмал байж магадгүй. Энэ нь урам хугалахаар байж магадгүй. Энэ нь аймаар байж магадгүй. Энэ Сүмийн бид бодохыг хүсдгээсээ илүү их өөр юм. Тэр эмэгтэй үргэлжлүүлэн: “Бид



сонирхогчдын хувьд Сүмийн гишүүн болохдоо өөрийн гэсэн ёс заншил, соёл, хэлтэй дэлхий болох тэс өөр гадаад ертөнц рүү орж байгаага олж мэдээд гайхацгаадаг. Бид энэ шинэ ертөнцөд орох аялалд удирдамж асуухаар хандах нэг ч хүн, бишрэлийн нэг ч газар байхгүй болохыг олж мэддэг. Эхлээд энэ аялал нь маш сэтгэл хөдлөм, алдаанууд маань хүртэл гайхам байснаа удалгүй сэтгэлээр унаж эхэлдэг бөгөөд урам хугарсан байдал маань уур болон хувирдаг. Ингээд энэ л урам хугарсан, ууртай байдалдаа бид үлддэг. Бид хэн байснаа мэдэх, хувь нэмрээ оруулж байсан, мөн нөгөө л хэлээрээ ярьж болох өөрсдийн ирсэн тэр л дэлхий рүүгээ буцдаг” гэж бичжээ (Ensign, 1999 оны Тавдугаар сар, 108).

Үйл Ажиллагаа: Хувиараа болон Хамтрагчтайгаа Суралцах

Өмнөх мэдээллийг унш. Дараах асуултуудад хариулан судлах тэмдэглэлдээ бичих юмуу, эсвэл хамтрагчтайгаа ярилц. Тохирох зорилго болон төлөвлөгөөнүүдийг хий.

- Энэ мэдээллийг дагуу шинэ гишүүдийг идэвхтэй хэвээр үлдэхийг хэцүү болгодог зарим хүчин зүйлүүд юу вэ?
- Заах явцынхаа эхнээс гишүүдийг хамруулж байх нь эдгээр сорилтуудад хэрхэн тусалж чадах вэ?
- Зааж байгаа тэдгээр хүмүүсийнхээ тухай бод. Та Сүм рүү хийх өөрчлөлтөө эхлэхэд нь сонирхогчдодоо туслахын тулд гишүүдийг хэрхэн илүү сайн оролцуулж чадах вэ?

Гэрийн болон Айлчлагч Багшлалт

Гадасны ерөнхийлөгч болон бишопууд номлолын ерөнхийлөгчтэй зөвшилцсөнөөр идэвх сул болон гэр бүлийн нэг хэсэг нь гишүүн хүмүүсийнхээр айлчлахдаа номлогч нарыг ашиглаж болно. Тохиромжтой нөхцөл байдлын үед тэд бас номлогч нарыг гэрийн багшлалт болон айлчлагч багшлалтанд оролцохыг асууж болох юм. Эдгээр заах боломжууд нь гишүүдийг хүчирхэгжүүлж, номлогч нарын заах чадварыг өсгөж, бусдын зааж өгсөн хүмүүсийг олж авахад нь номлогч нарт туслах болно (“Statement on Missionary Work,” Тэргүүн Зөвлөлийн захиаг үз, 2002 оны Арванхоёрдугаар сарын 11).

Шинэ болон Идэвх Султай Гишүүдийг Хүчирхэгжүүлэхээр Хэсгийн Зөвлөлтэй Хамтран Ажилла

Номлолынхоо ерөнхийлөгчийн удирдлага дор сонирхогчдодоо нартаа зааж, баптисм хүртээх ёстой. Хэдий тийм ч гэсэн сайн мэдээг номлох ажил нь бүрэн цагийн номлогч нар гишүүдтэй хичээл зүтгэлээ хавсарган хамтарч ажиллавал илүү хүчтэйгээр урагшлах болно. Таныг хэсгийн зөвлөл болон санваарын гүйцэтгэх хорооны хуралд оролцохыг байн байн урьж болно. Таны эн тэргүүний баттай байх зүйл тань сонирхогчид тань Сүм дээр байх явдал юм. Ихэнхдээ энэ нь та тэдэнтэй хамт байна гэсэн утгыг илэрхийлж байна. Хэрэв хэсгийг зөвлөлийн хуралд оролцох болон хэн нэгнийг сүм дээр авчрах хоёрын хооронд сонгох хэрэгтэй болбол хэн нэгнийг авчрахыг нь сонгоорой. Энэ тохиолдолд хэсгийн номлолын удирдагчдаа Өсөлтийн Тайлангийн нэг хувийг өгч, түүнд хэсгийн зөвлөл болон



© 1889 Beag K. Olsen, Courtesy Mill Pond Press. Хувилал өмнүүлж болохгүй.

Тэмдэглэл

санваарын гүйцэтгэх хороонд өгөх хэрэгтэй бүх мэдээллүүд байгаа эсэхийг хянаарай.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

“Шинэ хөрвөгч бүрд гурван зүйл хэрэгтэй байдаг:

“1. Тэр байнга хандаж байх, түүнд тусалж, асуултуудад нь хариулж, бэрхшээлүүдийг нь ойлгож байх Сүмийн найз.

“2. Даалгавар. Үйл ажиллагаа нь энэ Сүмийн мөн чанарыг тодорхойлж байдаг. Энэ нь биднийг өсгөж байдаг тэр үйл явц юм. Их Эзэнд итгэх итгэл болон хайр нь миний гарын булчинтай адил. Хэрэв бид эдгээрийг ашиглах юм бол тэд илүү хүчирхэг болдог. Хэрэв бид тэднийг зүгээр л орхичих юм бол тэд суларч ирдэг. Хөрвөгч бүр үүрэг хариуцлагыг авах хэрэгтэй. . . .

“3. Хөрвөгч бүр Бурханы сайн үгсээр тэжээгдэх ёстой (Моронай 6:4). Тэднийг санваарын чуулган юмуу Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Залуу Эрэгтэйчүүд, Ням Гарагийн Хичээл, эсвэл Хүүхдийн Хэсэгт нэгтгэж өгөх нь их чухал билээ. Тэднийг ариун ёслолын цуглаанд ирж ариун ёслолоос хүртсэнээр баптисмынхаа үед хийсэн гэрээгээ шинэчлэхийг урамшуулж байх ёстой” гэжээ (Ensign, 1999 оны Тавдугаар сар, 106).

Хэсгийн зөвлөл нь шинэ хөрвөгчид найз, үүрэг хариуцлага болон сүнслэг тэжээлээр хангах үүргийг өөрсдөд дээрээ авдаг. Та тэдний хүссэний дагуу тэдэнд туслаарай. Таны тусламжтайгаар санваарын удирдагчид болон гишүүд нөхөрлөлийг дэмжинэ.

Нөхөрлөл

- Баптисм болон гишүүнээр батлуулахаас өмнө хэрэв боломжтой бол бүх хичээл дээр гишүүдийг байлцуул. Эдгээр гишүүд сонирхогчдын асуултанд хариулж, тэдний сорилтуудыг ойлгож, тэднийг дэмжихээр ойр ойрхон очиж байх ёстой.
- Гишүүдийг баптисмын үйлчлэлд оролцож, шинэ хөрвөгчийг хэсэгтээ хүлээн авахыг урь. Гишүүд шинэ хөрвөгчийг олон янзын Сүмийн цуглаануудад таатай мэдрэмжтэй байхад нь тусалдаг.
- Сонирхогчдоо бишоп, түүний зөвлөхүүд, ахлагчийн чуулган болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нар, хэсгийн бусад удирдагчидтай аль болох хурдан танилцуул. Бишоп болон хэсгийн бусад удирдагчдын үүргийг тайлбарла.



Үйлчлэх Боломжууд

- Эрэгтэй хөрвөгчдөд Аароны Санваар болон Мелкизедекийн Санваарыг ойлгож хүлээн авахдаа бэлтгэхэд нь тусал. Санваарын чуулган нь сурах, бишрэх хийгээд хамтдаа үйлчлэх боломжуудаар хангах болно гэдгийг тайлбарла.
- Шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдийг бэлэвсэн юмуу өвчтэй хэн нэгэнд туслах, эсвэл халамжийн хөтөлбөрт оролцуулах гэх зэрэг үйлчлэх боломжуудад хамруул.

- Хөрвөгчид гэр бүлийн бичээс, удмын бичгээ бичиж болохын тулд тэднийг гэр бүлийн түүхийн зөвлөхтэй уулзуул. Хэрэв нөхцөл байдал зөвшөөрөх юм бол тэднийг нас барсан өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмд баптисм хүртэхээр бэлтгэхэд нь тусал.
- Хөрвөгчдийг өөрсдийн гэр бүлийн гишүүд хийгээд найз нөхдөө номлогчоос хичээл авахад бэлтгэхийг урь. Номлогч нар нь шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдээс бусад хэн нэгнийг зааж өгөхийг асуух ёстой.

Бурханы Үгээр Тэжээх нь

- “Хуулиуд ба Ёслолууд”, хичээл 5 дахь зарчмуудыг зааж дуусга.
- Шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдэд баптисмынхаа өмнө хийсэн даалгаврууд хийгээд баптисм хүртэж, гишүүнээр батлуулах үедээ хийсэн гэрээнүүдийг нь сануул.
- Тэднийг хувиараа болон гэр бүлээрээ өдөр бүр залбирахыг урамшуул.
- Тэднийг өдөр бүр судруудаас, ялангуяа Мормоны Номноос суралцахыг урамшуул.
- Шинэ хөрвөгчдийн Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн талаарх гэрчлэлийг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан батжуул. Баптисм болон гишүүнээр батлуулахын өмнө зааж байсан бүх хичээлүүдээ тэдний одоогийн хэрэгцээнд тохируулан даалгавар болон урилгуудыг нь өөрчлөн тэдэнтэй тоймлон үз.
- Ням гараг бүр сүм дээр ирж, зохистойгоор ариун ёслолоос хүртэхийн чухлыг заахаа үргэлжлүүл. Ирээд шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдтэй хамт суу.
- Ням гарагийн хичээлийн үеэр тэднийг Сайн Мэдээний Зарчмууд ангид орохыг урь.
- Даваа гарагийн орой бүр гэр бүлийн үдшийг хэрхэн хийхийг Family Home Evening Resource Book-ыг ашиглан тэдэнд заа.
- Тэднийг бусадтай сэргээгдсэн сайн мэдээг хуваалцахыг урамшуул.
- Тэднийг семинар болон институтын ангид хамрагдахад нь тусал.
- Тэдэнд Сүмийн www.mormon.org, www.lds.org болон www.familysearch.org веб сайтуудыг сонирхуул.

Судар Судлах

Бурханы Үгээр Тэжээ

Мозая 18:18–20

Алма 31:5

Моронай 6:4

Үйлчлэл

Мозая 2:17

Матай 25:40

Guide to the Scriptures, “Service”

Бүрэн Цагийн Номлолын Ерөнхийлөгчийн Үүрэг Юу Вэ?

Бүрэн цагийн номлолын ерөнхийлөгч нь хөрвүүлэгч баптисмын түлхүүрүүдийг атгадаг. Түүний удирдлага дор бүрэн цагийн номлогч нар сонирхогчдоо зааж анхан шатны үүрэг хариуцлагыг хүлээдэг. Гэсэн хэдий ч бишоп сонирхогчдын

хичээл авч байх үеийнх нь өсөлт болон нөхөрлөлийг ажиглан хардаг. Хэсгийн номлолын төлөвлөгөө нь бишопын удирдах эрх мэдлийн дор явагддаг. Номлолын ерөнхийлөгч бүрэн цагийн номлогч нарыг орон нутгийн санваарын удирдагч нартай зохицож ажиллаж байгаа эсэхийг батлахаар гадасны ерөнхийлөгчтэй тогтмол уулздаг юм. Тэр номлолын ажлын зарчмууд болон туршлагаудад удирдамж өгөхөд нь гадасны ерөнхийлөгчид туслах номлолын хүчин чармайлт хийгээд саналыг зохицуулдаг.

Гадас болон Хэсгийн Удирдагчид Ямар Үүрэг Хариуцлагатай Вэ?

Сүмийн орон нутгийн удирдагчид болон гишүүд таны хамгийн сайн холбоотнууд юм. Тэднийг хүндэлж, тэдэнтэй сайн харьцаа тогтоохыг эрмэлз. Та эдгээр удирдагчидтай ажиллаж байхдаа тэд өөрсдийн дуудлагатай холбоотой өөр үүрэг хариуцлагуудтай гэдгийг сана. Гадас болон хэсгийнхээ удирдагчдад дарамт бус адислал байхыг эрэлхийлээрэй. Таны хандлага “Бид хэрхэн тусалж чадах вэ?” гэдэг л байх ёстой. Өөрсдийн төлөвлөгөө ба үйл ажиллагаануудаа бишоп болон хэсгийн номлолын удирдагчтай зөвлөлд. Юу хийж байгаа тань хэсгийн номлолын төлөвлөгөөг дэмжихээр байгаа гэдэгт итгэлтэй бай.

Номлолын ажил дахь орон нутгийн санваарын удирдагчийн үүргүүд дор дүрслэгдэх болно. Тэдний үүргүүдийг ойлгох нь таныг тэдэнтэй илүү сайн хамтран ажиллахад тусална.

Гадасны Ерөнхийлөгч

Гадасны ерөнхийлөгч нь бишопуудыг өөрсдийн номлогч, идэвхтэй хэвээр үлдээх болон идэвхжүүлэх үүрэг хариуцлагууддаа хэр байгааг ажигладаг. Бишоптой хийх сар бүрийнхээ ярилцлагад тэр төлөвлөгөөнүүд хийгээд тодорхой сонирхогчид болон гишүүдийн өсөлтийн тухай ярилцдаг. Тэр номлогчийн ажилтай холбоотой сургаалууд нь гадас болон хэсгийн цуглаанууд дээр тогтмол заагдаж мөн санваарын удирдагчид болон бусад нь өөрсдийн номлогчийн үүрэг хариуцлагадаа сургагдсан байхыг баталдаг.

Гадасны ерөнхийлөгч нь номлолын ерөнхийлөгчтэй удирдагч болон гишүүдийн сургалт, бүрэн цагийн номлогч нарыг ашиглах хийгээд тэднийг идэвхжүүлэх хичээл зүтгэлд нь туслах зэрэг номлогчийн хичээл зүтгэлийг зохицуулах асуудлаар тогтмол уулздаг.

Дээд Зөвлөх

Дээд зөвлөх нь гадас дахь номлогч, идэвхтэй хэвээр үлдээх болон идэвхжүүлэх ажилд тус дэм үзүүлэхээр гадасны ерөнхийлөгчөөр дуудагддаг. Тэр энэ ажлын явцыг гадасны ерөнхийлөгчид тогтмол тайлагнадаг. Тэр бас хэсгийн номлолын удирдагчид нь өөрсдийн хэсгийн номлолын төлөвлөгөөг бэлтгэх зэрэг үүрэг хариуцлагад зохих ёсоор сургагдсан гэдгийг баталдаг.

Бишоп

Бишоп нь хэсэг дэх номлогч, идэвхтэй хэвээр үлдээх болон идэвхжүүлэх хичээл зүтгэлүүдийн төлөө үүрэг хариуцлагатай. Түүний хувийн оролцоо хийгээд удирдлага их чухал юм. Энэ ажлыг амжилттай хийж дуусгахад туслахаар бишоп зохистой Мелкизедек Санваартныг хэсгийн номлолын удирдагчаар үйлчлүүлэхээр дууддаг. Тэр бас хэсэг дэх хэрэгцээнд тохируулан хангалттай тооны хэсгийн номлогч нарыг дууддаг.

Бишоп нь номлогч, идэвхтэй хэвээр үлдээх болон идэвхжүүлэх хичээл зүтгэлүүдийг зохицуулахдаа санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөлийг ашигладаг. Тэр хэсгийн номлолын төлөвлөгөөг хөгжүүлэх, хэрэгжүүлэх чиглэлийг өгдөг.

**Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах**

Бишоптой уулзах цагийг төлөвлө. Хэсэгт хамгийн сайнаар хэрхэн үйлчилж чадах вэ гэдэгт түүний удирдамжийг эрэлхийл.

Санваар болон Хавсралт Байгууллагуудын Удирдагчид

Санваар болон хавсралт байгууллагуудын удирдагчид шинэ гишүүд, идэвх султай гишүүдийн байдлыг тогтмол хянаж, хэрхэн илүү сайн нөхөрлөж мөн тэднийг хүчирхэгжүүлэхийг төлөвлөх ёстой. Тэд бас хэсгийн номлогч нар болон бүрэн цагийн номлогч нартай хамт номлогч, идэвхтэй хэвээр үлдээх болон идэвхжүүлэх хичээл зүтгэлүүдийг зохицуулахаар хэсгийн номлолын удирдагчтай хамтран ажиллах ёстой.

Хэсгийн Номлолын Удирдагч

Бишопын удирдлага дор хэсгийн номлолын удирдагч нь:

- Бусадтай сайн мэдээг хуваалцаж мөн сонирхогч, шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдтэй нөхөрлөснөөр үлгэр жишээ үзүүлдэг.
- Хэсгийн номлогч нар болон бүрэн цагийн номлогч нарын ажлыг санваарын удирдагчид, хавсралт бүлгийн удирдагчид ба гишүүдийнхтэй зохицуулдаг.
- Санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл дээр сонирхогч, шинэ хөрвөгчид болон идэвх султай гишүүдийн явцыг үзүүлэхдээ Өсөлтийн Тайлан, Хөрвөгчийн Ажил Хэргийн Жагсаалт ба Бишопын Зөвлөлийн Ажил Хэрэг ба Ярилцлагын Жагсаалтыг ашигладаг.
- Номлогчийн долоо хоног тутмын нэгдсэн уулзалтыг хөтөлдөг.
- Бүрэн цагийн номлогч нартай хамтарч хэсэг дэх хөрвөгчийн баптисмын үйлчлэлийг зохион байгуулдаг. Эдгээр үйлчлэлүүдийг ерөнхийдөө бишопын зөвлөлийн гишүүн юм уу хэсгийн номлолын удирдагч хөтөлдөг.

Хэсгийн номлолын удирдагч нь бас санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл болон хэсгийн халамжийн хороонд үйлчилж, гадасны санваарын удирдлагын цуглаанд оролцдог.

Хэсгийн Номлогч Нар

Дадлагажсан ах эгч нар хэсгийн номлогчоор үйлчлэхээр дуудагддаг. Тэднийг хэсгийн номлолын удирдагч зохицуулан удирддаг.

Хэсгийн номлогч нар сонирхогчдыг олж, нөхөрлөж, заадаг. Тэд бас шинэ хөрвөгчид, идэвх султай гишүүдэд зааж сургаж мөн нөхөрлөдөг.

Мелкизедек Санваартай хэсгийн номлогч нь хэсгийн номлолын удирдагчийн туслах байхаар дуудагдаж болно.

Номлогчийн Зохицуулалт

Хэсгийн номлогчийн ажил ерөнхийдөө бүрэн цагийн номлогчийн өгсөн Өсөлтийн Тайланг ашиглах замаар санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл дээр зохицуулагддаг. Эдгээр цуглаанууд дээрх номлогчийн зорилго нь доорхи догол мөрүүдэд дурдагдсан олох, заах, нөхөрлөх, идэвхжүүлэх даалгавруудыг тайлагнаж, төлөвлөж мөн зохицуулах явдал юм.

Заах Хүмүүсийг Олох. Санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл нь бүрэн цагийн номлогчоор заалгах тодорхой хүмүүсийг бэлтгэх төлөвлөгөөг ярилцдаг. Тэд хувь хүн, гэр бүлийг номлогчийн хичээлд бэлтгэж байгаа хэсгийн тодорхой гишүүдийн явцыг ярилцдаг.

Зааж, Баптисм Хүртээх нь. Санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл нь бүрэн цагийн номлогчоор заалгаж байгаа хүн бүрийн өсөлтийг дүрслэн үзүүлсэн Өсөлтийн Тайланг долоо хоног бүр нягтлан үздэг. Тэд бас гишүүдийн гэрт заах, сонирхогчидтой нөхөрлөх, баптисмын үйлчлэл дээр гишүүдийг оролцуулж байгаа эсэхийг зохицуулдаг.

Шинэ Гишүүдтэй Нөхөрлөж, Заах нь. Санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл нь шинэ гишүүн бүрийн өсөлтийн явцыг хянахаар Хөрвөгчийн Ажил Хэргийн Жагсаалтыг нягтлан үздэг. Тэд бас шинэ гишүүдийг хэрхэн нөхөрлүүлэх талаар ярилцдаг. Бишопын хүсэлтээр тэд шинэ хөрвөгчдөд тохирох дуудлагуудыг санал болгодог.

Идэвх Султай Гишүүдтэй Нөхөрлөж, Заах нь. Санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөл нь санваарын чуулгууд болон бүрэн цагийн номлогч нарын идэвхжүүлэх хичээл зүтгэлүүдийг нь удирдан зохицуулдаг. Тэд бас идэвх султай гишүүдийг ялангуяа Сүмийн цуглаан, үйл ажиллагаануудад урьснаар хэрхэн нөхөрлүүлэх талаар төлөвлөдөг.

Хэсгийн Номлолын Удирдагчтай Хамтарсан Нэмэлт Зохицуулалт

Хэсэг дэх номлолын ажил нь ерөнхийдөө санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөлд зохицуулагддаг. Хэрэв нэмэлт зохицуулалт хэрэгтэй бол хэсгийн номлолын удирдагч бүрэн цагийн номлогч нартай номлогчийн зохицуулалтын цуглааныг зохион байгуулж болно. Үүнээс гадна энэ цуглаанд хэсгийн номлогч нар, дээд санваартны бүлгийн удирдлагын туслах, ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөх, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөх нар оролцож болно.

Эдгээр цуглаанд оролцож байгаа хүмүүс өмнөх цуглаануудаас гарсан үүрэг даалгавар болон зорилгуудыг хянан үзэж, тайлагнаж мөн ирэх долоо хоногийн төлөвлөгөөнүүдийг ярилцаж болно. Хэрэгтэй бол тэд бас хэсгийн номлогч нарыг бүрэн цагийн номлогч нартай хамт ажиллах даалгаврыг зохицуулж, хэсгийн номлогч болон бүрэн цагийн номлогч нарын хичээл зүтгэлийг нэгтгэж хэрхэн илүү үр дүнтэй болгох талаар ярилцаж болно.

Хэсгийн Номлолын Төлөвлөгөө

Олон хэсгүүд хэсгийн номлолын төлөвлөгөөг хөгжүүлэх нь хэсгийн номлогчийн ажилд тус дэм болдгийг олж мэджээ. Ийм төлөвлөгөөнүүд нь хэсгийн гишүүдэд хүмүүсийг сайн мэдээ сонсохыг урихад туслах зорилтууд, санаачлагууд болон үйл ажиллагаануудыг багтааж болно.

Гишүүд Сэргээлтгийн мэдээг сонсох хүсэлтэй хүмүүсийг олох бүх л боломжтой арга замуудыг ашиглах ёстой. Тэд Сүмд гэр бүлээрээ ирэх аав нар, ээж нар мөн хүүхдүүдийг олохыг онцолж үзэх хэрэгтэй. Номлолын төлөвлөгөөг хөгжүүлэхдээ авч үзэж болох зарим санаануудыг дор дурдлаа.

- Их Эзэнийг тодорхой хүмүүсийг сайн мэдээг сонсоход зүрх сэтгэлийг нь бэлдээч хэмээн залбир. Бас Түүний бэлдэж байгаа тэдгээр хүмүүсийг мэдрээсэй хэмээн залбир (Алма 6:6–г үз). “Хүмүүс дэлхий даяарх номлогч нарын төлөө залбираад зогсохгүй өөрсдийнх нь хэсэгт ажиллаж байгаа номлогч нарт дэмжлэг үзүүлэхэд нь тэдэнд туслаач хэмээн Их Эзэнээс хүсэх тэр өдөр ямар агуу вэ” хэмээн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли заасан (“Missionary Service,” *First Worldwide Leadership Training Meeting*, 2003 оны Нэгдүгээр сар, 19).
- Бусдад нөлөөлөх боломжуудыг сонирхож мэддэг бай. Бүх хүмүүстэй нөхөрсөг байж, хайраар хүрч ажилла.
- Олон нийтийн үйлчлэл, хэрэгцээтэй байгаа хүмүүсийг хоол хүнсээр хангах, Нийгмийн Халамжийн Бүлгийн Баяжуулалтын цуглаанууд дээр бага хэмжээний хичээлүүдийг заах, хэсгийн үйл ажиллагаануудад туслах, хүмүүсийг нүүхэд нь туслах, Скаутад ажиллах хийгээд гэр бүлийн түүх юмуу халамжийн хөтөлбөрт туслах зэрэг зүйлүүдэд гишүүдийг найз нөхөд, хөршүүдтэйгээ үйлчлэхийг асуу.
- Сүмийн гишүүн биш хамаатан, найз нөхөд, хөршүүдээ баптисм, гишүүнээр батлах болон санваарын ёслолуудад урь.
- Сүмийн гишүүн бус хүмүүсийг үндэсний баярыг тохиолдуулан өглөөний унд бэлдэх зэрэг онцгой үйлд туслахыг урь.
- Хэсгийн цуглаанууд, үйл ажиллагаанууд, галын дэргэдэх ярилцлагууд хийгээд нээлттэй хаалганы өдөрлөгийг гишүүд танилуудаа ирж оролцохыг чин сэтгэлээсээ урихаар чанарлаг, сонирхолтой хий.
- Хүмүүсийг гэр бүлийн үдэшт урь.
- Гэрлэлт, шинэ хүнтэй болох юмуу үхэл хагацал зэрэг өөрчлөлтүүд амьдралд нь тохиолдож байгаа хүмүүсийнхээр айлчил.
- Ойр орчиндоо нүүж ирж байгаа хүмүүсийнхээр айлчилж, тусал. Олон нийт, хөршүүд болон Сүмийнхээ тухай мэдээллийг хуваалц.
- Сайн мэдээний тухай ярих боломж бүрийг ашигла. Аврагч, Мормоны Ном, Ариун Библи, амьдралын зорилго, гэр бүл, гэр бүлийн түүх зэрэг сэдвээр ярилц.

Тэмдэглэл

- Залуучуудыг өөр залуустай нөхөрлөж, Сүмийн цуглаан болон үйл ажиллагаануудад урихад нь урамшуул.
- Гэр бүлийн нэг хэсэг нь гишүүн гишүүдтэй ажилла.
- Сүнслэг байдалд өргөх ариун ёслолын цуглаануудыг төлөвлө.

Үйл Ажиллагаа: Хамтрагчтайгаа Суралцах

- Хамтрагчтайгаа *True to the Faith*, “Church Administration” номон дээрх 34–37–р хуудсуудыг уншаад ярилц.
- Юу сурснаа хамтрагчтайгаа хуваалцаад, судлах тэмдэглэлдээ бич.
- Сүмийн удирдагчидтай ажиллахад хүргэх арга замуудад таны ойлголт хэрхэн нөлөөлөхийг ярилц.

Сүмд Идэвхтэй Хэвээр Үлдэх Амлалт

Хүмүүс бүхий л амьдралынхаа турш Сүмд идэвхтэй хэвээр үлдэх амлалтыг хийж, сахиснаар номлогчийн ажлыг агуу их үр нөлөөтэй болгодог. Хүмүүсийн хувьд зүгээр л Сүмд ирэх нь хангалттай биш юм. Тэд үлдэхээр ирэх ёстой. Таны бүх заалт болон урилгууд энэ төгсгөл уруу чиглэсэн байх ёстой. Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд зориулан нөөцөлсөн бүх адислалуудыг хүртэхийн тулд гишүүд үргэлжлүүлэн сайн мэдээний дагуу амьдарч, Сүмд идэвхтэй байх ёстой.

Нифай заахдаа “Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нарыг энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа, бүгд хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; . . . Христэд тууштайгар итгэн урагш тэмүүлэх ёстой . . . мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцгийн тийн хэлсэнчлэн: Та нарт мөнхийн амьдрал байх болно” гэж хэлсэн (2 Нифай 31:19–20).

Хүмүүсийг “Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу бэлэг болох мөнх амьдралтай байхад” нь туслах хамгийн сайн хичээл зүтгэлүүдээ өг (С ба Г 14:7).

Үүнийг Сана

- Бишоп болон хэсгийн зөвлөлийн гишүүдтэй бат бэх харилцааг бий болго.
- Санваартны гүйцэтгэх хороо, хэсгийн зөвлөлд тохирох арга замуудаар оролц.
- Хэсгийн зөвлөлд үйлчлэл нь бай. Зөвлөлийн гишүүд танаас тусламж асуух юм бол:
 - Хөрвөгчид болон идэвх султай гишүүдтэй дуудлагууд болон үйлчлэх боломжуудад нь туслах, номлогчийн хичээлүүдийг дахин заах зэргээр нөхөрлөх хүсэлтэй бай.
 - Шинэ хөрвөгчдөд “Хуулиуд ба Ёслолууд” хичээлийг гишүүдтэй хамт заа.

Заах Санаанууд болон Хэрэглэгдэх нь

Хувиараа Суралцах

- Өдөр тутмын төлөвлөгөөгөө ашиглан шинэ хөрвөгч болон саяхан идэвхтэй болсон гишүүдтэй тэдний амьдралын өөрчлөлт болон сүмд ирж байгаа тухай нь ярих төлөвлөгөөнүүдийг хий. Тэдэнд юу илүү сайн туслах вэ? Тэдэнд тохиолдсон явдлуудын тухай өөрийн бодлуудыг судлах тэмдэглэлдээ бич. Одоогийн сонирхогчтойгоо ажиллахад тань туслах юуг сурсан бэ?
- 2 Нифай 31:18–20, Алма 26:1–7 ба 32:32–43 болон Морунай 6–г судал. Эдгээр шүлгүүдээс шинэ хөрвөгчдийг хүчирхэгжүүлэх талаар юу сурснаа бич.

Хамтрагчтайгаа Суралцах

- Хэсгийн зөвлөлийн цуглааны үеэр бишопоосоо энэ долоо хоногийн турш өөрсдийг тань айлчлаасай гэж хүсч байгаа идэвх султай гишүүн байгаа эсэхийг асуу. Та эдгээр идэвх султай гишүүдийнхээр айлчлан очихдоо тэдний Есүс Христэд итгэх итгэлийг нь бий болгохыг эрэлхийл. Тэднээс бусдын зааж өгсөн хүмүүс байгаа эсэхийг асуу.
- 1 Коринт 3:2, Еврей 5:12 болон Сургаал ба Гэрээний 19:22-ыг судал. Сүүгээр юуг төлөөлүүлж байгаа вэ? Мах гэж юу вэ? Өөрийн хариултуудыг “Би Юуг Суралцаж, Заах вэ?” бүлэг дэх сургаалуудтай харьцуул. Та яагаад сүү болон махыг зөв дараалал болоод зөв хэмжээгээр өгөх ёстой вэ? Та үүнийг хэрхэн хийж чадах вэ?
- Ерөнхийлөгч Иосеф Ф.Смитийн баптисмынхаа үед ямар сэтгэгдэлтэй байснаа дүрсэлсэн дараах ишлэлийг унш:

“Над дээр ирж байсан тэр мэдрэмжүүд нь жинхэнэ амар амгалан, хайр болон гэрэл байсан. Хэрэв би гэм нүгэл үйлдвэл—би үнэхээр гэм нүгэлгүй байхгүй— би өршөөгдөх болно; гэм нүглээсээ үнэхээр цэвэрлэгдэх болно; зүрх сэтгэл маань хөдөлж, хөл доорхи өчүүхэн жижиг шавьжийг хүртэл гэмтээхгүй гэсэн сэтгэгдэл бодгальд минь мэдрэгдэж байлаа. Би газар сайгүй, хүн бүрт болон бүх зүйлд сайныг үйлдэхийг хүсч байсан. Би амьдралын шинэ байдлыг, зөв гэсэн зүйлсийг хийх хүслийн шинэ байдлыг мэдэрч байв. Миний бодгальд хилэнцэтийг хийх хүслийн өчүүхэн хэсэг байгаагүй юм. . . . Энэ нь над дээр ирсэн нөлөө бөгөөд би үүнийг Бурханаас ирсэн хийгээд Их Эзэнийг хүлээн авсан гэсэн миний амьд гэрчлэл байсан мөн байх ч болно гэдгийг мэднэ” (Gospel Doctrine, 5th ed. [1939], 96).

Одоо Ерөнхийлөгч Смитийн баптисмаас хойш нилээн хугацаа өнгөрсний дараа ямар сэтгэгдэлтэй байсныг нь уншъя:

“Өө! Баптисмын маань өдрөөс өнөөг хүртэлх амьдралынхаа мөч бүртээ тэр л сүнс болон зүрх сэтгэл дэх чин хүсэл маань хэвээр хадгалагдсан байсан болоосой. Тэр л гэрчлэл, шинэ төрөлт, зүрх сэтгэлийн өөрчлөлтийг хүлээн авсан бидний олон нь шийтгэлд алдаж юмуу олон алдаануудыг хийж байхдаа ихэнхдээ тун удалгүй амьдралынхаа үнэн жишигт хүрч, хилэнцээ наманчилснаар Их Эзэний гар дахь өршөөлийг цагаас цагт хүртэхийг эрэлхийлдэг; Тиймээс энэ өдрийг хүртэл бид баптисм хүртэж, гэм нүглийнхээ өршөөлийг авч байхад бидний сүнсэнд шингэсэн тэр л хүсэл, эрмэлзэл зүрх сэтгэлийг минь эзэмдсэн хэвээр байж, сүнсний маань сэтгэл болон дур хүслийг захирч байгаасай” (Gospel Doctrine, 97).

- Ерөнхийлөгч Смитээс өөрийн сайн мэдээний дагуу амьдрах гэрчлэл болон даалгаврын тухайд та хувьчлан юу сурсан бэ?
- Та шинэ хөврөгчдөд, бүр ирээдүйн бошиглогчдод баптисмын дараа тулгардаг хүндрэл, бэрхшээлүүдийн талаар юу сурсан бэ?

Тэмдэглэл

- Саяхан хөрвөгчид, идэвх султай гишүүдийн талаар бодоод тэднийг нэгэнтээ мэдэрч байсан “хүсэл болон зорилгоо” эргүүлэн олж авахад нь туслахын тулд та юу хийж чадах вэ?

Дүүргийн Хурал болон Бүсийн Чуулган

- Бишопыг идэвх султай гишүүд, шинэ хөрвөгчтэй ажиллаж байхад тулгардаг бэрхшээлүүдийн талаар ярилцахыг урь.
- Алдагдсан хонь, хаягдсан зоос болон үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэрийг ярилц (Лук 15–ыг үз).

Номлолын Ерөнхийлөгч

- Орон нутгийн санваарын удирдагчдыг шинэ хөрвөгчдөд туслахад нь урамшуулан хамтран ажилла.
 - Санваартнаар томилогдсон бай.
 - Гэрийн багш нарыг хүлээж ав.
 - Өвөг дээдсийнхээ нэрийг ариун сүм рүү авч явж, нас барагсдын төлөөх баптисм хийхээр бэлд.
 - Гэрийн багшаа байлцуулан “Хуулиуд ба Ёслолууд” хичээлийг ав.
- Орон нутгийн удирдагчдад номлогч нарыг хэрхэн ашиглах талаар хэсгийн зөвлөлд заа.
- Орон нутгийн удирдагчдад Өсөлтийн Тайлангийн зорилго, хэрэглээг заа.
- Номлогч нараас Өсөлтийн Тайлангийнхаа хувийг үе үе үзүүлж байхыг хүс.
- Үе үе сүүлийн үед хөрвүүлэгдсэн хүмүүстэй хэр явж байгаа болон номлогч нар, гишүүд хэрхэн тусалж болохыг олж мэдэхээр эргэн уулзаж бай.
- Номлогч нар хэрхэн агуу их тусламж байж болох талаар номлогч нартай яриулахаар гадас буюу хэсгийн удирдагчдыг урь.
- Саяхан хөрвөгдөгсдийг номлогч нартай яриулахаар урьж, Сүмийн шинэ гишүүний хувьд тэдэнд юу тохиолдож байгааг нь яриул.
- Заримдаа бүсийн чуулган дээр хөрвүүлэгдсэн гишүүдийг хөрвөгдсөн тохиолдлоосоо хуваалцахыг хүс.

А

Аароны санваар, дахин сэргээгдсэн, 40
 Аврал, бүгдэд боломжтой, 95
 тодорхойлолт, 64
 төлөвлөгөө нь, 51–59
 Адам Ева хоёрын уналт, 53–55
 тодорхойлолт, 64
 Адислалууд, ба амлалтууд, 224–25
 Алдар суугийн хаант улсууд, 58–59
 Айлчлагч багшлалт, 245
 Амжилт, тодорхойлолт, 11–12
 Амлалт, ба адислалууд, 224–25
 итгэлээ нэмэгдүүлэх, 226–27
 мөн дахин шалгах, 222
 мөн шууд асуултууд, 223–24
 наманчлалын хэрэгтэй хэсэг, 221
 Амлалтууд, Амлалтын зорилго, 9
 Амлалтын урилга, 221–22
 Амилуулалт, 58
 тодорхойлолт, 56–57, 64
 Амьдралын мод, үйл ажиллагаа, 2
 Англи хэл, сурах хэрэгтэй, 146
 Анхааруулга, илэрхийллийг хүлээн авахад,
 110–11
 Аравны нэг болон өргөлүүд, хандивлах, 88–89
 Аравны нэг, хууль нь, 86–87
 Арван Зарлигууд, дуулгавартай байх нь,
 85–86
 Ариун Ёслол, 71
 Ариун Журам, 135
 Ариун Сүмүүд, шүтэн бишрэх нь, 95–96
 Ариун Сүнс, бэлэг, 102
 сурах, 20
 хүн байх нь, 101
 хүч, 101
 Ариун Сүнсний Амлалт, 102
 Ариун Сүнсний бэлэг, 72, 102
 Ариун явдал, хууль нь, 86
 Асуултууд, ба даалгаврууд, 224
 хэрхэн хариулах, Мормоны Номыг
 ашиглан, 123–24
 хэрэглээ, заахад, 208–09

Б

Баллард, М.Рассел, зорилгууд дээр, 166–67
 Ариун сүнсний хүчин дээр, 104
 Баптисм ба гишүүний баталгаа, 9–10, 83
 тухай асуулт ба хариулт, 234–36
 бүртгэлүүд, 237
 Баптисм, урилга, 43, 73
 сүмийн гишүүнчлэлийн хамгийн хэрэгтэй
 зүйл, 70–71
 бага насны хүүхдүүдэд чухал хэрэгтэй
 биш зүйл, 71
 галын, 72
 батлагдаагүй нэр дэвшигч, 235
 бидний эхний гэрээ, 70–71
 бэлтгэл, 231–33
 чанарууд, 231–32
 Баптисмын үйлчлэл, хэн удирдах, 236
 Баптисмын ярилцлага, хэрхэн удирдах, 233–35
 сонирхогчийг бэлтгэх, 232
 асуултууд, 234
 хэн удирдах нь, 234
 Бенсон, Эзра Тафт, Мормоны Номны
 хамтаар асуултанд хариулж буй нь, 123–24
 Мормоны Ном тулгуурын чулуу болох
 дээр, 117–18
 Сүнсний талаарх агуу асуулт дээр, 121–22

Сүнсний чухал болох талаар, 200
 сайн мэдээг дэлхий дахинд авчрах дээр, 2
 ажиллах талаар, 138
 Библи, Мормоны Номыг дэмжих нь, 120
 Бие махбодийн үхэл, тодорхойлолт, 64
 Бишоп, 169–70
 ба номлолын ажил, 184
 хэсгийн номлогчийн хичээл зүтгэлийг
 удирдах нь, 244
 бишопын үүрэг, 249
 Бошиглогч нар, тайлбарласан, 36
 үүрэг нь, 35–36
 Бошиглогчийг дагах, 84
 Будда (Готом), 50
 Бурхан, бидний Тэнгэрлэг Эцэг, 33–34, 52–53
 Бурханыг шүтэх, Бурханыг зөв зохистойгоор
 шүтэх, 85–86
 Бурханы гэр бүл, 33–34, 177
 Бурхан, Христийн шашинтан бус хүмүүст
 заах нь, 34
 Бурхан Эцэг, Иосеф Смитэд үзэгдсэн, 39–40
 Бусдын зааж өгсөн хүмүүстэй ажиллах
 удирдамжууд, 186
 Бүртгэлүүд, баптисм болон гишүүнээр
 батлуулахад, 237
 Бүсийн Ном, дүрслэгдсэн, 158–60
 хуучин сонирхогч нарыг олоход ашиглах,
 189–90
 Бүсийн чуулган, ба суралцах нь, х
 Бүтээл, дэлхийн, 53

В

Вислиффе, Жон, 49
 Вөртлэнд, Иосеф Б, Мормоны Номыг
 хэрэглэх дээр, 125

Г

Гадасны дээд зөвлөх, үүргүүд нь, 248
 Гишүүд, номлогчийн ажил хийх айдас, 184
 сонирхогчдыг олоход туслах, 183–85
 хэрхэн туслах, номлогчийн ажилтай, 185
 Гишүүн байх эрхээ хасуулсан гишүүд,
 баптисм хүртэх эсэх, 236
 Гишүүн болж болох сонирхогчид,
 үзүүлэгдсэнээс, 162
 Гишүүний баталгаа, 71
 тодорхойлолт, 77
 хэрхэн гүйцэтгэх, 237–38
 гишүүнээр батлахад бэлтгэх нь, 231–32
 Баптисм ба гишүүний баталгаа үз
 “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”
 3, 94
 Гэр бүлийн түүхийн ажил, 95–96
 Гэр бүлийн түүхийн төвүүд, сонирхогч нарыг
 олох эх сурвалж, 188
 Гэр бүлийн түүх, сонирхогч нарыг олох эх
 сурвалж, 187–89
 Гэр бүлийн үдэш, 94
 Гэр бүлүүд, сайн мэдээгээр адислагдсан, 34
 сэргээгдсэн сайн мэдээ адисладаг, 3
 ач холбогдлыг заадаг, 182–83
 Гэрээ, тодорхойлсон нь, 77
 тайлбарласан нь, 70–71
 Гэрчлэл, тогтмол авчрах, 225–36
 Гэтэлгэл, тодорхойлолт, 64
 Гэрийн багшлалт, 245
 Гэр бүл, зорилго, 94

Д

- Даруу төлөв байдал, 137–38
 Долоо хоногийн төлөвлөх цаг, хэрхэн хийх вэ, 167–70
 Донтолтыг эмчлэх нь, 213
 Дуулгавартай байдал, 139
 зарлиг, 80
 Дуудлага, Сүм дэх, 96
 Номлогчийн дуудлага-ыг хар
 Дүүргийн хурал, болон суралцах, viii
 зорилго, ix–x
 Дэлхий дээрх амьдрал, 55
 Дэлхийн өмнөх амьдрал, 52–53
 тодорхойлолт, 64

Е

- Едений цэцэрлэг, 54
 Елиагийн Сүнс, 187–89
 Есүс Христ, Иосеф Смитэд үзэгдсэн, 39–40
 Гэтэлгэгч, 56–57, 68
 Цагаатгагч, Цагаатгагчийг үз
 дэлхий дээрх үйлчлэл, 36–37
 хүмүүст сурахад нь туслах, 51–52
 Есүс Христийн Сайн Мэдээ. Сайн мэдээг үз
 Есүс Христийн Хоёр Дахь Ирэлт, 40

Ё

- Ёслол, тодорхойлолт, 70–71

З

- Заах Бүртгэл, үзүүлэгдсэнээр, 159–60
 Заах санаанууд ба хэрэглэгдэх нь, хэрхэн хэрэглэх, xii
 Заах, хэрэгцээнд нь тохируулах, 202
 ба олох, 181–82
 ба сонсох, 208–09
 ба цээжлэлт, 148
 Сүнсээр, 4
 Тэргүүн Зөвлөлийн зөвлөгөө, 199–200
 хэрхэн эхлэх, 200–01
 Сүмийн дуудлагад, 97
 тохирсон цагийн урт, 202
 хичээлийн үргэлжлэх хугацааны урт, 202
 Христийн шашинтан бус хүмүүс, 216–17
 номлогчийн хувьд дахь сайн мэдээ, 203
 хамтрагчтай, 203
 гишүүдтэй, 203–04
 асуултуудтай, 208–09
 судруудтай, 204–06
 Залбирал, зарлиг, 81
 ба итгэл, хөрвүүлэлт дэх, 104–06
 түвшингийн үнэлгээ, 106
 хэрхэн санал болгох, 43
 үнэнийг сурах хэрэгслүүд, 42
 үүрэг нь, 42–43
 зөвлөгөөнүүд, 105–06
 Залуу Эмэгтэйчүүд, байгууллага, 93
 Залуу Эрэгтэйчүүд, байгууллага, 93
 Зарлигууд, 79–90
 Хэрхэн сурах, 80
 зарлигуудын тухай хэрхэн заах нь, 79–80
 Зорилго тавих, 155
 Зорилгууд, долоо хоногийн төлөвлөх цаг, 167–70
 хэрхэн тавих, 166–67
 Зорилт, номлогчийн хувьд, 1
 Зуурдын байдал, 55
 тодорхойлолт, 64
 зорилго нь, 33–34

Ж

- Жижиг хүүхдүүд, болон баптисм, 235

И

- Идэвх султай гишүүд, сонирхогч нарыг олох эх сурвалж, 185
 хүчирхэгжүүлэх нь, 243–44
 Ижил хүйстэнтэйгээ харилцаанд орох, болон баптисмд зохистой байх нь, 235–36
 Илчлэлт, хувийн, 99–100
 Индаумент, 95
 Иргэний хууль, дуулгавартай ба нэр төртөй байх, 90
 Ирээдүйн ахлагч нар, сонирхогчдыг олох эх сурвалж, 185
Итгэлд Үнэнч, 23
 Итгэл, болон заах хүмүүсийг олох, 177
 залбирал, 104–06
 Есүс Христэд, 68, 131–32

К

- Кабрера, Виктор Мануэль, өөрчлөгдсөн түүх, 179–80
 Калвин, Жон, 49
 Кимбалл, Спенсер В, номлогчийн болон ариун сүмийн ажил дээр, 187
 томилон адислагдах дээр, 4–5
 Кунзийн сургаал, 50

Л

- Ли, Харолд Б, гэр бүлүүдийн ач холбогдол, 3
 ойлголтын тухай заах дээр, 219
 Лутер, Мартин, 49

М

- Максвел, Нил А, итгэл найдвар дээр, 134
 Мацаг барилт, хууль, 89
"Миний Сайн Мэдээг Номло" хэсгийн номлогч нар ба удирдагчдаар хэрэглэгдсэн, 243–44
 Монсон, Томас С, гэрчлэл авчрах дээр, 225
 Сүнсний хэл дээр, 152
 гүйцэтгэлийг хэмжих дээр, 171
 гэсвэр гэвчээр дээр, 136
 гишүүдтэй заах дээр, 203–04
 Мормоны Ном, Сүнсний тухай асуултуудын хариултууд, 121–22
 Мормоны Ном шаантаг чулуу болох нь, 117–18
 хүмүүсийг Бурхан руу авчрах нь, 122–23
 Есүс Христийн тэнгэрлэг шинжийг гэрчлэх нь, 117
 Дахин Сэргээлтийн шинж тэмдэг, 7–8, 41–42, 117
 сонирхогч нартай хамт хэрхэн унших вэ, 124–26
 хэрхэн хэрэглэх нь, 124–26
 зорилт нь, 41
 унших, номлолын хэлийг сурах, 149
 Библийг дэмжих нь, 120
 Есүс Христийг гэрчлэх нь, 119
 Мөнхийн амьдрал, тодорхойлох, 77
 Мөнхийн гэрлэлт, 94
 Мөсөн уул, сэтгэл зовоосон зүйлүүд нь адил, 212
 Мухамед, 49
 Мэдлэг, 136
 Мэдээллийн хайрцгууд, *"Миний Сайн Мэдээг Номло"*, x

Мэдээллийн пирамид, 158
Мэдээллийн хэрэгслээр бусдын зааж өгсөн хүмүүс, 186
Мэргэн Ухааны Үг, 87
хэрхэн хэрэглэх, 87

Н

Найдвар, 133–34
Нас барагсдын төлөөх баптисм, 95–96
Нигүүлсэл, тодорхойлолт, 78
Нийгмийн Халамжийн Бүлэг, 93
Номлогчийн ажил, гишүүдийн хийх, 93
Номлогчийн амжилт, 11–12
Номлогчийн Долоо Хоног Тутмын Тайлан, үзүүлэгдсэнээс, 165
Номлогчийн дуудлага, ба үүрэг хариуцлагууд, 4–5
хүч болон эрх мэдэл, 4–5
сэргэсэн сайн мэдээг заах, 199
Номлогчийн зорилго, Есүс Христийг төлөөлөх нь, 2
Номлогчийн зохицуулалт, 250
Номлогчийн номын сан, ix
Номлогчийн Өдрийн Төлөвлөгөө, үзүүлэгдсэн, 163–64
Номлогчийн өдрийн хуваарь, viii
Номлолын ерөнхийлөгч, үүрэг нь, 247–48
Номлолын хэл, ба төрөлх хэл, 145
сурахад бэлтгэх нь, 145
бүхнээ зориулахыг шаарддаг, 146
Ноцтой гэмт хэрэг, ба баптисмд зохистой байх нь, 235–36
Нөхөрлөл, шинэ гишүүдийн, 239
Нүглээ наманчлал, 69, 213–14
ба амлалт, 221–22
Нүглээс ариусгагдах нь, 2–7, 67
Нүгэл, олон янзын соёлуудад үзэгдсэн, 67

О

Оакс, Даллин Ч, Бусдыг Христэд ирэхийг урих дээр, 9–10
Олж, заах, 181–82
Сүнсээр, 179
гишүүдтэй, 183–85

Ө

Өдрийн төлөвлөх цаг, 171
Өөрчлөлт, 37–38
Өөрчлөн байгуулагч, 49
Өргөмжлөл, 58
тодорхойлолт, 64
Өсөлтийн Тайлан, үзүүлэгдсэнээс, 161–62

П

Пабло, үйлчлэлээр дамжсан хөрвүүлэлтийн түүх, 192–93
Пакер, Боид К, ус болон галаар баптисм хүртэх дээр, 10
сүнслэг зүйлсд хүчлэх дээр, 114
Сүнсийг мэдрэх дээр, 107, 110
Хөрвүүлэлт дэх Сүнсэн дээр, 102
сүнслэг тохиолдлууд дээр, 110
суралцах нь зан чанарыг хэрхэн өөрчилдөг дээр, 21
Мормоны Номын тэжээх хүч, 122
Христийн гэрэл дээр, 101
Пери, Л.Том, дуулгавартай байдал дээр, 139

С

Сайн Мэдээ, 66–73
гэр бүлүүдийг адисалдаг, 3, 34
тодорхойлолт, 6–7, 78
хүмүүсийн хэрэгцээнд тулгуурлах, 1–2
зорилго нь, 6–7
Сэргээлтийн, 39–40
Сайныг хий, 192–93
Санваар, Аароны, 92
тодорхойлолт, 35
Мелкизедек, 93
сэргээлтийн, 39–40, 92
Санваар болон хавсралт бүлгүүд, 92–93
Санваарын удирдагчид, үүргүүд нь, 249
Смит, Иосеф, ба Анхны Үзэгдэл, 40
болон Сэргээлт, 39–40
ус болон Ариун Сүнсээр баптисм хүртэх дээр, 10
Мормоны Ном шаантаг чулууны хувьд дээр, 117–18
сайн мэдээг номлох дээр, 183
Сүнсэнд найдах дээр, 109
бүх боломжтой заалт дээр, 179
Ариун Сүнсний бэлэг дээр, 101
илчлэлтийн хэрэгцээн дээр, 99–100
Смит, Иосеф Ф, баптисм хүртэж байх үеийнхээ сэтгэгдэл дээр, 253
Смит, Хайрам, анхны зарчмуудыг заах дээр, 6
Снайдерс, түүх нь, 128
Соёл, сурах хэрэгцээ, 151
Сонголт, 52, 54
Сонирхогчдыг олох, санал болгох, 190–91
Сонирхогчид, номлогч нар бэлдэх, баптисмын ярилцлагад, 231–32
зорилгуудыг тавих, 167–70
Мормоны Номыг унших, 124–25
Сонсох, хэлний чадвараа нэмэгдүүлэх, 149
заахад хэрэглэх нь, 210–11
Судлах тэмдэглэл, тайлбарлагдсан, х
Судраас суралцах, зарлиг, 82
Судрууд, тэмдэглэх нь, 27
хэрэглээ нь, заахад, 204–06
Судруудыг тэмдэглэх нь, 27
Суралцах, зөвшөөрөгдсөн эх сурвалжуудаас, 25–26
заах бэлтгэлийн хувьд, 22–25
залбиралаар эхлэх, 19, 26
үр нөлөөтэй, 19
удирдамж, 23–24
үр нөлөөтэй байхад зориулсан санаанууд, 25–27
Сурах, илэрхийлэлт хүлээн авах үйл явц, 21
Сүмийн гишүүний хувьд, 97
Ариун Сүнсээр, 20
Сүмийг байгуулсан нь, 179
Сүмийг төлөвшүүлэх, 11
Сүмийн Ерөнхийлөгч нар, номлогчийн ажил дээр, 13–15
Сүмийн удирдах байгууллагуудын зааж өгсөн хүмүүс, 186
Сүнслэг үхэл, тодорхойлолт, 64
Сүнсний тухай асуултууд, Мормоны Ном, 121–22
Сүнсний бэлэг, 102
Сүнсний дэлхий, 57
Сүнс, хүч нь, хөрвүүлэлтэнд, 102–03
өдөөлт нь, 107–08
заалтыг удирдах ёстой, 200
заах нь, 4

Сэлэстиэл хаант улс, 58
 Сэргээлт, захиас нь, тайлбарлагдсан, 6–8
 сайн мэдээний, 39–40
 Сэргээлтийн захиас, 33
 болон гэр бүлүүд, 182–83
 тайлбарлах, 7–8
 Сэтгэл гонсойх, гунихрал, 11–12

Т

Тиндэйл, Виллиам, 49
 Тодотгол, нийтлэг бус үгсийн тодотгол, 24
 Тэвчээр, 136–37
 Тэйлер, Жон, энгийнээр заах, 207
 Тэлэстиэл хаант улс, 58
 Тэнгэр дэх Эцэг, 52–53
 Тэнгэрлэг Эцэг, 33–34
 Тэрриэстиэл хаант улс, 58
 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг, 31–32

У

Удмын бичиг, сонирхогчдыг олох эх сурвалж,
 187–89
 Урвалт, тодорхойлолт, 35
 Агуу Их, 37–38
 Урьд нь сонирхогч байсан хүмүүс, заах
 хүмүүсийг олох эх сурвалж, 189–90
 Утсаар өгөх тайлан, дүрслэгдсэн маягт, 163
 Уян хатан байдал, суралцахад, vii
 заахад, vii

Ү

Үе, тодорхойлолт, 35
 Үеүд, 35–36
 Үйл ажиллагааны шинж чанар, өөрийгөө
 үнэлэх, 143
 Үйлчлэл, Сүмийн гишүүний хувьд, 96
 сонирхогч нарыг олох эх сурвалж, 191–92
 Үндсэн үзүүлэлт, тодорхойлолт, 156–57
 хөрвүүлэлтэд, 156–57
 зорилгуудыг тавих, 166
 Үр хөндөлт, ба багтисм хүртэхэд зохистой
 байх, 235–36
 Үхэшгүй байдал, тодорхойлолт, 64
 тайлбарлах, 58

Ф

Фауст, Жэймс И, найдвар, 134
 тодорхой заах, 207

Х

Хавсралт байгууллагын удирдагчид, үүрэг нь,
 248
 Хайр, 134–35
 Хамтрагчтайгаа суралцах, зорилго, цагийн
 хуваарь, ix
 Хамтрагчийн нэгтгэн дүгнэлт, 170
 Хантер, Ховард В, Сүнсний мэдрэх дээр, 110
 Хариуцлага, 171–72
 Хиймэл шүтээнүүд, 85
 Хинкли, Гордон В, номлогч нар хөрвөгчдийг
 Сүмд холбодог, 244
 хөрвөгчдийг идэвхтэй хэвээр үлдээх дээр,
 244
 итгэл болон залбирал дээр, 104–05
 номлогч нарт тусалж байгаа гишүүд дээр,
 183–84
 номлогчийн залбирлууд дээр, 105
 шинэ хөрвөгчдийн хэрэгцээн дээр, 245–46

Мормоны Номыг залбиралтайгаар унших
 дээр, 122–23
 Сүнсийг мэдрэх нь, 108
 үйлчлэл дээр, 191
 Хичээлүүд, шинэ гишүүдэд, 31
 сонирхогч нарт заах, 31
 суралцах болон сургалтанд хэрэглэх нь, 31
 Хичээнгүй байдал, 138
 Хойд дүр, ба амилуулалт, 58
 Холанд, Жеффри Р, хэл сурах дээр, 146
 сонсох дээр, 210
 хүчтэйгээр заах дээр, 9
 Хөрвүүлэлт дэх номлогчийн үүрэг, 103
 Хөрвүүлэлтийн баптисм, тодорхойлолт,
 243–45
 Хөрвүүлэлт, хөрвүүлэлт дахь номлогчийн
 үүрэг, 103
 Хөрвүүлэлт дэхь сүнсний үүрэг, 102
 Христ, Гэрэл нь, Христийн Гэрэл-ийг үз
 Христ. Есүс Христ-ийг үз
 Христийн Гэрэл, 101
 Христийн шашинтан бус хүмүүст сайн
 мэдээг заах, 216–17
 Христтэй адил зан чанар, Бурханы бэлэг,
 131–32
 хэрхэн хөгжүүлэх нь, 140
 хөгжүүлэх хэрэгцээ, 132
 Хуваариа суралцах, зорилго, ix
 хуваарь, viii
 Хуваарь, Номлогчийн өдрийн хуваарийг үз
 Хувийн илчлэлт, 100–01
 Хуулиуд ба ёслолууд, баптисмын дараах,
 91–98
 хэрхэн суралцах, 92
 хэрхэн заах тухай, 91
 Хууль, дагах хийгээд хүндэтгэх, 90
 Хүндэтгэлийн өдөр, сахих, ариун, 82–83
 Хүүхдийн Хэсэг, байгууллага, 93
 Хэлний бэлэг, 152
 Хэлнүүд, бэлэг нь, 152
 Хэл сурах, болон дүрэм, 148
 цээжлэх нь, 148
 зорилгууд, 147
 зарчмууд, 147
 суралцах төлөвлөгөө, 147–50
 багаж хэрэгслүүд, 147
 хамтрагч нартайгаа, 150–51
 Хэсгийн зөвлөл, 170, 245–47
 ба шинэ хөрвөгчдийн нөхөрлөл, 246
 ба шинэ хөрвөгчдийг дуудлагад үйлчлэхэд
 нь туслах, 247
 ба шинэ хөрвөгчдийг тэжээх, 247–48
 нөхөрлөлд үүрэг хариуцлагатай, 244
 Хэсгийн номлогч нар, үүргүүд нь, 250
 “Миний Сайн Мэдээг Номло”-ыг хэрхэн
 хэрэглэх, 251
 Хэсгийн номлолын төлөвлөгөө, 251–52
 Хэсгийн номлолын удирдагч, үүргүүд нь,
 249–50
 Хэсгийн удирдагчид, ба номлогчийн ажил,
 243
 үүргүүд нь, 249

Ц

Цагаатгал, 32–34, 35, 52–53, 56–57, 67
 тодорхойлолт, 64
 Цаг ашиглалт, үр нөлөө, 155
 Цээжлэлт, болон заах, 148

Ш

Шалгах, болон амлалт, 226–27
 Шинж чанарууд, хэрхэн суралцах, 132
 Христийн, 131–32
 Шинэ гишүүд, сонирхогч нарыг олох эх
 сурвалж, 185
 номлогч нарын нөхөрлөх, 239
 хичээлүүдийг авах, 31
 хүчирхэгжүүлэх, 245–46
 хичээлүүдийг дахин авах, 239
 Шульц, Франк болон Милдрид,
 хөрвүүлэлтийн түүх, 188
 Шүүлт, тодорхойлолт, 65
 эцсийн, 58

Э

Энэрэл, тодорхойлолт, 78
 Энэрэнгүй байдал, 134

Эргэлзээ, сонирхогчийн эргэлзээг тайлах
 хэрэгцээ, 212–13
 Эргэн төлөх, тодорхойлолт, 78
 Эрх Мэдэл, номлогчийн, 4–5
 Санваар, алдагдсан, 37–38
 Дахин сэргэсэн нь, 39–40
 Эрх мэдэл, сэргээгдсэн сургаалыг заах, 1
 Эсэргүүцэл, хэрхэн хариулах, Мормоны
 Номтой, 123–24
 Эхчүүд, үүрэг нь, 94
 Эцгүүд, үүрэг, 94
 Эцсээ хүртэл тэвчих, 73, 97
 тодорхойлолт, 78

Я

Янг, Бригам, гэрчлэл хүлээн авах дээр, 226
 Ярих, санаанууд, бусадтай, 177
 олох багаж хэрэгслүүд, 177–78

Үүнийг сана . . .

- Сүнснүүдийг Христэд авчрах нь таны зорилго юм.
 - Сургаал ба Гэрээ 20:37 дээрх баптисм хийлгэх шаардлагууд болон баптисмын ярилцлагын асуултуудад хүмүүсийг бэлдэх.
-
- Өөрийн болон бусдын төлөө тогтмол залбир.
 - Танд хаашаа явах, юу хийх, юу хэлэхийг үзүүлэх Сүнсэнд найд.
 - Яг таг дуулгавартай бай.
 - Номлолынхоо хэлийг өдөр бүр суралц.
-
- Өдөр бүр төлөвлөж, үндсэн үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуул.
 - Бүхэл өдрийн турш, өдөр бүр үр бүтээлтэй ажилла.
-
- **Хүн бүрээс** хэн нэгнийг зааж өгөхийг асуу.
 - Олоод заа, заагаад ол.
-
- Зааж байгаа хүмүүстэйгээ Мормоны Номыг унш.
 - Иосеф Смит бол Бурханы бошиглогч гэдгийг мэдэх нэг чухал арга нь Мормоны Номыг уншиж, үүний тухай залбиран асууж болохыг хүмүүст заа.
 - Бүх сонирхогчидтойгоо өдөр бүр холбоо барь.
 - Гэрчлэлээ тогтмол хуваалц.
 - Боломжтой бол хичээл бүр дээрээ хэн нэгэн гишүүнтэй оч.
 - Дараагийнхаа хичээлийг хийх он сар өдөр, цагийг ямагт тодорхой тохир.
 - Бүх сонирхогчдоо баптисмын үйлчлэлд урь.
 - Хичээл бүрийн дараа сонирхогчдоо дараагийн уулзалтанд бэлтгэн уншиж, эргэцүүлэн бодуулах ямар нэгэн зүйлээр ханга.
-
- Гишүүдэд үйлчилж, хэсгийнхээ удирдагчидтай ажилласнаар тэдэнтэй харьцаа тогтоо.
 - Идэвхтэй хэвээр нь үлдээх, мөн идэвхжүүлэх үйл ажиллагаануудад нь хэсгийн удирдагчдад тусал.
-
- Зааж байгаа хүн бүртээ наманчлалд авчрах хийгээд Аврагчид итгэх итгэлээ хүчирхэгжүүлэх даалгавруудыг хийхэд нь тусал.
 - Их Эзэнийг хайрлаж, өөрийн чадах хамгийн сайнаар Түүнд үйлчил.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

